“УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ”

Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл

Улаанбаатар хот
2023 он

ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ УЛААН ТУГИЙН
БОЛОН ЦЭРГИЙН ГАВЪЯАНЫ ОДОНТ
ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ

“УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ”

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар хот
2023 он

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ СЭДЭВТ ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ

Эмхэтгэсэн: Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Ч.Чулуунхүү
Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, дэд хурандаа М.Ганбаатар

Цаасны хэмжээ B/5
Хэвлэлийн худас 31.25
Хэвлэлийн тоо 5
ДХИС-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ГАРЧИГ

1. **Хил хамгаалалтад тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.**
   ДХИС-ийн ЭШНХ-ийн ХАБСХ-ийн захирал, хил судлалын доктор, бригадын генерал, Ч.Сайнтөр 6
2. **Усан хил хамгаалалтад орчин үеийн техник технологи нэвтрүүлэх арга зам.**
   Батлан Хамгаалахын Удирдлагын Академийн аюулгүй байдал стратегийн төвийн ахлах багш, доктор, дэд профессор, хурандаа Д. Чойбаатар.....13
3. **Монгол Улсын өмнөд хилийн хамгаалалтад хийсэн судалгаа**
   Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэнгийн захирал, доктор, хурандаа Ц.Одбаяр.....21
4. **Хилийн анги, салбарын алба хаагчдын нийгмийн сэтгэл зүйн нөлөөлөл, шалтгаан, үр дагавар.**
   Хилийн албаны сургуулийн Сэтгэл зүйн тэнхимийн дэд профессор, докторант, дэд хурандаа П.Цацрал.....42
5. **Хилийн шалган нэвтрүүлэх албанд орчин үеийн дэвшилтэд техник технологи нэвтрүүлэх арга зам.**
   ҮБХИС-БХУА-ийн магистрант, дэд хурандаа М. Энхманлай.....74
6. **Улсын хил хамгаалалтад нисэгчгүй нисэх хэрэгсэл /дрон/-ыг ашиглах болон түүнтэй тэмцэх арга тактикийг боловсруулах нь**
   Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд.....84
7. **Гэрээт хилчний албаны үйл ажиллагааг боловсронгуй болгох зарим асуудал**
   Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, хурандаа Ц.Эрдэнээ.....93
8. **Хугацаат цэргийн албанд татагдсан иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн зарим асуудал, тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн тусламж үйлчилгээ**
   Хилийн албаны сургуулийн Сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад Б.Хишигжаргал.....103
9. **Хилийн заставын үүсэл, хөгжил, цаашдын чиг хандлага**
   Хилийн албаны сургуулийн Хил судлалын I дамжааны магистрант, ахлах дэслэгч Э.Батнасан.....115
10. **Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн технологийн системийн эрх зүйн орчинд хийсэн судалгаа**

Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн захирагч, докторант, хурандаа Г.Ган-Эрдэнэ.....121
11. **Улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх арга замыг судалсан нь**
Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн багш, хошууч Э.Сандагжав.....134
12. **Гэрээт хилчний албыг ээлжийн зохион байгуулалтад оруулах хэрэгцээ шаардлага**
ДХИС-ийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, докторант, дэд хурандаа М.Ганбаатар.....151
13. **Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн үнэлгээ, шинжилгээ**
ДХИС-ийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч С.Түмэн-Өлзий.....156
14. **Удирдах ажилтны манлайлалд нөлөөлөх шинжилгээ**
ДХИС-ийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, хошууч А.Тэмүжин.....168
15. **Хувь хүний манлайлал**
ДХИС-ийн Удирдлагын академийн 8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа Б.Ариунболд.....174
16. **Хүний нөөцийн бодлогод нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээ**
ДХИС-ийн Удирдлагын академийн суралцагч, магистрант, хошууч С.Пүрэв-Очир.....195
17. **Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал ажлын гүйцэтгэлд нөлөөлөх нь**
ДХИС-ийн Удирдлагын Академийн 8022 дугаар дамжааны суралцагч, магистрант, дэд хурандаа Б.Мөнхбат.....206
18. **Улсын хилийн бүс, зурваст ан агнуур ажил, үйлдвэрлэл явуулахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудал**
Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн ахлах багш, Хил судлалын магистр, дэд хурандаа Б.Ням-Очир...216
19. **Хилийн аюулгүй байдлыг хангах төрийн цэргийн байгууллагуудын харилцан ажиллагааны эрх зүйн зохицуулалтын зарим асуудал**
Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн дэд профессор, дэд хурандаа М.Баттулга.....224
20. **Хилийн заставт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх боломж**

Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, хошууч Б.Батгэрэл.....230
21. **Улсын хил хамгаалалтын инженер-техникийн хангалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч Ч.Баярболд.....240
22. **Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн сургалт бэлтгэл**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч Ж.Гарав-Очир.....247
23. **Хилийн салбарын офицерын сэтгэл ханамжийг сайжруулах арга зам**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч Б.Азжаргал.....256
24. **Улсын хил хамгаалалтад орон нутгийн ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга зам**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч С.Сумъяабазар.....264
25. **Шалгагчийн ур чадварыг сайжруулах арга зам түүнд тулгамдаж буй асуудал**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч Б.Сэндэр.....269
26. **Хилчин ахлагч нарын боловсролд тулгамдаж буй асуудал**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахмад Г.Төрмөнх.....275
27. **Хилчдийн албаны ачааллыг тодорхойлох арга зүйн үндэс**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахлах дэслэгч Ц.Билгүүн.....280
28. **Хил хамгаалах байгууллагад үйлдэгдэж буй гэмт хэрэг, сэтгэл зүйн учир шалтгаан**
Хилийн албаны сургуулийн Хил судлалын магистрант, ахмад Ц.Анхбаяр.....293
29. **Биометрийн онцлог, хэрэглээ, боомтын нэвтрүүлэх чадварт нөлөөлөх нь**
Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Б.Мөнгөнбагана.....302
30. **Хилийн аюулгүй байдлыг хангах зарим асуудал**
Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн эрхлэгч, хурандаа Х.Баясгалан.....311
31. **Бүсчилсэн хил хамгаалалтын онцлог**

Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа Ч.Чулуунхүү.....323

32. Хилийн албаны сургуулийн сонсонгчдын суралцахуйн тулгамдсан асуудал, тэдний хөгжлийг дэмжих зарим арга зам

Хилийн албаны сургуулийн Хилийн албаны тэнхимийн ахлах багш, хошууч Д.Энхтайван.....337

33. Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох шаардлага, үндэслэл

Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, докторант, хошууч О.Гантулга.....346

34. Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад орон нутгийн хөгжил, нөлөөлөл, оролцоо

Хилийн албаны сургуулийн цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, докторант, дэд хурандаа Ч.Отгонсүрэн.....360

35. Усан хилийн шугамын инженерчлэл үндэсний аюулгүй байдалд нөлөөлөх нь

Хилийн албаны сургуулийн ар тал, эдийн засгийн тэнхимийн дэд профессор, Хил судлал, Боловсрол судлалын магистр хошууч Л.Лхагвасүрэн.....367

36. Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам

ДХИС-ийн Ахисан түвшний боловсролын сургуулийн магистр, докторын хөтөлбөрийн менежер, доктор, дэд хурандаа М.Баярсайхан.....374

37. Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтнуудын сургалт хөгжил

Хилийн цэргийн 0257 дугаар ангийн Сэтгэл зүйн бэлтгэлийн албаны социологи, дүн шинжилгээний ахлах офицер, ахмад Д.Гэрэлтуяа.....389

ХИЛ ХАМГААЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Ч.Сайнтөр
ДХИС-ийн ЭШНХ-ийн ХАБСХ-ийн захирал,
хил судлалын доктор, бригадын генерал,

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал нь “Улсын хил” бөгөөд түүний гол хүчин зүйл нь хил хамгаалалт юм. Монгол Улсын хувьд 1933 оноос одоог хүртэл 90 жилийн турш улсын хилээ хамгаалж ирсэн түүхтэй. Монголчууд бид эрт дээр үеэс газар нутгийнхаа зах хязгаарыг сахин хамгаалж ирсэн уламжлалт арга барилаа технологийн хөгжлийн эрин зуунд ч хадгалсаар ирсэн нь түүхийн хувьд ач холбогдолтой ч гадны хөгжингүй улс орнуудтай харьцуулахад хоцрогдож буй нь ажиглагдаж байна. Манай улстай зах нийлэн хиллэдэг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газраас 2000 оны дунд үеэс эхлэн хил хамгаалалтын арга, хэлбэрээ шинэ шатанд гаргах бодлого баримталж, олон улсад үүсэж буй геополитикийн нөхцөл болон хилийн цагийн байдлын өрнөлт, өөрчлөлт, цаашдын чиг хандлага, хүн амын нягтрал, байгаль цаг агаарын онцлогтойгоо уялдуулан харилцан адилгүй байдлаар зохион байгуулж байна. Үүний нэгэн жишээ нь хилийн хэсгийг хиймэл дагуулын тусламжтайгаар хянах, хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах, өндөр хүчин чадалтай телекамерын хяналтыг нэмэгдүүлэх, хилийн шугамын дагуу дохиолол хяналтын системээр төхөөрөмжлөх зэргээр хил хамгаалалтдаа орчин үеийн техник технологийг уламжлалт арга барилтайгаа хослуулан явуулах бодлого баримталж байна.

Дэлхийн зарим улс орнуудад ч газар нутаг, тусгаар тогтнолын баталгаа болсон хил хязгаарынхаа халдашгүй дархан байдлыг хангахад чиглэсэн урт хугацааны бодлого, төлөвлөгөөг боловсруулан, төрийн бодлогодоо тусган, хилийн аюулгүй байдал болон улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудлуудлыг судалгаа шинжилгээнд тулгуурлан нарийвчлан тодорхойлж, шийдвэрлэх арга замыг эрэлхийлсээр ирсэн. Энэхүү асуудал нь тухайн улсын бүрэн эрхт байдал, цаашлаад улс орон оршин тогтнохын салшгүй хэсэг мөн гэдгийг зүй ёсоор хүлээн зөвшөөрч, төрийн бодлогын түвшинд авч үздэг байна.

Монгол Улсын хувьд хил залгаа улс орнуудын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай ижил түвшинд хөгжих эдийн засгийн боломж хязгаарлагдмал хэдий ч сүүлийн үед Улсын хил хамгаалалтад зайнаас удирдах орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслийг турших, шинээр хилийн отряд, застав, харуулын байр барих, авто техникийн парк шинэчлэлтийг хийх, цаашлаад хилийн цэргийн байгуулалтыг сайжруулах, шалган нэвтрүүлэх боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахим хилийн застав төслийг хэрэгжүүлэх зэрэг томоохон ажлуудыг бодлогын баримт бичигтээ тусган хэрэгжүүлж байна. Монгол Улсын хил хамгаалалтад Шийдлээ хүлээж буй томоохон асуудлууд байсаар байна.

Монгол Улсын хил хамгаалалтын өнөөгийн байдалд SWOT, TOWS матриц дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд тулгамдаж байна. Үүнд:

- Төрийн хилийн бодлогын хэрэгжилт хангалтгүй, цаашид шинэчлэн боловсруулах хэрэгцээ шаардлага бий болсон;
- Улсын хил хамгаалалт, түүний тогтолцоо онолын түвшинд бүрэн судлагдаагүй;
- Газрын хэвлийн хилийг хамгаалах эрх зүйн болон онол арга зүйн асуудал тодорхойгүй;
- Нисгэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалатад ашиглах эрх зүйн орчин бүрдээгүй;
- Гадаад, дотоодоос улсын хил зөрчиж буй нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дронтой тэмцэх асуудалд онцгой анхаарах;
- Дунд түвшний буюу оперативын удирдлагын байгууллагын бүтэц байхгүйгээс ХХЕГ-т удирдлагын хэт төвлөрөл бий болсон;
- Цэргийн холбоо, мэдээллийн технологи, системийн аюулгүй байдлын хамгаалалтын тогтолцоо сул;
- Зэвсэглэл техникийн хангалт, орчин үеийн шинэ техник технологийн шинэчлэл үе шаттайгаар хийгдэж байгаа ч шаардлагын түвшинд хүрээгүй;
- Хилийн инженер-техникийн байгууламжийг шинэ шатанд гаргах асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй.

Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудлуудаас гадна төрийн хилийн бодлого, газрын хэвлийн хил хамгаалалт, гадаад, дотоодоос улсын хил зөрчиж буй нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дронтой тэмцэх, дунд түвшний буюу оперативын удирдлагын байгууллагын бүтцийн асуудал зэрэг 4 асуудлыг онцгойлон тодруулан авч үзэж байна.

Үүнд:

1.Төрийн хилийн бодлогын талаар:

Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдал нь Үндэсний аюулгүй байдлыг хангах мөнхийн эрх ашиг бөгөөд оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс болох хилийн баталгаажилт, улсын хил хамгаалалтын асуудал нь олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагддаг.

Төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон төрийн залгамж чанартай, тулгуур бодлогын баримт бичиг юм.

Дэлхийн улс төр, эдийн засаг, цэрэг-техник, технологийн тэргүүлэх бодлогыг тодорхойлогч хөрш ОХУ, БНХАУ-тай хиллэдэг манай улсын хувьд төрийн хилийн бодлого, түүний зорилго, стратеги, агуулга нь цар хүрээний хувьд бусад хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй (Алсын хараа-2050) харьцуулахад харьцангуй тогтвортой, удаан хугацаанд хэрэгжиж, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг болдог.

Энэхүү бодлогын баримт бичиг нь УИХ-ын 2002 оны 20 дугаар тогтоолоор батлагдаж, нийт 3 зорилтын хүрээнд 23 заалт тусгагдсан бөгөөд 2022 оны байдлаар 82.1 хувьтай хэрэгжсэн гэсэн дүн мэдээлэл гарсан. Дээрх бодлогын баримт бичгийн биелэлтэд дүгнэлт хийхэд хэрэгжилт нь хангалтгүй байна гэж үзэж байна.

2.Газрын хэвлийн хилийг хамгаалах асуудал:

Монгол Улс газар зүйн байршлаараа олон зууны турш дэлхийн геополитикийн сонирхлын хүрээнд багтсаар ирсэн. Монгол Улс нь “Атлантын дайлайгаас Номхон далай хүрэх” геополотикийн шугам, Ази тивийн геостратегийн чухал түшиц газар, их гүрнүүдийн

геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн болон ашиг сонирхлын уулзвар, цэрэг, стратегийн бодлого, дэлхийн том шашнуудын нөлөөллийн уулзвар цэг дээр оршиж байна.

Хилийн зурваст үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн ашигт малтмалын орд газрууд байдаг нь газрын хэвлийн хил хамгаалалтын асуудлыг хөндөх шалтгаан болж байна. Монгол Улсын хувьд одоогийн байдлаар газрын хэвлийгээр улсын хил зөрчсөн тохиолдол бүртгэгдээгүй ч сүүлийн үед газрын хэвлийн зөрчил нь олон улсад анхаарал татахуйц түвшинд хүрч байна.

Судалгаанаас үзэхэд Өмнөд болон хойд Солонгосын хилийн хэсэгт газар доогуур хил дамнасан 30-40 км урттай 4-5 туннелийг цэрэг-байлдааны зориулалтаар байгуулсан, Америк-Мексикийн хилийн хэсэгт хил дамнасан туннель барьж, түүгээрээ хууль бус үйл ажиллагаа явуулж байсан нь тогтоогдсон зэрэг зөрчлүүд нь хуурай газраар хиллэдэг улс орнуудын хувьд дээрх хэлбэрийн хамгаалалтыг шинэ шатанд гаргахад онцлон анхаарч, технологийн дэвшил хийх хэрэгцээ шаардлага бий болж байгааг харуулж байна.

Улсын хилийн толорхойлолтод хилийн шугамаас эгц дээш агаарын, доош газрын хэвлийн хил байна гэж заасан хэдий ч нам өндөрийн болон газрын хэвлийн хамгаалалтын асуудал тодорхой бус байсаар ирсэн.

3.Улсын хил зөрчиж буй нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дронтой тэмцэх асуудал:

Сүүлийн үед бага оврын нисгэгчгүй нисэх хэрэгсэл буюу дроныг хилчид хил хамгаалалтын, иргэн, аж ахуйн нэгжүүд ахуйн болон тандалт судалгааны зориулалтаар ашиглах тохиолдол нэмэгдсээр байна. Хилийн ойролцоох агаарын орон зайд дур мэдэн нисдэг хэрэгсэл ашиглах явдал нь улсын хилийн халдашгүй дархан байдал цаашлаад хилийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй байгаагаас гадна тэдгээрийг хил дамнасан хууль бус үйл ажиллагаанд ашиглахгүй гэх баталгаагүй юм. Дэлхийн зарим улсад нисгэгчгүй нисэх хэрэгсэлээр хар тамхи зөөвөрлөх, хил хамгаалалтын арга тактикийг илрүүлэх, тандан судлах, харилцан мэдээ, мэдээлэл солилцох замаар хууль бус үйл ажиллагаанд ашиглаж байгаа тохиолдлууд нэмэгдсээр байна. Манай улсын хувьд 2019-2021 онуудад Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас нисгэгчгүй нисэх хэрэгсэл улсын хил зөрчсөн хэд хэдэн удаагийн

тохиолдлыг хилийн манаяны бүрэлдэхүүн илрүүлсэн боловч түүний эсрэг ямар нэгэн арга хэмжээ авч чадаагүй нь нам өндрийн хил хамгаалалтын асуудал орхигдсонтой шууд холбоотой гэж үзэж болно.

Гадны улс орнуудад цэрэг дайны үйл ажиллагаанд нисгэгчгүй нисэх хэрэгслийг тактикийн зэвсэг болгон ашиглаж буй нь асар их хор хөнөөл дагуулж байгаа талаар олон улсын ажиглагчид онцолж байна. Техник технологийн дэвшил хурдацтай хөгжиж буй энэ цаг үед нисгэгчгүй нисэх хэрэгслийг ашиглах, импортлох, бүртгэлжүүлэх эрх зүйн орчинг боловсронгуй болгох хэрэгцээ шаардлага бий болж байна.

Хилийн ойролцоо иргэн, аж ахуйн нэгжүүд ахуйн зориулалтаар нисэх хэрэгсэл ашиглахыг хязгаарлах, хил хамгаалахын байгууллагын алба хаагчид бүртгэлгүй нисэх хэрэгслийг албанд ашиглахыг хориглох зэрэг олон талт зохицуулалтыг тусгасан хууль, түүнийг дагасан журмуудыг боловсруулан батлуулж, мөрдүүлснээр дотоодоос нисгэгчгүй нисэх хэрэгсэл улсын хил давах асуудал багасахаас гадна хил дамнасан хууль бус үйлдлээс урьдчилан сэргийлэх асуудал шийдэгдэнэ гэж харж байна.

4.Дунд түвшний буюу оперативын удирдлагын байгууллагын бүтцийн асуудал:

Хил хамгаалах байгууллагын бүтцийн асуудлыг өөрчлөх, шинэчлэх, хил залгаа улсын ижил төстэй чиг үүрэг бүхий байгууллагуудтай статусын хувьд нэг түвшинд байлгах нь зүйтэй гэсэн асуудлын хүрээнд бүсийн удирдах газрыг байгуулахаар судалгааны ажил хийж, харьяа яаманд саналаа танилцуулсан байдаг. Оперативын удирдлагыг шинээр байгуулж, бүтцийн өөрчлөлт хийснээр ХХЕГ-т бий болсон удирдлагын хэт төвлөрөл багасах, тактикийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа анги, салбаруудын хил хамгаалалтын чиглэлээр тулгамдаж буй асуудлууд шуурхай шийдвэрлэгдэх, Монгол Улсын Хил хамгаалах байгууллага нь хил залгаа улсын хилийн байгууллагуудтай ижил түвшинд харилцах зэрэг асуудлууд бүрэн шийдэгдэнэ гэж үзсэн болно.

Одоогийн бүтцээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах явцад гадаад харилцааны чиглэлээр гарч байсан хүндрэлүүдээс дурдахад хил залгаа улсын талтай улсын хил хамгаалалт, харилцан

ажиллагааны талаар хэлэлцээр буюу уулзалт зохион байгуулахад албан тушаалын зэрэглэлийн хувьд зөрүүтэй ойлголтууд гарч байсан бөгөөд үүнээс үүдэн хилийн зөрчлийн шийдвэрлэлт, хил хамгаалалтын холбогдолтой зарим асуудлууд хүлээгдэх, дээд түвшины уулзалт зохион байгуулах шаардлага бий болох зэрэг асуудлууд тулгарч байсан.

Иймд бүсийн удирдах газрыг шинээр байгуулж, дээрх тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх, оперативын урлагийг хөгжүүлэх, стратегийн түвшинд бодлого төлөвлөлтийн асуудлуудаа боловсруулдаг болох хэрэгцээ шаардлага бий болж байна.

САНАЛ, ДҮГНЭЛТ:

1.Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, улсын хил хамгаалах байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх, улсын хил хамгаалалтад иргэн, байгууллагын оролцоог тодорхойлж, хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон бусад харилцааг зохицуулах зорилго бүхий Монгол Улсын хилийн тухай хуулийг 2016 онд батлагдаж, дагалдах дүрэм, журмууд өөрчлөгдсөнөөр Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг хуулийн заалттай уялдуулан нэмэлт өөрчлөлт оруулах, эсвэл шинэчлэн боловсруулах;

2.Монгол Улсын Хилийн тухай хуулийн 22.1.3-т “Улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн” гэсэн заалт байгаа ч газрын хэвлийн хилийг зөрчсөн тохиолдолд түүнийг шийдвэрлэх, урьдчилан сэргийлэх талаар эрх зүйн зохицуулалт байхгүй байгаад дүгнэлт хийж, дээрх асуудлын талаар холбогдох хууль тогтоомжид нэмэлтээр тусгуулах;

3.Улсын хил зөрчиж буй нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дронтой тэмцэх асуудлыг шийдвэрлэх замаар Улсын хил хамгаалалтад нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах, түүнтэй тэмцэх арга тактик, эрх зүйн орчныг бий болгох;

4.Улсын хил хамгаалалт түүний тогтолцоог онолын түвшинд бүрэн судалж, санал дүгнэлт гаргах;

5.Дунд түвшний буюу оперативын удирдлагын байгууллага, бүсийн удирдах газрыг шинээр байгуулж, ХХЕГ-т удирдлагын хэт төвлөрөлийг багасгах арга замыг тодорхойлох;

6.Цэргийн холбоо, мэдээллийн технологи, системийн аюулгүй байдлын хамгаалалтын тогтолцоог сайжруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх;

7.Зэвсэглэл техникийн хангалт, орчин үеийн техник технологийн шинэчлэлийг Улсын хил хамгаалалтыг бэхжүүлэхэд чиглүүлэн үе шаттайгаар зохион байгуулж, тэдгээрийг албанд ашиглахад зориулж тусгай мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх зэрэг хэрэгцээ шаардлагууд бий болж байна гэж дүгнэсэн.

УСАН ХИЛ ХАМГААЛАЛТАД ОРЧИН ҮЕИЙН ТЕХНИК, ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

Д.Чойбаатар
Батлан Хамгаалахын Удирдлагын Академийн
Аюулгүй байдал стратегийн төвийн ахлах багш,
доктор, дэд профессор, хурандаа

Товч агуулга: Усан хил хамгаалалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага, усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох эрх зүйн үндэслэл.

Түлхүүр үг: Усан хил, гол, нуур, хил хамгаалалт, хилийн дэглэм

Оршил

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн онцгой асуудлуудын нэг бөгөөд түүнийг хил залгаа орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллага хооронд хамтран шийдвэрлэж үндэсний, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримт бичгүүдээр баталгаажуулдаг онцлогтой.

Улсын хил, хилийн дэглэмийн асуудлыг зохицуулах үйл ажиллагаа нь олон улсын гэрээ хэлэлцээрт үндэслэн хэрэгждэг.

Монгол Улсын нэгдэн орж соёрхон баталсан олон улсын гэрээ конвенцууд нь хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны эрх зүйн үндэс болдог.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хилийн эрх зүйн асуудлыг олон улсын 50 гаруй гэрээ, хэлэлцээрээр зохицуулж байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 31 дүгээр зүйлд:

"Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн. Газар, усан дээрх улсын хилийг улсын хил хамгаалах байгууллага, агаарын хилийг зэвсэгт хүчний агаарын цэрэг хамгаална" гэж тодорхойлсон нь усан хил хамгаалалтыг зохион байгуулах эрх зүйн үндэслэл болж байна.[1]

Үндсэн хэсэг

Нэг. Хилийн ус, усан хилийн талаар товч ойлголт

[1] Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он

Монгол оронд 3600 орчим нуур, 3800 орчим гол, 187 орчим мөнх цас, мөс байдаг.Эдгээр нь Хойд мөсөн далайн, Номхон далайн, Төв Азийн гадагш урсгалгүй гэсэн 3 үндсэн ай савд хамрагдаж, нийтдээ 590 км.куб орчим усны нөөцтэйгээс Хөвсгөл нуур 381 км. кубыг нь эзэлдэг байна.

Монгол орны усны нийт нөөц нь дэлхийн усны нөөцийн 0.00004 хувийг, гол мөрний усны нөөцийн 1,63 %- ийг тус тус эзэлдэг байна.Усны нөөцийн 83,7 %-ийг нуур, 10,5 %-ийг мөсөн гол, 5,8 %-ийг голын ус тус тус эзэлдэг.

Гадаргын усны нөөцийн 85 %-ийг цэнгэг ус, түүний 93,6 %-ийг Хөвсгөл нуурын ус эзэлнэ. Гол мөрний жилийн дундаж урсацын 60 % нь гадагш хил даван урсах ба үлдэх хувь нь хөрсөнд нэвчиж, газрын доорх усыг тэжээх ба говийн нууруудад цутгаж ууршин шингэдэг онцлогтой.

Монгол Улсын хилийн шугамын урт 8252,6 км бөгөөд хуурай газраар 7351.6 км, усаар 901.058 км-ээр тус тус хиллэдэг.

Үүнээс Оросын Холбооны Улстай 3543 км, хуурай газраар 2863 км, усаар 680 км, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай 4709.6 км, хуурай газраар 4488 км, усаар 221 км хэсгээр хиллэн оршдог.

Усан хил нь Монгол Улсын нийт хилийн хэсгийн 10,9 % бөгөөд **усан хилийн 96,6 %-ийг голоор хил болгосон** хэсэг эзэлдэг. Буйр, Увс, Дөрөө нууруудаар хилийн шугам дайран өнгөрдөг. Буйр нуурын усан хил нь 30.7 км бөгөөд Монгол Улсын усан хилийн 3.4%, БНХАУ-тай хиллэдэг хэсгийн 13,8%-ийг, Монгол Улсын усан хилийн томоохон хэсгийг эзэлдэг. [2]

Монгол Улсын хилийг хөндлөн огтолж гарсан гол, мөрөн, горхины судалгаа

Д/д	Байрлал			Ялгаа				Урсгалын чиглэл		Нийт
	Аймаг	Сум	Хилийн тэмдэг	Мөрөн	Гол	Горхи	Булаг	Орсон	Гарсан	
Монгол –Оросын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
1	8	22	33	1	55	69	-	**110**	**15**	**125**
Монгол –Хятадын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
2	4	9	59	*	33	8	3	**23**	**21**	**44**
Монгол Улсын хилийг хөндлөн гарсан гол, мөрөн, горхи										
3	**12**	**31**	**92**	**1**	**88**	**77**	**3**	**133**	**36**	**169**

Монгол- Оросын хилийг хөндлөн огтолж гарсан усан хилдтомоохон байр суурь эзэлдэг голуудад:

[2] Т. Оюунбадам " Экологийн эрх зүй 2007 он

-Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Боршоо, Хандгайт, Улиастай, Торхилог;

-Завхан аймгийн Тэс, Хачиг, Цэрэг, Зос, Зайгал;

-Хөвсгөл аймгийн Дэлгэрмөрөн, Бүс, Хус,Шар гэр, Шишигт

-Булган аймгийн Их Илэнгэ;

-Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ мөрөн, Зэлтэр, Цөх, Минж, Хиагт,Бургастай;

-Хэнтий аймгийн Онон, Балж, Улз, Хужирт, Цагаан Чулуут, Хярхан[3]

Монгол- Хятадын хилийг хөндлөн огтолж гарсан усан хилд томоохон байр суурь эзэлдэг голуудад:

-Баян-Өлгий аймгийн Асгат, Ёлт, Шар хамар, Харгайт, Улиастай;

-Ховд аймгийн Булган;

-Дорнод аймгийн Хэрлэн, Халх, Нөмрөг, Оршуун, Шарилж зэрэг усан хилд томоохон байр эзэлдэг хилийн голуудыг нэрлэж болох юм.

Хоёр. Асуудлын тулгамдсан байдал

Сүүлийн жилүүдэд хилийн цагийн байдлын өрнөлт, түүний дотроос ялангуяа гол, нууртай хэсэгт хоёр талын хил орчмын нутаг дэвсгэрт амьдарч буй этгээдүүд үгсэн хуйвалдаж гэмт үйлдлээ хамтран хэрэгжүүлдэг хил зөрчигчдийн үйл ажиллагаа зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, орчин үеийн өндөр хүчин чадалтай техник хэрэгсэл ашиглан улсын хил зөрчих, хилийн бүс, зурвас, хил орчмын нутаг дэвсгэрт байгаа байгалийн баялгийг хууль бусаар олборлож түүгээр ашиг хонжоо олох зэрэг хэлбэрээр усан хилийн хэсгүүдээр улсын хилийг зөрчих болсон нь усан хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд үүсэж болзошгүйг харуулж, усан хилийн хамгаалалтын хэлбэр, арга тактикийг шинэчлэхийг зүй ёсоор шаардаж байна.

Монгол Улсын усан хилийн хэсгээр гарсан хилийн зөрчлийн сүүлийн 20 жилийн судалгаанд дүгнэлт хийхэд гадаадаас гарсан хилийн зөрчлийн 65%-ийг Буйр нуурын усан хилийн хэсгээр гарсан дээрхи хэлбэрийн зөрчлүүд эзэлсэн байна.

[3] Д. Чойбаатар " Хилийн ус" 2022 он



Дээрхи судалгаанаас Монгол Улсын усан хилийн томоохонд тооцогддог Буйр нуурын усан хилийн хэсэг нь хилийн цагийн байдлын өрнөлтөөр тулгамдсан асуудалд зүй ёсоор орж байгаа нь харагдаж байна.

Иймд Хил Хамгаалах Байгууллагын удирдлагаас Буйр нуурын усан хилийн хэсгийг бэхжүүлэх, хамгаалалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох асуудлыг сүүлийн жилүүдэд онцгойлон анхаарч, төрийн бодлогын түвшинд тавьж, дорвитой арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлсэнээр энэ хэсгээр гарч байсан хилийн зөрчлийг таслан зогсоосон.

ХХБ-аас сүүлийн жилүүдэд Буйр нуурын хэсгийн усан хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, боловсронгуй болгох чиглэлээр үе шаттай арга хэмжээнүүд, бодит хөрөнгө оруулалтыг оновчтой, тасралтгүй хэрэгжүүлснээр усан хилийн хамгаалалтын нягтрал нэмэгдэж, найдвартай байдал хангагдаж, "Усан хил хамгаалалт дэд хөтөлбөр" амжилттай хэрэгжиж, Буйр нуурын усан хилийн хэсгээр гарч байсан хилийн зөрчил, хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг таслан зогсоож, энэ хэсгийн усан хилийн хамгаалалт олон улсын жишигт хүрч, хилчид хуулиар хүлээсэн үүргээ бүрэн биелүүлэх боломтой болсон нь шинэ үеийн усан хилчдийн дүр төрхийг тодоор харуулсан, шинэ зууны хил хамгаалалтанд оруулсан үнэтэй хувь нэмэр, түүхэн ололт амжилт болсон.

Гурав: Цаашид усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь саналуудыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1.

-Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн **техник, технологийн дэвшлийг** ашиглана.[4]

2. "Алсын хараа 2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын зорилт 7.2.3.

-Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, **техник, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем**, арга туршлагыг нэвтрүүлж, албаны бэлэн байдал дээшилсэн байна.[5]

3. Хилийн цэргийн штабаас 2023 онд баримтлах бодлого чиглэлд:

-Буйр, Увс, Дөрөө нуурын усан хил хамгаалалтанд орчин үеийн **техник технологийн дэвшлийг** нэвтрүүлнэ.

-Уулын бүсийн хилийн отрядуудын ХЗГБЧ-ийн **инженерийн байгууламжуудыг** нэмэгдүүлж, хяналт удирдлагын системээр тоноглоно гэсэн эрх зүйн актуудыг үндэслэнэ:

1. Усан хил хамгаалалтын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд:

-Усан хил хамгаалалттай холбоотой олон улсын гэрээ, хэлэлцээрүүдийг шинэчлэх;

-Усан хил хамгаалалтын онол, эрх зүйн тусгайлсан гарын авлагатай болох;

-Усан хил хамгаалалт хөтөлбөрүүдийг шинэчлэн үе шаттайгаар хэрэгжүүлэх**;**

2. Усан хил хамгаалалтын арга тактикийг боловсронгуй болгох чиглэлээр:

---

[4] Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөр " Ногоон хөгжлийн бодлого " 2020 он

[5] "Алсын хараа-2050 " Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2020 он

-Хилийн цэргийн штабаас уул, ой тайгын бүсийн отряд, заставуудын хариуцсан хэсэгт мэргэжлийн бүлэг томилж, инженерийн хайгуул, газар орны туршуул явуулж усан хилийн тэмдгүүдийг шалгаж, гол, нууртай хэсгийн усан хилийн хамгаалалтыг бэхжүүлэх, боловсронгуй болгох бодомжийг боловсруулж хэрэгжүүлэх;

-Буйр нуурын усан хилийг тэмдэгжүүлээгүй байгаа нь олон улсын конвенци, гэрээ, хэлэлцээрүүд зөрчигдөх, хилийн зөрчил, будлиан үүсгэх, хил зөрчигчдөд хууль бус үйлдлүүдээ гүйцэтгэх боломж олгох зэрэг олон талын сөрөг нөлөөллийг үүсгэж байгаа учраас Буйр нуурын усан хилийг тэмдэгжүүлэх асуудлыг БНХАУ-ын талтай хамтарч яаралтай шийдвэрлэх;

3. Сургалт бэлтгэл, усан хилчдийг мэргэшүүлэх чиглэлээр:

-Хөгжингүй улс орнуудын усан хил хамгаалалтын арга тактикийг судлах, туршлага солилцох, усан хилчдийг сургалтанд хамруулах;

-Усан хилийн мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэх сургалтын төв, дамжаа, хотхон /бассейн/ байгуулж, албаны үйл ажиллагааг бие дааж явуулах;

-Хөнгөн хөлөг, завины жолооч, засварчин, усчин аврагч, усны мэргэжилтэнг сургаж бэлтгэх;

-Усан хилчидэд мэргэжлийн ур чадвар, ажлын үзүүлэлтийг харгалзан, мэргэжлийн зэрэг олгох;

4. Усан хил хамгаалалтанд орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх чиглэлээр:

-Усан хилийн хамгаалалтанд өндөр хүчин чадлын телекамер, нисгэгчгүй нисэх хэрэгсэл, радиолокацын станц, хяналт дохиололын, дохиолол хамгаалалтын, хяналт хамгаалалтын, гэрэлтүүлэг хамгаалалтын орчин үеийн техник хэрэгсэлийг ашиглах;

-Хөвөгч усан зогсоолыг усаар хиллэдэг томоохон голууд дээр буюу бусад шаардлагатай хэсэг, газар орнуудад шинээр төхөөрөмжлөх;

-Буйр нуурын усан хилийн хэсгийг давалгаа хагалагч, эргийн бэхлэлтийн байгууламжтай болгож, дулаан мэдрэгч камер, радарын системийн хосолсон хамгаалалтад үе шаттайгаар шилжүүлэх;

-Завь, хөнгөн хөлөг, усны мотоцикль, хөвөгч зогсоол болон техник, хэрэгслүүдийг хадгалах зориулалтын байруудыг барьж ашиглах;

-Хөрш орнуудтай хамтран усаар хиллэдэг гол мөрний эргийн нуралт, идэгдэлтээс хамгаалах зорилгоор хил болгосон голуудын

эргийн хамгаалалтыг мэргэжлийн байгууллагуудаар стандартын дагуу хийлгэх;

-Булан дэрсний заставыг эрчим хүчний нэгдсэн системд холбож, хилийн төлөөлөгчийн уулзалтын цэг байгуулах;

-Хилчид үүрэг гүйцэтгэдэг томоохон голуудыг эрсдэлээс урьдчилан сэргийлж хөвөгч гүүр буюу ган татлагаар төхөөрөмжлөх;

-Усан хилчдийг олон улсын жишигт нийцсэн шинэ загварын хувцас, аврах, хамгаалах, холбооны хэрэгсэлээр хангах;

-Голоор улсын хил болгосон хэсгийн усан хилийн хамгаалалтыг зохион байгуулдаг уулын болон ой тайгын бүсийн зарим хилийн салбаруудыг “**Jetseeker”** тийрэлтэт хөдөлгүүр бүхий гүехэн усны хөнгөн хөлгөөр хангах;

-Усан хил хамгаалалтын зарим анги. салбаруудыг эргүүл, хамгаалалтын зориулалт бүхий газар уснаа явагч хөнгөн хөлөг /Шинэ Зеланд улсад үйлдвэрлэгдсэн **“SEALEGS 7,1M RIB”/**-өөр хангах;

Дүгнэлт

Дээрх цогц арга хэмжээнүүдийг үе шаттай хэрэгжүүлснээр усан хилийн хэсгээр гарсан хилийн зөрчлийг таслан зогсоож, хил хамгаалалтын арга тактик шинэчлэгдэж, хил орчмын нутаг дэвсгэр, ард иргэдийн аюулгүй байдал хангагдаж, Монгол Улс дэлхийн болон олон улсын жишигт нийцсэн мэргэжлийн усан хилчидтэй болж, шинэ үеийн усан хилчдийн дүр төрхийг бий болгож, хилчид хуулиар хүлээсэн усан хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлэх бүрэн боломжтой болно гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. Т. Оюунбадам "Экологийн эрх зүй " гарын авлага 2007 он
2. "Ус" үндэсний хөтөлбөр 2010 он
3. Монгол Улсын усны тухай хууль 2012 он
4. Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он
5. Д.Чойбаатар "Монгол Улсын усан хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь" сэдэвт докторын диссертаци 2016 он
6. Д.Чойбаатар "Усан хилийн хамгаалалт” 2017 он

7. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллаганы хөтөлбөр" Ногоон хөгжлийн бодлого " 2020 он
8. "Алсын хараа-2050“ Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа 2020 он
9. Д.Чойбаатар "Хилийн ус” 2022 он

МОНГОЛ УЛСЫН ӨМНӨД ХИЛИЙН ХАМГААЛАЛТАД ХИЙСЭН СУДАЛГАА

Ц.Одбаяр
Хилийн цэргийн Хил судлалын
хүрээлэнгийн захирал, доктор,
хурандаа

Түлхүүр үг: Хил хамгаалалт, оператив чиглэл, зэвсэглэл, хүч хэрэгсэл, нягтрал

Агуулга: Энэхүү судлгаагаар тухайн үеийн нэршлээр БНМАУ-ын төр засгаас өмнөд хилийн хамгаалалтад хэрхэн анхаарч байсан, хил хамгаалалтын онцлох чиглэлзздийг хэрхэн тодорхойлж, түүний хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлж байсан талаар авч үзлээ.

ОРШИЛ

Дэлхийн улсууд ялангуяа том газар нутаг бүхий улс гүрнүүд цэрэг түүний дотор улсын хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг бүс нутгийн хэмжээнд авч үздэг бөгөөд энэ ч утгаараа Хилийн тойрог, Бүс нутгийн удирдах газар, Хуурай газар, Далай тэнгисийн эргийн командлал зэргийг байгуулж тухайн бүс нутгийн хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын бүхий л асуудлыг хуулиараа дээрх нэгжүүдэд хариуцуулан бие даасан оперативын удирдлага, нэгдлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нь улсын хилийн нягтралыг нэмэгдүүлж, хил хамгаалалтын найдвартай байдлыг хангаж байгаа төдийгүй улсын хил, хилийн орон зай, түүнтэй холбоотой олон талт асуудлуудыг цогцоор нь судалж, үнэлэлт дүгнэлт хийх, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж байна.

Монгол Улсын хувьд улсын хил хамгаалалт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалахад нөлөөлөх, шийдвэрлэх хүчин зүйлийн нэг байсаар ирсэн билээ. Монгол Улсын Үндсэн Хууль[6], Үндэсний Аюулгүй байдлын Үзэл Баримтлал[7], Гадаад бодлогын үзэл баримтлал[8], Төрөөс хилийн талаар баримтлах бодлого[9], Монгол улсын Хилийн тухай хууль[10], Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны

6.Монгол улсын үндсэн хууль., УБ.,1992.,
7.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.,УБ., 2010.,
8.Гадаад бодлогын үзэл баримтлал.,УБ.,2011.,
9.Төрөөс хилийн талаар баримтлах бодлого., УБ.,
10 .Монгол улсын Хилийн тухай хууль.,УБ., 2016.,

хөтөлбөр[11], “Дархан хил” хөтөлбөр[12], “Монгол Улсын Бүсчилсэн хил хамгаалалт” Засгийн Газрын тогтоол[13] зэрэг эрх зүйн баримт бичигт бүсчилсэн хил хамгаалалтын үндсийг тавих, түүнийг боловсронгуй болгохоор заасан. Хилийн цагийн байдлын өөрчлөлт, хил зөрчигчдийн үйл ажиллагаа нь зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, улсын хилийг өөрсдийн гэмт үйлдлийг хэрэгжүүлэх обьект болгон сонгон авч, орчин үеийн өндөр хүчин чадалтай автомашин техник, холбоо дохиоллын хэрэгслээр газар орон, цаг хугацааг товчлох болсон нь улсын хил хамгаалах урлагийг хөгжүүлэх, судлах, боловсронгуй болгохыг шаардаж байна.

Монгол улсын төр засгаас хил хамгаалалтыг бэхжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

Монгол улсын хил хамгаалалт нь тасралтгүй явагдаж байдаг ажиллагаа бөгөөд улсын хилийг зөрчилгүй байлгах, гарсан зөрчлийг цаг тухайд нь илрүүлэн саатуулж, хууль эрх зүйн дагуу шийдвэрлэх, мөн хил хамгаалалтыг онцлох чиглэлүүдэд хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлж, найдвартай байдлыг дээшлүүлж байгаагаар эцсийн дүн нь илэрхийлэгддэг.

Хилийн зөрчлийн судалгаанаас үзэхэд 1970-1990 онуудад өмнөд хилд 3738 удаа хилийн зөрчил гарсны 51,5 хувь нь тагнан турших, өдөөн хатгах, /улс төрийн шинжтэй/, 48,5 хувь нь төөрөх, ан хийх, хил давсан малаа авах, өвс түүх /аж ахуйн шинжтэй/ зэрэг зорилготой байсан бол 1991-2001 онуудад хилийн цагийн байдал өөрчлөгдөж шинэ хэлбэр, агуулагатай зөрчил, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүд нууц далд аргаар үйлдэгдэж байгаа нь гэмт хэргийн шинжийг агуулах болсон.

Монгол-Хятадын хилд автомашин, спирт, ноолуур, өнгөт метал, Монгол-Оросын хилд сум галт хэрэгсэл, ан амьтаны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар давуулах, малын хулгай, дээрмийн хэлбэртэй зөрчлүүд давамгайлан гарч байна. Тухайлбал, 1990-2012 оны хооронд 15565 хилийн зөрчил бүртгэгдэснийг өмнөх 20 гаруй жилийн хугацаанд гарсан зөрчилтэй

11.Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр., УБ.,2016.,

12.Дархан хил хөтөлбөр.,УБ.,

13 .МУ-ын Засгийн Газрын ...-р тогтоол

харьцуулбал 4,1 дахин өсч, “зорилго”, “агуулга” нь улам бүр сөрөг үр дагавар агуулах болжээ.[14]

Хилийн зөрчлийн зорилго, агуулга өөрчлөгдөж, зөрчил улам бүр өссөөр байгаа нь хил хамгаалалтын нягтрал, түүний дотор оперативын чиглэлийн хил хамгаалалтын нягтралыг зохих түвшинд байлгахаас хил хамгаалалтын үр дүн шууд хамааралтай болох нь харагдаж байна.

Монгол Улсын хувьд стратегийн болон оператив-стратегийн орон зайгаа тодорхойлохын зэрэгцээ стратегийн болон оператив, тактикийн түвшинд хилийн аюулгүй байдалд аюул занал учруулж болзошгүй чиглэлүүдээ тодорхойлж, тухайн чиглэлд хил хамгаалалтын нягтралыг илүү байлгах талаар анхаарч иржээ[15].

Улсын хил хамгаалалтын онцлох чиглэл буюу оперативыг чиглэлийг тогтоож ирсэн уламжлал, харгалзан үздэг хүчин зүйлсүүд байна.Үүнд:

1.Улсын нутаг дэвсгэрт цэргийн хүчээр халдан довтолж байсан болон халдан довтолж болзошгүй;

2.Тагнуул, хорлон сүйтгэх тагнуулын бүлэг улсын хил зөрчиж хил орчмын нутаг дэвсгэрт аюул занал учруулж байсан болон учруулж болзошгүй;

3.Хил зөрчигч болон хил зөрчигч бүлэг этгээдүүд удаа дараа улсын хил зөрчин хил орчмын нутагт дээрэм, тонуул хийж, иргэдийн амь нас аюулгүй байдалд аюул занал учруулж байсан болон учруулж болзошгүй;

4.Хил залгаа улсын хилийн районд цэрэг улс төр, нийгэм эдийн засгийн төвлөрсөн суурин газар ихсэх, тэдгээрээс манай улсын эсрэг цэрэг улс төрийн элдэв сөрөг өдөөн хатгалга, суртал ухуулга явуулах, хилийн маргаан, мөргөлдөөн үүсгэж болзошгүй;

5.Манай улсын хил орчмын нутаг дэвсгэрт стратегийн болон бүс нутгийн ач холбогдол бүхий үйлдвэрлэл, уул уурхай, дэд бүтэц бий болж, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлага бий болсон;

---

14. Одбаяр.Ц., Хлийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, түүнээс урьдчилан сэргийлэх нь., УБ.,2018., 2х

15.Наранжамц.Н.,Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.,УБ.,2018., 194х

6.Дотоодоос улсын хил зөрчин хар тамхи, мансууруулах бодис, хүний наймаа, зэвсэг галт хэрэгсэл хил нэвтрүүлдэг, тухайн үйлдэл нь зохион байгуулалтын хэлбэрт шилжсэн;

7.Улсын хил нэвтэрсэн дэд бүтэц сайтай төмөр зам, авто замаар тээвэрлэх үйл явц тасралтгүй явагддаг, хилийн боомт бүхий чиглэл, хэсэг; гэх мэт хүчин зүйлсүүд хамаарна.

Оператив чиглэл гэж албан ёсоор баталгаажсан тодорхойлолт байхгүй бөгөөд эрдэмтэн доктор /PhD/, профессор Н.Наранжамц “Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг чиглэлд цэрэг улс төрийн болон нийгэм эдийн засаг, хүн амын аюулгүй байдлыг хангах зорилгоор тодорхой хүчин зүйлүүдийг харгалзан сонгон авсан хүч хэрэгслийн төвлөрлийг бий болгосон чиглэлийг оператив чиглэл” гэж тодорхойлсон байна.

Өнөөдрийн байдлаар Хил Хамгаалах Байгууллагын хэмжээнд Улсын хил хамгаалалтын нягтрал, түүнийг нэмэгдүүлэх талаар бодлогын баримт бичигт Үндсэн чармайлалтаа төвлөрүүлэх чиглэлийн буюу цагийн байдлын өрнөлттэй 1-2 хилийн цэргийн ангиудыг сонгон авч хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлнэ гэж заажээ.

Энэ нь цэргийн урлагт өөрөөр хэлбэл давших, хориглох байлдааны ажиллагааны үед сонгон авдаг чиглэл, дайсны сул талыг тогтоож, тухайн чиглэлд хүч хэрэгслийг төвлөрүүлж амжилтанд хүрдэг, байлдааны ажиллагаа дуусмагц ач холбогдолгүй болдог чиглэл юм. Харин Монгол улсын оперативын чиглэл нь бүс нутаг дахь цэрэг улс төрийн байдал, цэргийн анги, салбар тэдгээрийн бүрэлдэхүүн, боломж, албаны түвшин, физик-газар зүйн онцлог, газар орон, бүс нутгийн хөгжил, санхүү эдийн засгийн байдал зэрэг олон талт хүчин зүйлүүдээс шалтгаалж байнга тогтвортой байдаг чиглэлийг хэлэх бөгөөд эдгээр нөхцөл байдлаас үндэслэн 1980-аад оны эхэн үеэс Хайлаар-Чойбалсан, Хөх хот-Сайншанд, Үрэмч-Ховдын чиглэлийг Монгол Улсын оперативын чиглэл гэж тогтоож энэ чиглэлд тухайн бүс нутгийн хил хамгаалалтын нягтралыг төвлөрүүлж байсан болно.

“Нягтрал”-ыг Монгол хэлний тайлбар тольд: **нягтрал сайтай** (Нягт шигүү, зай завсар багатай, шигүү[16]; Орос хэлний толь бичигт

16.Цэвэл.Я.Монгол хэлний тайлдбар толь., УБ.,2015., 210х

аливаа зүйлийг нягт шигүү байлгах, нягтруулах[17], Англи хэлний толь бичигт: Тухайн газар нутаг эсвэл орон зайд байгаа хүн эсвэл эд зүйлийн тоо хэмжээ[18] гэж заажээ.

Дээрх тайлбаруудаас харахад “**Нягтрал**” гэдэг нь тухайн газар нутаг эсвэл орон зайд байгаа хүн эд зүйлийг нягтруулах, шигүү, зай багатай байлгах гэсэн утгаар тайлбарласан байна.

Оросын Холбооны Улсын “Хилчний тайлбар толь бичиг”-т: Хил хамгаалалтын нягтрал гэж хил хамгаалах байгууллагын хариуцсан хэсэгт байрлуулсан хүн хүч, инженер техникийн байгууламжийн тоон үзүүлэлтийг хэлнэ гэсэн бол;[19] Америкийн нэгдсэн улсын толь бичигт: Гааль, хил хамгаалалтын байгууллагуудын хамгаалалтын үндсэн хэсгийн урт, түүнийг хаах, халхлах боломж, гэж тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтууд, судалгааны ажлын дүнд Оперативын чиглэлийн хил хамгаалалтын нягтралыг эрдэмтэн, цэргийн ухааны доктор, профессор хурандаа Н.Наранжамц “**Монгол улсын бүс нутгийн хилийн хэсгийн уртад оногдож байгаа Хилийн цэргийн хүч хэрэгслийн тоон үзүүлэлтэд харьцуулсан илэрхийлийг хэлнэ**” гэж үзэж тодорхойлсон байна.

Монгол улсын хилийг хамгаалж ирсэн түүхийг авч үзвэл дараах түүхэн үечлэл, он дараалал гарч ирж байна. Үүнд:

1.1921-1933 он. Ардын журамт цэргээр хил хязгаарыг хамгаалсан үеийн хил хамгаалалт

2.1933-1953 он. Хилийн цэрэг байгуулагдаж улсын хилийг хариуцаж хамгаалсан хамгаалалт

3. 1953-1966 он. Хязгаарын цэрэг татан буугдсан үеийн хил хамгаалалт

4.1967-1977 он. Хилийн цэргийг дахин байгуулсан үе

5.1977-1987 он. Хилийн цэргийн байгуулалт, хил хамгаалалт бэхжсэн үе

6.1990-2000 он. Өөрчлөн шинэчлэлтийн үеийн хилийн цэрэг

7.2000-2010 он XXI зууны эхэн үеийн хилийн цэрэг

8.2010-оос одоог хүртэл өнөөгийн хил хамгаалалт

17.Ожегови.И.С. Словарь руссого языка.,Москва.,

18. The okxford Paperbeck Distionari.,US.,2012.,115x

19.Пограничный словарь.,М.Академия ФПС России.,2002.,

Үүний зэрэгцээ Хил Хамгаалах Байгууллагын бүтэц, зохион байгуулалт тухайн цаг үе, нийгмийн байдалтай уялдан

-1933-1957 он -Хязгаарын цэрэг;

-1962-1964 он - Хилийн ба Дотоодын цэргийн аюулаас хамгаалах хэлтэс;

-1964-1967 он- НАХЯ-ны Хилийн ба Дотоодын цэргийн хэргийг эрхлэх хэлтэс;

-1968-1979 он- НАХЯ-ны Хязгаарын ба Дотоодын цэргийн хэргийг эрхлэх газар;

-1979-1990 он -Хилийн ба Дотоодын цэргийн удирдах ерөнхий газар;

-1990-1993 он - УАБХЕГ-ын ХЦУГ

-1993-1996 он-ХЦУГ

-1996-2000 он БХЯ-ны харьяа ХЦУГ

-2001-оос Хил хамгаалах ерөнхий газар болон өөрчлөгдөн зохион байгуулагдаж иржээ[20].

Ингэж бүтцийн өөрчлөлт хийж байсан нь улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг нэмэгдүүлэх, зарим үед буурах явдалд хүрэж байсан болно. Энэ асуудал нь дараах байдлаар ангилагдаж байна.

1921-1933 онд хил хамгаалалтын байдал:

Ардын хувьсгал ялахаас өмнө Монгол улсын хилийг эрт дээр үеэс харуул занги, тайж нарт захирагдаж байсан цагдаа харуул хамгаалж байсан ба 1924 онд татан буулгасан байна.

1921-1933 онд Монгол улсын зүүн болон зүүн өмнөд хилийг голчлон хамгаалж ирсэн. Үүний шалтгаан нь: Монгол орныг колончлох шунахай бодлогыг өвөрлөж байсан Хятадын харгисууд Хиагтын гурван улсын Гэрээний нэгэн этгээд Оросын хаант засаг Октябрийн хувьсгалаар унагаагдсаныг Монгол орныг ганцаараа эзэмших завшаан[21] гэж бодож улс төрийн бурангуй үйл ажиллагаа явуулж байсантай холбож байна.

Мөн Монгол улсын зүүн, зүүн өмнөд хилийн дагуу Японы цэргийн том бүлэглэлүүд байрладаг болсны дээр манай улсын хилийн гадна талаар зүүн зүгт Алтан эмээл, Ганжуур сүм, Халуун

20. Цэдэн-Иш.Б., Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс.-УБ., 2003., 82х.,

21.Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ.,2008.,7х.,

рашаан, зүүн өмнө зүгт Бандид гэгээний сүм, Баруун сөнөдийн төв, Дунд гүний хошууны төв зэрэг газруудад Японы цэргийн тагнуулын томоохон төвүүд байрлаж, түүнээс салбарласан 30 гаруй тагнуулын пунктууд хилийн дагуу дайны зорилгоор тагнах, хорлон сүтгэх, турших ажиллагааг байнга идэвхтэй явуулж байжээ.

Ардын засгийн газраас эх орны тусгаар тогтнолд учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч 1922 оны хавар төвийн цэргийн ангиудаас 750, Сэцэн хан аймаг дахь цэргийн ангиудаас 750 бүгд 1500 цэргийг дорнод хязгаарт, баруун болон өмнөд хязгаарт 1600 орчим цэрэг байрлуулж, хязгаарын цэргийн ангиудыг хязгаарын цэргийн тусгай морин цэргийн хороо, дивизион, сумангийн зохион байгуулалтай байхаар орон тоо, зэвсэглэлийг тогтоож, Хилийн тусгай ангиуд нь Хэрлэнгийн Гурванбаян, Тамсаг, Егүзэрийн хийд, Дарьганга, Замын-Үүд, Сулинхээрт нийт 6 анги байсан бөгөөд анги бүр 3 комендатуртай, 1 комендатурт 6-8 харуул байв.

Мөн хилийн тусгай ангийн дэргэд Гурванбаян, Егүзэр, Замын-Үүд, Өмнөговьд гаалийн хороотой, гаалийг хамгаалах цэрэг гэдэг Дотоодыг хамгаалах газрын 1 салаа шахам цэрэгтэй байсан. Хилийн харуул нь 3 өрхтэй, өрх бүр 4 цагдаатай, түүний нэг нь ахлагч буюу цэргийн албаны хугацаа дуусч халагдсан албан хаагч, өрх бүр 1 винтов буутай, морин уналагатай, тэр нь 2-3 мөчийн морин өртөөтэй (нэг мөч нь 12 морьтой). Энэ өртөө нь хилийн хамгаалалт, анги, комендатурын дарга, төлөөлөгч, тусгай томилолтоор явсан цэргийн салбарын ажиллагаанд зориулагдаж байжээ.[22]

Тухайн үед цагийн байдалтай уялдуулан Монгол улсын хилийн оперативын чиглэлийг **Дорнод, Сүхбаатар, Дорноговийн** чиглэлд тогтоон Монгол улсын өмнөд хил 4676,8 км хэсгийг 6 анги, 18 комендатур, 130-аад цагдаа харуул буюу 3100 гаруй хүн, агт уналга, винтовтой хамгаалж байсан.

Дорноговь аймгаас Баян-Өлгий аймаг хүртэл 3000 гаран километр хэсгийг Дорноговийн 2 анги, 3 комендатур, 20 гаруй заставын хүчээр хил хамгаалалтыг зохион байгуулж байсан байна.

---

22. Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ., 2008.,72х.,

Дээрхээс дүгнэхэд Монгол улсын зүүн, зүүн өмнөд чиглэлийн хил хамгаалалтын нягтрал илүү нэмэгдсэн боловч өмнөд, баруун чиглэлийн хил хамгаалалт төдийлөн нэмэгдээгүй, хилчдийн албаны ачаалал их байсан байна.

1933-1953 онд хил хамгаалалтын байдал:

1930-аад онд үүссэн Монгол улсын гадаад дотоод цагийн байдал нь хил хязгаарын хамгаалалтыг чанаржуулж, улсын хилийг мэргэжлийн цэргээр найдвартай хамгаалахыг зүй ёсоор шаардсан. Төр засгаас улс орныхоо батлан хамгаалах хүчийг зузаатгах талаар хэд хэдэн чухал арга хэмжээ авсаны нэг нь 1933 оны эхээр хилийн харуулын цагдааг татан буулгаж улсын хилийг мэргэжлийн цэргийн хүчээр хамгаалах ажилд шилжиж, хилийн ортяд, командатуруудыг байгуулж эхэлсэн.

Тухайн үед одоогийн оперативын чиглэлүүдэд хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлж дараах арга хэмжээг авчээ.

Баруун, баруун өмнөд буюу Үрэмч-Ховдын чиглэлд:

Монгол Улсын өмнөд, баруун чиглэлийн 3000 гаруй километр хэсгийг 2 ангийн хүчээр хамгаалж байсан бол БНМАУ-ын СнЗ-ийн 1933 оны нэгдүгээр сарын 20-ны гуравдугаар тогтоолоор Хязгаарын цэргийг ДХГ-ын харъяанд байгуулж, уг шийдвэрийн үндсэн дээр Цэргийн яамны Улаанбаатар хот болон орон нутгийн цэргийн ангиудаас зарим анги, салбаруудыг хязгаарын цэргийн мэдэлд шилжүүлэн өгсөн[23].

Уг шийдвэрээр: Цэргийн бөгөөд хязгаарын хэлтэс нь дотроо жагсаал, улс төр, бэлтгэл, гүйцэтгэх зэрэг 4 тасагтай, 20 нэгжээр өргөтгөн зохион байгуулагдаж, Ховдод хилийн отряд, Алтайд Тусгай комендатур байгуулан тус улсын баруун ба баруун өмнөд хилийг хязгаарын цэрэг хариуцан хамгаалдаг болсон.

Шинээр байгуулагдсан отряд, тусгай командатуруудын 300-400 орчим хүнтэй, заставууд тус бүр 28 хүнтэй, хөнгөн пулемёт 2, цэрэг бүр 120 сумтай винтов буу, гранат 2, сэлмээр зэвсэглэж, 2 ээлжийн морь, тэмээн уналагатай байв. Заставууд нь зүүн гартаа хайч холбоо барьж мөр ул гаргах, хариуцсан хэсгийн өндөрлөг газарт нь өдрийн цагаар хянах пост, шөнийн цагт цагийн манаа гаргах, сэжиг бүхий газруудыг нууц манаа, тодорхой аюул бүхий

23. Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ., 2008.,80, 81х.,

газруудад хүч нэмэгдүүлсэн постуудыг тавих зэргээр улсын хилийг хамгаалж байсан.

Тухайн үед төр засгаас улсын хилийг хамгаалах ажлыг сайжруулахын тулд улсаас ихээхэн хөрөнгө зарцуулж хязгаарын цэргийн зардалд 1 сая гаруй төгрөг нэмж төсөвлөж байжээ. Энэ нь хилийн цэргийн боловсон хүчин, байлдааны зэвсэг техник, агт морьд, амьдрал ахуйн хэрэгцээт бүхий зүйлээр хангаж, улсын хилийг найдвартай хамгаалахад зориулагдсан.

Ийнхүү 1500 гаран километр хэсгийг 2 анги, 3 комендатур, 20 гаран харуул, 800 орчим хүнээр хамгаалж байж, түүн дээр дахин нэг отряд, 3 комендатур байгуулж 1700 орчим хүн нэмэгдсэн байна.

Өмнөд буюу Далай хөв-Даланзадгадын чиглэлд:

Өмнөговь аймгийн 1100 гаран километр хэсэгт тусгай комендатур 10 гаран заставтай байгуулан хил хамгаалалтыг зохион байгуулж байсан байна. Тусгай комендатур 300-400 орчим хүнтэй, заставууд тус бүр 28 хүнтэй, хөнгөн пулемёт 2, цэрэг бүр 120 сумтай винтов буу, гранат 2, сэлмээр зэвсэглэж, 2 ээлжийн морь, тэмээн уналагатай байв.

Хөх хот-Сайншандын чиглэлд:

Манай орны гадаад байдал хүндэрч, дайны аюул занал нэмэгдсэнтэй холбогдуулан хязгаарын цэргийн отряд, заставуудыг байлдааны цагийн байдалд оруулж, удирдлагыг шуурхай болгохын тулд ДЯЯ-ны сайдын 1942 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдрийн тушаалаар “Шуурхай удирдлагын штаб”-ыг Сайншандад байгуулж, хилийн 9, 12, 17 дугаар отрядыг бригад командлан захирагч Намжил нарт хариуцуулсан байна[24]. Мөн 1940 онд дахин 2 хилийн отряд болох Сулинхээрийн 9-р отряд, Өмнөговьд тусгай комендатур байгуулахаар шийдвэрлэсэн байна.

Хилийн цагийн байдалтай уялдуулан энэ мэтчилэн хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, хүч хэрэгслийг нэмэх, зэвсэг техникээр хангах арга хэмжээг авсаар байсан. Ардын журамт цэргийн 6 анги, харуул цагдаагаар хамгаалж байсан улсын хил хамгаалалт богино хугацаанд хүчирхэгжиж, хүн хүч, зэвсэг техникээр хангагдсан юм.

24.Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ., 2008.,83-88х.,

Хязгаарын цэрэг байгуулагдсанаар “Шуурхай удирдлагын штаб” 2, хилийн отряд 9, командатур 2, нэг отряд дунджаар 2-3 суман, 6-9 застав, 350-600 орчим хүнтэй, морь, тэмээтэй, ачааны автомашин 4-5, суудлын автомашин 1, Рф-2 радиостанц 4, винтов хүний тоогоор, нагаан буу, хөнгөн пулемёт 11, хүнд пулемёт 8, бөмбөг буудах хэрэгсэл 29, сэлэм хүний тоогоор, хорт утааны баг 468, дуран 35, винтовын сум 304270, нагааны сум 96787-тай, Отрядуудын төвд 69, суман, заставууд 75 гэртэй, отрядуудад шинээр орон тоо бүтцэд өөрчлөлт орж маневрын групптэй болж энэ групп нь моторчилсон 2 салаа, хүнд пулемётын салаа 1, зенит пулемётын салаа 1, их бууны салаа 1, галт хэрэгслийн ангиас бүрдэж хүчин чадал нэмэгдэж хил хамгаалалтын нягтрал улам нэмэгдсэн байна.

Зүүн, зүүн өмнөд буюу Хайлаар-Чойбалсангийн чиглэлд:

Хилийн дагуух гадаад цагийн байдал хурцдаж байсан үед УБХТ, СнЗ-ийн 1936 оны хоёрдугаар сарын 27-ны өдрийн хамтарсан 15 дугаар хурлаар ДХГ-ыг өргөтгөж ДЯЯ-ыг байгуулав. Түүний харъяанд Цэргийн ба хязгаарын хэргийг удирдах газрыг 42 нэгжтэйгээр байгуулж, уг газарт штабыг бий болгон, холбооны тасгийг нэмсэн.Цэргийн ба хязгаарын хэргийг удирдах газар нь хил хамгаалах албаны зохион байгуулалтыг сайжруулах, хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, зэвсэг техникээр хангах, хилчдийн улс төр, байлдааны бэлтгэлийг дээшлүүлэх, хил хамгаалалтын ажилд орон нутгийн байгууллага, хөдөрмөрчдийн туслалцааг өргөн авч байх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлж байсан. Үүнтэй зэрэгцээд Дарьганга, Эрдэнэцагаанд 2 отряд байгуулсан бол, 1937 оны есдүгээр сарын 17 өдрийн 25 дугаар хурлын тогтоолд, тус улсын дорнод хилийн хамгаалалтыг ДЯЯ-ны хязгаарын цэрэгт шилжүүлэн өгөхийг зааж, 1937 оны 10-р сарын 18-ны өдрийн 28 дугаар тогтоолоор Халх гол, Тамсаг булаг, Хэрлэнд хилийн отрядыг байгуулж 1938 оны 1-р сарын 15-аас улсын хил хамгаалалтанд шилжүүлсэн бол 1940 онд нэмж Баянцагааны 23 дугаар отрядыг 1942 онд Шуурхай удирдлагын штаб”-ыг Баянтүмэн байгуулж, хилийн 20, 23, 24, 27, 31 дүгээр отряд, морин хороон корпус командлан захирагч Б.Дорж тус штабын даргаар томилогдож байсан байна.

ДЯЯ-ны сайдын 1943 оны хоёрдугаар сарын 17-ны тушаалаар “БНМАУ-ын Хязгаарын албаны дүрэм”-ийг бүх хавсралт, зааврын

хамт гаргаж, бүх ангиудад мөрдүүлсэн байна.[25] Энэхүү дүрмээр хязгаарын цэрэг нь улсын хилийг зөрчилгүй байлгах, элдэв зөрчил контарбанд үйлдэх явдалтай тэмцэх, хилийн шугамаас дотогш 100 км гүн зурвас хариуцаж, хил орчмын ардууд тэдгээрийн мал хөрөнгийг зэвсэглэсэн дээрэмчид, бусад довтолгооноос хамгаалах, хилийн зурвас доторхи ус, малын бэлчээрийг зөв зохистой ашиглахад хяналт тавина гэж тодорхойлжээ.

Үүний хамт хамгаалалтыг боловсронгуй болгоход чиглэгдсэн хэд хэдэн чухал арга хэмжээ авав. Үүнд:

-Хил хамгаалалтанд шинжлэх ухаан-техникийн сүүлийн үеийн ололтыг ашиглах эхлэл тавигдаж авто машин, радио холбооны тоог нэмэгдүүлж, алслагдсан суман, заставуудыг радио холбоотой болгов.

-Хилийн шугамд саад барих, хянах байр байгуулах зэргээр инженер техникийн байгууламж ашиглаж эхэллээ.

-Хилийн цэрэгт алба хаах хугацааг 5 жил болгож, хилчдийн дунд биеийн тамир-спортын ажил ялангуяа янз бүрийн зайд явган ба морин марш өргөн зохиодог болсон нь хилчдийн бие бялдарын хувьд чийрэгжүүлэхэд зохих ач холбогдлоо өгөв.

-Дайсны гэнэтийн довтолгоонд орохгүйн тулд урьдчилан боловсруулсан төлөвлөгөөний үндсэн дээр анги бүхэн өнгөлөн дадлалт хийж, түүнийг ямагт хэвийн ажиллагаатай байлган ашигладаг болов[26].

Ингэж хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлсэн нь отряд, заставын хариуцах хилийн шугамын хэмжээ багасч, хилийн аливаа зөрчил, өдөөн хатгалгыг цаг тухайд нь илрүүлэх анги, салбарын харилцан ажиллагааг сайжруулахын зэрэгцээ хилийн манаанд тавих хяналт шалгалтыг хүчтэй болгох бололцоонуудыг олгож байв.

1930-аад онд харийн зэвсэгт дээрэмчдийн эсрэг явуулсан хилчдийн баатарлаг тэмцлийн үр дүн нь хилийн цэрэг, дайсан этгээдийн хорон муу санаа бодлыг таслан зогсоож, төр засаг, ард түмнийхээ итгэлийг олж, эх орноо найдвартай хамгаалах хүчин болж

25.Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II.,-УБ., 2008.,93х.,

26. Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II.,-УБ., 2008.,281х.,

чадсаныг харуулсан боловч эх орныхоо тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын төлөө халуунд халж, хүйтэнд хөрч явсан хилчид хэлмэгдүүлэлтийн салхинд өртөж, 1938-1940-өөд онуудад Хилийн цэргийн удирдах газар, бүх отряд, ангиудын удирдлага шат дараалан баригдаж, харгис хатуу эрүү шүүлтэнд орж, энэхүү хоёр жилийн хугацаанд Хилийн цэргээс бүрэн бус мэдээгээр 370-аад хүн баригдан хилс шийдгэгдсэний бараг тал хувь нь дарга нар, 190 нь жагсаалын дарга, салааны туслах, тасгийн дарга, хилчин хүртэл байсан байна. Судалгаанаас үзэхэд энэ үед хилчдийн дундаас ажлын туршлагатай, мэдлэг боловсролтой дарга нарыг хэлмэгдүүлсэн хил хамгаалалт, цаашлаад улсын хилийг тогтоох ажилд ч сөргөөр нөлөөлсөн байна.

Хязгаарын цэргийг татан буулгасан үеийн хил хамгаалалт:

Дэлхийн II дайн зөвлөлтийн ард түмний ялалтаар дуусч, олон улс орон, тусгаар тогтнол хөгжлийн замд орж энх тайваны хөдөлгөөн дэлхийн улс оронд хүчтэй өрнөж байсан 1940-өөд оны дундуур манай өмнөд хөршид өрнөсөн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн улам идэвхжин 1949 онд хувьсгал ялж БНХАУ-ыг тунхаглав. Энэ нь манай орны гадаад байдлыг энх амгалан байлгахад таатай нөхцөл бүрдүүлэн, идэвхтэй нөлөө үзүүлж байлаа.

БНМАУ 1950 оны зургаадугаар сард БНХАУ-тай дипломат харилцаа тогтоон улмаар 1952 оны аравдугаар сарын 6-нд БНМАУ, БНХАУ-ын хооронд эдийн засаг соёлын талаар хамтран ажиллах хэлэлцээр байгуулав. Монгол-Хятадын хооронд найрамдалт харилцаа тогтоосон нь хилийн цагийн байдал манайд ашигтайгаар өөрчлөгдөж, үүний үр дүнд 1951 оноос улсын хилийг хамгаалж байсан Хилийн цэргийн анги, салбаруудын орон тоог цомхотгон цөөлөх бодлого барьж, өмнөд хөрштэй хил залгах хэсгээр хил хамгаалж байсан 12 отряд, шугамын 30 суман, хилийн 135 заставыг цомхотгон цөөрүүлж заримыг нь татан буулгаж 1952 оны 12 сар гэхэд хилийн отряд 4, тусгай суман 1-ийг үлдээж улсын хилийг бага хүчээр хамгаалах эхлэлийг тавьсан байна.Ингэснээр хилийн отряд, суман заставуудын тоо 80 шахам хувиар багасч тэдгээрийн хариуцсан хэсгийн хамгаалбал зохих хилийн хэсгийн хэмжээ 3-5 гаруй дахин нэмэгджээ.

БНМАУ-ын засгийн газар, БНХАУ-тай залгаа хилээ цэргийн хүчээр хамгаалж байснаа зогсоож өмнөд хилийг хамгаалж байсан 4

отряд, 1 тусгай суманг 1953 оны зургаадугаар сард татан буулгаж оронд 10 гаруй хилийн пункт (тус бүр 12 хүнтэй) байгуулав.

Хоёр орны найрамдалт харьцаа тогтож үүний ачаар ЗХУ ба БНХАУ-ын хооронд орших болсон нь манай орны гадаад байдлыг зөвхөн бэхжүүлээд зогсоогүй түүний энх тайван, аюулгүй байдал найдвартай хамгаалагдсан байна. Энэ байдлаас үндэслэн улсын хилийг цэргийн ангиудаар хамгаалуулахаа зогсоож тус хоёр орны хооронд хилийн дагуу гарах элдэв асуудлыг хоёр талаас томилогдсон хилийн төлөөлөгчийн шугамаар шийдвэрлүүлж байх саналтай байгаагаа дурьдаад БНМАУ-ын нутаг дэвсгэр дээр ажиллах хилийн төлөөлөгчид ба түүний харьяа төлөөлөгчдийн байрлалын тодорхойлолт, зураг схемийг өгсөн байна.[27]

БНМАУ-ын Хилийн цэргийн хүчээр хамгаалж байсан үйл ажиллагааг гэнэт зогсоож, 7000 орчим хүнээр хамгаалж байсан өмнөд хөрштэй хиллэдэг 4600 гаруй км хэсгийг хил хамгаалалтыг зохион байгуулах удирдлагын ямарч бичиг баримтгүйгээр 120 гаруйхан хүнийг ёс төдий үлдээж, хамгаалах болсон нь алсын бодлогогүй, хилээ эзэнгүйдүүлсэн ноцтой алдаа төдийгүй хил хамгаалалтын нягтрал гэж ярихад ч хүнд байсан нь тодорхой юм.

Гэвч үнэн хэрэг дээрээ тухайн үед хоёр улсын хооронд хилийн зөрчил арилаагүйгээр барахгүй хилийн зөрчил улам өсч байсан нь хилийн хэсэг эзэнгүйдсэн, мөн хилийн шугам тодорхой болж албан ёсоор тогтоогдоогүйгээс болж байсан гэж үзэж байна.

Үүнээс улбаалан БНХАУ-ын талд хэд хэдэн удаа улсын хилийг тогтоох бичгийг хүргүүлж улмаар 1962 онд тогтоосон билээ.

1966-1990 оны хил хамгаалалтын байдал /Хилийн цэрэг дахин байгуулагдсан/:

Өнгөрөгч зууны жараад оны сүүлчийн хагасаас (1967 он) Хилийн цэргийн (ХЦ) хөгжлийн шинэ үе эхэлж 1990-ээд оны сүүл хүртэл үргэлжилсэн. Энэ үе нь чухамдаа татан буугдсан ХЦ-ийг дахин сэргээсэн, ингэхдээ Монгол улсын хил хамгаалалтын түүхэнд урьд өмнө үзэгдээгүй бүтэц, бүрэлдэхүүн, зэвсэг техниктэй болж, хилчин бүрт ногдох галын хүч, байлдах чадамжийн хувьд эргэлт гарсан, улсын хилийн хамгаалалтыг бэхжүүлэх гадаад дотоод хүчин

27. Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ., 2008.,284х.,

зүйл нөлөөлсөн онцлогтой байжээ. Эдгээр нөхцөл байдал, хүчин зүйлүүд нь ХЦ-ийг өргөтгөх агуулга болсон байна. Монгол улсын хил хамгаалалтын энэхүү үеийн түүхийг хоёр шаттайгаар авч үзэж болно.

Нэгдүгээр шат нь: 1967-1978 оныг хамаарна. Энэ хугацаанд хилийн цагийн байдлаас шалтгаалан нам, төрөөс улсынхаа эдийн засгийн бололцооны хэрээр өмнөд хилийг байнгын хяналтад авах эхлэлийг бүрдүүлсэн.

Хоёрдугаар шат нь: 1979-1990 оныг хамаарах бөгөөд ХЦ-ийг өргөтгөн зохион байгуулах хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд ХЦ-ийн бүтэц, бүрэлдэхүүн, тухайн үеийн шинэвтэр зэвсэг, байлдааны техник, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, сургалтын шинэ тогтолцоог төлөвшүүлэн, анги, салбаруудын байлдааны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадамжид эргэлт гаргасан оргил үе юм.

1960-аад оны эхээр дэлхийн коммунист, ажилчны хөдөлгөөнд ноцтой хагарал гарч, төр, засгийн эрх баригч намууд өөр хоорондоо сөргөлдөж эхэлсэн, тэр үеэс эхлэлтэй ЗСБНХУ, БНХАУ-ын удирдагчдын хооронд буй болсон зөрчил, үл итгэлцэх сөргөлдөөн нь бүс нутгийн цэрэг, улс төрийн байдлыг хурцатгаж, Монгол улсын гадаад бодлогод өөрчлөлт оруулахыг шаардаж эхлэсэн. ХЦ-ийг өргөтгөн зохион байгуулах гадаад хүчин зүйл нь Хятадын удирдагчид өнгөрөгч зууны тавиад оны дунд үеэс газар нутгаа тэлэхийн тулд картографын буюу зураг зүйн түрэмгийллийн аргаар зэргэлдээ улс орнуудын хилд халдаж, тухайн ард түмний оюун санаанд нөлөөлөн, бүх нийтийн анхаарлыг энэ зүг хандуулахыг эрмэлзэх болсонтой холбоотой юм.

Улс төрийн товчооны 1967 оны 25-р тогтоолд: Олон улсын байдал хурцдаж, Хятадын эрх баригчдаас тус улсын эсрэг өдөөн хатгах ажиллагаа улам хүчтэй болж байгаа үед улсын хил хязгаарыг батлан хамгаалах нь ач холбогдолтой болж байгааг онцлон тэмдэглээд өмнө зүгийн хилийн хамгаалалтыг бэхжүүлэхийн тулд бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тодорхой заалт орж, одоо байгаа пунктүүдийн хүний тоог нэмэгдүүлэх, 1968 оноос 11 застав, Ховд, Өмнөговь, Дорнод аймгуудын хилийн төлөөлөгчийн аппаратыг отряд болгон өөрчлөх, отряд бүрийг маневрлах бэлтгэл хүч, ар талын салаатайгаар байгуулах, харуулын тусгай батальоныг хилийн хороо болгох, үүний бүрэлдэхүүнд Хилийн ба ДЦ-ийн анги салбарын

бага дарга нарыг бэлтгэх сургуулийг рот болгон өргөтгөж, холбооны радистыг бэлтгэх байнгын курсыг байгуулах, Хязгаарын ба ДЦ-ийн Хэрэг эрхлэх хэлтсийг газар болгож, штаб, улс төр, холбооны хэлтэс, гүйцэтгэх тасаг, арын алба, аж ахуй, тээврийн роттойгоор байгуулж, Хязгаарын ба ДЦ-ийн орон тоог 3000 гаруй нэгжээр баталжээ. Энэ нь 10 пүнкт, 100 гаруй хүнээр хамгаалж байсан хилийн хамгаалалтыг нэмэгдүүлсэн ажил байсан төдийгүй 1970 онд УтТ-ны 21-р тогтоолд зааснаар Хязгаарын газарт командатур 2 (Дорнод, Баян-Өлгий аймгийн нутагт), застав 12-ыг нэмж байгуулах, 543 орон тоог нэмэгдүүлэх болсон.

1972 онд Хязгаарын ба ДЦ-ийн тусгай шүүх, прокурор, эмнэлгийн хөдөлгөөнт групп байгуулж, 1973-1975 онд инженер, сапёр, барилга засварын рот, бага дарга нарыг бэлтгэх сургууль, 1974 онд ХЦ-ийн тусгай дунд сургууль, Нисэх тусгай хэсгийг тус тус байгуулж, 1975 онд “АН-24” онгоц, “МИ-8” нисдэг тэргийг ЗХУ-ын тусламжаар авч, иргэний агаарын тээврийн шилжүүлэн авсан нисгэгч, техникч 15 нэгжтэйгээр нисэх холимог хэсэг болгон өргөтгөв. 1976-1978 онд баруун хязгаарт хилийн отряд нэг, застав дөрөв, Баян-Өлгий аймагт тусгай командатур, Улаанбаатар хотод холбооны батальон, Барилга инженерийн батальон, Авто батальон, биеийн тамирын ротыг байгуулж, төр засгаас отряд заставын тоог нэмэгдүүлж, хил хамгаалалтын нягтрал, хүч хэрэгслийг сайжруулсаар байлаа.

Хилийн цэргийн түүхэн дэх чухал үйл явдлын нэг нь 1973 онд БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн 161-р зарлигаар “БНМАУ-ын хил хамгаалах хууль”-ийг анх удаа баталсан нь хилчдийн эрх зүйн чадамжийг өсгөсөн явдал байлаа. Энэхүү хууль нь 3 бүлэг, 37 зүйлээс бүрдэж байсан ба зорилт нь “БНМАУ-ын хилийн халдашгүй дархан байдлыг хангаж, хилийн тогтоосон тусгай дэглэмийг хүндэтгэн сахих, БНМАУ-ын хилийн асуудлаар бусад улстай байгуулсан гэрээ хэлэлцээрийг нарын чанд биелүүлэн БНМАУ-ын хилийг зөрчилгүй байлгахад оршино” хэмээн заажээ.

Дээрх авсан арга хэмжээний үр дүнд улсын хил хамгаалалтын нягтралд өөрчлөлт орж, 1967 оны үзүүлэлтээр хилийн нэг отряд дунджаар 1168 км зурвасыг газар орны онцлогийг харгалзан 4-9 заставаар хамгаалдаг болсон нь улсын хил эзэнтэй болж, өмнөх онтой харьцуулбал застав 56 хувь, бие бүрэлдэхүүн 89 хувь тус тус

нэмэгдэж, автомат буу, пулемёт, холбооны радио станцаар зуун хувь, автомашин, уналгаар 80 хувийн хангалтад ганцхан жилийн хугацаанд хүрсэн байна.

Гэвч дайны жилүүдийнхээс застав 5 дахин, хүн хүч 4 дахин бага байсан ба орон нутгийн иргэдийн хил хамгаалалтанд татан оролцуулах Хилийн цэрэгт туслах бригадын хүчийг шаардаж байсан. Энэ ажиллагаанд хилийн отрядууд идэвхтэй ажиллан 1400 гишүүнтэй 78 ХЦТБ-ын гишүүдийг байгуулсан нь ололт байлаа. Хил хамгаалах хүчин бэхжиж хараахан амжаагүй үед Хятадын талаас 1966-1977 оны хилийн зөрчлийн дундаж нь өмнөх 25 жилийнхээс 25 хувь хүртэл өссөн байна[28].

1970 онд нэг отряд дунджаар 1000 гаран км хилийн хэсгийг хариуцаж байсан бол 1973 онд 320-350 км хэсгийн хамгаалдаг болсон хил хамгаалалтын нягтрал жилээс жилд ахиц олж байсны илрэл юм.

Цагийн байдлаас шалтгаалан Монгол улсын хилийн цэргийн бие бүрэлдэхүүний 80 хувь нь улсын хил дээр байсны дийлэнх нь өмнөд хилд төвлөрч байлаа. Ингэхдээ Хятадын хил хамгаалалтын ангиудтай харьцуулахад бие бүрэлдэхүүн, зэвсгээр манайхаас гурав дахин их байсан төдийгүй их буу огт байгаагүй байна.

1980 онд СнЗ-ийн 38-р тогтоолоор Хилийн ба дотоодын цэргийн штабын орон тоог 58 нэгжээр, ар талын удирдах газрын орон тоог 68 нэгжээр, Тусгай шүүхийг 11, Прокурорыг 15, бүгд 225 нэгжээр баталсан төдийгүй Хилийн ба дотоодын цэргийн орон тоог 14500 хүнээр батлав. 1985 онд хилийн отряд 11, хилийн застав 100 гаруй, шалган нэвтрүүлэх боомт 10, хилийн пост 21, Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн газар тавыг байгуулсан байв. Энэ хүрээнд улсын хилд 14 ангиас хоногт 800-1000 манаа үүрэг гүйцэтгэх болов. Энэ үеийг хилийн цэргийн эрдэмтэд ХЦ нь морьт цэргээс мотобуудлагын бүтэц зонхилсон цэрэг болон өөрчлөгдсөн гэж үздэг байна.

Цэргийн шинжлэх ухааны доктор, хошууч генерал П.Сүндэвийн тооцоолсноор: хилийн отрядууд 1960 оноос эхлэн хүч хэрэгсэл зохион байгуулалт боловсронгуй болсноор 1987 онд

28.Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх III.,-УБ., 2008.77-83х.,

дунджаар 430 км хэсэг хариуцан, 500-1000 хүний бүрэлдэхүүнтэй, бие даасан байлдааны хороо-бригадын зэрэгтэй анги болсон байв.

Отряд: 6-12 заставтай, төвдөө 100-250 хүртэл бүрэлдэхүүнтэй маневрын (рот) бүлэгтэй, оперативын чиглэлийн 0130, 0219, 0198 дугаар ангиуд зенит ба миномётын батарейтэй байжээ. Үүний хамт анги бүр холбоо, инженер, хими, техник, барилга, үйлчилгээний тусгай салаатай, орон тооны буудлагын нэг бүрийн ба салбарын зэвсэг хэрэглэлээр хангагдсаны дотор отряд байлдааны "БТР60 ПБ", хуягт тагнуулын "БРДМ" тус бүр 2, 15-20 хөнгөн тэрэг, 25-40 ачааны ба тусгай зориулалтын техниктэй байв.

Эдгээр нь өдөр тутмын ердийн хамгаалалтын шаардлагыг бүрэн хангахаас гадна отрядын хэсэгт эрэл зохиох, зэвсэгт халдлагыг няцаах боломжтой болж, галт хэрэгслийн зургаан ижийг нөөцөлсөн байна. Хилийн цагийн байдал эрс хурцадсан үед хилийн отрядуудын 80 орчим хувь, техник хэрэгслийн 20 хувийн хохирлыг нөхөхөд хүрэлцэхүйц нөөцийг төв агуулахад хадгалж байсан байна[29].

Үүнтэй зэрэгцэн хилийн инженерийн байгууламж нь 1970-аад оноос эхлэн хилийн хамгаалалтанд бие даасан төрлийн шинжтэй нэвтэрч орж ирсэн. Инженерийн байгууламжийн зорилго нь хилийн манаа, застав отрядаас хяналт зохиох, дотоодоос санамсар болгоомжгүй хил зөрчихөөс сэрэмжлэх, мал хил давахыг хязгаарлах, хил зөрчигчдийг төвөг багатай илрүүлэн баривчлах, манааны бие бүрэлдэхүүн, зэвсэг техникийг гэнэтийн халдлагаас хамгаалах, отрядоос застав, заставаас хилийн шугам дагуу явах техникийн туулах боломжийг дээшлүүлэх, албыг шуурхай удирдах бололцоо нөхцлийг хангах юм.

Нэн түрүүнд хилийн дагуу мөр хянах зурвас байгуулах, өргөст утсан хашаа татах, худаг ус гаргах, зам засах, жижиг гүүрүүд барих ажлуудыг хийж байв. Хилийн шугамын дагуу 3650 гаруй км, 500 метр гүнд 10 метр өргөн зурвасыг байгуулж хилийн хэсгийг 78,8 хувийг, 360 гаруй зам дээр явахыг хориглосон тэмдэг хаалт тавьсан байна. Мөн өрөө явагч шуудуу ухагч "БТМ", гүн өрөмийн худаг өрөмдөгч "УРБ-ЗАМ", богино яндант худаг өрөмдөгч "ПБУ-50", хээрийн ус хангалтын зориулалтын бүхий усыг шүүн цэвэрлэгч лаборатори иж

[29].Сүндэв.П., УБ., 2006

бүрдэл бүхий машин “МАФС”, зөөврийн, хээрийн хөрөө рам “ЛРВ”, түүний цогцолбор зөөврийн цахилгаан станц “ЭСД-75-ВС” зэргийг албанд нэвтрүүлэв. Үүний зэрэгцээ улсын хил хамгаалалтад алсыг харах цамхаг (хянах цамхаг) онцгой чухал ач холбогдолтой байв. 1967 оноос дээрээ бүхээгтэй 16-18 метр өндөр төмөр хянах цамхагийг анх босгож байсан бол нийтдээ 50 гаруйг босгосон байна.

ЗХУ-ын тусламжтайгаар холын зайд төвтэй харьцах Р-118, Р-104 радиостанц ашилаж эхэлсэн бол өдрийн цагт хяналт хийх хилийн бүх манаа Б-8, 30, ТЗК дурангаар хангагдаж, бүрэнхий цагт 60 хувь нь шөнийн харааны хэрэгсэл, прожектор, лакоторын станц ашиглаж, зэвсэглэл нь ротын пулемёт, мэргэн буудагчийн винтов, тасгийн пулемёт, грантмёт, автоматтай болсон байна.

1978-1983 онд Хилийн ба ДЦ-ийн бие бүрэлдэхүүний 80 хувь нь улсын хилд байрлаж, оперативын чиглэлийн хил хамгаалалтын нягтралыг хилийн отряд, застав нэмж байгуулснаар эрс сайжирч, нэг километрт 8 хүртэл хүн ноогдох болсон. Тухайн үед хилийн нягтралыг тасралтгүй, идэвхтэй, уян хатан зохион байгуулж, хүч, хэрэгслийг оперативын чиглэлд нягтруулан, маневрлуулж ажилласны үр дүнд хилийн зөрчлийг 100 % саатуулсан нь харагдаж байгаа юм.[30]

Энэ үед Монгол-Зөвлөлтийн хилийг найрамдлын хил гэж үзэн 1958, 1976 онд хилийн гэрээ хийн улсын хилийг баталгаажуулж, Баян-Өлгийд Цагаан-нуур, Хөвсгөлд Ханх, Сэлэнгэд Сүхбаатар, Дорнодод Эрээнцавын байцаан шалган нэвтрүүлэх салбарууд, орон нутгийн иргэдийг байршлаар нь хил хамгаалалтанд ашиглаж байсан байна. Улсын хилийг нягтруулах зорилгоор 1970-аад оны дунд үеэс Монголын талаас аймаг бүрт ялангуяа хилийн зөрчил гардаг чиглэлүүдэд хилийн 10 орчим салбарыг нэмэн байгуулсан байна.

1966 онд Ховдын отрядыг байгуулан Баян-Өлгий, Ховд, Говь-Алтайн хэсэг 1500 орчим километрыг хариуцуулж байсан бол 1972 онд Баян-Өлгийн 1-р комендатур, 1977 онд бие даалган Тусгай комендатур, 1984 онд 1-р отряд болгон, Говь-Алтай аймгийн хэсэгт мөн 5-р отрядын харьяанд 1953 онд командатур, 1977 онд отрядуудыг байгуулж, энэ хэсэгт нийт 25 застав байгуулснаар

30..Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх III., -УБ., 2008.,92,93х.,

отрядуудын хариуцсан хэсэг дунджаар 400-500 км, хилийн заставууд 35-60 км хэсгийг хариуцдаг болж хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлсэн байна.

Өмнөговь аймгийн 1100 гаран километр хэсэгт тусгай 2 пункт, 20 гаруй хүний хүчээр хамгаалж байсан бол 1975 онд Өмнөговь аймгийн төвд отряд, 7 застав, 1967 онд Овоотод нэг отряд, 7 застав байгуулж, мөн дээрх чиглэлүүдтэй адил хүн хүч техник хэрэгслээр хамгаалж байсан байна.

Хилийн 6, 7, 8 дугаар отрядуудын хариуцсан хэсэгт хилийн шугамын дагуу 700 гаруй км 78,8 хувийг 500 метр гүнд 10 метр өргөн зурвасыг байгуулж, 360 гаруй зам дээр явахыг хориглосон тэмдэг хаалт тавьсан байна. Мөн өрөө явагч шуудуу ухагч “БТМ”, гүн өрөмийн худаг өрөмдөгч “УРБ-ЗАМ”, богино яндант худаг өрөмдөгч “ПБУ-50”, хээрийн ус хангалтын зориулалт бүхий усыг шүүн цэвэрлэгч лаборатори иж бүрдэл бүхий машин “МАФС”, зөөврийн, хээрийн хөрөө рам “ЛРВ”, түүний цогцолбор зөөврийн цахилгаан станц “ЭСД-75-ВС” зэргийг албанд нэвтрүүлэв. Мөн улсын хил хамгаалалтад хянах цамхагийг 16-18 метр өндөр 14 төмөр хянах цамхагийг босгосон байна.

БНМАУ-ын өмнөд хилийг Даланзадгад-Хүрмэн, Даланзадгад-Номгон, Даланзадгад-Баян-Овоогийн чиглэлд халхлах зорилгоор тухайн үеийн БНМАУ-ын БХЯ-ны сайдын 1973 оны 8-р сарын 07-ны өдөр Ардын армийн мотобуудлагын 1 дүгээр тусгай бригадын 2-р мото буудлагын тусгай бригадыг Өмнөговь аймгийн Даланзадгад хотод байгуулах тушаал гарчээ.

Мөн агаарын хилийг хамгаалах зорилгоор зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн 148 дугаар тусгай ротыг Даланзадгад хот, 065 дугаар ангийн 104 дугаар салбарыг Хүрмэн суманд, 252 дугаар салбарыг Номгон суманд байгуулжээ.,

ЗХУ-ын тусламжтайгаар холын зайд төвтэй харьцах Р-118, Р-104 радиостанц ашилаж эхэлсэн бол өдрийн цагт хяналт хийх хилийн бүх манаа Б-8, 30, ТЗК дурангаар хангагдаж, бүрэнхий цагт 60 хувь нь шөнийн харааны хэрэгсэл, прожектор, лакоторын станц ашиглаж, зэвсэглэл нь ротын пулемёт, мэргэн буудагчийн винтов, тасгийн пулемёт, грантмёт, автоматтай болсон байна.

Дорноговь аймгийн хилийн 910 км хэсгийг хилийн төлөөлөгчийн аппарат, 2 пунктын хүчээр хамгаалж байсан бол

Эрдэнэ суманд хилийн нэг отряд, 12 застав, Сулинхээрт нэг отряд, 8 застав байгуулан хил хамгаалалтын нягтралыг нэмсэн байна.

1977 оноос орчин цагийн техник технологийг улсын хил хамгаалалтанд нэвтрүүлсэн нь локатор ба прожекторын станцын таван тоотыг суурилуулан ашиглаж 1987 онд дохиоллын “С-100”, “Скала” системүүдийг хилийн 12 дугаар отрядын хариуцсан хэсэгт ашиглаж хилийн зөрчлийг илрүүлэх чадавх 1987 оныг түрүүчийн 10 жилийн дундаж нэг жилтэй харьцуулахад гурав өсөж, шөнийн цагт хил давсан хил зөрчигчийг илрүүлэх чадвар 75%-иар өссөн байв.

“Скала” систем нь техникийн өндөр боломжтой бөгөөд 12 км хэсгийг халхалж, ажиллах найдвартай баталгаа 0,9, илрүүлэх магадлал 0,8, ашигт өгөөж нь 0,72 хүрдэг байжээ. Мөн тухайн хэсэгт үл үзэгдэх торон саад, авто машин саатуулах шуудуу зэрэг инженерийн нэмэгдэл төхөөрөмж байгуулсан нь үр дүнгээ өгч мөн “Кристал-М” дохиоллын хэрэгсэл тавьсан байна.

Улсын дорнод чиглэлд 1093,5 км хэсгийг 3 пунктын хүчээр хамгаалж байсныг 1967 онд 24-р отрядыг 10 застав, хилийн 31-р отрядыг 12 застав, хилийн 17-р отряд 1974 онд 5 заставтай байгуулагдаж 1980 онд нэмж 2 застав байгуулсан, хилийн 20-р отрядыг 1969 онд 9 заставтай байгуулагдаж хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлсэн.

БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газрын хооронд 1966 онд байгуулсан найрамдал, хамтын ажиллагааны болон харилцан туслалцах гэрээний дагуу Зөвлөлтийн Алс дорнодын цэргийн бүлэглэлийн зарим анги Монголд шилжин Дорнод, Дорноговь аймгийн хилийн ойролцоо 100-150 км-т байрлаж байсан.

Дээрх улсын хил хамгаалалтыг бэхжүүлэх ажиллагааны хүрээнд тууштай арга хэмжээ авсаны үр дүнд 1971-1975 онд хил зөрчигчийн тоо өмнөх 5 жилийнхээс 25, 1976-1980 онд 55 хувиар тус тус буурсан юм.

ДҮГНЭЛТ

Монгол улсын Хил хамгаалах байгууллагын түүхт 90 жилийн ойн хугацаанд ХЦ, Хилийн ба дотоодын цэрэг, ХЦУГ, ХХЕГ, ХХБ гэх мэтээр нэр хаяг нь өөрчлөгдөж НАХЯ, УАБХЕГ, ЗГ, БХ, ХЗДХЯ гэх мэт байгууллагын харъяанд хилийн застав, хилийн суман, хилийн отряд, хилийн хороо гэсэн бүтэц зохион байгуулалттайгаар оргил үедээ буюу 1980-1990 онуудад хүн хүч, техник хэрэгслийн хувьд

бэхжсэн харьцангуй бие даасан, маневрлах болон алба-байлдааны бэлэн байдлын зэргүүдэд шилжин ажиллахад зохицсон, дайчилгаа бүхий цэрэг, захиргаа, аж ахуйн нэгдлийн хэмжээний цэргийн байгууллага байсан бол Ардчилсан зах зээлийн харилцаанд шилжсэн шилжилтийн үед буюу 1990-оос одоог хүртэл улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, мөнгө санхүүгийн хомсдол, төрийн нүсэрдмэл бүтцийг халах гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан ХЦ-ийн байгуулалт жижгэрч зарим нэг бүтэц нэгжүүдээ алдаж, техник хэрэгсэл, хилийн инженерийн байгууламж муудаж бэлэн байдал нь алдагдсан, шаардлага хангахгүй болсон, шөнийн цагт хил хамгаалалтын нягтрал алдагдах, загварчлагдан хэлбэрдсэн хил хамгаалалт давамгайлж ХЦ-ийн хүч хэрэгсэл 2-3 дахин багассан зэргээс хил хамгаалалтын оперативын нягтрал, бэлэн байдал буурч байна.

Оперативын чиглэлийн хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх талаар судалгаа шинжилгээний ажил хийгдэж байгаа боловч хил хамгаалалтын практик үйл ажиллагаанд хэрэглээ болж чадахгүй хөрөнгө, мөнгөгүй гэсэн шалтгаанаар, оперативын урлагийн талаар мэдлэг, туршлагатай эрдэмтэдийн гаргаж ирсэн онол, нэвтрүүлж болох үнэтэй санал санаачлагыг дэмжихгүй байна.

Хил хамгаалах байгууллагаас нэн тэргүүнд хилийн оперативын урлагийг хөгжүүлэх, хилийн цэргийн ирээдүйн судлаачдад энэ талаар системтэй мэдлэг олгох шаардлага гарч ирж байна.

Ашигласан материал:

1.Монгол улсын үндсэн хууль., УБ.,1992.,
2.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.,УБ., 2010.,
3.Гадаад бодлогын үзэл баримтлал.,УБ.,2011.,
4.Төрөөс хилийн талаар баримтлах бодлого., УБ.,
5 .Монгол улсын Хилийн тухай хууль.,УБ., 2016.,
6.Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр., УБ.,2016.,
7.Дархан хил хөтөлбөр.,УБ.,
8. Цэдэн-Иш.Б., Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс.-УБ., 2003.

9.Лувсанбалдан.Э., Нэргүй.Ц., Алтангэрэл.Ч., Лхагвасүрэн.Ц., Монгол улсын хил хамгаалалтын түүх II., -УБ., 2008.
10.Наранжамц.Н.,Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам.,УБ.,2018.
11. Одбаяр.Ц., Хлийн аюулгүй байдалд учирч болзошгүй аюул, түүнээс урьдчилан сэргийлэх нь., УБ.,2018.
12.Цэвэл.Я.Монгол хэлний тайлдбар толь., УБ.,2015.
13.Ожегови.И.С. Словарь руссого языка.,Москва.,
14. The okxford Paperbeck Distionari.,US.,2012.
15.Пограничный словарь.,М.Академия ФПС России.,2002.

ХИЛИЙН АНГИ, САЛБАРЫН АЛБА ХААГЧДЫН НИЙГМИЙН СЭТГЭЛ ЗҮЙН НӨЛӨӨЛӨЛ, ШАЛТГААН, ҮР ДАГАВАР

П.Цацрал
Хилийн албаны сургуулийн
Сэтгэл зүйн тэнхимийн дэд профессор,
докторант, дэд хурандаа

Агуулга

Нэг. *Хилийн цэргийн албa хаагчдын нийгмийн сэтгэл зүйн онцлог зарим асуудал*

Хоёр. *Хилийн тусгай салбарын албa хаагчдын нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаанд хийсэн дүн шинжилгээ, шийдвэрлэх зарим арга зам*

Хураангуй. Хилчний албa нь эр зориг, хатуужил тэсвэр, эх оронч үзэл, бие дааж шийдвэр гаргах чадвар, тасралтгүй, уйгагүй үйл ажиллагаа шаарддаг төрийн тусгай албa. Өөрөөр хэлбэл хувь хүнээс хариуцлага, тэсвэр тэвчээр, эр зориг, хамт олонд эвсэн нэгдэж, удирдан зохион байгуулах олон талт харилцааны ур чадвар, хичээл зүтгэл, мэдлэг чадвар, орон зайгаас үл хамааран дасан зохицох чадамж гэх мэт олон хүчин зүйлийг даван “Хилчин” бие хүний онцлог төлөвших юм

Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, үндэсний эрх ашгийг батлан хамгаалах, илэрхийлэх гол хүчин зүйлсийн нэг нь хилчдийн сонор соргог байдал, сэтгэл зүйн бэлтгэл, сургалт, тэдний хөгжил, дэвшил юм. Бэлтгэл гэдэг цогц ойлголтод цэргийн мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар, бие махбодийн эрүүл чийрэг байдал болон сэтгэл зүйн хувьд тогтвортой, дасан зохицох чадвар /адаптаци/ сайтай байх зэрэг асуудал багтана.

Хилчдийн нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлийн нөлөөг судлан авч үзэхэд: Өнөөгийн нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөө, –Мэргэжлийн хөгжлийн сэтгэл зүйн саад, -Ажлын байрны нөхцөл, түүнээс хамаарах хүчин зүйлсийн улмаас ажлаас халшрах, залхах хам шинжүүд илрэн гарч байгаа юм. Хилчдийн ажиллаж амьдрах орчин нөхцөл, эрүүл мэнд, байгаль цаг уур, дасан зохицох чадвар гэх мэт хувь хүний болон нийгмийн хүчин зүйлс сэтгэл зүйд нөлөөлөх нь судалгаагаар гарч байна.

Хилийн анги, салбарын алба хаагчдын ажлын байрны зураглалын судалгааг сэтгэл зүйн хэв шинж, социометрийн судалгаатай харьцуулан, Хил хамгаалах байгууллагаас дэвшүүлсэн 2022, 2023 оны зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаанд дүн шинжилгээ хийж, практик жишээн дээр тулгуурлан шинжлэх ухаанчаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлэхэд уг илтгэлийн гол агуулга оршино.

Түлхүүр үг. Улсын хил хамгаалалт, хилийн анги, салбарын алба хаагчид, сэтгэл зүйн бэлтгэл, сургалт бэлтгэл, ажлын арга барил, цагийн менежмент, харилцаа, хандлага, зан төлөв, авир араншин, ажлаас халшрах хам шинж, сэтгэцийн шинж, байдал, гажилт

Оршил

Өнөөдөр олон улсын хэмжээнд Зэвсэгт хүчний, цэргийн болон цэрэгжсэн байгууллагын бие бүрэлдэхүүний өндөр ёс суртахуун, сэтгэл зүйгээр хангах асуудал хурцаар тавигдаж байна. Үүнийг зэвсэгт мөргөлдөөн дэгдэн, шатлан өргөжих аюул бүхий гадаад хүчин зүйл, мөн эх оронч үзэл, эх орныхоо өмнө хүлээх үүрэг, нэр төрийн тухай ойлголт, бие бүрэлдэхүүний ертөнцийг үзэх үзэл, цэргийн албан хаагчдын ухамсарт гарсан гүнзгий өөрчлөлт бүхий дотоод хүчин зүйлс ихээхэн нөхцөлдүүлж байна.

Зан чанар бол хүний хандлагыг тодорхойлох үндсэн хүчин зүйл юм. Өөрөөр хэлбэл хүн хүрээлэн буй орчноо хүртэн хүлээн авсаны дараа үзүүлж буй хариу үйлдэл, хүчин зүйл бөгөөд хил хамгаалах байгууллагын алба хаагчдын хувьд зан төлөв, сэтгэлзүйн онцлогоороо бусад байгууллагын алба хаагчдаас ялгарч байдаг. Цэргийн алба хаагч болсон өдрөөс эхлэн цэргийн албаны зохион байгуулалт, дүрэм журам, алба үйл ажиллагааны ачаалал зэргээс шалтгаалан сэтгэлзүйн хувьд хатуужилтай чанга болон төлөвшиж байдаг. Хил хамгаалах байгууллага нь бусад албан байгууллагаас хуулиар хүлээсэн үүрэг хариуцлага, чиг үүрэг, орчин нөхцөл зэргээрээ ялгардаг бөгөөд хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох хилийн салбарын алба хаагчдын сэтгэл зүйн ажиллах нөхцөлд эерэг, сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг судлан нэг өдрийн ажлын

зураглалд тулгуурлан дүгнэлт хийж шийдвэрлэх арга замыг тодорхойлоход чиглэсэн.

Хилчдийн сэтгэл зүйд сөргөөр нөлөөлж буй зөрчлийн шалтгааныг дурдвал: Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчид нь өдөр тутмын үйл ажиллагаандаа дотоод, гадаад хүчин зүйлээс үүдэлтэй бие махбодийн болон сэтгэл зүйн томоохон сорилтуудтай тулгарч байдаг бөгөөд хилийн отряд, застав, харуул, шалган нэвтрүүлэх цэгүүдэд хот суурин газраас алслагдсан байдал, хаалттай жижиг хүрээлэл дундах амьдрал, цаг наргүй алба, бие махбодийн байнгын ачаалал зэрэг хүндрэлтэй асуудлууд тогтмол гарч байдаг.

Хилийн цагийн байдлын талаар урьдчилан хэлэх боломжгүй, нэгэн хэвийн нам гүм байдал ямар ч үед хилийн зөрчил, мөргөлдөөн болж хувирах боломжтой.

Шалган нэвтрүүлэх цэгээр дамжин өнгөрч буй зорчигч, тээврийн хэрэгсэлтэй харилцах үед стрессийн байдал бий болох явдал цөөнгүй бөгөөд хилийн цэргийн алба хаагчдын хувьд стрессээ тайлах боломж бага байдгаас ядаргаа, сэтгэл зүйн дарамт өдрөөс өдөрт хуримтлагдсаар эцсийн дүндээ бие махбодид нь сөргөөр нөлөөлдөг байна.

Хилийн заставын амьдралын өвөрмөц нөхцөл, цэргийн алба хаагчид, дарга, цэрэг, хамт олны хоорондын харилцаа, нийгмийн жижиг бүлэг /гэр бүл/ зэрэг нь цэргийн алба хаагч “хилчин бие хүн” бий болоход ихээхэн нөлөө үзүүлдэг.

Хилийн застав, хилийн харуулд цэргийн алба болон аж ахуйг зохион байгуулахдаа дээрх стресээс үүдэлтэй зөрчил болох “Хил хамгаалалах аюулгүй ажиллагааны заавар”-ын шаардлагыг зөрчих, гаж буруу уламжлалыг хөхүүлэх, архидалт, хэлбэрдэлт, хүнд сурталтай тэмцэхгүй байх нь “хилчин бие хүн” буруу төлөвших, зарим нэгэн цэргийн алба хаагчдад нийгэмд аюултай буруу чиг хандлага төлөвшихөд хүргэдэг.

Тиймээс та бидний хамтын зорилго болох “хилчин бие хүн”-цэргийн алба хаагчдын сэтгэл зүйг төлөвшүүлэх, тэдгээрт сэтгэл зүйн хангалтыг зохион байгуулах нэгдмэл зорилго, чиглэл бүхий үйл ажиллагаа явуулж байгаа нь өнөөдөр бидний сургалт, эрдэм шинжилгээний ажлын агуулга, чиглэлийг зангидаж байгаа гэж ойлгож болно.

Уг илтгэлийн гол агуулга: Хилийн анги, салбарын алба хаагчдын талаарх дараах зангилаа асуудлыг тойрон хөндсөнд **шинэлэг тал нь** оршиж байгаа юм. Үүнд:

Алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх хэрэгцээ байна. Алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэхийн тулд уламжлалт сургалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дээрх асуудлууд шийдвэрлэгдэхгүй.

Асуудал бүр, өөрөөр хэлбэл ёс зүйн зөрчил, тааламжгүй харилцаа, зохимжгүй үйлдэл болгон усны эх, модны үндэс лугаа дор бүрдээ учир шалтгаантай. Асуудлын шалтгааныг олж илрүүлээд шалтгаанд суурилсан мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх цогц сургалтын хөтөлбөрийг оролцооны аргаар хэрэгжүүлснээр хилийн цэргийн алба хаагчийн ёс зүй, харилцаа, хандлагыг дээшлүүлэх боломжтой гэж үзсэн.

Нэг. Хилийн цэргийн алба хаагчдын нийгмийн сэтгэл зүйн онцлог, сэтгэл зүйн бэлтгэл олгох зарим асуудал.

Сэтгэл зүйн бэлтгэл гэдэг нь эх орон, ард түмэндээ өргөсөн тангарагтаа үнэнч байж, шаардлагатай тохиолдолд албаныхаа эрх ашигт өөрийн мэдлэг, чадвар, авьяас билэг, оюун ухаан амь насаа ч зориулахад бэлэн байх сэтгэцийн бэлэн байдлыг хэлнэ.[31]

Улсын хил хамгаалалтын үеийн сэтгэл зүйн хангалтын үндсэн зорилго бол: Хил хамгаалах албан үүргээ биелүүлэх явцад хилчид, цэргийн алба хаагчдын сэтгэл зүй, сэтгэл санааг үүрэг биелүүлэхэд бэлэн тогтвортой байх явдал юм.

Улсын хил хамгаалалтын **сэтгэл зүйн хангалт нь:** цэргийн хангалт, удирдлагын нэг хэлбэр бөгөөд үүссэн цагийн байдлын ямар ч үед хилчид сэтгэл зүйн хувьд бэлэн, тогтвортой байдлаа хадгалж, цэргийн сургалт, байлдааны ямар ч нөхцөлд үүргээ биелүүлэх бэлтгэлжилт, сэтгэл зүйг бүрдүүлэн төлөвшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ юм.

Цэргийн бие хүний сэтгэл зүйн бэлтгэл, тогтвортой байдалд **нөлөөлдөг хүчин зүйлсийг** авч үзэхдээ гурван бүрдэл хэсэгт хуваадаг.

1.Бие хүний хувийн ухамсар, төлөвшил

2.Нийгмийн орчин, нөлөөлөл

---

[31] Гүржав С. Цэргийн хамт олон, ёс суртахуун сэтгэл зүйн ажлын зарим арга хэлбэрүүд. УБ.,2002, 28-р тал.

3.Цэргийн сургалт, бэлтгэлийн үйл ажиллагаа юм.

Цэргийн сэтгэл зүй нь цэргийн албаны өвөрмөц нөхцөлүүдэд байгаа хүний сэтгэц, мөн тэрчлэн цэргийн хамт олны санаа сэтгэл юм. Хүний сэтгэц бол хүний сэтгэлийн хөдлөлт, бодол санаа, үг яриа буюу бусад нөхөдтэй харилцах харилцаа, зан үйл, үйл ажиллагаанд илэрч байдаг хүний субьектив дотоод ертөнц мөн.

Хилчдэд өндөр тэсвэр хатуужил, сэтгэл зүйн бэлтгэл төлөвшүүлэх үндсэн арга нь сургалт юм. Хилчин хүний хөдөлмөр нь өвөрмөц, өөрийн гэсэн онцлогтой, өндөр хариуцлага, сахилга, дэг журам шаарддаг, цаг агаар байгаль, газар орны хүнд нөхцөлд цагийн байдлын өрнөлтөн дунд явагддаг тул энэ бүхнийг даван туулах чадварыг хилчдээс шаарддаг. Энэ шаардлагын нэг гол үндэс нь хилчдийн сэтгэл зүйн бэлтгэл болдог.

Хил зөрчигчидтэй тулгарах, цагийн байдал хүндэрсэн үед үүрэг гүйцэтгэх хилчдэд ямар нэгэн зохих хэмжээнд айдас байдаг. Энэ айдас нь хувь хүний хүмүүжил, онцлог, сэтгэл зүйн бэлтгэлээс хамааран харилцан адилгүй байдаг. Уг айдсаа хэрхэн жолоодож тухайн үед өөрийгөө ялан дийлж чадах вэ? гэдгээс их зүйл хамаарах болно. Энэ утгаараа сэтгэл зүйн бэлтгэл гэдэг нь уг айдсыг давж чадах сэтгэл зүйн чадвар гэж үзэж болох юм.

Хилчдийн сэтгэл зүйд нөлөөлөх олон хүчин зүйлүүдийн дотроос хилчдийн сэтгэл зүйн бэлтгэлийг хэрхэн хангаж болох:

Нэгдүгээрт: Хилчдэд албаных нь онцлог, эх орноо хамгаалах шаардлагыг зөв ойлгуулах итгэл үнэмшил болгох

Хоёрдугаарт: Өөрийн айдсыг даван туулах чадварыг хилчдэд эзэмшүүлэх

Гуравдугаарт: Аливаа бэрхшээлийг давж чадах, сэтгэл санааны хүмүүжил олгох явдал бол хилчдийн сэтгэл зүйн хувьд албанд нь бэлдэх гол үндсэн чиглэл мөн.[32]

Үүний тулд даргалах бүрэлдэхүүн хүнтэй ажиллахдаа:

-Итгүүлэн үнэмшүүлэх

-Хувийн үлгэр дууриал

-Дасгах

-Үзүүлэх

-Урамшуулах

[32] Мөн тэнд. 49-р тал.

-Албадах аргуудыг хэрэглэх бөгөөд хооронд нь зөв хослуулбал зохино.

Хилийн албанд гүйцэтгэх үүрэг нь тухайн хүнээс янз бүрийн боломжийг шаардана. Өөрөөр хэлбэл тухайн нэг албан үүргийг гүйцэтгэхэд темпраментын онцлогоос хамаарч түүний биелэлтийн эцсийн үр дүн нь янз бүр байж болох юм. Жишээ нь: Заставын холбоочин удаан хугацаагаар холбооны аппаратын дэргэд сууж, нэгэн хэвийн ажлыг олон цагаар хийхэд хүрдэг. Ийм ажилд тэсвэр хатуужил, өөр зүйлд анхаарал татагдахгүй биеэ барих чадвар сайтай дайчид хэрэгтэй болдог. Ийм ажил флегматик темпраментын хүнд тохиромжтой юм. Мөн жолооч хүнд хурдан реакц, шаламгай хөдөлгөөн шаардагдана. Энэ чанар сангвиник хүнд илүү байх жишээтэй.

Ялангуяа хилийн заставт хилийн манааны бүрэлдэхүүнд орох хилчдийг сонгон авахдаа темпраментын онцлогыг харгалзан үзэх нь чухал юм. Хэрэв ингэж чадвал бидний амьдралд тохиолдлоод байгаа /энгийн харилцааны зөрчлөөс авахуулаад бие биенийхээ амь насыг хөнөөх хүртэл сахилга, ёс зүйн зөрчлүүд/ нийгэм сэтгэл зүйн сөрөг үзэгдлийг зохицуулах олон хүчин зүйлүүдийн нэг нь байж болох юм.

Хилчин дайчдын сургалтын процесст олгох мэдлэгийг хүлээн авах боломж чадвар нь темпраментаас хамаардаг болохыг сэтгэл зүйчид тогтоосон байна. Иймд хичээлийг зохион байгуулахдаа холерик темпраменттай дайчдын ачааллыг байнга нэмэгдүүлж байх шаардлагатай. Флегматик темпраменттай дайчдад бүхий л материалыг хичээлийн явцад бүрэн ойлгуулахыг хичээх хэрэгтэй. Холерик дайчдыг байнга дэмжиж тэдний зориг итгэлийг төрүүлэхээр ажиллавал зохино.[33]

Хүмүүжлийн ажилд тэр тусмаа дайчидтай зохиох нэг бүрчилсэн хүмүүжлийн ажилд темпраментийн онцлогийг харгалзан үзэх нь ихээхэн ач холбогдолтой. Энэ нь офицер хүнд хүмүүжүүлэх зөв үр нөлөө бүхий аргыг сонгон авахад дөхөм болдог. Тухайлбал, холерик темпраменттай дайчдыг байнга өөрийн хяналтанд байлгах шаардлагатай. Тэдэнд огцом ууртай байдлаар хандвал мөн тийм маягаар хариу үйлдэл илэрхийлж болзошгүй. Тэдний албаны болон

[33] Эрдэнэбаатар Д. Хилчдийн сэтгэл зүйг судлах арга замууд. УБ.,1990, 42-р тал.

цэргийн тангараг дүрмийн заалтанд хайнга хандсан, зөрчил дутагдал гаргасан тухай бүрд нь байнга хэлж хариу нөлөө ямагт үзүүлж байх шаардлагатай.

Зан төлөв, темпрамент, сэтгэцийн онцлогийг таньж мэдсэний гол ач холбогдол нь ЦАХ-ын сургалт-хүмүүжлийн ажлын өгөөж үр нөлөөг дээшлүүлж бие хүн, хамт олныг удирдахад шинжлэх ухааны үндэслэлтэй хандаж байгаад оршино.

Цэргийн бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн бэлтгэлийг явуулахдаа нэн тэргүүнд түүнийг бүрдүүлэгч элементүүдийг тодорхойлж, бүрдэл хэсгүүдэд бүлэглэн авч үзэх шаардлагатай. Үүнд:

1. Мэдрэхүйн болон сэтгэл санааны бэлэн байдал
2. Ёс суртахуун, итгэл үнэмшлийн төлөвшил
3. Цэргийн мэргэжлийн бэлэн байдал, ур чадвар
4. Цэргийн болон байлдааны үйл ажиллагаанд сэтгэл зүйн хувьд бэлэн тогтвортой байх явдал юм.[34]

Сэтгэцийн бэлэн, тогтвортой байдал тодорхой хэмжээгээр алдагдах нь цэргийн үйл ажиллагаанд маш ноцтой хохиролд хүргэж болно. Цэргийн зориг мохож, сэтгэлээ барьж чадахгүй, хэт догдолсноос анхаарал төвлөрч чадахгүй, дохионд түргэн зөв хариу өгөх чадваргүй болж, байдлыг үнэлж цэгнэх боломжгүй болно.

Дараах хүчин зүйлүүдийг харгалзан үзэж хөгжүүлсэн нөхцөлд сэтгэл санааны хэвийн ажиллагааны найдвар нэмэгдэнэ. Үүнд:

- Мэдрэх эрхтэнүүдийн мэдрэмтгий өндөр чанар, хариу үйл хурдан зөв зохистой байх, хөдөлгөөн ба үйл ажиллагааны хүч, зохицуулалт, тогтвортой чанарыг эзэмшүүлэх,
- Байлдааны ажиллагааны явцад орон зай, цаг хугацаа, объектын том жижиг, хөдөлгөөний хурдыг тогтвортой зөв үнэлэх авьяас чадварыг хөгжүүлэх,
- Байлдаанд цэргийн албан хаагчдын анхаарлын багтаамж, түүний тогтвортой чанарыг хангаж, анхаарлыг үндсэн үйл ажиллагаан дээр төвлөрүүлэхийн зэрэгцээгээр хуваарилах, хурдан шилжүүлэх зэрэг чанарыг эзэмшүүлэх,
- Юмс үзэгдлийн нийлбэр цогцыг хамарч чадах олон талын төсөөллийг бий болгож бэхжүүлэхийн зэрэгцээгээр байлдааны үед үр өгөөж, түргэн санах, цээжлэх, зөв сэргээн бодох зэрэг ойн

---

[34] Мягмаржав Г. Сэтгэл зүйн бэлтгэл. УБ.,2005, 5-р тал.

[10] Банзрагч Б. Цэргийн сэтгэл судлал. УБ.,1989, 926-р тал.

оператив чанар, материалыг ой ухаанд удаанаар хадгалах сэтгэхүйн уян хатан, хурц сэтгэх зэрэг чанаруудыг улам дээшлүүлэх гэх мэт.

Мэдрэмж нь сэтгэцийн тэсвэр хатуужлыг төлөвшүүлэх нь урт удаан хугацааны байлдааны ажиллагааны явц дахь ажиллах чадварыг хадгалахад чухал ач холбогдолтой юм. Энэхүү чадварыг төлөвшүүлэх гол хэрэглүүр бол олон өдрийн хээрийн сургууль юм.

Сэтгэлийн хөдөлгөөн нь хүний танин мэдэх үйл ажиллагааны явцад үүсэж хөгжих, эргэж танин мэдэх үйл ажиллагааны хөгжилд нөлөөлж байдаг онцлогтой. Сэтгэлийн хөдөлгөөн нь сэтгэл хөдлөл, сэтгэл мэдрэмж гэсэн хоёр үндсэн процесстой. Сэтгэл мэдрэмж нь хүний хийж үйлдэж, танин мэдэж байгаа ба түүнийг хүрээлэн буй бүх зүйлд хандах хандлагад илрэх сэтгэл догдлол бөгөөд сэтгэл хөдлөл нь энэ мэдрэмжийн илрэлийн хэлбэр юм.

Түүнчлэн эдгээр сэтгэлийн хөдөлгөөний сөрөг үзэгдэл нь хүний зохион бодохуйн процесст хүчтэй нөлөөлснөөр хүн бодит байдлыг хэтрүүлэн үнэлэх, хүртэхүйн алдаа эндэгдэлд хүргэж цаг хугацаа орон зайн баримжаагүй болох нь маш ноцтой байдалд хүргэж болзошгүй. Хэрвээ цэрэг, байлдааны ажиллагааны үед дайчдад ийм зүйл тохиолдвол айдас, түгшүүр тэднийг эзэмдэж орчны байдлыг зөв үнэлэн ухаарах, эр зориг овсгоо самбаа гаргах зэрэг идэвхит байдал алдагдаж болох үндэстэй юм.

Үүрэг даалгаврыг гүйцэтгэх сэтгэлийн тэнхээ, түүний зайлшгүйг ухамсарлаж ойлгосон байдал нь сэтгэл зүйн дотоод бэлэн байдалд эерэгээр нөлөөлнө.

Харин удирдах албан тушаалтны хувьд цагийн байдлыг зөв үнэлэх, оновчтой шийдвэрийг гаргах, байлдааны ажиллагааны тактик, стратегийг боловсруулах, өөрийн удирдлагад байгаа хүмүүсийг удирдлага зохион байгуулалтаар хангах, сэтгэл зүйн нөлөөлөл үзүүлэх зэрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно.

Цэрэг дайчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийг хангах асуудал нь салбарын өдөр тутмын үйл ажиллагаатай холбоотой. Өөрөөр хэлбэл цэргийн албан хаагчийн өдөр тутмын үүрэг, даалгавар, сургалт, харуулд гарах, жижүүрлэлт, галын бэлтгэл, тактикийн бэлтгэл, бие бялдрын бэлтгэл зэрэг нь сэтгэл зүйн тодорхой нэг чиг зорилтыг хангаж байх ёстой.

Бүлгийн бүтэц, бүрэлдэхүүний хувьд бие хүний нийлэмжийн төвшин, үзэл бодол, асуудлыг шийдвэрлэхэд оролцох хандлагыг

хамааруулдаг. Янз бүрийн шинж чанар, зан төлөвтэй хүмүүсээс бүрдсэн бүлгийн ажлын үр дүн, нэгэн төрлийн үзэл бодолтой хүмүүсээс илүү болох нь судалгаагаар нотлогдсон ажээ. Тодруулбал:

Хүмүүсийн хүртэхүй, анхаарал, ой тогтоолт, сэтгэхүй, хувийн онцлог нь обьектив ертөнцийн юмс үзэгдлийн тусгай шинжийг танин мэдэхэд хүмүүст тусалдаг байна. Жишээ нь: Зарим хүн мэдээлэл сайтай байхад зарим нь хийсвэр сэтгэхүй илүү хөгжсөн, нөгөө хэсэг нь илүү их зориг, тэвчээртэй, сэтгэлийн хөдөлгөөнтэй байдаг нь бүлгийн янз бүрийн нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэх, шийдвэр гаргахад тус болдог байна.

Энэ үүднээс авч үзэхэд цэргийн албан хаагчдыг ямар ч зэрэглэл, зан төлөвийн онцлог байдал, мөн бүлгийн бүтцийн зохистой хэмжээг харгалзан үзэлгүйгээр дурын байдлаар бүлэглэх нь бүлгийн ажиллах чадвар, үүрэг даалгавар биелүүлэх бэлтгэлийн төвшин, хамт олны дотоод уур амьсгалд ихээхэн сөрөг нөлөө үзүүлж болдог байна.

Бүлгийн сэтгэл зүйн бэлэн байдлыг хангахын тулд:

-Бүлгийн нэгдэл, нягтралыг идэвхжүүлэх үйл ажиллагааг тогтмол явуулж байх

-Сэтгэл зүйн бэлтгэлийг хангах сургалт явуулахдаа хүн нэг бүрийн сэтгэл зүй, зан төлөвийн онцлог байдалд тохируулах,

-Бэлтгэлийг байлдааны бодит нөхцөлтэй аль болохоор ойр нөхцөл байдалд хийлгэж байх,

Цэрэг, дайчид байлдааны үүрэг даалгаврыг бүлгээр гүйцэтгэх чадвартай байхын зэрэгцээ ганцаарчилсан үүрэг, даалгаврыг мөн гүйцэтгэх чадвартай байх ёстой. Энэ ойлголтод цэргийн мэргэжлийн бүрдэл хэсгээс гадна:

1. Байгаль, гадаад орчин, цаг уурын хүнд нөхцөл байдалд үүрэг гүйцэтгэх чадвартай байх,
2. Амьдрах /амьд гарах/ ухаанд суралцсан байх
3. Цагийн байдлыг зөв үнэлж, шийдвэр гаргах чадвартай байх зэрэг ойлголтуудыг багтааж болно.

Цэргийн сэтгэл зүйн бэлтгэлийг хангах асуудлууд бие бүрэлдэхүүнийг байлдааны ажиллагааны орчинд дасан зохицох буюу “адаптаци” ихээхэн үүрэгтэй байдаг. Энэ нь байлдааны

ажиллагаанд биеийн болон сэтгэлзүйн талаар бэлэн байна гэсэн үг буюу бидний ярьдаг “цагийн байдалд орох” гэдэгтэй утга ижил юм.

Байлдааны ажиллагаанд оруулах гэж буй цэргийн албан хаагчийн сэтгэл зүйг тайван цагт хангах буюу сэтгэл зүйн хангалт гэж юу байх талаар баримтлах зарчмын гол асуудлууд дараах байдлаар илэрхийлэгддэг.[35]

1. Хамт алба хааж байгаа бүрэлдэхүүндээ итгэлтэй байх зарчим.
2. Зэвсэгтээ итгэлтэй байх зарчим.
3. Дарга нартаа итгэх зарчим зэрэг болно.

Хилчдийн нийгэм-сэтгэл зүйн хүчин зүйлийн нөлөөг судлан авч үзэхэд: Өнөөгийн нийгэм-эдийн засгийн сөрөг нөлөө, –Мэргэжлийн хөгжлийн сэтгэл зүйн саад, -Ажлын байрны нөхцөл, түүнээс хамаарах хүчин зүйлсийн улмаас ажлаас халшрах, залхах хам шинжүүд илрэн гарч байгаа юм. Эдгээрийг онолын үүднээс судалж, практик судалгаан дээр буулган цаашид даван туулах арга замуудыг тодорхойлох нь зүйтэй юм.

Ажил мэргэжлээс шалтгаалсан сэтгэл зүйн сөрөг өөрчлөлтүүд: Ажиллах нөхцөл нь хортой биш боловч мэргэжлийн үйл ажиллагааны онцлог нь хүний сэтгэл зүйг гэмтээх /нэгэн хэвийн, өндөр хариуцлага шаарддаг, байнгын осол гэмтэлд өртөх магадлал бүхий, сэтгэцийн өндөр ачаалалтай гэх мэт/ нөлөө үзүүлж байдаг. Олон жил нэг ажлаа тасралтгүй хийх нь ажлаас залхах, ядрах, сэтгэл зүйн саад бэрхшээл үүсэх, мэргэжлийн чадвар дадлаа алдах, ажиллах чадвар буурахад хүргэдэг.[36] Ажилтанд өөрт нь болон ажлын бүтээмж, бусад хүмүүстэй харилцах харилцаанд нь сөргөөр нөлөөлдөг өөрчлөлтүүд илэрдэг.

ОХУ-ын эрдэмтэн А.К.Маркова ажил, мэргэжлээс шалтгаалан хувь хүнд сөргөөр нөлөөлөх дараах өөрчлөлтүүдийг тодорхойлсон.[37] Энэ нь:

-Насны болон социаль хэм хэмжээтэй харьцуулахад мэргэжлийн хөгжил удаашрах, хоцрох;

-Мэргэжлийн ухамсар, хариуцлага уналтад орох, түүнээс улбаалсан зөрчил үүсэх;

---

[35] Баярсайхан Д. Сэтгэл зүйн хямрал. Цэргийн шинэчлэл сэтгүүл. УБ.,2004, №4
[36] Артамонова В.Г. Профессиональные болезни: учебник. Москва.,1988, 416 с.
[37] Маркова А.К. Психология профессионализма. Москва.,1996, 308 с.

-Хөдөлмөрийн шинэ нөхцөл байдалд дасан зохицох чадваргүй байдал;

-Мэргэжлийн хөгжлийн бүрдэл хэсгүүд зөрчилдөх. Жишээ нь ажиллах чадвар байсан ч хийх хүсэлгүй болох, хийх хүсэл байсан ч чадвар дутах гэх мэт;

-Мэргэжлийн чадвар буурахад

-Мэргэжлийн хөгжлийн чиглэл гажих, мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлдөг зан төлөвийн шинжүүд илрэх;

-Мэргэжлээс шалтгаалсан үйл байдлын өөрчлөлт илрэх /ажлаас халшрах хам шинж г.м/;

-Мэргэжлээс шалтгаалсан өвчлөл, хөдөлмөрийн чадвар алдсаны улмаас мэргэжлийн хөгжил зогсонги байдалд орох.

Эдгээр өөрчлөлтүүд нь тухайн ажилтны дасан зохицох чадвар, сэтгэл зүйн тогтвортой байдал, үйл ажиллагааны бүтээмжид сөргөөр нөлөөлдөг. Өөрчлөлт үүсэх шалтгаан нь ихэнхдээ нэгдүгээрт, тухайн мэргэжлийн онцлог, нэр хүнд, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал. Хоёрдугаарт, хувь хүний болон мэргэжлийн онцлогийн харилцан үйлчлэлээс шалтгаалсан өөрчлөлт. Гуравдугаарт, байгууллага, удирдлагын үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан өөрчлөлтүүд байдаг.[38]

Бодит амьдрал дээрх ажил мэргэжлийн талбар нь мэргэжлийн боловсрол дөнгөж эзэмшсэн төгсөгчдийн төсөөллөөс эрс ялгаатай. Ажлын байранд хөл тавьж байгаа шинэхэн мэргэжилтэнгүүдийн хувьд хамгийн эхний бэрхшээл нь ажиллах арга барилаа олох байдаг. Бүтэлгүйтэл, сөрөг сэтгэл хөдлөл, урам хугаралт нь шинэхэн мэргэжилтнийг мэргэжлийн үйл ажиллагаанд дасан зохицох чадваргүй байдлыг үүсгэдэг. Мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх явцад нэг л үйлдэл, ажиллагаагаа дахин дахин давтдаг. Ихэнх тохиолдолд мэргэжлийн үйл ажиллагаа, үйлдлийг хэрэгжүүлэх хэвшил тогтох нь гарцаагүй зүйл байдаг. Энэ хэвшил нь хөдөлмөрийн үйл ажиллагааг хөнгөвчилж, хийх ажлыг илүү тодорхой болгохоос гадна хамт ажиллагсадтайгаа харилцах харилцаанд эерэг нөлөө үзүүлдэг.

---

[38] Сыманюк Э.Э. Психологические барьеры профессионального развития личности. Москва.,2005, 252 с.

Тодорхой нэг мэргэжлийн үйл ажиллагааг олон жил гүйцэтгэхэд бий болох сөрөг нөлөө нь бүтээмжид муугаар нөлөөлж, тухайн мэргэжилтэнд байж боломгүй сэтгэл зүйн шинжүүд үүсч, мэргэжилтний үйл байдлыг өөрчлөлтөд оруулдаг. Үүнийг сэтгэл судлалд **“Мэргэжлээс шалтгаалсан үйл байдлын өөрчлөлт”** гэж нэрлэдэг. Ихэнх судлаачид мэргэжлээс шалтгаалсан үйл байдлын өөрчлөлтийг дараах 4 төвшинд хуваажүздэг:

-Ерөнхий мэргэжлийн үйл байдлын өөрчлөлт буюу тодорхой нэг мэргэжлийн хүрээнд нийтлэг үүсдэг үйл байдлын өөрчлөлт.

-Тусгай мэргэжлийн үйл байдлын өөрчлөлт. Тодорхой нэг мэргэжил дотроо нарийн мэргэших үед үүсдэг үйл байдлын өөрчлөлт.

-Сэтгэцийн шинж болон мэргэжлийн үйл ажиллагааны онцлогоос шалтгаалсан үйл байдлын өөрчлөлт. Хувь хүнд тогтвортой илэрдэг сэтгэцийн шинжүүд, тухайлбал, темперамент, зан төлөв, авьяас, чиг хандлагын өвөрмөц онцлогууд нь мэргэжлээрээ олон жил ажиллах явцад сэтгэл зүйн бусад шинжээс хурцадмал хэлбэрээр илрэх байдал.

-Ажилтны хувийн онцлогоос шалтгаалсан үйл байдлын өөрчлөлт. Тухайлбал, олон жил тухайн мэргэжлээр ажиллахад мэргэжилд чухал чанар хэтийдсэн, хэвийн хэмжээнээс хэт рүү байдлаар илэрч хурцадмал шинжтэй болж эхэлдэг.

Мэргэжлээс шалтгаалсан өөрчлөлтүүдийг хэрхэн залруулах вэ? Дээр дурдсан ажил мэргэжлээс шалтгаалсан сөрөг нөлөө, үйл байдлын өөрчлөлтийг залруулах арга зам нь хувь хүний сэтгэл зүйн онцлогоос шалтгаалах боловч сэтгэл судлаачид дараах нийтлэг арга замыг зөвлөдөг. Үүнд:

-Харилцааны болон мэдлэг, чадвар, дадал, хандлагын нийцтэй байдлыг дээшлүүлэх;

-Мэргэжлийн сэтгэл судлаачид хандаж мэргэжлээс шалтгаалсан сөрөг нөлөө, үйл байдлын өөрчлөлтийг оношлуулах, тэдгээрийн даван туулах төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллах;

МЭРГЭЖЛИЙН ХЯМРАЛЫН СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ, ДАВАН ТУУЛАХ НЬ

д/д	Хямрал	Хямралыг бий болгогч хүчин зүйлс	Хямралыг даван туулах аргууд
1.	**/14-18 нас/** Мэргэжил сонгоход тулгарах сургалт-мэргэжлийн чиг баримжааны хямрал	-Мэргэжилд чиглэсэн сонирхолоо тодорхойлж чадахгүй байх. -Өөрийн сэтгэл зүйн онцлогоо харгалзахгүй мэргэжлээ сонгох. -Нөхцөл байдлаас шалтгаалан мэргэжил сонгох.	Ажил мэргэжлийн чиг баримжааг шинжлэх ухааны үндэстэй олгох, мэргэжлийн сэтгэл зүйчээс зөвлөгөө авах. Мэргэжилд чиглэсэн хүсэл сонирхол, чадвар, чадавхиа тодорхойлох.
2.	**/18-21 нас/** Мэргэжлийн боловсрол эзэмших үеийн мэргэжил сонголын хямрал	-Сурч буй мэргэжилдээ дургүй болох. -Амьдралын нийгэм-эдийн засгийн нөхцөл өөрчлөгдөх.	Суралцах-танин мэдэхүйн үйл ажиллагаандаа идэвхтэй оролцох. Суралцах-мэргэжлийн үйл ажиллагааны сэдлээ өөрчлөх
3.	**/18-23 нас/** Мэргэжилд дасан зохицох үе шатны мэргэжлийн хүлээлтийн хямрал	-Мэргэжилдээ дасан зохицоход хүндрэл үүсэх, -Шинэ голлох үйл ажиллагаа эзэмших, -Мэргэжлээрээ ажиллаж эхлэхэд хүлээлт /Төсөөлөл ба бодит байдал нийцэхгүй байх/.	Хүч чармайлтаа нэмэгдүүлэх эсвэл мэргэшиж ажиллах чиглэл, мэргэжлээ солих
4.	**/30-33 нас/** Мэргэжиж хөгжих эхний үе шатны мэргэжлийн хүлээлтийн хямрал	-Мэргэжлийн өсөлт, эзэлж буй албан тушаалдаа сэтгэл ханамжгүй байх, -Мэргэжилтний хувьд өөрийгөө батлах хэрэгцээ давамгайлах, энэхүү хэрэгцээг хангахад бэрхшээлтэй тулгарах.	Мэргэжил дээшлүүлэх, нийгэмд чиглэсэн мэргэжлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх. Ажлын байраа солих.
5.	**/38-40 нас/** Мэргэжиж хөгжих II үе шатны мэргэжлийн карьерийн хямрал	-Мэргэжлийн байр суурь албан тушаалдаа сэтгэл ханамжгүй болох, -Мэргэжлийн үйл ажиллагааны давамгайлах үнэт зүйл өөрчлөгдөх.	Ажлын чанар, гүйцэтгэл, бүтээмжийг нэмэгдүүлэх өөрийн гэсэн арга барилыг хөгжүүлэх, Шинэ мэргэшил эзэмших, мэргэжил дээшлүүлэх.
6.	**/48-50 нас/** Мэргэжлийн ур чадвар эзэмших үе шатны өөрийгөө идэвхжүүлэхтэй холбоотой үүсэх хямрал	-Мэргэжлийн үйл ажиллагааны хүрээнд үүссэн тодорхой нөхцөл байдлыг шийдвэрлэх боломжгүйдэх сэтгэл ханалуун бус байх, -Мэргэжилтний хувьд өөрийн эзэмшиж буй байр суурьтаа сэтгэл дундуур байх, -Эрүүл мэндийн байдал муудах, психофизиологийн өөрчлөлтүүд гарах, -Мэргэжлээс шалтгаалсан үйл байдлын өөрчлөлтөд орох.	Үйл ажиллагааны гүйцэтгэлээ шинэлэг, бүтээлч төвшинд хүргэх.
7.	**/55-60 нас/** Мэргэжлийн үйл ажиллагаанаас хөндийрөх үеийн хямрал	-Тэтгэвэрт гарч, мэргэжил-нийгмийн харилцааны хүрээ хумигдах, -Эрүүл мэндийн байдал муудах, психофизиологийн өөрчлөлтүүд гарах	Амьдралын шинэ хэв маягт сэтгэл зүйгээ бэлтгэх, нийгэмд тустай олон нийтийн үйл ажиллагаанд тогтмол оролцож, нийгмийн идэвхтэй байх

-Хувь хүний болон ажил мэргэжлийн хөгжлийн дасгалжуулалтад хамрагдах;

-Мэргэжлийн өсөлт хөгжлийн нарийвчилсан төлөвлөгөө боловсруулах;

-Шинээр ажилд орж буй залуу мэргэжилтэнүүдэд ажил, мэргэжилдээ дасан зохицох чадварыг нь дээшлүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

-Сэтгэл хөдлөлөө удирдах, мэргэжлээс шалтгаалсан сөрөг нөлөө, үйл байдлын өөрчлөлтийг бие даан даван туулах арга замыг зааж өгөх, чиглүүлэх;

-Ажилтнуудыг тодорхой чиглэлээр мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх, карьерийн хөгжлийн замналаа тодорхойлоход нь туслах, чиглүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлдэг. /Хавсралт 1/

Ажлаас халшрах, залхах, ажлын идэвхийг үнэлэх, тодорхойлох нь: Хэдийгээр ажлаас халшрах байдлыг олон янзаар тодорхойлдог боловч өнөөгийн судлаачдын дунд хамгийн их ишлэгддэг тодорхойлолт нь Маслач, Жексон, Лейтер нарын: **“Ажлаас халшрах нь ихэнхдээ “Хүнтэй ажилладаг” үйл ажиллагааны салбарынханд тулгардаг ажилтны хувийн амжилт буурах, “өөрийн биш, бодит биш” болох сэтгэл хөдлөл туйлдах хам шинж”** хэмээх тодорхойлолт юм. Энэ тодорхойлолтод ажлаас

халшрах хам шинжийг хэмжих гурван үзүүлэлтийг тодорхойлсон байгаа юм.

Нэгдүгээрт, сэтгэл хөдлөлийн туйлдал гэдэг нь хүмүүс хоорондын харилцаанд нэн шаардлагатай сэтгэл хөдлөл үгүй болох гэсэн утгыг илэрхийлдэг.

Хоёрдугаарт, өөрийн биш, бодит биш болох хам шинж /depersonalization/ гэдэг нь харилцаж байгаа, үйлчлүүлж байгаа хүмүүстээ сөрөг, цэвдэг хүйтэн, эрээ цээргүй харилцах байдал.

Гуравдугаарт, хувийн ололт амжилтгүй байдал гэдэг нь ажилтан өөрийн хийж байгаа ажилд сөргөөр хандах хандлага юм. Ажлаас халшрах хам шинжтэй мэргэжилтнүүдийн хувьд тэдний ажил ямар нэгэн утга учиргүй, үр дүнгүй санагдахаас гадна мэргэжлийн чадварын хувьд өөрийгөө голох байдлаар илэрдэг мэргэжлийн өөрийн хүндэтгэл маш доогуур байдаг. Өөрөөр хэлбэл:

Сэтгэл хөдлөлийн туйлдал: тодорхой шалтгаангүйгээр сульдах

Эрээ цээргүй байдал: ажилдаа хөндий хүйтэн, сэтгэлгүй, ялгаваргүй хандах хандлага

Мэргэжлийн үйл ажиллагааны үр дүнгүй байдал: Хувь хүний болон нийгмийн үйл ажиллагааны хүрээн дэх үр дүн, үр нөлөөгүй байдал.

Сэтгэл зүйн хувьд эдгээр гурван бүрэлдэхүүн хэсэг нь хоорондоо холбоотой. Сэтгэл хөдлөлийн туйлдал нь ажил дээрх стресс үүсгэгчид тухайлбал, ажлын хэт их ачаалал, сэтгэл хөдлөлийн хэрэгцээ хангагдахгүй байх, хувь хүмүүсийн хоорондын зөрчил зэргээс үүсдэг. Энэ тохиолдол ажилчид өөрийн сэтгэл зүйг хамгаалахын тулд ажлаасаа оюун санааны хувьд хөндийрүүлэн тусгаарлаж, хүнийрхүү, эрээ цээргүй хандах хандлагатай болдог. Ингэснээр тэдний ажлын гүйцэтгэл багасч, улмаар ажлаа хийх чадваргүй, үр дүнгүй болсон мэт мэдрэмжийг мэдэрч эхэлдэг. Судлаачдын үзсэнээр ажлаас халшрах хам шинж дундажаар 2 жил үргэлжлэх бөгөөд 35-45 насны эмэгтэйчүүд болон эрчүүдэд ажлаас халшрах хам шинжийн өндөр төвшин илэрдэг.

Ажлын байрны сайн сайхан байдлын янз бүрийн хэлбэр, тухайлбал ажлаас халшрах, залхах болон идэвх оролцоог сэтгэл хөдлөлийн тойрог загвараар дүрсэлж болно. Энэхүү загвар нь хүний

бүх сэтгэл хөдлөлийг таашаал авахаас дүргүйцэх, идэвхтэйгээс идэвхгүй болох хүртэл хоёр туйлт хэмжигдэхүүнээр тодорхойлдог.[39]

Ажлын байрны сайн сайхан байдлын таксономи:[40]

Ажлаас халшрах, залхах, идэвх оролцооны шалтгаан:

Ажлаас халшрахад нөлөөлдөг тоон болон чанарын хүчин зүйлс, шаардлагуудыг судлаачид ялгаж тодорхойлсон байх нь түгээмэл:

Тоон үзүүлэлтээр хэмжиж болох хүчин зүйлс:

-Ажлын хэт их ачаалал,

-Давчуу хугацаанд гүйцэтгэх шаардлага,

-Ажлын цаг урт байх,

-Иргэд-үйлчлүүлэгчтэй байнга харилцах шаардлага зэрэг үзүүлэлтүүд байдаг.

Харин чанарын үзүүлэлт талын нөлөөлөх хүчин зүйлс нь:

-Ажил үүргийн уялдаа холбоогүй, зөрчилтэй байдал,

---

[39] Батболд Ш. Амьдралын психологи II: Ажлын байр, нийгмийн сэтгэл зүй. УБ.,2022, 83-р тал.

[40] Russell, J.A. /1980/. A circumplex model of affect. Journal of Personality and Social Psychology, 39, 1161-1178.

-Тухайн ажил үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай мэдээлэл тэнцвэргүй, зөрчилтэй байх,

-Сэтгэл хөдөлгөсөн нөхцөл байдал,

-Ажил – гэр бүлийн тэнцвэргүй байдал зэрэг хүчин зүйлс, шаардлагын нөлөөгөөр ажлаас халшрах хам шинж үүсдэг байна..

Дээрх хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс ажилтнууд хүчин чармайлтаа тасралтгүй нэмэгдүүлэх нөхцөл байдал үүсч улмаар энэ нь тэдний хүчийг шавхаснаар ажлаас халшрал үүсдэг.

Ажлаас халширахад юу нөлөөлдөг вэ?

Ажлын шаардлагатай холбоотой хүчин зүйлс:

-Ажлын хэт ачаалал

-Цаг хугацааны дарамт

-Ажлын цагийн үргэлжлэх хугацаа

-Харилцаж байгаа хүмүүсийн тоо

-Ажил үүргийн тэгш бус хуваарилалт /үүрэгт нийцэхгүй байх/

-Ажил – гэр бүлийн тэнцвэр алдагдах

Ажлын нөөцтэй холбоотой хүчин зүйлс:

-Хамт олон, удирдлагын дэмжлэг байхгүй

-Эргэх холбоо байхгүй

-Шийдвэр гаргалтад оролцуулдаггүй

-Ажилд тавих хяналт сул

Ажлаас халшрах ямар үр дагавартай вэ?

Ажилтанд үзүүлэх сөрөг нөлөө:

-Байнгын түгшүүр /сэтгэл гутрал

-Зүрх судас /мэдрэлийн гаралтай өвчлөл

-Нойрны хэм алдагдал, халшрал

Байгууллагад нөлөөлөх сөрөг нөлөө:

-Оролцоо /хувь нэмэр үгүй болох

-Өвчлөл /таслалт/ хийдүүлэлт нэмэгдэх

-Бүтээмж /гүйцэтгэл буурах

<u>Үр дагавар:</u>

-Осол /гэмтэл

-Архи, тамхины хэт их хэрэглээ

-Ажил дээр бие өвдсөн мэт санагдах

-Ажлын байран дээрх хорт үйл байдал /хулгай хийх, цаг нөгцөөх, хов ярих/

Ажилтны идэвх оролцоонд нөлөөлдөг хүчин зүйл бол:

Ажлын идэвх оролцоо нь ажилтнуудад үүрэг хариуцлага хүлээхэд бэлэн, санаачлагатай, тууштай байдал зэрэг эерэг үйл байдлыг бий болгож ажилдаа хандах эерэг хандлагыг төлөвшүүлэхэд чухал үүрэгтэй.

Сорилт ба боломж:

-Сонирхол /чадварт тохирсон ажил/ ачаалал

-Шуурхай гүйцэтгэх шаардлага

-Хариуцлага

-Танин мэдэхүй /оюун санааны хувьд хөгжих боломж

Ажлын нөөц /боломж:

-Байнгын тогтмол хяналт

-Социаль дэмжлэг

-Гүйцэтгэлийн эргэх холбоо

-Олон талт үйл ажиллагаа

-Хувь хүний хувьд хөгжих боломж зэрэг нь тухайн албан хаагч, ажилчдад нийгмийн сэтгэл зүйн эерэг нөлөө үзүүлдэг байна.

Хоёр. Хилийн салбарын алба хаагчдын нийгмийн сэтгэл зүйн хандлагад нөлөөлж буй хүчин зүйлсэд хийсэн дүн шинжилгээ

Хил хамгаалах ерөнхий газрын захиалгаар 2022 оны 04 сард 3а/803 тоот албан тоотын дагуу “Хил хамгаалах байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангахад нөлөөлж буй хүчин зүйлс” сэдвийн хүрээнд Хилийн цэргийн тусгай салбарын алба хаагчдын ажлын цаг ашиглалт, амралт, ачааллын тэнцвэртэй байдал, тэдний сэтгэл санаа, албандаа хандах хандлага болон ажиллаж, амьдрах орчинд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсэд дүгнэлт хийх, цаашид авах арга замыг эрэлхийлэхэд уг судалгааны зорилго чиглэгдсэн.

Судалгааны бүтэц: Уг судалгааг “Сэтгэл зүйн хангалтын дамжаа”-нд суралцсан Хилийн 23 ангийн, 57 хилийн тусгай салбарын орлогч, офицерууд болон тухайн салбарт ажиллаж буй ахлагч, гэрээт хилчид, төрийн үйлчилгээний алба хаагч гэсэн 180 гаруй бүрэлдэхүүнийг хамруулж, тэдний нас, хүйс, гэр бүлийн байдал, ажилласан жил, хувь хүний сэтгэл зүйн болон зан төлөвийн онцлог, ажил, албанд сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйл, давуу ба сул талыг хамгийн ачаалалтай ажилладаг 1 өдрийн зураглал дээр тулгуурлан гаргаж дүгнэлт хийсэн. Энэхүү илтгэлийн агуулгад 3 бүлэг судалгааны дүнг нэгтгэж оруулсан бөгөөд 1/ сэтгэл

зүйн, 2/ ажлын байрны зураглал, 3/ ХХБ-ын зорилтыг хэрэгжүүлэхэд нөлөөлж буй хүчин зүйлсийн судалгаа зэрэг болно.

Судалгааны арга зүй: Анкетийн, асуулгын, социометрийн /хүчин зүйлийн болон сэтгэл ханамжийн судалгаа/, темпраментийн хэв шинжийг тодорхойлох Г.И.Айзенкийн сорил, дасан зохицох чадварын судалгаа, сэтгэл гутралыг тогтоох тест, ой тогтоолтыг тодорхойлох сорил зэргээр судалгаа авч, нэгтгэж, дүгнэсэн.

Судалгааны үндэслэл: Хил хамгаалах байгууллага үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтыг тасралтгүй зохион байгуулахын тулд хилчдийн гэр бүлийн тогтвортой байдлыг хангах нь нэн тэргүүний чухал асуудлын нэг юм. Гэр бүлийн харилцаа тогтвортой, гэрээ зассан алба хаагч гэрээсээ гараад ажлаа амар тайван, чин сэтгэлээсээ үр дүнтэй, бүтээмжтэй хийж чаддаг. Хилчдийн гэр бүлийг тогтвор суурьшилтай ажиллуулах тэдний нийгмийн баталгааг хангах талаар “Хилчдийн нийгмийн хамгаалал-2024” болон “Хилийн тухай хууль”-д заасан байдаг ба ХХБ-аас 2022 онд “Дархан хилийн албанд итгэл дүүрэн, сэтгэл хангалуун хилчин” зорилт дэвшүүлэн ажиллаж байна.

Хилийн салбарын бие бүрэлдэхүүн нь хил хамгаалалтын үндсэн хүч бөгөөд офицер, ахлагч, хугацаат болон гэрээт цэргийн албан хаагчид, энгийн ажилтнуудаас бүрдэнэ.

Хилийн салбарын офицеруудыг хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах, хилийн шугам, тэмдэг манааны үүрэг гүйцэтгэлт, холбооны шугам, инженерийн байгууламж шалгах, харуул манаа ахлах, заставын бие бүрэлдэхүүн болон хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг сургах, дадлагажуулахад ашиглана.

Ахлагч, түрүүч, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдыг заставын жижүүрт томилох, харуул манаа ахлуулах, хилийн манаа, холбооны шугам, инженерийн төхөөрөмжүүдийг шалгуулах, бүх төрлийн манаанд үүрэг гүйцэтгүүлнэ.

Хилийн салбарын жагсаалын дарга, албаны нохой сургагч, жолооч, холбоочин нарыг хил хамгаалалтад ашиглахдаа тэдний үндсэн ажлын ачааллыг харгалзана.

Ажилд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлс: Ажлын байрны стресс, цалин хөлс, гэр бүлийн үл ойлголцол, техник технологийн дутмаг байдал, ажлын орчин-нөхцөл, удирдлагын

бодлого шийдвэр, хувийн зохион байгуулалт, эрүүл мэндийн байдал, улирал цаг агаар зэрэг бусад хүчин зүйл.

Судалгааны үндсэн боловсруулалт. Судалгааны үндсэн боловсруулалтад Хилийн тусгай салбарын офицер, ахлагч, үйлчилгээний ажилтан нийт 180 алба хаагчдын ажлын байрны зураглалд тухайн салбарт ажиллаж буй Сэтгэл зүйн хангалт эрхэлсэн орлогч нарын хамт судалгаа хийж, “Сэтгэл зүйн хангалтын дамжаа”-ны мэргэшүүлэх сургалтын үеэр бүс бүсээр хэлэлцүүлэн, ялгаатай ба төсөөтэй талыг нэгтгэн, агуулгын хувьд онцгойлох, болон ойролцоо байдлаар ангилан боловсруулж, дараах кейсүүдийг сонгон авч илтгэлдээ тусгасан. Хилийн анги салбарын ажлын цагийн хуваарь, хүн хүчний тоо нууцлалтай тул судалгаанд ерөнхий байдлаар оруулсан болно.

<u>I-судалгааны дүгнэлт:</u> /алба хаагчдын төлөөлийн судалгааг кейс болгож оруулав./

2018-2021 онд Хилийн цэргийн .... дүгээр ангийн ..... дугаар салбарт сургалтын орлогчоор ажиллаж байгаад 2021 оноос хилийн цэргийн ..... дугаар салбарт шилжин томилогдон одоог хүртэл тус албан тушаалаар ажиллаж байна.

Темпраментийн хэв шинжийг тодорхойлох Г.И.Айзенкийн сорилоор судлахад флегматик буюу тайван дөлгөөн темпраменттэй, интроверт хэв шинжийн хүн юм. Түгшүүр огт үгүй, түүний ердийн байдал тайван, орчиндоо чимээгүйхэн таашаал авдаг. Тэдэнд зан байдлын шинэ хэлбэр удаан бий болдог. Гэхдээ тогтвортой. Ихэвчилэн жигд тайван байдаг. Бухимдал үүсч хяналтгүй болох нь ховор. Нөхцөл байдлаас болж зарим тохиолдолд флегматикуудад тэсвэр, гүн сэтгэлгээ зэрэг сайн талууд бий болдог бол зарим тохиолдолд сул, хүрээлэн буй орчиндоо идэвхи оролцоогүй, сэтгэлийн тэнхээгүй байх шинж бий болдог.

График 1 Сэтгэцийн процесс:



Ой ухааны чадамж: Тухайн алба хаагчийн сэтгэцийн процессийг судлах зорилгоор оюун ухааныг чадамжыг түүний хэв шинж бүрээр тооцож гаргасан дээрх графикаас үзэхэд энэ судлуулагчийн хувьд логик чадамж, харилцааны чадамж, дотроо тунгаах чадамж, бие бялдарын чадамжууд нь илүү хөгжсөн бол хэл ярианы чадамж, хөгжим мэдрэмжийн чадамж тийм ч сайн хөгжөөгүй нь харагдаж байна. Энэхүү үр дүнг үнэн гарсан эсэхийг магадлан тухайн судлуулагчийн хувийн онцлогийг харьцуулан үзэхэд тухайн алба хаагч бүрэг, үг дуу цөөтэй, даруу төлөв байдаг нь судалгааны үр дүнтэй нийцэж байгаа нь харагдаж байна.

Дасан зохицох сорил: Судлуулагчаас 23 асуулга бүхий дасан зохицох чадварын арга зүйг ашиглах судалгааг авахад алба хаагч дасан зохицох дундаж чадвартай гэсэн үнэлгээрээр дүгнэгдсэн. Үүнд: Намайг уурлуулахад амархан, ялихгүй шалтгаанаар миний сэтгэл зовдог, ямар нэг зүйлд миний сэтгэл хурдан түгшдэг, хүлээх хэрэгтэй болоход би бухимддаг, бэрхшээлээс зайлсхийдэг гэсэн асуултуудад тийм гэж хариулсан нь судлуулагчийн дасан зохицох чадвар дундаж байгааг харуулж байна.

Сэтгэл гутралыг тогтоох тест: Н.Векийн судалгааны ажлыг ашиглан Судлуулагч нь сэтгэл гутрал байхгүй гэж дүгнэгдсэн.**Үндэслэл нь:** Би өөрийгөө бүтэлгүй гэж боддоггүй, бусад хүмүүстэй харьцуулахад дутуу биш, хуучин шигээ нойрондоо сайн байгаа, өмнөх шигээ шийдвэр сайн гаргаж байгаа гэсэн хариултуудыг авч үзэхэд ажилдаа сэтгэл хангалуун, ямар нэгэн зүйлийг хүндээр тусгаж авдаггүй өөртөө итгэлтэй байдал ажиглагдаж байгаа нь сэтгэл гутралын шинж байхгүй болохыг харуулж байна. /алба хаагч бүрийн сэтгэл зүйн картыг хилийн анги, салбарууд дээр хөтөлдөг./

<u>II-судалгааны үр дүн:</u> Хилийн салбарт үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаас ажлын хамгийн ачаалалтай үеийн ажлын байрны 1 өдрийн зураглалыг авахад офицерын хувьд салбарын эргүүлд гарч буй өдөр болон долоо хоногийн ... гаригт, ахлагч нарын хамгийн ачаалалтай өдөр бол салбарын жижүүрт гарах өдөр болон ... гараг буюу тавиулан аж ахуйн өдөр зохион байгуулагддаг үе, төрийн үйлчилгээний ажилтан цэргийн гал тогоонд ээлжинд гарах өдөр буюу эрүүл мэндийн өдөр зохион байгуулагддаг Мягмар гараг хамгийн их ачаалалтай байдаг гэж тус тус асуулгад оролцсон.

Албаны үйл ажиллагааг зохион байгуулж явуулахдаа цаг ашиглалтанд хяналт тавих, төлөвлөлтийн ажлыг сайтар хийж, амралт ачааллыг тэнцвэртэй зохицуулж ажиллах шаардлагатай гэсэн дүгнэлт гарсан.

Түүнчлэн хилийн цэргийн салбарын офицерууд нь бүх үйл ажиллагаанд биечлэн оролцохоос гадна хяналт тавин ажилладаг, ажил хавсарган гүйцэтгэдэг, бичиг баримт боловсруулах шаардлагатай байдаг тул ажлын цагт өөрчлөлт орж сунгагдаж, нэмэлт цагаар өдөр бүр ажилладаг тухай дурдсан.



Хилийн цэргийн салбарын ахлагчийн нэг өдрийн ажлын цагийн график



Харуулын дарга нар нь хилийн салбарт ажлын цаг бага, тодорхой ажлуудад хамрагдаад чөлөөт цаг гардаг тул хилийн салбарт чөлөөт цаг гэр бүлдээ зарцуулах цаг харьцангуй их гардаг.

Гэрээт хилчдийн хангалт дутмаг байгаа учраас гэрээт хилчдийн ажлын ачаалал нэмэгдэж, гэрээ цуцлах, ээлжийн амралт чөлөө хэтрүүлэх зэрэг асуудлууд үүсч байна.

Хилийн цэргийн салбарын үйлчилгээний ажилчдын нэг өдрийн ажлын цагийн график



Хилийн салбарт үйлчилгээний ажилчид 3-4 хоногт 1 удаа ээлжинд гардаг. Ээлжинд гарахаас бусад өдөр хийгдэх ажил байвал хийгээд ажлаа хийж дууссан бол амралт, гэр бүлдээ цагаа зарцуулдаг.

Хилийн цэргийн салбарын бие бүрэлдэхүүний нэг өдрийн ажлын цаг ашиглалтын судалгаа



<u>III-судалгааны үр дүн:</u> ДХИС дээр “Сэтгэл зүйн хангалтын дамжаа”-нд хамрагдсан 23 ангийн 57 хилийн тусгай салбарын Сэтгэл зүйн хангалт эрхэлсэн орлогч нараас 1-хилийн заставын үйл ажиллагаа, 2-ажлын байрны дарамт, нөлөө, 3-ажлын байрны дарамт, хүчирхийллийн ойлголт, 4-хөдөлмөрийн хүрээний суурь зарчмын талаар, 5-албан хаагчийн ёс зүйн нийтлэг асуудал, 6-удирдах зарчим гэсэн 6 бүлэг асуулгаар судалгааг авч, онцлон үзэх шаардлагатай зүйлүүдийг нэгтгэхэд:

Хилийн заставын үйл ажиллагааны талаар:

1.3. Ажил үүргийн тэгш бус хуваарилалт танай салбарт ямар хэлбэрээр илэрдэг вэ?

- Ээлжийн амралт авсан албан хаагчийн ажил орлон гүйцэтгэх нөхөн хангамж үгүй-2
- Сар бүрийн шалгалтад бэлтгэх ажлын давхцал их, долоо хоногийн ажил төлөвлөгөөт цагийн хуваарийн дагуу явагддаггүй.
- Хилийн салбарууд дээр мал аж ахуй давхар явагддагаас
- Тусгай мэргэжлийн албан тушаалд ажиллаж байгаа алба хаагчдын ачаалал харуулчдынхаас их байдаг
- Төрөл садангийн байдал
- Мэргэжлийнх нь дагуу ажиллуулах аль эсвэл тэр албан тушаал дээр ажиллахаар болбол мэргэшүүлэх шаардлагатай-2
- Орон тоо дутуу, олон хүний ажлыг 1 хүн хийдэг-5
- Ажил хийдэг нь байнга ямар нэгэн байдлаар бүх ажилд оролцдог, юм хийж чаддаггүй нь ажилд оролцдоггүй. Салбарын захирагч нээх их юм хийдэггүй.
- Шинэ болон хуучин ажиллаж байсан гэдгээр тэгш бус хуваарилдаг.





Үгүй /үгүй бол яагаад/ Орчин бүрдээгүй, хүлээж авдаггүй учир хэлсэн хэлээгүй ялгаа байхгүй, зөрчил маргаан үүсдэг нэг нэгнээ сонсдоггүй.

1.7. Таны албан тушаалдаа тогтвор суурьшилтай ажиллахад сөргөөр нөлөөлдөг хүчин зүйлсийг бичнэ үү?

- Хэт алслагдсан байдал, тог цахилгаан, гэр бүл, үр хүүхэд-3
- Гэр бүлийн хүнийг орон нутагт ажиллуулдаггүй.
- Хүний нөөцийн бодлого зохицуулалт, буруу томилолт
- Төрийн үйлчилгээний ажилтан нар үүргээ мэдэхгүй
- Санхүүгийн байдал, техник тоног төхөөрөмж, бичиг хэргийн хангалт муу, ангиас ирэх бүлгийн дарамт шахалт, албаны ачаалал, эд материал-4
- Албан тушаалтан удирдлагууд залуу боловсон хүчнээ дэмждэггүй, дарамтлах
- Нэг албан тушаалаар удаан жил ажиллах

• Удирдлагын дээрэлхүү, дарангуй харилцаанаас болж алба хаагчид өөрийн үзэл бодлоо удирдлагад чөлөөтэй хэлэх боломж хомс

АЖЛЫН БАЙРНЫ ДАРАМТЫН НӨЛӨӨ:



2.4. Алба хаагчдын ажлын гүйцэтгэл?



2.5. Алба хаагчдын сэтгэл ханамж?



2.6. Та шаардлагатай үедээ эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай авч чаддаг уу?



2.7. Танд албан үүргээ гүйцэтгэхэд санхүүгийн ямар хүндрэл тулгардаг вэ?



Ажиллах орчинд нөлөөлөх хүчин зүйлс:

Гадаад хүчин зүйлс:

-Дэндүү хийсвэр, бодит бус, нийтэч байж чаддаггүй хандлагатай. Заримдаа өөрийгөө ухаарах чадвараараа сэм бахархдаг учраас бардам юм шиг харагдах үе байдаг.

-Албанд хөтлөгдөх бичиг баримт их.

-Ажил дуусгахдаа хөнгөн хандлагатай.

-Хөдлөшгүй итгэл үнэмшил болон халуун сэтгэлээр өөрийгөө илэрхийлдэг сэтгэлгээний удирдагчид олон байдаг.

-Сэтгэлээ хэр барагтаа хуваалцаж чаддагүй.

-Дотоод сэтгэлдээ зөрчил ихтэй байдаг.

-Нэг л зүйлд анхаарлаа хандуулж, эргэн тойрныхоо хэрэгцээг анхаарахгүй байх магадлал өндөр.

Дотоод хүчин зүйлс:

-Хүн болон эд зүйлст бодитой, ухаалгаар хандах чадвартай.

-Өрөвч зөөлөн сэтгэлтэй, бусад хүмүүст анхаарлаа ихээр хандуулдаг, эв нэгдлийг чухалчилдаг.

-Тэвчээртэй, ажиглах болон шууд ухаарах чадвартай, хүн чанар сайтай.

-Дулаахан сэтгэлтэй, чимээгүй өөртэйгөө холбоотой ажил болон хүний талаар хариуцлага өндөртэй, үнэнч.

-Цалин хөлснөөс илүүгээр өөрийн сонирхлыг харж ажил хийдаг.

-Хүнийг ойлгох, хүн хамгаалалттай холбогдох салбарт ажиллах дуртай.

-Бусад хүмүүсийн бодол болон үзэл санааг дэмжихэд анхаарал тавьдаг бөгөөд хамт олныхоо төлөө бусадтай адил үзэл бодолтой байдаг.

-Бусад хүмүүсийг өөртэйгөө адил хэмээн хүлээн авах хандлага ихтэй байдаг.

-Дотоод итгэл үнэмшил хүчтэй.

ДҮГНЭЛТ

Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй хилчид нь өдөр тутмын үйл ажиллагаандаа дотоод, гадаад хүчин зүйлээс үүдэлтэй бие махбодийн болон сэтгэл зүйн томоохон сорилтуудтай тулгарч байдаг бөгөөд хилийн отряд, застав, харуул, шалган нэвтрүүлэх цэгүүдэд хот суурин газраас алслагдсан байдал, хаалттай жижиг

хүрээлэл дундах амьдрал, цаг наргүй алба, бие махбодийн байнгын ачаалал зэрэг хүндрэлтэй асуудлууд тогтмол гарч байдаг.

Цэргийн алба хаагчдын сэтгэцийн байдал нь гадаад дотоод орчин нөхцөл, амьдралын хэв маяг, нийгмийн хангамж үйлчилгээ зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан тогтсон байдаг. Цэргийн албаны өвөрмөц нөхцөл байдал, цагийн хуваарь үйл ажиллагаа, цэргийн сургалт бэлтгэл, аливаа хүндэрсэн цагийн байдал нөхцөлд ойртуулсан дасгал сургуулилт, тусгай үүрэг гүйцэтгэх, өссөн төрсөн нутаг орноосоо хол алба хаах зэрэг зөвхөн цэргийн алба хаагчдад тохиолддог. Амьдралын хэв маяг нь тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлогч үзүүлэлт гэж хэлж болно. Цэргийн үүрэг албаны хариуцлагыг гүнзгий ухамсарласан ухамсар, цэргийн сэтгэл зүйн бэлтгэл, сэтгэл зүйн хангалтын явцад тэдний сэтгэл зүйн байдал эерэг агуулгаар тогтох хамгийн гол хүчин зүйл болж байдаг байна. Юуны өмнө цэргийн анги, байгууллагад цэргийн албыг зохион байгуулах зааврын дагуу сайн зохион байгуулагдсан алба, ахуйн нөхцөлд, цэргийн сургалт бэлтгэл, цэргийн алба хаагчдын ар гэрийн ая тухтай амьдрах орчин цэргийн хөдөлмөрийг үнэлэх нийгмийн үнэлэмж, цалин хөлс зэрэг нь сэтгэцийн байдалд нөлөө үзүүлдэг.

Хилийн салбарт ажилаж амьдрахад стресс багатай, залуу гэр бүлийн хувьд мөнгөн хуримтлал үүсгэхэд хамгийн давуу тал болдог бөгөөд гэр бүлээрээ ажиллахад хамгийн тохиромжтой ажиллах орчинд эерэгээр нөлөөлдөг. Салбарт ачаалалтай үе цөөнгүй байдаг ба орон тоо дутмаг хангалтгүй учир хийсвэр ачаалал их ирдэг нь сөргөөр нөлөөлдөг. Үүнээс шалтгаалан ар гэртээ гаргах цаг хомс учир гэр бүлийн маргаан гардаг гэж дүгнэгдэж байна.

Үүнээс дүгнэхэд алба хаагчдын, офицерийн бүрэлдэхүүн ажилдаа бага хэмжээгээр халшрах шинж тэмдэг ажиглагдасан ба

ахлагчийн зүгээс дундаас дээгүүр сэтгэл ханамжтай байдаг, харин төрийн үйлчилгээний алба хаагч ажлаас халширсан хам шинжэд өртөх магдлалтай байгаа нь судалгааны дүнгээс харагдаж байгаа ба энэхүү байдал удаан үргэлжилвэл ажлын үр дүн буурах, үйл ажиллагаа доголдох, ажлын эрч хүчийг бууруулах зэрэг сөрөг үр дүн гарах юм.

Хилийн салбарын өдөр тутмын үйл ажиллагаа хэвийн хэмжээнд явагддаг боловч хамгийн гол ачаалалтай өдөр нь шалгалтын болон бусад бүлэг ажиллахад эмэгтэйчүүд болон бусад үйлчилгээний ажилчид илүү ачаалалтай байдгийг дурджээ. Түүнчлэн үйлчилгээний ажилчдын хувьд ажлын байрны тодорхойлолтод заасан үүрэгт ажлаас гадна заставын аж ахуйн ажил болох зөөлөн эдлэлийн урсгал засвар, цагаан идээ боловсруулалт, байр орчны цэвэрлэгээ үйлчилгээ, нийтээр тэмдэглэх баяр ёслолын үед ширээ засч хоол хийх гэх мэт үүргийг давхар гүйцэтгэх шаардлага тулгардаг нь ажлын ачааллыг нь нэмэгдүүлж заставын ажлаас халшраах асуудал бий болгож болзошгүй.

Хил хамгаалах байгууллагын тулгуур бүрэлдэхүүн болсон хилийн анги, салбарын алба хаагчдын ажлын байрны нийгмийн сэтгэл зүйд нөлөөлж буй хүчин зүйлсийг нарийвчлан судалж ажлаа зохион байгуулах шаардлага байгааг дээрх судалгаанд тодорхой харуулж байна.

Цаашид алба хаагчдын нийгмийн сэтгэл зүйг тогтвортой байлгахад харгалзан үзэх шаардлагатай олон асуудал байгаа бөгөөд тухайлбал, эрүүл мэндийн асуудлыг нэгдүгээрт тавих, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ажлын байрны сэтгэл ханамжийг дээшлүүлэх, үр хүүхдийн сурах орчинг бий болгох, цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулах, */хүүхдийн тоог үл харгалзан сургуулийн өмнөх боловсрол олгох/* мөн орчин үеийн техник технологийн дэвшлийг нэвтрүүлэх, хүч хэрэгслийг сайжруулах, тог сүлжээний асуудлыг шийдвэрлэж өгөх зэрэг нэн тулгамдсан асуудлууд байгаа юм.

Цаашид авч хэрэгжүүлэх арга зам:

-Алба хаагчдыг илүү цагаар ажиллуулах, албан үүргийн хувьд хавсран гүйцэтгүүлэх асуудал гаргуулахгүй байхад анхаарах.

-Энэхүү байдал нь даамжирсаны улмаас алба хаагчдын ажлын бүтээмж буурах, ажлын ачааллаас шалтгаалж бие бүрэлдэхүүн албанаас няцах, шантрах асуудлууд гарч болзошгүй.

-Тиймээс алба хаагчдын орон тоог нэмэгдүүлж хүний нөөцийг бүрдүүлэх, алба хаагчдын ажлын байрны тодорхойлолтуудыг бодит байдалтай уялдуулан шинэчилж өөрчлөх талаар санал оруулах.

-Зарим тохиолдолд гадаад болон дотоод нөлөөллийн хүчин зүйлүүд алба үйл ажиллагаанд нөлөөлдөг. Мөн түүнээс үүссэн ажлын байрны ачаалал нь хэт их болж, алба үйл ажиллагаа саармагжих, ажлын бүтээмж буурах эрсдэл ихсэж болзошгүй учир бие бүрэлдэхүүний мэдлэг боловсрол, ур чадварыг дээшлүүлэх сургалт дамжаануудад идэвхтэй хамруулах, сэдэлжүүлэх сургалтыг цахимаар болон бүлгээр явуулж хэвших.

-Түүнчлэн бие бүрэлдэхүүний ажиллаж, амьдрах орчинг сайжруулж, ая тухтай байдлыг дээшлүүлэх, нийгмийн баталгаа, эрх зүйн зүйн чадамжийг дээшлүүлж, цалин нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Санал: Хилчин бие хүн-цэргийн алба хаагчдын сэтгэл зүйг төлөвшүүлэх, сэтгэл зүйн бэлтгэл олгоход нийгмийн сэтгэл зүйн болон газарзүй, мөн гадаад, дотоод хүчин зүйлийн нөлөөллийг нарийвчлан судлан тодорхойлох, сэтгэл зүйн судалгааг бүсчлэлээр нь хийж, албанд харгалзан үзэж арга, аргачлал боловсруулах, онцлогт тохирсон нэгдсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх шаардлага байна.

ДХИС-ийн ХАС-ийн Сэтгэл зүйн тэнхимээс 2022 онд 2 удаа зохион байуулсан “Хилийн салбарын сэтгэл зүйн хангалт эрхэлсэн орлогч нарыг мэргэшүүлэх дамжаа”-д суралцагсдаас судалгаа авч үзэхэд 80 гаруй хувь нь өөр мэргэжлээс хөрвөсөн, давтан болон мэргэшсэн дамжаанд анх удаа сууж буй офицеруудаас бүрдэж байсан бөгөөд тэдний өөрсдийн салбарт ажиллах мэргэжлийн сэтгэл зүйчийн мэргэжил, мэдлэг, ур чадвар дутмагийн улмаас өөртөө итгэлтэй ажил үүрэг гүйцэтгэхэд учир дутагдалтай байдаг талаар дурдсан байсан. Судалгаанд оролцогчид цаашид энэ чиглэлийн сургалтыг ХХЕГ-ын мэргэжлийн хэлтсээс ДХИС-ийн Хилийн албаны сургуулийн Сэтгэл зүйн тэнхим дээр түшиглэн бусад мэргэжлийн сэтгэл зүйчид бэлтгэдэг сургууль, судалгааны төвүүдтэй хамтран ажиллах, сургалтанд суух, мэргэжил дээшлүүлэх сонирхолтой байгаа тухай сэтгэл ханамжийн судалгаанд 90 гаруй хувь нь санал өгсөн байсныг дурдаж, цаашид ажил хэрэг болгох нь зүйтэй байна.

Хилийн албаны сургуулийн Сэтгэл зүйн тэнхимээс дангаараа болон захиалагч агентлаг болох ХХЕГ-тай хамтарсан төгсөгчдийн мэдлэг мэргэжил, ур чадварын судалгаа, ХХБ-ын алба хаагчдын сэтгэл ханамжийн судалгаа, сахилга, ёс зүй, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгааг сүүлийн жилүүдэд тогтмол явуулж, мэргэжлийн хэлтэстэй хамтран захиалгат сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулж, 2 удаагийн сургалтыг амжилттай зохион байгуулж төгсгөөд байна. Үүний үр дүнд дээрх судалгаанууд хийгдэж, цаашид явуулах төлөвлөгөөт ажлууд болон, сургалтын хөтөлбөрт тусгах хичээлийн агуулгыг сайжруулахад чиглэсэн ажлууд шат дараатай зохион байгуулагдаж байгаа юм.

Ашигласан материал:

1. Гүржав С. Цэргийн хамт олон, ёс суртахуун сэтгэл зүйн ажлын зарим арга хэлбэрүүд. УБ.,2002.
2. Эрдэнэбаатар Д. Хилчдийн сэтгэл зүйг судлах арга замууд. УБ.,1990.
3. Мягмаржав Г. Сэтгэл зүйн бэлтгэл. УБ.,2005.
4. Банзрагч Б. Цэргийн сэтгэл судлал. УБ.,1989.
5. Цэдэн-Иш Б. Дархан хилийн домогт сургамж. УБ.,1978.
6. Арвай Ш. Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол. УБ.,2005.
7. Алтангэрэл Ч. Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл. УБ.,1993.
8. Одбаяр Ц. Хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарын гүйцэтгэх үүргийн судалгаа. УБ.,2018.
9. Сэтгэл зүй ба улсын хил. Ред.Намсрай Ч. УБ.,1989.
10. Уранцэцэг Л, Дэлгэржав М. Нийгмийн сэтгэл судлал. УБ.,2012.
11. Баярсайхан Д. Сэтгэл зүйн хямрал. Цэргийн шинэчлэл сэтгүүл. УБ.,2004.
12. Батболд Ш. Амьдралын психологи II: Ажлын байр, нийгмийн сэтгэл зүй. УБ.,2022.
13. Эх орны манаа. УБ.,2022. 10 сар №30/3055/
14. Артамонова В.Г. Профессиональные болезни: учебник. Москва.,1988, 416 с.
15. Маркова А.К. Психология профессионализма. Москва.,1996, 308 с.
16. Сыманюк Э.Э. Психологические барьеры профессионального развития личности. Москва.,2005, 252 с.

ХИЛИЙН ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНД ОРЧИН ҮЕИЙН ДЭВШИЛТЭД ТЕХНИК ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ АРГА ЗАМ

М. Энхманлай
ҮБХИС-БХУА-ийн магистрант,
дэд хурандаа

***Товч агуулга*:**

Хилийн шалган нэвтрүүлэх алба нь улсын хил хамгаалалтын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны нэг хэлбэр юм.

Дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж хувь хүн зорчих эрхийнхээ хүрээнд аль ч улс оронд чөлөөтэй зорчих боломжтой болсон нь тухайн улс орны хөгжил дэвшилд нөлөөлөөд зогсохгүй сөрөг талыг нэмэгдүүлэх болсон. Өөрөөр хэлбэл тухайн улс үндэстэн аюулгүй байдалдаа сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг улам боловсронгуй болгох, шаардлага урган гарч байна.

Тус илтгэлд хилийн шалган нэвтрүүлэх албанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага, боломжийг тодорхойлохыг зорилоо.

Түлхүүр үгс: Аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх алба, техник хэрэгсэл, E Gate, biometric technology

Оршил

XXI зуун гарсаар дэлхий дахинд даяаршил улам бүр тэлж, шинжлэх ухаан, мэдээллийн технологи үсрэнгүй хөгжин, улс төр, эдийн засгийн интеграц өргөжиж, улс хоорондын харилцан хамаарал гүнзгийрч байна. Олон улсын харилцаа өнгөрсөн зууны сүүлийн хагасын хоёр туйлт үеийнхээс эрс өөрчлөгдлөө. Нөгөөтэйгүүр, улс орнуудын хөгжлийн хурд, түвшин улам бүр ялгарч, буурай, эмзэг эдийн засагтай улсуудад ажилгүйдэл, ядуурал нүүрлэж, эдийн засгийн хямрал буурахгүй байна.

Зарим улс, бүс нутагт цөмийн зэвсэгтэй болох оролдлого үргэлжилж, хурцадмал байдал намжихгүй байна. Түүнчлэн улс гүрний бодлогоос шалтгаалсан орчин үеийн дайн, түрэмгийлэл, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол хийгээд олон улсын

терроризм, хүний болон хар тамхины наймаа, гоц халдварт өвчний тархалт зэрэг аюул, сорилт нэмэгдэх болсон.

Энэ онцлог нь улс орнууд техник технологийн бүх талын тогтолцоотой болсон, түүнийгээ үндэсний аюулгүй байдлаа сахин хамгаалахад үр дүнтэйгээр ашиглаж байна. Манай улс ч гэсэн болзошгүй аюул заналыг сэрэмжлэн зайлуулах, түүнээс урьдчилан сэргийлэх ялангуяа хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн тогтолцоог боловсронгуй болгох, төр засгийн бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх, хилийн шалган нэвтрүүлэх албанд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, хэрэгцээ, шаардлага боломжийг тодорхойлох шаардлага урган гарч байна.

Үндсэн хэсэг

Нэг: Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба хилийн шалган нэвтрүүлэх алба

Монголчууд бидний өвөг дээдэс олон мянган жилийн турш нутаг усаа эзэмшин идээшихдээ өөрийн түүх соёл, асар уудам газар нутаг, хүчирхэг арми, төрт улсаа бүтээж үр хойчдоо уламжлуулан залгаж хөгжүүлсээр ирсэн.

Их эзэн Чингис хаан “Хүннү нэрт өвөг дээдэс Хүчийг олж, хөрстөд дархалсан Хөх Монголоо сэргээн мандуулаад Хойчис та нартаа даатгасу би” хэмээн хэлсэн сургаалаас улс орны тусгаар тогтнол бүрэн бүтэн, халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах, үр хойчдоо өвлүүлэх талаар өгүүлжээ.

Монгол улс үндсэн хуулиндаа /нэгдүгээр бүлэг, дөрөвдүгээр зүйл/ “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна[41].” хэмээн тунхаглан зарласан.

"**Үндэсний аюулгүй байдал**" гэж[42] /цаашид "үндэсний аюулгүй байдал" гэнэ/ Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ.

Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд Монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал, эдийн засгийн харьцангуй бие

[41] Хууль зүйн үндэсний хүрээлэн УБ., 2022. Монгол Улсын үндсэн хууль

[42] Төрийн мэдээлэл сэтгүүл УБ., 2017. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил, үндэсний эв нэгдэл багтана[43]. Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхол нь төр, ард түмний онцгой анхаарал хамгаалалтад байна.

Монгол Улсын хилийн тухай хуулийн нэгдүгээр бүлгийн тавдугаар зүйлд Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь /цаашид "хилийн аюулгүй байдал" гэх/ “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн[44]. "Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа" гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хамгаалан бэхжүүлэх тал бүрийн баталгаа бий болгоход чиглэсэн төрийн бодлогыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэнээс хэрэгжүүлж буй арга хэмжээг хэлнэ хэмээн заасан байдаг.

Мөн улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээний салшгүй хэсэг мөн гэж тодорхойлжээ.

Улсын хил хамгаалалт нь: Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг хэлнэ.[45]

Тэгвэл олон улсад улсын хил, хил орчмын нутагт улс, нийгэм, иргэдийн амин чухал эрх ашиг хангагдсан байх нөхцөлийг хилийн аюулгүй байдал гэж үздэг. Язгуур эрх ашиг нь хувь хүн, нийгэм, төрийн оршин тогтнох, цаашид хөгжин дэвших боломжийг найдвартай хангах амин чухал хэрэгцээний нийлбэр юм.

Үндэсний аюулгүй байдлыг хангах, бэхжүүлэх бодлого нь аливаа аюулыг “болзошгүй” үед нь тодруулан тогтоож арилгах, субъектив аюулыг цаг тухайд нь арилгах замаар объектив аюулыг багасгах, урьдчилан сэргийлэхэд чиглэнэ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд**:**

---

[43] Төрийн мэдээлэл сэтгүүл УБ., 2017. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

[44] Төрийн мэдээлэл сэтгүүл УБ., 2016. Монгол Улсын хилийн тухай хууль

[45] Монгол Улсын хуулиуд УБ., 2016. Монгол улсын Хилийн тухай хууль

Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ[46]. гэж заасан нь үндэсний аюулгүй байдал тэр тусмаа хилийн шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд техник технологийн шинэчлэлийн асуудлыг тусгасан нь харилцан хамаарал бүхий чухал асуудал мөн гэдгийг тодорхойлж байна.

Хоёр: Хилийн шалган нэвтрүүлэх албаны техник хэрэгслийг сайжруулах шаардлага, боломж

Монгол Улсын засгийн газраас хилийн боомтын хүчин чадалыг нэмэгдүүлэх, шалган нэвтрүүлэх албыг боловсронгуй болгох, техник хэрэгслийг шинэчлэх, сайжруулах талаар дараах зорилтот хөтөлбөр хэрэгжүүлхээр төлөвлөсөн.

Монгол Улсын урт хугацааны “Алсын хараа 2050” хөгжлийн бодлогод 7.2.5. Орчин үеийн дэвшилтэт техник, технологид суурилсан Монгол Улсын хил хамгаалалтын удирдлагын төвийг байгуулж, хил хамгаалалтад шилжүүлнэ, 7.2.7. улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд орчин үеийн цэргийн холбоо, зэвсэглэл, техник, технологи, дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн систем, арга туршлагыг нэвтрүүлж, хангана, 7.2.9. эдийн засгийн хамтын ажиллагааны бүс болон хилийн боомтуудад орчин үеийн хяналт шалгалтын техник хэрэгсэл, дэвшилтэт технологийг үе шаттай нэвтрүүлж, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлнэ, мөн “Хүний биеийн давхцахгүй өгөгдөлд тулгуурласан ухаалаг цахим гарцыг шалган нэвтрүүлэх албанд нэвтрүүлнэ.”, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хөтөлбөрийн 7.2.4 дэх заалтад “Гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.” -Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.3.1.5-д “...улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх үйл ажиллагаанд "Ухаалаг цахим" технологийг нэвтрүүлж, шалгалтын техник, хэрэгслээр хангах,

[46] Төрийн мэдээлэл сэтгүүл УБ., 2017. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал

цэргийн холбооны техник хэрэгсэл, хүн нэг бүрийн тусгай хэрэгслийг шинэчлэнэ.” гэж тус тус заасан.

“Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлснээр урт хугацаанд эдийн засгийн өсөлт дунджаар 6 хувьд хадгалагдаж, нэг хүнд ногдох үндэсний орлого 2 дахин нэмэгдэж, ажиллах хүчний оролцооны түвшин 65 хувьд хүрнэ. Боомтын хүчин чадлыг 3 дахин нэмэгдүүлж, эрчим хүчний эх үүсвэрийг 2 дахин өсгөх бөгөөд боомтын сэргэлтийн хүрээнд

1.1.Боомтуудын хатуу, зөөлөн дэд бүтцийг хөгжүүлэн ачаа болон зорчигч нэвтрүүлэх хүчин чадлыг дээшлүүлж, экспортыг нэмэгдүүлэх, хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгасан.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд:

3.1.2.4.Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ гэж заасан бол бөгөөд хэрэгжилтийг хангах зорилгоор олон улсын хилийн боомтуудад ухаалаг цахим гарцыг үе шаттайгаар нэвтүүлэх шаардлага үүсч байна. Дэлхийн ихэнх улс, орон хилийн хяналт шалгалтыг сайжруулах зорилгоор хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан ухаалаг цахим гарцыг нэвтрүүлж эхэлсэн нь үр дүнгээ өгч, Монгол Улс олон улсын жишигт нийцэх шаардлага тулгараад байна.

Иймд эхний ээлжинд Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг, улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, экспорт, импортын дийлэнх хувийг эзлэх “Чингис хаан” агаарын замын боомт, “Замын-Үүд” авто замын боомтуудад хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан цахим гарц E-GATE коридор үүсгэх, “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн болон зорчигчийн нэрийн бүртгэлийн дэвшилтэд систем”-ийг буюу API/PNR (Advanced Passenger Information/Passenger Name Record)

Улс орон бүр хилийн боомтынхоо хүчин чадалыг нэмэгдүүлэх, зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх хүчин чадалыг нэмэгдүүлэх, хөдөлгөөнийг хурдасгах, хилийн хяналт шалгалтыг

сайжруулах зорилгоор төрөл бүрийн дэвшилтэд техник, технологийг нэвтрүүлэхийг эрмэлзэх болсон.

Энэ талаар манай хөрш улс болох БНХАУ нь 2015 оноос хүний биеийн давхцахгүй өгөгдлийн систем, E gate-ийг нэвтрүүлж эхэлсэн бол БНХАУ 2030 он гэхэд хиймэл оюун ухаанаар дэлхийд тэргүүлэх зорилт тавин ажиллаж, улс орон даяар видео тандалтын сүлжээ байгуулж, 2018 онд 200 сая гаруй хяналтын камер ашиглаж байсан бол 2025 онд 626 саяыг суурилуулахаар төлөвлөжээ.

ОХУ-ын хувьд төв банк нь 2017 оноос улс даяар нүүр царай, дуу хоолой, хурууны хээ цуглуулах зорилготой хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. 2019 онд 160,000 хяналтын камер бүхий нүүр царай таних технологийг олон нийтийн аюулгүй байдлыг хангах үүднээс Москва хотод суурилуулсан байна. “Шереметьево” олон улсын нисэх буудал нь ОХУ-д хамгийн анх “Единая биометрическая система” нэртэй төрийн мэдээллийн системийг ашиглан улсын хилээр нэвтрэх зорчигчдын ижилсүүлэлтийг гүйцэтгэж эхэлсэн.

Европын Холбооны аюулгүй байдал, хилийн удирдлагын шинэчилсэн Шенгений мэдээллийн систем (SIS) бүртгэлтэй хүмүүсийн биометрийг нэгтгэсэн. Их Британи улс цахим аялалын зөвшөөрөл (ETA) схемийг нэвтрүүлсэн бол Кипр улс цахим системд нэгдэхээр бэлтгэж байна[47].

Энэхүү систем нь европын холбооны 26 гишүүн орон, Шенгений дөрвөн улсаас бүрдсэн 30 оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд /SIS/ үндэсний системийг төвлөрсөн системтэй холбож, терроризмын эсрэг, тогтмол бус шилжилт хөдөлгөөн, эмзэг бүлгийн хүмүүс, хар тамхи, галт зэвсгийн бүртгэлийн системүүдийн хоорондсүлжээ болж ажилладаг.

Их Британийн Засгийн газар цагаачлал, хууль ёсны шилжилт хөдөлгөөн, хилийн хяналтын талаарх шинэ алсын хараагаа “Хууль ёсны шилжилт хөдөлгөөн ба хилийн хяналт” нэртэй бодлогын баримт бичигт тусгаж "Биометрийн коридор" эсвэл "E-Gates" гэж нэрлэгддэг биометрийн технологийн тусламжтайгаар бичиг баримтыг гар аргаар шалгахгүйгээр хилээр нэвтрүүлэх ажиллагааг амжилттай нэвтрүүлээд байна.

---

[47] Biometric Schengen Information System goes live, UK readies ETAs Mar 13, 2023, https://www-biometricupdate-com.

Дэлхийн ихэнх улс орон хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан ухаалаг цахим гарцыг нэвтрүүлж эхэлсэн нь үр дүнгээ өгч, Монгол Улс ч олон улсын жишигт нийцэх шаардлага тулгараад байна. Хүний биеийн давхцахгүй өгөгдлийн систем / тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар хүнийг тодорхойлох боломжтой гарын хурууны хээ, нүдний солонгон бүрхэвч, нүүр царай, дуу хоолой, биеийн хөдөлгөөний онцлог шинж / биометрик мэдээллийг хэлнэ.

Иймд эхний ээлжинд Монгол Улсын гадаад худалдаа, эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг, улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, экспорт, импортын дийлэнх хувийг эзлэх “Чингис хаан” агаарын замын боомт, “Замын-Үүд” авто замын боомтуудад хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан цахим гарц E-GATE, “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн болон зорчигчийн нэрийн бүртгэлийн дэвшилтэд систем”-ийг буюу API/PNR (Advanced Passenger Information/Passenger Name Record)

Хилийн шалган нэвтрүүлэх албанд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага:

-Засгийн газрын мөрийн хөтөлбөр, бодлого төлөвлөгөө, ойрын болон алсын зорилго, зорилтуудад боомтын сэргэлт, өргөтгөл, шинэчлэлийг хэрэгжүүлж олон улсын агаарын замын Хөшигийн хөндий, автозамын Замын-Үүд боомтыг ашиглалтад оруулсан боловч зорчигчийг шалгах техник хэрэгсэл нь орчин үеийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй болсон.

-Хилийн боомтод одоо ашиглаж байгаа улсын хилээр нэвтэрч буй зорчигчийг бүртгэх программ нь ИБМҮТ-тэй шууд холбогдсон боловч гадаад улсын олон улсын байгууллага / интерпол, олон улсын терроризмтэй тэмцэх /-уудтай холбогдоогүй, мэдээ, мэдээллийг солилцох ажиллагаа нь хязгаарлагдмал байна.

-Монгол Улс руу нэвтэрч буй гадаад иргэдийн зорилго, чиглэл, байршлыг тогтоох, үйлчлүүлсэн зочид буудал, такси, хоолны газрууд болон төлбөр тооцоо хийсэн банк, бэлэн мөнгөний машин, галт тэрэг, хот хоорондын болон орон нутгийн тээврийн хэрэгслээр зорчсон тухай мэдээллүүдийг нэгтгэх хяналтын нэгдсэн мэдээллийн систем байхгүйгээс энэ байдлыг эсрэгээр ашиглах боломжтой.

-Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд гадаад паспортыг чиптэй

паспортонд шилжүүлсэн нь тус паспорттой иргэдийг шалган нэвтрүүлэх унших, бүртгэл явуулах хосолсон техник хэрэгсэл шаардлагатай байна.

Дээрх техник технологийн дэвшлийг нэвтрүүлснээр дараах үр дүнд хүрнэ:

-Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх урсгал сайжирч, гадаад, дотоодын жуулчдын тоо нэмэгдэх, бараа бүтээгдэхүүний экспорт, импортыг нэвтрүүлэх хүчин чадал дээшилж эдийн засагт эерэг нөлөө үзүүлнэ.

-Хилийн зөрчлөөс бүрэн сэргийлж хуурмаглал хийсэн болон бусдын баримт бичиг, хуурамч визээр улсын хил зөрчих асуудал бүрэн таслан зогсоогдоно.

-Гадаадын алан хядах, хорлон сүйтгэх болон террорист этгээдүүдийн хань хамсаатан тэдгээрийг хянах боломжийг бүрдүүлж ирээдүйд олон улсын түвшинд учир болзошгүй аюул заналаас урьдчилан сэргийлэх боломжийг хангах;

-Олон улсын хамтын ажиллагааны байгууллагуудын дундын сүлжээ болох Интерполын зорчигчийн урьдчилсан мэдээллийн систем “Go Travel” (API, PNR), ICAO-ын зорчигчдын мэдээллийн дэвшилтэт технологийн систем /APP/-ийг шалган нэвтрүүлэх албанд ашиглах.

-Террорист этгээд, үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэл, гэмт этгээдүүд, хүний наймаа, хар тамхи, мөнгө угаах зэрэг олон улсад тулгамдаад буй гэмт хэргүүдтэй тэмцэхэд ашиглах;

-Зорчигчийн мэдээллийн системд сэжигтэй этгээдийн талаар автоматаар хайлт хийх бөгөөд энэхүү хайлт хийдэг мэдээллийн баазыг олон улсын мэдээллийн нэгдсэн сангууд болох НҮБ, Интерпол болон НҮБ-ын гишүүн орнуудаас гадна дотоодын гэмт хэргийн болон иргэний бүртгэлийн системийн тусламжтайгаар баяжилт хийгдэнэ.

-Мөн олон улсад үүсч буй терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн нөхцөл байдалтай холбогдуулан хилийн хяналт, шалгалтыг сайжруулах үндэсний чадавхыг бэхжүүлэх, төрийн байгууллага хоорондын мэдээлэл солилцооны шуурхай байдлыг сайжруулах зорилгоор “Зорчигчийн урьдчилсан мэдээллийн болон зорчигчийн нэрийн бүртгэлийн дэвшилтэд систем”-ийг буюу API/PNR (Advanced Passenger Information/Passenger Name Record)-ийг нэвтрүүлэх зайлшгүй

шаардлага үүссэн гэж холбогдох байгууллагаас үнэлгээ хийсэн бөгөөд доорх төрлийн аюул занал, эрсдэлтэй дотооддоо болон олон улсад тэмцэх чадавх нэмэгдэнэ гэж үзэж байна. Үүнд:

“Зорчигчийн урьдчилсан мэдээллийн болон зорчигчийн нэрийн бүртгэлийн дэвшилтэд систем”-ийг нэвтрүүлж хилийн хяналтыг сайжруулах чиглэлээр Монгол Улсын ЗГХЭГ-ын даргын 2018 оны 3 дугаар сарын 01-ний өдрийн 62 дугаартай “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаал, “Хилийн хяналт, шалгалтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 306 дугаар тогтоол, “Хилийн хяналт, шалгалтыг сайжруулж, олон улсын зорчигч шалган нэвтрүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах тухай” Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн зөвлөмжүүд тус тус гарсан.

Монгол улсад энэхүү мэдээллийн цогц системийг нэвтрүүлсэнээр төрийн байгууллагуудын мэдээлэл солилцох ажиллагаа сайжирч, үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд бодитоор нөлөөлнө гэж үзэж байна

ДҮГНЭЛТ

Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд учирч болзошгүй гадаад, дотоод аюул заналыг арилгах, сэрэмжлэн зайлуулах, төр нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих зэрэг нийгмийн бүхий л салбартай салшгүй холбоотой.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 100 орны 250 нисэх онгоцны буудал биометрийн цахим хаалга байрлуулж, өөрийгөө шалган нэвтрүүлэх зориулалт бүхий E gate коридорыг нэвтрүүлэн, хэвлэмэл гадаад паспортын хэрэглээг багасгаад байна.

Монгол Улс хилийн хяналтыг сайжруулах хэрэгцээ, шаардлагын хүрээнд нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, дотоодын хууль тогтоомжид заасан үндэслэл, шаардлагын хүрээнд хүний биеийн давхцахгүй өгөгдөлд суурилсан болон зорчигчийн урьдчилсан мэдээллийн, төрийн байгууллагуудын нэгдмэл бүртгэлийн тогтолцоо, дэвшилтэд системийг зайлшгүй нэвтрүүлэх хэрэгцээ, шаардлага байна гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Ш.Арвай Монгол Улсын хилийн аюулгүй байдлын онолын үндэс УБ., 2021 он
2. Ш.Арвай Монгол Улсын тусгаар тогтнол ба улсын хил УБ., 2021 он
3. Ж.Өвгөнбүргэд Хилийн аюулгүй байдлын онол арга зүй УБ., 2021 он
4. Б.Түмэн Цэргийн урлагт гарч буй өөрчлөлт УБ., 2010 он
5. Б.Түмэн, Н.Нараночир, Л.Онцгойбаяр. Оперативын урлаг УБ.,2021 он
6. Олон улсын терроризм ба Монгол улс / Онол практикийн бага хурлын материал / УБ., 2004
7. Олон улсын терроризм түүнтэй тэмцэх онол арга зүйн үндэс УБ., 2006
8. БХИС-ын БХЭШХ-ын “Цэргийн нэр томьёоны тайлбар толь” 2014 он
9. Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал / Эрдэм шинжилгээ судалгааны онол, арга зүйн сэтгүүл / УБ., 2019
10. https://www.bing.com/search go+travel&go
11. http://nctc.gov.mn/
12. Biometric Schengen Information System goes live, UK readies ETAs Mar 13, 2023, https://www-biometricupdate-com.
13. Rebounding air passenger numbers drive biometric gate and digital ID app expansions Mar 8, 2023, https://www-biometricupdate-com.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД НИСЭГЧГҮЙ НИСЭХ ХЭРЭГСЭЛ /ДРОН/-ЫГ АШИГЛАХ БОЛОН ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ТАКТИКИЙГ БОЛОВСРУУЛАХ НЬ

Ц.Ганболд
Хилийн аюулгүй байдал судлалын
хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан,
доктор, профессор, хурандаа

Дроны үүсэл хөгжлийг харвал 1800 оноос эхлэлтэй. Харин өнөөдөр аж үйлдвэрийн салбар бүрт ашиглагдаж буй дроны хөгжил нь 2009 оноос эхэлсэн. Үндсэндээ нийт 10 жилийн хугацаанд дрон технологи үсрэнгүй хөгжсөн байна. Аж үйлдвэрийн дөрөвдүгээр хувьсгалд ашиглагдах үсрэнгүй технологи нь дрон технологи байх ёстой бөгөөд бүх салбарт ашиглах боломжтой болсон. Түүнчлэн хүний амь нас эрсдэх аюултай ажиллагаанд хүртэл дроныг ашиглах боломж нээгдэж байна.

Сүүлийн 10 гаруй жилд үсрэнгүй хөгжсөн технологийн жишээ бол нисэгчгүй нисэх төхөөрөмжийн нэгэн төрөл болох “Дрон” бөгөөд “Enterprise Drone” буюу тусгай зориулалтын дроны технологийн хөгжлийн чиг хандлага, ач холбогдол, хэрэглээ, боломжууд ихээр нэмэгдсэн

Дроныг бид зураг авч, бичлэг хийх зориулалттай хэрэгсэл мэтээр хүлээн авдаг байсан бол тус технологийн хэрэглээ асар хурдацтайгаар өсөн нэмэгдсээр байна. Үйлдвэрлэлийн тоо хэмжээ болон дрон технологийн үр ашигтай байдал сайжирснаар дэлхийн улс орны төрийн, цэргийн болон бизнесийн байгууллагууд, энгийн хэрэглэгчдийн тус технологид оруулах хөрөнгө оруулалт нэмэгдсээр ирэв.

АНУ-ын байгууллагууд үйл ажиллагаандаа дроныг нэвтрүүлэх нь сүүлийн 2 жилд 552 дахин өсжээ. Мөн АНУ-ын хууль сахиулах байгууллагын мэргэжилтнүүд 2025 он гэхэд 20,000 дроныг жил бүр ашиглалтад оруулан үйл ажиллагаандаа ашиглах тооцооллыг гаргажээ.

Дроныг анх мэйл хүргэх, зураг авах зэргээр ашигладаг байсан бол өнөөдөр барилгын 3D зураг боловсруулах, онцгой байдал, гал унтраах, хөрсний бүтэц тодорхойлох, кино үйлдвэрлэл, дэд бүтцийн

хяналт шалгалт, ашигт малтмалын хайгуул, хилийн хяналт гэх зэрэг маш олон салбарт төрөл бүрийн зориулалтаар ашиглах болсон[48].

Дроныг цэрэг армийн зориулалтаар ашиглаж эхэлсэн түүх шинэхэн бөгөөд 2001 оны 11 дүгээр сард америкчууд “Талибан” хөдөлгөөний эсрэг анх удаа байлдааны дрон ашиглажээ. Тэр үеэс Израйль, АНУ хоёр байлдааны дроныг шинэчлэх, сайжруулах, үйлдвэрлэх тал дээр ихээхэн ажиллаж, дэлхийд ноёрхож эхэлсэн. Аливаа шинэ зүйлээс хоцордоггүй, дууриалган хуулбарлахыг мастер өмнөд хөрш Хятадууд ч энэ чиглэлд ихээхэн анхаарч ажилласны үр дүнд тодорхой амжилтад хүрч, Ойрхи Дорнодын байлдаантай бүс нутагт нийлүүлсээр байна.

Дрон нь хямд төсөр өртөгтэй, радарт баригдахгүй нисдэг, устгаж байгаа байгаа зурагжуулж, дүрсээ дамжуулдаг, устгах байг тодорхойлоод нисгэсэн байхад баталгаатай устгах чадвартай, пуужин, зэвсэг тээж өрсөлдөгч талдаа хөнөөл учруулахаас гадна тагнуулын зориулалттай, мэдээллийн зориулалттай, долгионы саатуулга хийх зэрэг олон зориулалтаар ашиглах болжээ.

Дронууд нь ажиглалтын, тагнуулын ба цохилтын гэсэн 3 үндсэн зориулалттай. Түүнчлэн камиказе-дрон гэж байдаг бөгөөд энэ нь байг бөмбөгддөггүй, пуужингаар харвадаггүй, харин байг илрүүлсэн даруйдаа дээрээс нь унаж дэлбэлдэг “амиа золиослогч дрон” юм.

Дроны хамгийн том давуу тал бол хямд үнэ. Тухайлбал, хамгийн үнэтэйд тооцогддог Израилийн “Hermes” гэдэг цохилтын дрон 20 орчим сая доллар бол тагнуулын Orbiter 2M нисгэгчгүй төхөөрөмжийн үнэ нь 600 мянга орчим доллар. хамгийн хямд дрон болох Израилийн “Heron” 100 мянган долларын үнэтэй.

Бүтэн өдрийн туршид агаарт байж чаддаг, хэдэн зуун км-ийн холоос оператор удирдаад лазеран овоотой дөрөв хүртэлх пуужинг есөн км-ийн өндрөөс өндөр нарийвчлалтайгаар чиглүүлсэн байруугаа унагаж чаддаг Туркийн Bayraktar TB2 хэмээх дрон Сири болон Армен-Азербайжаны хооронд өрнөсөн мөргөлдөөнд амжилттай хэрэглэгдэж, нэр алдар нь цуурайтаж, дэлхийн зэвсгийн

[48] Эх сурвалж: МТҮП itpark.mn/

зах зээл дээр эрэлт ихтэй болж, украйн, сербүүд олноор нь худалдан авч байна[49].

Энгийн олон зориулалтат дрон

Bayraktar TB2

Bayraktar TB2 нь 5 мянган метрийн өндөрт нисдэг, 200 км/цагийн хурдтай, агаарт 27 цаг байж чадна. Пуужингаас гадна MAM гэдэг лазерын онилуур бүхий алсын удирдлагатай тэсрэх бөмбөгийг тээдэг.

Уулын Карабахад болж буй зэвсэгт мөргөлдөөнийг цэргийн шинжээчид “дронуудын дайн” гэж нэрлэж байгаа бөгөөд байлдагч талууд дайсны газар дээрх байнуудыг устгахын тулд нисгэгчгүй төхөөрөмжүүдийг өргөн ашиглаж байгаа нь өнөө үед байлдааны ажиллагаа явуулах арга тактик эрс өөрчлөгдсөнийг харууллаа.

Азербайжан, Армени хооронд дрон олноор нь өргөн ашигласан, хэрхэн үр дүнтэй ашиглаж байгаагаас тулааны үр дүн хамаарсан анхны дайн болж байна гэж дүгнэж болох юм.

Дроныг тусгай төрлийн будгаар будсан холимог материалууд, хуванцраар хийдэг ба овор хэмжээ багатай бензин ба цахилгаан хөдөлгүүрүүд нь дулаан, чимээ бараг ялгаруулдаггүй, радарын антениас цацруулж буй долгионыг тун багаар буцаан ойлгодог учраас тэдгээрийг илрүүлэн устгахад хэцүү. Гэсэн хэдий ч дронтой тэмцэх аргууд хэдийнээ бий болжээ. Тухайлбал, GPS-ээс дрон руу ирж буй дохиололд саад учруулах, түүнийг дарах байдлаар дроныг төөрүүлэн унагах арга, мөн GPS -ийн байршил тогтоох систем рүү электрон спуфинг дайралт хийх тодруулбал, навигацийн хуурамч өгөгдөл бүхий дохиоллыг дроны хүлээн авагчид өгснөөр тухайн дрон

[49] Б.Хулан. Орчин үеийн дайнд ялагчийг дрон тодорхойлно. Өдрийн сонин. 2020.10.16. №215.

чиглэлээсээ хазайж, хуурамч бай руу довтолдог аргуудыг боловсруулжээ.

Монгол Улсын Хил хамгаалах байгууллагатай нягт хамтран ажилладаг Энэтхэг улсын Хилийн аюулгүй байдлын хүчин дронтой тэмцэх чиглэлээр багагүй туршлага хуримтлуулсан байна. 2018 онд Пакистаны талаас дроноор хил зөрчиж, зэвсэг зөөвөрлөх хэд хэдэн тохиолдлын дараа Энэтхэгийн талаас дрон эсэргүүцэх 4-5 системийг хилийн дагуу байршуулсан бөгөөд уг систем нь нэгээр болон бүлэг ННХ-ийг (сүргийн дайралт) алсаас илрүүлэх чадвартай бөгөөд өөрийн хариуцлагын бүсэд орсон байг 10 секундийн дотор илрүүлж, 360 градусын орчинд эдгээрийг бодит цаг хугацаанд сканердах, илрүүлэх, мөрдөх, саармагжуулах чадвартай[50] гэжээ.

Мөн арабын зарим орнуудад бүргэд, шонхор зэрэг анч шувуудыг бага оврын дрон барих (устгах) аргад сурган тэмцэх оролдлогуудыг хийж байгаа ч тодорхой үр дүнд хүрээгүй байдаг. Манайд ч Баян-Өлгий аймаг дахь хилийн ангиудад туршлагын журмаар анч бүргэд ашиглан дрон ангуучлах санаачлага гарган сургаж бэлтгэж байсан туршлага, сургамж бий.

Мөрөн дээрээс бууддаг зенитийн пуужингийн 9К333 “Верба” цогцолбор, радио саатуулгын Красуха 4 цогцолборыг ашиглах нь үр дүнтэй байгаа болон ойрын ирээдүйд лазерын их буу зэвсэглэлд нэвтэрсэнээр дронуудыг асар хямд өртгөөр устгах боломж гарч ирэх юм.

Монгол Улсын зэвсэгт хүчин байлдааны дроныг худалдан авч ашиглах нь цаг үеийн асуудал бөгөөд техникийн сонголт хийхдээ дараах улсуудын дронуудаас сонголт хийх нь зүйтэй болов уу гэж үзлээ.

Техникийн үзүүлэлтээр байлдааны дроны шилдгүүдийн жагсаалтанд Америкийн 5, Хятадын 2, Израиль ба АНЭУ-ын тус бүр 1 дрон, түүнчлэн дээр дурдсан Туркийн Bayraktar TB2 дрон багтсан байна. Тухайлбал, жагсаалтыг тэргүүлж буй Америкийн Predator C Avenger нисгэгчгүй онгоцыг 2009 онд General Atomics Aeronautical Systems компанид зохион бүтээж үйлдвэрлэжээ. Hellfire пуужингууд, хэд хэдэн төрлийн удирдлагатай бөмбөг, лазерын онилууртай

---

50 https//economictimes.indiatimes.com/news/defence/bsf-to-be-armed-with-anti-drone-system-for-border-near-jammu-kashmir-soon/articleshow/73701217.cms?from=mdr

бөмбөгөөр зэвсэглэсэн энэ дрон 15 мянган м-ийн өндөрт нисэж чадах ба дээд хурд нь 740 км/цаг, агаарт 20 цаг байх чадвартай.

Predator C Avenger

Харин 5 дугаарт бичигдсэн, дунд өндөрт нисдэг тагнуул-цохилтын хосолсон зориулалттай Хятадын CH-5 дрон агаарт 60 цаг, түүний ард бичигдсэн Yabhon United 40 гэдэг АНЭУ-д зохион бүтээсэн тагнуул-цохилтын дрон агаарт 5 хоног хүртэлх хугацаагаар байж чадна. Харин 2 дугаарт бичигдсэн Израилийн Heron TP дрон агаарт 36 цаг тогтож, нэгэн зэрэг 6 байг онилдог зэрэг үзүүлэлтээрээ ялгаатай[51].

Хөрш ОХУ-ын зэвсэгт хүчинд “Калашников” концернд бүтээгдсэн алуурчин дронуудын цуврал “Ланцет -1, 2, 3” гэсэн Дрон-камекадзенуудыг зэвсэглэлд авч эхлээд байна. Уг дронууд агаарт чөлөөтэй маневр хийж, 40 минут хүртэл нисдэг, 110 км/цаг хурдална, 3кг тэсрэх бодис тээдэг, цахилгаан хөдөлгүүртэй учраас дуу чимээ бага гаргадаг онцлогтой.

Ланцет-1 нь агаараас төрөл бүрийн байг байнга дагалдах чадалтай ба залуурт сум, эсвэл алуурчин дроныг чиглүүлэн өгөх чадвартай.

Ланцет-2 алуурчин дрон нь агаарт байгаа жижиг, том дронуудыг илрүүлэн олж мөргөж сөнөөх үүрэгтэй юм.

Ланцет-3 алуурчин дрон нь амьд хүч, төрөл бүрийн хуягт техникийн устгах үүрэгтэй.

---

[51]Б.Адъяахүү. Эх сурвалжууд: http://bbc.com, zen.yandex.ru, inosmi.ru/politic, svpressa.ru/.

Ланцет-3

Монгол Улсын Зэвсэгт хүчин, Хил хамгаалах Байгуулага, Онцгой байдал, Байгаль орчныг хамгаалах байгуулагын хувьд агаарын болон газрын орон зайд тандалт явуулах, агаараас тоон стерео зургийн фотограмметр, ортофото, байр зүйн боловсруулалт хийх, хүрэхэд хүндрэлтэй, алслагдсан газар орныг хянах, орон зайн тагнуулын мэдээлэл цуглуулах, байн байршил тодорхойлох, заах, байрлалын солбилцолыг тодорхойлох, хөдөлгөөн үйлдэх үед замналын дагуу ажиглалт хийх, гамшиг ослын болон хилийн цагийн байдлын мэдээ цуглуулах, хяналт хийх, ан амьтны байршил тогтоох, тооллого хийх, ойн тандалт хийх зэргээр ашиглаж боломжтой.

Монгол Улсын ОБЕГ сүүлийн жилүүдэд гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд шинжлэх ухаан технологийн ололт, инноваци нэвтрүүлэхэд идэвхтэй ажиллаж, аврах ажиллагаанд хүн хүчнээс гадна технологийн ололтыг өргөнөөр ашиглаж байна. Тухайлбал, дроныг ашигласнаар ой хээрийн түймрийн тархалтыг тогтоох, хүн хүчээ оновчтой хувиарлах, удирдлагын шийдвэр гаргах түвшинд ажиллаж чадаж буй явдал юм. Өнөөдрийн байдлаар Онцгой байдлын газар 20 орчим дроныг ашиглаж байна. Хамгийн гол давуу тал нь цаг хугацаа, хүн хүч хэмнэх явдал тул эрэн хайх, аврах ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэх болов.

Өнөөдрийн байдлаар 70 гаруй дроныг Улсын Тусгай Хамгаалалттай Газруудад ашиглаж байгаа ба байгаль хамгаалагчдыг тусгай сургалтад хамруулсан[52].

Монгол Улс хилээ хамгаалахдаа хүний хүчин зүйлээр хамгаалах боломжгүй онцлогтой. Улсын хил хамгаалалтын

[52] С.Сарангэрэл. Дотоодын аялал жуулчлагчдын тоо сая давсан. Өдрийн сонин. 2020-11-05. №223 (6589).

нягтралыг нэмэгдүүлэх, найдвартай байдал, чадавхыг дээшлүүлэхийн тулд техник, технологийг нэвтрүүлэх шаардлагатай байна[53].

Монгол Улсын Хил хамгаалах байгууллагад нисэгчгүй нисэх хэрэгсэл-дроныг (цаашид ННХ гэх) ашиглах алхамуудыг хийж байгаа хэдий ч байнгын хэрэглээ болоогүй, техник, технологийн оновчтой сонголт хийгдээгүй, ашиглах дүрэм, журам ч гараагүй, арга тактик нь ч боловсруулагдаагүй байна.

Монгол Улсын хилийн баруун, зүүн чиглэлээр нисэгчгүй нисдэг хэрэгсэл-дроноор хил зөрчүүлсэн хэд хэдэн тохиолдол гарсан бөгөөд устгаж чадахгүй алдсан сургамж бидэнд үлдсэн. Хил зөрчин орж ирснийг илрүүлсэн даруйд нь устгах эрх зүйн орчныг, мөн боломжийг бүрдүүлэх шаардлагатай.

Мэдээ мэдээллийг шуурхай дамжуулах, агаарын байнд гал явуулах, удирдах ажиллагаанд хилийн манааны ахлагч, харуулын болон салбарын захирагч нарыг сургах нь эн түрүүнд тавигдах болж байна.

Тэмцлийн хэрэгсэл нь аргаа тодорхойлдог цэргийн сонгодог онолын дагуу нисэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалтад оновчтой, үр дүнтэй ашиглах арга тактикаа ч, улсын хил зөрчүүлэн, зөрчин орж ирсэн нисэгчгүй нисэх хэрэгсэлтэй үр дүнтэй тэмцэх, устгах арга тактикаа ч хамтад нь боловсруулж, эрх зүйн үндсийг нь тодорхой болгон хууль, дүрэм, зааварт тусган эрх зүйн чадамжтай болгох, бие бүрэлдэхүүнээ сурган дадлагажуулах, зориулалтын зэвсэг хэрэгслээр (торон болон лазер, импульсын буу, стрела, оса, игла загварын агаарын бай устгах зөөврийн пуужин) хангах шаардлага нэгэнт бий болжээ.

Хил залгаа улсын талаас гэмт хэргийн бүлэглэлүүд (зорилтот бүлгүүд) дрон ашиглан хил орчмын нутаг дэвсгэр, хилийн анги салбар, манаа, харуулын байрлал, үүрэг гүйцэтгэх замнал, арга тактикийг илрүүлэх болон мөнгө валют, алт эрдэнэс, соёлын үнэт өв, хар тамхи, сум галт хэрэгсэл зэргийг зөөвөрлөн нэвтрүүлэхэд ашиглаж байх магадлалтай.

---

[53] Ц.Сэргэлэн. Манай улс хилээ дан ганц хүний хүчээр хамгаалах боломжгүй, технологийн дэвшил ашиглах шаардлагатай. Өдрийн сонин. 2020-10-28.№217(6583).

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн одоо байгаа орон тооны хүч хэрэгслээр хэт нам өндрөөр хил зөрчин орж ирсэн нисэгчгүй нисэх хэрэгслийг илрүүлэх, түүнтэй тэмцэх боломж хязгаармагдал учраас Хил хамгаалах байгууллага хил дээр байгаа өөрийн хүч хэрэгслээр тэмцэхээс өөр аргагүй гэдгийг хүлээн зөвшөөрөх ёстой.

Зэвсэглэлд байгаа ПКС суурьт пулёметыг суурийн хамтаар зарим онцлог чиглэлийн анги, салбарыг хангах нь эхний ээлжийн тэмцлийн арга хэмжээ байж болох юм. ПКС пулёметийн суурь (Манайд А.В.Степанов болон Е.С.Саможенковын загварын гурван хөлт суурь байдаг) нь агаарын байнд гал явуулахад зориулагдсан бөгөөд 70 градусаас дээш өнцгөөр хараалан буудах, 360 градус эргэх боломжийг хангасан байдаг.

Хил Хамгаалах Байгууллагад тусгай томилгоот салбарын бүрэлдэхүүнд тактикийн зориулалт бүхий нисэгчгүй нисэх хэрэгсэлтэй бүлэгтэй болох, анги, салбаруудад нисэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах болон түүнтэй тэмцэх бүлэг, тоотыг бий болгох шаардлагатай болжээ. Хил хамгаалах байгууллагад ННХ-ийн операторoор бэлтгэсэн мэргэжилтнээ хэрэгцээтэй газар нь байршуулан, мэдлэг мэргэжлийг нь ашиглах цаг нэгэнт иржээ.

Нисэгчгүй нисэх хэрэгслийг улсын хил хамгаалалтад ашиглах журам, тактик ажиллагааг болон хил зөрчин ирсэн нисэгчгүй нисэх хэрэгслийг устгах, түүнтэй тэмцэх журам, тактик ажиллагааг мөн Зэвсэгт хүчний Агаарын цэргийн салбаруудтай мэдээ мэдээлэл солилцох, харилцан ажиллах журам зэргийг шинээр боловсруулагдаж батлагдах “Хил хамгаалалтын дүрэм”-д оруулж өгөх нь зүйтэй байна.

Дүрэмд тусгах хувилбарыг боловсруулж байгаа бөгөөд холбогдох мэргэжлийн албадтай зөвшилцөн, хамтран ажиллаж, боломжит хэлбэрээр дүрэм зааварт тусгагдах байх гэж найдна.

Цаг уурын зориулалттай нисэх бөмбөлөг хилээр хяналтгүй нэвтрэн манай улсын нутаг дэвсгэрт олноор унаж байсан түүх бий. Сүүлийн жилүүдэд өмнөд хилийн хэд хэдэн ангиудын хариуцсан хэсгээр гадаадаас нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон) улсын хил зөрчинманай улсын газар нутгаар нислэг үйлдэж байгаад буцаж гарсан зөрчлүүд цөөнгүй байна. Уг зөрчлүүдийг хүснэгтээр харуулбал:

д/д	Хилийн цэргийн анги	Зөрчил гаргасан чиглэл	Он	Тоо
Нисгэгчгүй нисэх хэрэгслийн зөрчил				
1	108	Гадаадаас	2016	2
2	0131			1
3	0166		2017	1
4	0108			4
5	0168			1
6	0214		2020	1
7	0132			3
8	0168		2022	4
Нисдэг тэрэгний зөрчил				
9	0287	Гадаадаас	2019	1
10	0287	Дотоодоос	2020	1

Хүснэгт №1. Нисдэг тэрэг болон нисгэгчгүй нисэх хэрэгслийн зөрчлийн судалгаа.

ГЭРЭЭТ ХИЛЧНИЙ АЛБАНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

Ц.Эрдэнээ
Хилийн цэргийн Хил судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, хурандаа

Түлхүүр үгс: Улсын хил, хилийн түүх, хилийн аюулгүй байдал, гэрээт хилчний алба, түүний үйл ажиллагаа.

Хураангуй: Гэрээт хилчний алба, улсын хилийг гэрээгээр хамгаалж ирсэн уламжлалт бодлого, гэрээт хилчний албаны өнөөгийн байдал, эрх зүйн үндэс, хөрш орнууд болон хөгжингүй зарим орны туршлага, олон улсын жишигт нийцүүлэн эрх зүйн зохицуулалт, тогтолцоог боловсронгуй болгох

Боловсруулах асуудлууд:

1. Цэргийн албыг гэрээгээр хаах ойлголт, түүний эрх зүйн орчин;
2. Гэрээт хилчний албаны өнөөгийн байдал;
3. Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох талаар;

1. Цэргийн албыг гэрээгээр хаах ойлголт, түүний эрх зүйн орчин

Гэрээт хилчний албыг гадаад оронд нэвтрүүлж буй туршлага

Дэлхий нийтийн улс, төр болон геополитикт томоохон өөрчлөлтүүд гарч, олон туйлт систем, олон улсын аюулгүй байдалд шинэ дэг журам бий болгож байна. Цэргийн номлолд гарсан өөрчлөлт нь “ирээдүйн дайны шинж чанар нь технологижсон, мэдээлэлжсэн нөхцөлд хязгаарлагдмал орон зайд буюу хил дагуух зах хүрээ бүс нутагт богино хугацаанд “түргэн" бөгөөд “ширүүн” дайн өрнөх магадлалтай”[54] тул шинэ технологи, инновацийг дэмжих, мэдээллийн ажиллагааны чадавхи, дайны бус цэргийн ажиллагааг дэмжихэд батлан хамгаалах бодлого, цэргийн стратегийг чиглүүлж байна.

ОХУ нь Украинд “цэргийн тусгай ажиллагаа”-г 2022 оны 02 дугаар сарын 24-нд эхлүүлж дайны байдалтай байна. НАТО-ийн гишүүн Европын зарим улсууд болзошгүй дайнд бэлтгэж, цэргийн

[54]Олон улс судлал - 2020: Монголын Хятад судлал. -Уб., 2021. 98 дахь тал.

хүчээ зузаатгаж, мөн Франц улс Африкийн хэд хэдэн улс бие даасан цэргийн ажиллагаа явуулж, илүү өргөн хэмжээний дайны бэлтгэлийг хангаж, АНУ, БНХАУ хоёр Тайваны асуудал дээр хурцадмал байдалд шилжиж, Тайвань улс дайнд далдуур бэлдэж байна. Энэ ч үүднээс дэлхийн ихэнхи улс орон гэрээт цэрэг (хөлсний цэрэг) буюу мэргэжлийн армитай болох хандлагатай байна. Байнгын бүрэлдэхүүн, мэргэжлийн цэрэг, дайчидтай армийн байлдааны ур чадвар өндөр байдаг билээ. Энэ нь мэргэжлийн хүчирхэг бие бүрэлдэхүүнтэй болохын үндэс болох нь дэлхий нийтийн улсуудын мэргэжлийн армиудын чиг хандлагаас харагдаж байна. ОХУ, БНХАУ, АНУ, Казахстан зэрэг орны мэргэжлийн цэргийн давуу талыг харьцуулсан судалгаан дээр үндэслэн алба хаах нөхцөл, цалин, хангамж, нийгмийн асуудлыг Хилийн цэрэгт хэрэгжүүлэх нь зайлшгүй асуудал болж байна.

ОХУ, Монгол Улс батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарт хамтын ажиллагаагаа улам гүнзгийрүүлэхээр ажиллаж байгаа өнөө үед хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн хамтарсан тунхаглалд "...талууд хоёр улсын прокурор, шүүх, хил хамгаалах, хууль сахиулах байгууллага, тусгай албад хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ"[55] гэж дурьджээ. Улсын хил хамгаалах байгууллагын хууль, тогтоомжоор хүлээлгэсэн чиг үүрэг нь олон талтай, өргөн хүрээтэй болж үндэсний аюулгүй байдал, орчин цагийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагаар шинэчлэгдэх, чадваржих шинэ шинэ зорилтууд дэвшигдэж байна.

”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого-д долоодугаар бүлгийн “Амар тайван, аюулгүй нийгэм” Зорилго 7-д ‘Мэргэжлийн цэрэг’[56], ‘Мэргэшсэн хилчин’[57], ‘Мэргэшсэн хилчний алба’[58], Хил хамгаалах байгууллагын стратегийн зорилгод туссан “мэргэжлийн” чиг хандлагад нийцүүлэх, улсын хилийг гэрээт болон “мэргэжлийн” цэргээр хамгаалах, бие бүрэлдэхүүнийг

[55] Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 100 жилийн ойн Хамтарсан тунхаглал. 2021.12.17.
[56]”Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. //Төрийн мэдээлэл. 2020. №. 25.
[57]Мөн тэнд 1287 дахь тал.
[58]Мөн тэнд 1287 дахь тал.

“мэргэшүүлэх” нь Хил хамгаалах байгууллагын анхаарал хандуулах асуудал мөн.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлийн 1.11-д ”Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх”[59], Зэвсэгт хүчний тухай хуулийн 5.2.6-д Монгол Улсын Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн ”бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон гэрээгээр сайн дурын үндсэн дээр нөхөн хангах”[60] нь төрийн цэргийн байгуулалтын үндсэн зарчмын нэг болохыг хуульчилж өгсөн байна. Энэ бол Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн байгуулалтын нэгэн чухал арга хэмжээ юм.

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг дэлхийн нийтийн жишигт ойртуулан мэргэжлийн чиг хандлагад шилжүүлж, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг бол Мэргэжлийн цэрэгт суурилсан гэрээт хилчний албыг зохион байгуулах явдал юм.

Монгол Улс XXI зууны хөгжлийн чиг хандлагатай уялдуулан цомхон бүтэц бүхий мэргэжлийн цэргийн албыг бий болгох талаар гаргасан төрийн бодлого, цэргийн шинэчлэлийн бодлого, үзэл баримтлалыг хэрэгжүүлэх зорилгоор хил хамгаалах байгууллагад гэрээт хилчнээр улсын хилийг хамгаалж ирсэн 15 гаруй жилийн хугацааны явцад дүн шинжилгээ хийх, ололтыг нь бататгах, гарсан сөрөг үзэгдлийг багасгах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, цэргийн гэрээт албанд шинэлэг арга, хэлбэрээр хандах шаардлага тулгамдсан асуудал болж байна.

Монгол Улсын Их хурлаас 2016 онд батлагдсан Батлан хамгаалахын багц хуулийн Цэргийн албаны тухай хуулиар алба хаах дараах 5 хэлбэрийг хуульчлан баталгаажуулсан байна. Үүнд:

-“хугацаат цэргийн алба;

-цэргийн сургуулийн сонсогч, сурагч;

-оюутан цэрэг;

-цэргийн дүйцүүлэх алба (энэ алба нь мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах; биеэр дүйцүүлэн хаах гэсэн хоёр хувилбартай);

---

[59] Мөн тэнд.

[60]Зэвсэгт хүчний тухай хууль. //Төрийн мэдээлэл. 2016. №36.

-гэрээт цэргийн алба тус тус болно.”[61]

Монгол Улсын батлан хамгаалахын багц хуулиудаар цэргийн алба хаах олон хэлбэрийг бий болгосон нь Монгол Улсын иргэн бүрийн эх орноо батлан хамгаалах хийгээд цэргийн алба хаах үүргээ биелүүлэх боломжийг бүрдүүлэх зорилготой юм. Энэ чиглэлээр хийх ажил үүрэг, шинэчлэл өөрчлөлт нь тулгамдсан асуудал болж байна. Цэргийн алба хаах олон хэлбэрийг бий болгосон шийдвэр гарснаас хойш зарим нааштай давуу талыг авч үзэн тооцож, цаашид алба хааж байгаа бие бүрэлдэхүүний мэргэжил эзэмшүүлэх, улсын хил хамгаалалтад цэргийн гэрээт алба хаагчдыг оролцуулах, тэдний эрх зүйн орчин, сургалтын тогтолцоог боловсронгуй болгох, алба хаах нөхцөл, ахуй хангалт, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, илүү оновчтой тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй байна.

2. Гэрээт хилчний албаны өнөөгийн байдал

Гэрээт цэргээр хамгаалж ирсэн түүх

Монголын нутаг дэвсгэрийн хил хязгаар нь өрхийн харуул, цагдаагаар хамгаалагдаж ирсэн түүхтэй. “Өрхийн харуулыг хошууны захиргаанаас зөвхөн өрхийн хошууны хилд томилон суулгадаг байсан бөгөөд өрхийн харуул нь арваад хүний бүрэлдэхүүнтэйгээр өөрийн харъяалсан нутгийн байгалийн баялаг, хүн ам оршин сууж байгаа нутаг, бэлчээр, зах хязгаарыг сахин хамгаалдаг байжээ.”[62] Харуул тус бүр өөрийн гэсэн мал сүрэгтэй, хэрэглэх цай, нүүрс, түлээ, гэр зэргийг улсаас олгодог, хийсэн бүх ажилдаа тодорхой цалин хөлс авдаг байсан. Түүхэн явцад “харуулын цайз“, “гэр харуул”, “суман харуул”, “өртөө хавсарсан өрхийн харуул”, “цагдаа харуул”, “алтны харуул”, “хайч харуул”, “харуул занги”, “хилийн пост”, “хилийн харуул” гэх мэт янз бүрээр нэрлэгдэж, тухайн үеийн нийгмийн хөгжлийн үйл явцад тохирон өөрчлөгдөж, шинэ шинэ агуулгаар баяжин өнөөг хүрчээ.

Монгол Улсын хилийг өнө эртнээс гэрээт цэргээр хамгаалах үйл явц нь 1990 онтой золгож, улсын хилийн хамгаалалтын арга, хэлбэрийг боловсронгуй болгох, нягтралыг нэмэгдүүлэх талаар янз бүрээр эрэл хайгуул хийж байсан бөгөөд хилийн заставын тодорхой хэсгийг гэрээгээр хамгаалах туршилтыг хилийн 0165, 0129, 0184,

[61]Төрийн мэдээлэл.Уб.,2016 он №36./945/.1928 дахь тал.

[62]Цэдэн-Иш Б. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. Тэргүүн дэвтэр. (БНМАУ-ын өмнө зүгийн хил).Уб.,1984.47 дахь тал.

0146, 0198, 0132, 0277, 0257, 0286 дугаар ангиудад 2000 он хүртэл явуулаад эрх зүйн орчин, улс төрийн нөхцөл байдал, эдийн засгийн боломж, төсөв хөрөнгийг хүрэлцээгүй байдал гэх мэт шалтгааны улмаас тухайн үед Хилийн цэрэгт гэрээт хилчний албыг хөгжүүлэх бодлого төгс хэрэгжиж чадаагүй байна.

Хил хамгаалах байгууллагад 1990 оны үед УАБХЕГ-ын ХЦ-ийн даргын 1991 оны Б/383 дугаар “Гэрээт хил хамгаалагч нарыг авах тухай” тушаалын дагуу умард хилийн 0277, 0257, 0286, өмнөд хилийн 0165, 0214, 0129, 0184, 0146, 0132, 0198 дугаар ангиудад гэрээт хэсэг хариуцагч, гэрээт хил хамгаалагч нарыг гэрээгээр авч үүрэг гүйцэтгүүлж эхэлсэн боловч улс орны эдийн засгийн боломж, төсөв хөрөнгийн хүрэлцээгүй байдлаас шалтгаалж, гэрээт хилчний албыг хөгжүүлэх бодлого төгс хэрэгжиж чадаагүй байна.

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг дэлхийн нийтийн жишигт ойртуулан мэргэжлийн чиг хандлагад шилжүүлж, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд зайлшгүй шийдвэрлэх асуудлын нэг бол бол гэрээт хилчний албыг зохион байгуулах явдал юм.

2007 оноос эхлэн хилийн 0129 дүгээр ангийн “Үзүүр ус”, 0243 дугаар ангийн “Хутаг-Өндөр” заставуудад “Гэрээт хилчин”-ий албыг туршилтаар хэрэгжүүлж, хил хамгаалах байгууллагад 2007 оноос хойш 6 мянга гаруй иргэн байлдагч, түрүүчээр гэрээт хилчний алба хааснаас ахлагчийн бүрэлдэхүүнд 867 гаруй, офицерын бүрэлдэхүүнд 100 гаруй цэргийн алба хаагч байна. Хилийн 13 отрядын 38 заставт гэрээт хилчний албыг зохион байгуулж байна.

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд хилийн цэргийн 13 ангийн гэрээт хилчний нөхөн хангалт 44.7 хувьтай байна.

3. Гэрээт хилчний албыг боловсронгуй болгох талаар;

1. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний жанжин штабын холбогдох газар, хэлтэстэй хамтарч “Гэрээт хилчний алба”-ны талаар хуулийн төсөл боловсруулж, эрх бүхий байгууллагад уламжилж УИХ-аар батлуулах;

2. Монгол Улсын Цэргийн албаны тухай хуульд *“цэргийн гэрээт алба хаагч”*, Монгол Улсын хилийн тухай хуульд *“гэрээт хилчин”* гэж нэр томьёог өөр өөрөөр томьёолон хуульчилсан байна. Тиймээс “Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д *“гэрээт хилчин”* гэсний оронд *“цэргийн гэрээт алба хаагч”*

гэж өөрчлөн оруулж Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-т заасантай адил ойлголттой болгох;

3. Монгол Улсын хилийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.7-д “Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагч, *гэрээт хилчинд* нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн салбарт 50 хувь, суурин бус газарт байрладаг хилийн цэргийн ангид 35 хувь, нийслэл, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн цэргийн анги, агаарын цэргийн салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно” гэж нэмэлт өөрчлөн томъёолох;

4. Монгол Улсын хилийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-д *“Гэрээт хилчин” гэж “хилийн цэрэгт хугацаат цэргийн албыг 6 сар хаасны дараа сайн дурын үндсэн дээр гэрээгээр цэргийн жинхэнэ алба хааж байгаа иргэнийг”* гэж өөрчлөн томъёолох;

5. Хилийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д “Гэрээт хилчин нь улсын хил хамгаалах байгууллагад алба хааж байгаа ахлагчийн нэгэн адил хууль тогтоомжид заасан цалин, хангамж эдэлнэ” гэж заасан заалтын дагуу ахлагчийн бүрэлдэхүүний цалингийн шатлалаар цалинжуулах;

6. Хилийн тухай хуулийн 39.4-д “Улсын хил дээр алба хааж байгаа хилчний гэр бүлийг тэргүүн ээлжид ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгоно” гэж заасны дагуу гэрээгээ дахин сунгасан тохиолдолд гэрээт хилчний гэр бүлийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож улсын төсвөөс олгодог байх.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах:

1. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоолын "Цэргийн гэрээт алба хаах журам"-ын 2.3.1-т Хугацаат цэргийн албыг 6 сар хаасан байх;

2. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоолын "Цэргийн гэрээт алба хаах журам"-ын 4.2-т “гэрээний хугацааг цаашид хоёр жилээр 36 нас хүртэл сунгаж болно;

3. Монгол Улсын Засгийн газрын тогтоол "Цэргийн цолны цалингийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай” -д “Гэрээт хилчдийн цолны нэмэгдэлийг ялгавартайгаар олгох; - байлдагч 10%, - ахлах байлдагч 12%, - дэд түрүүч 14%, - түрүүч 16%, - ахлах түрүүч 18% нэмэлт өөрчлөлт оруулах тухай;

4. Гэрээт хилчин нь гэрээгээ дахин сунгасан тохиолдолд Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 174 дүгээр тогтоолын дагуу ахлагчийн бүрэлдэхүүнийг цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлээр тэднийг нэмж хангах;

1. Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албыг байлдагч, түрүүчээр хаах журмыг шинэчлэх;

2. Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам”-ын 4.11-ын “Цэргийн гэрээт албаны байлдагч, түрүүч цэргийн нэгтгэл, анги, байгууллагын захирагч, даргын шийдвэрээр цэргийн ангийн байнгын байрлалаас гадна байрлаж болно” гэсэн заалтыг үндэслэн цаашид тогтвор суурьшилтай ажиллах, гэр бүлтэйгээ хамт амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хилийн 0108, 0101, 0303 дугаар анги, хилийн шалган нэвтрүүлэх заставт алба хааж байгаа гэрээт хилчдийг байнгын бүрэлдэхүүний нэгэн адил ажлын хуваарьт оруулах;

3. Гэрээт хилчний алба зохион байгуулж байгаа хилийн анги, тусгай салбарын гэрээт хилчдийг ээлжийн системд оруулж, 14, 14 хоногоор ажилдаа ирж, очдог болгох;

4. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.6, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4 дэх заалтыг үндэслэн хөдөлмөрийн гэрээнд тодорхой тусгаж, хуваарын дагуу амралтыг эдлүүлэх боломжтой гэсэн эрх зүйн орчныг үндэслэн гэрээт хилчдийн ээлжийн амралтыг хугацааг хувааж жилд *2 удаа олгох,* орон нутгийн чөлөөг *улиралд 1 удаа 14 хоногоор* ажлын үр дүн, ар гэрийн байдлыг харгалзаж олгох;

5. Гэрээт хилчний албыг жилд цэрэг халагдсаны дараа 2-3 удаа элсүүлдэг журамд шилжүүлэх;

6. Гэрээт хилчнээр иргэнийг сонгон шалгаруулах комиссын үүрэг, хариуцлагыг нарийвчлан тодорхойлж, үр дүнг тооцох хэмжүүртэй болгох, гэрээт хилчинг шалгаруулах тоон болон чанарын шалгуур үзүүлэлтийг шинэчлэх;

7. Гэрээт хилчин нь хилийн болон хил орчмын нөхцөл байдалтай уялдсан хил хамгаалах үндсэн чиг үүргээ биелүүлэхээс гадна энхийг сахиулах ажиллагаанд болон хилийн боомт дээр үүсэх эмх, замбараагүй байдал, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох, гамшгийн үед орон нутгийн байгууллагад дэмжлэг үзүүлэх, хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд баялгийг авран хамгаалахад туслах зэрэг үүрэг гүйцэтгэх чадавхыг зохих түвшинд эзэмшүүлэхэд цэргийн сургалт бэлтгэлийн зорилго, зорилт чиглэгдсэн байх;

8. Гэрээт хилчний албаны түрүүч, байлдагчийн сургуулийн жилийн сургалт, бэлтгэлийг *“өвлийн улирлын”, “зуны улирлын”* гэсэн хоёр үе шаттай байхаар төлөвлөн, өвлийн улирлын сургалтыг хугацаат цэргийн алба хаагчдын цэргийн сургалт бэлтгэлийн үе шаттай зэрэгцүүлэн 11 дүгээр сарын 15-наас дараа оны 4 дүгээр сарын 15 хүртэл, зуны улирлын сургалт, бэлтгэлийг 5 дугаар сарын 15-наас 9 дүгээр сарын 15 хүртэл үргэлжлэхээр зохион байгуулах;

9. Гэрээт хилчнээр бүрдүүлсэн анги, тусгай салбарын гэрээт офицер, ахлагч нь цэргийн сургалт бэлтгэлийг удирдан явуулах явцдаа ажлын байран дээр суралцаж, өөрийгөө хөгжүүлснээр эрхэлж буй албан тушаалаас нэг шат дээгүүр албан тушаалд ажиллах боломжийг холбогдох журамд тусгах;

10. Гэрээт хилчний албанд шинээр элсэж байгаа иргэний албаа хаахын өмнөх сургалтыг 30 хоногийн хугацаатай томилогдох албан тушаалын цэргийн мэргэжил эзэмшүүлэх сургалтад заавал хамруулж байх;

11. Хилийн анги, салбарыг байлдагч, түрүүчийн албыг гэрээгээр хаахаар элссэн залуучуудыг хүсэл, сонирхлоороо мэдлэг, мэргэшлээ ахиулах, мэдээлэл олж авах, эрүүл мэндээ хамгаалах, бие бялдраа чийрэгжүүлэх эрэлт, хэрэгцээг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэх;

12. Гэрээт хилчнийг аймаг орон нутгийн харьяаллыг харгалзан хилийн ангиудад томилох;

13. Харуул хамгаалалт, нэгдсэн арга хэмжээнээс бусад тохиолдолд соёл олон нийтийн ажил, хоолонд орох, амралтын өдрүүдэд энгийн хувцастай байхыг зөвшөөрөх талаар ангийн захирагч гэрээнд нь тодотгол оруулах;

14. Гэрээт хилчний ахуйн хангамжийг сайжруулах, амралт, чөлөөт цагаараа өмсөх дүрэмт хувцасны хангамжтай болгох;

15. Хугацаат цэргийн албанаас гэрээт хилчний албанд шилжсэн гэрээт хилчдийг ар гэрийн болон бусад шалтгаанаар гэрээ цуцлагдах тохиолдолд хугацаат цэргийн албыг нөхөж хаалгах;

16. ХХЕГ-т гэрээт хилчний хэлтэс, гэрээт хилчний албанд бүрэн шилжсэн хилийн отрядод алба, хилийн застаыг гэрээт хилчний заставын дарга орон тоог тус тус бий болгох.

17. Төрийн болон байгууллагын нууцыг задруулахгүй байх талаар салбарын захирагч баталгаа авсны үндсэн дээр гэрээт хилчинд үүрэн холбооны утас чөлөөтэй ашиглахыг зөвшөөрөх;

18. Засгийн газрын 11 дүгээр тогтоолоор батлагдсан “Цэргийн гэрээт алба хаах журам”-ын 4.10-ын “Цэргийн гэрээт алба хаагчийг энхийг дэмжих ажиллагаанд Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай хуулийн дагуу сайн дурын үндсэн дээр оролцуулж болно” гэсэн заалтыг үндэслэн 2 жил алба хаасан гэрээт хилчнийг Энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах;

1. Хилийн албаны сургууль, офицерийн курс, ахлагч бэлтгэх дамжаа, харуулын даргын сургалтын хөтөлбөрт гэрээт цэргийн талаар хоёр хүртэл багц цагийн хичээл оруулах асуудлыг шийдвэрлэн, сургалтын хөтөлбөрт тодотгол оруулах;

2. Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуульд гэрээт хилчдийг 2 дугаар дамжаанаас элсүүлэн суралцуулах, 1 дамжааны хичээлийн хөтөлбөрийг эчнээгээр болон онлайнаар Хил хамгаалах байгууллага өөрийн байгууллага дээрээ явуулах талаар БШУЯ, ХХЕГ, ДХИС-ийн хооронд санамж бичиг байгуулах;

3. БШУЯ, ХХЕГ, ДХИС-ийн хооронд байгуулсан санамж бичигт захиалагч байгууллагаас элсэх гэрээт хилчдийг элсэлтийн ерөнхий шалгалтын суурь хичээл болон хавсарга хичээлд 50 хувиас дээш оноо авсан тохиолдолд Хилийн албаны сургуульд элсүүлэн суралцуулж байхаар заалт оруулж мөрдөх;

4. БШУЯ, ХХЕГ, ДХИС-ийн хооронд байгуулсан санамж бичигт Дотоодын их, дээд сургууль, коллежид суралцаж байх хугацаандаа цэргийн гэрээт албыг хилийн цэрэгт үлгэр жишээчээр бүрэн хааж дуусгасан иргэнийг тухайн сургуульдаа эргэж суралцахад нэг жилийн сургалтын төлбөрийг 50 хувиар хөнгөлөх, өөрийн хүсэлтийн

дагуу Дотоод Хэргийн Их Сургуулийн Хилийн албаны сургуулийн элсэлтийн шалгалтад орох эрхийг олгох;

5. Цэргийн гэрээт алба хаасны дараа иргэн мэргэжил эзэмших сургалтын зардлынхаа зохих хувийг төлөх хуримтлалтай болохуйцаар сарын үндсэн цалин, мөнгөн урамшууллыг нэмэгдүүлэх гарц, арга замыг олж хэрэгжүүлэх;

1. Хилийн цэрэгт гэрээт хилчний албыг бүрэн хаасан иргэнийг орон нутгийн засаг захиргаа төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжүүд эхний ээлжинд ажлын байраар хангах, талаар аймаг орон нутгийн удирдлагатай зөвшилцөж, санамж бичиг байгуулах;

2. Ерөнхий боловсролын сургуулийн төгсөх анги бүрээс 10 гаруй хүүхдийг гэрээт хилчнээр элсүүлэх судалгааны ажлыг аймаг, орон нутагт зохион байгуулж, явуулдаг журмыг аймаг орон нутгийн удирдлагатай байгуулсан санамж бичигт тусгаж, хүний нөөцийн эх үүсвэртэй болох арга хэмжээг зохион байгуулах;

ДҮГНЭЛТ:

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод “Хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох”-оор заасан билээ.

Тиймээс хилчид шинжлэх ухаан ба онолын гүнзгий мэдлэгт тулгуурлан улсын хил хамгаалалт туүний онолын үндсэн асуудлуудыг судалж өөрсдийн үйл ажиллагааны үндэс болгох нь зайлшгүй шаардлагатай албаны хэрэгцээ мөн.

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБАНД ТАТАГДСАН ИРГЭДИЙН СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАРИМ АСУУДАЛ, ТЭДЭНД ҮЗҮҮЛЭХ СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ

Б.Хишигжаргал
Хилийн албаны сургуулийн
Сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад

Илтгэлийн хураангуй: *Хил хамгаалах албанд* тулгамдаж буй асуудлын дотор цэргийн алба хаагчийн сэтгэцийн эрүүл мэнд, зохистой тусламж, үйлчилгээ чухал байр суурь эзэлж байна. Сүүлийн жилүүдэд хугацаат цэргийн алба хаагч хүний амь нас хохироох, цэргийн албанаас оргон зайлах зэрэг гэмт хэрэг үйлдэх, амиа хорлох тохиолдол цөөнгүй гарч, цэргийн албаны нэр хүнд, бие бүрэлдэхүүний сэтгэл зүйд сөргөөр нөлөөлөх болсон. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил гарахад олон хүчин зүйл нөлөөлж байгаагаас цэргийн албанд татагдсан эрэгтэйчүүдийн нийгэм, сэтгэл зүйн онцлог, эрүүл мэндийн байдал жил ирэх тусам доройтож байгаа шалтгаан, нөхцөл ихээхэн анхаарал татаж байна. Иймд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдагчдаас сэтгэл зүйн сорил авч, үр дүнг шинжлэн судалсны үндсэн дээр зохистой тусламж, үйлчилгээ үзүүлж үр нөлөөг тандах замаар цэргийн албанд сэтгэл зүйн шинжлэх ухааны онол, практикийг оновчтой ашиглах арга зүйн хэрэгцээ, шаардлага, ач холбогдол их байгааг онцлон дүгнэж, санал, зөвлөмж дэвшүүлэв.

Тус илтгэл дараах агуулгатай. Үүнд:

1. Оршил;
2. 18-25 насны эрэгтэйчүүдийн сэтгэл зүйн онцлог, сэтгэцийн эрүүл мэндийн асуудал;
3. Цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдагчдаас авсан сэтгэл зүйн зарим сорилын үр дүнд хийсэн дүн шинжилгээ;
4. Цэргийн анхан шатны бэлтгэл сургалтын хугацаанд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний үр дүн гэсэн асуудал багтана.

Түлхүүр үг: Цэрэг татлага, сэтгэцийн эрүүл мэнд, тусламж үйлчилгээ

ОРШИЛ

Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үүргийг ёсчлон биелүүлнэ[63]. Үүний хүрээнд, Монгол Улсын иргэн 18-25 насны эрэгтэйчүүдийг хугацаат цэргийн албанд татна[64] хэмээн хуульчилсан. Цэрэгт татагдсан иргэдийг аймаг, нийслэлийн цэрэг татлагын дамжин өнгөрүүлэх төв дээр баримт бичгийн болон бие махбод, сэтгэл зүйн эрүүл мэндийн үзлэгт оруулсны үндсэн дээр тэнцсэн иргэдийг цэргийн албанд авдаг. Гэвч сүүлийн жилүүдэд цэргийн албанаас зайлсхийх хандлага нэмэгдэж, цэрэг татлагын хяналтын тоонд хүрэхгүй байдал гарах болсны улмаас эрүүл мэндийг сайтар харгалзахгүйгээр цэргийн албанд тэнцүүлэхийг илүүд үзэх болжээ.

Түүнчлэн мэргэжлийн сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарын хүрэлцээ бага, цэрэг татлагын хугацаа давчуу зэргээс шалтгаалан цэргийн албанд татагдсан иргэдийн сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгийг нарийвчлан хийх боломж хомс зэрэг асуудал бий. Алба хаах эхний саруудад (1-6 сар хүртэл) дасан зохицох явцдаа ихээхэн стресст орж, хууль бус үйлдэл, зөрчил гаргадаг байдал нь цэрэг татлагын үеэр сэтгэцийн эрүүл мэндийн үзлэгийг сайтар хийж, улмаар зохистой бэлтгэл сургалт хийх хэрэгцээ, шаардлага тулгамдаж байгааг харуулж байна.

Цэргийн залуусын төлөө хийх нийгэмд чиглэсэн ажил нь юуны түрүүнд нэн аюултай, стрессийн эмгэг бий болгоход хүргэдэг шинэ нөхцөл болон цэргийн амьдралын бэрхшээл, түүнийг даван туулах чадваргүй хүмүүсийг тодорхойлоход орших бөгөөд энэ нь цэргийн нөхөд ба удирдлагуудаа хөнөөх, иргэдийн эсрэг хүчирхийлэл үйлдэх, амиа хорлох зэрэг хор уршгаас урьдчилан сэргийлнэ[65]

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд 217 гэмт хэрэг, зөрчилд 298 алба хаагч холбогдон шалгагдаж, 37 цэргийн алба

---

[63] Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 1-ийн 4, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сан https://legalinfo.mn/mn/detail/367 , [сүүлд үзсэн: 2023.04.08]

[64] Монгол Улсын Цэргийн албаны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим сан https://legalinfo.mn/mn/detail?lawId=12124, [сүүлд үзсэн: 2023.04.08]

[65] Халилюлина, Т. Н. (2009). *Социально-психологические тенденции диссоциальных явлений у призывников.* Москва.

хаагчийн амь нас хохирсны 13 нь хугацаат цэргийн алба хаагч,107 цэргийн алба хаагч дүрмийн бус харьцааны зөрчил гаргасны 36 нь хугацаат цэргийн алба хаагч байсан бол цэргийн албанаас оргон зайлах гэмт хэрэгт 31 хугацаат цэргийн алба хаагч холбогджээ[66]

Хугацаат цэргийн алба хаагчдын зан үйлийн нийгэм-сэтгэл зүйн сөрөг шинж чанар нь гэр бүл дэх орон гэргүй байдал, хайхрамжгүй байдал, зохисгүй хүмүүжил зэрэг нийгмийн үзэгдэлтэй холбоотой.

Нийгэм, эдийн засгийн хурдацтай өөрчлөлт, олон талт соёлын нөлөөгөөр цэргийн насны залуусын нийгэм-сэтгэл зүйн сөрөг хандлага нэмэгдэж байгааг олон судалгааны үр дүн харуулж байна. Тухайлбал:

ДЭМБ-ийн судалгаагаар манай улсын хүн амын 3% нь ямар нэг хэлбэрийн сэтгэцийн эмгэгтэй бол 38% нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай буюу сэтгэцийн эмгэгт өртөх магадлал өндөр гэсэн статистик гарсан;

Хүн амын дундах амиа хорлосон нийт тохиолдол хүйсийн харьцааны хувьд 1729 эрэгтэй, 326 эмэгтэй бөгөөд жилд дунджаар 346 эрэгтэй, 66 эмэгтэй буюу эрэгтэйчүүд эмэгтэйчүүдээс 5,2 дахин их амиа хорлож байна. Өөрөөр хэлбэл амиа хорлосон иргэдийн 84% нь эрчүүд байгаа ба 29 хүртэлх насныхны амиа хорлолт өсөх хандлагатай байна[67]

“Оптимал эн макс” ХХК-ийн судалгааны багийн 2022 онд хийсэн “Монгол өсвөр насныханд тохиох сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлүүд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлс” сэдэвт судалгаагаар өсвөр насныхны 21% буюу 5 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох тухай нухацтай бодож /5 болон түүнээс дээш удаа/, 16% буюу 6 хүүхэд тутмын 1 нь амиа хорлох үйлдэл дор хаяж нэг удаа хийж байсан. Өсвөр насныхны 10 хүүхэд тутмын 7 нь буюу 72,1% нь нэр хочоор дуудуулах, янз бүрийн үгээр хэлж шоглуулах зэрэг сэтгэл зүйн дээрэлхэлтэд 2-оос дээш удаа, 38,2% нь зодуулах, цохиулах зэргээр

---

[66] ХЭҮК. (2021). *Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл.* Улаанбаатар.

[67] Б.Өнөрмаа. (2017). *Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа.* Улаанбаатар.

бие махбодын дээрэлхэлтэд 2-оос дээш удаа тус тус өртөж байсан гэсэн дүн гарсан[68]

Цэргийн сэтгэл зүйч, эрдэмтдийн судалгааны үр дүнгээр сүүлийн жилүүдэд цэргийн албаа хаах залуучуудын бие бялдар, сэтгэц мэдрэл, мэдээллийн стрессээс үүдэн дасан зохицох чадвар буурснаар цэргийн албаны эхний саруудад мэдрэл, сэтгэцийн өвчнөөр буцагсдын тоо нэмэгдэж байна.[69]

Иймээс хугацаат цэргийн албанд татагдсан иргэдийн нийгэм, сэтгэл зүйн байдалд дүн шинжилгээ хийх, сонгон шалгаруулалтад өндөр ач холбогдол өгч, тэднийг албанд дасгаж, дадлагажуулах ажлыг сэтгэл зүйн шинжлэх ухаанд тулгуурлан зохион байгуулах хэрэгцээ шаардлага тулгарч байна. Ялангуяа цэрэг татлага болон цэргийн анхан шатны бэлтгэл сургалтын төвд суралцах хугацаанд олон соёлын нөлөөн дор өсч хүмүүжсэн төрөл бүрийн сонирхол, зан төлөвтэй залуусын сэтгэц-физиологи, нийгэм-сэтгэл зүйн шинж чанар, алба хаах хандлага, сэдэл, цэргийн алба хаах бэлэн байдал, дасан зохицох чадварыг богино хугацаанд оношлон, сонгон шалгаруулахад шаардлагатай мэдлэг, чадвар сэтгэл зүйч, сэтгэцийн эмч нарт нэн чухал асуудал болоод байна.

Судалгааны зорилго: Хугацаат цэргийн албанд татагдсан эрэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндийн төлөв байдлыг тандаж, цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад сэтгэл зүйн сорил ашиглах болон сэтгэл зүйн бэлтгэлийг дээшлүүлэх дэмжлэг, туслалцаа үзүүлэх онол, арга зүйг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлоход энэхүү судалгааны зорилго оршино.

Судалгааны арга зүй: Судалгааг гүйцэтгэхдээ Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, ном, судалгааны бүтээл зэрэг эх сурвалж судлан, анализ, синтезийн арга болон харьцуулсан судалгааны аргыг хэрэглэв. Цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдагчдаас авсан сэтгэл зүйн сорилын дүнд шинжилгээ хийж, судалгаанд ашигласан.

---

[68] Optimal Nmax. (2022). “Монгол өсвөр насныханд тохиох сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлүүд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлс”. Улаанбаатар.

[69]Филатов, Константин Геннадьевич. (1998) Психофизиологические и психологические особенности юношей-призывников с различным отношением к военной службе. Ростов на Дону

Судалгааны түүвэр: Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 2021 оны II, 2022 оны I ээлжийн хугацаат цэргийн алба хаагчдын дунд хийсэн судалгааг түүвэрлэж тусгалаа.

18-25 НАСНЫ ЗАЛУУСЫН НИЙГЭМ СЭТГЭЛ ЗҮЙН ОНЦЛОГ, СЭТГЭЛ ЗҮЙН ЭРҮҮЛ МЭНДЭД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Хугацаат цэргийн албанд татагдаж буй залуус насны хувьд өсвөр насны сүүл үе /ДЭМБ-аас өсвөр насыг 10-18 нас хэмээн тодорхойлсон/ болон орь залуу нас /18-22/ гэсэн ангилалд хамаарагдана.

Өсвөр нас нь хүүхэд наснаас насанд хүрэгч болох завсрын буюу шилжилтийн үе учир бие физиологийн хувьд ихээхэн өөрчлөлтөд ордог. Тухайлбал бэлгийн бойжилтын нөлөөгөөр, сахал, үс ургах, биеийн галбир, хэлбэр, дуу хоолой зэрэгт өөрчлөлтүүд явагддаг. Эдгээр нь тархины бүтцийн хөгжил, олон төрлийн гармоны нөлөөгөөр зохицуулагддаг бөгөөд үүнийг дагасан сэтгэл зүйн хямралууд ч эрчимтэй явагдана. Үйл байдлаа хянах, өөрийгөө удирдах, үйл ажиллагаагаа зохион байгуулах, шийдвэр гаргахад голлох нөлөөтэй тархины духны дэлбэнгийн хэсэг 21 нас хүртэл гүйцэд хөгжөөгүй байдаг.[70]

Сэтгэл хөдлөл, урамшуулалтай холбоотой тархины лимпийн тогтолцооны эрт хөгжил, тархины духны дэлбэнгийн хожуу хөгжлийн зөрүү нь өсвөр насныхан алдаатай шийдвэр гаргах, эрсдэлт зан үйлд өртөх, сэтгэл хөдлөлөө хянах чадвар сул байх зэрэг олон асуудлын шалтгаан болдог.

Өсвөр насны үед сэтгэл ханамж, таашаал, сэтгэл ханамжийг мэдрэхтэй холбоотой допамин дааврын нөлөөнд хамгийн мэдрэг байдаг үе юм[71]. Допамины хэт идэвхжлийн нөлөөгөөр өсвөр үеийнхэн сэтгэл ханамж, таашаалыг илүүд үзэж аливаа эрсдлийг тооцоолох нь бага учир эрсдэлт зүйлд автах нь их байдаг. Мөн өсвөр үеийнхний найз нөхөдтэйгөө ойр байх, шинэлэг, эрсдэлт, сонирхолтой зүйлд татагдах шалтгаан нь окситоцин дааврын нөлөө юм.

---

[70] Ш.Батболд.(2022). Амьдралын психологи-1. Улаанбаатар.
[71] Ш.Батболд.(2022). Амьдралын психологи-1. Улаанбаатар.

Э.Эриксоны “Насны үечлэлийн онол”-оор 12-19/20 насанд “Би-ийн адилтгал ба үүрэг холилдох мэдрэмжийн зөрчил үүсдэг[72]. Цэргийн албанд дур сонирхолтой байдал хөдөө орон нутгаас татагдан ирсэн залууст илүүтэй ажиглагддаг. Үүний шалтгаан нь хөдөө орон нутгийнхан цэргийн албаны тухай эерэг хандлагатай, цэргээс халагдаж ирсэн залуусын үлгэр дуурайллыг илүүтэй харж мэдэрдэг, цэргийн алба хааснаараа бахархдаг зэрэг байдал нөлөөлсөн байх магадлалтай юм. Түүнчлэн сум, орон нутгийнхны дунд хэн цэргийн алба хаасан, хаагаагүй тухай аман бүртгэл байдаг



Зураг-1: Монголын өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа - 2022

ба ангийн болон үеийн нөхөд цэрэгт явах үед ганцаараа хоцрох нь нэр хүндгүй, хоцорсон мэт мэдрэмжийг төрүүлдэг зэргээр цэрэгт ирсэн шалтгаанаа тайлбарлах тохиолдол нэлээдгүй бий. Өсвөр насны сүүл үеэр үеийнхэнтэйгээ харилцах харилцаа, гадаад төрх болон спортын аль нэг төрөлд амжилт гаргаж эхэлбэл өөрийгөө үнэлэх үнэлэлт нь тогтвортой болж өөртөө сэтгэл хангалуун болж эхэлдэг[73]

Би-ийн адилтгал болон үүрэг холилдох зөрчлийн илрэл нь их, дээд сургуульд сурч байх үедээ цэргийн албанд татагдсан, малчин айлын хүүхдүүд, гэр бүлийнхээ гол туслах хүч байсан залууст илүүтэй илэрч байгаа нь шинэ цэргийн сургалтын төвд хийсэн

[72] Ж.Батдэлгэр, Д. Эрдэнэчулуун, Б.Туяа, Б.Оюунцэцэг. (2018). Хүний хөгжлийн сэтгэл судлал. Улаанбаатар.
[73] Birkeland, M. S. (2012). Trajectories of global self-esteem during adolescence. Journal of Adolescence , 35.

уулзалт ярилцлага, сэтгэл зүйн зөвлөгөө тусламжийн явцад ажиглагдаж байсан.

Дээрх бие физиологи, тархины хөгжил, дааврын идэвхжлийн нөлөө нь өсвөр насныханд эрсдэлтэй зан үйлээс эхлээд сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг дагуулж байдаг. Сэтгэцийн өвчний 50% орчим нь 14 хүртэл насанд, 75% нь 24 хүртэл насанд үүсдэг[74] ба энэ насныхан архи согтууруулах ундаа, мансууруулах бодист донтох эмгэгт өртөх байдал насанд хүрсэн хүмүүсээс илүү байдаг[75]. “Монголын өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа – 2022” тайланд дурдсанаар өсвөр насныхны согтууруулах ундааны хэрэглээ нас нэмэгдэх тусам 31%-89% болтлоо өссөн байна[76] */зураг-1/*

ЦЭРГИЙН АНХАН ШАТНЫ БЭЛТГЭЛ ОЛГОХ СУРГАЛТАД ХАМРАГДАГЧДААС АВСАН СЭТГЭЛ ЗҮЙН ЗАРИМ СОРИЛЫН ҮР ДҮНД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

Дайныг амжилттай даван туулахын тулд дайны нөхцөл, байдалд дасан зохицох нь чухал хэмээн цэргийн сэтгэл зүйч нар үздэг. Цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын төвийн сэтгэл зүйн хангалтын үйл ажиллагааг шинэ дайчдыг албанд дасан зохицуулахад чиглүүлж, сэтгэл судлалын шинжлэх ухааны ололт, амжилтад тулгуурлан зохион байгуулах нь чухал юм. ХХБ-ын хэмжээнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын төвийн шинэ дайчдын дунд зохион явуулах сэтгэл зүйн хангалтын ажлыг ХХЕГ-ын даргын А/40 дүгээр тушаалаар баталсан “Хил хамгаалах байгууллагын бие бүрэлдэхүүнтэй зохиох сэтгэл зүйн хангалтын түр заавар”-ыг удирдлага болгон зохион байгуулж байна.

Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 2021-2022 оны цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын хугацаанд К.Леонгардын “Зан төлөвийн хурцдал”, Лир ба Коффигийн “Дотоод зан төлөвийн онцлог, бусадтай харилцах нийтлэг чанарыг тодорхойлох”, “Мэдрэлийн цочролд орох, сэтгэцийн эмгэг авах түвшин тодорхойлох”, “Дасан зохицох чадвар”, “Түгшүүрийн илрэл”, Г.Айзенкийн “Темперамент

[74] Giedd, J. (2015). The amazing teen brain. Scientific American, 32-37.
[75] Weir, K. (2016). The risks of earlier puberty. Monitor on Psychology, 47.
[76] Optimalnmax. (2022). “Монгол өсвөр насныханд тохиох сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлүүд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлс”. Улаанбаатар.

тодорхойлох”, М.А.Манайловын “Сэтгэл хөдлөлийн чадамж тодорхойлох” аргачлалуудаар судалгаа авсан.

Дасан зохицох чадварыг тодорхойлох судалгаагаар хугацаат цэргийн алба хаагчдын 8,5% маш сайн, 45,1% дунд, 42,7% доогуур, 2,4% маш доогуур гэсэн ангиллыг тус тус эзэлж байна. Шинэ дайчдын түгшүүрийн илрэл 10,7% нь дунд /бага талдаа/, 46,3% нь дунд /өндөр талдаа/, 42,9% нь өндөр бол 1,2% нь маш өндөр түвшинд байна.

Сургалтын төвийн дайчдад хэт эрчтэй, хэт мэдрэмтгий, солигдомтгой, цочромтгой-догдломтгой хэв шинжийн зан төлөвийн хурцдал ихээр буюу 43,5%-63,5% илэрч байгаа бол хамгийн бага илэрсэн нь түгшимтгий аймтгай хэв шинж байна. Хэт эрчтэй, хэт мэдрэмтгий, солигдомтгой, цочромтгой-догдломтгой хэв шинжийн нийтлэг онцлог нь сэтгэлийн хөдөлгөөн амархан солигддог, хөнгөмсөг, хөдөлгөөнтэй байдлаасаа хэрэг төвөгт өртөх магадлал ихтэй бөгөөд ийм хэв шинжид хамаарах цэргүүдтэй аль болох тайван харилцах, тухайн үеийн сэтгэл зүйн байдлыг харгалзан ажиллах шаардлагатай. Тус аргачлалаар авсан судалгааны үр дүнд анхаарал татсан дайчдын зан төлөвийн хурцдал олон бөгөөд өндөр илрэлтэй байгаа нь ажиглагдсан.

Мэдрэлийн цочролд орох түвшин өндөр хэмээн тодорхойлогдсон хугацаат цэргийн алба хаагч 32,5%, сэтгэцийн эмгэгт өртөж болзошгүй түвшин өндөр гарсан байлдагч 28,9%-ийг тус тус эзэлж байв.

Дээрх хоёр түвшин нэгэн зэрэг өндөр гарсан болон анхаарал татаж буй байлдагч нартай ганцааарчилсан уулзалт хийхэд, гэр бүлийн харилцаа таагүй мэдрэмж төрүүлдэг; эцэг эхийн хэн нэгэн нь салсан, эсхүл нас барсан; хүүхэдтэйгээ харилцдаггүй буюу харилцааны дутмагшилтай, харилцах үедээ айдас, түгшүүр, сандралыг мэдрүүлсэн хэв шинжтэй байсан зэрэг хүчин зүйлүүд нөлөөлсөн байна. Ялангуяа хүүхдийг багад нь өвөө эмээгээр өсгүүлэх нь эцэг эхийн халуун дотно харилцаа дутагдах, өсвөр насанд тэдэнтэй харилцааны зөрчил үүсэх, гэмтлийн дараах сэтгэц цочролд орох /өвөө, эмээ нас барах, хүндээр өвчлөх үед/ шалтгаан болж, улмаар цэргийн албанд дасан зохицоход сөргөөр нөлөөлж, цэргийн захирах захирагдах харилцаа нь тухайн таагүй мэдрэмжийг өдөөх хүчин зүйл болж байна.

Эцэг эхдээ хүлээн зөвшөөрөгдөөгүй /биеийн болон үгэн хүчирхийлэлд өртөх, үл хайхрагдах/, алдаа дутагдлаа мэдэрсэн /алдаа бүрийг нь шүүмжлэх, буруутгах/ таагүй мэдрэмж, илэрхийлж чадаагүй уур бухимдал, бусад сөрөг сэтгэл хөдлөлүүд хуримтлагдсаар сэтгэцийн тулгамдсан асуудал болж, өөртөө итгэлгүй байдалд хүргэж байна. Энэ нь бусадтай харилцах, суралцах, үр бүтээлтэй ажиллахад сөргөөр нөлөөлж, сэтгэл гутрал, амиа хорлолтод хүргэх томоохон хүчин зүйл болж байдгийг /зураг-2/ “Оптимал Эн Макс” ХХК-ийн судлаачдын хийсэн “Монголын өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа – 2022” сэдэвт судалгааны тайлангаас үзнэ үү.

Зураг-2: Монголын өсвөр үеийнхний сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийн судалгаа - 2022

Эдгээр таагүй мэдрэмж, илэрхийлэгдээгүй сөрөг сэтгэл хөдлөлүүдийг тухайн байлдагч нарт таниулах, сэтгэцийн эрүүл мэнд, харилцаанд нь хэрхэн нөлөөлж байгааг ойлгуулах зорилгоор психодинамик аргыг ашиглан сэтгэл зүйн тусламж, үйлчилгээг үзүүлж ажилласан.

Сэтгэл хөдлөлийн чадамж нь амжилттай харилцааны үндэс бөгөөд ХЦАХ-дын сэтгэл хөдлөлийн чадамж /EQ/-ийг сайжруулахын тулд сэтгэл зүйн мэдлэг боловсрол олгох, сэтгэл хөдлөлөө таних, удирдах арга барилд суралцуулах, сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг тогтмол үзүүлэх шаардлагатай юм.

ЦЭРГИЙН АНХАН ШАТНЫ БЭЛТГЭЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ХУГАЦААНД ҮЗҮҮЛСЭН СЭТГЭЛ ЗҮЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Хилийн цэргийн 0243 дугаар ангийн 2021-2022 оны цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын хугацаанд сэтгэл зүйн хангалтын хүрээнд дараах ажлыг зохион байгуулсан нь нэлээд үр дүнтэй байсныг онцлон тэмдэглэж байна. Үүнд:

- Сургалтын эхний долоо хоногт цэргийн алба, захирах-захирагдах харилцааны онцлог, сүүлийн долоо хоногт хилийн застав, харуул, манаанд үүрэг гүйцэтгэхэд анхаарах зүйлийн тухай ухуулга яриа зохион байгуулсан нь цэргийн албанд болон очсон газар оронд богино хугацаанд дасан зохицоход эерэг нөлөө үзүүлсэн;
- Мэдрэмжийн карт /“Бамбар”, “Ийкүү”, “Мэдрэмж”, “Котейка” г.м/ ашиглан 8-12 дайчны бүрэлдэхүүнтэй бүлгийн дасгал ажиллуулах болон халамжлан хүмүүжүүлэгчдийн ганцаарчилсан уулзалтын тусламжтайгаар ярилцлага хийлгэснээр шинэ дайчид цэргийн албаны талаар төрсөн мэдрэмж, сэтгэгдлээ илэрхийлэх нөхцөл бүрдэж, стресс, түгшүүрийн өндөр илрэлийг бууруулах боломжтой;
- Сургалтын төвд явуулах сэтгэл зүйн бэлтгэл сургалт, ухуулга хүмүүжлийн яриаг “Сэтгэл хөдлөлийн чадамж”-ийг хөгжүүлэх сэдвээр зохион байгуулах нь тэдэнд өөрийн болон бусдын сэтгэл зүйг ойлгох, зохистойгоор удирдах, нөлөөлөх, сэдэлжүүлэх чадварыг олгоно. Үүнд, сэтгэл хөдлөлийн чадамжтай холбоотой подкаст сонсгож, богино хэмжээний видео контент үзүүлсэн нь өндөр үр дүнтэй байсан;
- Ажиглалт болон асуулгын аргын судалгааны үр дүнд үндэслэн сэтгэл зүйн байдал тогтворгүй ХЦАХ-дад психодинамик, танин мэдэхүй-зан үйлийн сэтгэц заслын аргуудыг ашиглан сэтгэл зүйн зөвлөгөө, тусламж үзүүлсэн нь дасан зохицох чадварыг дээшлүүлсэн;
- Буудлагын үеэр сэтгэл зүйч ажиглалт хийж сэтгэл зүйн байдал тогтворгүй шинэ дайчдад амьсгалын дасгал ажиллуулж, сэтгэл хөдлөлийг нь танин мэдүүлэх нь сэтгэл зүйгээ удирдах бололцоог бүрдүүлж, буудлагын чанарыг ахиулсан;
- Шинэ дайчдыг ар гэртэй нь холбоо бариулах ажлыг зохион байгуулснаар гэр бүлийн гишүүдтэйгээ ярихаас зайлсхийгсэдтэй ганцаарчилсан уулзалт хийж, тухайлбал сэтгэл хөдлөлөө барьж чадалгүй бусдын дунд уйлах, ар гэрийнхнийхээ санааг зовоохоос

эмээсэн санаа зовинол байдгийг илрүүлснээр бусад дайчдаас тусад нь яриулах хэрэгцээ, шаардлагыг хангасан;

- Бусдыг дээрэлхэх хандлагатай шинэ дайчидтай ганцаарчилсан уулзалтыг хийж, хүчирхийлэл, дээрэлхэлтэд өртөж байсан эсэхийг судлан, тухайн үеийн мэдрэмж, сэтгэл хөдлөлийг илэрхийлж гадагшлуулах сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээ үзүүлснээр эрсдэлээс урьдчилан сэргийлэх нөхцөл бүрдсэн юм.

ДҮГНЭЛТ

Улс орны нийгэм, эдийн засаг, улс төрийн тогтворгүй байдлаас үүдэн ажилгүйдэл, ядуурал, архидалт, хүчирхийлэл зэрэг нийгэм-сэтгэл зүйн сөрөг үзэгдэл нэмэгдэх хандлагатай байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд хүн амын дунд хийгдсэн сэтгэл зүйн судалгааны үр дүн цэргийн албаны насны залуусын сэтгэцийн эрүүл мэндийг анхаарах асуудал тулгамдаж байгааг илтгэж байна.

Иймд цэрэг татлагыг чанартай зохион байгуулах, тэнцсэн иргэдийг цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын хугацаанд албанд дасан зохицуулж, дадлагажуулахад сэтгэл зүйн хангалтыг оновчтой чиглүүлэх зохион байгуулалт нэн чухал юм. Цэргийн албанд татагдсан иргэдийг дадлагажуулах, сэтгэл зүйн бэлтгэл олгох сургалтын болон тэдэнд үзүүлэх сэтгэл зүйн тусламж, үйлчилгээний арга зүйг сэтгэл судлалын шинжлэх ухааны онол, практикт тулгуурлан боловсруулах шаардлагатай.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Дээр дурдсан дүгнэлтэд үндэслэн дараах санал, зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

- Хил хамгаалах байгууллагын хэмжээнд цэргийн анхан шатны бэлтгэл олгох сургалтын төвд цуглуулсан сэтгэл зүйн судалгааны датаг нэгтгэн дүн шинжилгээ хийх;
- Сэтгэл зүйчид болон сэтгэл зүйчийн орон тоонд ажиллаж буй алба хаагчдыг сэтгэл зүйн зөвлөгөөний арга зүйд суралцуулах;
- Байнгын бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, тэр дундаа сэтгэл хөдлөлийн чадамжийг хөгжүүлэх сургалтыг тогтмол зохион байгуулах санал, зөвлөмж багтана.

Ашигласан материал:

1.Ш.Батболд.(2022). Амьдралын психологи-1. Улаанбаатар.

2.Ж.Батдэлгэр, Д. Эрдэнэчулуун, Б.Туяа, Б.Оюунцэцэг. (2018). Хүний хөгжлийн сэтгэл судлал. Улаанбаатар.

3.Optimal Nmax. (2022). “Монгол өсвөр насныханд тохиох сэтгэл хөдлөл, зан үйлийн эрсдэлүүд болон түүнд нөлөөлөх хүчин зүйлс”. Улаанбаатар.

4.Б.Өнөрмаа. (2017). Монгол Улсын хүн амын дундах амиа хорлох тохиолдлын суурь судалгаа. Улаанбаатар.

5ХЭҮК. (2021). Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэл. Улаанбаатар.

6Халилюлина Т.Н. (2009). Социально-психологические тенденции диссоциальных явлений у призывников. Москва

7.Филатов, Константин Геннадьевич. (1998) Психофизиологические и психологические особенности юношей-призывников с различным отношением к военной службе. Ростов на Дону

8.Birkeland, M. S. (2012). Trajectories of global self-esteem during adolescence. Journal of Adolescence , 35.

9.Giedd, J. (2015). The amazing teen brain. Scientific American, 32-37.

10.Weir, K. (2016). The risks of earlier puberty. Monitor on Psychology, 47.

ХИЛИЙН ЗАСТАВЫН ҮҮСЭЛ, ХӨГЖИЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Удирдагч багш,
дэд хурандаа Б.Ням-Очир
Э.Батнасан
Хилийн албаны сургуулийн
магистрант, ахлах дэслэгч

Хураангуй:

Улсын хилийн тодорхой хэсгийг газар орон дээр нь байнга хариуцан хамгаалж, шинжлэх ухааны дэвшилтэд техник, технологийг хил хамгаалалтад ашиглаж, Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах нь хилийн заставын үндсэн зорилго юм.

Түлхүүр үгс: Хилийн застав**,** хилийн суман, хилийн пункт.

ОРШИЛ

Хилийн заставын алба үйл ажиллагаанд орчин үеийн зэвсэглэл, техник, теле-хяналтын технологийг нэвтрүүлснээр улсын хил хамгаалалтын үр дүн, хилийн зөрчлийн баримтжуулалт сайжирч, хилийн заставт гарч болзошгүй эрсдэлийг бууруулах, заставт алба хааж байгаа албан хаагчдын ажиллаж, амьдрах орчин нөхцлийг бүрдүүлэх, эдийн засаг, байгаль, экологийн хувьд үр ашигтай байх болно[77].

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 382 дугаар тогтоолоор Хилийн цэргийн зарим ангийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж “Хөдөлгөөнт хилийн застав”, “Тусгай бэлтгэлийн застав”, “Сургууль-застав”, “Инженер технологийн застав”, “Сөрөг тусгай ажиллагааны застав”, “Хүч нэмэгдүүлсэн застав” гэсэн нэршилтэй заставуудыг шинээр байгуулсан.

Эдгээр заставууд нь улсын тодорхой хэсэгт хил хамгаалалтыг нягтралыг нэмэгдүүлэх, хилийн зурвас, боомт, бүсэд үүссэн эмх замбараагүй байдал, гэмт хадлагын үед хилийн тусгай ажиллагаа явуулах, хил хамгаалалтад шинээр нэвтрүүлж буй технологийн дэвшилтэд техникүүдийг ашиглах, эзэмших, сургалт, дадлага зохион байгуулж, хилчдийг мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөгдөн байгуулагдаж, тавигдсан үүргээ ажилттай

[77] “Шинэ зууны застав” төсөл

гүйцэтгэж, улсын хил хамгаалалтад оролцсноор тодорхой амжилт, үр дүн гарч байгаа боловч одоог хүртэл заставын чиг үүрэг, албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолт, бүтэц зохион байгуулалтын асуудал тодорхой болоогүй байна.

Иймд судлаачдын зүгээс хилийн заставын бүтэц зохион байгуулалт, цаашдын хөгжлийн чиг хандлагад өөрсдийн санал бодлыг нэмэрлэх зорилгоор застав гэх бүтэц хэзээ анх үүссэн, хэрхэн хөгжиж, өөрчлөгдөж ирсэн, цаашдын хөгжлийн чиг хандлагын талаар судалгаа хийхийг зорьсон юм.

Үндсэн хэсэг

Застав гэдэг нэр томьёог анх XVI зууны үеэс Европын хэд хэдэн муж, сууринд ашиглаж эхэлсэн ба тухайн үед хот руу орох, гарах хөдөлгөөн, импортын бараа, материалд хяналт тавих зорилго бүхий харуулуудыг ингэж нэрлэдэг байсан байна[78].

Хөрш Оросын Холбооны Улсад (цаашид ОХУ гэх) 16 зуунаас эхлэн одоог хүртэл застав гэсэн нэр томьёог ашиглаж байна. Тухайлбал, Хувьсгалын өмнөх Орос улсад хотод орох газар, импортын бараа, зочдыг хянах цэг (Место въезда в город, пункт контроля привозимых грузов и приезжающих)[79] гэж нэрлэдэг байжээ.

ОХУ-ын Хил хамгаалатын дүрэм (Правило охраны границы)-д “...Улсын хилийн тодорхой хэсгийг шууд, тасралтгүй хамгаалах чиг үүрэг бүхий хилийн отряд, хилийн комендатурын бүрэлдэхүүнд багтдаг хилийн цэргийн (Основное подразделение пограничных войск, входящее в состав пограничного отряда или пограничной комендатуры, выполняющее задачи по непосредственной и непрерывной охране определенного участка государственной границы)[80] үндсэн нэгж...” гэж тодорхойлсон байна.

Манай улс БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1933 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Хязгаарын цэргийг дотоодыг хамгаалах газрын харьяанд байгуулж, уг шийдвэрийн үндсэн дээр Цэргийн яамны Улаанбаатар хот болон орон нутгийн цэргийн ангиудаас зарим анги, салбаруудыг хязгаарын цэрэгт шилжүүлэн өгч, хилийн отряд, комендатур, заставуудыг анх

[78] Яндекс.ru
[79] Яндекс.ru
[80] Правила охраны границы

байгуулсан[81] боловч хилийн застав гэдэг тодорхойлолтыг албаны баримт бичигт ямар нэгэн байдлаар тодорхойлоогүй байна.

Хил хамгаалалтын түүхийн эх сурвалж, баримт бичгүүдэд судалгаа хийснээр хилийн заставын үүсэл, хөгжлийг түүхийн гурван үе шатад хувааж авч үзлээ (судлаачийн санал). Үүнд:

Нэгдүгээр шат. 1933-1953 он. Хилийн заставын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийг тодорхойлж, зэвсэг, техникийн хангалт бүрдэж, улсын хилийг 80 гаруй заставын хүч хэрэгслээр хамгаалж эхэлсэн.

Хоёрдугаар шат. 1967-1978 он. Хилийн цагийн байдлаас шалтгаалан нам, төрөөс улсынхаа эдийн засгийн бололцооны хэрээр улсын хилийг байнгын хяналтад авах эхлэлийг бүрдүүлсэн.

Гуравдугаар шат. 1979-1990 он. Хилийн заставыг шинэ зэвсэг, байлдааны техник, мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, сургалтын шинэ тогтолцоог төлөвшүүлэн, байлдааны бэлэн байдал, үүрэг гүйцэтгэх чадамжид эргэлт гарсан байна.

Анхны хилийн заставууд нь хариуцсан хэсгийн өндөрлөг газарт өдрийн цагаар хянах пост, шөнийн цагт цагийн манаа томилон, сэжиг бүхий газруудыг нууц манаа, тодорхой аюул бүхий газруудад хүч нэмэгдүүлсэн постууд тавих зэргээр улсын хилийг хамгаалах чиг үүрэгтэй байсан.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Дотоод явдлын яамны сайдын 1943 оны 2-р сарын 17-ны өдрийн тушаалаар “Хязгаарын албаны дүрэм”-ийг баталж бүх отряд, заставуудад мөрдүүлж эхэлсэн байна[82].

Энэхүү дүрмээр хилийн застав нь “...Улсын хилийг зөрчилгүй байлгах, элдэв зөрчил, контрбанд үйлдэх явдалтай тэмцэх, хилийн шугамаас дотогш 100 км гүн зурвас хариуцаж, хил орчмын ардууд тэдгээрийн мал хөрөнгийг зэвсэглэсэн дээрэмчид, бусад довтолгооноос хамгаалах, хилийн зурвас доторхи ус, малын бэлчээрийг зөв зохистой ашиглахад хяналт тавих...”[83] үндсэн чиг үүрэгтэй гэж тодорхойлсон байна.

Дүрэм батлагдан гарснаар хилийн заставт шинжлэх ухаан-техникийн сүүлийн үеийн ололтыг ашиглах эхлэл тавигдаж авто

---

[81] Монгол Улсын хил хамгаалалтын түүх III. УБ 2008 он
[82] Монгол Улсын хил хамгаалалтын түүх III. УБ 2008 он
[83] Монгол Улсын хил хамгаалалтын түүх III. УБ 2008 он

машин, радио холбооны тоог нэмэгдүүлж, алслагдсан заставуудыг радио холбоотой болгож, хилийн шугамд саад барих, хянах байр байгуулах зэргээр инженер техникийн байгуулалтыг ашиглаж эхэлсэн.

Түүхийн хөгжлийн явцад хилийн заставын нэршил дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн байна[84]. Үүнд:

1933 онд Хилийн застав;

1952 онд Хилийн суман;

1953 онд Хилийн пункт;

Хил хамгаалах байгууллагаас хилийн заставын нэршил, бүтэц, зохион байгуулалтад олон удаа өөрчлөлт хийж байсан ч түүхэн цаг хугацаанд улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, цаг үеэ даган шинжлэх ухаан, техник технологийн ололтыг нэвтрүүлж, хөгжүүлэх чиглэлээр анхаарч, нэг чиглэлийн тууштай бодлого барьж байсан нь өнөөгийн шинэ зууны хилийн заставын хил хамгаалалтын үндсэн суурь болж байна.

Шинэ зууны застав буюу 2000 оны эхэн үеэс өнөөгийн хилийн заставууд нь:

-Төвлөрсөн болон нарны сэргээгдэх эрчим хүчний систем

-Сансрын холбооны утас (всат)

-Албаны программ хангамж, орон зайн мэдээллийн систем

-Байршил тогтоогч систем

-Хил хамгаалалтын нэгдсэн систем, хиймэл оюун ухаан

-Туулах чадвар сайтай автомашин ланд 76, 79, Patrol

-Нисгэгчгүй нисэх хэрэгсэл,

-Шөний дуран харааны хэрэгсэл, дулаан мэдрэгч

-Хөнгөн хөлөг RIB-750, 650, 580

-Цасны мотоцикл

-4х4 квадроцикл гэх мэт сүүлийн дэвшилтэд техник хэрэгслүүдийг хил хамгаалалтад ашиглаж байна.

2006 онд батлагдсан Хил хамгаалалтын дүрэмд хилийн заставыг “...Улсын хилийн тодорхой хэсгийг газар орон дээр нь байнга хариуцан хамгаалдаг хил хамгаалах байгууллагын тусгай салбар, хилийн отрядын үндсэн нэгж мөн..."[85] гэж тодорхойлсон. Уг

[84] Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ 2003 он

“Хил хамгаалалтын дүрэм”-д хилийн заставын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны талаар нарийвчлан тусгаж өгсөн байна.

2016 онд шинэчлэн найруулсан Хилийн тухай хуульд “...Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын Хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ...”[86] гэж заасан.

“...Улсын хилийн бүс, зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт, дохиолол, зам, тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх...”[87] зэрэг бодлогын баримт бичгүүд гарснаар эрх зүйн орчин тодорхой болж өгсөн гэж үзэж байна.

ДҮГНЭЛТ

Сүүлийн жилүүдэд хилийн зөрчлийн шинж, тэмдэг, арга хэлбэр өөрчлөгдөж, хор нөлөө нь улам бүр аюултай болж байна. Хил зөрчигчид орчин үеийн дэвшилтэд техник технологийг ашиглаж хилийн халдагшүй дархан байдалд халдаж байгаа нь өнөөгийн хилийн заставуудын одоо байгаа хүч хэрэгслээр Монгол Улсын хилийг найдвартай хамгаалах, хилийн зөрчилтэй тэмцэх, хил зөрчигчийг барьж саатуулах боломж улам бүр хязгаарлагдмал болж байна. Хил хамгаалах байгууллагаас явуулж буй эрх зүйн шинэчлэлийн хүрээнд 2022 онд Хилийн цэргийн зарим ангийн бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт оруулж “Хөдөлгөөнт хилийн застав”, “Тусгай бэлтгэлийн застав”, “Сургууль-застав”, “Инженер технологийн застав”, “Сөрөг тусгай ажиллагааны застав”, “Хүч нэмэгдүүлсэн застав” гэсэн нэршилтэй заставуудыг шинээр байгуулсан нь орчин үеийн шинжлэх ухааны хурдацтай хөгжил, дэвшилд нийцүүлэн гаргасан цаг үеэ олсон өөрчлөлт, шинэчлэлт болсон гэж дүгнэж байна. Мөн Хил хамгаалалтын дүрэм

[86] Монгол Улсын Хилийн тухай хууль
[87] Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого

шинэчлэгдэн боловсруулагдаж байгаа нь хиймэл оюун ухаанд суурилсан хил хамгаалалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх, хилийн шугамын дагуух өндөр нарийвчлал бүхий сансрын зураглалд байршил тогтоогч систем ашиглах, дохиолол, хяналтын нэгдсэн систем суурилуулах, нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон), теле-хяналтын камер ашиглан нэгэн зэрэг газарын болон агаарын хяналт зохиох зэргээр хил хамгаалалтад ашиглаж буй техник, технологи цаг үеийн шинэчлэл, өөрчлөлтүүдийг хийх нөхцлийг бүрдүүлсэн.

“Хөдөлгөөнт хилийн застав”, “Тусгай бэлтгэлийн застав”, “Сургууль-застав”, “Инженер технологийн застав”, “Сөрөг тусгай ажиллагааны застав”, “Хүч нэмэгдүүлсэн застав” гэсэн нэршилтэй заставууд нь улсын тодорхой хэсэгт хил хамгаалалтыг нягтралыг нэмэгдүүлэх, хилийн зурвас, боомт, бүсэд үүссэн эмх замбараагүй байдал, гэмт хадлагын үед хилийн тусгай ажиллагаа явуулж, хил хамгаалалтад шинээр нэвтрүүлж буй технологийн дэвшилтэд техникүүдийг ашиглах, эзэмших, сургалт, дадлага зохион байгуулж, хилчдийг мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах зорилгоор байгуулагдан, өмнөө тавигдсан үүргээ ажилттай гүйцэтгэж, улсын хил хамгаалалтад оролцсноор тодорхой үр дүн гарч байгаа боловч, орон тоогоор томилогдон ажиллаж байгаа алба хаагчдын ажлын байрны тодорхойлолт, эрх, үүрэг тодорхойгүй байгаа нь цаашдын хөгжлийн чиг хандлагад сөргөөр нөлөөлж болох юм.

Ашигласан материал:

1. “Шинэ зууны застав” төсөл
2. Правила охраны границы
3. Монгол Улсын хил хамгаалалтын түүх III. УБ 2008 он
4. Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс. УБ 2003 он
5. Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм
6. Монгол Улсын Хилийн тухай хууль
7. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого
8. Яндекс.ru

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН СИСТЕМИЙН ЭРХЗҮЙН ОРЧИНД ХИЙСЭН СУДАЛГАА

Г.Ган-Эрдэнэ
Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн
захирагч, докторант, хурандаа

Түлхүүр үг: Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн системийн эрхзүйн орчин

Оршил

Монгол Улсын засгийн газар 2003-2007 онд Харилцаа холбооны тухай хуулийн шинэчилсэн найруулга, Радио долгионы тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Шуудангийн тухай бие даасан хууль, 2008-2011 онд цахим гарын үсгийн тухай, 2012-2015 онд Инновцын тухай, хаягжуулалтын тухай хуулиуд батлагдсан байна. Салбарын хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, мэдээллийн багц хуулийг гаргах замаар эрх зүйн орчин сайжруулах арга хэмжээг үе шаттайгаар авсаар байна.

Орчин цагийн цэргийн холбоо, мэдээллийн системийг хөгжүүлэх гол чиглэл бол цэргийн удирдлагын тогтолцооны гол бүрэлдэхүүн хэсэг болсон эрхзүйн орчныг сайжруулж, техникийн үндсийг шинэчлэх явдал юм.

Хил хамгаалах байгууллага нь 2008 онд “Хилийн цэргийн холбооны заавар”-ыг гаргасан бөгөөд одоог хүртэл нэмэлт тодотгол оролгүйгээр холбоо зохион байгуулалтын үндсэн удирдлага болгож ирсэн. Энэ нь нь Хууль эрхзүйн орчны шинэчлэл технологийн хөгжил, нийгмийн хэрэгцээ шаардлагаас хоцрох үндсэн шалтгаан болсон бөгөөд орчин үеийн шаардлагад нийцсэн, техник технологийн хөгжилтэйгөө хөл нийлсэн эрхзүйн орчныг байгууллагын хэмжээнд бүрдүүлэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Үндсэн хэсэг:

Монгол улсын харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиг хандлага

Манай улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тодорхойлсон харилцаа холбоо, мэдээллийн технологийн хөгжлийн зорилтуудыг дараах хүснэгтэд үзүүлэв.

Монгол Улсын хөгжлийн зорилтуудын зэрэгцүүлэлт Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
Мэдээллийн технологи, харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө. (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг арав дахин нэмэгдүүлэх II үе шат (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын эрх зүйн тогтолцоо, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох замаар салбарын хөгжлийн таатай орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд мэдээлэл, харилцаа холбооны эрх зүйн тогтолцоо, зохицуулалтын сайжруулах Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний өсөн нэмэгдэх хэрэгцээ шаардлагыг хангах мэдээлэл, харилцаа холбооны үндэсний суурь сүлжээ, дэд бүтцийг төрийн дэмжлэг, хувийн хэвшлийн оролцоотойгоор байгуулах Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологид суурилсан үйлчилгээний төрөл, хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх Мэдээлэл, харилцаа холбооны судалгаа- хөгжлийн үйл ажиллагааг эрчимжүүлж, шинжлэх ухаан технологийн парк байгуулах арга хэмжээ авч Монгол Улсад инноваци, судалгаа хөгжлийн нэгдсэн тогтолцоог бий болгох	“Монгол контент” бүтээгчдийг дэмжих бодлого баримтална. Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлж, газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны сүлжээ байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална. Монгол Улсад Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээ бүхий өгөгдлийн төв (Data center) байгуулах боломж бүрдүүлж, төрийн хамгаалалтад авч, мэдээллийн аюулгүй байдлыг ханган олон улсын компаниуд чөлөөтэй транзит ашиглах боломж бүрдүүлнэ. Утасгүй интернетийн хүртээмжийг нэмэгдүүлж, амралт, зугаалгын бүс, номын санд ашиглах боломжийг бүрдүүлнэ.

доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх. III үе шат (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.	Мэдээлэл, харилцаа холбооны технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, үндэсний тоон контент, программ хангамжийн үйлдвэрлэлийг дэмжих, үйлдвэрлэлийн үйл явц, удирдлага, хяналтад мэдээлэл, харилцаа холбооны технологийг нэвтрүүлэх замаар олон улсын зах зээлд өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх. Эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх туршилтын үйлдвэр байгуулах, өндөр өртөгтэй, үр өгөөжтэй тоног төхөөрөмжийг суурилуулахад төр, хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх Үндэсний ашиг сонирхлыг хамгаалах, төр, иргэн, байгууллагын мэдээллийн бүрэн бүтэн болон, үнэн зөв, хамгаалалттай, хүртээмжтэй байдлыг баталгаажуулах замаар мэдээллийн аюулгүй байдлыг хангах. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааны бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, засаглалын ардчилсан, нээлттэй, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай байдлыг идэвхижүүлэх, төрийн үйл ажиллагааны инновацийг дэмжиж, цахим засгийн хөгжлийг боловсронгуй болгох	

БОДЛОГЫН ЗАЛГАМЖ ЧАНАРТ ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Он	2004-2007 он	2008-2011 он	2012-2015 он	2016 оноос хойш
Салбарын хуулиуд	Харилцаа холбооны тухай хууль /1995 он/, 2001 онд шинэчлэн найруулсан.	Цахим гарын үсгийн тухай хууль /2011 он/	Инновацийн тухай хууль /2012 он/	
	Радио долгионы тухай хууль /1999 он/			
	Шуудангийн тухай хууль /2003 он/			
Бодлогын баримт бичиг	Мянганы хөгжлийн зорилтууд /2005 он/	Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр
		Үндэсний хөгжлийн цогц бодлого /2008 он/	Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	
	Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал /2001 он/			
	Монгол Улсын мэдээлэл холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал /2000 он/			Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого (2017-2025 он) /МУЗГ-ын 2017 оны 47-р тогтоол/

	Монгол улсад мэдээлэл, технологийг хөгжүүлэх дунд хугацааны стратеги /2002 он/			
Үндэсний хөтөлбөр	Цахим Монгол үндэсний хөтөлбөр /2005 он/	Монгол Улсад бүртгэл, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох үндэсний хөтөлбөр /2008 он/	Цахим засаг үндэсний хөтөлбөр /2012 он/	
		Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр /2010 он/	Монгол Улсын Үндэсний хиймэл дагуул хөтөлбөр /2012 он/	
		Радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх үндэсний хөтөлбөр /2010 он/		
		Өндөр хурдны өргөн зурвасын сүлжээ үндэсний хөтөлбөр /ЗГ-ын 145-р тогтоол/		
		Өрх бүрт шуудан хөтөлбөр /ЗГ-ын 2011 оны 126-р тогтоол/		
Бодлогын баримт бичиг,	Хөдөөгийн холбоог 2020 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2003 он/	Төрөөс өндөр технологийн талаар баримтлах бодлого	Монгол Улсад радио, телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэх	Цахилгаан холбооны харилцан холболт, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын

			шилжилтийн үед баримтлах чиглэл, Тоон өргөн нэвтрүүлгийн шилжилтийн үеийн нарийвчилсан төлөвлөгөө /МШХХТГ-ын 2012 оны 166-р тушаал/	чиглэл /МТШХХГ-ын 2016 оны А/67 тушаал/
	Шуудангийн үйлчилгээг 2010 он хүртэл хөгжүүлэх мастер төлөвлөгөө /2002 он/	Монгол Улсад интернет протоколд суурилсан телевиз (IPTV)-ийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл /МШХХТГ-ын даргын 2009 оны 111-р тушаал/	Монгол Улсад дараа үеийн хөдөлгөөнт холбооны системийг нэвтрүүлэхэд баримтлах бодлогын чиглэл /МТШХХГ-ын даргын 2015 оны 10-р тушаал/	Суурин өргөн зурвасын интернетийн үйлчилгээний талаар баримтлах бодлогын чиглэл /МТШХХГ-ын 2016 оны А/40 тушаал/
	Шуудангийн салбарын үйл ажиллагааны дунд хугацааны бодлогын хөтөлбөр /2005 он/	Монгол Улсад хөдөлгөөнт телевизийн үйлчилгээг нэвтрүүлэхэд баримтлах чиглэл /МШХХТГ-ын даргын 2009 оны 112-р тушаал/		Монгол Улсын харилцаа холбооны үйлчилгээний үнэ тарифын талаар бодлогын баримтлах чиглэл
	Цахилгаан холбооны салбарын үйл ажиллагааны дунд хугацааны бодлогын баримт бичиг /2001 он/	Монгол Улсад радио өргөн нэвтрүүлгийг тоон технологид шилжүүлэхэд баримтлах чиглэл /МШХХТГ-ын		Монгол Улсын Харилцаа холбооны сүлжээний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө

		даргын 2011 оны 58-р тушаал/		
	Мэдээлэл, харилцаа холбооны салбарын бодлогын баримт бичгүүд /2005 он/	Монгол Улсад телевизийн өргөн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахад баримтлах чиглэл /МШХХТГ-ын даргын 2011 оны 83-р тушаал/		
	Монгол улсын мэдээлэл, холбооны салбарын бодлого зохицуулалтын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал /концепц/ /2005 он/			
	Мэдээллийн технологийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын зорилт /2005 он/			
	МУ-ын мэдээлэл, харилцаа холбооны үйлчилгээний болон харилцан холболтын үнэ тарифын өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн үзэл баримтлал /концепц/ /2005 он/			
	Радио телевизийн			

	хөгжлийн бодлогын баримт бичиг /2005 он/			
	Монгол Улсын улс, хот хооронд, орон нутгийн мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээг хөгжүүлэх концепц /2005 он/			
	Монгол Улсын хөдөөгийн холбоонд CDMA-450 технологийг нэвтрүүлэхэд баримтлах журам /МХХТГ-ын 92-р тушаал/			
	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны GSM системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл /МХХТГ-ын даргын 2005 оны 136-р тушаал/			
	Монгол Улсад телевизийн нэвтрүүлгийг тоон системээр дамжуулахад баримтлах чиглэл /МХХТГ-ын даргын 2005 оны 136-р тушаал/			
	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны CDMA-450 технологийг нэвтрүүлэх талаар			

	баримтлах чиглэл /МХХТГ-ын даргын 2005 оны 136-р тушаал/			
	Монгол Улсад хөдөлгөөнт холбооны 3 дахь үеийн системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл /МХХТГ-ын даргын 2005 оны 136-р тушаал/			
	Монгол Улсад утасгүй холболтын системийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл /МХХТГ-ын 2006 оны 122-р тушаал/			
	Монгол Улсад утасгүй суурин холбооны /WLL/ технологийг нэвтрүүлэх талаар баримтлах чиглэл /МХХТГ-ын 2006 оны 21-р тушаал/			
Дүрэм, журам	Улс хоорондын шуудангийн илгээмжид гаалийн бүрдүүлэлт хийх журам /2004 он/	Шуудангийн үйлчилгээ үзүүлэхэд мөрдөх дүрэм /ЗТАЖ-ын сайдын 2008 оны 30-р тушаал/	Радио давтамжийн зурвасыг төлөвлөх, ашиглах журам /МТШХХГ-ын даргын 2012 оны 32-р тушаал/	Харилцаа холбооны салбарт тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд үзүүлэх зохицуулалтын үйлчилгээн

				ий хөлс тогтоох журам
	Шуудангийн илгээмжийг түр хадгалах, задлах, хураах болон устгахтай холбогдсон журам /2006 он/	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журам /МУЗГ-ын 2009 оны 151-р тогтоол/	Радио давтамжийн ашиглалтын нэгдсэн бүртгэл хөтлөх журам /МТШХХГ-ын даргын 2012 оны 39-р тушаал/	
	Биоаюултай илгээмж, биобэлдмэл тээвэрлэх журам /2006 он/		Шуудангаар үйлчлэгч болон тээвэрлэгч байгууллагуудын хоорондын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах журам	
	Бүсчлэлийн кодыг нэвтрүүлэх, хэрэглэх журам /ЗГ-ын 2007 оны 200-р тогтоол/		Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журам /МУ-ын сайд, ЗГХЭГ-ын дарга, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 269/264-р тушаал/	

Монгол Улсын “Үндсэн хууль”, “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс”, “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Хилийн тухай хууль”, “Хил хамгаалалтын

дүрэм”, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенц болон бусад эрх зүйн актуудын заалт, шаардлагыг үндсэн удирдлага болгон Монгол Улсын хилийн цагийн байдлын өрнөлтийн талаар удирдлагыг үнэн зөв, бодитой мэдээллээр шуурхай хангаж, цугласан мэдээлэлд боловсруулалт хийж, бодит байдалд тулгуурласан шийдвэр гаргах нөхцөлийг бүрдүүлэх нь хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн системийн үндсэн үүрэг.

Цэргийн холбоо, мэдээллийн системд тавигдаж буй үндсэн шаардлага[88] нь

-Цэргийн удирдлагын дээд байгууллага, түүний удирдлагын байрнаас цэрэг, зэвсэг байлдааны нэгжүүдэд баталгаат мэдээ, мэдээллийг хүргэх;

-Операци, байлдаанд оролцож байгаа цэргийн удирдлагын тогтвортой тасралтгүй шуурхай, нууц байдлыг хангах;

-Бүх төрлийн цэргийн холбоо, мэдээллийн системийг ашиглан мэдээллийн солилцоог хангахуйц нэгдсэн үйлчилгээг удирдлагын байгууллага, албан тушаалтнуудад үзүүлэх;

-Удирдлага холбооны систем дээрх гадны нөлөөллийн дор тогтвортой, амь бөхтэй, шуугианаас хамгаалагдсан, найдвартай байх;

-Мэдээлэл дамжуулалт хадгалалт, боловсруулалтын бүх шатуудад аюулгүй, тогтвортой, нэгдмэл байх зэрэг шаардлагыг хангасан байна.

Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн технологийн системийн эрх зүйн орчны хувьд SWOT шинжилгээ хийхэд дараах үр дүн гарч байна. Үүнд:

Strengths буюу Давуу тал:

Бодлогын “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”, “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”, “Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого /2017-2025/”, тогтоол “Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөр” баримт бичгүүд;

---

[88] Золзаяа М. Зэвсэгт хүчний холбоо, ЦУАС-ийн хөгжлийн үзэл баримтлалыг тодорхойлох онол, арга зүйн зарим асуудал. УБ.2017

Эрхзүйн Монгол Улсын “Монгол Улсын Хилийн тухай”, “Монгол Улсын Батлан хамгаалах тухай”, “Зэвсэгт хүчний тухай”, “Дайны байдлын тухай”, “Радио долгионы тухай”, “Харилцаа холбооны тухай”, “Шуудангийн тухай”, “Төрийн болон албаны нууцын тухай”, “Гамшгаас хамгаалах тухай”,“Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай”, “Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай”, “Цахим гарын үсгийн тухай”, “Кибер аюулгүй байдлын тухай хуулиуд, Засгийн газрын “Төрийн албаны интернэтийн зохистой хэрэглээний тухай”, “Төрийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээний тухай”, “Төрийн байгууллагуудын цахим мэдээллийн сан ашиглах тухай” тогтоол, Монгол Улсын “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн стратеги-2030”, “Стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”, “Монгол Улсын хилээр нэвтэрч байгаа зорчигч, тээврийн хэрэгслийн нэгдсэн санг ашиглах, мэдээлэл харилцан солилцох журам”, “Үндсэн хөрөнгийн элэгдэл тооцоход баримтлах хугацаа, жилд байгуулах элэгдлийн хэмжээ“, “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам”, “Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ байгуулах, ашиглах журам” зэрэг журмуудад холбоо, мэдээллийн технологийн харилцааг зохицуулах заалтууд тусгагдсан нь байгын үйл ажиллагаандаа ашиглах бодлого, хууль, эрх зүйн орчин тодорхой хэмжээгээр бүрдсэн, тэдгээрийг ашиглаж хэвшсэн болох нь харагдаж байна.

Weaknesses буюу Сул тал:

Хууль эрх зүйн орчны шинэчлэл мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн хурдаас хоцорсон;

Байгууллагын дотоод дүрэм, журам, заавар дутагдалтай, Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмаас нэр томьёоны зөрүүтэй ойлголттой зэрэг сул талууд байсаар байна.

Opportunities буюу Боломж:

Бодлого, эрхзүйн баримт бичгүүдэд хууль эрх зүйн шинэчлэл хийх орчин, нөхцөл бүрдсэн;

Тусгайлсан чиг үүрэг бүхий болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

Threats буюу Эрсдэл

Улс эх орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн чадавхаас хамаарч хилийн аюулгүй байдал алдагдаж, шинэ төрлийн хилийн

зөрчлийг илрүүлэх магадлал буурч, хөрш улсын хил хамгаалалтын хөгжлөөс хоцрох;

Төрийн цэргийн болон тусгай чиг үүргийн байгууллагуудын мэдээллийн нэгдсэн тогтолцоо бүрдээгүй, харилцан ажиллагаа, түүний аюулгүй байдал хангалтгүй;

Байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын хөндлөнгийн хяналт сул, хилийн шалган нэвтрүүлэх албаны сервер цахим халдлагад өртөх өндөр эрсдэлтэй.

Дүгнэлт, санал

Дүгнэлт, санал Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн системийн эрхзүйн орчныг өнөөгийн байр сууринаас дүгнэн харахад улс орны хэмжээнд хууль, эрхзүйн шинэчлэл хийгдэж байгаа боловч байгууллагын хэмжээнд хоцрогдолтой байгаа нь харагдаж байна. Иймд дараах саналыг оруулж байна.

1.Хил хамгаалах байгууллагын холбоо, мэдээллийн систем зохион байгуулах үндсэн удирдлага болсон “Холбооны заавар”-ыг шинэчлэх.

2.Кибер аюулгүй байдлыг хангах журам, Шуудан холбоо зохион байгуулах журам боловсруулж албанд мөрдөх.

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН НЯГТРАЛЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМЫГ СУДАЛСАН НЬ

Э.Сандагжав
Хилийн албаны сургуулийн Цэргийн хэргийн тэнхимийн багш, хошууч

Түлхүүр үг: Улс, хил, хамгаалалт, нягтрал, орчин үе, арга зам, хэлбэр, цэргийн хяналт, техник технологи.

ОРШИЛ

Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам, хилийн шугам олон мянган километр үргэлжилсэн урт, хүн амын нягтрал бага, өмнөд хилийн зарим хэсэгт хил орчмын нутаг дэвсгэр үндсэндээ эзэмшилгүй байна.

Иймээс улсын хилийг найдвартай хамгаалах, хамгаалалтын нягтарлыг нэмэгдүүлэх аргыг судалж хил хамгаалалтад нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдсаар ирсэн.

Монгол Улсын хувьд улсын хил хамгаалалт нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнол, батлан хамгаалахад нөлөөлөх, шийдвэрлэх хүчин зүйлийн нэг байсаар ирсэн билээ. “Монгол Улсын хилийн тухай хууль”, Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Дархан хил” хөтөлбөр[89], “Монгол Улсын Бүсчилсэн хил хамгаалалт” Засгийн Газрын тогтоол[90] зэрэг эрх зүйн баримт бичигт бүсчилсэн хил хамгаалалтын үндсийг тавих, түүнийг боловсронгуй болгохоор заасан.

Хилийн цагийн байдлын өөрчлөлт, хил зөрчигчдийн үйл ажиллагаа нь зохион байгуулалтын хэлбэрт шилжиж, улсын хилийг өөрсдийн гэмт үйлдлийг хэрэгжүүлэх обьект болгон сонгон авч, орчин үеийн өндөр хүчин чадалтай технолги, автомашин техник, холбоо дохиоллын хэрэгслээр газар орон, цаг хугацааг товчлох болсон нь улсын хил хамгаалах урлагийг хөгжүүлэх, судлах, боловсронгуй болгохыг шаардаж байгаа болно.

Үүнээс үндэслэн бүс нутгийн хэмжээнд, цаашлаад Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх арга замыг онол, арга зүй, удирдлага

89.Дархан хил хөтөлбөр.,УБ.,
90 .МУ-ын Засгийн Газрын ...-р тогтоол

зохион байгуулалт, Монгол Улсын хил хамгаалалтыг өнөөгийн байдал, гадаад орны туршлага, орчин үеийн техник технологийн талаас нь цогц байдлаар судлах шаардлага, үндэслэл урган гарч байна. Түүнд шинжилгээ хийж цаашид хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох нь энэхүү судалгааны ажлын зорилго юм.

ҮНДСЭН ХЭСЭГ

1.Улсын хил хамгаалалтын нягтрал, түүнд хийсэн дүн шинжилгээ;

Улсын хил хамгаалалтын онол гэдэг нь цэргийн шинжлэх ухаан ба онолын бусад салбаруудтай диалектик холбоотой оршдог, шинжлэн ухааны мэдлэгийн тусгай салбар улсын хил хамгаалалтын мөн чанар, зүй тогтол, үр ашигийг дээшлүүлэх арга зам, алба-байлдааны ажиллагааны арга хэлбэр, хилийн цэргийн байгуулалтын онцлог зэргийг судалдаг үзэл бодлын систем юм[91].

Улсын хил хамгаалалтад өөрийн орны болон хил залгаа орны цэрэг, улс төрийн байдал шийдвэрлэх нөлөөтэй, бүх орчинд (газар, ус, агаарын хил, шалган нэвтрүүлэх боомт) хил хамгаалалтын талаар явуулж буй үйл ажиллагаа нэгдмэл байх шаардлагатай, шинжлэх ухаан техникийн ололт, улс орны эдийн засгийн хүчин чадавхи, удирдлагын бэлтгэлийн түвшингээс хамаарах гэсэн зүй тогтлуудтай байдаг.

Улсын хил хамгаалалт тасралтгүй, гүнтэй, хүч хэрэгслээ болзошгүй чиглэлд төвлөрүүлэх, нууц далд, гэнэт, харилцан ажиллагаатай байх зэрэг зарчмаар явагддаг.

Хил хамгаалах урлагийн онол хил хамгаалах онолын цөм болдог. Энэ нь хил хамгаалах онолын хууль, зүй тогтол, зарчим, арга, хэлбэрт тусгалаа олсон байдаг юм.

Хил хамгаалах урлагийн онолыг судлахын өмнө урлаг гэдэг ойлголтыг тодорхойлох нь чухал. Урлаг гэж хүн төрөлхтөний аливаа үйл ажиллагаан дахь дээд зэргийн ур чадварыг хэлдэг.

Үүнээс үзвэл улсын хил хамгаалах урлаг нь өргөн утгаараа улсын хил хамгаалах үйл ажиллагаанд урьд нь хэрэглэж байсан эсвэл одоо хэрэглэж байгаа хүний ухаан, ур чадварыг илэрхийлсэн үнэт зүйл болох нь тодорхой байна. Тиймээс улсын хил хамгаалах

---

[91] Хил хамгаалалтын онол П.Даш 2002 он 16 дугаар тал

зорилгоор хуурай газар, нуур, гол, мөрөн, хилийн боомт, гарцад алба-байлдааны ажиллагаа бэлтгэж явуулахыг улсын хил хамгаалах урлаг гэдэг бөгөөд үүнийг хил хамгаалах урлагийн онол судалдаг.

Улсын хил хамгаалах урлагын онол гэдэг нь хил хамгаалалтын янз бүрийн орчинд улсын хилийн аюулгүй байдлыг хангах сонирхолын үүднээс хил хамгаалах үйл ажиллагааны зүй тогтол, түүнийг хэрэглэх зарчим, үйл ажиллагааны төрөл, цэргийн болон төрөл бүррийн байгууллагын хүчийг ашиглах арга, хэлбэрийг судалдаг шинжлэх ухааны мэдлэгийн систем юм.

“Нягтрал”-ыг Монгол хэлний тайлбар тольд: **нягтрал сайтай** (Нягт шигүү, зай завсар багатай, шигүү[92]; Орос хэлний толь бичигт аливаа зүйлийг нягт шигүү байлгах, нягтруулах[93], Англи хэлний толь бичигт: Тухайн газар нутаг эсвэл орон зайд байгаа хүн эсвэл эд зүйлийн тоо хэмжээ[94] гэж заажээ.

Дээрх тайлбаруудаас харахад “**Нягтрал**” гэдэг нь тухайн газар нутаг эсвэл орон зайд байгаа хүн эд зүйлийг нягтруулах, шигүү, зай багатай байлгах гэсэн утгаар тайлбарласан байна.

Оросын Холбооны Улсын “Хилчний тайлбар толь бичиг”-т: Хил хамгаалалтын нягтрал гэж хил хамгаалах байгууллагын хариуцсан хэсэгт байрлуулсан хүн хүч, инженер техникийн байгууламжийн тоон үзүүлэлтийг хэлнэ гэсэн бол;[95] Америкийн нэгдсэн улсын толь бичигт: Гааль, хил хамгаалалтын байгууллагуудын хамгаалалтын үндсэн хэсгийн урт, түүнийг хаах, халхлах боломж, гэж тодорхойлсон байна.

Дээрх тодорхойлолтууд, судалгааны ажлын дүнд хил хамгаалалтын нягтралыг эрдэмтэн, цэргийн ухааны доктор, профессор хурандаа Н.Наранжамц “**Монгол улсын бүс нутгийн хилийн хэсгийн уртад оногдож байгаа Хилийн цэргийн хүч хэрэгслийн тоон үзүүлэлтэд харьцуулсан илэрхийлийг хэлнэ**” гэж үзэж тодорхойлсон байна.

Монгол улсын хилийг хамгаалж ирсэн түүхийг авч үзвэл дараах түүхэн үечлэл, он дараалал гарч ирж байна. Үүнд:

92.Цэвэл.Я.Монгол хэлний тайлдбар толь., УБ.,2015., 210х
93.Ожегови.И.С. Словарь руссого языка.,Москва.,
94. The okxford Paperbeck Distionari.,US.,2012.,115х
95.Пограничный словарь.,М.Академия ФПС России.,2002.,

1.1921-1933 он. Ардын журамт цэргээр хил хязгаарыг хамгаалсан үеийн хил хамгаалалт;

2.1933-1953 он. Хилийн цэрэг байгуулагдаж улсын хилийг хариуцаж хамгаалсан хамгаалалт;

3.1953-1966 он. Хязгаарын цэрэг татан буугдсан үеийн хил хамгаалалт;

4.1967-1977 он. Хилийн цэргийг дахин байгуулсан үе;

5.1977-1987 он. Хилийн цэргийн байгуулалт, хил хамгаалалт бэхжсэн үе;

6.1990-2010 он. XXI зууны эхэн үеийн хилийн цэрэг;

7.2010 оноос одоог хүртэл өнөөгийн хил хамгаалалт.

Дээрх өөрчлөлтүүд нь улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, зарим үед буурах явдалд хүрэж байсан болно.

Ардчилсан, зах зээлийн харилцаанд шилжсэн шилжилтийн үед 1990 оноос улс төрийн тогтворгүй байдал, эдийн засгийн хямрал, мөнгө, санхүүгийн хомсдол, төрийн нүсэрдмэл бүтцийг халах гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан ХЦ-ийн байгуулалт жижгэрч зарим чухал бүтэц нэгжүүдээ алдаж, заримыг нь эргүүлэн авах гэх мэт байдлуудаас шалтгаалан ХЦ-ийн хүч хэрэгсэл, 1980 оныхоос 2-3 дахин буурч, үүнийг дагаад хил хамгаалалтын нягтрал ч мөн ялгаагүй буурсан.

Сүүлийн жилүүдэд хилийн аюулгүй байдлын гадаад, дотоод орчин эрс өөрчлөгдөж, хилийн аюулгүй байдлын асуудал улам бүр нарийн төвөгтэй болж хурцдан, даамжирч хилийн нөхцөл байдал шинэ хэлбэр, агуулгатай зөрчил, хил дамнасан зохион байгуулалттай бүлэглэлүүд бий болж, байгалийн баялагийг хууль бусаар хил давуулах, хар тамхи, зэвсэг галт хэрэгсэл, хүний наймаа гэх мэт гэмт хэргүүд нууц, далд аргаар үйлдэгдсээр байна.

Монгол-Хятадын хилд автомашин, хар тамхи худалдаалах, зөөх, хүний наймаа, спирт, ноолуур, өнгөт металл, Монгол-Оросын хилд сум галт хэрэгсэл, хар тамхи зөөх, худалдаалах, ан амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийг улсын хилээр хууль бусаар давуулах, малын хулгай, дээрмийн хэлбэртэй зөрчлүүд давамгайлан гарч байна. Хилийн зөрчил сүүлийн 20-30 жилд 4.1 дахин өсч, “зорилго”, ”агуулга” нь улам бүр нарийсч, зохион байгуулалтай болсоор байна.

Хил хамгаалалтын нягтралын өнөөгийн байдлыг Дорноговь аймагт үйл ажиллагааг явуулж байгаа хилийн ангиудын хил хамгаалалтыг харьцуулсан шинжилгээ хийж үзэхэд:

Дорноговийн хилийн анги, салбарууд нь төв суурин газраас алслагдсан, заставын 84.2 хувь нь төвлөрсөн эрчим хүчинд холбогдоогүй, хилийн дагуух замын сүлжээ хангалтгүй, бартаа саад ихтэй. Хилийн отряд, застав, харуулууд нь 80 гаруй булаг шанд, худгаас ундны усаа хэрэглэдгээс 60.4 хувь нь эрүүл ахуйн шаардлага хангадаггүй. Хилийн застав, харуулуудын 40.2 хувь нь 5-68 км газраас ундны усаа зөөвөрлөдөг. Хилийн заставуудын 57 хувь, хилийн харуулуудын 59,3 хувь нь хил хамгаалалтад морь, тэмээ ашигладаггүй.

Дорноговь аймгийн нутаг дэвсгэрт одоогийн байдлаар Хилийн 3 анги, өөрийн харьяа салбарууд, хилийн 3 боомт, хилийн харуул, манааны хүчээр 600 орчим км хэсгийг хамгаалж байна. Энэ нь хилийн нэг отрядод 250-300 км орчим хэсэг, нэг заставт 20-40 км орчим, нэг хилийн харуулд 10-20 км орчим хэсэг тус тус ноогдож байгаа болно.

Нийт хилийн харуул дундажаар 1 хилчинд 1,4 агт, уналга ноогдож бусад хилийн харуул хил хамгаалалтад мотоцикль ашиглаж байна. Бие бүрэлдэхүүний хувьд хилийн отрядууд 300-400 орчим хүнтэй байна.

Зэвсэг, галт хэрэгслийн хувьд хүн нэг бүрийн болон бүлгийн зэвсэглэлтэй байна.

Улсын хил хамгаалалтыг цэргийн, инженер техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөллөгчийн албаны арга хэмжээг хослуулан зохион байгуулж байна.

Хилийн цэргийн 0108 дугаар ангийн хариуцсан хэсэгт Телекамерын хяналт, дунай дохиоллын систем ашиглан хариуцсан хэсгийг тасралтгүй хяналтад байлгаж байна.

Хил хамгаалалтыг хилийн зурваст Хилийн отряд, застав, харуул, манааны хүчээр, хилийн бүсэд отрядын бэлтгэл хүч, хилийн хяналтын болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагууд орон нутгийн засаг захиргааны удирдлага, хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, гишүүд, иргэдийн оролцоотойгоор хамгаалдаг.

Цэргийн хяналтыг хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлд төвлөрүүлж, хилийн зөрчлийн шинж тэмдэг илэрсэн, мэдээлэл авагдсан үед офицерын хяналтыг идэвхжүүлэн ажилладаг.

Хилийн анги салбарууд нь Монгол Улсын болон хариуцсан хэсгийн гадаад, дотоод нөхцөл байдлын үнэлгээг хийхгүй, зөвхөн хилийн цагийн байдалд дүн шинжилгээ хийж, хил хамгаалалтын шийдвэр боловсруулан, хил хамгаалалтын идэвхтэй байх зарчмыг орхигдуулан, хил хамгаалалтыг нэг хэлбэрээр загварчилсан байдлаар зохион байгуулж, байгаль цаг уурын байдлаас шалтгаалан хилчид хэт тайвшралын байдалд орсон, аж ахуйн ажил ихээр хийснээр ажлын үр дүн нь гардаг зэргээс уг чиглэлийн хил хамгаалалтын нягтрал буурсан гэж үзэж байна.

Үүнээс гадна хилийн боомтуудын ачаалал эрс нэмэгдэж байна. Ханги-Мандалын боомт нь байнгын боомт болсон. Боомтуудын хөгжил нь эдийн засагт чухал нөлөө үзүүлж байгаа боловч, зөв бодлого баримталж, хяналт шалгалтыг сайн хийхгүй бол эргээд сөрөг нөлөөлөл их гарч байна.

Дорноговь аймаг дахь Замын-Үүд, Ханги-Мандалын боомтод үүссэн цагийн байдалд дүгнэлт хийж тодорхой арга хэмжээ авахгүй бол дараах сөрөг үр дагаварууд гарч болзошгүй гэж үзэж байна.

Нэг: Барилга болоод төмөр зам, уул уурхайн салбарт ажиллах хүч, тэр дундаа мэргэжлийн ажилчин дутмаг байгаа манай улсын хувьд Хятадын зүгээс цэргэжсэн ажилчдыг оруулж ирэх, уул уурхайн үйл ажиллагаар халхавч хийн улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт гадаадын тусгай албадын тагнан турших үйл ажиллагаа өргөжих;

Хоёр: Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон эд зүйл, амьтан ургамлын аймгийн ховордсон болон устаж байгаа олдворууд, түүх дурсгалын хосгүй үнэт зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх;

Гурав: Хятад улс хилийн мөргөлдөөн, газар нутгийн маргааныг эв зүйгээр шийдвэрлэх боломжгүй тохиолдолд цэргийн хүчээр шийдвэрлэх үзэл баримтлалтай;

Дөрөв: Монгол улс өнөөдрийн байдлаар уул уурхайн үйл ажиллагаанаас шалтгаалан эдийн засгийн байр суурια алдах, манай улсын эдийн засгийн орон зайд хөрш улс нэвтрэх зэрэг аюул тулгарч байна.

Дорноговийн аймаг дахь Хилийн цэргийн 0108 дугаар ангийн хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх талаар 2010 оноос эхлэн өмнө авч хэрэгжүүлж ирсэн туршлага дээр тулгуурлан судалгаа шинжилгээний ажил хийгдэж, түүний мөрөөр олон төрлийн ажил арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байгаа нь сайшаалтай боловч бусад хилийн отрядуудад хөрөнгө, мөнгөгүй, хүн хүч дутмаг гэсэн шалтгаанаар хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх ажиллагааг үе шаттайгаар хийхгүй байгаа нь албаны бэлэн байдлыг алдагдуулах, шөнийн цагт хил хамгаалалтын нягтрал алдагдах, загварчлагдсан хил хамгаалалт давамгайлж зэрэг эрсдэлүүд үүссээд байна.

2.Хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх, хэрэгцээ, шаардлага, боломж;

Орчин үеийн дэлхийн улс төр болон бусад салбарт гарч буй томоохон өөрчлөлтүүд урд хойд хөршийн улс төрийн бодлого, Монгол Улс хүчирхэг гүрнүүдийн хооронд оршин тогтнож буй бодит байдал, дотоодын нийгэм, эдийн засгийн хямрал зэргээс үүдэн гарч буй сөрөг үзэгдлүүд нь улсын хил орчмын болон хилийн асуудал дээр хурцаар илэрч, Монгол Улсын үндэсний аюулгүй байдалд бодитойгоор нөлөөлж болзошгүй байна.

Үүнээс үүдэн улсын хил хамгаалалтад шинэ бүтэц, арга хэлбэрийг сонгох шинэ төрлийн техник хэрэгслийг сонгож хэрэглэх шаардлага гарч байна.

Дэлхийн улс гүрнүүд өөрйн улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх асуудлыг байнга анхаарч, үе шаттайгаар хөгжүүлж ирсэн байна. Энэ талаар жишээ болгон зарим улсын хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлсэн туршлагыг авч үзэв.

БНХАУ-ын хил хамгаалалт. БНХАУ-ын хил хамгаалалт нь арми, зэвсэгт цагдаа, аюулаас хамгаалах байгууллага, хилийн бүсийн ард иргэдээс бүрдсэн нэгдмэл тогтолцоотой, "нэг төр, гурван шугам" гэсэн томъёололтой.

БНХАУ-ын хил хамгаалалтын систем: Хятадын төлөөлөгчдийн их хурлын V хурлаас 1997 оны 3 дугаар сарын 14-ний өдөр "Батлан хамгаалахын тухай хууль"-ийг баталсан бөгөөд уг хуулийн 4 дүгээр бүлгийн 26 дугаар зүйлд БНХАУ-ын хуурай зам, ус, далай, агаарын хил халдашгүй байна. Орон нутгийн бүх шатны Ардын засгийн газар, төрийн зөвлөлийн холбогдох газар болон цэргийн байгууллагууд

төрөөс заасан бүрэн эрхийн хүрээнд ажил үүргийн хуваарилалт хийж хил хамгаалах ажлыг гүйцэтгэн улс орны аюулгүй байдал, эрх ашгийг хамтран хамгаална" гэж заасан байдаг.

Сүүлийн үед Хятадууд хил хамгаалалтад цэргийн хүч хэрэгслийг ашиглахаас илүүтэйгээр байнгын байрлалаас орчин үеийн техник технологиор хяналтыг зохион байгуулах ажлыг идэвхжүүлэхэд голчлон анхаарч ердийн болон тусгай техник хэрэгсэл ашиглаж байгаагаас гадна морин ба автомашин уналгатайгаар хилийн тодорхой хэсэгт 5-7 хүний бүрэлдэхүүнтэйгээр харуул, нууц манаа томилон ул мөрийн шалгалт хийх, багана тэмдэг шалгах зорилгоор үүрэг гүйцэтгүүлдэг.

БНХАУ-ын зүгээс сансрын хиймэл дагуул ашиглаж хилийн зөрчлийг түргэн шуурхай илрүүлэх, ямар нэг хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, хилд тулсан мал, гал түймэр зэргийг шууд сансраас хянаж ажиллахаар төлөвлөж байна. Мөн анхаарал татаж буй хилийн хэсгийнхээ гол чиглэлд байрлах хянах цамхгуудад хөдөлгөөн мэдрэгч тусгай камер тавьж байгаа ба хилд ойртсон ямар ч хөдөлгөөнийг илрүүлэн дохиолол өгдөг байна.

Дээрх камер нь 24 цаг тасралтгүй бичлэг хийдэг ба бичлэгүүдийг хилийн ангиудаас шууд хянаж байдаг.

Мөн хил дагуу амьдарч хил хамгаалалтад оролцож буй малчид, иргэдэд олгох урамшуулал нь өсөж тогтвортой цалин хангамж авдаг болсон ба дунджаар нэг малчин 1500-2000 юань авдаг болсон.

Хятадын төр засгаас 1 дүгээрт хил орчмын боомт газрыг хөгжүүлэх, 2 дугаарт хилийн боомтуудтай хамтран ажиллах асуудалд онцгой анхаарч, Монголын байгалийн баялгийг ашиглах, тэдгээрийг боомтоор нэвтрүүлэх сонирхол илүүтэй нэмэгдэж байна.

ОХУ-ын хил хамгаалалт.

ОХУ-ын хил хамгаалалтын үндсэн арга хэлбэр нь цэргийн хүч байсан бөгөөд тагнуул, оператив эрлийн ажиллагаа, техник хэрэгсэл ашиглах нь хил хамгаалаптын хангалт гэж үздэг байсан бол одоо хил хамгаалалтын үндсэн арга хэлбэр болон цагийн байдлын зайлшгүй шаардлагатай үед цэргийн хүчийг ашиглах арга хэлбэрт шилжсэн.

ОХУ-ын хил хамгаалалт дараах онцлогуудтай. Үүнд:

1.Улсын хилийг гүйцэтгэх ажлын хэрэгслээр хамгаалах,

халхлахад онцгой анхаардаг. Энэ нь хил хамгаалалтын гол арга хэлбэр болсон.

2.Улсын хил хамгаалалтад орон нутгийн ард иргэд, хилийн цэрэгт туслах хүчийг өргөнөөр ашиглахын зэрэгцээ сайн дурын ардын тусгай бүлэг, казакуудын уламжпалт бүлгүүдийг зохион байгуулан удирдлагаар ханган ажиллуулдаг.

3.Улсын хил хамгаалалтад орон нутгийн байгууллага, удирдлагуудын оролцоог шефийн холбоо хэлбэрээр өргөн ашиглаж, эдийн засгийн ихээхэн туслалцааг авдаг.

4.Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах үүргийг отрядын удирдлагаас салган тусгай мэргэшсэн бүрэлдэхүүнээр эрхлүүлэх болсон.

Сүүлийн үед ОХУ улсын хил хамгаалалтандаа тусгайлан захиалгаар бүтээж гаргасан хамгийн орчин үеийн иж бүрэн тоноглол бүхий хяналт ажиглалтын автомат ажиллагаа бүхий хөдөлгөөнт техникүүд, хяналтын камерууд, нисэгчгүй нисэх хэрэгсэл, үргэлжилсэн урт хэсгийг бүрэн хэмжээгээр халхлах, дохиолох зориулалт бүхий радио электрон багаж, төхөөрөмжүүдийг ашиглаж байна.

“Шугамын тасаг” нь хил хамгаалалтад эрэл-тагнуул, эрэл-хайгуулын аргаар байнгын хөдөлгөөнт бүлгийн бүрэлдэхүүнээр үүрэг гүйцэтгэж оперативын чиглэлд хилийн эрэл явуулах гол хүч болсоор байна. Өөрөөр хэлбэл, хил зөрчигчийг байнга эрж хайж, идэвхтэй үйл ажиллагаа явуулах болсоор багагүй хугацаа өнгөрч байна[4]

Америкийн Нэгдсэн Улсын хил хамгаалалт: АНУ нь УХХ, хилийн эрэлд орчин үеийн дэвшилтэт техник, технологийг өргөн хэрэглэхийн зэрэгцээ уламжлалт хил хамгаалалтын аргыг хослуулан ашиглаж үр дүнд хүрч байна. Төрөлхийн мөрч, анч, газарч, апачи омгийн индиан үндэстнүүдийг морь, нохойн хамт гэрээний үндсэн дээр улсын хил хамгаааалалт, хилийн эрэлд өргөнөөр ашигладаг туршлагатай.

АНУ-ын хувьд Мехсик болон Канадтай хиллэж байгаа хуурай газрын хилийн шугамынхаа дагуу хэсгийг ямар аргаар, ямар техник хэрэгслээр хамгаалах тухайгаа төрийн бодлогын хэмжээнд авч үзэн шийдвэрлэж, ялангуяа Мехсиктэй хиллэж байгаа хэсэгтээ хамгийн сүүлийн үеийн электрон хэрэгслүүд, хяналтын камерууд, нисгэгчгүй

болон нисэгчтэй нисэх хэрэгслүүд, туулац сайтай орчин цагийн тээврийн хэрэгслүүд, агаар сансрын хяналтын системийг өргөнөөр ашиглах болсон.

Бусад өндөр хөгжилтэй улсуудын хил хамгаалалт: *Манай улсын хнл залгаа улсуудаас гадна улсын хил хамгаалалт,* тэр тусмаа хилийн эрэлд орчин үеийн техник хэрэгслийг өргөнөөр ашиглаж байгаа улс орнуудаас АНУ, Израйль, Солонгос, Энэтхэг гэх мэт олон улс орнуудад хүний хүчин зүйлээс илүү техник хэрэгслүүдийг ашиглах талаараа бусдад үлгэр жишээ болж байна.

Израйль, Өмнөд Солонгос, Пакистан зэрэг орнуудад хилийн шугамынхаа дагуу үргэлжилсэн урт хэсгийг бүхэлд нь инженерийн саадуудаар хааж, орчин үеийн хяналтын болон илрүүлэлтийн техник, багаж хэрэгслээр давхар тоноглон, цэрэг тагнуулын аргатай идэвхтэй хослуулан хэрэгжүүлснээр оперативын чиглэлд хилийн хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлж байна.

Хилийн зөрчлийн судалгаанаас үзэхэд өмнөд бүсийн хилийн ангиудын хэсгээр гуравдагч орны иргэд хэсэг бүлгээрээ хил зөрчих, хориглосон бараа спирт нууцаар хил нэвтрүүлэх, хилийн боомтуудаар хууль бус эд зүйл нэвтрүүлэх, хилийн бүсэд байрлаж үйл ажиллагаа явуулж байгаа гадна болон дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудаас байгалийн баялагийг хууль бусаар ашиглах, олборлох, тээвэрлэх, улмаар хилийн боомт болон боомт бус газраар хил нэвтрүүлэх явдал гарч байна.

Дээрх хүчин зүйл, хилийн зөрчлийн хэлбэр, агуулгаас дүгнэлт хийж үзэхэд дараах арга хэмжээг авах шаардлагатай байгаа болно:

1.Хилийн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхай, ашигт малтмалын орд газруудын хайгуул, олборлолт нэмэгдэж, цаашид өргөжих, тэдгээрийг дагасан олон төрөл үйлчилгээ бий болж байгаа болон бусад хууль бус аргаар алт олборлох гэх мэт үйл явцыг хянах;

2.Хилийн ангиудын хүн хүч, техник, хэрэгслийг нэмэгдүүлж, Ханги-Мандалын боомтыг эхний ээлжинд Замын-Үүдийн жишигт хүргэх.

3. Хилийн ангиудын хариуцсан хэсгийн мөр хянах зурвас, инженерийн байгууламжийг бүхэлд нь сэргээх, засварлах.

4.Хил хамгаалалтад орчин үеийн нисгэгчгүй нисэх хэрэгсэл, дохиолол хамгаалалтын хэрэгсэл, телекамер, нисгэгчгүй нисэх

хэрэгслийн эсрэг төхөөрөмж гэх мэт шинэ техник хэрэгсэл нэвтрүүлж, ашиглах;

5.ХХБ-ын бие бүрэлдэхүүний нийгмийн хамгаалалыг сайжруулах;

Үүний үндсэн дээр эдийн засаг, үр ашгийн тооцооллыг дэвшүүлсэн зорилго, зорилт, хүрэх үр дүнд чиглүүлж, өмнөх оны төсөв, санхүүгийн гүйцэтгэлд суурилан боловсруулж, шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсвөөс авч санхүүжих бус Хил Хамгаалах Байгууллага улсын төсөвт тодорхой хэмжээний орлого оруулах ямар боломж, бололцоо байгааг тодорхойлон гаргаж, түүнээс тодорхой хувийг хил хамгаалах байгууллагыг бэхжүүлэх, хилчдийг мэргэшүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд хуваарилан зарцуулж байх талаар хууль тогтоомж, эрхийн актуудад өөрчлөлт оруулж болохыг ч үгүйсгэх аргагүй юм.

3.Хил хамгаалалтын нягтралыг боловсронгуй болгох зарим арга зам;

Судалгааны үндсэн дээр хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлагыг гадаадын орнууд хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлж байгаа туршлагын үндсэн дээр тодорхойлж үнэлэлт, дүгнэлт гаргасан бөгөөд үүн дээрээ үндэслэн сайжруулах, боловсронгуй болгох арга замуудыг тодорхойлсон болно.

Тухайлбал:

1.Хилийн ангиудад орон тооны тактикийн түвшинд үүссэн онцгой нөхцөл байдалд хурдан шуурхай ажиллах чадвартай 30 хүнтэй тусгай томилгоот салааг хариуцсан хэсэгт тохирсон орчин үеийн зэвсэг, техниктэйгээр байгуулж, хил хамгаалалтанд ашиглах.

2.Ханги-Мандалын хилийн боомтын хүчин чадлыг сайжруулж, боомтын гарах гарцын урсгалыг 3-4 дахин нэмэгдүүлэх, орчин үеийн рентген аппаратаар тоноглох.

3.Хил хамгаалалтын инженерийн байгууламжийг засварлан сэргээх, нэмэж төхөөрөмжлөх.

4.Хил хамгаалалтанд дохиололын хамгаалалтын хэрэгслийг ашиглах шаардлагатай байна.

5.Хилийн эрлийн ажиллагаа болон шалган нэвтрүүлэх албаны шалгалтад албаны нохойг ашиглах талаар сургалтыг тогтмол зохион байгуулах, албанд үр дүнтэй ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.

6.Улсын хил хамгаалалтын үндсэн арга нь хилийн зурваст цэргийн тогтвортой хяналт байх тул орчин үеийн хийцтэй хяналтын цогцолбор байруудыг барьж, өндөр хүчин чадлын өдөр, шөнийн дуран харааны хэрэгсэл, дулаан ялгаруулалтыг мэдрэх зарчимд үндэслэсэн төрөл бүрийн хяналтын төхөөрөмж, хяналтын хэрэгслээр хангах.

7.Хар тамхи, зэвсгийн болон хүний наймаа газар авч тэдгээртэй тэмцэхэд шинжлэх ухааны ололтыг улсын хил хамгаалалтад нэвтрүүлж, улсын хилийн бүс, зурвас, боомт газруудад илүү боловсронгуй техник хэрэгслийг хил хамгаалалтад нэвтрүүлэхийг шаардах болсон.

Монгол улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шинжлэх ухаан технологид тулгуурласан бүс нутгийн онцлогт тохирсон Улсын хил хамгаалалтыг бий болгох зорилготой “Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрийн заалт нэг бүрийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Орчин үеийн дэлхий нийтийг хамарсан үйл явц болох даяаршлалын үр дагавар, нөлөөгөөр улс дамнан алан хядах ажиллагаа явуулах, улсын хил давуулан хар тамхи, мансууруулах бодис наймаалах, хүн худалдаалах, захиалгат аллага үйлдэх, мөнгө угаах, төрөл бүрийн халдварт өвчин тараах зэрэг уламжлалт ба уламжлалт бус аюул занал бий болж “улс болж тоглогч бүлэглэл”, хил орчмын нутаг дэвсгэрийн зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэг, зэвсэгт бүлэглэлийн үйл ажиллагаа нь зохион байгуулалтын хэлбэрт шилжих зэргээр урьд өмнө нь байгаагүй гэмт хэрэг, зөрчлүүд гарах болсон цагийн байдал, түүнд орсон өөрчлөлт, хэтийн төлөвөөс дүгнэлт хийхэд: Улсын хил хамгаалалт, түүний нягтралыг нэмэгдүүлэх ажиллагааг боловсронгуй болгох, үр дүнг дээшлүүлэх шаардлага тавигдаж байна.

Монгол Улсын нутаг дэвсгэр өргөн уудам, улсын хил олон мянган километр үргэлжилсэн урт, хүн ам цөөн, хил орчмын нутаг дэвсгэр үндсэндээ эзэмшилгүй ийм нөхцөлд улсын хилийг дан ганц хүний хүчээр, цэрэгжүүлсэн хамгаалалтаар хамгаалах боломжгүй юм. Тийм учраас дээр өгүүлсэн хүн хүч, зэвсэглэл, техник, инженерийн байгууламж, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг олон талт

асуудлыг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Өмнөд чиглэлийн буюу говийн бүсэд оперативын чиглэлийн хил хамгаалалтын нягтралыг нэмэгдүүлэхээр судалгааны ажилд санал болгосон арга хэмжээнүүдийг хил хамгаалалтанд нэвтрүүлж, хэрэгжүүлэх шаардлагатай байгаа болно.

САНАЛ:

1.Хилийн ангиудад орон тооны тактикийн түвшинд үүссэн онцгой нөхцөл байдалд хурдан шуурхай ажиллах чадвартай 30 хүнтэй тусгай томилгоот салааг хариуцсан хэсэгт тохирсон орчин үеийн зэвсэг, техниктэйгээр байгуулж, хил хамгаалалтанд ашиглах.

2.Хил хамгаалалтын инженерийн байгууламжийг засварлан сэргээх, нэмэж төхөөрөмжлөх.

3.Хил хамгаалалтанд дохиололын хамгаалалтын хэрэгслийг ашиглах шаардлагатай байна.

4.Хилийн эрлийн ажиллагаа болон шалган нэвтрүүлэх албаны шалгалтад албаны нохойг ашиглах талаар сургалтыг тогтмол зохион байгуулах, албанд үр дүнтэй ашиглах нөхцөл, боломжийг бүрдүүлэх.

5.Улсын хил хамгаалалтын үндсэн арга нь хилийн зурваст цэргийн хяналтыг тогтвортой зохион байгуулах байх тул орчин үеийн нарны зайгаар өөрийгөө цэнэглэдэг, үүрэн холбооны сим ашиглан интернетэд холбогдон мэдээллээ дамжуулдаг камерууд бүхий хяналтын цэг хийх, өндөр хүчин чадлын өдөр, шөнийн дуран харааны хэрэгсэл, дулаан ялгаруулалтыг мэдрэх зарчимд үндэслэсэн төрөл бүрийн хяналтын төхөөрөмж, хяналтын хэрэгслээр хангах.

6.Хар тамхи, зэвсгийн болон хүний наймаа газар авч тэдгээртэй тэмцэхэд шинжлэх ухааны ололтыг улсын хил хамгаалалтад нэвтрүүлж, улсын хилийн бүс, зурвас, боомт газруудад илүү боловсронгуй техник хэрэгслийг хил хамгаалалтад нэвтрүүлэхийг шаардах болсон.

Ашигласан материал:

1.Монгол улсын хууль.,УБ.,1992.,
2.Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал.,УБ., 2010.,
3.Гадаад бодлогын үзэл баримтлал., УБ.2011.,
4.Монгол хилийн тухай хууль., УБ.,2016.,

5.Төрөөс хилийн талаар баримтлах бодлого.,УБ.,
6.Монгол Улсын Засгийн Газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр., УБ.,2016.,
7.Дархан хил хөтөлбөр.,УБ.,
8.Монгол Усын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал.,УБ.,2005.,
9.Монгол улсын хил хамгаалалтын дүрэм 2007 он
10.Н.Наранжамц “Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал” УБ 2012 он
11.Н.Наранжамц "Улсын хил хамгаалалтын онол - Практикийн үндсэн асуудлууд” УБ 2015 он
12.Я.Цэвэл.Монгол хэлний тайлдбар толь., УБ.,2015
13.Ожегови.И.С. Словарь руссого языка.,Москва.,
14.The okxford Paperbeck Distionari.,US.,2012.,115x
16.Пограничный словарь.,М.Академия ФПС России.,2002.,
17.Ё.Хадхүү.”Хил зөрчигчийн тактик ажиллагааг урьдчилан тооцоолох нь хилийн эрэлд амжилт олохын үндэс мөн”., ЭШӨ., УБ.,
18.Э.Лувсанбалдан, Ц.Нэргүй,Ч.Алтангэрэл,Ц.Лхагвасүрэн. “Монгол улсын хил хамгаалалтын түүх” II.,-УБ., 2008
19.Э.Лувсанбалдан, Ц.Нэргүй,Ч.Алтангэрэл,Ц.Лхагвасүрэн. “Монгол улсын хил хамгаалалтын түүх” III.,-УБ., 2008
20.П.Сүндэв. “Монгол Улсын хилийг тогтоож хамгаалсан нь” УБ.2006 он
21.Б.Цэдэн-Иш, “Монгол улсын хил хязгаар бүрэлдэн тогтсон түүхээс”.-УБ., 2003.
22.Ц.Ганболд. “Монгол Улсын Хил хамгаалаптад хил орчмын оршин суугчдын үндэсний онцлог, эан заншил нөлөөлөх нь" өгүүлэл. УБ.,2009 он
23.Оросын Холбооны Улсын Цэргийн номлол
24.БНХАУ-ын Цэргийн номлол
25.Д.Нямдорж “Улсын хилийг инжөнөр төхникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох нь” УБ 2004 он
26.Ш.Лхачинжав “Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь” УБ 2010 он
27.Л.Манжийлаа “Говь цөлийн нөхцөлд хил хамгаалалтыг зохион байгүүлах онцлог” УБ 2008 он

28.Ш.Арвай Монгол-Хятадын хилийн хэсэгт БНМАУ-ын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох үндсэн чиглэл.,УБ.,
29.Ш.Арвай Монгол Улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь.,УБ.,
30.Д.Базарсад “Хурцадмал байдал үүсэх үед Хятадтай хиллэсэн Монгол Улсын хилийн хамгаалалт”.,УБ.,
31.Н.Наранжамц. “Тал хээрийн бүсэд хилийн операци зохион байгуулж явуулах нь”.УБ.2006.
32.Д.Нямдорж. “Улсын хилийг инженер-техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох нь”
33.В.Жавхланцогт. “Улсын хилээр дүрвэгсэд нэвтрэх үеийн хилийн отрядын ажиллагааг боловсронгуй болгох нь”

ГЭРЭЭТ ХИЛЧНИЙ АЛБЫГ ЭЭЛЖИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ОРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

М.Ганбаатар
ДХИС-ийн ЭШНХ-ийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан-багш, докторант, дэд хурандаа

Хураангуй

Монгол Улсын Хил хамгаалах байгууллага гэрээт хилчний албанд үе шаттайгаар шилжиж улсын хил хамгаалалтад гэрээт хилчдийг ашиглах болсон ба гэрээт хилчний нөхөн хангалтаас шалтгаалж, нэг хүнд ноогдох албаны ачаалал нэмэгдэж, гэрээт хилчид, офицер, ахлагч нар ажлаасаа гарах шалтгаан нөхцөл болж байна. Иймд гэрээт хилчний алба хаах журамд өөрчлөлт оруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэх, ахуй хангалтыг сайжруулах зэрэг хэрэгцээ шаардлагууд гарсаар байна.

Түлхүүр үг: Гэрээт хилчний алба, сонгон шалгаруулалт, сургалт, ахуй хангалт, цалин хөлс, амралт, чөлөө, гэрээний нөхцөл

Оршил

Монгол Улсын Хилийн тухай хууль, Засгийн газрын 2018 оны 11 дүгээр тогтоол “Цэргийн гэрээт албыг хаах журам”-ыг үндэслэн ХХЕГ-ын даргын тушаалаар “Цэргийн гэрээт албыг байлдагч, түрүүчээр хаах журам”-ын дагуу гэрээт хилчний албыг зохион байгуулж байна. Гэрээт хилчний алба хаах сонирхлоо илэрхийлсэн хугацаат цэргийн алба хаагч, иргэдийг цэргийн гэрээт алба хаагчаар сайн дурын үндсэн дээр журмын дагуу бие бялдрын хөгжил, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшин, мэргэжил, ёс зүй, сахилга, сэтгэл зүйн байдал гэсэн үзүүлэлтээр сонгон шалгаруулалтыг явуулж, сургалтад хамруулж байна. Сонгон шалгаруулалт, сургалтыг Хил хамгаалах байгууллагаас нэгдсэн журмаар зохион байгуулдаг байсан бол одоо Хилийн цэргийн ангиуд сонгон шалгаруулалт, сургалтаа зохион байгуулдаг болсон.

Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлд “Төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх болзлыг тодорхойлохдоо хуулийн дагуу цэргийн жинхэнэ алба хаах үүрэг хүлээсэн иргэн төрийн албаны онцлог төрөл болох энэ үүргээ биелүүлээгүй бол төрийн

жинхэнэ албан тушаалд авч ажиллуулахыг хориглоно” гэсэн 16.2.4 дэх заалтыг 2008 оны тавдугаар сарын 6-ны өдрийн хуулиар нэмсэн байдаг. Энэ хууль батлагдсанаар залуусын цэргийн албаа хаах сонирхол тодорхой хэмжээгээр нэмэгджээ.

Гэрээт хилчдээс Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуульд 70 гаруй, ОХУ-ын Хилийн цэргийн дээд сургуульд 20 гаруй, офицерын албанд 80 гаруй, ахлагчийн албанд 700 гаруй залуус шилжсэн гэх тоон үзүүлэлт байдаг аж.

Гэвч сүүлийн үед эх орондоо хүчээ өргөх, хязгаар нутаг улсын хил дээр өөрийн хүслээр үүрэг гүйцэтгэх залуусын тоо тодорхой хэмжээнд буурах болсон.

Монгол Улс 21 аймаг, 330 сумтай. Хилийн ангиуд өөрийн байрлаж буй орон нутагтаа гэрээт хилчний албыг сурталчилж, бүртгэл явуулж байна.

Сүүлийн 3 жилийн хугацаанд хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын бие бүрэлдэхүүний ажлын нөхцөл байдал сайжирсэн, төв суурин газар байрладаг, ажилласан жилийн нэмэгдэл олгодог болсон, цалин нэмэгдсэн, бусад төрийн өмчийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын цалин нэмэгдсэн, ажлын ачаалал бага байгаа зэргээс шалтгаалан Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчнээр алба хаах залуусын тоо буурсан үзүүлэлттэй байна.

Хил хамгаалах байгууллага болон Дотоод хэргийн их сургуулийн Хилийн албаны сургуулиас гэрээт хилчний албыг, хилийн албаны сургуулийн элсэлтийн хөтөлбөрийг сурталчлах зорилготой бүлгүүд Хилийн аймаг, сумдаар үүрэг гүйцэтгэх болжээ. Сурталчилгаа явуулах явцад хилийн аймаг, сумдад гэрээт хилчний албанд тохирох насны залуусын тоо хангалттай байгаа боловч ар гэртээ санаа зовох, эхнэр хүүхэдтэй, цалин хөлс бага, ээлжийн амралт эдлэх хугацаа бага байгаа талаар л ярьж байна.

Гэтэл Цагдаа, дотоодын цэрэг, Онцгой байдлын алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зэрэгт ажилтан авч байгаа байдалд дүгнэлт хийхэд Хил хамгаалах байгууллагад гэрээтээр алба хаасан хүмүүсийг сургалтад суулгахгүй, шалгалт авахгүйгээр л бараг ажлын байраар хангаж байна.

Өвөрхангай аймаг 114,000 орчим хүм амтай. Хүн амын тоогоороо улсын хэмжээнд хоёрдугаарт ордог. Энд бидний хайж буй

18-29 насны 20 мянга гаруй залуус оршин суудаг. Тэдний дунд ажилгүйдлийн түвшин 6,3 хувьтай байна. Ард иргэдийн дийлэнх нь мал аж ахуй эрхэлж амьжиргаагаа залгуулдаг бол сүүлийн жилүүдэд худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал дагалдан хөгжиж байгааг орон нутгийн удирдлага хэлэв. Ажилгүйдлийн гол шалтгаан нь мэргэжил эзэмшилт, боловсролын түвшин, ажлын байрны хүртээмж муу гэдгийг нутгийн удирдлагууд онцолж байлаа.

Тус аймгаас гэрээт хилчний албанд 140 залуус үүрэг гүйцэтгэсэн байдаг. Тэдний дийлэнх нь хугацаат цэргийн албыг Хил хамгаалах байгууллагад хааж байх хугацаандаа гэрээтийн алба руу шилжин үүрэг гүйцэтгэсэн байдаг аж.

Дундговь аймгийн хувьд орон нутгийн ард иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр нь мал аж ахуй. Дундговь аймгийн хувьд газар тариалан, уул уурхайн салбар хөгжөөгүй, хүн ам, газар нутгийн хувьд улсын хэмжээнд багадаа ордог. Үүнийгээ дагаад төрийн захиргааны болон цөөн тооны айл өрхийн бизнесээс өөр ажлын байрны хангалт байдаггүй гэв.

Залуус цэргээс халагдаад ирэхээр хүссэн ажлын байр нь байдаггүй учир мал дээр гардаг байна. Тус аймагт бидний хайж яваа 18-29 насны 4500 гаруй залуус байдгаас 40 гаруй хувь нь цэргээс халагдаж ирээд ажлын байраар хангагдсан бол бусад нь уламжлалт мал аж ахуй эрхэлж, идэвхтэй ажил хайгчид болон үлджээ. Өнгөрсөн жилүүдэд гэрээт хилчний албанд энэ нутгаас 90 орчим залуус элсэн оржээ.

Дээрх хоёр жишээнээс харахад гэрээт хилчин болох насны залуус тооны хувьд хангалттай байна.

“Гэрээт хилчин гэрэлтэй алба” уриатай гэрээтүүд Хил хамгаалах байгууллагын үндсэн бүрэлдэхүүний нэг хэсэг болоод чамгүй хугацааг үдсэн. Энэ хугацаанд гэрээт хилчний алба үр дүнгээ үзүүлсэн, бүр баталсан. Анх тус албыг шаардлагагүй гэж үзэн үл ойшоогчид ч байсан. Удаа дараагийн үл ойлголцол, багахан эсэргүүцэлтэй тулгарч байсан талаараа гэрээтийн албаны улаан шугамыг таталцсан хүмүүс хүүрнэдэг. Тэгвэл “Гэрээт хилчид хил хамгаалалтад хэрхэн үүрэг гүйцэтгэв” гэсэн асуултад сэтгүүлчийн зүгээс дахин хариулт эрлээ. Гэрээт хилчний албанд бүрэн шилжсэн хилийн 0168 дугаар анги болон хилийн боомтын аюулгүй байдал,

шалган нэвтрүүлэх албанд гэрээт хилчдээр үүрэг гүйцэтгүүлж буй хилийн 0108 дугаар ангиар судалгаа хийсэн юм.

Хилийн 0168 дугаар анги 2008 оноос хойш гэрээт хилчдийг улсын хил хамгаалалтад тасралтгүй үүрэг гүйцэтгүүлж байгаа. Гэрээт хилчид улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж эхэлснээс хойш хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийн илрүүлэлт 20 хувиар өссөн байна.

Тэгвэл хилийн 0108 дугаар ангийн хувьд хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд 2017 оноос гэрээт хилчдийг оролцуулж эхэлсэн байна. Улсын хил хамгаалалт, хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албанд гэрээт хилчид үүрэг гүйцэтгэснээр хилийн болон хил орчмын дэглэмийн болон хилийн боомтод мөрдөх журмын зөрчлийн илрүүлэлт, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон хязгаарласан эд зүйлийн илрүүлэлт тус тус хоёр дахин нэмэгдсэн хэмээх дүнг гарч байгаа юм

Мөн сонор сэрэмж, хариуцлага алдах, дүрэм журам зөрчих зэрэг хугацаат цэргийн алба хаагчдын зонхилон гаргадаг алдаа дутагдал, сахилга, ёс зүйн зөрчил буурсан зэрэг давуу талууд гарч байгааг хоёр анги дуу нэгтэй онцолж байлаа. Учир нь гэрээт хилчний албанд хугацаат цэргийн алба хаасан, бүрэн дундаас дээш боловсролтой сахилга, ёс зүйн хувьд төлөвшсөн, гэмт хэрэг, сахилгын зөрчилд холбогдож байгаагүй, ар гэрийн хувьд хүндрэлгүй, бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй залуусыг сонгон шалгаруулж авахын зэрэгцээ хил дээр үүрэг гүйцэтгэнэ гэсэн сэтгэл зүйн бүрэн бэлтгэлтэй бэлтгэгдсэн албa хаагчид ирдэг. Сэтгэл зүйн хувьд илүү байна гэдэг албa, үйл ажиллагаа алдаа дутагдал багатай явагдахын нэг үндэс.

Дээрх хоёр ангийн жишээнээс харахад Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчний албa хэрэгтэй юу гэвэл нэн чухал хэрэгтэй. Энэ зөвхөн байгууллагын хэмжээнд яригдаад өнгөрөх асуудал биш юм. Хил хамгаалалтын үр дүн сайн байна гэдэг улс эх орны аюулгүй байдал, эдийн засаг, цаашлаад ард иргэдийн амар амгалан аж төрөхийн гол тулгуур хүчин зүйл болдог жамтай. Гэтэл сүүлийн жилүүдэд гэрээт хилчний албыг сонирхох залуусын тоо бага багаар буураад байгаа. Харин улсын хэмжээнд цэргэг албa хаагаад ирсэн идэвхтэй ажил хайгч залуусын тоо буураагүй байна.

“2010-2017 онуудад гэрээт хилчний албанд орох залуусын тоо эрс нэмэгдэж, оргил үе байсан ба сүүлийн жилүүдэд залуусын тоо нэлээд буурсан. Энэ нь нэг талаас уул, уурхай, төмөр замын бүтээн байгуулалт эрчимтэй хөгжиж, тус салбарт ажиллагсадын цалин, хангамж өндөр байгаа явдал. Мөн мөрдэс зүүж хил дээр үүрэг гүйцэтгэхэд цэргийн дүрэм, журмын хүрээнд хувь хүний эрх тодорхой хэмжээнд хязгаарлагддаг. Тиймээс нийгмийн хандлага, өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, журмандаа тодотгол оруулах шаардлага тулгарч байна.

Залуус энэ хуулийн талаар 18-22 насандаа тэр бүр онцолж анхаардаггүй ч их, дээд сургуулиа төгссөний дараа ажлын байрны сонгон шалгаруулалтад хамрагдахад нь “цэргийн алба хаасан байх” гэсэн шалгуур үзүүлэлттэй дийлэнх нь нүүр тулдаг байна. Тиймээс 26 нас хүрэхээсээ өмнө цэргийн алба хаах сонирхолтой залуусын тоо ч нэмэгджээ. Хуулийн энэхүү заалт нь залуусыг цэргийн албанд хамруулах бас нэг хөшүүрэг болж чаджээ.

Үүнтэй адил гэрээт хилчин болно гэсэн ирээдүйн төлөвлөгөөндөө хүрэхийн тулд хугацаат цэргийн алба, тэр дундаа хилийн цэрэгт алба хаах хүсэлтэй залуус өрсөлдөж, уралдаж, дараагийн сонгон шалгаруулалтыг хүлээдэг тийм л нөхцөл боломж, хөшүүрэг энэ үед хэрэгтэй болов уу. Залуусын амьдралаа гэрэл гэгээтэй, зорилготой харах нэг харгуй нь гэрээт хилчний алба байгаасай гэсэн багахан санал сэтгэгдэл байгаа юм.

ДҮГНЭЛТ:

-Гэрээт хилчний албанд шилжсэн бөгөөд Монгол Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүний нөхөн хангалт хангалтгүй байгаа ба нэг хилчинд ноогдох албаны ачаалал эрс ихэссэн.

-Хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын ажлын хөлс, ажилласан жилийн нэмэгдэлд өөрчлөлт орсон. Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын цалин хөлс, ажилласан жилийн нэмэгдэл энэ өөрчлөлтөд хамрагдаагүй, ялгаварлан гадуурхагдсан нь тэдний сэтгэл зүйг хүнд дарамтад оруулсан.

-Бусад хууль сахиулах чиг үүрэг бүхий байгууллагуудын байршил сумын төв, суурин газар байрлаж байхад, Хил хамгаалах байгууллагын хилийн застав, салбарууд эзгүй хээр, суурьшлын

бүсээс хол байрладаг. Дэд бүтэц хангалтгүй. /Утасны сүлжээ, интернет, зам харгуй гэх мэт/.

-Хил хамгаалах байгууллага ахуйн чанартай ажил хөдөлмөр хэт их хийдэг. /Ус, түлээ бэлтгэх, мал маллах, идэш хоолоо бэлтгэх, байр орчноо цэвэрлэх, барилга байгууламжаа барих, засварлах гэх мэт/.

-Гэрээт хилчний сонгон шалгаруулалт хангалтгүй. /Хүн олдохгүй байгаа учраас орох хүсэлт гаргасан хүмүүсийг сонголтгүйгээр тухайн албанд авдаг/.

-Гэрээт хилчний албанд нөхөн хангалт хангалтгүй байгаагаас гэрээт хилчний албанд шилжсэн Хилийн цэргийн анги, салбаруудын ажлын дүнгийн үзүүлэлтэд гэрээт хилчний гэрээг цуцалсан тохиолдолд ажлын дүнг бууруулах тухай заалт оруулж байгаа нь албаны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх шалтгаан болдог.

-Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчнээр алба хааж байгаа гэрээт хилчид эхнэр, хүүхэдтэй байх тохиолдол цөөнгүй байдаг бөгөөд ар гэр, үр хүүхэддээ санаа зовох, жилд ганц удаагийн ээлжийн амралт хангалтгүй байгаа нь албанд нөлөөлдөг. /сэтгэл санааны болоод биеийн/.

-Хөдөлмөрийн тухай хуульд заасан ээлжийн амралтаа хүссэн сар, хугацаандаа эдэлж чаддаггүй. /Хүн хүч дутмаг, урин дулааны цагаар аж ахуй тохижилт, бүтээн байгуулалтын ажил ихтэй гэх мэт/

САНАЛ:

1.Хил хамгаалах байгууллагад гэрээт хилчнээр алба хаах журамд өөрчлөлт оруулж ээлжийн зохион байгуулалтад шилжүүлэх /ээлжийн ажилчдыг солилцдог шиг/ 15 хоног ажиллаад, 15 хоног ар гэртээ харьдаг байх;

2.Гэрээт хилчдийн ажлыг бодитой дүгнэж, 15 хоног ажиллахдаа албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, сахилгын болон харьцааны зөрчил гаргасан гэрээт хилчдийн дараа сарын ар гэртээ амрах 15 хоногоос хасаж тооцох, удаа дараа зөрчил гаргасан гэрээт хилчдийг захиргааны санаачилгаар гэрээг нь цуцлах;

3.Хугацаат цэргийн алба хаагчдаас журамд заасан хугацаат цэргийн алба хаах хугацаагаа хангасан залуусыг шалгуур үзүүлэлтийн дагуу түлхүү авах;

4.Гэрээт хилчдийн ажилласан жилийн нэмэгдэл, цалин хөлсөнд өөрчлөлт оруулах;

5.Хил хамгаалах байгууллагаас шинээр барих хилийн заставыг бодлогоор сумын төв, суурин газар барьж байгуулах;

6.Гэрээт хилчдийг шагнаж, урамшуулах журамд өөрчлөлт оруулах. /Орон нутгийн чөлөө, Хил хамгаалалтад амжилт гаргасны төлөө, онц хилчин тэмдэг л өгдөг/;

7. Өвөл 10 сараас хавар 3, 4 сар хүртэл байгалиараа хамгаалагддаг цас ихтэй зарим нэг хилийн заставуудыг түр хугацаагаар буулгаж, хилийн цагийн байдлын өрнөлттэй, зөрчил ихтэй хэсэгт хүч нэмэгдүүлэн үүрэг гүйцэтгүүлэх, сургалтад хамруулах, эрүүл мэндийн үзлэг оношилгоонд оруулах гэх мэт /Арал толгойн застав/;

8.Хүрэхэд хүндрэлтэй алслагдсан хэсэгт байрлах хилийн заставуудыг ээлжийн зохион байгуулалтад оруулах /Минжийн хилийн застав/.

Ашигласан материал:

-Монгол Улсын хилийн тухай хууль, 2016 он

-Цэргийн албаны тухай хууль, 2016 он

-Ц.Эрдэнээ. “Гэрээт хилчний албаны үйл ажиллагаа”. дисс. УБ., 2002 он

-Д.Нямдорж. “Гэрээт хилчний алба” ном. УБ., 2011 он

-Ч.Сайнтөр. “Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэх арга зам”. дисс. УБ., 2020 он

ХИЛИЙН ЦЭРГИЙН АНГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ, ШИНЖИЛГЭЭ

С.Түмэн-Өлзий
ДХИС-ийн Удирдлагын академийн 8022
дугаар дамжааны суралцагч, хошууч

Товч агуулга: Энэхүү сэдвийн хүрээнд хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээг гурван чиглэлээр хийн, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангахад анхаарах талаар санал дэвшүүлэхийг зорилоо.

Түлхүүр үгс: Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, нөлөөлөх хүчин зүйл, шинжилгээ, анхаарах зарим асуудал.

Key words: Security, border security, current status, legal regulation, some issues for improvement.

Оршил

Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлохын тулд:

Нэг. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай онолын мэдлэг ямар төвшинд байгаа болон орчны үнэлгээнд хийсэн тойм судалгаа;

Хоёр. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар судалгаа хийлээ.

Судалгаанаас тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангахад анхаарах зарим санал дэвшүүлэхийг зорилоо.

Үндсэн хэсэг.

Нэг. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, орчны үнэлгээний талаар гурван ангийн нийт 144 цэргийн алба хаагчдаас доорх 7 асуулгаар судалгаа авлаа.

1. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай таны ойлголтын талаар судалгаанд оролцсон цэргийн алба хаагчдын 106 буюу 73.6 хувь нь мэднэ, 24 буюу 16.6 хувь нь мэдэхгүй, 14 буюу 9.8 огт ойлголтгүй гэж тус тус хариулсан байна.



Зураг 1. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай ойлголт.

2.Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал нь Хилийн цэргийн албаны аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд хилийн цэргийн анги, салбарын байр, обьект, орчны аюулгүй байдал, хилийн цэргийн алба хаагчийн аюулгүй байдлын тухай ойлголтууд тус тус хамаарна" гэж үзэж байна. Та дээрх тодорхойлолт, ойлголттой санал нэгдэж байна. уу гэсэн асуултанд 114 буюу 79 хувь нь тийм, 14 буюу 10 хувь нь ойлголтгүй, 16 буюу 11 хувь нь огт мэдэхгүй гэж тус тус хариулсан байна.



Зураг 2. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын тухай ойлголт.

3. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдал нь эрх зүйн хувьд бүрэн зохицуулагдсан уу гэсэн асуултанд нийт судалгаанд хамрагдагсдын 50 хувь нь дунд, 22 хувь нь сайн, 4 хувь маш сайн, 14 хувь нь муу, 10 хувь нь маш муу гэж хариулсан байна.



Зураг 3. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалт.

4. Хилийн цэргийн анги, салбарын байрны бүрэн бүтэн байдал, харуул хамгаалалт өнөөгийн шаардлага хангаж байгаа эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 60 хувь нь "Дунд", 19 хувь

нь “Сайн”, 7 хувь нь муу, 13 хувь нь маш муу, 1 хувь нь маш сайн гэж хариулсан байна.

Дүгнэлт: Дээрх асуултанд судалгаанд оролцогсдын 60 хувь нь “Дунд”, 20 хувь нь сайн болон маш сайн, 20 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.



Зураг 4. Хилийн цэргийн анги, салбарын байрны бүрэн бүтэн байдал, харуул хамгаалалт өнөөгийн шаардлага хангаж байгаа эсэх.

5. Алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд байгаа эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын маш сайн гэж хариулаагүй бөгөөд 50 хувь нь “Дунд”, 28 хувь нь “Сайн”, 17 хувь нь муу, 5 хувь нь маш муу гэж хариулсан байна.

Дүгнэлт: Дээрх асуултанд судалгаанд оролцогсдын 50 хувь нь “Дунд”, 28 хувь нь сайн болон маш сайн, 22 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд бүрэн хүрэхгүй байгаа, тэдний энэхүү мэдлэгийг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.



Зураг 5. Алба хаагчдын албаны ур чадвар, техник, технологи ашиглах мэдлэг нь хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах хэмжээнд байгаа эсэх.

6. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдсэн эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын маш сайн гэж хариулаагүй бөгөөд 44 хувь нь “Дунд”, 20 хувь нь “Сайн”, 21 хувь нь муу, 15 хувь нь маш муу гэж тус тус хариулсан байна.



Зураг 6. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдсэн эсэх.

7. Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээтэй эсэх гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 42 хувь нь “Маш муу”, 27 хувь нь “Муу”, 25 хувь нь “Дунд”, 2 хувь нь маш сайн, 4 хувь сайн гэж тус тус хариулсан байна.



Зураг 7. Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээтэй эсэх.

Дээрхээс нөхцөл байдлын судалгаа (орчны судалгаа)-г дүгнээд үзэхэд хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын нэр томъёо, тодорхойлолтын талаар судалгаанд оролцогсдын ойлголт хэвийн;

ХЦААБ-ыг хангах асуудал нь эрх зүйн хувьд хэвийн хэмжээнд зохицуулагдсан болохыг илэрхийлсэн бөгөөд өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатайг харуулсан;

ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатай;

Хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдээгүй, техник технологийн хангалтыг шинэчлэх, сайжруулах шаардлагатай;

Алба хаагчдын цалин хангамж хүрэлцээгүй, шаардлагын түвшинд хүрэхгүй учир дутагдалтай гэж тус тус дүгнэгдсэн.

Орчны судалгаанаас хилийн цэргийн анги, салбарын аюулгүй байдалд техник, технологийн хангалт дутмаг, цалин хангамжийн

хүрэлцээ муу, сэтгэл дундуур байна. Цаашид дээрх хоёр асуудалд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

Хоёр. Хилийн цэргийн ангийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлж, асуулгын аргаар хилийн цэргийн гурван ангийн 144 цэргийн алба хаагчдаас судалгаа авч судлан шинжиллээ. Үүнд:

2.1. Гадаад хүчин зүйл.

1. Хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал (хашаа, камер, шалган нэвтрүүлэх байр, дохиоллын систем) гэсэн судалгаанд оролцогсдын 46 хувь нь “Дунд”, 19 хувь нь сайн болон маш сайн, 10 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал хэвийн, харин камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

2. Харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 43 хувь нь “Дунд”, 51 хувь нь сайн болон маш сайн, 6 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт хэвийн байгааг илэрхийлж байна.

3. Тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдал гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 36 хувь нь “Дунд”, 46 хувь нь сайн болон маш сайн, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан, тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдал 72 хувь нь дундаас дээш байгааг илэрхийлсэн нь энэхүү харилцааны байдал хэвийн байгааг, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь энэхүү харилцааг илүү сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

4. Тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь гэсэн асуултанд судалгаанд оролцогсдын 29 хувь нь “Дунд”, 53 хувь нь сайн болон маш сайн, 18 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь сайн байгааг илэрхийлж байна зэрэг 15 асуулгаар гадаад хүчин зүйлийн нөлөөллийг тодорхойлсон.

2.2. Дотоод хүчин зүйл.

1. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчин хангалттай эсэх гэсэн судалгаанд оролцогсдын 51 хувь нь “Дунд”, 33 хувь нь сайн болон маш сайн, 16 хувь нь хангалтгүй гэж

хариулсан нь Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчний хангалт хэвийн, хангалттайг илэрхийлж байна.



Зураг 7. Алба хаагчдын мэргэжлийн ур чадвар, чадварлаг боловсон хүчин хангалттай эсэх.

2. Алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан эсэх гэсэн судалгаанд оролцогсдын 45 хувь нь “Дунд”, 25 хувь нь сайн болон маш сайн, 30 хувь нь хангалтгүй гэж хариулсан нь Алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан байдлыг 75 хувь нь бүрэн хангагдаагүй буюу дундаас доош түвшинд үнэлсэн нь алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах шаардлагатайг илэрхийлж байна.

Аюулгүй байдлын онолоор “аюулгүй байдалд нөлөөлөх сөрөг хүчин зүйл” гэдэг нь үндсэндээ төр, нийгэм, бие хүний (иргэний) язгуур эрх ашигт аюул учруулж буй хүчин зүйлс, нөхцөл байдлын нэгдэл юм. Энэхүү ойлголтод тулгуурлан ХЦААБ-д нөлөөлж буй хүчин зүйлийн нөлөөллүүдийг:

- ХЦААБ-ын тухай ойлголт болон орчны нөлөөллийн хүчин зүйлийн шинжилгээг 7 асуулгаар;

- ХЦААБ-д нөлөөлж буй гадаад хүчин зүйлийн нөлөөллийг 15 асуулгаар;

- ХЦААБ-д нөлөөлж буй дотоод хүчин зүйлийн нөлөөллийг 25 асуулгаар боловсруулан, дээрх асуулгуудаар хилийн цэргийн гурван ангийн 144 алба хаагчдаас судалгаа авч шинжилгээ хийлээ.

Дүгнэлт:

Нэг. Гадаад орчны шинжилгээ.

Давуу тал:

- нөхцөл байдлын судалгаа (орчны судалгаа)-г дүгнээд үзэхэд хилийн цэргийн ангийн аюулгүй байдал, хилийн цэргийн ангийн аюулгүй байдлын нэр томъёо, тодорхойлолтын талаар судалгаанд оролцогсдын ойлголт сайн;

- харуул хоногийн манааны үүрэг гүйцэтгэлт хэвийн, сайн;

- тухайн аймаг, орон нутгийн иргэд, хилчдийн хоорондын харилцааны байдлыг судалгаанд оролцогсдын 72 хувь нь дундаас дээш байгааг илэрхийлсэн нь энэхүү харилцааны байдал хэвийн, сайн байгааг харуулсан;

- тухайн орон нутаг дахь хилчдийн нэр хүнд, иргэдийн дунд эзлэх байр суурь сайн;

- орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллагууд болон хилийн цэргийн ангийн харилцан ажиллагаа маш сайн;

- тухайн анги, салбарын байрлал зөв газраа байрласан;

- улсын хилийн аюулгүй байдлыг хангасан байдал нь сайн байна.

Сул тал:

- ХЦААБ-ыг хангах асуудал нь эрх зүйн хувьд хэвийн хэмжээнд зохицуулагдсан болохыг илэрхийлсэн бөгөөд өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатайг харуулсан;

- ХЦААБ-ыг хангах байр, харуул хамгаалалтын өнөөгийн байдал нь шаардлагыг бүрэн хангаж чадахгүй, сайжруулах шаардлагатай;

- хилийн цэргийн ангийн аюулгүй байдлыг хангах техник, технологийн хангалт бүрэн шийдэгдээгүй, техник технологийн хангалтыг шинэчлэх, сайжруулах шаардлагатай;

- хилийн цэргийн ангийн байрны хамгаалалт, бүрэн бүтэн байдал хэвийн, харин камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатай;

- орон нутгийн бизнес, эдийн засгийн нөхцөл байдал сайн биш, хангалтгүй;

- хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 70 хувь нь, нөлөөлөхгүй гэж судалгаанд оролцогсдын 30 хувь нь илэрхийлсэн;

- улсын хил дээр үүссэн эмх замбараагүй байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 64 хувь нь, нөлөөлөхгүй гэж судалгаанд оролцогсдын 36 хувь нь илэрхийлсэн;

- цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгаль цаг уурын байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө гэж 88 хувь нь үзсэн;

- тухайн орон нутгийн байгууллага, иргэдээс нөлөөлөх ашиг сонирхол ХЦААБ-д 29 хувийн муугаар нөлөөлж болзошгүй;

- хилийн цэргийн анги, салбар дахь улс төрийн нөлөөлөл нь ХЦААБ-д 40 хувийн муугаар нөлөөлж болзошгүй;

- гамшиг, аюул осол, гал түймэр, гол усны үер, газар хөдлөлтийн аюулгүй байдал нь хангалттай хангагдаагүй;

- хилийн цэргийн ангийн техникийн хангалтын боломж нь хангалтгүй, энэ нь ХЦААБ-д 48 хувийн сөргөөр нөлөөлж болзошгүй;

- алба хаагчдын цалин хангамж хүрэлцээгүй, шаардлагын түвшинд хүрэхгүй учир дутагдалтай гэж тус тус дүгнэгдсэн.

Дээрх гадаад орчны судалгаанаас дараах тулгамдаж буй асуудал байна. Үүнд:

- өнөөгийн нөхцөл байдалтай уялдуулан эрх зүйн зохицуулалтын актыг шинэчлэх шаардлагатай;

- хилийн цэргийн анги, салбарын аюулгүй байдалд техник, технологийн хангалт дутмаг, алба хаагчдын цалин хангамжийн хүрэлцээ муу, сэтгэл дундуур байна;

- түүнчлэн орон нутгийн бизнес, эдийн засгийн нөхцөл байдал сайн биш, хангалтгүй, цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, байгаль цаг уурын байдал, гамшиг, аюул осол, гал түймэр, гол усны үер, газар хөдлөлт, тухайн орон нутгийн байгууллага, иргэдээс нөлөөлөх ашиг сонирхол, хилийн цэргийн анги, салбар дахь улс төрийн нөлөөлөл ХЦААБ-д 40-88 хувийн сөргөөр нөлөөлөх магадлалтай;

- албаны үйл ажиллагааны хувьд хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчил, улсын хил дээр үүссэн эмх замбараагүй байдал нь ХЦААБ-д дундаас дээш болон маш ихээр нөлөөлнө;

- камерын хамгаалалт, дохиоллын системийг сайжруулах шаардлагатай зэрэг болно. Эндээс цаашид эдгээр асуудалд бодлогын болоод удирдлага, зохион байгуулалтын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

Хоёр. Дотоод орчны шинжилгээ.

Давуу тал:

- алба хаагчдын мэргэжлийн ур чадвар хэвийн, чадварлаг боловсон хүчний хангалт сайн;

- хилийн цэргийн ангийн тасаг албадын уялдаа холбоог 83 хувь нь дундаас дээш сайн, хэвийн гэж үзсэн;

- шат дараалсан хяналт, шалгалт маш сайн явагддаг;
- тушаал, дүрэм, журам, зааврын хэрэгжилт хэвийн;
- алба хаагчдын хоорондын харилцаа, зарчимч шаардлага сайн;
- алба хаагчдын албанд хандах хандлага (үнэнч, шударга байдал) сайн;
- алба хаагчдын гэр бүлийн байдал тогтвортой, хэвийн сайн;
- алба хаагчдын сахилга, хариуцлагын байдал хэвийн сайн;
- алба хаагчдын ёс зүй хэвийн сайн;
- алба хаагчдын албаны мэдлэг, туршлага хэвийн сайн;
- алба хаагчдын аюулгүй байдал, эрсдэлийн мэдлэг хэвийн;
- харуул хоногийн манааны тохироо маш сайн;
- хилийн цэргийн ангийн албаны зохион байгуулалт сайн;
- зэвсэг галт хэрэглэл, тавиулан, агуулахын хадгалалт, хамгаалалт сайн;
- нууц хадгалалт, хамгаалалтын байдал маш сайн;
- мэдээллийн аюулгүй байдал сайн;
- алба хаагчдын хүнсний аюулгүй байдал хэвийн;
- алба хаагчдын үүрэг гүйцэтгэх орчин нөхцөл (өрөө тасалгаа) хэвийн;
- алба хаагчдын хувцас хэрэгслийн хангалт хэвийн хэмжээнд сайн зэрэг болно.

Сул тал:

- алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдал бүрэн хангагдсан байдлыг 75 хувь нь бүрэн хангагдаагүй буюу дундаас доош түвшинд үнэлсэн нь алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах шаардлагатайг илэрхийлсэн;
- цалин хангамжийн хүрэлцээтэй байдал хангалтгүй, цалин хангамж нэмэх шаардлагатай;
- төсвийн зүй зохистой хуваарилалтад анхаарах шаардлага байгаа;
- алба хаагчдын ажлын ачаалал дундаас дээш их;
- алба хаагчдын амьжиргааны түвшин хангалтгүй муу;
- цэргийн дүрмийн бус харилцаа тодорхой хэмжээнд байгааг 22 хувь нь илэрхийлсэн болно.

Дээрх дотоод орчны судалгаанаас дараах тулгамдаж буй асуудал байна. Үүнд:

- алба хаагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажиллагааг сайжруулах;
- цалин хангамж нэмэх шаардлагатай;
- алба хаагчдын ажлын ачаалал дундаас дээш их;
- алба хаагчдын амьжиргааны түвшин хангалтгүй;
- цэргийн дүрмийн бус харилцаа тодорхой хэмжээнд байгаа зэрэг болно.

Иймд эдгээр асуудалд бодлогын болоод удирдлага, зохион байгуулалтын түвшинд анхаарч ажиллах шаардлагатай гэж бидний зүгээс дүгнэж байна.

ХЦААБ-ын гадаад, дотоод орчинд хийсэн дээрх судалгаанд үндэслэн хилийн цэргийн анги, байгууллагын аюулгүй байдал, түүнийг хангах ажиллагаанд дараах нөхцөл байдлуудыг анхааран, үйл ажиллагаагаа чиглүүлж болох юм. Үүнд:

Гадаад хүчин зүйлс:

- улс орны эдийн засгийн хүндрэл;
- байгалийн аюул гамшиг (ган, зуд, гал усны аюул, газар хөдлөлт, гоц халдварт өвчин тархах);
- шударга бус өрсөлдөөнөөс үүдэн байгууллагуудын хооронд үл ойлголцох байдал бий болох;
- гэмт бүлэглэл буюу гэмт этгээдийн халдлага;
- ангийн нэр хүндэд санаатай болон санамсаргүйгээр халдах;
- хамт олны эгнээнд таагүй этгээд шургалах;
- өөр байгууллага, этгээдийн буруугаас осол аваар гарах, эрүүл мэнд, эд хөрөнгөөр хохирох;
- гадны байгууллага хувь хүний нөлөөнд автаж, буруу үйл ажиллагаа явуулах;
- гадны нөлөөгөөр чухал мэргэжлийн болон авьяас чадвартай хүмүүсээ алдах;
- гадны нөлөөнд автан удирдах ажилтнуудын гар нийлэмжтэй ажиллагаа болон хамт олны санал сэтгэгдэл алдагдах, ажлын идэвх буурах;
- буруу, ташаа мэдээлэл авснаас буруу шийдвэр гаргах;
- томилогдон ирж буй офицер, ахлагч нар ажлын шаардлага, хэрэгцээг хангахгүй байх;

- дээд шатны байгууллагаас ангийн үйл ажиллагаа, бодит байдлыг өрөөсгөл буруу дүгнэх, улс төрийн нөлөө орох;

- техник, технологийн хоцрогдолд орох;

- нийгмийг хамарсан ядуурал, гэмт хэргийн өсөлт;

- бие бүрэлдэхүүний ар гэрт тохиолдсон бэрхшээлээс үүдэн таагүй байдал бий болох (гэр бүлийн гишүүдээс гэмт хэрэгт холбогдох, тааламжгүй байдал, хүнд өвчлөх, үхэл зовлон тохиолдох, аюул гамшигт өртөх) зэрэг болно.

Санал

Дээрх хүчин зүйлс, нөлөөллөөс хамгаалж үндсэн үүргээ бүрэн биелүүлэхийн тулд дараах ажлуудыг зохион байгуулах саналтай болно. Үүнд:

- бүх төрлийн нөөцтэй байх;

- материал хэрэгслийг зүй зохистой зарцуулж ашиглах өөрсдийн хүчинд тулгуурладаг байх;

- ангийн байрлалд орж гарах, гадны хүнтэй уулзах журмыг хатуу чанд сахих, бүх газрыг харуул, манааны хяналтад байлгах;

- гэнэтийн халдлага, хулгай дээрэм гарсан үед явуулах ажиллагааг төлөвлөж, дадлага, сургууль хийх, бие бүрэлдэхүүнийг бие хамгаалах урлагийн зохих бэлтгэлтэй болгох;

- шинжлэх ухаан, технологийн ололтыг нэвтрүүлэх, орчин үеийн техник хэрэгслээр хангаж, офицер, ахлагч нарын албаны мэдлэгийг сайжруулах;

- айл өрхийн судалгааг тодорхой хийж, офицер, ахлагч, ажилчдын ар гэрт анги, хамт олны нөлөөллийг бий болгох зэрэг болно.

Ашигласан материал:

1.Монгол Улсын Үндсэн хууль (1992)

2.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль (2001)

3.Монгол Улсын Хилийн тухай хууль (2016)

4.Монгол Улсын Цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах тухай. (МУЕ-ийн зарлиг №180, 2022)

5.Монгол Улсын хилийн цэргийн штабуудын албаны заавар. (ХХЕГ-ын даргын тушаал №А/68, 2007)

6.Хил хамгаалах байгууллагад цэргийн албыг зохион байгуулах заавар. (ХХЕГ-ын даргын тушаал №А/259, 2019)

7.Дашзэвэг, Ц. Цэргийн нэр томъёоны тайлбар толь. Уб., 2014. 57 х. 65 х. 209 х.
8.Пүрэвбаасан, В. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол арга зүй. Уб., 2022. 219 х.
9.Улаанхүү, Ч. Аюулгүй байдал. Уб., 2009. 35 х.
10.Мандахбаяр, Д. Артиллерийн анги салбарын аюулгүй байдлыг хангах зарим арга зам. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2018. 48 х.
11.Эрдэнэцогт, Д. Цэргийн албаны аюулгүй байдлыг хангах үндэс. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2002. 65 х.
12.Пүрэвбаасан, В. Хилийн цэргийн албаны аюулгүй байдлыг хангах онол арга зүй. Хил судлалын докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2020.
13.https//www.bolor-toli.com/dictionary/word search=security
14.https//www.werriam-webster.com/dictionary/sefity

УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛД НӨЛӨӨЛӨХ ШИНЖИЛГЭЭ

А.Тэмүжин
ДХИС-ийн Удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, хошууч

Хураангуй: НҮБ-ийн Мянганы хөгжлийн зорилтуудыг хангах, засаглалын баримт бичигт төрийн байгууллагуудын үйлчилгээг сайжруулахад сайн манлайлал, алсын хараа нэн чухал... хөгжиж буй орнуудын улсын салбарын удирдлагад тулгардаг асуудлуудын нэг хэмээн заасан байдаг. Мөн Монгол Улсын 2016 оны “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын 2.4 Тогтвортой хөгжлийн засаглалын Зорилт 2.т Төрийн бүх шатны байгууллагын удирдлагын манлайллыг дээшлүүлэх, бүх нийтийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг үндэсний болон орон нутгийн түвшинд бүрдүүлнэ гэж заасан байна.

Түлхүүр үг: ур чадвар, харилцаа, мэдлэг, ёс зүй, манлайлал

Манлайлал, манлайллын орчин үеийн чиг хандлага

Үндсэн ойлголтын тайлбар

“Манлайлах” Манлай болох, тэргүүлэх: ажилчид манлайлах (ажилчид тэргүүлэн хошуучлах), манлайлан хошуучлах (бүгдийн түрүүнд байх)

“Манлайлах байдал” Удирдагчийн манлайлал (удирдагч хүний үлгэрлэх байдал).

“Манлайлагч” Манлай бодогч, тэргүүлэгч, хошуучлагч[96]

Манлайллын тухай онолын олон хандлага нь түүний мөн чанарыг олж мэдэх гэсэн оролдлогыг илтгэдэг. Манлайллын тухай онолын хандлагуудад генетикийн онол, манлайлах хувийн шинжийн онол, зан үйлийн онол, нөхцөл байдлын онол багтдаг бөгөөд удирдах арга барилын онолын үндэс болон хөгжсөн юм.[6]

Генетикийн онол. Манлайллын хамгийн эртний тайлбар бол манлайлах чадвар “ген”-ээр дамждаг гэж үздэг генетикийн хандлага юм. “Манлайлагч болж төрдөг болохоос, түүнийг бий болгож болдоггүй” гэсэн үгээр хандлагыг дүгнэдэг. Манлайлах чадвар, байр

[96] Монгол хэлний их тайлбар толь

суурийн удамшин шилжих тухай бодлыг төрмөл эрх гэж үздэг тал ч бий.[7]

Хувь шинжийн онол. Анхны судалгаанууд манлайлагчдын шинж чанарыг судлахад чиглэгдэж байв. Харин Стогдилл[8] энэ бүх судалгааг нэгтгэн шинжилж үзээд манлайлагч хүний бие бялдрын шинж (дайчин, шаламгай байдал, гадна байдал, ноён нуруу); чадавхын 4 шинж, хувийн 16 онцлог шинж чанар (зохицох чадвар, зоримог, түрэмгий шинж, сэтгэлийн тэнхээ, өөртөө итгэх итгэл); ажилтай холбоотой 6 шинж (амжилтад тэмүүлэх, шаргуу уйгагүй чанар, санаачилга гэх мэт); нийгмийн 9 шинж чанар (хамтарч ажиллахад бэлэн байдал, хүмүүстэй аятай харилцаа тогтоох чадвар, захирамжлах авьяас гэх мэт)-ыг тодорхойлсон байдаг.

Манлайллыг хувь хүний манлайлал, удирдах ажилтны манлайлал, хамтын манлайлал, салбарын манлайлал гэж дөрвөн хүрээгээр тайлбарладаг[97]. Энэхүү дөрвөн хүрээ нь тус тусдаа хэрэгждэг ч, хоорондоо уялдаатай судлагддаг.

Манлайлагч бүр удирдагч байх албагүй, харин удирдагч бүр манлайлагч байх ёстой. Манлайлагч нь бусдын мэдрэмж, хандлага, зан үйлд өөрчлөлт оруулж чадаж байвал нөлөө үзүүлж байгаа хэлбэр. Ийнхүү нөлөө үзүүлэхэд эрх мэдэл бодит болсон шинж шууд нөлөөлнө. Эрх мэдлийг бодит болгохын тулд манлайлагч өөрийн мэдлэг, ур чадварыг бүрэн ашигласны үр дүнг хэрэгжүүлнэ. Манлайлагч зорилгодоо хүрэхийн тулд олон төрлийн эрх мэдлийг хослуулан хэрэглэх чадвар нь бусдыг араасаа дагуулахаас эхэлнэ.

Манлайллын талаар нийгмийн шинжлэх ухааны судалгааны ажилд олон судлаачид манлайлалд нөлөөлөх хүчин зүйлийн уялдааг дараах байдлаар дэлгэрэнгүй судаллаа. Үүнд:

-Мэдлэгийн менежмент болон манлайллын хоорондын хамаарлыг эрдэмтэд судлан батлахдаа, мэдлэгийг түгээж, өөрийн мэдлэгээрээ ажилчид манлайлах хандлага ихэнх хувийг эзэлж байна (McFarllane, 2008). Манлайлал нь байгууллагын доторх мэдлэгийг удирдахад чухал үүрэг гүйцэтгэдэг (Donate, 2011). Байгууллагын үйл ажиллагаанаас хамаарч ажилчдын мэдлэг манлайлах арга барилд шууд нөлөөлж байна (Millar, 2016).

---

[97]Стефен Ковейгийн “Өндөр бүтээмжтэй хүмүүсийн 7 дадал” ном, 1-р хэвлэл, Нью Иорк, Саймон энд Шустер, 1989 он.

-Мэргэжлийн ур чадвар нь манлайлалтай хэрхэн уялдах талаар, Роберт Л.Кац (1955; 1974) нь өөрийн судалгааны цуврал бүтээлээрээ, менежерийн үүрэг, манлайллыг амжилттай гүйцэтгэхэд менежментийн ур чадварыг тодорхойлохын ач холбогдлыг нотолсон (Nataša Ritonija, 2016). Мэргэжлийн ур чадвар нь манлайлах чадварыг хөгжүүлж байгууллагын засаглалд хувь нэмэр оруулдаг (Abbass, 2016).

-Манлайллыг хандлагатай уялдуулан судлахдаа “Манлайлагч бол өөрсдийн яриагаа цэгнэж байдаг ба тэдний гаргаж ирсэн онол болон бодит байдлынх нь хооронд ямарч ялгаа байдаггүй, манлайлал нь хандлагаар илэрдэг (Bennis, 2008,2021).

-Edgar Schein (2004) Соёл нь байгууллагад зан төлөвийн 90 хувийг бий болгож, байгууллагын гол цөм, ажилтан тэрхүү цөмд ажиллаж, хөтлөгддөг. Манлайлал нь соёлыг бий болгож, удирддаг (Cotter-Lockard, 2009).

-Сургалт хөгжил нь тухайн ажилтныг манлайлах арга барилд сургадаг (Seidle, 2016). Сургалтаар олгож буй мэдлэг, мэргэжлийн ур чадвар нь ажилчдыг хөгжүүлсний үр дүнд бий болж буй манлайлал. Манлайлал нь зөвхөн хувь хүний төлөв байдал бус, удирдагчдын хоорондын харилцаа, нийгэмд оршин байх олон үзүүлэлтийг хамарсан цогц ойлголт байдаг (Dalakoura, 2010).

Манай эрдэмтдийн судалгааны аижлтай танилцахад, Манлайллын талаар нэг сэдэвт бүтээл олон улсын эрдэмтэд ихээхэн туурвисан ч манай орны эрдэмтдээс төрийн захиргааны салбарт доктор, В.Өлзийбаяр[98] “Төрийн захиргааны удирдах ажилтны манлайллын талаар”, доктор, А.Хандмаа[99] “Боловсролын салбарын багшийн манлайллыг загварчлалын тухай” бүтээлд тус тус манлайллын талаар салбарын онцлогийг тусган судалсан байна.

Судалгааны боловсруулалт

Энэхүү судалгааны ажлаараа анхдагч судалгааг хийн нийт **79** оролцогчийн өгөгдлийг SPSS 25.0 программаар боловсруулан нэгтгэлээ. Асуумжын найдвартай байдлыг хувьсагч бүрээр нь харьцууллаа.

---

[98]В.Өлзийбаяр, Төрийн захиргааны удирдах ажилтны манлайллын өөрчлөлт, УБ хот, 2010 он

[99]А.Хандмаа, Багшийг манлайллыг загварчлах нь: Их сургуулийн жишээн дээр, УБ хот, 2018 он

Найдвартай байдлын статистик /ур чадвар/

Cronbach's Alpha	N of Items
.847	5

Найдвартай байдлын статистик /харилцаа/

Cronbach's Alpha	N of Items
.907	5

Найдвартай байдлын статистик /мэдлэг/

Cronbach's Alpha	N of Items
.919	5

Найдвартай байдлын статистик /манлайлал/

Cronbach's Alpha	N of Items
.922	5

Судалгааны асуумж бүрийн нэг бүрчлэн харьцуулан судлахад, ур чадвар 0.847, харилцаа 0.907, мэдлэг 0.919, манлайлал 0.922 тус тус 0.7 -оос өндөр гарч манай судалгааны ажлын найдаврtай байдал батлагдлаа.

Хувьсагч бүрийн Кронбах альфа утга өссөн үзүүлэлттэй байгаа нь энэхүү судалгааны өгөгдлийн далд хувьсагч бүрийн утга хэрхэн өссөнг дараах графикаар дүрсэллээ.

График 1. Манлайллыг тодорхойлогч хүчин зүйлийн найдвартай байдлын утга



Дүгнэлт:

Судалгааны ажлаараа, манлайлал, ур чадвар, харилцаа, мэдлэг хувьсагчдыг тус бүрт нь 5 далд хувьсагчаар илэрхийлэн асуумжаар судалгааг авсан. Судалгааны далд хувьсагчдын хамгийн бага утга 1, хамгийн их туга 5 үнэлгээг судалгаанд оролцогчид өгсөн.

Судалгаанд оролцогчдын хувьд хамгийн өндөр үнэлгээг дараах асуумжид өгсөн байсан. Үүнд:

- Техникийн ур чадвар
- Гадаад хэлний ур чадвар
- Богино хугацаанд эзэмших мэдлэг
- Гадаадад мэдлэг эзэмших
- Багийн үйл аижллагаагаар манлайлах
- Хувь хүний хандлагад төвлөрөн шийдвэр гаргах
- Ажилчдын санал асуулгаг тогтмол авах зэрэг асуултад хамгийн өндөр оноог өгсөн байна.

Энэхүү судалгаа нь дараа дараагийн судалгааны ажилд харьцуулалт хийж болох суурь ойлголтыг бататгасан нь ач холбогдолтой байлаа. Богино хугацаанд суурь судалгаа болгон авсан тул зарим нарийн тооцоолол, шинжилгээг цаашид дэлгэрэнгүй хийх шаардлагатай гэж дүгнэж байна.

Судалгааны ажлын үр дүнгээс, манлайлалд ур чадвар, мэдлэг, харилцаа хандлагыг хувьсагч болгон таамаглал дэвшүүлж судлах боломж байна гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

Монгол хэл дээр ашигласан материал

1. Г. Гантөгс “Хүний нөөцийн менежмент” 2014, УБ хот,
2. Т.Гэрэлхүү, “Менежмент” гарын авлага, 2014, УБ хот,
3. Н. Оюунжаргал “Хүний нөөцийн менежмент” сурах бичиг 2013 он, УБ хот,
4. Б. Мөнхжаргал, Б. Амаржаргал “Менежмент” 2013 он, УБ хот,
5. Ө. Өлзийбалсан “Хүний нөөцийн удирдлага” 2014 он, УБ хот,
6. П. Увш, Б. Хэрлэн “Байгууллагын зан үйл” 2004он, УБ хот,
7. Ларри Стаут “Хүний нөөцийн удирдлага” орчуулсан С. Дабааням, С. Дулмаа 2009 он, УБ
8. Гуннар Андерссон, Лейф Фисен “Өөрийгөө болоод хамтран зүтгэгч нөхдөө танин мэдэх нь” суралцагч байгууллагыг хөгжүүлэх манлайлал , УБ хот,

Англи хэл дээр ашигласан номын жагсаалт

1. Training Personal Confidence and Motivation, year 2013, chapter 3, p-20
2. Work Motivation History, Theory, Research and Practice, publications, London 2007,
3. Drafke, M. W. & Kossen, S. (2002). The human side of organizations, 8th Edition, pp. 287.
4. Fernandes, F. N. (1998). Total Reward-An Actuarial Perspective. Actuarial Research Paper, No.116.
5. Manmohan Joshi 'Human Resource Management' 2013, p-88
6. C.A Myers, industrialism and Industrail man, Harvard University, press, 1980, p131-5
7. Appeldorn, R. H. Technology Transfer in a Diversified, Global Manufacturing Company. 2008.
8. "CYBER SOLUTIONS HANDBOOK" Making Sense of Standards and Framework, 2014

Орос хэл дээр ашигласан номын жагсаалт

1. Воробьев С. Люди кончаются вообще / Коммерсантъ Деньги, №30 (837), 01.08.2011
2. Шевцова И.Л. Инструменты повышения эффективности бизнеса. – Москва, 2008

Интернет эх үүсвэр

1. http://www.allbusinessschools.com/business-careers/human-resources/salary/
2. http://www.inc.com/encyclopedia/human-resource-management.html
3. http://www.journals.elsevier.com/human-resource-management-review/
4. http://www.boozallen.com/content/dam/boozallen/documents/2014/10/vehicle-cyber- security-viewpoint.pdf
5. http://www.slideshare.net/CharlesCotter/strategic-total-rewards-management-remuneration- and-rewards-summit-11-june-2014

ХУВЬ ХҮНИЙ МАНЛАЙЛАЛ

Б.Ариунболд
ДХИС-ийн Удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, дэд хурандаа

Оршил:

Уг сэдвээр 2017 онд Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн Н.Нарангэрэл судалгааны ажил хийж байжээ. Тэрээр хөгжил гэж шинэ хариуцлага, ахиц дэвшлийн төлөө хүмүүсийн мэдлэг ур чадварыг сайжруулах, төгс төгөлдөр болгох, үр ашиг, үр дүнг нь дээшлүүлэх үйл явц, үйл ажиллагаа юм гэж үзсэн байна. Мөн бие хүн хувь хүний ялгаа онцлогийг гарган ирж авч үзжээ. Бие хүн гэж ухамсартай, хэл яриатай, байгаль орчныг танин мэдэж, түүнийг идэвхитэй хувьсган өөрчлөх чадвартай биологийн амьтан юм. Харин хувь хүн гэдэг нь биологийн болон сэтгэлзүйн өвөрмөц онцлог бүхий субъект.

Судалгааны ач холбогдол:

Уг сэдвийн хүрээнд судалгаа хийж онолын мэдлэгийг эзэмшсэнээр зогсолтгүй өөрийгөө хөгжүүлж, хүрээлэлдээ эерэгээр нөлөөлж, тэднийг удирдан зохион байгуулах чадварт суралцах юм. Амжилттай ажиллаж сурч боловсроход манлайлал, хувь хүний хөгжил хэр чухал болохыг мэдэх нь зайлшгүй юм.

Судалгааны арга:

Судалгааг амжилттай болгохын тулд сурвалжлага хийх, анкет бөглүүлэх, ажиглалт хийх, харьцуулах мөн туршилт хийх зэрэг судалгааны аргуудаас тохиромжтойг сонгон ашигласан болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. Манлайлалын тухай ойлголт

Манлайлал буюу Лидершип гэдгийг “Нийтийн үйл хэргийг биелүүлэхэд хэн нэгэн хүн бусдадаа сайн дураар тусламж дэмжлэг үзүүлэх нийгмийн нөлөөний үйл явц” гэж тодорхойлж болно.

Манлайлал гэдэг нь итгэл үнэмшил, үнэт зүйлс, ёс зүй, зан чанар, мэдлэг, чадвараараа удирдан манлайлж бусдыг зорьсондоо хүрэхэд нөлөөлөх процесс юм.

Манлайлал бол нөлөөлөх чадвар.

Манлайлал гэдэг нь хувь хүн ба бүлэг хүмүүсийг зорилгод нь хүргэх үйл ажиллагаанд өдөөж өгөхийн тулд нөлөөлөх ур чадвар юм.

Манлайлал гэдэг нь хувь хүн тодорхой зорилгод хүрэхийн тулд бусдад нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа юм. Манлайлах үйл ажиллагаа гэдэг нь бизнесийн байгууллагын дотор бол хамгийн дээд удирдлагын тодорхойлсон зорилгыг хэрэгжүүлэхийн тулд менежер өөрийн удирдлагад байгаа хүмүүстээ нөлөөлөх явдал юм.

Манлайлалын үүрэг, ач холбогдол

Манлайлалын дөрвөн үүрэг

-**Үлгэрлэх:** Үзэл баримтлал, эрхэм зорилгоо тууштай хамгаалж, бусдад үг хэл үйл хөдлөлөөрөө үлгэрлэж байх;

-**Чиглүүлэх**: Хүрэх газар, явах замыг зааж өгөх;

-**Бусдыг зоригжуула**х**:** Хүмүүст юмыг үнэн сэтгэлээсээ хийж бүтээх боломж, нөхцөлийг нь бүрдүүлж өгөх;

-**Нэгтгэх**: Харилцан илтгэлцэлийн уур амьсгалыг бий болгож, хамт олноо нэгэн зүгт хөдөлгөх

Ач холбогдол

-Удирдлагын харилцаатай холбоотой

-Бусдад нөлөөлөх чадвар

-Байгууллагын зорилго, зорилтыг хэрэгжүүлэх хүсэл тэмүүлэл төрүүлэх

-УРЛАГ юм

-Удирдуулж буй хүмүүс зорилгодоо хүрэхийг хүсээд зогсохгүй, түүнд хатуу итгэл үнэмшилтэй, шаргуу тэмүүлж байх нь манлайлалын үр дүнгийн гол үзүүлэлт болдог.

-Хүмүүст өмнөө тавьсан зорилго, зорилтоо дээд зэргийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд нь зөвхөн манлайлагч л тусалж чадна

-Манлайлагч хэзээ ч бүлгийн ар талд явдаггүй, харин ямагт урд нь явж, араа дагуулж, замыг нь зааж, урагшлах хөдөлгөөнийг хөнгөвчилж өгөх ёстой.

Манлайлалын онол, хандлагууд

-Дэлхийн 2-р дайны дараа

-1974 Стогдилл судалгаа хийсэн

1.Генетикийн онол

2.Шинж чанарын үүднээс хандах хандлага

3.Зан үйлийн хандлага

4.Нөхцөл байдлын хандлага

Генетикийн онол

-Хамгийн эртний тайлбар

-Манлайлах чадвар генээр л дамждаг. Манлайлагч болж төрдөг болохоос бий болгодоггүй.

-18-19-р зуун

Шинж чанарын үүднээс хандах хандлага

-1945 он хүртэл

-Стогдилл нэгтгээд бие бялдарын шинж, чадавхын 4 шинж, хувийн 16 онцлог шинж, ажилтай холбоотой 6 шинж, нийгмийн 9 чанар гэх мэтийг тодорхойлсон

-Бүгд эдгээрийг эзэмшсэн байдаггүй

-Ухаан эрдэм билэг итгэл даах чанар хариуцлага нийгмийн идэвхи зэрэг нь өөр

-Удирдагчаас хүссэн хүсээгүй гардаг ийм шинжүүд манлайлагч болгодог уу?

-Хэтэрхий олон манлайлалын төрх, төрхийн шинжийн зөрсөн байдал

-Шинжийг сурч эзэмшдэггүй

Зан үйлийн хандлага

-Суралцдаг гэдэгт анхаарсан

-Хамгийн сайн удирдах арга барилыг тодорхойлохыг хичээсэн

-Ажил үүрэг дээр бус ажилчид, хувь хүн дээр төвлөрдөг

Нөхцөл байдлын хандлага

-Хүмүүс сонирхолдоо хөтлөгддөг

-Урлагийн хэмжээнд хүрсэн ойлголт

-Өөрчлөлтийг авчирсан

Б.Р.Леикертийн дөрөвтийн систем

-Менежментийн тор

-Э.Фидлерийн онол

-Зорилгын онол

Б.Р.Леикертийн дөрөвтийн систем:

-Систем 1	Мөлжигч-захирангуй
-Систем 2	Аядуу-захирангуй
-Систем 3	Зөвлөлдөх-ардчилсан
-Систем 4	Оролцуулах-ардчилсан

Менежментийн тор

-Р.Блейк Д.Мутон

-Арга барилын 5 хэв маяг

-Хүмүүсийн төлөө санаа тавих-Үйлдвэрийн төлөө санаа тавих

-1-9 хүртэл

-1:9 5:5 9:1 9:9 1:1

Э.Фидлерийн онол

-Нөхцөл байдлын хувьсагчдыг бий болгосон

-Эдгээр хувьсагчыг тодорхойлсон тохиолдолд арга барилыг зөвлөн гаргаж болно

-Хяналтгүй бол эрх мэдэлгүй

-Эрх мэдэл

-Дээд доод тушаалтны харилцаа

-Зорилтын бүтэц

Зорилгын онол

Манлайлагчын зан үйл нь ажилчид сонирхолтой болох эсэхэд нөлөөлнө.

1. Хэрэглээний зан үйл
2. Дэмжих зан үйл
3. Оролцуулах зан үйл
4. Ажилтанд чиглэсэн зан үйл

-Ажлыг гүйцэтгэх итгэлтэй байх

-Зохицсон урамшуулалтай байх

-Урамшуулал нь хувь хүнд хэрэгтэй байх

Манлайлагч гэж хэн бэ?

-Хот, суурин, жижиг сум, баг хаана ч манлайлагч байдаг

-Дагалдаж буй хүмүүс нь том зорилгод хүрэх хүсэл эрмэлзэлтэй байдаг

-Бусдын хараагүйг түрүүлж хардаг

-Хамгийн нөлөө бүхий хүмүүс

Манлайлагч гэдэг бол нэг үгээр дагалдагчтай хэн нэгэн юм. Манлайлагч нь сайн зохион байгуулалтын төлөө дагалдагчдынхаа хүсэл сонирхолд нийцүүлж урам өгч, зоригжуулдаг хүн юм.

Сайн манлайлагч байснаар:

-Дагалдагчид илүү бүтээлч, санаачлагатай болдог

-Дагалдагчид илүү хувийн амбиц, зорилгынхоо төлөө явдаг

-Маш их итгэл найдвар, урам зоригийг бий болгодог

Хэрвээ чи бусдыг зоригжуулж, мөрөөдүүлж, сургаж, хийлгүүлж чадаж байвал чи бол манлайлагч.

Манлайлагчдын шинжүүд:

-Хувийн анхаарал халамж

-Урам зориг

-Хүчтэй нөлөөлөл

-Оюун ухааны сэрэл

Хувийн анхаарал халамж:

Ажилтан тус бүр дээр анхаарал халамж тавин, өөрийн гэсэн зөвлөгөө заавар өгөх;

Урам зориг:

Итгэл найдварыг төрүүлж хүчин чармайлтыг бий болгон зорилгыг ойлгомжтой тайлбарлах;

Хүчтэй нөлөөлөл:

Зорилго зорилтыг бий болгож, хүмүүст хүчтэй нөлөөлөн бахархал, нэр хүнд итгэлийг ихэсгэдэг.

Оюун ухааны сэрэл:

Мэдлэг боловсрол, оновчтой байдал, асуудлыг шийдвэрлэх байдлыг бий болгох;

Манлайлагч менежер хоёрын ялгаа:

-Манлайлал бол хаашаа явах чигийг заагч луужин

-Тодорхой ажлыг хэрхэн сайн гүйцэтгэх вэ гэдэг асуудал менежментийн шийдвэрлэх зүйл

-Менежментийн ухааны агуу сэтгэгчдийн нэг Петер Дракерийн тодорхойлсноор “Менежмент гэдэг нь юмыг зөв хийх арга бол манлайлал нь зөв юм хийх тухай ойлголт юм”

-Менежмент гэдэг нь амжилтын шатаар зогсолтгүй үр дүнтэй өгсөх замыг зааж өгдөг бол манлайлал өгсөж байгаа шатыг зөв хананд нь налуулсан байх үүрэгтэй

Удирдагч - Шинэ жанжин шугам, алсын хараа, зорилго, зарчим, үнэт зүйлс, чиглэлийг тодорхойлогч, түүндээ бусдыг зоригжуулан удирддаг хүн

Менежер - Байгууллага, группын хүний болон бусад нөөцийг тогтсон дүрэм, журам, зарчмын дагуу захирдаг, зохицуулдаг хүн

Манлайлагч - Ажил үйлс, үг яриа, үйл хөдлөлөөрөө бусдыг үлгэрлэн манлайлагч хүн

ХОЁРДУГААР БҮЛЭГ. Судалгааны үр дүн

Та манлайлагчын найз байхыг хүсэх үү?

58 хариулт



Амжилттай ажиллахад манлайлал чухал уу?

58 хариулт



Манлайлагч гэж хэн бэ?

58 хариулт



Та манлайлагч мөн үү?
58 хариулт



Манлайлал юу чухал вэ?
58 хариулт



Хэрхэн манлайлагч байх вэ?

Манлайлагчийг хүүхэд наснаас нь хүмүүжүүлэх нь хамгийн зөв. Оксана Селендеева 2015 оны сүүлээр 5-14 насны хүүхдүүдэд зориулсан програмчлалын CODDY (coddyschool.com) сургуулиа үүсгэн байгуулжээ. Энд хүүхдүүдэд тоглох, кодлох, уран бүтээлч төслүүд ба бизнес эрхлэх аргачлалаар чадамжийг нь нээж шийдвэр гаргахад суралцуулдаг.

Оксана нэг жилээс бага хугацааны дотор Москва хотод CODDY сургуулиа нээж Санкт-Петербург, Самара, Казань ба Ростов-на-Дону хотуудад түншүүдтэй болж чаджээ. Москва хотын салбаруудад 250 хүүхэд суралцдаг. Уг сургууль нь үндсэн 3 чиглэлтэй. Programming – код бичихтэй холбоотой бүх сэдэв (сайт, туслах хэрэгсэл ба тоглоом боловсруулах). Creative & Art – зураглаач програмын тусламжтай загвар гаргаж дүрс бичлэг боловсруулах. Хөгжил - загварчилсан сэтгэлгээ, цээжлэх, илтгэх ур чадвар, санхүүгийн боловсрол, тоглоом. Энэ бүхэн дээр нэмээд цахим ертөнцийн аюулгүй байдал ба онлайн хичээлүүд байдаг. Нийтдээ 50 хичээлтэй. Окана ба Coddy сургуулийн тухай бизнес хэвлэлүүд, Buro24/7, Marie Claire зэрэг алдарт сэтгүүлүүд бичиж байжээ.

«Бид бүх олон нийтийн сүлжээг туршиж үзсэний үр дүнд LinkedIn-г сонгосон. Энд яг бидний хүсэж буй хэрэглэгчид төвлөрсөн байдаг. Миний эхний тойрогт 29 961 хүн байгаа. Энэ бол туршлага, боловсрол, сонирхол, гэр бүлийн түвшний хүмүүс. Энэ л хүмүүс яаж хүрэхээ мэдэхгүй байгаа тэр зүйлд хүрэхэд маань тусалдаг. Нэг танил маань надаас сансраас мэндчилгээ дамжуулах сансрын нисэгчийн мэдээллийг олж өгөөч гэж гуйж байсан. Би гайхширч “Тийм зүйл ер нь байдаг юм уу?” гэж асууж билээ. Танил маань: “Бидэнд тийм санаа байгаа юм, чи тусалж чадах уу?” гэж асуусан. Би оролдоод үзье гэж хариулсан».

Оксана LinkedIn дээр нийтлэл бичжээ. Хоёр цагийн дараа түүнд “Роскосмос”-н утасны дугаар, сансарт байгаа нисэгчийн эхнэрийн утас, мөн саяхан нислэгээс ирсэн нисэгчийн утасны мэдээлэл ирсэн байна. Танил нь нисэгчтэй холбогдсон ба сансрын нисэгч ямар ч үнэ төлбөргүй мэндчилгээ явуулсан ба түүнд санал болгосон мөнгийг хүүхдийн асрамжийн газарт хандивлахыг хүсчээ.

«Энэ бол зүгээр нэг санаанаас төрсөн бодит баймааргүй түүх юм. LinkedIn-ий ид шид үүнд байгаа юм. Coddy сургууль ч бас ингэж эхэлж байсан. 2015 оны 12-р сард бид төслөө боловсруулж эхэлсэн. Би хувийн хуудаснаа энэ төслийг сонирхох танил байвал надтай холбогдох хүсэл тавьсан. Одоо бидний байгаа энэ газар буюу Actis Wunderman миний нийтлэлд хариулж билээ. Харин өнөөдөр бид энд уг агентлагийн бидэнд зориулж худалдан авсан компьютер дээр ажиллаж байна. IBS, “KROK”, Glowbyte, “Касперскийн Лаборатор”, Avito, Deloitte ба бусад олон компани бидэнтэй адил аргаар үүсэж байжээ. Энэ бол чөлөөт үзэл бодолтой, хүнд сурталгүй, эрч хүчтэй хүмүүс юм. Тэд зөвхөн энэрэнгүй сэтгэлтэй байгаад зогсохгүй, зөв сэтгэлгээ, ертөнцийг харах зөв үзэл бодолтой, яг л Цахиурт хөндийд байдагтай адил. Та ч бас туршиж үзэхийг хүсэж байна уу? Хамтдаа оролдоод үзье! Алдаа гарвал засаж болно. Амьдралд ч бас ингэж хандах хэрэгтэй.

Oriflame компанийн тухай ярьвал, та нарын хувьд хүн болгон – брэнд юм. Тиймээс маш зөв нэр хүнд үүсгэх хэрэгтэй. Тухайн хүний масс-д оруулах зүйл брэндийнх нь ба өөрийнх нь нэг хэсэг байна. Би танай нэг арга хэмжээнд оролцож байсан. Эхлээд надад жаахан сонин санагдаж байсан ч, арга хэмжээний төгсгөлд би тайзны хажууд зогсчихсон, алгаа ташаад, үсрээд “Ори-флэйм! Ори-флэйм!” гэж

хашгирч байсан. Энэ бол эрч хүч! Энэ бол миний хажууд байсан хүмүүсийн цог хийморь, эрч хүч гэдэгт би итгэлтэй байна! Чин сэтгэлийн, ил тод дотоод хүч. Энэ бол бүх Лидерүүдэд хэрэгтэй зүйл».

10 см урттай хайчилсан цаас төсөөлөөд үзье. 70 хувь нь амьдралын туршлага. Өөрийгөө бүрэн таньж ойлгоогүй нэг ч манлайлагч би хараагүй. Тэд бүгд нээлттэй хүмүүс байдаг. Яагаад гээч? Яагаад гэвэл тэд өөрсдийгөө хэдийнэ ойлгож чадсан. Тэд хүмүүсийг таньж чаддаг. Тэдэнд хаанаас авах уу гэсэн бодол байхгүй, тэд яаж өгөх үү гэж боддог, өөрөөр хэлбэл хүмүүс хооронд харилцан үйлчлэл үүсгэхийг хүсдэг. Үлдсэн 30% - энэ бол ажлын туршлага, хөдөлмөрч зан чанар, суралцах хүсэл эрмэлзэл ба золиос зэрэг үндсэн зүйлс юм. Золиос гаргаж байгаагүй нэг ч кэйс би хараагүй. Золиос гэдэг нь цаг зав, эрүүл мэнд (ид шид байдаггүй шүү дээ) юм. Өглөө 5 цагт сэрээд, ойд гүйгээд, өглөөний цайгаа уугаад, 9 цагт ажилдаа яваад, орой 10 цагт оронд оо ордог, хүүхдүүд тань онц сурдаг, нөхөр тань бүх талаар ойлгож дэмждэг байвал үнэхээр сайхан байна. Харамсалтай нь бодит амьдрал дээр ийм зүйл байдаггүй билээ.

Таны эрч хүч бусад хүмүүст ойлгомжтой байх ёстой. Хүнтэй нүд рүү нь харж ярих, сонсох, яриаг нь таслахгүй байх чадвар маш чухал. Миний одоо ажиллаж байгаа “Сбербанк”-ны нэгэн ахлах-менежер надад: “Оксана, чи үргэлж хүний яриа тасалж ерөөсөө сонсож чадахгүй юм. Намайг уучлаарай, чамайг гомдоох гэж хэлсэнгүй. Гэхдээ миний бодлоор чи үүн дээр анхаарч өөрийгөө өөрчлөх хэрэгтэй байх” гэж хэлж байж билээ. Эхлээд би үүнийг хүлээн зөвшөөрч чадахгүй байсан ч яваандаа бодож эхэлсэн. Нээрээ л тэр хүний зөв юм шиг байна. Энэ байдлыг яаж өөрчлөх вэ? Хүний яриаг таслахгүй сонсох хэцүү байдаг. Хэрвээ тэвчээртэй үргэлжлүүлэн сонсвол та хэрэгтэй мэдээллээ авах болно.

Нэгдүгээрт, хэрвээ та яриаг нь тасалсан бол тэр мэдээллийг хэзээ ч олж авч чадахгүй байх байсан.

Хоёрдугаарт, бүх зүйл маш зөв өрнөдөг. Та тухайн хүнд түр зуур завсарлаж бодох боломжийг олгоно. Тэр өөрийг нь сонсож байгааг мэдэрч бүр ч нээлттэй ярьж эхэлнэ.

Гуравдугаарт, хүн ярих тусам танд шинэ төслийн санаа, шинэ бодол төрөх болно. Тэгэхээр та хоёрын дунд харилцан үйлчлэл

үүсэж байна гэсэн үг. Бага зэрэг тэвчээр гаргаад энэ дадалд суралцаж болно. Амьдрал сайн ба муу дадал зуршлаас бүрддэг. Өөртөө хэр олон сайн дадал бий болгож чадна тэр зэргээр таны амжилт нэмэгдэнэ. Өдөрт хагас цаг ухаантай хүмүүстэй харилцаж байгаарай. Энэ дадал суумагц дараагийнх руу шилжээрэй. Ингэснээр та үргэлж эрэлттэй байж, ямар ч саад бэрхшээл таныг зөв замаас гаргаж чадахгүй»

Гаднаас урамшуулал хүлээж манлайлагч битгий бол. Дотроосоо урамшууллаа авахын төлөө манлайлагч болоорой. Чи өөрөө манлайлах урамтай байж бусдыг урамшуулж чадна.

Мотиваци бол шилдэг манлайлагч байх хамгийн чухал шинжүүдийн нэг юм. Тэрээр бусдынхаа сэтгэл санааг нь идэвхжүүлж, урамшуулж, сэнхрүүлж нийтлэг хүсэл зорилгыг биелүүлэхийн төлөө хөтөлдөг. Гэсэн хэдий ч та манлайлагч нарыг юу идэвхжүүлж байдаг талаар бодож байсан уу? Тэд хаанаас тэр хүсэл тэмүүллээ олдог юм бол?

Бүх манлайлагч нар өөрсдийн гэсэн тодорхой алсын хараатай байдаг. Тэдний дотор хүсэл тэмүүллийн гал шатдаг. Энэ гал нь тэдний шургуу занг хүртэл цэнэглэж байдаг. Алсын хараа, хүсэл тэмүүлэл, шургуу байдал бол манлайлагч байхын гол түлхүүрүүд ажээ.

Манлайлагч нарын мотиваци олон талт эсвэл маш хувиа хичээсэн байж болдог. Эдгээр мотиваци нь ихэвчлэн манлайлагч нарын өөрсдийн хувийн зан чанар, амьдарч буй орчин эсвэл биширдэг хүнээс нь үүдэлтэй байдаг.

Герман улсын улс төрч, Нацист намыг үндэслэн байгуулагч Адольф Гитлер нь хамгийн харгис хэрцгий дарангуйлагч, цэргийн манлайгч гэдгээрээ түүхэнд тэмдэглэгээтэй. Бидний ялгаварлах үзэл суртал болон өлсгөлөн түүнийг ийм манлайлагч болоход хэргэсэн хэмээдэг. Түүний амин хувиа хичээсэн мотиваци нь дэлхийн 2-р дайны суурь байдаг.

Өөр нэгэн эсрэг жишээ гэвэл Махатма Ганди байдаг. Түүний олон талт философи нь нийт Энэтхэгчүүдийг Британийн эсрэг тусгаар тогтнолоо олохын төлөө урамшуулсан. “Өөрчлөхийг хүсэж буй ертөнцийн өөрчлөлт нь өөрөө бай” хэмээх үгэндээ тэрээр өөрөө үнэнч байж, насан туршдаа үгэндээ үнэнч амьдарсан юм. Нийгмийн

сайн сайхан байдал түүнийг ийнхүү манлайлагч болоход хөтөлсөн юм.

Эдгээрээс харахад ямар ч манлайлагчдын төрөлхийн идэвхжүүлэгч нь “зорилго” юм. Эдгээр зорилго нь хүч чадал, хөрөнгө мөнгө, байр суурь, нийгмийн сайн сайхан, харилцаа холбоо, сэтгэл хөдлөл, үүрэг даалгавартай холбоотой. Манлайлагч хүрэхүйц зорилго тодорхойлсон эсэхээс хамааран дагалдагчид дагаж явдаг. Дэлхийн алдартай бизнесийн коуч Др Маршалл Голдсмит /Marshal Goldsmith/ өөрийн хувийн блогтоо маш үнэ цэнэтэй зөвлөгөөг манлайлагчдад хүргэсэн байна:

Мөнгө, байр суурь нь гаднах материаллаг шинж чанар бөгөөд ажилчдын, олон нийтийн сайн сайхан байдал нь дотоод хүмүүнлэгийн шинж чанар юм.

Бизнесийн ертөнцөд байгууллагын манлайлагчийн мотиваци байгууллагын алсын хараатай нийцдэг. Тэрээр өөрийн хүлээн авсан төсөл хөтөлбөрөө амжилттай хэрэгжүүлэхийн тулд бүхий давуу тал, ур чадвар, чадавхиа ашигладаг.

Мөн байгууллагын жинхэнэ манлайлагч багийг байгууллагын зорилготой уялуулах чадвартай байдаг. Үүний тулд гадаад, дотоод мотивациа хоёуланг нь жолоодох хэрэгтэй болно.

Хувь хүний мотиваци бүр нийгмийн, бизнесийн, манлайлагчийн эсэхээс хамаарч нэгээс нөгөөд харилцан адилгүй байдаг.

Дүгнэлт:

Сүүлийн хэдэн арван жилд хөгжил дэвшлийн хурдыг даган байгууллагууд үйл ажиллагаа, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийх явцдаа манлайллын үүрэг, ач холбогдлын чухлыг улам бүр ойлгох болжээ. 1999 онд Америкийн Менежментийн холбооноос “Форчун” сэтгүүлийн шилдэг 500 компаний 259 дээд шатны менежерээс судалгаа авахад 92 хувь нь өөрчлөлтийн гол түлхүүр бол манлайлал хэмээсэн нь үүнийг бэлхнээ нотолно.

Мөн орчин цагийн менежментийн онолын нэрт төлөөлөгч П.Дракер 1999 онд “21 дүгээр зууны менежментийн сорилтууд” хэмээх алдартай номоо бичиж өнгөрсөн зууны менежментийн хоцрогдолд ороод буй асуудлыг нэрлэж, улмаар шинэ зууны менежментийн найман хандлагыг тодорхойлсны дотор “Хүмүүсийг

удирдах гэхээс илүү тэдний давуу тал, мэдлэгийг үр бүтээлтэй болгохын тулд манлайлах хэрэгтэй” гэсэн байдаг.

Чингэж манлайллын үүрэг, ач хопбогдол товойн гарч ирсэн нь нэг талаар манлайлал, манлайлагчийн хомсдол үүсээд байгааг харуулж байгаа. Дэлхийн олон оронд нийтлэг байгаа энэхүү асуудлын учир шалтгааныг судлаачид дорх байдлаар тайлбарладаг.

Нэгд, 1980-1990-ээд онд ДЭЛХИЙ НИЙтээр манлайлал гэхээс илүү менежментэд анхаарал хандуулж удирдлагын хөгжил, удирдах ажилтны мэдлэг чадвар, үнэлгээг чухалчилж байв. Харин сүүлийн үед ирээдүйн сорилтыг даван туулахад өнгөрсөн 20-30 жилд бий болгосон менежерүүдийн мэдлэг чадвар хангалтгүй болж иржээ.

Хоёрт, манлайлагчид үеийн үед ховор байдаг, үүний дээр “1970- аад оноос хойш эхэлсэн байгууллагын бүтцийн өөрчлөлт, орон тооны цомхотголоос болж албан тушаалын тогтрлцоо алдагдаж орчин цагаа мэдрэн байгууллагыг манлайлах чадвар бүхий (тэр дундаа өөрчлөх чадвартай) удирдах ажилтны бэлтгэл үе тасалджээ’’[1] (Evans Gunz8 and Jalland;1998). Коммунист хэв маягийн тогтолцооноос ардчилал, зах зээлийн тогтолцоонд шинэ тутам шилжиж байгаа манай мэтийн орнуудад энэхүү учир шалтгаан бүр ч далайцтай үйлчилсэн билээ.

Гуравт, өөрчлөлт шинэчлэлийг манлайлах нь хэцүү тул манлайлах чадвар дутагдаж байв. Манлайллын бүх төрөл дундаас өөрчлөлтийг манлайлах нь хамгийн хэцүү бөгөөд “хувьсган өөрчлөгч манлайлал нь үйл хэргийнхээ төлөө тууштай, шургуу, зоригтой ажиллаж, хувийн ашиг сонирхлыг огоорохыг шаарддаг” болохыг Бернс (1978) тэмдэглэсэн байдаг. Глобал эдийн засгийн энэ орчинд бүх байгууллага тэр дундаа төрийн байгууллагуудын хүрээнд ч өрсөлдөөн нэмэгдэж манлайлагчдын эзэмшсэн байвал зохих ур мэдлэг чадварын түвшин өндөрсөж байна.

Дөрөвт, бүх цаг үед манлайлах хэцүү байсан боловч өнөөгийн манлайлагчид бүр ч олон сорилт, бэрхшээлтэй тулгарч байгаа нь 20 дугаар зууны хоёрдугаар хагаст эрчимтэй хөгжиж эхэлсэн ардчилал, эрх мэдэл хуваарилах зарчимтай холбоотой. Өнөөдөр хэвлэл мэдээлэл, интернетийн нөлөөгөөр манлайлагчдын үйл хөдлөл олон түмний нүдэн дээр ил тод, тэдний байнгын хараа хяналтанд байдаг болсон нь манлайлагчдад тавих шаардлагыг өндөржүүлж байна.

Тиймээс төвлөрөл саарсан, мэдлэгт суурилсан, веб-ээр сүлжилдсэн өнөөгийн нийгэмд өөрчлөлт шинэчлэлийг санаачлан хэрэгжүүлж чадах манлайлагчдыг бэлтгэх, нэгэнт бэлтгэгдсэн менежерүүдээс манлайлагчдыг төрүүлэх шаардлага улам бүр өсөн нэмэгдэж байна.

Орчин үеийн манлайллын онолын хөгжлийн чиг хандлага:

Манлайллын онол 19 дүгээр зууны төгсгөл, 20 дугаар зууны эхэн үеэс эрчимтэй хөгжжээ. “Агуу хүн’’-ий зан чанарын зэрэг эхэн үеийн онолууд нь сайн манлайлагчийн нийтлэг шинж чанар, манлайлагч хүнийг бусдаас ялгаруулдаг зан чанарын тухай эрэл хайгуул хийж байсан бол цаашид манлайллыг удирдлагын арга барилтай холбон авч үздэг зан үйлийн онол, удирдагч нөхцөл байдалдаа тохируулан манлайллын өөр өөр аргыг хэрэглэх тухай нөхцөл байдлын онолын урсгалууд хөгжжээ. Тэднийг залгамжилж буй “шинэ манлайлал”-ын үзэл санааны бүлэгт алсын хараат, харизматик, солилцооны ба өөрчлөгч манлайллын тухай авч үздэг.

Шинэ манлайллын онолуудаас хамгийн нэрд гарсан нь болох солилцооны ба өөрчлөгч[2] манлайллыг анх 1978 онд Америкийн улс төр судлаач Жэймс Мак Грегор Бернс тодорхойлжээ. Цаг үе нь засаглал, удирдлагын өөрчлөлт шинэчлэл эхэлсэн 80-аад он байсан тул удирдагчдад урьд өмнө хэрэглэж байгаагүй шинэ соргог манлайлах арга барил хэрэгтэй болсоноор эдгээр “транс” эхлэлтэй манлайллын онолууд хөгжсөн аж.

Бернс “солилцооны манлайлагч нь ажил гүйцэтгэлийн хариуд шагнал урамшил өгөх буюу шийтгэл оноодог; өөрчлөн манлайлагч нь хүмүүсийн захирагдан дагалдах байдал, итгэл унэмшил, хэрэгцээ, үнэт зүйл дээр суурилан ажил хэрэгт бие, сэтгэлийг нь бүрэн татан оролцуулж чаддаг’’ хэмээн тайлбарлажээ. Өөрчлөгч манлайлал нь үлгэрлэн манлайлах, ажиллагчдынхаа сэтгэлийг бадраан идэвхжүүлэх, сэтгэлгээний өөрчлөлтийг дэмжих, хүн бүрийг анхаарах гэсэн үндсэн дөрвөн агуулгыг (үүнийг өөрчлөгч манлайллын 4 “I” гэдэг) багтаадаг.

Солилцооны болон өөрчлөгч манлайлал нь дэлхий нийтээр түгээмэл хэрэглэгддэг. Харин өөрчлөлт шинэчлэлийн орчин нөхцөлд өөрчлөн манлайлах арга барилын хэрэглээ давамгайлдаг ба Бернсийн онолыг гүнзгийрүүлэн хөгжүүлсэн Б.Басс (2006)

дэлхийн олон оронд авсан судалгаанаас харахад өөрчлөн манлайлагчдын ажлын амжилт нь солилцооны манлайлагчдынхаас ямагт өндөр байдаг хэмээн баталжээ. Тэрээр мөн өөрчлөгч манлайлал нь шилдэг манлайллын тухай хумүүсийн бодол төсөөлөлд илүү ойрхон байдаг тул манлайллын хамгийн үр дүнтэй арга байж болох юм гэдэг.

Солилцооны ба өөрчлөгч манлайллын зэрэгцээ Р.Гринлифын “үйлчлэн манлайлах”[4] (1976), П.Блокын “харж хамгаалж манлайлах’’ (1993) нь өнөө үеийн манлайлал, удирдах арга барилыг тодорхойлж буй шинэлэг үзэл баримтлалын тоонд орно. “Үйлчлэн манлайлах” үзэл баримтлалаар байгууллагын пирамид нэг ёсондоо уруугаа харж, манлайлагч нь пирамидын суурь, дунд хэсэгт байгаа захирагдагчдынхаа төлөө ажилладаг гэсэн шинэ парадигм үүслээ. Энэ санааг П.Блок үргэлжлүүлж 1993 онд “харж хамгаалж манлайлах” тухай үзэл баримтлалаа дэвшүүлсэн ба өөрийн байгууллага, нэгжийн хүний ба бусад нөөцийг үнэн сэтгэлээс ариг гамтай, хариуцлагатай удирдан зохицуулахад энэхүү манлайллын утга учир оршино.

Мөн 1995 онд Ж.Каузис, Б.Познер нар “манлайлал бол хүн бүрийн үйлс” хэмээжээ. Энэхүү манлайлал зөвхөн удирдах ажилтнуудад хамаатай ойлголт бус бүх түвшинд байдаг хэмээх үзэл нь нэлээд алсын үр дагавартай, манлайллыг өөр өнцгөөс харж, шинэлэг байдлаар хэрэгжүүлэх практикийн эхлэл байж болох юм.

Манлайлагчийн ур чадварт тавигдаж буй шаардлагын талаар:

Манлайллын парадигмын өөрчлөлт нь манлайлагчийн ур чадварт тавигдах шаардлагыг өөрчилж байна.

Манлайлагчдын шийдвэрийн хамрах хүрээ, нөлөө орон нутгийн түвшнээс хальж глобал түвшинтэй уялдах болсон тул илүү өргөн хүрээнд, холч сэтгэн байгууллагынхаа үйл ажиллагааг гадаад орчны өөрчлөлтөд зохицуулах алхмуудыг үе шаттай хийх хэрэгтэй байгаа.

Үндэсний удирдах ажилтнуудын манлайлах ур чадварын асуудлыг хөндөхүй

Монгол улс ардчиллын замаар замнаж, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжээд хориод жилийн нүүр үзэж байна. Энэ хугацаанд төрийн, төрийн бус хэвшил төлөвшихийн сацуу манай үндэсний менежерүүдийн шинэ үе төрөн гарсан юм. Төвлөрсөн

тогтолцоот үеийнхтэй огт адилгүй чөлөөт зах зээлийн өрсөлдөөнт орчин нөхцөлд дасан зохицож ажиллахын тулд удирдах ажилтнууд мэдлэг, ур чадварын олон сорилтыг амжилттай даван туулсан билээ. Гэхдээ зах зээлийн нийгэм гэдэг байнгын өрсөлдөөний талбар тул шинэ зуун гарсаар Монголын удирдах ажилтнууд ур чадварын олон шинэ сорилттой тулгараад буйн нэг нь манлайлал юм.

Төр засгийн хэмжээнд манлайллын тухай үзэл санаа нь Монгол Улсын Засгийн газрын 1999 оны 96-р тогтоол, 2004 онд батлагдсан “Монгол Улсын Төрийн албаны шинэтгэлийн дунд хугацааны стратеги” зэрэг бодлого, стратегийн олон баримт бичигт тусгалаа олсон.

Манлайллын хөгжилд зарим ахиц дэвшил байгаа боловч төрийн албаны удирдах албан тушаалтнуудыг бүхэлд нь хамарч чадахгүй байгаа, манлайллын зарим ур чадвар олгож байгаа боловч чадавхийг бүхэлд нь сайжруулахгүй байгааг цөөнгүй судалгаа харуулдаг. Энэ нь зөвхөн ард иргэд, иргэний нийгмийн байгууллагууд зэрэг үйлчлүүлэгч талууд төдийгүй төрийн албан хаагчдын удирдах ажилтнаа үнэлсэн үнэлгээнээс харагдаж байгаа юм. Тухайлбал, 2006 онд Удирдлагын Академийн судлаачдын багаас авсан төрийн албан хаагчийн мотивацийн тухай судалгаанд “төрийн албан хаагчид бүхэлдээ удирдах ажилтнуудынхаа мэдлэг боловсрол, зохион байгуулах ур чадвар, ажлын арга барилд шүүмжлэлтэй хандсан’’байв.

Гэхдээ манай улсын төрийн албаны өөрчлөлт шинэчлэлийн хүрээнд удирдах ажилтны манлайллыг дээшлүүлэхийн тулд тэдний мэдлэг чадварт тавих шаардлагыг шинэчлэн тодорхойлох, сонгон шалгаруулах үйл явцыг боловсронгуй болгох, ур чадварыг хөгжүүлэх талаар тодорхой алхмууд хийгдсээр байна. Үүний нэг илрэл нь Засгийн газраас бүх албан тушаалд сонгон шалгаруулах, хөгжүүлэх үйл явцыг дэмжих зорилготой ерөнхий мэдлэг чадвар буюу манлайллын хүрээг тодорхойлсон явдал юм. Үүнд:

- Алсын хараа боловсруулах, хуваалцах
- Итгэл үнэмшлийг хөхиүлэн дэмжиж, баталгаатай хангах
- Өөрчлөлтийг санаачлах, удирдах
- Хамтран ажиллагчид, бусад ажилтнуудынхаа урам зоригийг сэргээх, тэдэнд үнэнч байгаагаа харуулах
- Ажлын өндөр үзүүлэлттэй баг бүрдүүлэх

- Эрсдлийг ухамсарлан мэдрэх, шийдэмгий ажиллах
- Багийн ажиллагааны төлөө хариуцлага хүлээх
- Ажилдаа үнэнч, шудрага, чин сэтгэлээсээ хандах өндөр стандартыг харуулах” зэрэг багтжээ.

Дээрх төрийн удирдах албан тушаалтны манлайлал буюу мэдлэг чадварын хүрээнээс харахад өмнө дурьдсан хөгжингүй орнуудад тавигддаг шаардлагатай нэлээд ойролцоо байгаа нь манлайллыг хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, хандлага зөв гольдрилдоо орж буйн илрэл гэж үзэж байна.

Бизнесийн менежерүүд, тэдний мэдлэг чадварт тавигдаж буй шаардлага өөр улс орнуудтай харьцуулахад хэр ялгаатай байгааг харуулахын тулд Шведын судлаач Ингрид Толгерт-Андерсон нарын шинжилгээн дээр суурилан хийсэн харьцуулалтынхаа үр дүнг та бүхэнд толилуулъя.

Тэд 1996 онд өөрийн орны компаниудын удирдах ажилтан авах тухай олон арван зарлалыг шинжилж, үүндээ хожим Швед, Дани, Норвеги, Герман, Их Британи, Франц, Итали, Испани зэрэг Европын Холбооны өөр улсуудыг хамруулж аль улсад удирдах ажилтнаас ямар ур чадвар түлхүү шаарддаг болохыг харуулсан нь (Хүснэгт4) судлаач, мэргэжилтнүүдийн сонирхлыг ихэд татсан байдаг.

Уг жишээг дагаж манай улсын компаниуд удирдах ажилтнуудаас ямар ур чадвар шаардаж буйг олж харахын тулд үндэсний өдөр тутмын хэвлэлүүд болох “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, “Өдрийн сонин”-д 2007 оны 1-4 дүгээр сард гарсан менежер, удирдах ажилтан авахтухай 142 зарлалыг шинжилж үзсэн юм. Судалгаанд хамрагдсан зарлалуудын дийлэнх нь бизнесийн нэгжүүд, мөн цөөн тооны төрийн байгууллага, олон улсын бизнесийн нэгжүүдийн салбар, бүтээгдэхүүний борлуулагчид байв. Зарлалууд нэлээд говч боловч тухайн компаний удирдах ажилтанд тавих гол шаардлагыг (дунджаар 5-6) илэрхийлж чадаж байв.

Хүснэгт 3-д менежерээр ажиллах хүнд тавигдах шаардлагуудыг давтамжаар нь байр эзлүүлсэн болно. Энд тэмдэглэхэд Толгердт-Андерсон нарын шинжилсэн зарлалуудад ч манай компаниудын зарлалд ч удирдагчийн ур чадвар төдийгүй хувийн зан чанарт тавих шаардлага орсон байгаа.

Бүх зарлалд эхлээд тухайн чиглэлийн сургууль төгссөн буюу мэргэшсэн байхыг, 92 зарлалд тухайн чиглэлээр 2-оос 10 хүртэл жил ажилласан туршлага шаардсан байлаа.

Нийт 37 янзын шаардлага бүртгэгдсэнээс англи буюу өөр гадаад хэл (хятад, япон, солонгос, герман, франц зэрэг)-ний мэдлэг чадвар, компьютерын хэрэглээний программуудыг эзэмшсэн эсэх, харипцааны болон багаар ажиллах чадвар тэргүүлж байна. Үүнээс харвал манайд эхний 10-15 хүртэлх шаардлагын дийлэнхийг хангасан, 35 хүртэлх насны хүнд менежерээр ажиллах боломж байна.

Манай компаниудын удирдах ажилтанд тавьж буй шаардлагыг Толгертд-Андерсон нарын хүснэгтэнд (Хүснэгт 4) нэгтгэн харьцуулахад хамтран ажиллах, бие даах, манлайлах, санаачилга гаргах, харил цааны чадвар, бүтээлч байдлыг Европын компаниудын адил шаарддаг байна. Харин Европын орнуудад нэлээд их шаардагддаг зорилго, үр дүнд чиглэсэн байдал болон бусДыг идэвхжүүлж, өдөөх чадварыг манай компаниуд төдийлөн шаарддаггүй ажээ. Гэхдээ Европын аль ч оронд шаардаагүй гадаад хэлний мэдлэг (110 зарлал), компьютерын ур чадвар (90 зарлал), хувийн зохион байгуулалт болон цагийн менежмент (33 зарлал), бичиг баримт боловсруулах чадвар (21 зарлал), зөвхөн ганц оронд (Испани) шаардсан хариуцлагатай байдлыг (26 зарлал) манай компаниуд чухалчлан үзэж байна.

Энэ нь манай орны удирдах ажилтан авах зарлалд гадаад хэл, компьютер эзэмшсэн байдал зэрэг мэдлэгийн, ажилласан жил, нас зэрэг үндсэн шаардлагын шинжтэй зүйлс эн түрүүнд тавигддагийн илрэл юм.

Өнөөдөр аливаа улс үндэстний нийгэм, эдийн засгийн хөгжил дэвшлийн гарц нь дан ганц технологи, мэдээлэл, бүтээмж бус харин дээд зэргийн удирдлага, зохион байгуулалттай байгууллага гэж үзэх болжээ. Харин байгууллагыг сайн удирдагч л үр дүн, үр ашигтай удирдаж чадах тул удирдах ажилтны манлайллын чадавхийг хөгжүүлж бэхжүүлэх талаар онцгой анхаарч хөрөнгө, хүч зарах хэрэгтэй болжээ.

Төгсгөлд нь өнөөгийн дэлхий дахины манлайллын хөгжлийн чиг хандлага, манлайлагчийн ур чадварт тавигдаж байгаа шаардлагаас үүдэн манай манлайллын сургалт хөгжлийн ажлын

цаашдын агуулга, хэлбэрт анхаарч болохуйц цөөн санааг хуваалцахыг хүслээ.

-Манлайлал нь нэг талт бус захирагч-захирагдагчийн харилцаан дээр суурилсан хоёр талт үйл явц байдаг. Манай байгууллагуудад манлайлагчаа хүлээн зөвшөөрч дагалдах байдал сул, байнгын сайн манлайлагчийн “хүлээлт” ажиглагддаг. Энэ нь манлайллын сургалт хөгжлийн ажилд дан ганц манлайлагчийн хувийн зан үйлийг бус захирагдагчдын “бэлэн байдлыг’’ (Херси ба Бланчар нарын нөхцөл байдлын загварт нэрлэдэгийн адил) нэмэгдүүлэх ур чадварыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэйг харуулж байна. Захирагдагчгүй манлайлагч бол сэлүүргүй завьчин, хүлээн зөвшөөрөгдөөгүй удирдагч бэлэг тэмдэг төдий хүн болж хувирах тул манлайлагчдад төлөөлүүлэн гүйцэтгүүлэх, хамтын үнэт зүйл бий болгох, дэмжиж харилцах зэрэг захирагдагчдаа хүчирхэгжүүлэх бүхий л арга ажиллагааг эзэмшүүлэх хэрэгтэй байна.

-Захиргаадал, ганцаарчлан захирах нь Монголд өмнөх тогтолцооноос уламжлан ирсэн арга барил бөгөөд өнөөдөр ч зарим удирдах ажилтан энэ арга барилтайгаа зууралдсаар байна. Гэтэл шинэ үеийн манлайлагчид багаар ажиллах, багийг удирдах, бусадтай хамтрах өндөр ур чадвар шаардагдаж байгаа тухай өмнө өгүүлсэн. Энэ нь шинэ зууны манлайллын хөгжил хувь хүн дээр бус, бүлэг (баг, байгууллага гэх мэт) төвтэйг харуулж байгаа юм.

-Манлайллын чадавхийг мэдлэг, ур чадвар, хандлагаар тодорхойлдог билээ. Ажиглалтаас харахад манай удирдах ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх өөрийн болон өрөөлийн хүчин чармайлт байдаг боловч хандлагын өөрчлөлт хоцрогдонгуй байдаг. Гэтэл хандлага бол хүний мэдлэг, ур чадвараа зөв ашиглах үндэс тул хандлагыг өөрчлөх асуудлыг нэг талаас манлайллын сургалт хөгжлийн үйл ажиллагаанд, нөгөө талаас манлайлагч хүн өөрийн хувийн хөгжилд түлхүү анхаарах шаардлага байна.

-Төр, хувийн аль ч хэвшлийн манлайллыг хөгжүүлэх үйл ажиллагаанд албан ёсны сургалт (танхимын сургалт голдуу), гадаад танилцах аялал зэрэг тун цөөхөн хэлбэр давамгайлж байгааг анхаарч илүү олон арга хэлбэр ашиглан, олон улсын шилдэг туршлагаас бүтээлчээр суралцвал зохилтой. Үүнд, манлайллын сургалт нь олонд зориулж “бөөндсөн” биш харин тодорхой захиалга,

хэрэгцээнд зориулсан тусгай хөтөлбөрүүд байх, албан ёсны сургалтын агуулгад “үйлдлээс суралцах” зэрэг практик ач холбогдолтой аргуудыг түлхүү оруулах нь чухал. Мөн ажлын байр сэлгэж ажиллах боломж олгох, цалин хөлсийг ур чадварын хөгжилтэй уялдуулан өсгөх, туршилт ба туршлагаас суралцах цаг хугацаа гаргаж өгөх, ажиллагчдын ажлын үнэлгээнд хөгжлийн асуудлыг тодорхой зүйл болгон оруулж өгөх, шилдэг туршлагаас суралцахын тулд зөвхөн гадаад биш дотоодын өөр газар, байгууллагууд руу танилцах аялал хийхийг дэмжих зэрэг олон арга зам байна.

Санал зөвлөмж

Жинхэнэ манлайлагчдын өдөр тутамдаа ашигладаг харилцааны 10 нууц арга барил.

Хэнд юу ярихаа мэд: Сайн харилцагчид нь чухал мэт сонсогдох, мэдлэг чадвараа гайхуулах, өөрийгөө магтахыг гол зорилгоо болгодоггүй. Тэд хүмүүсийн сонсохыг хүссэн, мэддэг зүйлийг нь биш, зайлшгүй мэдэж авах шаардлагатай, ухаарал хайрлах зүйлсийг хэрхэн яаж хүлээн авч байгаа хүндээ хүргэхийг урьтал болгодог. Мөн тэд сонсогчдодоо гашуун үнэнийг өгүүлэхээс хэзээ ч айдаггүй.

Биеийн хэлийг гарамгай унш: Сонсогчдынхоо ямар хариу үйлдэл үзүүлж байгааг сайн харилцагчид гярхай ажиглаж байдаг. Хүмүүсийн дийлэнх нь зөвхөн биеийн хөдөлгөөнөөр хариу үйлдэл үзүүлэх хандлагатай байдгийг тэд мэддэг учир нүүр царайны хувирал, биеийн хөдөлгөөн зэргийг сайн харилцагчид андахгүй олж харж чаддаг. Сайн манлайлагчид энэ чадвараа ашиглан илтгэлээ дундаас нь хувиргаж, харилцах арга барилаа өөрчилж чаддаг.

Үнэнч шударга бай: Сайн манлайлагчид үр бүтээмжтэй харилцааг бий болгохын тулд үнэнч шударга байх нь чухал гэдгийг мэддэг. Эс бөгөөс сонсогчид нь тэдний ярианаас юу үнэн, юу худал болохыг ялгахаар хэлсэн үг бүрээс нь өө хайх гарах эрсдэлтэй. Хэрвээ манлайлагчдад хэлж болохгүй ямар нэгэн мэдээлэл байгаа бол тэд энэ тухайгаа шулуухан хэлээд л тайлбарлачихдаг; учир нь хагас үнэний ортой үг сонсогчдын итгэлийг хөсөрдүүлж, сэтгэлийг тогтворгүйжүүлдэг билээ. Ямар ч нөхцөлд зөвхөн чигч шударга зан л бусдын итгэлийг олж чаддаг гэдгийг санаарай.

Худал дүр бүү эсгэ: Сайн харилцагчид индрийн ард гарч зогслоо гээд өөрөөсөө өөр хэн нэгэн болох гэж оролддоггүй. Марк Зукерберг Фэйсбүүкийг хөрөнгө оруулагчдадаа танилцуулахдаа яагаад юүдэнтэй цамц, жинсэн өмд өссөн гэж бодож байна? Өөрөө өөртөө үнэнч байсан цагт хүмүүс аяндаа тэдний үгэнд татагддаг гэдгийг сайн удирдагчид мэддэг. Харин дүр эсгэж эхэлсэн тэр цаг мөчөөс юмс орвонгоороо эргэдэг гэдгийг манлайлагчид мөн ухамсарладаг.

Хүсч буй зүйлдээ тууштайгаар ярь: Сайн манлайлагчид юу гэх гээд байгаа нь ойлгомжгүй, сул дорой, хэт даруу зангаар өөрсдийн үг яриаг хаацайлах гэж оролддоггүй. Харин ч эсрэгээрээ тэд толгой харц өөдөө бат зогсоод, байгаа үнэнийг байгаа чигээр нь, цаашид яах ёстой шулуун шударгаар хэлж орхидог хүмүүс юм.

Хүн нэг бүрчлэн ярианд оролцож байгаа мэт мэдрэмжийг төрүүл: Удирдагч хүнд хүн болгонтой ганцаарчилсан яриа өрнүүлэх цаг зав байхгүй нь элбэг. Дугуй ширээнд тойрч суугаад хуралдах ч бай, танхимд бужигналдаж байгаа үзэгчид ч бай, сайн удирдагчид танхимыг бүхэлд нь захирч, хүн болгонд түүнтэй шууд харилцаж буй мэт мэдрэмжийг төрүүлж чаддаг.

Бусдыг сонс: Жинхэнэ харилцаа нь хоёр талын идэвх оролцоогоор бий болдог гэдгийг сайн харилцагчид мэддэг ба, өөрөө ярихаас илүүтэйгээр бусдыг сонсох нь илүү чухал байдгийг мэддэг. Сайн харилцагчид хэзээ ч бусдыг ярьж байхад дараа нь юу ярих тухайгаа төлөвлөж сарнидаггүй, харин тэд нөгөө хүнийхээ яриаг чих тавин сонсож, тэр хүний үзэл бодлыг ойлгоход бүх анхаарлаа төвлөрүүлж байдаг.

Алдаа дутагдлаа хүлээхээс ичих хэрэггүй: Сайн удирдагчид алдаа гаргасан бол тэр дор нь хүлээн зөвшөөрдөг. Тэд бусад хүмүүсээр алдаагаа олуулж, чичлүүлэх гэж ч айж хүлээдэггүй. Алдаагаа хялбархан булзааруулж болох байлаа ч гэсэн үг хэл, үйл хөдлөлдөө бүрэн дүүрэн хариуцлага хүлээж чаддаг хүмүүс бол сайн удирдагчид юм. Тэгэх тэгэхдээ худал дүр эсгэж, сүр бадраалгүй ердөө байгаа байдлыг үнэнээр нь өчдөг.

Санал гомдлыг хүлээж авахдаа нээлттэй бай: Сайн харилцагчид хэзээ ч илэрхийлэх гэсэн санаагаа үзэгчдэд алдаа мадаггүй, үнэн зөв хүргэж чадсан гэж сохроор итгэж найддаггүй. Тэд хүлээн авч байгаа хүмүүсээсээ өөрийнх нь санааг зөвөөр ойлгож

авсан эсэхийг лавлаж, хэрэв тэгээгүй бол нөгөө хүмүүсээ буруутгалгүй, өөрсдийн арга барилаа өөрчлөн өөр өнцгөөс оролдож үздэг.

Идэвх санаачлагатай бай: Харилцааны шилдэг ур чадвартай манлайлагч хүн хэзээ ч бусадтай хөл нийлүүлэх гэж цаг алддаггүй. Тэд муу мэдээг тухай бүрд нь мэдэгдэж, цуу яриа дэгдэхээс сэргийлж чаддаг ба дагагчдадаа товч тодорхой, ойлгомжтой зааварчилгаа өгдөг учир хүмүүсийг буруу зүгт чиглүүлж, гаргасан алдаагаа засах гэж цаг алддаггүй.

Сайн харилцагчид үргэлж олны дундаас цойлон гарч ирж чаддаг. Учир нь тэд чигч шударга, үнэнийг баримтлагч бөгөөд бусдыг сонсож чаддаг хүмүүс юм. Тэд үр дүнтэй харилцаа холбооны үнэ цэнийг мэдэж, эрхэмлэдэг учраас л үүндээ тун гаргууд сайн байдаг. Тиймээс та сайн харилцагч болсноор сайн манлайлагч болохын эхний алхмыг амжилттай тавина.

Ашигласан материал:

- Сэтгэлгээний хурдтай бизнес Билл Гейтс 2009 он
- 30 дэлхийг захирч буй эрхмүүд
- Өлзийбаяр. В., Төрийн албаны манлайллын өөрчлөлт, Улаанбаатар, 2009 он
- Burns, J. Mc. Leadership (1st ed.). New-York: Harper Colophon, 1978
- “Attitudes, Values and Demands on Leadership-A Cultural Compariso among Some European Countries” in Managing across Cultures, ed. Pat Joynt and Malcolm Warner, London: International Thomson Bus ness Press, 1999

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГОД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ШИНЖИЛГЭЭ

С.Пүрэв-Очир
ДХИС-ийн Удирдлагын академийн
суралцагч, магистрант, хошууч

Хураангуй: Хүний нөөцийн бодлогод нөлөөлөх нөлөөллийн судалгаанд оролцогчдын өгөгдөлд боловсруулалт хийж шинжлэн, SMART PLS-3.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийх замаар судлахыг зорилго болгон дэвшүүлсэн болно.

Түлхүүр үгс: Хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн бүрдүүлэлт, байгууллагын хэв маяг, ажлын гүйцэтгэл, сургалт, хөгжил, шагнал урамшуулал.

Оршил

Хүний нөөцийн бодлогод нөлөөлөх хүчин зүйлсийн шинжилгээнд нөлөөлөх хүчин зүйлийн харилцан хамаарал, уялдааг онол, практик талаас нь судлаж, өнөөгийн байдлыг тодорхойлоход оршиж байна.

Хүний нөөцийн бодлого нь хүний нөөцийн бүрдүүлэлт, байгууллагын хэв маяг, ажлын гүйцэтгэлт, сургалт хөгжил, шагнал урамшуулал гэсэн хувьсагчаар хөндөн таамаглал дэвшүүлж судалсан. Судалгааны үр дүнгээс харахад дэвшүүлэн таамагласан нийт зургаан таамаглалаас зургаан таамаглал батлагдаж, харин замын шинжилгээний үр дүнгээс харахад таван таамаглал батлагдаж, дөрвөн таамаглал батлагдаагүй. Судалгааны асуумжид тусгагдсан зарим далд хувьсагчийг илүү дэлгэрэнгүй судлах, зарим хувьсагчийн утга агуулгыг тусгай ангийн онцлогтой нийцүүлэн хувиргах, хооронд нь харьцуулан үр дүнг нэгтгэх зэргийг дараа дараагийн судалгааны ажлаараа судлах шаардлагатай болох нь харагдаж байна.

Нэг. Хүний нөөцийн бодлогын тухай ойлголт, онолын үндэс.

Хүн гэдэг ойлголт нь байгууллага дахь чадварлаг ажиллах хүчийг хэлнэ.Нөөц гэдэг нь хязгаарлагдмал хүртээмжтэй эсвэл хомс байдлыг хэлнэ. Хүний нөөц гэдэг нь Англи хэлээр "Human

resource" орос хэлээр "Человеческий ресурсы", герман хэлний “personalwesen”, франц хэлний “resource humaine”, испани хэлний “recursos humanos” зэрэг үгсээр "Хүний нөөц"-ийн утгыг илэрхийлдэг.

Хүний нөөц нь ирээдүйд байгууллага, нийгмийн хөгжилд ганцаараа эсхүл багаараа бөрсөлдөх давуу тал, үнэ цэнийг бий болгох, өөрөө хөгжиж боловсронгуй болох чадвартай, мэдлэг, ур чадварыг агуулагч, биет бус, баялаг-хөрөнгө” юм.[100]

Хүний нөөц бол бусад нөөцүүдтэй харьцуулахад хамгийн шавхагдашгүй, арвин баялаг юм. Учир нь хэрвээ хүмүүсийг зөв удирдаж, хүмүүжүүлж чадвал тэд ур ашигтай хөдөлмөрлөхийн зэрэгцээ хөгжихийн хэрээр сэтгэж шинийг эрэлхийлэх бүтээлч сэтгэлгээтэй болдог[101].Хүний нөөц гэдэг ойлголтыг хэрхэн тодорхойлж тайлбарласныг дурьдвал:”Хүний нөөц бол бусад нөөцүүдтэй харьцуулахад хамгийн шавхагдашгүй, арвин баялаг юм.Учир нь хэрвээ хүмүүсийг зөв удирдаж чадвал тэдгээр хүмүүс үр ашигтай хөдөлмөрлөхийн зэрэгцээ өөрсдийгөө хөгжүүлж тэр хэмжээгээрээ сэтгэж, шинийг илэрхийлж бүтээлч сэтгэлгээг бий болгодог баялаг юм.[102]

Менежмент: байгууллагын зорилго, зорилтод хүрэхийн тулд ийм хязгаарлагдмал эсвэл хомс нөөцийг хэрхэн оновчтой, оновчтой ашиглахыг хэлнэ[103].

Хүний нөөцийн бодлого. Human resource policy Хүн хүчний чадавхийг хадгалах, бэхжүүлэх, хөгжүүлэх, цаг үеийн өөрчлөлтөд хариу өгөх чадвартай, мэргэшсэн бүтээлч хамт олныг бий болгоход чиглэгдсэн баримтлах зарчим, хэрэгжүүлэх арга, зохион байгуулалт юм.

Хүний нөөцийн бодлого нь ажилд авах, ажлын явц, нөхөн олговор, чөлөө олгох, сургах, дэвшүүлэх, ажлын орчин, ажлаас халах болон бусад чухал чиг үүргүүдийг хэрэгжүүлдэг үйл явц юм.

Хүний нөөцийн бодлого нь мэдлэг, чадвар, дадлага, туршлагаас шалтгаалан хэнээр, ямар ажил хийлгэж, ямар үр дүн хүрэх, хүнээ хэрхэн хөгжүүлж үр ашиг, үр өгөөжөө яаж нэмэгдүүлэхээ

---

[100] Бурмаа Н.ба бусад: Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь-Уб 2020 он 167 дахь тал

[101] Цэцэгмаа Ц. 2018, Хүний нөөцийн менежмент-Уб.,16 дахь тал

[102] Адам Смит “Үндэсний баялаг, түүний эх сурвалж” 1976

[103] www.whatishumanresource.com/human-resource-management

тооцож, хүний нөөцөө зөв хуваарилах, байршуулах, тэднийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь хангах олон талт ажиллагаа юм.[104]

Хүний нөөцийн хөгжлийн үндэс нь (Их Британиас үүсэлтэй гэж үздэг) хүний нөөцийн удирдлага, удирдлагын арга барилтай салшгүй холбоотой.Англи хэлээр бичигдсэн ном, сурах бичгүүдийн хувьд хүний нөөцийн дадлага, бодлого, систем, шийдвэр, үйл ажиллагаа, хүний оролцоо, хүний нөөцийн архитектур, хүний нөөцийн хөтөлбөр, хүний нөөцийн стратеги зэрэг үг хэллэгүүд нэлээд хэрэглэгддэг байна[105].

Судалгааны ажилдаа дээрх хүний нөөцийн бодлогын тухай ойлголт, судалгааны ажлуудын үр дүнг дэмжин, хүний нөөцийн бодлогод ажлын гүйцэтгэлт, байгууллагын хэв маяг, хүний нөөцийн бүрдүүлэлт, шагнал урамшуулал, нийгмийн баталгаа хэрхэн нөлөөлөх хамаарлыг таамаглал дэвшүүлэн судаллаа.

Ажлын гүйцэтгэл: Америкийн зохиолч, хэвлэн нийтлэгч, Америкийн уран зохиолын "алтан үе"-ийн эцэг Жон П.Кэмпбелл ажлын гүйцэтгэлийг байгууллагын үр дүн, амжилтанд хүрэх чухал шалгуур юм. Мөн тухайн хүний стандарт хугацааны туршид гүйцэтгэсэн зан үйлийн салангид хэсгүүдийн зохион байгуулалтад хүлээгдэж буй нийт үнэ эцэнэ, үр дүн гэж тодорхойлжээ.

Гүйцэтгэлийн удирдлага зорилгоос эхэлнэ, зорилго бол бидний тэмүүлж буй үр дүн бөгөөд төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал, ажилтны хөгжил зэрэг бүхний үндэс юм. Зорилго байхгүй бол ажилтнууд байгууллагын амжилтад онц нөлөөгүй дэмий ажлуудад цагаа зориулж, хүч нөөцөө тарамдана.[106]

Гүйцэтгэлийн менежментийн ойлголтыг дараах хоёр онол дээр тулгуурлан хөгждөг гэж үзсэн. Salaman (2005) үүнд:

- Шударга байдлын онол;
- Хүлээлтийн онол;

Шударга байдлын онол ба Гүйцэтгэлийн удирдлага: байгууллагын шударга байдлын гэдгээр нь мэддэг шиг шударга ёсны онол нь байгууллагын гүйцэтгэлийн менежментийн тогтолцоо, ажилчдын үнэлгээний ойлголтыг тайлбарладаг. Гүйцэтгэл нь ажлын

---

[104] Даш П.Улсын хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндэстэй удирдъя Уб., 2002 9 дэх тал

[105] Бурмаа Н. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага-Уб., 2022. 15 дахь тал

[106] Гүйцэтгэлийн удирдлага-УБ., 2015. 2 дахь тал

зан төлөв ба хандлагад нөлөөлж чаддаг. Эдгээр зан төлвүүд нь байгууллагын амжилт ба ажлын гүйцэтгэлд эергээр ба сөрөг байж болно (Baldwin, и.d.).

Байгууллагын хэв маяг: О.С. Виханский, А.И.Наумов нар эдхократи гэдэг удирдлагын хэв маяг, зохион байгуулалтын дизайн гэж үзсэн байдаг.[107]

Хүний нөөцийн бүрдүүлэлт: Хүний нөөцийн бүрдүүлэлтийн гол зорилго нь байгууллагын эрхэм зориого, зорилтууд болон хөдөлмөрийн нөхцөл байдал, ажлын байранд, мэргэжил, ёс суртахуунд тавигдах шаардлага, удирдлагын систем зэргийг харгалзан, ажилд орох чин хүсэл эрмэлзэлтэй хүмүүсийг шалгаруулан цуглуулахад оршино.Аливаа байгууллагын оршин тогтнох, амжилттай ажиллах нь хүний нөөцийг хэр зэрэг зөв бүрдүүлж, удирдахаас шалтгаална.

Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулах үйл ажилалагааг амжилттай явуулахын тулд байгууллагын удирдлагууд алба хаагчдын мэргэжлийн чадварт тодорхой шаардлага тавих хэрэгтэй гэж үзсэн.Мэргэжлийн чадамжид тавигдах нэгдсэн шаардлагыг нэвтрүүлсэнээр алба хаагчдыг сонгох, томиллоход бодит байдал, ил тод байдал, тэгш, хүртээмж, шударга ёсны зарчмуудыг бэхжүүлэх боломж гардаг.Эхлээд чадамжийн тухай ойлголтыг тодорхойлох хэрэгтэй. Милев (Milev) “Чадамж” гэдэг тухайн хүн эсвэл байгууллага үр дүнтэй ажиллах боломжийг олгодог мэдлэг, чадвар, хүсэл, ур чадварын кластер “гэж тодорхойлсон.

Шагнал урамшуулалт:

Цалин гэдэг нь нэр томъёог байгууллагаас төлж буй шанд холбогдуулан хэрэглэдэг. Цалин гүйцэтгэсэн ажил болон үзүүлсэн үйлчилгээнийх нь төлөө, бас бүтээмжээ хүссэн хэмжээндээ хүргэхүйц урам зориг төрүүлэхийн тулд ажилчдад өгөх ёстой гэж эрдэмтэн Венделл Л.Френч цохон хэлсэн байдаг.

Түүнчлэн ажил хийдүүлэх болон боловсон хүчний тогтворжилт суурьшил нь урамшуулал, шан харамжтай шууд холбоотой байдгийг Эдуард Е.Лаулер болон Жон Минер зэрэг эрдэмтэд судлан нотолсон байдаг.[108]

---

[107] Реньш, М.(2009).Организационная психология: Учебное пособие. Екатеринбург: Изд-во ГОУ ВПО “Рос.гос.проф.-пен, ун-т”

[108] Дорж Т. Менежмент-Уб., 2018. 312 дахь тал

Ажилчдад үзүүлдэг нэмэлт хөнгөлөлтийн тухайд ер нь ажилчид, алба хаагчдынхаа олонх нь уян хатан хөтөлбөртэйгээр түүнийг хэрэгжүүлж байх нь зүйтэй гэж үздэгийг Альберт С.Шалтчтемер, Роберт Б.Боат нар судлан тогтоосон.

Дэвид Пакард хүмүүсийг урамшуулах, дэмжин хөгжүүлэхэд 5 зарчим баримталдаг байсан.Үүнд:

-Хувь хүнд байгууллага нэг бол сайнаар, эсвэл муугаар нөлөөлөх нь;

-Хүндхэн үүрэг даалгавар оноох, өндөр хариуцлага хүлээлгэх

-Сайн талуудаа гаргах;

-Ажын байр ба дарга;

-Амжилт ба өсөлт хөгжлийг дүгнэх зэрэг дээр дурдсан эдгээр зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх хэрэгтэй гэдгийг олон жилийн өмнөөс батлагдсан хэдий ч байгууллагууд тэр бүр бүгдийг нь нэгэн дор, шаардлагтай түвшинд хэрэгжүүлдэггүй. Удирдлага бүрийн хийх ёстой үүрэг даалгаврыг нэг бол хүмүүсийг дэмжих, хөгжүүлэх, бөгөөд энэ ажлыг системтэй хөгжүүлэх явдал юм.[109]

Нийгмийн баталгаа:Нийгмийн баталгаа гэдэг нь алба хаагчид ар гэр, ахуйдаа ямар нэгэн санаа зовох зүйлгүй байх нөхцлийг бүрдүүлсэн байхийг хэлэх бөгөөд маш өргөн цар хүрээтэй сэдэв тул доорх байдлаар нийгмийн баталгааг ангилан үзсэн. Үүнд:

1.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ;

2.Цалин хөлс, нэмэгдэл;

3.Орон байрны нөхцөл;

4.Ажиллах орчин нөхцөл, албан тушаалын чиг үүрэг;

5.Албан томилолт, нөхөн төлбөр ;

6.Амралт, чөлөө олгох үр ашигтай зохицуулалтууд;

7.Алба хаагчийг мэргэшүүлэх болон бусад сургалт дамжаа;

8.Бусад нийгмийн хэрэгцээ, сэтгэл зүйн байдлыг судлах гэх мэт зүйлсийг багтааж ойлгож болно.

Төрийн алба, төрийн алба хаагчдын талаар баримтлах улс орнуудын бодлого ялгаатай хэдий ч төрийн албаны шинэтгэлийн хүрээнд өндөр ур чадвар бүхий мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэн, алба хаагчдын тогтвортой, идэвх санаачлагатай ажиллах нөхцөлийг

[109] Франк Арнолд. Менежмент шилдгүүдээс суралцъя-Уб., 2017. 267 дахь тал

бүрдүүлэхэд чиглэгдэнэ.Төрийн алба хаачдын цалин дийлэнх улс орнууд нийт төсвийн 70-аас дэээшгүй хувийг учир цалин хөлсний талаар баримтлах бодлого нэн чухал байдаг.[110]

Тусгай үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, үр дүн, чанарыг сайжруулахад үүрэг гүйцэтгэх нөхцөлд тохирсон цалин хөлсний талаарх цогц бодлого нь алба хаагчдын гүйцэтгэлд суурилсан цалин, нөхөн олговор, урамшууллын систгтемийг багтаадаг.Тухайлбал: Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын төрийн алба хаагчийн баталгааны бодлогын хүрээнд тогтвортой ажлын байраар хангагдах, ээлжийн амралт, сургалтын чөлөө, бүтээлийн авах, ажлын байран дахь шаардлагатай ур чадварыг нэмэгдүүлэх сургаралтад хамрагдах, нөхөн төлбөр, хуульд заасан шагнал урамшуулал, тэтгэвэр тэтгэмж авах баталгаагаар хангагдахаар заасан.[111]

Улс орнууд алба хаагчдын нийгмийн баталгааны хүрээнд тэднийг тогтвортой ажлын байраар хангахыг зорино.Алба хаагчдын нийгэмд эзэлж буй нэр хүнд, алба хаагчдын цалин хөлсний өрсөлдөх чадвар, тухайн ажлын байрны сонирхол татах чадварыг мөн нийгмийн баталгаа ойлголтын хүрээнд хамруулдаг.Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн алба хаагчид насан туршид төрд ажиллах эрхтэй бол Норвег улсын төрийн алба хаагчид өрсөлдөөнд суурилсан бизнесийн байгууллагын ажиллагсадтай адил концепцын дагуу зохицуулагддаг.

Дээрхи эрдэмтдийн судалгааны ажлаас үүдэн судалгааны үр дүнг дэмжин өөрийн судалгааны ажлын таамаглалыг гаргасан. Үүнд:

[110] Бурмаа Н. Төрийн албаны хүний нөөцийн удирдлага-Уб., 2022. 203 дахь тал
[111] Actionaid: Remuneration and Benefits Policy for IS Staff.2012

Зураг 1. Хүний нөөцийн бодлогод нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөлөл

Тайлбар: Судлаачийн санал болгож буй загвар

ТААМАГЛАЛ-1. Хүний нөөцийн бүрдүүлэлт нь хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-2. Байгууллагын хэв маяг нь хүний нөөцийн бодлого эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-3. Ажлын гүйцэтгэлт нь хүний нөөцийн бодлого эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-4. Сургалт хөгжил нь хүний нөөцийн бодлого эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-5. Шагнал урамшуулал нь хүний нөөцийн бодлого эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-6. Нийгмийн баталгаа нь хүний нөөцийн бодлого эерэгээр нөлөөлнө.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Судалгааг 2022 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2023 оны 01 дүгээр сарын 30-ны хооронд Хилийн цэргийн тусгай ангийн удирдах ажилтан, алба хаагч, ажилчдыг хамруулсан нь судалгааны ажлын сэдвийн хүрээнд нийцсэн гэж үзэж байна.

Чанарын судалгааны арга нь тоон судалгаагаар хэмжигддэг үйл ажиллагаа , үр дүнг мэдээлэх утгыг илтгэдэг. Энэ төрлийн судалгааны үр дүн нь судлаачдын чиг хандлагыг тодорхойлох, кодлох, дүн шинжилгээ хийх нарийн, системчилсэн аргуудыг ашигладаг онцлогтой тул энэ хүү аргыг сонгосон.

Хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн бүрдүүлэлт, ажлын гүйцэтгэлт, сургалт хөгжил, шагнал урамшуулал, нийгмийн баталгааг хангасан байдлыг төлөөлөх чадварыг тооцон, тусгай ангийн алба хаагчдаас түүврийн бүлгийн сонгон судалгааг явуулсан болно.

Судалгаанд нийт 110 оролцогч хамрагдсан ч хүчин төгөлдөр 100 оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийн асуумж бүрээр тоймлон ерөнхий мэдээлэл гаргасан.

Зураг 2. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн



Тайлбар: Human resource formation, job performance, training and development, rewards and social security, human resource policy

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Хүний нөөцийн бүрдүүлэлт	Rec-1	0.791	0.876	0.910	0.669
	Rec-2	0.633			
	Rec-3	0.825			
	Rec-4	0.895			
	Rec-5	0.600			
Байгууллагын хэв маяг	St-1	0.826	0.923	0.942	0.766
	St-2	0.850			
	St-3	0.920			
	St-4	0.894			
	St-5	0.882			
Ажлын гүйцэтгэл	Per-1	0.786	0.876	0.910	0.699
	Per-2	0.876			
	Per-3	0.739			

	Per-4	0.846			
	Per-5	0.835			
Сургалт хөгжил	Tr-1	0.869	0.925	0.944	0.772
	Tr-2	0.894			
	Tr-3	0.918			
	Tr-4	0.936			
	Tr-5	0.766			
Шагнал урамшуулал	Rew-1	0.962	0.972	0.978	0.899
	Rew-2	0.943			
	Rew-3	0.944			
	Rew-4	0.942			
	Rew-5	0.983			
Нийгмийн баталгаа	Wel-1	0.729	0.860	0.900	0.643
	Wel-2	0.776			
	Wel-3	0.748			
	Wel-4	0.869			
	Wel-5	0.876			

Тайлбар: human resource formation-хүний нөөцийн бүрдүүлэлт, job performance- ажлын гүйцэтгэлт, training-сургалт хөгжил, rewards and social security шагнал урамшуулал, нийгмийн баталгаа

Судалгааны ажлын хүчин зүйлийн шинжилгээнээс харахад:

Хүний нөөцийн бүрдүүлэлт хувьсагчийн 5 далд хувьсагч 0.876-0.942 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.876, найдвартай байдлын утга 0.910, дундаж утга 0.669 байгаа нь найдвартай байдал, дундаж утга сайн,

Байгууллагын хэв маяг хувьсагчийн 5 далд хувьсагч 0.766-0.910 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.923, найдвартай байдлын утга 0.942, дундаж утга 0.766 байна.

Ажлын гүйцэтгэлт хувьсагчийн 5 далд хувьсагч 0.699-0.910 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.876, найдвартай байдлын утга 0.910, дундаж утга 0.699 байна.

Сургалт хөгжил хувьсагчийн 5 далд хувьсагч 0.869-0.766 хооронд Кронбах альфа утга 0.925, найдвартай байдлын утга 0.944, дундаж утга 0.772 байгаа нь найдвартай байдал, дундаж утга, сайн

Хүснэгт 2. Замын шинжилгээний үр дүн

№	Таамаглал	Стандарт хазайлт	T статистик	П үнэ цэнэ	Үр дүн
1	Таамаглал-1. Ажлын гүйцэтгэлт хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.136	0.347	0.729	Батлагда агүй

2	Таамаглал-2. Байгууллагын хэв маяг хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.148	0.680	0.497	Батлагдаагүй
3	Таамаглал-3. Нийгмийн баталгаа хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.108	2.148	**0.032**	**Батлагдсан**
4	Таамаглал-4. Сургалт, хөгжил хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.201	0.489	0.625	Батлагдаагүй
5	Тааамаглал-5. Хүний нөөцийн бүрдүүлэлт хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.136	2.477	**0.014**	**Батлагдсан**
6	Тааамаглал-9. Шагнал урамшуулал хүний нөөцийн бодлогод эерэгээр нөлөөлнө.	0.166	1.737	0.083	Батлагдаагүй

Тайлбар: Судалгааны үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, мэдлэг манлайлалд эерэгээр нөлөөлнө таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.113, Т стаистик үр дүн 2.888, П үнэ цэнэ 0.004 утгатай гарч таамаглал батлагдсан. Хувь хүний ур чадвар манлайлалд эерэгээр нөлөөлнө таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.098, Т стаистик үр дүн 6.112, П үнэ цэнэ 0.000 утгатай гарч таамаглал батлагдсан (Хүснэгт 2).

Дүгнэлт, санал

Хүний нөөцийн бодлого, хүний нөөцийн бүрдүүлэлт, ажлын гүйцэтгэлт, сургалт хөгжил, шагнал урамшуулал, нийгмийн баталгаа хэрхэн хамаарах хамаарлыг судалгаагаар таамаглал дэвшүүлсэн. Судалгаанд оролцогчдод өгөгдөлд боловсруулалт хийн шинжлэн, SMART PLS-3.0, SPSS-25.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийсэн.

Судалгааны үр дүнгээс харахад, дэвшүүлэн таамагласан нийт зургаан таамаглалаас хоёр батлагдаж, дөрвөн таамаглал батлагдаагүй.

Хүний нөөцийн тухай талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн олон аргаас “Бүрэн хүрээний загвар”-ын аргад суурилан энэхүү судалгааны ажлын гүйцэтгэлээ. Чанарын болон тоон харьцуулалтын судалгааны арга зүйг илүүтэй хэрэглэн найдвартай байдал, дундаж утгыг харьцуулан шинжилсэн.

Судалгааны үр дүнгийн боловсруулалтаас харахад, зарим далд хувьсагч болох асуумж хүний нөөцийн бодлогод зарим зүйлс нөлөөлж хараахан нийцэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.

Хүний нөөцийн бодлогод нөлөөлж байгаа хувьсагчдыг тухайн салбарыг судалсан олон улсын эрдэмтдийн судалгаатай харьцуулан илүү дэлгэрэнгүй судлах нь дараагийн судалгааны ажлын үндэслэл болсон гэж үзэж байна.

Ашигласан материал:

1.Н.Бурмаа ба бусад: Менежментийн шинжлэх ухааны нэр томьёоны тайлбар толь-Уб., 2020 он

2.Ц.Цэцэгмаа, Хүний нөөцийн менежмент-Уб.,2018,

3.Адам Смит . Үндэсний баялаг, түүний эх сурвалж.1976

4.Даш П.Улсын хил хамгаалалтыг шинжлэх ухааны үндэстэй удирдъя Уб.,2002

5.Н.Бурмаа “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага” УБ.2022 он

6.Гүйцэтгэлийн удирдлага Уб., 2015.

7.Дорж “Менежмент сурах бичиг-Уб., 2018 он.

8.Франк Арнолд “Менежмент шилдгүүдээс суралцъя-Уб 2017 он

9.Н.Бурмаа “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага- Уб 2022 он

10.www.whatishumanresource.com/human-resource-management

11.Actionaid: Remuneration and Benefits Policy for IS Staff.2012

12.Реньш, М.(2009).Организационная психология: Учебное пособие.

13.Екатеринбург: Изд-во ГОУ ВПО “Рос.гос.проф.-пен, ун-т”

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛАЛ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Мөнхбат
ДХИС-ийн Удирдлагын Академийн
8022 дугаар дамжааны суралцагч,
магистрант, дэд хурандаа

Хураангуй: Хил хамгаалах байгууллагаас 2022, 2023 онд дэвшүүлсэн зорилт “Дархан хилийн албанд итгэл дүүрэн, сэтгэл хангалуун хилчин”, “Офицерын манлайллын жил”-д удирдах ажилтны албаны ур чадвар, ёс зүй, сахилга хариуцлагыг бэхжүүлэх ажлын хүрээнд удирдах ажилтны манлайлал нь хил хамгаалах байгууллагын алба үйл ажиллагааны болон ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлж болох, түүнчлэн тэдгээрийн харилцан хамаарлын талаар авч үзэхэд оршино.

Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайллыг шинжлэх ухааны үндэслэлтэй шинжилж, харьцуулан; манлайлах арга барил, ур чадвар, хүний хөгжил ажлын гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөхийг хөндөн таамаглал дэвшүүлсэн. Энэхүү судалгааг ажлын гүйцэтгэл, манлайллын арга барил, ур чадварын хүчин зүйл хэрхэн хамаарах хамаарлыг судлахыг зорилоо. Судалгаанд нийт 64 оролцогчийн өгөгдөлд боловсруулалт хийж шинжлэн, SMART PLS-3.0, SPSS-25.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийсэн.

Түлхүүр үг: Удирдах ажилтны манлайлал, ажлын гүйцэтгэл, арга барил, ур чадвар

Keywords: Managerial leadership, job performance, knowledge and skills of managers

СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮНДЭСЛЭЛ, СУДЛАГДСАН БАЙДАЛ

Аливаа байгууллагын үйл ажиллагааны амжилт нь удирдах ажилтны ур чадвар, арга барил, манлайлал, багаар ажиллах чадвар, ажлын гүйцэтгэл зэрэг олон хүчин зүйлээс хамаарна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилтын 2 дахь зүйлд хилчний алба бэхэжсэн байна. Төрийн албаны тухай хуулийн 3.1.3."чадахуйн зарчим

/мерит/" гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг; 52 дугаар зүйл. Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх нийтлэг үндэслэл**,** Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Хууль зүйн сайдын 2016 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдсан “Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөр”-ийн 4.5.2. “Бие бүрэлдэхүүний албаны сургалт бэлтгэл, ур чадварыг дээшлүүлэх” гэж заасан байна.

Манлайллын талаар нэг сэдэвт бүтээл эрдэмтдээс доктор, В.Өлзийбаяр Төрийн захиргааны удирдах ажилтны манлайллын талаар “Төрийн захиргааны удирдах ажилтны манлайллын өөрчлөлт” доктор, дэслэгч генерал Ш.Арвай “Эгэл хилчдийн ээдрээтэй сургамж”, харин ажлын гүйцэтгэлийн талаар А.Цогтбаатар “Ажлын гүйцэтгэлийн үнэлгээг боловсронгуй болгох зарим асуудал”, Ц.Өнөржаргал “Удирдахуй ухаан”, “Ажлын гүйцэтгэл”, Н.Хашбат “Гүйцэтгэлийн удирдлага” /Harvard business essentials цувралын орчуулга/ бүтээлд тус тус тусган судалсан байна. Харин Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтны манлайлал ажлын гүйцэтгэлд нөлөөлөх талаар нэг сэдэвт бүтээл одоогоор хараахан бүрэн судлагдаагүй байгаа нь судлаачийн зүгээс сэдэв сонгох үндэслэлийг бий болсон гэж үзэж байна.

МАНЛАЙЛАЛ, АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ОНОЛЫН ҮНДЭС

Америкийн зохиолч, хэвлэн нийтлэгч, Америкийн уран зохиолын "алтан үе"-ийн эцэг Жон П.Кэмпбелл ажлын гүйцэтгэлийг байгууллагын үр дүн, амжилтанд хүрэх чухал шалгуур юм. Мөн тухайн хүний стандарт хугацааны туршид гүйцэтгэсэн зан үйлийн салангид хэсгүүдийн зохион байгуулалтад хүлээгдэж буй нийт үнэ цэнэ, үр дүн гэж тодорхойлжээ.

Шмидт, Хантер (1998) нар энэ чиглэлээр хийсэн судалгааг нэгтгэн дүгнэж, холбогдох мэдлэг, арга барил, ур чадвар, ухамсартай байх нь ажлын гүйцэтгэлтэй холбоотой байдаг, учир нь

илүү ухамсартай хүмүүс "илүү их хүчин чармайлт гаргаж, ажилдаа илүү их цаг зарцуулдаг" ажлын гүйцэтгэл сайн байдаг гэж тодорхойлсон.

Гүйцэтгэлийн удирдлага зорилгоос эхэлнэ, зорилго бол бидний тэмүүлж буй үр дүн бөгөөд төлөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээ, шагнал урамшуулал, ажилтны хөгжил зэрэг бүхний үндэс юм. Зорилго байхгүй бол ажилтнууд байгууллагын амжилтад онц нөлөөгүй дэмий ажлуудад цагаа зориулж, хүч нөөцөө тарамдана.[112]

Гүйцэтгэл нь тухайн хүн ажлаа сайн гүйцэтгэж байгаа эсэхийг үнэлдэг. Аж үйлдвэрийн болон байгууллагын сэтгэл судлалын нэг хэсэг болгон эрдэм шинжилгээний чиглэлээр судлагдсан ажлын гүйцэтгэл нь хүний нөөцийн менежментийн нэг хэсэг юм.

Байгууллагын зорилго нь гүйцэтгэлийг өндөр байлгаж, үр ашгийг нэмэгдүүлэхэд оршдог бөгөөд хамгийн сайн гүйцэтгэл нь байгууллагад өндөр үр ашгийг авчрах үндсэн нөхцөл болж байдаг.

Дээрх тодорхойлолтуудыг нэгтгэж үзвэл ажлын гүйцэтгэл гэдэг нь судлаач миний үзэж байгаагаар байгууллагын зүгээс ажилтан бүрт өөрт ноогдсон үүрэг даалгавраа хэрхэн биелүүлж, ямар үр дүнд хүрч байгаа нь түүний эзэмшсэн мэргэжил, мэрэгшил, ажиллах арга барил, ур чадвар, мэдлэгээ бүрэн ашиглан үүрэг даалгаврыг биелүүлэх үйл ажиллагаа, арга хэлбэр гэж ойлгож болох юм.

Гүйцэтгэлийн менежментийн ойлголтыг дараах хоёр онол дээр тулгуурлан хөгжсөн гэж үзсэн. Salaman (2005) үүнд:

- Шударга байдлын онол
- Хүлээлтийн онол

Шударга байдлын онол ба Гүйцэтгэлийн удирдлага: байгууллагын шударга байдлын гэдгээр нь мэддэг шиг шударга ёсны онол нь байгууллагын гүйцэтгэлийн менежментийн тогтолцоо, ажилчдын үнэлгээний ойлголтыг тайлбарладаг. Гүйцэтгэл нь ажлын зан төлөв ба хандлагад нөлөөлж чаддаг. Эдгээр зан төлвүүд нь байгууллагын амжилт ба ажлын гүйцэтгэлд эергээр ба сөрөг байж болно (Baldwin, и.d.).

Шударга байдлын онол: Д.Адамсийн шударга байдлын онол- Аливаа байгууллага ажиллагсдын цалин хөлсний

[112] Гүйцэтгэлийн удирдлага УБ., 2015. 2 дахь тал

хуваарилалт, бусад шагналын үнэлгээнд шударга хандах нь чухал. Шударга байдлын тухай ойлголтод ажлын чармайлт, боловсрол, туршлага дадлагаараа тэргүүлэх ажилтан байх, өөрийн авсан цалин, шагналыг бусадтай харьцуулах зэрэг ордог.

Эдгээр эмпирик болон онолын мэдэгдлүүд нь танин мэдэхүйн чадвар, туршлага, ухамсар нь үндсэндээ мэдлэг, ур чадвар, ялангуяа мэдлэгт үзүүлэх нөлөөгөөр ажлын гүйцэтгэлд нөлөөлдөг гэж үздэг.

Хүлээлтийн онол ба гүйцэтгэлийн удирдлага: хүлээлтийн онолыг Виктор Врум (Victor Vroom, 1964) -анх судалсан. Энэ онол нь хувь хүмүүсийн эрхэмлэсэн зорилгуудыг урьдчилан таамагласан сэтгэл ханамжийн үндсэн зан байдлыг зохицуулдаг таамаглал дээр суурилсан. Энэ онол нь гүйцэтгэлийн менежментийн ойлголт шиг гүйцэтгэл бол ирээдүйн үйл ажиллагаануудын хамаарах хүлээлтүүдэд итгэх үндэс болдог (Salaman 2005).

Гүйцэтгэлийн удирдлага нь фермийн хувь хүн ажилчдын үйл ажиллагааг тасралтгүй хэмжих, хянах үйл явцыг бүрдүүлэгч нөхцөл, тогтолцоог тодорхойлдог[113]. Хүлээлтийн онол нь Гүйцэтгэлийн удирдлагын үндсэн үзэл баримтлалыг онцлон тодорхойлсон үндсэн онол юм.

Манлайлах арга барил

Судлаач Том Петерс манлайллыг өргөн агуулгатай тодорхойлсон байдаг. “Манлайлал гэдэг нь алсын хараа, урам зориг, хайр, итгэл, цог жавхаа, тууштай чанар, анхаарал тавих, бүхий л түвшинд баатруудыг төрүүлэх, урамшуулах, бэлтгэн дасгалжуулах, аливаад ажил хэрэгч байдлаар хандах явдал болно”.

Аливаа төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааны эцсийн үр дүн, амжилт, ололт зөв менежмент, сайн удирдагчаас шууд хамаарна. Тийм ч учраас удирдах албан тушаалтны удирдах арга барил, байгууллагын хөгжил юу юунаас чухал бөгөөд энэ нь цаашдаа байгууллагын хөгжил дэвшилд эерэгээр нөлөөлөх гол үндэс болдог.

[113] Aguinis Herman. 2009. 2 Edition. Performance Management Dorling Kindersley India Pvt, Ltd

Судлаач, эрдэмтэн Ренсис Лайкерт[114] удирдах арга барилын талаар дагнан судалж, улсаар удирдах арга барилд дараах хэв загвар байгааг тодорхойлон дэвшүүлжээ. Үүнд:

1. Дарангуйлан захирах арга барил
2. Найрсаг хандах арга барил
3. Хамтран зөвшилцөх арга барил
4. Оролцоонд тулгуурлах арга барил гэж тодорхойлсон байдаг.

Сүүлийн 20-иод жилийн хугацаанд Өөрчлөлтийг эрхэмлэх манлайллын арга барил болон Гүйцэтгэлийг эрхэмлэх манлайллын арга барилыг судлаачид илүүтэйгээр авч үзэх болсон.

Өөрчлөлтийг эрхэмлэх манлайлах арга барил

1. *Бусдыг татах ур чадвар:* Бусдыг удирдахын тулд та эхлээд өөрийгөө толинд сайтар харах хэрэгтэй. Та бусдыг манлайлан, сайн удирдах арга барил сурмаар байвал дараах гурван зарчимыг баримтлаарай. Үүнд, нэгдүгээрт өөрийгөө таньж мэдэх, хоёрдугаарт өөртөө хариуцлагатай байх, гуравдугаарт зүрх зоригтой байх юм.

2. *Урам зориг өгөх чадвар*: Бид урам зоригтой үедээ ажлыг зүгээр л гялалзуулдаг. Бид зорилго, тэмүүлэлтэй бол эзэмшсэн чадвараа сайн ашиглаж байгаа мэт аз жаргалтай мэдрэмжийг авдаг.

Олон арван жилийн турш урам зоригийн тухай судалсан сэтгэлзүйч Тодд Траш (Todd Thrash), Андрев Эллиот (Andrew Elliot) нар хүмүүс урам зоригтой байхад

- Шинэ боломжийг олж харах чадвар өсдөг,
- Гадаад орчны нөлөөлөлд зохицох чадвар сайжирдаг
- Илүү эрч хүчтэй болдог гэж тодорхойлжээ.

Аз болоход, урам зориг гэдэг бол оюун ухаанд байрлах хөдлөшгүй зүйл биш тул түүнийг хүн бүр өөртөө үүсгэн бий болгох боломжтой юм.[115]

Манлайлах ур чадвар

[114] АНУ-ын нийгмийн сэтгэл зүйч, нийгмийн зан үйлийг судлах аргуудыг нотолгоог бий болгоход ихээхэн хувь нэмэр оруулсан. Байгууллага зохион байгуулалтын зан төлөв менежментийн асуудал судлаач. Байгууллагын судалгааныхаа явцад тэрээр манлайллын загварын онолыг боловсруулсан.

[115] *https://educated.mn/*

Ур чадвар гэдэг нь та өөрийн сурсан мэдлэг, хуримтлуулсан туршлагаа хослуулан аливаа ажил хэрэгт ашиглах чадварыг хэлнэ. Судлаачид үүнийг харилцааны, суурь ур чадвар (soft skills), болон мэргэжлийн, хэмжиж болохуйц ур чадвар (hard skills) гэж хоёр хуваан авч үздэг. Суурь ур чадвар нь хувийн зохион байгуулалт болон бүтээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн байдаг бол мэргэжлийн ур чадвар нь аливаа ажил мэргэжилд зайлшгүй шаардагдах ур чадваруудыг багтаадаг[116].

Удирдах албан тушаалтанд байвал зохих олон шинж чанар, эзэмшвэл зохих олон чанар, арга барил байдаг бөгөөд судлаачид удирдагчийн шинж чанар, эзэмшвэл зохих ур чадварыг дараах чиглэлээр ангилан авч үздэг. Үүнд:

1. Ажил хэргийн ур чадварт
- Удирдан зохион байгуулах арга барил
- Боловсрол, мэргэжил, мэдлэг, туршлагатай байх
- Манлайлал, нөлөөлөх, бие зөв авч явах
- Ярих, илтгэх, бичиг хэрэг, түүнд дүн шинжилгээ хийх
- Хувийн зохион байгуулалт, харилцааны соёлтой байх

2. Эр зоригийн ур чадварт
- Бие даасан шийдэмгий байх
- Алдаа гаргах, хариуцлагаас айхгүй ажиллах
- Шийдэмгий, шаргуу, тэсвэр хатуужилтай байх
- Үнэнч, шударга, өөртөө итгэлтэй байх
- Эхэлснээ төгс дуусгах

3. Зан төлөвийн зөв чадамж, чадварт
- Идэвхи санаачлагатай байх
- Зарчимч, ажил хэрэгч, цагийг зөв ашиглах
- Овсгоо самбаатай байх
- Мэдрэмжтэй байх
- Өөртөө шаардлагатай, бололцоогоо бүрэн ашиглах.

Судалгааны ажилдаа дээрх онол, судалгааны ажлуудын үр дүнг судлан, манлайлах арга барил, манлайлах ур чадвар ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хамаарлыг таамаглал дэвшүүлэн судаллаа.

[116] https://posted.mn/c/skills-for-future

Зураг 1. Ажлын гүйцэтгэлд нөлөөлөх хүчин зүйлийн нөлөөлөл



Тайлбар: Судлаачийн санал болгож буй загвар

ТААМАГЛАЛ-1. Манлайлах арга барил ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.

ТААМАГЛАЛ-2. Манлайлах ур чадвар ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН:

Судалгааг 2022 оны 10 дугаар сарын 10-20-ны хооронд Хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох алба, хэлтэс, уулын бүсийн хилийн цэргийн 0285 дугаар анги, ой тайгын бүсийн хилийн цэргийн 0101 дүгээр анги, тал хээрийн бүсийн хилийн цэргийн 0184 дүгээр анги, говь цөлийн бүсээс хилийн цэргийн 0131 дүгээр анги, төвийн бүсийн 0218 дугаар ангийн дунд, дээд удирдах албан тушаалтан хамруулсан нь судалгааны ажлын сэдвийн хүрээнд нийцсэн гэж үзэж байна.

Чанарын судалгааны арга нь тоон судалгаагаар хэмжигддэг үйл ажиллагаа, үр дүнг мэдээллэх утгыг илтгэдэг. Энэ төрлийн судалгааны үр дүн нь судлаачдын чиг хандлагыг тодорхойлох, кодлох, дүн шинжилгээ хийх нарийн, системчилсэн аргуудыг ашигладаг онцлогтой тул энэхүү аргыг сонгосон.

Манлайлал, манлайллын арга барил, хувь хүний ур чадварыг судлан үзэхдээ төлөөлөх чадварыг тооцон, Хил хамгаалах байгууллагын анхан болон дунд шатны удирдах ажилтнуудаас түүврийн бүлгийн сонгон судалгааг явуулсан болно.

Судалгаанд нийт 64 оролцогч хамрагдаж, өгөгдөлд боловсруулалт хийн асуумж бүрээр тоймлон ерөнхий мэдээлэл гаргасан.

Зураг 2. Хэмжил зүйн шинжилгээний үр дүн



Тайлбар: Lead-манлайлах арга барил, Lead Skills -манлайлах ур чадвар, Perf Rer -ажлын гүйцэтгэл

Хүснэгт 1. Хүчин зүйлийн шинжилгээний үр дүн

Хувьсагч	Асуумж	Далд хувьсагчдын утга	Кронбах альфа	Найдвартай байдлын утга	Дундаж утга
Манлайлах арга барил	Lead-1	**0.253**	0.887	0.915	0.549
	Lead-2	0.829			
	Lead-3	0.834			
	Lead-4	0.754			
	Lead-5	0.830			
	Lead-6	0.851			
	Lead-7	0.838			
	Lead-8	0.765			
Манлайлах ур чадвар	Lead Skills-1	0.804	0.930	0.943	0.675
	Lead Skills-2	0.899			
	Lead Skills-3	0.737			
	Lead Skills-4	0.844			
	Lead Skills-5	0.898			
	Lead Skills-6	0.861			
	Lead Skills-7	0.831			
	Lead Skills-8	**0.670**			

Ажлын гүйцэтгэл	Perf Rer-1	0.702	0.939	0.947	0.549
	Perf Rer-2	0.834			
	Perf Rer-3	0.801			
	Perf Rer-4	0.845			
	Perf Rer-5	**0.651**			
	Perf Rer-6	**0.498**			
	Perf Rer-7	0.761			
	Perf Rer-8	0.787			
	Perf Rer-9	0.774			
	Perf Rer-10	0.841			
	Perf Rer-11	0.866			
	Perf Rer-12	0.838			
	Perf Rer-13	**0.507**			
	Perf Rer-14	0.738			
	Perf Rer-15	**0.514**			

Тайлбар: Lead-манлайлах арга барил, Lead Skills -манлайлах ур чадвар, Perf Rer -ажлын гүйцэтгэл

Судалгааны ажлын хүчин зүйлийн шинжилгээнээс харахад:

Манлайлах арга барил хувьсагчийн 8 далд хувьсагч 0.253-0.851 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.887, найдвартай байдлын утга 0.915, дундаж утга 0.549 байгаа нь найдвартай байдал, дундаж утга сайн байгаа ч, *"*Know-1. Таны гадаад хэлний мэдлэг*"* асуумжид оролцогчид үнэлгээ бага өгсөн тул далд хувьсагч 0.7 нэгжээс бага гарсан.

Манлайлах ур чадвар хувьсагчийн 8 далд хувьсагч 0.670-0.899 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.939, найдвартай байдлын утга 0.947, дундаж утга 0.549 байгаа нь найдвартай байдал, дундаж утга сайн байгаа ч "Perf Rer-5 Ажлын гүйцэтгэлийн хүлээлт", "Яаралтай ажлыг гүйцэтгэх хурд, чадвар", "Ажлын гүйцэтгэлийн урамшууллын хэлбэр нь оновчтой байдал", "Ажлын гүйцэтгэлийн үр дүнг урьдчилан харах" асуумжид оролцогчид үнэлгээ бага өгсөн тул далд хувьсагч 0.7 нэгжээс бага гарсан.

Ажлын гүйцэтгэл хувьсагчийн 15 далд хувьсагч 0.498-0.866 хооронд хэлбэлзэж, Кронбах альфа утга 0.934, найдвартай байдлын утга 0.947, дундаж утга 0.718 байна. (Хүснэгт 1).

Хүснэгт 2. Замын шинжилгээний үр дүн

№	Таамаглал	Стандарт хазайлт	Т статистик	П үнэ цэнэ	Үр дүн
1	ТААМАГЛАЛ-1. Манлайлах арга барил ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.	0.123	3.934	**0.000**	**Батлагдсан**
2	ТААМАГЛАЛ-2. Манлайлах ур чадвар ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө.	0.143	3.099	**0.002**	**Батлагдсан**

Тайлбар: Судалгааны үр дүн

Замын шинжилгээний үр дүнгээс харахад, манлайлах арга барил ажлын гүйцэтгэд эерэгээр нөлөөлнө таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.123, Т стаистик үр дүн 3.934, П үнэ цэнэ 0.004 утгатай гарч таамаглал батлагдсан. Манлайлах арга барил нь ажлын гүйцэтгэлд эерэгээр нөлөөлнө таамаглалын хувьд, стандарт хазайлт 0.143, Т стаистик үр дүн 3.099, П үнэ цэнэ 0.002 утгатай гарч таамаглал батлагдсан (Хүснэгт 2).

ДҮГНЭЛТ

- Манлайлах арга барил, манлайлах ур чадвар ажлын гүйцэтгэлд хэрхэн хамаарах хамаарлыг судалгаагаар таамаглал дэвшүүлсэн. Судалгаанд оролцогчдод өгөгдөлд боловсруулалт хийн шинжлэн, SMART PLS-3.0, SPSS-25.0 программ хангамжийг ашиглаж, хэмжил зүй, хүчин зүйл, замын шинжилгээг хийсэн.
- Удирдах ажилтан нь манлайллын арга барил, ур чадвараа дээшлүүлсэнээр ажлын гүйцэтгэлд нөлөөлөх нь батлагдсан.
- Судалгаанд Хил хамгаалах байгууллагын анги, салбар, нэгжийн нийт 64 удирдах ажилтнуудаас санал асуулгаар өгөгдөл мэдээлэл цуглуулсан.
- Судалгааны үр дүнгээс харахад, дэвшүүлэн таамагласан нийт хоёр таамаглалаас хоёр таамаглал батлагдсан.
- Манлайлах арга барилын нийт дундаж үнэлгээг удирдах ажилчид **0.549** гэж үнэлсэн бөгөөд үүнийг манлайлах ур чадвартай харьцуулахад бага байна. Тиймээс Хил хамгаалах байгууллагын удирдах ажилтнуудын ажлын гүйцэтгэлд, манлайлах ур чадвар давамгайлсан байна.

- Ажлын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байгаа “гадаад хэлний мэдлэг”, “бусдаас суралцаж өөрийгээ хөгжүүлсэн байдал” зэрэг хүчин зүйлүүд байна.
- Удирдах ажилтнууд мэргэжлийн мэдлэг, ур чадвараараа хамт олноо манлайлан, удирдан чиглүүлэхийг илүүд үздэг байна. Мөн бусдад үлгэр дурайлал болж, урам зориг өгөх, ухаалаг оюунлаг чадвар, дүрэм журмын хэрэгжилтийг сайжруулбал ажлын гүйцэтгэлд эерэг хүчтэй нөлөө үзүүлэх нь харагдаж байна.
- Судалгааны үр дүнгийн боловсруулалтаас харахад, зарим далд хувьсагч болох асуумж манлайллын арга барилд зарим зүйлс нөлөөлж хараахан нийцэхгүй байгаа байдал ажиглагдаж байна.
- Ажлын гүйцэтгэлд нөлөөлж байгаа хувьсагчдыг тухайн салбарыг судалсан олон улсын эрдэмтдийн судалгаатай харьцуулан илүү дэлгэрэнгүй судлах нь дараагийн судалгааны ажлын үндэслэл болсон гэж дүгнэж байна.

Ашигласан материал:

1. Орчуулагч Н.Хашбат, Harvard business essentials цувралын Гүйцэтгэлийн удирдлага. УБ., 2014.
2. Д.Нямсүрэн “Хүний нөөцийн менежментийн функц”. УБ., 2015.
3. “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого. УБ., 2020 он
4. Монгол Улсын Төрийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл. УБ., 2020 он, №1
5. В.Өлзийбаяр, Төрийн захиргааны удирдах ажилтны манлайллын өөрчлөлт, УБ хот, 2010 он

УЛСЫН ХИЛИЙН БҮС, ЗУРВАСТ АН АГНУУР АЖИЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ ЯВУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ ХАРИЛЦААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Б.Ням-Очир
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн ахлах багш,
Хил судлалын ухааны магистр, дэд хурандаа

Хураангуй

Хил орчмын бүс нутаг нь Монгол орны газар нутаг мөн бөгөөд тэр газрын байгалийн баялаг, жуулчдыг татах байгалийн онцгой тогтоц зэргийг ашиглах бүрэн боломжтой боловч өнөөг хүртэл ашиглахад хүндрэлтэй байна. Хилийн тухай хуулийн дээрх зүйл, заалтад тусгагдсан тусгай журам зохицуулах тодорхой аргачлалгүй явж иржээ. Эдгээр тодорхой журам заалтгүй зохицуулалт нь тодорхойгүйн улмаас хил орчмын бүсийн ашиглалт тодорхойгүй байдаг. Энэхүү тодорхойгүй байдлаас үүдэлтэй хэд хэдэн асуудлууд үүсдэг. Хуулийн заалтууд нь ашиглахаас илүү хамгаалахад чиглэгдсэн бөгөөд ийм сэтгэлгээний онцлог нь орчин цагт нийцэхгүй байна. Улсын хил дээр ан агнуур ажил үйлдвэрлэл явуулахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалт дутагдалтай бөгөөд тодорхой чиглэл зохицуулалт шаардаж байна. Чиглэл зохицуулалтыг тодорхой судалгааны үндсэн дээр бэлтгэж журам дүрмийг боловсруулах шаардлагатай бөгөөд орчин үеийн хил хамгаалах зарчим, бусад улс орны туршлагыг нэвтрүүлэх нь чухал байна. Ингэхдээ ард иргэд, улс оны эрх ашгийг тэргүүнд тавьж шинэлэх нь зүйн хэрэг юм.

Үндсэн асуудал

“Улсын хил дээр ан агнуур хийх, байгалийн баялаг ашиглах, мал аж ахуй эрхлэх, эрэл хайгуул хийх болон бусад үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах журмыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу тогтооно”.

Хилийн тухай хуулийн дээрх зүйл, заалтад тусгагдсан тусгай журам зохицуулах тодорхой аргачлалгүй явж иржээ. Эдгээр тодорхой журам заалтгүй зохицуулалт нь тодорхойгүйн улмаас хил

орчмын бүсийн ашиглалт тодорхойгүй байдаг. Энэхүү тодорхойгүй байдлаас үүдэлтэй хэд хэдэн асуудлууд үүсдэг. Энгийн эрх зүйн хүрээнд шийдвэрлэвэл зохих асуудлыг тоймловол:

1.Хил орчмын бүс нутаг нь Монгол орны газар нутаг мөн бөгөөд тэр газрын байгалийн баялаг, жуулчдыг татах байгалийн онцгой тогтоц зэргийг ашиглах бүрэн боломжтой боловч өнөөг хүртэл ашиглахад хүндрэлтэй байна.

2.Монгол Улсын Хилийн тухай хуулийн 20 дугаар зүйлд “Улсын хил дээр ан агнуур хийх, байгалийн баялаг ашиглах, мал аж ахуй эрхлэх, эрэл хайгуул хийх болон бусад үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах журмыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу тогтооно”[1]. Гэж заагдсан ч тодорхой журам гараагүй, зарчмын тодорхой чиглэлгүй явсаар өнөөг хүрчээ.

3.ОХУ ба БНХАУ-ын иргэд хилд тулж ан агнуур хийх, хил орчмын нутагт нутаглах нь харьцангуй их байхад манай улсын иргэд хилээс харьцангуй дотогш нутагладаг. Бусад улс орнууд ч хил орчмын нутаг дэвсгэр газарт хүн амын сууршил үлэмж их байдаг. Тухайлбал АНУ-ын хүн амын гуравны хоёр нь буюу 200 гаран сая иргэн улсын хилийн 100 мил (160 км) зурваст багтах газарт суурьшин амьдардаг[2]. ОХУ улсын Санкт-Петербург гэх мэт том хот хилийн бүс нутагт маш ойрхон байрладаг[3]. Гэтэл манай улсын Газар нутгийн баялаг, хадлан бэлчээрийн үлэмж хэсэг хилийн ойр гэсэн шалтгаанаар ашиглагдахгүйд хүрдэг.

4.Хилийн зурвас газраас хэт хол нутагладаг өнөөгийн нөхцөлөөс үүдэн иргэд хил орчмын газрын нэрийг мартах, түүх дурсгалт газрын ач холбогдлыг бүрэн үнэлхэгүй байх зэрэг дутагдалтай талууд бий болж байна.

5.Цас зуд, цаг уурын хүндрэлтэй нөхцөлд хил орчмын бүс нутгийг ашиглах отрын бүс байдлаар ашиглах шаардлага тулгардаг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх шийдлүүд:

1.Хил орчмын бүс нутагт аялж жуулчлах, байгалийн үзэсгэлэнтэй болон түүхэн дурсгалт газрыг үзэх гадаадын болон дотоодын жуулчдад зөвшөөрөл олгох үйл явцыг хялбар ойлгомжтой болгох

2.Хил орчмын бүс нутагт мал маллах, отор нүүдлийн байдлаар түр мал байршуулахад эзэн хариуллагагүй мал санаандгүй байдлаар бэлчээрээр хил давах, хилийн инженерийн

байгууламж эвдэж гэмтээх байдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хилийн тухайн хэсгийг камержуулах, малд GPS суурилуулж 24 цагийн хяналтад байлгах зэрэг шийдлүүд байж болно.

3.Хил хамгаалах үйл явц, хил дээр ан агнуур хийх, байгалийн баялаг ашиглах, мал аж ахуй эрхлэх зэрэг үйл явцыг харилцан ашигтайгаар зохион байгуулж, менежмент хийх

4.Хил орчмын бүс нутгийн зам харилцаа, тээвэр ложистикийн байдлыг сайжруулах зэрэг шийдлүүд болно. Энэ шийдэлтэй холбоотой нэг тодорхой жишээ нь Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын төвд Цаатан иргэд болон зочдын төв байгуулж, уг төвөөр дамжуулан аялал зохион байгуулахад тайгын иргэд морьдоо түрээсэлж, хөтөч хийн, зочдыг урцанд хонуулах зэргээр орлого олдог ажээ. Жуулчдын хэрэгцээнд тохируулан зарим отгийн өрхүүд нүүдлийнхээ хэв шинжийг өөрчилсөн. Тэд жуулчдын хүрч очих боломжтой, хамгийн ойрын автозам руу мориор 6-8 цаг явах газарт нүүдэллэн ирж удаан хугацаагаар нутаглах болжээ[4]. Хэрэв тээвэр ложистикийн байдлыг сайжруулбал хил орчмын аялал жуулчлал тодорхой хувь нэмэр болох юм.

Хилийн тухай хуулийн 3.1.14. “хил орчмын нутаг дэвсгэр” гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг; хэлнэ. (14 аймаг 69 сум)

БХҮБ-ийн 2.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино. (20 жил болоод дууссан)

“Алсын хараа-2050” Дархан хил.Зорилт 7.2.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг ханган, хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ. 7.2.15. Хил орчмын нутаг дэвсгэрт суурьшиж байгаа иргэдийн аюулгүй байдлыг хангана.

Хилийн сумдын хүн амын тоо

-1990-1992 онуудад өсч шилжилтийн эхэн үед огцом буурч;

-1993-2002 он хүртэл харьцангуй тогтвортой;

-2002-2010 буурсан;

-2012-2018 оны хооронд хилийн сумдын хүн амын тоо дунджаар 11.4 хувь өссөн;

-2019, 2021, 2022 онд буурсан.

Түүхэн уламжлал алдагдаж байна.

-45.9 хувь нь Улаанбаатар хотод,

-18.7 хувь нь Хангайн бүсэд,

-15.8 хувь нь Төвийн бүсэд,

-12.6 хувь нь Баруун бүсэд,

-7.0 хувь нь Зүүн бүсэд оршин сууж байгаа бол

-хилийн нийт 14 аймгийн 69 суманд 324’193 хүн буюу 9,8% 1990-2023 оны хооронд

-Хилийн сумдын хүн ам 12.7 хувь өссөн

-Улсын хүн ам 60.8 хувь өссөн

-5 дахин бага үзүүлэлт

Хилийн боомтын хөгжил муу байна.

Монгол Улсын ОХУ-тай хиллэдэг хэсэгт

-Авто замын 27,

-Төмөр замын 2,

БНХАУ-тай хиллэдэг хэсэгт

-авто замын 12,

-төмөр замын 1,

агаарын замын 4 нийт 46 боомттой.

Одоогоор олон улсын 13, хоёр талын хамтын ажиллагаатай 9, улирлын ажиллагаатай 5, нийт 26 боомт ажиллаж байна.

Боомтоор дамжин тухайн улсын гадаад худалдааны үйл ажиллагаа, хөдөлгөөний урсгал явагдаж байдаг бөгөөд хөдөлгөөний урсгал хэдийн чинээ их байна төдий чинээ боомтын хөгжил сайн байдаг. Гэтэл Монгол Улсад энэхүү хөгжлийн чиг хандлага ажиглагдахгүй байна. Өмнөд хилийн Замын-үүд суманд байрлах хилийн боомтоос бусад боомтуудад хөгжил гэх зүйл байхгүй байна.

Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн байгаль орчин, амьтныг хамгаалах талаар дараах заалтууд тусгагдсан[1].

“21.1.Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн байгалийн унаган төрхийг хадгалах, амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ангилалд хамруулах асуудлыг хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.2.Хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин Монгол Улсын болон хил залгаа улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор өвчин гарсан голомтын хэсэгт улсын хил дээр зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түр зогсоох, хязгаарлах, бараа, мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

21.3. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хил орчмын нутаг дэвсгэрт ой, хээрийн гал түймэр гарахаас урьдчилан сэргийлж, гарсан гал түймрийг унтраах арга хэмжээ авна.”

Энэхүү хуулийн заалтууд нь ашиглахаас илүү хамгаалахад чиглэгдсэн бөгөөд ийм сэтгэлгээний онцлог нь орчин цагт нийцэхгүй байна.

Эдгээр асуудлуудын хүрээнд тулгарах бэрхшээлүүд.

1.Халдашгүй дархан хилийг хамгаалах уламжлалт сэтгэлгээр хил орчмын бүс нутагт нутаглах, мал байрлах, аж ахуй, ан гөрөө хийх нь хилийн тайван байдлыг алдагдуулж болзошгүй, хил зөрчигчийг илүүлэх, мөрдөн хөөх зэрэгт тодорхой хүндрэл учрах зэргээс хамаарч дээр дурдсан байгалийн баялаг ашиглах, ан агнуур, мал аж ахуй эрхлэх, аялал жуулчлал хийх зэрэг үйл ажиллагаануудад хатуу хяналттай хандаж, хязгаарлагдмал байдлаар ашиглаж ирсэн.

2.Техник технологи сайжирсан, хөрш улс орнуудын эдийн засаг хүний хөгжлийн байдал дээшилсэн, улсын хил хамгаалалт болон хилийн боомтын үйл ажиллагаа сайжирсан, хорьдугаар зуунд өнгөрсөн хэт үзэл сурталжсан байдал арилсан, хоёр хөрштэйгөө уламжлалт найрсаг харилцаа улам гүнзгийрч байгаа зэрэг орчин үед гарч байгаа эерэг өөрчлөлтийн нөлөөгөөр хил орчмын зөрчил буурсаар байна. Иймээс урьдын хатуу чанд байдлыг орчин үеийн нөхцөлд тохируулан илүү хөнгөн хаялбар улс орон ард иргэдийн эрх

ашигт нийцүүлэн илүү уян хатан болгох зайлшгүй шаардлага тулгарч байна.

3.Хил орчмын газрын нарийвчилсан газрын зураг улс орны онцгой нууц байхаа больсон. Орчин үеийн сансрын зургийн технологийн тусламжтайгаар дэлхийн хаанаас ч хэн ч үзэж болохоор нээлттэй зураглал интернэтийн сүлжээгээр тавигдах болоод олон жилийг үдэж байгаа билээ. Иймээс аялал жуулчлалын зорилгоор хил орчмын бүс нутагт аялахад хориглох үндсэн шалтгаан байхгүй болсон буюу ач холбогдолгүй болсон. Хил орчмын бүс нутагт байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, үндэсний парк бий болгох бүрэн боломжтой ч өнөөг хүртэл халдашгүй дархан хил, хилийн зурваст бүх зүйл хориотой мэтээр газар нутгийнхаа үлэмж хэсгийг ашиглахгүй эдийн засгийн эргэлтэд оруулахгүй үзэсгэлэнтэй байгалийг үзэж харах эрх хязгаарлагдмал байсаар байна.

4.Хил орчмын газар нутгийг ашиглах, хил орчимд хүн ам хэт сийрэг суурьшсанаас гал түймрийн үед яаралтай мэдээлэх, унтраах хүн хүч техник татан төвлөрүүлэх зэрэгт цаг хугацаа алдаж хохирлын хэмжээ нэмэгдэх хандлагатай байдаг. Хил орчмын Ойн санг хамгаалах, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, унтраах талаарх зарим хэлэлцээрийн үр дүн хангалтгүй байна гэж үндэсний аудитын газраас гаргасан ХИЛ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ҮР НӨЛӨӨТ БАЙДАЛ[5] тайланд дурджээ.

5.Хил орчмын бүс нутгийг ашиглахтай холоотойгоор гарч болох хүндрэлүүдийн нэг нь хог хаягдал нэмэгдэх, зэрлэг ан амьтадын хөдөлгөөнд саад учруулах, үргэж дайжуулах явдал гарч болзошгүй бөгөөд эдгээрийг нарийвчлан судалгаа хийж, бусад улс орнуудын туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

Улсын хил дээр ан агнуур ажил үйлдвэрлэл явуулахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалт дутагдалтай бөгөөд тодорхой чиглэл зохицуулалт шаардаж байна. Чиглэл зохицуулалтыг тодорхой судалгааны үндсэн дээр бэлтгэж журам дүрмийг боловсруулах шаарлагатай бөгөөд орчин үеийн хил хамгаалах зарчим, бусад улсын орны туршлагыг нэвтрүүлэх нь

чухал байна. Ингэхдээ ард иргэд, улс оны эрх ашгийг тэргүүнд тавьж шинэчлэх нь зүйн хэрэг юм.

Санал

1. Улсын хил дээр ан агнуур ажил үйлдвэрлэл явуулахтай холбоотой харилцааны эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг нарийн тодорхой судлан шийдвэрлэх
2. Уламжлалт хандлага, хэрэгжиж ирсэн туршлагыг эргэн харж орчин үеийн шаардлагад нийцүүлэх
3. Монгол Улсын хилийн тухай хуулийн 20 дугаар зүйлд дурдагдсан журмыг яаралтай гаргаж хил орчмын газар нутгийн ашиглалтыг нэмэгдүүлэх
4. Улсын хил хамгаалах болон хил орчмын газар нутаг дэвсгэрийн ашиглалтыг харилцан ашигтай уялдуулж, дэд бүтэц, техник технологийн шинэчлэл хийх

Ашигласан материал:

1. МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ. https://legalinfo.mn/.
2. Know Your Rights | 100 Mile Border Zone. *American Civil Liberties Union* https://www.aclu.org/know-your-rights/border-zone.
3. Saint Petersburg. *Wikipedia* (2023).
4. Changing Taiga - Mongolian. https://grid.cld.bz/Changing-Taiga-Mongolian/2/.
5. 2012-PA-BOA1-BorderEnvProtection.pdf.
6. Б.Баярсайхан: “Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарим арга зам”

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТӨРИЙН ЦЭРГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ХАРИЛЦАН АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

М.Баттулга
Хилийн албаны сургуулийн
Цэргийн хэргийн тэнхимийн
дэд профессор, дэд хурандаа

ОРШИЛ

Олон улсын харилцаанд зөрчил хямрал намжаагүй, бүс нутгийн аюулгүй байдлын орчин, түүнд нөлөөлөгч хүчин зүйлүүд хувиран өөрчлөгдсөөр байна.

Улс орнуудын дотоод засаглалын доройтол, эдийн засаг, нийгмийн тогтворгүй байдал зэрэг нь томоохон эрсдэлийг дагуулах боллоо.

Ийм нөхцөлд улс орон бүр үндэсний аюулгүй байдлаа хангах, төрийн тогтолцоо, газар нутаг, хүн амаа аюул, эрсдэлээс сэргийлэн хамгаалах асуудалд өндөр ач холбогдол өгч, олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Манай улсын хувьд ч гэсэн эдийн засгийн хямрал, нийгэм, улс төрийн тогтворгүй байдлууд өрнөсөөр байна.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдал, түүний дотроос хилийн аюулгүй байдлыг хангах асуудал бүхий л цаг үед чухлаар тавигдаж ирсэн билээ.

Энэ талаар төрийн бодлогын хэмжээнд олон тулгамдсан асуудлуудыг цаг тухай бүрд нь шийдвэрлэсээр ирснийг та бид мэдэж байгаа.

Аюулгүй байдлаа хангах нь аливаа улс орон тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлаа хадгалан, идэвхтэй үйл ажиллагаа явуулж хөгжих чадвар, эрх ашгаа зохион байгуулалтаар гадаад, дотоод нөлөөллөөс найдвартай хамгаалах боломжоо хадгалж байхад чиглэсэн бодлого, үйл ажиллагааны цогц юм.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалд " Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, монгол соёл иргэншлийн аюулгүй байдал, хүн ам, удмын сангийн аюулгүй байдлыг хангах нь оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс мөн " гэж заасан байдаг.

Батлан хамгаалах бодлого бол аливаа улс төрийн бодлогын нэг онцгой төрөл бөгөөд үндэсний аюулгүй байдлаа хангах хүрээнд улс орноо аливаа халдлагаас хамгаалах чиглэлийг тодорхойлсон төрийн бодлого байдаг.

Түүний дотор хилийн аюулгүй байдлыг хангах асуудал чухал байр суурь эзэлдэг.

Үндсэн хэсэг

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг бөгөөд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдахыг хэлдэг.

Тэгвэл хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагддаг.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогоо тодорхойлохдоо "Хилийн талаар баримтлах бодлого нь үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаарх Монгол Улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн" гэж томьёолсон байдаг.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэлд:

Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар:

-Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахих, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож байх;

-Хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах;

-Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хэвээр хадгалах;

-Хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах;

-Хилийн асуудлаар хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх;

-Улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийлэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будилааныг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх;

-Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах;

-Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх;

-Хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх;

-Эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцөлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах;

-Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх;

Энэ нь Монгол Улсын Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдлыг хангах дэд тогтолцоо байх эрх зүйн үндсийг тодорхойлсон явдал юм.

Сүүлийн жилүүдэд нийгэм, эдийн засгийн тогтворгүй байдал, даяаршлын үйл явц, техник технологийн хөгжилд тулгуурласан үндэстэн дамнасан нийгмийн сөрөг үзэгдэл нэмэгдсэн, экологийн тэнцвэрт байдал алдагдсанаас шалтгаалан байгалийн гамшиг, аюулт үзэгдлийн давтамж, хор хөнөөл улам бүр нэмэгдэж байгаа нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд хил хамгаалах чиг үүрэг бүхий

төрийн байгууллагаас бусад байгууллага, иргэдийн үүрэг оролцоог нэмэгдүүлэхийг шаардаж байна.

“Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 4.1.3.Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, ажил үүргийн давхцал, хийдлийг арилгаж, харилцан зохицуулалт хийх механизмыг боловсронгуй болгоно, 4.1.9.Гамшиг, гэнэтийн аюул, халдлагатай тэмцэх үндэсний чадавхыг дээшлүүлж, эрсдэлийг бууруулна. Аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд болон төрийн бусад байгууллага онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах бэлэн байдлын түвшнийг шинэ шатанд гаргана, “Төрөөс хийлийн талаар баримтлах бодлого”-ын 2.1. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох гэж тусган бодлогын чиглэлийг тодорхойлсон байдаг.

Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгддэг.

Хилийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 36.2. дугаар зүйлд Улсын хил хамгаалах байгууллага энэ хуулийн 36.1-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд зэвсэгт хүчин, тагнуул, цагдаагийн болон холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллана; 6 дугаар бүлгийн 49.2. дугаар зүйлд Төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, албан тушаалтан улсын хилийн аюулгүй байдлыг хангах чиг үүргийг холбогдох хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ гэж ерөнхий байдлаар тусгасан байна.

Өнөөдрийн байдлаар хил хамгаалах байгууллага нь бусад төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд /Цагдаа, Тагнуул, Онцгой байдал, Зэвсэгт хүчин г.м/-тай хамтран ажиллахдаа байгууллага, салбар, нэгж хооронд байгуулсан хамтран ажиллах санамж бичиг, харилцан ажиллагааны төлөвлөгөөг удирдлага болгон үйл ажиллагаагаа зохион байгуулж явуулаад хэвшсэн байна.

Хилийн бүс, зурвас газар гамшигт үзэгдэл тохиолдсон үед авран хамгаалах, гамшгийн хор хөнөөлийг арилгах, нүүлгэн

шилжүүлэх, татан гаргах, хүн малын гоц халдварт өвчний үед мэдээлэх, хорио цээрийн дэглэм тогтоох, тархалтыг хязгаарлах радио хордлогын үед голомтын бүсээс ард иргэдийг татан гаргах чиглэлээр Онцгой байдлын газартай;

Хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, мөрдөн шалгах ажиллагааг явуулах, хилийн бүс, зурваст гэмт хэрэгтнийг эрэх, саатуулах ажиллагааг Цагдаа, Тагууулын албатай;

Монгол улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг тогтоон барих, таслан зогсоох, улсын хилийг халхлах, няцаах, хөөн гаргах ажиллагааг зэвсэгт хүчинтэй тус тус харилцан ажиллаж байна.

Дээрх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулсан хуулиудад Улсын хилийн аюулгүй байдлыг хангах, хамтран ажиллах эрх зүйн зохицуулалт тусгагдаагүй байна. Жишээ нь:

Цагдаагийн албаны тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх төрийн тусгай алба мөн” гэж тодорхойлоод чиг үүргийн хүрээнд авч хэрэгжүүлэх бүрэн эрхийг 2 дугаар бүлэгт нэг бүрчлэн тогтоосон.

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 42 дугаар зүйлд “Онцгой байдлын байгууллага нь гамшгаас хамгаалах хууль тогтоомж, төрийн бодлогыг хэрэгжүүлэх, гамшгаас хамгаалах үйл ажиллагааг улсын болон орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангах тусгайлсан чиг үүрэг бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлоод мөн хуулийн 29, 33, 44 дүгээр зүйлүүдээр чиг үүрийг хуульчилсан.

Зэвсэгт хүчний тухай хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын зэвсэгт хүчин нь улсыг цэргийн хүч, хэрэгслээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллага мөн” гэж тодорхойлоод мөн хуулийн 6.2.2. агаарын хилийн халдашгүй дархан байдал, агаарын зайд хяналт тавих, хамгаалах; 6.2.3. улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх; гэж чиг үүрэгт ерөнхийлөн тусгасан байна.

Үүнээс харахад дээрх тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын хилийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр хамтран

авч хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдийн эрх зүйн зохицуулалт хангалттай бүрдээгүй байна гэж үзэж болохоор байна.

Иймд хилийн аюулгүй байдлыг хангах, хилийн бүс нутагт үүсэн нөхцөлд байдлын үед тусгай ажиллагаа явуулах үүрэг бүхий төрийн тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудын харилцан ажиллагааг хуульчлан эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох нь зүйтэй мэт харагдаж байна.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр Монгол улсын хилийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4-д заасан Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг хуулиар зохицуулах ач холбогдолтой гэж үзэж байна.

ХИЛИЙН ЗАСТАВТ АЖИЛЛАЖ БАЙГАА ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖИЛТНЫ ХӨДӨЛМӨРИЙН ҮНЭЛЭМЖИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ БОЛОМЖ

Б.Батгэрэл
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант, хошууч

Хураангуй

Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа төрийн үйлчилгээний ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх боломжийг судлах

Түлхүүр үг

Улсын хил хамгаалалт, хилчин эмэгтэйчүүд, хөдөлмөрийн үнэлэмж

Оршил хэсэг

Дэлхийн улс орнууд өөрийн гэсэн газар нутгаа хил хязгаараар зааглан оршин тогтнож байна.

Манай Улс нь дэлхийн 2 том гүрний дунд өөрийн газар нутгаа хил хязгаараар зааглан энх тайвнаар оршин, хилийн аюулгүй байдлыг сахин хамгаалж байна.

Хил хязгаар гэдэг бол улс орны хувьд хамгийн том амин чухал хэрэгцээ, тухайн улсыг хил хязгааргүйгээр төсөөлөх аргагүй юм.

Тэгвэл хил хязгаарыг сахин хамгаалах хариуцлагатай албыг хилчид олон жилийн түүхийн нугачаанд өнөөдрийг хүртэл нэр, төртэй гүйцэтгэж ирсэн түүхтэй.

Улсын хил хамгаалалтад офицер, ахлагч, цэрэг, түрүүч нарын нэгэн адил хилчин эмэгтэйчүүдийн гүйцэтгэх чиг үүрэг, орон зай чухал байр суурийг эзэлж байна.

Хил хамгаалах байгууллагын хилийн цэргийн анги, салбар нь хилийн 14 аймгийн 70 гаруй сумын нутаг дэвсгэрт байрладаг бөгөөд аймаг, сумын төвөөс 15-350 км хүртэл алслагдан байрладаг.

Хилийн цэргийн анги, салбар төв суурин газраас алслагдмал, үүрэн холбооны сүлжээ, эрчим хүчний эх үүсвэр дэд бүтэц бүрэн хөгжөөгүй.

Хилийн цэргийн салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтны нийгмийн баталгаа хууль эрх зүйн хүрээнд

бүрэн хангагдаагүй, цэцэрлэг, сургуулийн хүүхдийн боловсрол эзэмших асуудал хүндрэлтэй, цалин хангамж бага, ажлын ачаалал их, хөдөлмөрийн үнэлэмж доогуур байдаг тул сүүлийн жилүүдэд ажиллах хүчний нөөц хомсдож, офицер, ахлагч нарын тогтвор суурьшилтай улсын хилд ажиллах хүний нөөцийн бодлого алдагдаж, үүнтэй холбогдсон сөрөг үр дагаварууд бий болж хил хамгаалалтын үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хилчин эмэгтэйчүүд бол хил хамгаалалтад чиглэгдсэн олон ажлууд хийж гүйцэтгэж байдаг мөн найрсаг, зочломтойгоо харьцаатай, хийж байгаа ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг, тэдэнд хувийн ашиг сонирхол гэж хэзээ ч байдаггүй хил хязгаар, анги, салбар, эр нөхрийнхөө төлөө хөдөлмөрлөж чаддаг нэргүй баатрууд юм.

Хил хамгаалах байгууллагын хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтан, эмэгтэйчүүдэд тулгамдаж буй асуудлын талаар судалж, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна.

Судалгааны ажлын зорилго:

Хилийн цэргийн анги, салбарын төрийн үйлчилгээний ажилчдын хууль эрх зүйн орчинг судлах, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх, ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах улсын хил хамгаалалтад эерэг нөлөөллийг нэмэгдүүлэхэд чиглэсэн санал, зөвлөмж боловсруулахад оршино.

ХОЁР:ХИЛЧИН ЭМЭГТЭЙЧҮҮДЭД ТУЛГАМДСАН БАЙГАА АСУУДАЛ

1.Хилийн цэргийн салбарт ажиллаж байгаа офицер, ахлагч нар улсын хил дээр 20 жил ажиллаад 40 орчим насандаа цэргийн тэтгэвэрт гардаг бөгөөд тэдгээрийн гэр бүл хүмүүс /эмэгтэйчүүд/ төрийн үйлчилгээний албан тушаалд ажилладаг учраас тэтгэвэрийн нас хүрдэггүй, хувь тэнцүүлж, тэтгэвэрт гарах эрх зүйн зохицуулалтгүй улмаас тус байгууллагадаа үргэлжлүүлэн гэр бүлийн хүнээс тусдаа 5-10 жил ажиллах шаардлагатай болдог, эсвэл нөхрөө дагаад ажлаасаа гардаг бөгөөд ажилласан жил тасалдах, ажлын байр олдохгүй хохирдог;

2.Улсын хилд нөхрөө даган олон жил ажиллаж байгаа эмэгтэйчүүд улсын хилд ажилласан 5 жилийн урамшууллыг авдаггүй.

/Эрүүл мэндийн тухай хууль, боловсролын тухай хуулинд зааснаар аймаг, сумын төвд ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багш, эмч, сувилагч нарыг тогтвор сууршилтай ажиллуулах зорилгоор 3-5 жил тутам хөдөө орон нутагт ажилласны урамшуулал олгодог. Гэтэл манай хилчин эмэгтэйчүүд болон төрийн үйлчилгээний ажилчид сумын төвөөс алслагдмал газар ажиллаж байна/.

.Улсын хилд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилчдын цалин 680.000-780.000 төгрөгийн цалин авч байгаа нь амьдралын өдөр тутмын хэрэгцээнд хүрэлцэхгүй байна. Иймд цалинг нэмэгдүүлэх. /Хилийн цэргийн салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилчдад илүү цагийн мөнгө, ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдэл болон бусад төрлийн нэмэгдэл олгогдоггүй, ажлын ачаалал их, ажлын байрны орчин нөхцөл бүрдээгүй, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах хөшүүрэг бага.

4.Сургууль, цэцэрлэгийн хүүхдийн боловсрол орхигддог, нөгөө талдаа гэр бүл тусдаа амьдрах шаардлага гардаг, төрийн үйлчилгээний ажилтан өөрийгөө хөгжүүлэх нөхцөл бага, орчин бүрдээгүй;

5.Шинээр ажилд орсон, цэргийн дээд сургууль төгссөн залуу офицер, ахлагч нарын гэр бүлийн эмэгтэйчүүд төрөл бүрийн мэргэжлээр их, дээд сургуульд өндөр боловсрол эзэмшсэн хэдий ч бүтэц орон тооны дагуу үйлчилгээний ажил хийж, мэргэжлээрээ ажиллах боломжгүй учир ихэнх тохиолдолд төв, суурин газар бараадан хилийн цэргийн салбарт ажиллах сонирхолгүй байдаг. Үүнээс шалтгаалан гэр бүл салалт, офицер, ахлагч нар тогтвор суурьшилтай ажиллахгүй ажлаас гарах, төв суурин газар өөр байгууллагад шилжих хүсэл сонирхол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэх хандлагатай байна.

6.Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах хүний хөдөлмөрийг хөнгөвчилсөн техник технологийг албанд нэвтрүүлж ашиглах. /хилийн цэргийн салбарт гал түлэхгүй, үнс гардаггүй байдлаар хоол боловсруулах/.

Хилчин эмэгтэйчүүдэд тулгамдсан дээрх асуудлууд байгаа учир Гэр бүл тусдаа амьдрахаар хилчин офицер, ахлагч нар албандаа идэвхгүй ханддаг, ажлын бүтээмж буурдаг, /гэр бүл салалт, гэр бүлийн хооронд таагүй уур амьсгал бий болдог,

тодорхойгүй хугацаагаар гэр бүл тусдаа амьдрах зайлшгүй нөхцөл бүрддэг, офицер, ахлагч нар өөрийн хүсэлтээр ажлаас гарах, өөр байгууллагад шилжин томилогдох зэрэг нь улсын хил хамгаалалтыг зохион багйуулахад хүч хэрэгсэл, хүний нөөцийн бодлогод шууд болон шууд бус байдлаар сөрөг нөлөө үзүүлж байна.

Хилчин эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн үнэлэмжийн талаар авсан судалгаа

Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн төрийн үйлчлгээний ажилчдаас авсан судалгааны дүн

Нийт судалгаанд оролцогчдын зарим тохиолдолд албаны ачаалал их байдаг буюу 42.1 хувь байгаа нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалт хилийн цэргийн анги, салбарт ирж ажиллах, ээлжинд хамт үүрэг гүйцэтгэдэг ажилчид чөлөө, ээлжийн амралтаа авч явах, удирдлагын зүгээс үндсэн үүрэгт ажлаас гадна гэнэтийн үүрэг даалгавар өгөх зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж илүү цагаар ажиллаж зарим тохиолдолд ачаалал их байдаг нь дээрх судалгаанаас харагдаж байна.



Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн төрийн үйлчлгээний ажилчдаас авсан судалгааны дүн

Төрийн үйлчилгээний ажилчид өөрийн авч буй цалинд сэтгэл ханамжгүй байдаг нь дээрх судалгааны үр дүнгээс харж болохоор байна. Иймд цаашид төрийн үйлчилгээний ажилчдыг тогтвор суурьшилтай үр бүтээлтэй ажиллуулахын тулд цалин хангамжийг нэмэгдүүлж, ажил хавсран гүйцэтгэсэн, илүү цагийн мөнгө болон 5 жилийн урамшуулалыг олгож хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой үнэлэх шаардлагатай байна.

Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн төрийн үйлчлгээний ажилчдаас авсан судалгааны дүн

Хөдөлмөрийн үнэлэмжид удирдлага нь тийм ч таатай ханддаггүй буюу судалгаанд оролцогчдын 42.6 хувь хамрагдаж байгаа нь цаашид байгууллага, ангийн удирдлагууд төрийн үйлчилгээний ажилтан руу чиглэгдсэн олон талт ажлыг бодлогын түвшинд үе шаттайгаар шийдвэрлэх шаардлагатай.



Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн төрийн үйлчлгээний ажилчдаас авсан судалгааны дүн

Дээрх судалгааны үр дүнгээс харахад ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байна. (Хилийн цэргийн салбаруудад)



Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн төрийн үйлчлгээний ажилчдаас авсан судалгааны дүн

Төрийн үйлчилгээний ажилчид хариуцсан ажилдаа чин сэтгэлээсээ ханддаг боловч хийсэн ч удирдлага үнэлдэггүй нь цаашид анхаарах чухал асуудлын нэг юм.

Хилийн цэргийн 0184 дүгээр анги ангийн хилийн заставт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтны 1 сард авч байгаа цалингийн хэмжээ хүснэгтээр

2023 оны 03 дугаар сарын байдлаар

Монгол Улсын засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор батлагдсан шинэчлэгдсэн цалингийн шатлал

д/д	Албан тушаал овог нэр	Ажилласан жил	Үндсэн цалин	Хилийн нэмэгдэл	Удаан жил	Ашиг	Нийгмийн даатгалын шимтгэл	Нийт орлого	Гарт авах цалин
1	Тогооч, талхчин Ц.Энхцэцэг	20 жил	615,152 төгрөг	30 хувь	25 хувь	-66,384	-109,651	953.486	**777.452**
2	Халуун усны эрхлэгч Б.Оюунжаргал	2 жил	615,152 төгрөг	40 хувь	-	58,217	99,039	861,213	**703,956**

Жишээ:Хилийн цэргийн 0184 дүгээр ангийн 0160 дугаар салбар (Ламт) ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтны өдөр тутмын хөдөлмөр эрхлэлтийн байдал 1 сард 15-20 удаа цэргийн гал зууханд ажиллаж, 1 өдөрт 14-18 цэрэгт 3 удаагийн 4 хоол цайгаар үйлчлэх 1 өдөрт 10-12 цаг ажиллана, амралтын өдрүүдэд ХЦАХ-дын хувцас цагаан хэрэглэлийг угаана, Зочид буудал ирэгсдэд хоол цайгаар үйлчлэнэ ихэвчлэн шөнийн 23:00- 02:00 цагийн хооронд бүлэг ирнэ энэ нь (сард 5-6 удаа тохиолдоно). Зуны улиралд 05:30-07:30 цагийн хооронд үнээ сааж сүү цагаан идээ боловсруулж үйлдвэрлэлийн даалгавар биелүүлнэ, 10 хоногт 1 удаа хилийн харуулын 6 хүний 10 хоногийн хүнсийг хагас боловсруулж бэлтгэх.

Сард 20 хоногт 20х10=200 цаг цэргийн гал зууханд

Зочид буудал, хувцас цагаан хэрэглэл угаах, сүү цагаан идээ боловсруулах, харуулын хүнс бэлтгэх гэх мэт 10 хоногт 6-7 цаг 10х6= 70 цаг

200+70=270 цаг

Хөдөлмөрийн хуулиар ажилтан нь хөдөлмөрийн гэрээ байгуулж ажилладаг боловч сар бүр 70 цаг илүү ажиллаж байгаа нөхцөл байдал бий болж байна.

Хилийн заставт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилтанд амралтын өдөр гэж байдаггүй гэвэл

Нийт сард авч байгаа цалинг 30 өдөрт харьцуулвал 1 өдөрт авах цалинг харж болох юмаа

861213:30=28,707 төгрөг

ДҮГНЭЛТ

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргийг хэрэгжүүлж байгаа хилийн цэргийн анги, салбарын офицер, ахлагч нарын гэр бүлийн гишүүн (эмэгтэйчүүд) төрийн үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлж, нийгмийн баталгаа, ажлын байрны нөхцөл, эрх зүйн орчинг бүрдүүлснээр залуу боловсон хүчин (офицер, ахлагч нар) улсын хилд гэр бүлээрээ үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажиллаж хил хамгаалалтад эерэг нөлөө үзүүлнэ.

Тэр тусмаа өөрийн эзэмшсэн мэргэжил боловсрол, залуу насаа үл умартан байж алслагдсан хилийн буйдхан салбарт ажлын ачаалал ихтэй хүнд нөхцөлд хилчин нөхрөө дагаж Улс орны тусгаар тогтнолын баталгаа болсон хилийн торгон шугман дээр цэрэг хүний нэгэн адил үүрэг гүйцэтгэж ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилчдын цалин урамшуулал, нийгмийн баталгаа бүрэн хангагдсан байх ёстой гэж үзэж байгаа боловч бодит байдал дээр хөдөлмөрийн үнэлэмж доогуур байгаа нь бусад төрийн үйлчилгээний байгууллагын ажилтантай адилтган үзэж болохгүй юмаа

Цаашид хөдөлмөрийн үнэлэмжийг тогтмол биш гүйцэтгэлд тохирсон цалин урамшуулал авдаг бол хүн бүр сайн ажиллаж илүү их өөртөө хөрөнгө оруулалт хийхийг хичээж ажиллана. Энэ нь хөдөлмөрийн үнэлэмжийн шударга хэмжүүр юм.

(Ур чадварт цалин өг, Ёс суртахуунд албан тушаал өг. Япон зүйр үг)

Хилчин эмэгтэйчүүдийн нийгмийн асуудлыг тусгайлан судалж, бодлогын хэмжээнд үе шатттайгаар шийдвэрлэх зайлшгүй хэрэгцээ шаардлагатай гэж үзэж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1.Улсын хилд ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилчдад тогтвор суурьшилтай ажиллуулах зорилгоор улсын хилд ажилласан 5 жилийн мөнгөн урамшуулал тэтгэмж;

2.Нөхөр нь 20 жил ажиллаад (офицер, ахлагч) цэргийн тэтгэвэрт гарсан үед эхнэр нь ажилласан жилээ тооцуулж хувь тэнцүүлэн тэтгэвэрт гардаг эсвэл улсын хилд ажилласны 6 сард тутам 2 сарын нэмэгдэл ажилласан жилд тооцдог эрх зүйн орчинг бүрдүүлэх;

3.Хилийн цэргийн анги, салбарт ажиллаж байгаа төрийн үйлчилгээний ажилчдын цалингийн зэрэглэлийг нэмэгдүүлэх, илүү цаг болон ажил хавсран гүйцэтгэсэн мөнгөн урамшуулал тогтмол олгох;

/Бусад байгууллагын төрийн үйлчилгээний ажилтантай адилтган үзэж болохгүй/

4.Төрийн үйлчилгээний ажилчдад тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах хөшүүрэг болох бусад төрлийн нэмэгдэл олгох (онцгой нөхцөл, ээлжийн амралтын нэмэгдэл хугацаа, хөдөлмөр хамгааллын хувцас, хүнсний хангалт) гэх мэт;

5.Хилийн цэргийн салбарт ажиллаж байгаа 0-4 насны хүүхдүүдийг харах асрах үйлчилгээг нээн ажиллуулж, хилийн цэргийн салбарт ажиллах ажилчдын орон тоог нэмэгдүүлэх зэргээр сургуулийн өмнөх боловсролыг эзэмшүүлэх;

6.Жил бүр төрийн үйлчилгээний ажилчдад 2 ээлжийн хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр тогтмол хангах; (ажил мэргэжлийн онцлогт тохирсон хутга, заазуур, хувин, бусад хөдөлмөрийн багаж хэрэгсэл гэх мэт хилийн цэргийн салбарт)

7.Хил хамгаалах байгууллагад төрийн үйлчилгээний ажилтан хариуцсан мэргэжилтэнг шинээр томилж ажиллуулах;

(тэдний эрх ашиг, уу хоолойг сонсох, тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг хамгаалах)

(Хилийн цэргийн анги, салбарт 1400 орчим төрийн үйлчилгээний ажилчид ажиллаж байна. Түүнээс 90 орчим хувь эмэгтэйчүүд)

8.Хилийн цэргийн салбарт төрийн үйлчилгээний ажилчдын ажлын байр, ажиллах орчин нөхцөл бололцоог сайжруулах, боловсронгуй болгох;

/Гал түлж, үнс асгахгүй хоол боловсруулдаг байх/

9.Төрийн үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх.,

Улсын хил дээр 2 жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан бол 1 удаа 14 хоног амралт сувилалд үнэ төлбөргүй амраах, 4-5 жил тасралтгүй үр бүтээлтэй (хилийн цэргийн салбарт) ажилласан бол эзэмшсэн мэргэжил, ур чадварыг харгалзан байгууллагын захиалгаар сургаж мэргэшүүлэн цаашид офицер, ахлагч нарын бүрэлдэхүүнд оруулах гэх мэт (ажлын байрны тодорхойлолтод заалтууд оруулж өгөх)

Гэр бүлээрээ хилийн цэргийн салбарт ажиллах хүсэл сонирхолтой албан хаагчид тоо эрс нэмэгдэнэ.

10.Хилийн цэргийн салбарт төрийн үйлчилгээний ажилчдын орон тоог нэмэгдүүлж, ажлын байр бий болгох.

Ашигласан материал:

1.Монгол Улсын хилийн тухай хууль

2.Хөдөлмөриийн тухай хууль

3.Сайнтөр.Ч Хил хамгаалах байгууллагын хүний нөөцийн бодлого, хэрэгжүүлэр арга зам докторын ажил 2020 он

4.Цолмонбаяр.Ч Хилчин эмэгтэйчүүдийн нийгмийн асуудал судалгааны ажил 2022

5.httr://medee.mn байгууллагын ажилтны хөдөлмөрийн үнэлэмж

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ИНЖЕНЕР-ТЕХНИКИЙН ХАНГАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ЦААШДЫН ЧИГ ХАНДЛАГА

Ч.Баярболд
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант, ахлах дэслэгч

Хураангуй

Бидний судалгааны ажил нь хилийн инженерийн төхөөрөмж, техник хэрэгслийг уламжлал, хөгжлийн хандлага, хил хамгаалалтад үзүүлэх үр дүнг, өнөөгийн байдлыг судалж, инженер-техникийн хангалтыг боловсронгуй болгож, нэмэгдүүлэхэд оршино.

Түлхүүр үг

Улсын хил хамгаалалт, инженер-техникийн хангалт, инженерийн байгууламж

Удиртгал

Орчин үед техник технологийн дэвшил нь улс ардын аж, ахуй түүнчлэн иргэдийн хэрэгцээнд өргөн хүрээтэйгээр нэвтэрч байгаагаас аливаа үйл ажиллагааг богино хугацаанд өндөр хурдтай өргөн цар хүрээнд явуулах боломжийг бий болгож байна.

Сүүлийн үед гарч байгаа хилийн зөрчлүүдэд дүн шинжилгээ хийхэд хил зөрчигчид техник технологийн ашигласнаар хилийн зөрчлийн шинж чанар хувьсан өөрчлөгдөж богино хугацаанд, зохион байгуулалттай, үгсэн тохиролцох хэлбэрт шилжсэн.

Улсын хил хамгаалалтад тууштай нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд улсын хилийг инженер техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгохгүйгээр шийдвэрлэх нөхцөлгүй юм. Ингэснээр улсын хил хамгаалалтад шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурласан орчин үеийн техник технологи нэвтрэх болно.

Монгол Улсын засгийн газраас Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн инженерийн байгууламжийг нэмэгдүүлэх, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг түлхүү нэвтрүүлэх зорилтыг тавьж бодлогын бичиг баримтуудад дараах байдлаар тусгагдсан байна.

Монгол Улсын Их Хурлыг 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны

хөгжлийн бодлогын 7.2.3 дахь заалт “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах хилийн цэргийн байгуулалтыг хөгжүүлж, хил хамгаалалтын чадавхыг дээшлүүлнэ.[117]

“Бүсчилсэн хил хамгаалалт” хөтөлбөрт “Инженер, техникийн хангалтыг шинжлэх ухаан технологийн ололтод суурилан хөгжүүлнэ” гэж заан тус зорилтын хүрээнд “Хил хамгаалалтын инженерийн хангалтыг бүсүүдийн онцлогт тохируулан зохион байгуулна”.[118]

Монгол Улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1.Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хилийн торон саадыг шинэчилж, хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана.

Дээрх нөхцөл байдлаас үндэслэн Улсын хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэд техник технологийн дэвшлийг өргөн нэвтрүүлэхийн зэрэгцээ хил хамгаалалтын арга тактикийг оновчтой тодорхойлж, хүний оролцоог багасгаж, эдийн засгийн хувьд бага зардлаар үр дүнтэй хил хамгаалалтыг зохион байгуулах зайлшгүй шаардлагатай болж байна.

Үндсэн хэсэг

Хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулахад улс төр, дипломат, тагнуул, инженер-техник, хяналтын төхөөрөмжийг ашиглан хилийн болон хил орчмын дэглэм сахиулах аргыг оновчтой ашиглах шаардлагатай.

Улсын хил хамгаалалтын бүх төрлийн аргыг тууштай нэвтрүүлэх зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд дэвшигдсэн энэ зорилтыг “Улсын хилийг инженер-техникийн хэрэгслээр хамгаалах аргыг боловсронгуй болгох”-гүйгээр шийдвэрлэх нөхцөлгүй юм. Улсын хилийг инженер-техникийн хэрэгслээр хамгаалах арга хил хамгаалалтад жинхэнэ утгаараа нэвтэрч, бодит байдлаар хэрэгжиж байж сая хил хамгаалалт, шинжлэх ухаан, техник технологийн

[117] Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоол
[118] Бүсчилсэн хил хамгаалалт хөтөлбөр

ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлагдан зохион байгуулагдаж, шилдэг техник технологи нэвтрэх болно.

Хил хамгаалах үйл ажиллагааг явуулахад инженер-техникийн таатай орчин бүрдсэн байхын зэрэгцээ түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хангалт бас хэрэгтэй болно. Монгол улсын нутаг дэвсгэр өргөн уудам, улсын хил олон мянган километр үргэлжилсэн урт, хүн ам цөөн, хил орчмын нутаг дэвсгэр үндсэндээ эзэмшилгүй ийм нөхцөлд улсын хилийг дан ганц хүний хүчээр хамгаалах боломжгүй. Ийм учраас бага хүчээр их хэсгийг найдвартай хамгаалах аргыг олж хил хамгаалах аргыг олж хил хамгаалалтад нэврүүлэх шаардлагатай байна.

Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламж" гэж хилийн болон хил орчмын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, улсын хил хамгаалалтад дэмжлэг үзүүлэх зориулалт бүхий саад, мөр хянах зурвас, зам, гүүр, хянах цамхаг, холбоо дохиол хяналтын техник хэрэгсэл, замын хаалт болон бусад байгууламжийг хэлнэ гэж заажээ.[119]

Өнөө үед улсын хил хамгаалалтын инженерийн хангалтын арга нь улсын хилийн инженер-техникийн цогцолбор арга хэмжээгээр хэрэгждэг ба инженер техникийн арга хэмжээг дотор нь улсын хил дээр байгуулсан төрөл бүрийн байгууламжууд, хил хамгаалалтын техник хэрэгсэл, инженерийн зэвсэглэлийн тусгай арга хэмжээ гэж ангилан авч үзээд зориулалт, ашиглалтын нөхцөл, удирдлагын төвшинг харгалзан дараах ерөнхий байдлаар ангилж авч үзэж байна.

Улсын хил хамгаалалтын ореративурлагийн төвшинд хилийн инженер-техникийн арга хэмжээ нь бүс нутгийн онцлог, хилийн цагийн байдал, газар орон, улирал, цаг агаарын байдал, бүс нутаг дах хил хамгаалалтын нэгжүүд, тэдгээрийн чиг үүрэг, хилийн анги, салбаруудын хүч хэрэгслийн ерөнхий байдлаас хамаарч дараах төрлүүдтэй байж болно.[120]

Монгол Улсын хил хамгаалалтын дүрэмд[2] улсын хил хамгаалалтын техник хэрэгслийг дараах байдлаар ангилжээ.[121]

---

[119] Монгол Улсын хилийн тухай хууль 2016 он

[120] Х.Гөлгөө "Улсын хил хамгаалалтын инженер-техникийн хангалтын арга хэмжээний үндэс" Уб.

- Дохиоллын хэрэгсэл;
- Радиотехникээр хянах хэрэгсэл
- Гэрэлтүүлгийн техник хэрэгсэл
- Хяналтын хэрэгсэл
- Тээврийн хэрэгсэл
- Хими, радиац, туршуулын хэрэсгэл
- Холбоо, мэдээллийн хэрэгсэл гэжээ.

Эдгээр ангилал нь тактикийн төвшинд өөрөөр хэлбэл хилийн застав, отрядын хариуцсан хэсэгт инженер-техникийн арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай техник хэрэгслийг бүлэглэн авч үзсэн хэрэг юм.

Зураг 1. Хилийн инженерийн хангалт

Улсын хилийн инженерийн байгууламж (төхөөрөмж):

- Хилийн шугамын явалтыг тэмдэглэх (усан дээр болон хуурай газар)
- Хяналтын төхөөрөмжүүд (ердийн, техникийн бусад)
- Хөдөлгөөн хангах инженерийн төхөөрөмжүүд (зам, жим, гүүр, гарам, гатлалт)
- Инженерийн төрөл бүрийн саадууд (тэсэрдэг, тэсэрдэггүй, цахилгаанжуулсан)
- Хориглон хамгаалах хөнгөн маягийн байгууламжууд (манаанаы, харуулын, заставын, отрядын)

Хил хамгаалалтын техник хэрэгсэл:

Дохиололын техник хэрэгсэл (үргэлжилсэн урт хэсгийн, обьектын, түргэн дэлгэгдэх)

- Хяналтын техник хэрэгсэл (ердийн, шөнийн, дулаан мэдрэгч, дүрсийн хяналтын, радиотехникийн)
- Гэрэлтүүлгийн техник хэрэгсэл (прожекторын, хэт ягаан туяаны, нэг бүрийн болоод бусад)

Инженерийн зэвсэглэл, техник болон эд зүйлс:

- Инженерийн туршуулын
- Газар шорооны ажлын зориулалтай

- Зам, гүүрийн зориулалтай
- Инженерийн төрөл бүрийн саад байгуулах
- Төрөл бүрийн саадыг арилгах аюулгүй болгох
- Худаг, уст цэгийг байгуулах, засварлах, ус цэнгэгжүүлэх
- Ус гатлалтын болон хөвөх хэрэгслүүд
- Цэргийн эрчим хүчний төхөөрөмж
- Инженерийн гар багажууд, тэсэлгээний эд зүйлс, инженерийн галт хэрэгсэл, өнгөлөн далдлалтын эд зүйлс гэх мэтчилэн.

Улсын хилийн-инженерийн хангалт нь улсын хил хамгаалж байгаа Хил хамгаалах байгууллагын алба-байлдааны ажиллагааны оперативын (байлдааны) хангалтын нэг үндсэн төрөл бөгөөд улсын хил зөрчигчдийг илрүүлэн саатуулах (устгах), тэдгээрийн хөдөлгөөн ажиллагаанд хүндрэл учруулах, зэвсэг, байлдааны болон тусгай техникийг үр дүнтэй хэрэглэх, тавигдсан үүргийг амжилттай биелүүлэх зорилгоор хүч, хэрэгслийн нууц далдуур хөдөлгөөн үйлдэх, хилийн анги, салбаруудад заасан хугацаанд хүчээ задлах, төрөл бүрийн хөнөөлийн хэрэгслүүдийг цохилтоос учирч болох хохирлыг бууруулах, улсын хил хамгаалахтай холбоотой захирагчийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд ая таатай нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зохион байгуулалттайгаар авч хэрэгжүүлж байгаа инженер-техникийн болон тусгай арга хэмжээний нэгдэл юм.

Дээрх тодорхойлолтоос үүдэн улсын хил хамгаалалтын инженер-техникийн хангалтын гүйцэтгэх үндсэн үүргийг дараах байдлаар тодорхойлох болжээ. Үүнд:

- Хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт инженерийн туршуул зохион байгуулах;
- Хилийн багана, тэмдгийг байршуулах, засварлах, арчлан хамгаалах;
- Газар орныг инженерийн талаар төхөөрөмжлөх;
- Инженерийн саад байгууламжууд, дохиолол-халхлалтын болоод илрүүлэлт-хяналтын хэрэгслүүдийг байгуулах, арчлан хамгаалах, засвар, сэргээн босголтыг гүйцэтгэх;
- Нүдээр болон техник хэрэгслийн тусламжтайгаар хяналт-ажиглалтыг явуулах байгууламжуудыг шинээр байгуулах, тэдгээрийг шаардлагатай чиглэлд шилжүүлэн байрлуулах, засварлах, арчлах;
- Нисдэг тэрэгний буудал, талбайг байгуулах, сэргээн засварлах, байнгын ашиглалттай байлгах зорилгоор тогтмол арчлан хамгаалах, түүнд дөхөц замуудыг бэлэн байлгах;

- Хилийн замын сүлжээг байгуулах, түүнийг арчлан хамгаалах, тэмдэгжүүлэх;
- Усан болон байгалийн бусад саадуудыг туулах зорилгоор гүүр, гарц, гарам төхөөрөмжлөх, сэргээн засварлах, арчлан хамгаалах, гатлалтыг зохион байгуулах, шаардлагатай чиглэлүүдэд зохиомол саадууд үүсгэх;
- Гол нуурын хэсэгт хөнгөн хөлгийн зогсоол байгуулах, арчлан хамгаалах;
- Өнгөлөн далдлалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Усны хангалтын цэгүүдийг шинээр байгуулах, арчлах, ус цэнгэгжүүлэх зэрэг улсын хил хамгаалалтын зохион байгуулалтын нэн чухал үүргүүдийг биелүүлэхтэй холбоотой ажиллагаагаар илэрэх болжээ.

Хил хамгаалах байгуулага сүүлийн жилүүдэд хил хамгаалалт инженерийн байгууламж, нисгэгчгүй нисэх хэрэгсэл (дрон)-ийг хил хамгаалалтыг өргөнөөр нэвтүүлж ашиглаж байна.

Хилийн инженерийн байгууламжийн өнөөгийн байдал

Монгол Улсын хилийн **8252.658** километр хэсгийн **2527.873** километр буюу **30.6** хувь нь инженерийн багууламжаар төхөөрөмжлөгдсөн үүнээс Монгол-Оросын хилд **716.2** километр, Монгол-Хятадын хилд **1811.673** километр инженерийн байгууламжтай.

Хилийн хэсэгт 1977-2002 онуудад барьж байгуулсан торон саадын байгууламжийг Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон байгууллагын урсгал зардал, хилийн цэргийн ангиудын дотоод нөөц бололцоо, хил хамгаалах туслах хүчний зөвлөлийн дэмжлэгээр хилийн цагийн байдлын өрнөгл ихтэй хилийн хэсгүүдийн **529.246** километр торон саадын байгууламжийг засварлаж, **203.526** километрыг шинээр байгуулан нийт 2017-2022 онуудад **732.772** километр торон саадыг шинэчлээд байна.

Улсын хилийн боомт, зурвас, бүсэд **2527.8** километр саадын байгууламж, **1267.7** километр мөр хянах зурвас, **888.4** километр түймрээс хамгаалах шороон зурвас, **485.8** километр нүхэн саад, **516.1** километр ойн зурвас, **434** хянах байр, **225** ширхэг худаг усны байгууламж, **154** ширхэг гүүр гатлалтын байгууламж, ашиглагдаж, хилийн **6** боомтыг дохиолол, хяналт, хамгаалалтын нэгдсэн системд шилжүүлсэн.

Дүгнэлт

Монгол улсын хилийн бүсүүдийн онцлогт тохирсон инженерийн байгууламжаар төхөөрөмжилж, орчин үеийн дэвшилтэд техник хэрэгслүүдийг нэвтрүүлэх, цаашлаад нисгэгчгүй нисэх хэрэсгэлийг түлхүү ашиглах дүгнэлтэд хүрч байна.

Санал

-Усан хилийн 901.058 километр хэсэг буюу 10.9 хувь (Увс, Дөрөө, Буйр нуур)-ийн хилийн хэсгийн эргийн хамгаалалтад радарын болон дохиолол, хяналтын системийг түлхүү ашиглан тусгай зориулалтын хөнгөн хөлөг, гол гатлах инженерийн зориулалттай техник хэрэгсэл, аврах иж, тусгай хэрэгслүүдийг нэмэгдүүлж, шаардлагатай инженерийн нөөцүүдийг бүрдүүлэх.

-Гадаад, дотоодын их дээд сургуульд инженер-техникийн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх.

-Талын хээрийн бүсийн хилийн отрядын хариуцсан хэсгийг бүхэлд нь хилийн инженерийн торон саадын байгууламжаар төхөөрөмжлөх.

Ашигласан материал

- Монгол улсын хилийн тухай хууль, 2017 он
- Монгол Улсын хил хамгаалалтын дүрэм[2]
- Х.Гөлгөө, 2013 он. Улсын хил хамгаалалтын орчин үеийн техник хэрэгслүүд
- Т.Баяр-Эрдэнэ, 2017 он. Хилийн инженеийн төхөөрөмж, техник хэрэгсэл нь улс хоорондын хилийн харилцаанд нөлөөлөх нь. Магистрын ажил

ХИЛИЙН ОТРЯДЫН ТУСГАЙ ТОМИЛГООТ БҮЛГИЙН СУРГАЛТ БЭЛТГЭЛ

Ж.Гарав-Очир
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант,
ахлах дэслэгч

Товч агуулга: Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн гүйцэтгэх үүрэг, сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал, цаашид сургалт бэлтгэлийг сайжруулах талаар зарим асуудлуудыг тусгав.

Түлхүүр үг: Тусгай хүчин, тусгай томилгоот бүлэг, сургалт бэлтгэл

УДИРТГАЛ

Дэлхий дахин даяарчлагдан хөгжихийн хэрээр улс, үндэстэн дамнасан зохион байгуулалтай гэмт хэрэг өргөжиж, хил орчмын нутаг дэвсгэрт террорист үйл ажиллагаа, хүн ба объект барьцаалах, хар тамхи, мансууруулах бодис, хүний наймаа, зэвсэг, галт хэрэглэлийн хууль бус худалдаа, хориотой ан, малын хулгай гэх мэт зөрчлүүдийн арга нарийсч, зохион байгуулалттай болж, цар хүрээ нь жилээс жилд өргөжин тэлж байна.

Иймд Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахын тулд дэлхийн жишиг шаардлагад нийцсэн орчин үеийн зэвсэг, тусгай хэрэгсэл, хувцас хэрэглэл, техник хэрэгслээр хангагдсан, бие бялдар, сэтгэл зүйн өндөр бэлтгэлтэй цэргийн хэргийн болон тусгай бэлтгэлийн чиглэлээр мэргэшсэн, чадварлаг бүрэлдэхүүнтэй тусгай томилгоот бүлгийг байгуулж, өмнөө тавигдсан үүргээ амжилттай гүйцэтгэхэд, тэдэнтэй явуулах сургалт, бэлтгэлийг эрчимжүүлэх, шинэ шатанд гаргах шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хил хамгаалах байгууллага хилийн бүс (100 км), зурвас (15 км)-д хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхээс гадна гэмт хэрэг, террорист халдлага, онцгой нөхцөл байдал, аюул эрсдэл үүссэн үед холбогдох хууль, дүрэмд заасны дагуу эхний ээлжинд зайлшгүй оролцож, тухайн үүссэн эрсдэл, аюулыг бууруулах нь зүй ёсны асуудал болж байна. Үүний тулд хилийн отрядуудын орон тооны болон орон тооны бус тусгай томилгоот бүлэг байнгын бэлтгэлтэй байх нь зайлшгүй юм.

Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын хилийн тухай хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг үндэслэн Хил хамгаалах байгууллагын хөгжлийн стратеги хөтөлбөрийг баталсан. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд Хилийн зурвас, бүсэд болон боомтод олныг хамарсан эмх замбараагүй байдал, зорчигч, тээврийн хэрэгслийг барьцаалах зэрэг онцгой нөхцөл үүсвэл сөрөг тусгай ажиллагаа явуулах салбар, нэгжийг байгуулж, бүрэлдэхүүнийг мэргэшүүлсэн байх, Хил хамгаалах байгууллагын мэргэжлийн чиг хандлагыг төлөвшүүлэх, тусгай томилгоот салбарын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл, техникийн хангалтыг сайжруулах гэж тусгасан байдаг.

Тусгай томилгоот бүлэг гэдэг үгийг Монгол үг зүйн үүднээс судалж үзэхэд Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь”-д **Тусгай** гэдэг нь “ тусдаа, өөр, ангид” гэсэн утгаар, **Томилох** гэдэг нь “ажил үйлс гүйцэтгүүлэхээр хүнийг нэр зааж гаргах, тохоох, тохоон томилох[122]” гэсэн утгаар, хилийн албаны нэр томьёоны тайлбар тольд **Бүлэг** гэдэг нь “хязгаарлагдмал район” цаг хугацаанд байлдааны болон тусгай үүргийг бие даан биелүүлэх зориулалт бүхий хүч хэрэгсэл[123] гэж тус тус тайлбарласан байна. Харин ОХУ-ын цэргийн тайлбар тольд “Дайсны хамгаалалтын бүсийн гүнд тагнан турших, хорлон сүйтгэх, стратегийн болон тактикийн үүрэг биелүүлэхээр эртнээс бэлтгэгдсэн хүч” хэмээн тодорхойлогдсон байдаг. Иймд тусгай томилгоот бүлэг нь ахлах даргаас өгөгдсөн аливаа үүргийг бие даан биелүүлэхээр томилогдсон бүлэг хэмээн ойлгож болохоор байна.

Тусгай хүчний үүслийн талаар баримт үзэхэд XX зуунд АНУ-ын зэвсэгт хүчинд үүсгэн байгуулсан “Түргэн байрлуулах хүчин” болон бусад улсын ийм маягийн цэрэгтэй үүрэг, зориулалтын хувьд ижил “Хишигтэн” хэмээх цэргийг Монголчууд бүр XIII зуунд цэргийн хэрэгт хэрэглэж эхэлсэн байна.

АНУ-ын тусгай хүчнийг XVII зууны үед Английн эсрэг тусгаар тогтнолын төлөө байлдаж байсан Рожерсын Рейнжэрүүдээс

[122] Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он. 559 дах тал
[123] М.Ганболд. Хилийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2010 он. 53 дах тал

үүсэлтэй гэж үздэг. Тус байлдааны салбар нь тухайн үеийн сонгомол байдах арга хэлбэрээс ангид сонгомол бус байлдааны арга хэлбэрийг уугуул оршин суугчид болох индианууудаас уламжлан, ашиглан байлдааны үүрэг гүйцэтгэж байсан байна.

“Тусгай хүчний цэрэг” гэдэг ойлголтыг англи хэлэнд “Special Purpose Force (SPF)”, “Special Operation Force (SOF)” хэмээн нэрлэдэг бол, Орос хэлнээ “ Сил специального назначения (ССН)[124]”гэх зэргээр нэрлэж хэвшсэн байна.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг. Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн сургалт бэлтгэлийн өнөөгийн байдал:

Хилийн отрядын хариуцсан хэсгийг найдвартай хамгаалахад шаардагдах удирдлага, штаб, тагнуул, сургалт, соёл хүмүүжил, хангалтын алба, бэлтгэл хүч, хилийн салбарууд, бусад шаардлагатай нэгжтэй байна гэж хил хамгаалалтын дүрэмд заасан байдаг ч өнөөгийн байдлаар зарим хилийн отрядод орон тооны бус бүтэцтэй, албаны бэлэн байдлын удирдамжинд зааснаар цагийн байдлын үед ажиллах тусгай томилгоот бүлгийг сар бүр албаны бэлэн байдлын хувиараар тодотгож байна.

Мөн Хил хамгаалах албаны бэлэн байдлын тоот удирдамжинд тусгай томилгоот бүлгийн сургалт бэлтгэлийг дараах байдлаар явуулахаар заасан байдаг.

Үүнд:

Цагийн байдлыг үнэлж дүгнэх, бие даан шийдвэр гаргах, бэрхшээлийг даван туулахад бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл олгох, тавигдсан үүргийг хамтран амжилттай гүйцэтгэхэд чиглүүлэн зохион байгуулна;

Хил зөрчигч, хил дамнасан гэмт хэргийн бүлэглэлийн үйлдэл, арга заль, байгаль цаг агаарын гэнэтийн өөрчлөлт, аюулт үзэгдлийг оновчтой тодорхойлж, түүнд чиглэгдсэн сургалтыг хөнгөнөөс хүнд рүү чиглүүлэн явуулна;

Ажиллагааны урьдчилсан төлөвлөгөөний дагуу тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтарсан дадлага, сургуулийг тогтмол явуулна гэж заасан бол бүлгийн бүрэлдэхүүн дараах мэдлэг

[124] Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2019 он. 24 дэх тал

чадварыг эзэмшсэн байна;

- Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль, тогтоомжийг бүрэн судалсан байх;
- Хилийн цагийн байдлыг үнэлж, дүгнэж чаддаг байх;
- Хариуцсан хэсгийн газар орны тактик шинж чанарыг судалж мэдсэн байх;
- Биеийн тамирын тусгай бэлтгэл (уулын болон усан), гардан тулаан, тэсвэр хатуужлын бэлтгэлд суралцсан байх;
- Тусгай ажиллагааны гар дохиог мэддэг, ашиглаж сурсан байх;
- Зэвсэг, техник, тусгай хэрэгслийг чадварлаг эзэмшисэн байх;
- Хойшлуулашгүй мөрдөн шалгах ажиллааг хууль, дүрмийн хүрээнд явуулдаг байх;
- Цэргийн байр зүйн зураг дээр ажиллах, байршил тогтоогч GPS-ийг ашиглаж мэддэг байх;
- Холбооны хэрэгсэл, тусгай өгөгдөл ашиглан мэдээ боловсруулах, дамжуулж чаддаг байх;
- Байгаль цаг уурын өөрчлөлтийг зөв тооцож, хээрийн нөхцөлд амьдрах арга ухаанд суралцсан байх;
- Хилийн цагийн байдлын өрнөлтийн үед шуурхай шилжин байрлах, цагийн байдалдаа орж, шийдвэрээ үнэн бодитой гаргаж чаддаг байх;
- Шархтанд эмнэлгийн анхан шатны тусламж чаддаг байх;

Тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүний сургалт, бэлтгэлжилтийн түвшинг улирал бүр тогтоож, үр дүнг тооцно гэсэн байна.

Тэгвэл “**Сургалт”** гэж Хил хамгаалах байгууллага хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх зорилгоор бүх шатны удирдлага, штаб, хилийн анги, тусгай салбарын бэлтгэлжилтийг хангах, цэргийн алба хаагчдын мэдлэг, дадлага, чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэл олгох зорилго, чиглэл бүхий сургалтын цогц үйл ажиллагаа гэж тодорхойлсон байна.

Хил хамгаалах байгууллага, хилийн отрядын штабаас тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын хөтөлбөр, тушаал, захирамж гардаггүй. Тухайн жилд ангийн бие бүрэлдэхүүнтэй явуулах сургалт, дадлагыг Ангийн захирагчийн А/02 дугаар тушаал “Сургалт зохион байгуулах тухай”-аар баталж сургалтыг зохион байгуулдаг. Энэхүү тушаалд тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын улирлын онцлогоос хамаарч 14 хоног болон сард 1 удаа зохион байгуулах заалт орсон

байдаг. Заалтын дагуу тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй сургалт, дадлагыг зохион байгуулдаг боловч ач холбогдол, үр дүн багатай явагддаг.

Хилийн отрядууд тусгай томилгоот бүлгийн сургалтыг уламжлалт аргаар буюу танхимын болон дадлагын хэлбэрээр явуулдаг ч үр дүнг тухай бүр тооцдоггүй, дадлагын сургалтыг нэр төдий явуулдаг нь тухайн бүлгийн бүрэлдэхүүний хүрсэн байх түвшин, мэдлэг, чадвар төдийлөн сайжрахгүй байна.

Хил хамгаалах арга хэрэгсэл, хандлага, хүний хүчин зүйлээр хамгаалалт зохион байгуулдаг асуудал өөрчлөгдөх шаардлага тулгарч, хил хамгаалалтыг дэвшилтэд техник хэрэгслээр хамгаалах, түүнд хилчдийг сургах асуудал нэн тэргүүнд тавигдах асуудлын нэг болоод байна.

Манай байгууллага нь сүүлийн жилүүдэд хил хамгаалалтад дэвшилтэд техник технологийг нэвтрүүлж, эхний ээлжинд хилийн отрядуудын тусгай томилгоот бүлгийг хангаж, ямар ч цагийн байдал үүссэн үед ашиглах иж бүрэн техник хэрэгсэл, тэдгээрийг бүрэн хүчин чадлаар нь ашиглахад тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүний мэдлэг, ур чадвар, тэдэнтэй явуулах сургалт, дадлага хараахан тогтмолжиж, сургалтын үр дүнд ахиц, дэвшил гарахгүй байгаа нь тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын хөтөлбөр, тушаал захирамж байхгүй, сургалт зохион байгуулах албан тушаалтнуудыг тусгай бэлтгэлийн чиглэлээр мэдлэг чадвар дутмаг байгаагаас шалтгаалах гол үндэс болж байна.

Хоёр. Тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалт бэлтгэлийг сайжруулах талаар

Хилийн отрядуудын орон тооны болон орон тооны бус тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, сургалт, дадлагыг хөнгөнөөс хүнд рүү шилжих зарчимаар явуулах. Бүлгийн бүрэдэхүүнтэй явуулах сургалтын агуулга дараах хэлбэртэй байна. Үүнд:

1. **Хууль эрх зүйн чиглэлээр**

- Монгол Улсын хилийн тухай хууль
- Монгол Улсын төрийн албаны тухай хууль
- Цэргийн алба хаагчын эрх зүйн байдлын тухай хууль
- Зөрчлийн тухай хууль
- Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын

гэрээ хэлэлцээр

2. Хилийн албаны чиглэлээр

- Хилийн цагийн байдлыг үнэлж, дүгнэх, шийдвэр гаргах
- Хилийн бүрэн эрхт төлөөлөгчийн туслагчийн гүйцэтгэх үүрэг
- Хил зөрчигчийн мөрийг судлаж, үнэн зөв тодорхойлох
- Хил зөрчигчийг эрэх, саатуулах үеийн хилийн харуул, манааны ажиллагаа
- Хилийн эрэл зохион байгуулж, удирдах
- Хилийн харуул, манаанд тушаал өгөх
- ХХТХГ, орон нутгийн ард иргэдийг хил хамгаалалтад татан оролцуулах

3. Тусгай бэлтгэлийн чиглэлээр

- Уулын бэлтгэл
- Өндрийн бэлтгэл
- Усны бэлтгэл
- Цанын бэлтгэл
- Техникийн бэлтгэл

4. Цэргийн байр зүйн чиглэлээр

- GPS-ийг ашиглах талаар
- Цэргийн байр зүйн зургийг унших, зураг дээр ажиллах талаар
- Байгалийн юмс үзэгдэл, луужин, од мичид, нар, сар, цагны тусламжтайгаар зүг чиг тодорхойлох арга
- Тактикийн баримжаалал хийх талаар

5. Цэргийн биеийн тамирын чиглэлээр

- Холын зайн гүйлт (5000, 10000 метр)
- Холын зайн үүргэвчтэй алхалт (15 км, 30 км)
- Биеийн хүчний дасгал (гийр өргөх, гар дээр суниах, гэдэс таталт)
- Биеийн тамирын хэрэглэлүүдэд боловсруулах дасгалууд (дүүжин, савлуур, модон, ямаар морь)
- Бүх төрлийн уналт, өнхрөлтын техникүүд

6. Гардан тулааны бэлтгэл

- Гарын цохилтын техникүүд
- Өшиглөлтын техникүүд
- Зэвсэгтэй, зэвсэггүй гардан байлдааны арга техникүүд
- Барьцаалагдсан иргэдийг аюулгүй болгох арга

7. Амьдрах ухааны чиглэлээр

- Ус гаргаж, цэвэршүүлэх арга
- Зориулалтын гал гаргах хэрэгсэл ашиглахгүйгээр гал гаргах арга
- Өөрт байгаа нөөц боломжийг ашиглан оромж барих арга
- Эмнэлгийн анхан шатны тусламж үзүүлэх
- Хортон шавьж, араатан амьтнаас өөрийгөө болон бусдыг

хамгаалах арга

8. Сэтгэл зүйн бэлтгэлийн чиглэлээр

- Тухайн ямар ч нөхцөлд дасан зохицох чадварт суралцах
- Айдасаа таван туулах талаар
- Бусдад сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх
- Сэтгэл гутрал, уур бухимдалаа барьж чаддаг байх
- Аливаа зүйлд стресстэхгүй байх талаар

9. Галын бэлтгэлийн чиглэлээр

- Буудлагын бүх төрлийн зэвсгээр буудах арга техник
- Буудлагын үед өгөгдөх дохио команд
- Байлдааны хурдан буудлага хийх
- Тактикийн буудлага хийх

Дөрөв. Тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын төлөвлөгөөг улираллаар авч үзвэл. Жишээ нь:

Загвар

Сар, долоо хоног / Хичээлийн нэр	01 сар					02 сар					03 сар				
	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1 цагийн танхимын сургалтын 45 минут, дадлагын сургалтыг 60 минутаар тус тус зохион байгуулна															
Хууль эрх зүй		1				1			1						1
Хилийн алба	2			1		1		2				2			
Тусгай бэлтгэл		2				2		1					2		
Цэргийн байр зүй	2		1				1			1		2			
Цэргийн биеийн тамир				4					4					4	
Гардан тулаан			2				2						2		
Амьдрах ухаан		1			2			2			2				2
Сэтгэл зүйн хангалт			2			1		1			2			1	
Галын бэлтгэл					2		1			1					

Бүгд цаг	4	4	5	5	4	5	4	6	5	2	4	4	4	5	3
Шалгалт	4 цаг					4 цаг					6 цаг				

Тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтын дээрх агуулгын хүрээнд сургалтын хөтөлбөр боловсруулж, системтэйгээр сургалт, дадлагыг зохион байгуулж, үр дүнг сар бүр тооцож хэвшвэл тусгай томилгоот бүлэг тавигдсан үүргээ амжилттай биелүүлж, мэргэжлийн мэргэшсэн байх зарчим биелэгдэн гэж үзэж байна.

Мөн тусгай томилгоот бүлэг нь тухайн аймаг сум орон нутгийн үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтарсан сургалт дадлагыг улирал бүр зохион байгуулж, бүлгийн бүрэлдэхүүнийг үе шаттайгаар гадаадын орнуудад явагдаж байгаа сургалтуудад хамруулж мэргэжил дээшлүүлснээр сургалтын чанар хүрээмж сайжирна.

ДҮГНЭЛТ

Хил хамгаалах байгууллагаас хилийн ангиудыг тусгай томилгоот бүлгийг бие даасан бүтэц зохион байгуулалттай болгох талаар чиглэлээр ихээхэн анхаарч ажиллаж байна.

Тусгай томилгоот бүлэг нь үүссэн цагийн байдал, тавигдсан үүргээс хамаарч төрөл бүрийн үүргийг гүйцэтгэх бөгөөд бүлгийн бүрэлдэхүүнээс цэргийн өндөр түвшний бэлтгэлжилт, ур чадварыг шаардах болсон.

Хилийн бүс, зурваст олон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн тохиолдолд хилийн анги, салбарын тусгай томилгоот бүлэг нэн тэргүүнд очиж тогтоон барих, бүслэн хаах, хэсэгчилэн хуваах, магадлан шалгах, ажиллагааг явуулж, хууль бус үйлдлийг таслан зогсоох ажиллагааг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх үүрэгтэй.

Цаашид тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүний сургалтыг сайжруулж, жигдрэлтийг хангуулахын тулд гадаад, дотоодын мэргэшүүлэх сургалтад хамруулж, байнгын байрлалдаа дадлага, сургалтаа зохион байгуулах нөхцөл бололцоогоор хангаж, орчин үеийн шаардлагад нийцсэн зэвсэг тусгай хэрэгслээр хангалтыг

зохион байгуулах шаардлага тулгарч байна.

Ашигласан материал:

1. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он
2. М.Ганболд. Хилийн нэр томьёоны тайлбар толь. УБ., 2010 он
3. Эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2019 он
4. Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудлууд эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл. УБ., 2022 он

ХИЛИЙН САЛБАРЫН ОФИЦЕРЫН СЭТГЭЛ ХАНАМЖИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Б.Азжаргал
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант,
ахлах дэслэгч

Хураангуй:

Миний судалгааны ажилд хилийн салбарын офицерын сэтгэл ханамжийг сайжруулах арга зам гэсэн сэдвийг сонгон авч хилийн салбарт үүрэг гүйцэтгэж байгаа залуу офицер, алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжинд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар судлахыг зорилоо.

Хилийн салбарт шинээр томилогдон ирсэн залуусын хувьд шинэ орчин, шинэ хамт олон, найз нөхөд, гэр бүлээсээ хол байх, дэд бүтэц хөгжөөгүй тог цахилгаан, сүлжээгүй газар амьдрах зэрэг хүндрэл бэрхшээлтэй тулгарах нь тэдний сэтгэл зүйд нөлөөлөн ачаалал өгч ажилдаа хандах хандлагад сөргөөр нөлөөлж тэдний ажлын бүтээмж буурах, осол зөрчил, ажлын байрны стресс үүссээр байна.

Хилийн салбарын алба хаагчид ажилдаа сэтгэл хангалуун байх нь монгол улсын үндэсний аюулгүй байдал, мөн улсын хилийн халдашгүй дархан байдалд шууд холбоотой тул залуу офицер буюу хилийн салбарт үүрэг гүйцэтгэж буй офицерын ажлын байрны сэтгэл ханамжийг цаашид нарийвчлан судлан үзэх шаардлагатай байгаа тул дараах ойлголтын талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үг: Ажлын байрны сэтгэл ханамж, салбарын офицер, хилчид

Нэг: Үндэслэл

Төрийн байгууллагын гол үнэт зүйл болох хүний нөөц, боловсон хүчин бэлтгэх, сургаж дадлагажуулах, ажлын байрны нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг нь байгууллагын анхаарал татсан асуудал юм.

Өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нийгмийн шаардлагын улмаас ажилтан, алба хаагчдын ажилд хандах хандлагыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтны мэдлэг ур чадвар,

бусад нөөц бололцоог бүрэн ашиглахын тулд тэдний ажлын байрнаас авах сэтгэл ханамжийг судлах нь сэдвийн гол үндэслэл болсон.

Энэхүү судалгааны ажлын хүрээнд хилийн салбарт үүрэг гүйцэтгэж буй шинээр томилогдон ирсэн офицерын сэтгэл ханамжийг судлаагүй улмаас ажлын бүтээмж буурах улмаар ажлын байраа орхих зэрэг үүсч болох эрсдэлийн талаар судалж, сэтгэл ханамжид нөлөөлөх хүчин зүйлийг эрх зүйн хүрээнд шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай болж байна.

Албан байгууллагын амжилттай явах гол хүчин зүйл нь тухай байгууллагын бие бүрэлдэхүүн болон боловсон хүчин, хүний цөөц, алба хаагчдын уур амьсгал гар нийлэмжтэй ажиллагаа нь байгууллагын гол үзүүлэлт болдог. Үүний тулд байгууллага нь ажиллах хүчний сэтгэл ханамжийг нарийн судлаж, сэтгэл ханамжийг үнэлж байх нь чухал ач холбогдолтой. Хүний бүтээмж нь ажилдаа хандах хандлага нь сэтгэлзүйн байдалтай маш нарийн холбоотой. Сэтгэл санаа тогтвортой, эрч хүчтэй байгаа үед хийсэн зүйл нь бусад үеийнхээс илүү үр дүнтэй чанартай болдог байхад, уур уцаартай, тайван бус сэтгэлээр унасан үед ямар ч зүйлийг хийсэн үр дүн муутай байдаг. Иймд аливаа байгууллагын чухал асуудал нь хоорондын харилцаа, ажилчдын сэтгэл зүйн байдал маш чухал асуудал юм.

Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй алба хаагчдын тоо цөөрсөөр байгаа тул дагаад байгууллагын ажилтандаа чиглэсэн хариуцлага, ажилчдын сэтгэл ханамжид анхаарах шаардлага зайлшгүй тулгарч байна.

Хилийн цэргийн алба хаагчийн орон нутагт ажиллаж буй нөхцлийн хувьд сэтгэл ханамж ямар түвшинд байгаа мөн алба хаагчдын орон нутгаас хотод ажиллах хүсэл сонирхолтой байдаг эсэх тэдний ажлын байрны сэтгэл ханамж тэдний үнэлэмжээр ямар байгааг нь тодорхойлох нь чухал юм. Үүнээс үүдэн ажлын байрны сэтгэл ханамжгүй байдал үүсэж улмаар ажилчид ажлын идэвхи оролцоо сулрах магадлалтай юм. Тиймээс хил хамгаалах байгууллагын алба хаагчийг ажлын байрандаа тогтвортой байлгаж хил хамгаалах албанд хоёргүй сэтгэлээр зүтгэх, хил хамгаалах байгууллагын алба хаагчдын тоог нэмэгдүүлэхийн тулд бодлого

төлөвлөлт сайтай байж сэтгэл ханамжийг бүрэн бүрдүүлж өгөх шаардлага тулгарч байна.

Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжинд нөлөөлж буй хүчин зүйлийн талаар өнөөг хүртэл бүрэн бодитой судлагдаагүй байна.

Хилийн салбарт шинээр томилогдон ирсэн залуусын хувьд шинэ орчин, шинэ хамт олон, найз нөхөд, гэр бүлээсээ хол байх, дэд бүтэц хөгжөөгүй тог цахилгаан, сүлжээгүй газар амьдрах зэрэг хүндрэл бэрхшээлтэй тулгарах нь тэдний сэтгэл зүйд ачаалал өгч ажилдаа хандах хандлагад сөргөөр нөлөөлж байна. Хилийн салбарт алба хаагчид ажилдаа сэтгэл хангалуун байх нь монгол улсын үндэсний аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдалд шууд холбоотой гэж үзэж байна. Улсын хилд үүрэг гүйцэтгэж, ажиллаж амьдарч байгаа алба хаагчдын хувьд ажлын онцлог, амьдарч байгаа орчин, хамт олны харилцаа зэргээс үүдэн сэтгэл зүйн хувьд бусад байгууллагаас эрс ялгаатай байдаг. Иймд алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжинд нөлөөх хүчин зүйлүүдийг тодорхойлж, хүндрэл бэрхшээлийг даван туулахад шаардлагатай сэтгэлзүйн шинж чанарыг хилчдэд төлөвшүүлэх нь нэн шаардлагатай гэж үзэж байна. Ажлын байрны сэтгэл ханамж маш чухал бөгөөд сэтгэл санаа хямрах, биеийн өвчлөл зэрэг нь ажлын бүтээмжийг бууралдаг.

Энэ тал дээр байгууллагын удирдлагууд алба хаагчдын сэтгэцийн эрүүл мэнд онцгойлон анхаарч энэ тал дээр арга хэмжээ авах нь зүйтэй гэж үзэж байна.

2021 оны хугацаанд хил хамгаалах байгууллагаас 500 гаруй алба хаагчид өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хэдийгээр цалин хөлсний болон нийгэм ахуйн асуудал нь хилчдийн сэтгэл ханамжийг илэрхийлж болох боловч өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нийгмийн шаардлагуудын улмаас ажилтан, алба хаагчдын ажилд хандах хандлагыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтны мэдлэг ур чадвар, бусад нөөц бололцоог бүрэн ашиглахын тулд тэдний ажлын байрнаас авах сэтгэл ханамжийг судлах нь сэдвийн гол үндэслэл болсон бөгөөд энэхүү судалгааны ажлын хүрээнд Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл ханамжийг эрх зүйн хүрээнд хэрхэн шийдвэрлэх, ажилчдын сэтгэл ханамжийг орхидуулснаас ажлын байранд гарах осол зөрчил, ажлын байраа орхих зэрэг дутагдал

үүсэж тул судалгаа хийх зайлшгүй шаардлага байгаа тул энэхүү сэдвийг авч үзлээ.

Хоёр: Өнөөгийн байдал:

2021 оны хугацаанд хил хамгаалах байгууллагаас 500 гаруй алба хаагчид өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн байна.

Хэдийгээр цалин хөлсний болон нийгэм ахуйн асуудал нь хилчдийн сэтгэл ханамжийг илэрхийлж болох боловч өөрчлөгдөн шинэчлэгдэж буй нийгмийн шаардлагуудын улмаас ажилтан, алба хаагчдын ажилд хандах хандлагыг сайжруулах, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх, ажилтны мэдлэг ур чадвар, бусад нөөц бололцоог бүрэн ашиглахын тулд тэдний ажлын байрнаас авах сэтгэл ханамжийг судлах, Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын сэтгэл ханамжийг эрх зүйн хүрээнд хэрхэн шийдвэрлэх, ажилчдын сэтгэл ханамжийг орхидуулснаас ажлын байранд гарах осол зөрчил, ажлын байраа орхих зэрэг дутагдал нэмэгдсээр байна.

Хил хамгаалах байгууллагад гарсан гэмт хэрэг, ноцтой зөрчлийн судалгаа

Хил хамгаалах байгууллагын хэмжээнд сүүлийн арван жилд гарсан гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн тухай судалгаа:

- Хил хамгаалах байгууллагад гарсан гэмт хэрэг, ноцтой зөрчлийн төрөлжсөн судалгаа /2010-2020 он/
- Гэмт хэрэгт, ноцтой зөрчилд холбогдон шалгагдаж байгаа цэргийн алба хаагчдын судалгаа /2017 -2020 он/
- Гэмт хэрэгт, ноцтой зөрчилд холбогдон шийтгэгдсэн цэргийн алба хаагчдын судалгаа /2017 - 2020 он/

Үүнд: Сүүлийн 10 жилийн хугацаанд нийт 15 онц хүнд буюу хилчид нэг нэгнийхээ амь насыг хөнөөсөн гэмт хэрэг гарчээ. Эдгээр хэргүүдэд хүнд гэмтэл учруулсан хэргүүдийг оруулаагүй болно. Уг 15 гэмт хэрэг үйлдэгчдийг цол, албан тушаалаар нь ангилвал нийт 15 байлдагч буюу хугацаат цэргийн алба хаагчид, ахлагч 3 үүнээс харуулын дарга 2, жолооч 1, дэслэгч 1заставын сургалт эрхэлсэн орлогч/, хурандаа 1отрядын дарга, хохирогчийн албан тушаал, цолоор ангилвал хугацаат цэргийн албан хаагч 4, гэрээт уэргийн албан хаагч 3, дэд хурандаа1 ар талын дарга , ахлагч 8 харуулын

дарга, заставын дарга хошууч1, отрядын албаны дарга ахмад1, заставын орлогч дэслэгч1 энгийн ажилчин 1 байна.

Дээрхи 15 гэмт хэргийн улмаас нийт 22 хүний амь нас хохирч 4 хүн хүнд гэмтсэн байна. Судалгаанаас ажиглахад 15 хүнд гэмт хэргийн 8 нь хилийн харуулд, заставт 4, отрядын төвд 3 хэрэг үйлдэгджээ.

График-1



Мөн эдгээр гэмт хэргийн 9 нь захирах захирагдах ёсыг зөрчсөн зүй бус харьцаанаас, 2 нь цэрэгт ирэхийн өмнө хулгайн болон танхайн хэргээр ял шийтгүүлж байсан хугацаат цэргийн алба хаагчдаас, 3 нь архидалтаас, нэгийнх нь шалтгааныг хууль хяналтын байгууллага хараахан тогтоогоогүй байна. Захирах захирагдах ёсыг зөрчсөн хүнлэг бус харьцаанаас үүдэн гарсан хэргүүд нь голчлон хилийн харуул дээр хугацаат цэргийн албан хаагч харуулын дарга нарын хооронд гарсан байна.

Дүгнэлт: Хилийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан нөхцлийг судлан тогтоох, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байх зорилгоор хил хамгаалах байгууллагын хэмжээнд нэгдсэн журмаар хөтлөх гэмт хэрэг, сахилгын ноцтой зөрчлийн анхан шатны бүртгэл мэдээний тогтолцоо үгүйлэгдэж байна. Байгууллагын хэмжээнд гарч буй гэмт хэрэг,

сахилгын зөрчлийг үнэн зөв бүртгэж тооцохгүйгээр түүнийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх боломжгүй юм.

График-2

Судалгаанаас гэмт хэрэг, осол авар, сахилгын ноцтой зөрчил үйлдэгсдийн

тоон үзүүлэлтээр авч үзэхэд 2012-2022 онуудад гарсан нийт 337 хэрэгт 535 хүн хамрагдсан байна. Тэдгээрийг офицер, ахлагч, ХЦАХ, ГЦАХ, сонсогч, энгийн ажилтан гэсэн ангилалаар эзлэх хувийг авч үзэхэд доорхи график гарч байна.



Гурав: Тулгамдаж буй асуудал:

Уг судалгааны ажлын хүрээнд хилийн салбарт үүрэг гүйцэтгэж буй залуу офицер, ажилчдын ажлын байрны сэтгэл ханамж, түүнд сөргөөр нөлөөлөх, тулгамдаж буй гол хүчин зүйл нь цалин урамшуулал бага, албаны ачаалал их, удирдлагын буруу арга барил, ажлын байр, амьдрах орчин муу тул ажлын байранд гарах осол зөрчил, ажлын байраа орхих зэрэг дутагдал нэмэгдсээр байна.

Дөрөв: Шийдвэрлэх асуудал

Хилийн салбарт үүрэг гүйцэтгэж буй залуу офицер, ажилчдын цалин урамшууллыг нэмэгдүүлэх, тэдний ажиллаж амьдрах орчин нөхцлийг сайжруулах, шинээр томилогдон ирсэн алба хаагчдын сэтгэл зүйн байдал, тэдний ар гэр, өссөн орчиг харгалзан үзэж сайтар судлан судалгаанаас гарсан дүнг харгалзан үзэж зохицуулан томилолт хийх нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэснээр хилчдын ажиллах амьдрах, таатай нөхцөл бүрдэж ажлын байран дээр тулгамдаж буй асуудалыг шийдвэрлэгдэснээр

ажиллах идэвхи мөн стрессгүй ажиллах чадамж нэмэгдэх болноо гэж үзэж байна.

Тав: Дүгнэлт

Алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжинд сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлс нь цалин хангамж бага, ажиллах орчин нөхцөл муу, удирдлагын арга бариллал нь буруу байгаа нь энэхүү алба хаагчид ажлын байраа орхих гол хүчин зүйл нь болж байгаа гэж дүгнэж байна. Мөн хилийн салбарт ажиллаж байгаа залуусын хувьд цэргийн дүрэм чанга, алслагдсан орон нутагт ажиллаж байгаа үйлчилгээний ажилчдын хувьд хичнээн их дээд сургууль төгссөнч гэр бүлээ даган хилд ажиллаж байгаа нь тэдний сэтгэл ханамжинд ихээхэн нөлөөлж байна.

Мөн хилийн салбарт амьдардаг орон сууцны /70-80 хувь нь 1960-1980/ оны хооронд ашиглалтанд ажиллаж нөхцөл тааруу зэрэг дутагдлууд нь өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдлаас үүдэн төрийн бодлого зохион байгуулалтаас шалтгаалж байна.

Иймд хил хамгаалах байгууллагын алба хаагчдын алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах, алба хаагч өөрийгөө хөгжүүлэх, ажил хөдөлмөрийг шударгаар үнэлэх боломж нөхцлийг бүрдүүлэхийн тулд алба хаагчдад тулгамдаж буй нийгмийн асуудлыг шийдвэрлэх, цалин, хөлс, нөхөн олговорын тогтолцоог шинэчилэх, гэр бүлийн гишүүдэд анхаарах эзэмшсэн мэргэжлийн дагуу тохирсон албан тушаалд томилох, байгууллагын тогтолцоог шинэ шатанд олон улсын стандартад нийцүүлэх, эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэх гэсэн үндсэн чиглэлийг төр, байгууллагын зүгээс анхаарлаа хандуулах зайлшгүй шаардлагатай байна.

Алба хаагчдад цалин урамшууллаас гадна хамт олны харилцаа, хийж байгаа ажлаасаа урам авах зэрэг сэтгэлзүйн хүчин зүйлсийг хүсдэг бөгөөд тэдний сэтгэл ханамжид энэ чиглэлийн хүчин зүйлс хамааралтай байна.

Санал:

- Хилийн салбарт томилогдон ирж буй залуу офицер, алба хаагчдын сэтгэл санааг сайтар судлах
- Хилийн салбарт ажиллаж амьдарч буй алба хаагчдын нийгмийг асуудлыг сайжруулах

- Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын цалын урамшууллалыг нэмэгдүүлэх
- Алба хаагчдын амьдрах, ажиллах орчин нөхцлийг сайжруулах
- Алба хаагчдын ажлын байрны сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх арга замыг сайжруулах
-

Ашигласан материал:

- Хөдөлмөрийн тухай хууль
- Лхагваа, Б,. Хилийн цэргийн ар талын хангалтыг боловсронгуй болгох зарим асуудал 2005
-Барилга — Википедиа нэвтэрхий толь
-Барилгын түүхэн хөгжил - Барилга МН - Barilga.MN

УЛСЫН ХИЛ ХАМГААЛАЛТАД ОРОН НУТГИЙН АРД ИРГЭДИЙН ОРОЛЦООГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

С.Сумъяабазар
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант,
ахлах дэслэгч

Хураангуй: Хил хамгаалах туслах хүчний гишүүд нь Монгол улсын үндсэн хууль, Хилийн тухай хууль, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол улсын Ерөнхийлөгчийн 149-р зарлигт заасны дагуу Монгол улсын иргэнд, улс орныхоо тусгаар тогтнол, хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүднээс сайн дураар эвлэлдэн нэгдсэн, иргэнийхээ үүргийг биелүүлж байгаа зохион байгуулалттай бүлэглэлийг хэлнэ.

Түлхүүр үг: Улсын хил хамгаалалт, орон нутгийн ард иргэд.

Оршил:

Монгол улсын хилийн тухай хуульд тодорхойлсоноор Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах арга хэмжээний салшгүй нэг хэсэг бөгөөд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн асуудлаар байгуулсан Монгол улс, Олон улсын гэрээ, хилийн тухай хууль тогтоомжийг хэргжүүлэх, хилийн зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн бүс зурваст улсын хилийн болон хил орчимын дэглэмийг сахиулах цэргийн, инженер техникийн, улс төрийн, дипломатын, эдийн засгийн, тагнуулын зэрэг арга хэмээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагаа юм. Хил хамгаалах туслах хүчний гишүүд нь Монгол Улсын үндсэн хууль, Хилийн тухай хууль, Төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 149-р зарлигт заасны дагуу Монгол Улсын иргэнд, улс орныхоо тусгаар тогтнол, хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүднээс сайн дураар эвлэлдэн нэгдсэж, иргэнийхээ үүргийг биелүүлж байгаа зохион байгуулалттай бүлэглэл гэж ойлгож болно. Монгол Улсын хилийн тухай хуулинд төрийн захирааны төв болон орон нутгийн байгууллага, Монгол улсын иргэд, аж ахуйн нэгжийн улсын хилийн

хамгааллатад оролцох оролцоо, гүйцэтгэх үүрэг, эдлэх эрхийг дэлгэрэнгүй тусгаж өгсөн нь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг тодруулж, хуульчилан бататгаад зогсохгүй улсын хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, хүчний байгууллагуудын эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэгийг тодотгож өсгсөн хэм хэмжээ юм.

Хил орчмын дэглэмийг сахиулахад төрийн захиргааны байгууллага, орон нутгийн засаг захиргаа, хүчний байгууллагууд, иргэний эрх зүйн баталгаа, оролцоо, ажлын уялдаа хил хамгаалалтад оролцох журам, харилцан ажиллагааг судлан, санал дэвшүүлж байх. Монгол улс эх орныхоо хил хязгаарыг тухайн цаг үеийн онцлогт тохирсон арга хэлбэрээр хамгаалж ирсэн ариван баялаг туршилгатай бөгөөд түүний аль цаг үед улсын хил хамгааллатад төр захиргааны байгууллагууд, туслах хүчний гишүүдийн оролцоо тодорхой байр суурь эзлэж байсан бол хилийн цагийн байдлын өнөөгийн нарийн төвөгтэй нөхцөлд ч урьдын адил чухал хэвээр байна.

Улсын хил хамгааллатад иргэдийг оролцуулах журамыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарилгаар 2002 онд Монгол улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого баримт бичгийг УИХ-н тогтоолоор баталж хил хамгаалалтад төр захиргааны байгууллагууд, орон нутгийн засаг захиргаа, иргэдийг оролцуулах хамтран ажиллах талаар барим бичиг мөрдөгдөж байна. Журам хэрэгжисэнээр улсын хил хамгаалалтад хүч хэрэгсэлийн хүрэлцэхгүй байсан явдал багсаж хилийн болон хил орчимын дэглэмийн зөрчлийн ирүүлэлт нэмэгдэж, орон нутаг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага хуулиаар хүлээсэн үүрэгээ хэрэгжүүлхэд түлхэц болсон.[125]

Үндсэн хэсэг:

Монгол улсын “Хилийн тухай хууль”-ийн 5 дугаар бүлэгт Улсын хил хамгаалалтад иргэд, байгууллагууд оролцох асуудлыг хил хамгаалалтад оролцох чиг үүрэг бүхий төрийн захиргааны төв

[125] Ш.Лхачинжав Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захиргаа, ард иргэдийг оролцуулах УБ 2010
Төрөөс хилийн талаар баримтлах бодлого 2002
Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам 2002

байгууллагууд болон орон нутгийн засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн бүрэн эрх, үүргийг тус тус хуульчилж өгсөн юм. Иргэдийг Хил хамгаалалтад оролцуулах үйл ажиллагааг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 149-р зарилгаар батлагдсан иргэдийг улсын хил хамгаалалтад оролцуулах журам”-ын дагуу зохион байгуулж байна. Одоогийн байдлаар хилийн аймгуудын 14 зөвлөл, хилийн сумдын 74 салбар зөвлөлүүд ажиллаж 129 багийн нутаг дэвсгэрт Хил хамгаалах туслах хүчний гишүүдийн 1200 орчим гишүүд хил хамгаалалтад оролцож байна.

Хил хамгаалах туслах хүчний гишүүд төдийгүй хил орчмын ард иргэд ялангуяа мал аж ахуй эрхэлж хилийн зурваст улирлын шинжтэйгээр нүүдлэн нутаглах, малаа оторлох үед нь тэдэнд сургалт явуулж, улирлын шинжтэйгээр хил хамгааллалтад оролцуулж байна.

Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийг оролцуулах өнөөгийн гол онцлог нь түүнийг улс төр, тагнуулын зэрэг бусад зорилгод ашиглаж байсан түүхэн хэв загвараас татгалзаж зөвхөн улсын хил хамгаалалтад ашиглах болсон явдал юм. Хил хамгааллах байгууллага, ялан гуяа улсын хил хамгаалалтын зохион байгуулж байгаа хилийн цэргийн анги, салбарын удирдлага энэ талаар бодитой арга хэмжээ зохион байгуулах ёстой. Хил хамгаалах байгууллагын удирдах бүх шатны байгууллага, Орон нутгийн төр захиргаа түүний удирдлагатай ажил албаны амьд холбоо тогтоох шаардлагатай байна. Өнөөгийн байдлаар хил хамгаалах туслах хүчний гишүүд эрх, үүрэг, хариуцлагаа умартан хилийн болон хил орчимын дэглэмийн зөрчилд холбогдох нь цөөнгүй байна. мөн хилий цэргийн салбарт эд материалын ойр зуурын дэмжлэг өгөх, баяр ёслолын арга хэмжэээг хамтран тэмдэглэх, аж ахуйн чанартай зарим төрлийн ажлыг хамтран гүйцэтгэх төдийхнөөр хязгаарлагдаж байгаагаас бус хил хамгаалалтад иргэдийг үр дүнтэй, оновчтой татан оролцуулах, туслах хүчний үйл ажиллагааг газар орон дээр нь зохион байгуулж, байнгын амьд ажиллагаатай болгох арга хэмжээнд хараахан хүрч чадаагүй байна.

Үндэсний язгуур эрх ашигийн салашгүй хэсэг, улсын хил хамгаалалтад аймаг, орон нутгийн удирдлагын хэрэгжүүлж ажиллуулах эрх зүйн зохицуулалтын оновчтой механизм дутагдалтай байгаагаас, тэдгээрийн зохион байгуулж удирдах үйл

ажиллагаа нь орон нутгийн өдөр тутмын амьдралтай холбогдох үндсэн чиг үүргийн хүрээгээр хязгаарлагдаж туслах хүчний гишүүдийг зохион байгуулж улсын хил хамгаалалтад оролцоо дутмаг байна.

Улсын хил хамгаалалтын хүч хэрэгслийн өсөлт хөгжил, хилийн цэргийн анги, салбарын захирагч нарын мэргэжилийн ур чадвар, хилийн цагийн байдлын өрнөлт өөрчлөлтийн өнөөгийн хурдацаас мэдэгдэхүйц хоцорч ард иргэдийг улсын хил хамгаалалтад татан оролцуулах зохион байгуулах түвшинд хүрч чадахгүй байна.

Дүгнэлт:

Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй Хил хамгаалалтад туслах хүчний гишүүийн 90 орчим хувь нь хилийн цэргийн салбаруудын ойролцоо буюу хилийн зурваст нутаглан байрлан, оршин сууж буй байрлал, ажил үйлдвэрлэл явуулж байгаа хэсэгтээ хил хамгаалалтад тодорхой хэмжээгээр хамрагдан үүрэг гүйцэтгэж байна. Мөн тэдний талаас илүү хувь нь улиралын шинж чанартай байгын бус байрлалтай байдаг нь хил хамгаалах туслах хүчний гишүүдийг хил хамгаалалтад татан оролцуулах нь хүндэрэлтэй байдаг. Хил орчим нутагладаг малид нь газар ороны өвс, ургамал, усны эх булаг, тохилдож болзошгүй байгалийн гамшиг, бэрхшээлүүдийг даган цаг агаарын таатай нөхцөл буюу дулааны улиралд хилийн зурваст бөөнөөрөө нутаглаж, ингэсээр тухай цагт хил хамгаалалтын нягтралыг тодорхой хэмжээгээр нэмэгдүүлэх, хилийн болон хил орчимын дэглэмийн зөрчлийг илрүүлэх, хил зөрчигчтэй холбогдолтой мэдээ мэдээлэл цуглаах, хилийн эрэлийн үе газар орноо танин мэдэх давуу талыг нь ашиглах зэргээр тодорхой нөлөө үзүүлдэг.

Харин өвлийн улиралд нутгийн гүнрүү нүүдгээс энэ хугацаанд хил хамгаалалтад татан оролцуулах нь хязгаарлагдмал болдог.

Иимээс хил хамгаалалтын найдвартай байдал гадаад дотоод эерэг хүчин зүйлсийг нэмэгдүүлэх, Орон нутгийн засаг захиргаа ард иргэд, төр захиргааны байгууллага болон хууль хяналтын байгууллага нягт хамтран ажиллах хил хамгаалалтад тэдний үйл ажиллагааг чиглүүлж, улсын хил дээр гарсан малын хулгай, хууль бус наймаа, хилийн зөрчилөөс урьдчиан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох

зорилгоор харилцан ажиллагаатай арга хэмжээнүүдийг зохион байгуулах, Хил хамгаалалтад туслах хүчний гишүүдийн зөвлөл менежментийг сайжруулах шаардлагатай гэж үзэж байна.

Санал:

Улсын хил хамгаалалтад Хил хамгаалах тусах хүчний гишүүд, орон нутгийн засаг захиргаа ард иргэдийг татан оролцуулж, Хил хамгаалар байгууллага орон нутгийн хамтын ажиллагааны удирдлагын менжментийг сайжруулахын тулд дараах саналыг дэвшүүлж байна.

Хил хамгаалалтын найдвартай байдлалыг хангахын тулд орон нутгийн ард иргэд, төр захиргааны болон хууль хяналтын байгуулагуудтай нягт хамтран ажиллах, хил хамгаалалтад тэдний үйл ажиллагааг чиглүүлж, улсын хил дээр гарах малын хулгай, хууль бус наймаа, хилийн зөрчилөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх таслан зогсоох зорилгоор хамтарсан болон харилцан ажиллагааны арга хэмжээнүүдийг зохион байгуулж, хэрэгжүүлэх.

Хил хамгааллах туслах хүчний гишүүд болон хил орчмын оршин суугч, иргэдийг ажил үйлдвэрлэл явуулж буй газар орон, нүүж байрлах чиглэлээр нь, хил хамгаалалтад үүрэг гүйцэгэх журмыг тухайн газар орны онцлог, тэдгээрт байрлах хугацаа, хилийн цагийн байдлын өрнөлт зэргийг харгалзан ялгвартайгаар тогтоон тухай бүр нь мэргэжлийн туслалцаа, зааварчилгаа өгөх.

Хилийн цэргийн анги, салбаруудын хэрэгжүүлж байгаа Хот айлын хамгаалалтыг боловсронгуй болгож иргэдийн идэвхи санаачилга өрнүүлсэнээр

Ашигласан материал:

1. Ш.Лхачинжав Хил хамгаалалтын тогтолцоонд орон нутгийн засаг захирга, ард иргэдийг оролцуулах ажиллагааг боловсронгуй болгох нь УБ 2010
2. Я.Батбаяр Улсын хил хамгаалалтад орон нутгийн ард иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга зам УБ 2013
3. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого УБ 2002
4. Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцууах журам УБ 2000

ШАЛГАГЧИЙН УР ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ ТҮҮНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Б.Сэндэр
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант
ахлах дэслэгч

Товч агуулга: Шалгалтын техник хэрэгсэлийг ашиглах, шалгагчийн ур чадварыг боловсронгуй болгох арга зам.

Түлхүүр үг: Шалгагч, ур чадвар

Оршил:

Өнөөдөр дэлхийн улс, орнууд өөр өөрийн онцлогт тохируулан улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж хилийн халдашгүй дархан байдлыг сахиж байна. Орчин цагийн Хил хамгаалах байгууллага нь түүхэн 90 жилийн хугацаанд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах зорилгоор сүүлийн жилүүдэд шинэлэг техник хэрэгслийг хил хамгаалалтад түлхүү ашиглаж байна. Дэлхий нийтээр шинжлэх ухаан, техник технологи дэвшил дээр суурилан нийгмийн хөгжлийн зүй тогтол гэдгийг бодит амьдрал дээр баталж өгсөнөөр өнөөдөр дэлхийн улс, орнууд өөр өөрийн онцлогт тохируулан улс орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хамгаалж хилийн халдашгүй дархан байдлыг сахиж байна. Өнөө үед цэргийн ангийн, тэр дундаа хилийн цэргийн ангийн чадавх нь цэргийн удирдлагын бэлэн байдал, бие бүрэлдэхүүний нөхөн хангалт, хил хамгаалалтын төхөөрөмж, материал техник хэрэгсэл тэдгээрийн чанар, цэргийн удирдах бүрэлдэхүүний мэдлэг, чадвар, оюун санаа, сэтгэл зүйн бэлтгэл, бие бялдрын түвшин зэрэг үзүүлэлтээр хэмжигдэнэ. Хил хамгаалах байгууллагын алба хаагч хэмээх тэргүүн нэршил нь нөгөө утгаараа хилчин хэмээх эрхэм алдар дор тодорхойлогдож байна.

Хил хамгаалах байгууллагын үндсэн нэгж болох хилийн салбар нэгжийн үйл ажиллагаа нь олон улсын чиг хандлагын дагуу “Олон Улсын үндэсний аюулгүй байдлаа хангах үзэл баримтлал”, “Олон улсын эрх зүй”, “Хилийн талаар байгуулсан Монгол Улсын Олон улсын гэрээ хэлэлцээрүүд “ийн хүрээнд явагдаж байгаа билээ.

Тиймээс хилийн цэргийн ангийн улсын хил хамгаалах ажиллагаа, хилчдийн хил хамгаалах албаны мэдлэг, чадвар, дадлага, менежметийн бодлоготой шууд холбоотой байдаг нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлыг хилийн орон зайд хангах үйл ажиллагаанд Хилийн цэргийн ангийн сургалт, бэлтгэл чухал байр суурь эзэлж байна гэж үзэхэд хүргэж байна. Хилийн цэргийн анги нь улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, явуулахад шууд нөлөөлөхөд шаардлагатай шийдвэр захирамж, үүнийг боловсруулан гаргаж байдаг зохион байгуулах мэдлэг чадвар, түүнийг хэрэгжүүлж байгаа ур чадвартай шууд хамааралтай албанд хүчин зүтгэж байгаа билээ. Эдгээр чадварын тодорхойлолтуудыг нэгтгэн хуульнд тусгахдаа.

Хилийн тухай хуулийн 3.1.18 дугаар зүйлд зааснаар “хилчин” гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг хэлнэ гэсэн байдаг. Мөн “Хил хамгаалах байгууллагын ЭРХЭМ ЗОРИЛГО”-д “улсын хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллага, мэргэшсэн хилчид болон шинжлэх ухаан, техник технологийн ололтод тулгуурлан хэрэгжүүлж, хилийн аюулгүй байдлыг хангана” гэсэн байдаг бол Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагууд чанарын шинэчлэлийн хүрээнд байгууллага бүр “Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого” хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж байна. Иймээс хилчид албаны ур чадвараа дээшлүүлж, тогтмол өөрийгөө хөгжүүлэх шаардлага гарч байна.

Үндсэн хэсэг:

Дэлхийн улс орнууд өдөр ирэх тусам өөрчлөгдөн шинэчлэгдэж техник технологи өндөр хурдтай хөгжиж, тэр дундаа хил хамгаалалтын техник хэрэгсэл сайжруулах чиглэлээр өөрчлөлт шинэчлэлт хийсээр байна. Монгол Улс газар зүйн байршлаараа Ази тивийн төв түшиг нутаг, их гүрнүүдийн геополитик, эдийн засаг, соёл иргэншлийн ашиг сонирхлын уулзвар, онцгой бүсэд оршиж байна. Улсын хил хамгаалалтын бүрэлдэхүүн хэсэг болон хилийн шалган нэвтрүүлэх албаны гүйцэтгэх үүрэг нь үндэсний аюулгүй байдалтай дээрх эрх зүйн зохицуулалтаар холбогдохоос гадна улсын хилээр зорчигч тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал,

тэдгээрийн гарлтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журмыг тогтоох, өөрчлөхдөө дараах зарчмуудыг баримтлана.

1. Үндэсний аюулгүй байдлыг хангах
2. Гадаад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх
3. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах гэж хуулинд заасан байдаг.

Улсын хилийн халдашгүй дархан байдал гэж хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр өөрчлөгдөөгүй байх явдлаар хангагдана гэсэн байдаг. Энэхүү нөхцөл нь цэрэг зэвсэглэл, эдийн засгаараа дэлхийд тэргүүлэгч хоёр улстай хил залган байршиж буй Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах бодлогод нөлөөлөл үзүүлж байгаа бөгөөд манай улсын өөрийн онцлог, газар зүйн байрлал, нийгэм эдийн засгийн хүчин чадалд нийцсэн оновчтой бодлого, үйл ажиллагаа явуулахыг шаардаж байна. Сүүлийн жилүүдэд техникийн тусламжтай хил хамгаалалтыг зохион байгуулж байгаа нь давхар хилчдийг хөгжүүлэх боломжт нөхцөл боловч хилчдийн хөгжил бол нэг талаас төрийн зүгээс хилчдийг хөгжүүлэх бодлого дэмжлэг нөгөө талаас хилчдийн өөрийн хичээл зүтгэл гэсэн хоёр хүчин зүйлийн зангилаа юм. Хилчин хэмээх хариуцлагатай үүрэг үйцэтгэх эздийг бэлтгэгч хөшүүрэг нь техникийн хурдтай хөл нийлүүлэн алхах нь Монгол Улсын шалгалган нэвтрүүлэх боомтын хөгжил нүүр царай болох ч нөгөө талаараа улс орны хөгжилд тулгуур болох нь дамжиггүй.

Техник хэрэгсэл тасралтгүй хөгжих хэдий ч ашиглаж, ажлуулах, бэлтгэгдсэн алба хаагчид хэр хэмжээтэй байгаа билээ гэдэг асуулт гарах байх мэдлэг дадлага чадварын талаар улсын болон хувийн хэвшлийн байгууллагууд, эрдэмтэд судлаачид өндөр ач холбогдол өгч өргөн хүрээтэйгээр тал бүрээс нь судалж олон янзын сургалтын хөтөлбөр, шалгуур үзүүлэлт гаргасан боловч одоогоор томоохон өөрчлөлт гараагүй байна гэж хэлхэд хэлэсдэхгүй байх. Тиймээс хилчдийг мэргэшсэн газартаа өөрийгөө хурдан өөрчлөх, дадлагажиж, томилогдсон ажлыг хурдан, шуурхай, алдаа дутагдалгүй ажиллах хэрэгтэйг автоматаар хөгжихийг шаардаж байна. Хөгжил гэдэг нь өмнө байсан мэдлэг, чадвар дээрээ

суурилсан шинэ мэдлэг, шинэ чадвар өөртөө олж авахыг хэлнэ. Хөгжиж буй хилчин гэдэг нь тухайн шинжлэх ухаан болон түүний дидактикийн онол, арга зүйг гүнзгийрүүлэн судалж, мэргэшиж байгаа, ур чадвараа системтэй дээшлүүлэн, өөрийгөө боловсруулан хөгжүүлэх тодорхой зорилго, чиглэлтэй ажиллаж буй хилчинг хэлнэ. Гэвч цаг үеийн нөхцөл байдал, бусад хүчин зүйлээс шалтгаалж албаны мэдлэг, боловсрол, ур чадварыг харьцуулан жишиж шалгуур тогтоохгүй томилгоонд шудрага бус хуваарилалтууд хийх нь болсон нь ажлын бүтээж муу алдаа дутагдал их гарахаас харагдахаас гадна бусад алба хаагч нарын хувьд ажлын нэмэгдүүлэн ажиллах таатай нөхцөлд ихээр нөлөөлж байна.

Дидактик- мэргэжилийн сургалт, хөтөлбөр гэсэн утгатай.

Жишээ нь: Шалган нэтрүүлэх албанд үүрэг гүйцэтгэх бүрэлдэхүүний хувьд шалгалчийн сэтгэлгээнд штамп дарж, хил нэвтрэх эрхийн баримт бичигт тэмдэглэгээ хийх, бүртгэх үүрэгтэй гэсэн бодол давамгайлсан байдаг нь цөөнгүй алба хаагч нарт ажиглагдах нь элбэг. Бусад албанд хэрэглэгдэж байгаа шалгалтын техник хэрэгсэл, офицер хүний хийж гүйцэтгэх үүргийн түвшинд хүрэхгүй байгаа нь бусад албанд шилжин үүрэг гүйцэтгэхэд мэдлэг, чадвар хангалтгүй байгаагаас харагдах нь цөөнгүй. Сурах хүсэл тэмүүлэл гэдэгт Хилчид байнга мэдэрч, үргэлж сонирхолыг нь татаж байдаг хөгжихийн хэрээр тансаг амьдарч ажиллах нөхцөл бүрддэг сэтгэл санааны болон материаллаг урамшуулал, шагнал, дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх нээлттэй ил тод тогтолцоо, түүнийг үйл ажиллагааг ойлгож болно гэж тодорхойлсон байдаг. Шинэчлэгдсэн техник хэрэгсэл, бүртгэлийн прагроммын ашиглалтад алдаа их гаргах нь алба хаагчдийн техник хэрэгслийг ашиглах, мэргэжлийн ур чадварыг сайжруулах, мэдлэг боловсролыг тасралтгүй сэргээн суралцах, ахлах даргын тушаалаас ангид өөрийгөө хөгжүүлэх хэрэгтэй байгааг харуулж байна.

Дээрх жишээ нь үндсэн ажлын хажуугаар өөрийгөө хөгжүүлэх боломжийг бүрдүүлж хөгжлийн хурдацаас хоцрохгүй байх чадварыг хилчин бүрээс шаардаж байгаа хэдий ч нөгөө талаараа бага зэрэг явцуу ойлголт байгаа юм. Энэ нь алба хаагчийг шат дараалалсан шалгагч бэлтгэх сургалтнд хамруулан, албанд ашиглагдаж байгаа техник хэрэгсэл, бүртгэлийг программ, штамп дарах ур чадвар зэрэгт тогтмол дадлагажуулан сургалтын хөтөлбөрийг шалгагчид юу

хэрэгтэй, юуг сурах хүсэлтэй байгаагаар харгалзан үзэж, тэнцвэртэй байдлыг гуйвуулахгүйгээр хамруулах шаардлагатай байгааг харуулж байгаа юм. Мөн 2022 оны судалгаагаас анализ хийхэд ажлын байран дээрээ хөгжихөд ямар бэрхшээл тулгардаг вэ гэсэн асуумжид албаны ачаалал их байдаг учраас суралцах цаг зав гардаггүй гэж судалгаагаар гарсан байдаг. Судалгаагаас хархад хилчдийн өөрийгөө хөгжүүлэхэд тулгамдаад байгаа гол бэрхшээл нь ажлын ачаалал болох нь ажиглагдаж байна. Өөрийгөө хөгжүүлэхийг дийлэнх нь эрмэлздэг боловч ажлын нөхцөл байдал, ачаалал, ар гэрийн амьдралаас болж бэрхшээл тулгарч байна.

Үүнд:

- Ажлын ачаалал
- Техник тоног төхөөрөмж ашиглахад хэлний мэдлэггүй
- Алба хаагчдыг хөгжүүлэх сургалтанд ялгавартай хамруулдаг гэж судалгаанд хариулсан байна.

Мөн ажлын байранд тасралтгүй хөгжих гол арга зам бол хилчин өөрийнхөө үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, ажлын зорилт, зорилгодоо бусдаас хараат байж төлөвлөгөөт ажлыг ур чадвар, манлайлалын дээгүүр түвшинд хийж гүйцэх хэрэгтэй. Манлайлал нь хувь хүмүүсээс бүтээлч, шинийг илэрхийлэгч, өөртөө итгэлтэй, харилцааны ур чадвар, тууштай байдал, гэх үндсэн шинж чанарыг эзэмшихийг шаарддаг. Харин зарим үед ямар эрх мэдэл албан тушаал хашдаггүй ч өөрсдийн үйл ажиллагаа, чадвараараа манлайлагч байдлаа харуулж, одоо байгаагаас илүү байхын тулд эрмэлзэж чаддаг үндсэн үүрэгт ажлын хувьд тэргүүлэх эгнээнд байх нэгэн олонтой харагдах нь сайшаалтай.

Дүгнэлт:

Цаашид хилчдийн албаны ур чадварыг сайжруулах чиглэлээр дараах зүйлүүдэд хилийн анги, тусгай салбарууд анхаарал хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

Үүнд:

- Техник технологийн дэвшлийг ашиглах, суралцах боломжоор хангах
- Гадаад дотоодын мэргэжил нэгт хилчидтэй уялдаа холбоотой ажиллаж харилцан суралцах боломж бүрдүүлэх

- Албан тушаалын шудрага томилгоо хийж урамшуулах тогтолцоог хэрэгжүүлэх
- Сургалтыг хувь хүнийг хөгжүүлэх талаар бүх шатнд тэгш эрхийг мөрдөж ажиллах
- Албаны ачаалалыг амралт ачаалалын графикт тохируулан үүрэг гүйцэтгүүлэх
- Алба хаагчдийн ажлын бүтээмжийг шудрагаар дүгнэж, сайшаах
- Хилчид бид:
- Өөрийгөө хөгжүүлэх төлөвлөгөөтэй, төлөвлөгөөний биелэлт, ажлын үр дүнд анхааран ажиллах
- Бие дааж өөрийгөө хөгжүүлэх ажлуудыг үр дүнтэй зохион байгуулах шаардлагатай

Ашигласан материал:

1. Хилийн тухай хууль
2. Хил судлал 2023 он
3. Эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2022 он
4. Г.Хулан “Хил судлалын шинжлэх ухааны өнөөгийн байдал, цаашдын хөгжил, тулгамдаж буй асуудал” 2022 он
5. Б.Лувсанравдан “Эх оронч үндэсний үзэл ба хилийн аюулгүй байдал” 2022он
6. Улсын хил хамгаалалтад тулгамдаж буй асуудлууд эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл 2022 он

ХИЛЧИН АХЛАГЧ НАРЫН БОЛОВСРОЛД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Г.Төрмөнх
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант, ахмад

Товч агуулга: Хилчин ахлагч нарын өнөөгийн боловсрол, хэрхэн үр дүнтэй зохион байгуулах талаарх зүйлсийг тусгав.

Түлхүүр үг: Хилчин ахлагч нарын сургалтыг үр дүнтэй зохион байгуулах арга

Оршил:

Хил хамгаалах байгууллагын ахлагч нарын гүйцэтгэх үүрэг улам бүр нэмэгдэж байгаа энэ үед ахлагчийн албыг хөгжүүлж, мэдлэг боловсролыг нэмэгдүүлэхэд тулгамдаж буй асуудлуудыг шинжлэх ухааны үндэстэйгээр судлан эрдэмтэн судлаачдын хийсэн судалгааг гүнзгийрүүлэн судлах, мэдлэг боловсролтой мэргэжлийн хилчин ахлагч байх гол шалгуурыг хангуулах нь ахлагчийн хөгжлийн түвшин юм. Ахлагчийн албаны хөгжлийг эрчимжүүлхийн тулд, анги, салбаруудад ажиллаж байгаа хилчин ахлагч нарын дуу хоолойг сонсож тулгамдаад байгаа асуудлуудыг шийдвэрлүүлэх гарцыг өөрсдөөр нь тодорхойлуулан удирдлагын бүрэлдэхүүнд уламжлуулан шийдвэрлүүлэх явдал юм. Өнөө цагийн гадаадын хилийн цэргийн хөгжил дэвшил, Хилийн цэргийн хөгжлийн чиг хандлага бодлого гээд бидний өмнө олон асуудлууд байгаа эдгээрээс чухалчилж үзвэл цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо түүнийг хэрхэн хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, цаашид яаж сайжруулах гээд манай хилийн цэрэгт хэрэгжиж байгаа боломжит олон зүйлс байгааг үргэлжлүүлэх явдал юм. Аливаа улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлын салшгүй нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь Хилийн цэргийн чадавхыг нэмэгдүүлэх түүний дотор мэдлэг боловсролтой ахлагч нарыг хил хамгаалалтад ашиглах тэдгээрийг сургаж бэлтгэх чадваржуулах явдал юм.

Үндсэн хэсэг:

Нэг. Боловсролын тухай ойлголт

Боловсрол гэдэг нь **Education** гэсэн англи үгнээс гаралтай боловсрол гэдэг үгийн монголчууд соёлт хүний эзэмшвэл зохих эрдэм мэдлэг, арга барил, чадвар, дадлын тогтолцоо гэж нэвтэрхий толиндоо бичжээ

Цэргийн боловсрол гэдэг нь бие хүний цэргийн алба хаах явцад олж авч байгаа цэргийн эрдэм хүмүүжил хөгжил хөгжил зэрэг олон талт үйл ажилллагааг хэлнэ.

Хилчин гэж Хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг хэлнэ.

Цэргийн боловсролыг **гүн ухаан** талаас нь авч үзвэл цэргийн хүн өнөөгийн ертөнцөд нийгмийн хөгжил боловсролын ямар хэмжээнд байж болох захирагдагсадаа удирдах тал бүрийн харицаанд зөв орж, цэргийн алба улсын хил хамгаалалтыг шинэлэг арга замаар шинэ утга санаагаар баяжуулан хамгаалах бие хүн болж төлөвших бололцоо бодит байдал зөрчлийн нэгдэлд судлах сурах, **түүхийн** талаас нь авч үзвэл хил хамгаалалтыг цэргийн үүсэл хөгжлийн үе шат тэдгээрийн харилцан хамаарал зүй тогтол уламжлалт шинж чанарыг танин мэдэж ахмад үеэрээ бахархан дууриах хүмүүжил олж авч өөрийгөө төлөвшүүлэх, сурган хүмүүжүүлэх талаас нь үзвэл цэргийн хүний амьрал хөдөлмөрийн бэлтгэлийн зайлшгүй шаардлага цэргийн эрдмийн цэгцтэй мэдлэг дадлага, цэргийн дүрмийн хэрэгцээ үр дүнгийн нэгдлээр **менежментийн талаас нь авч үзвэл** цэргийн хүн амьдрал ахуй, ажил хөдөлмөрөө төлөвлөх гүйцэтэх хянаж шалгах тодруулж зохицуулахтай холбогдон мэдлэг, дадлага, туршлагын цогц нэгдлээр авч үзвэл өргөн хүрээтэй эмх цэгцтэй боловсрол бий болно цэргийн боловсрол судлалыг эдийн засаг эрх зүй эрх зүй социологи зэрэг олон шинжлэх ухааны нэгдэлд судлах шаардлагатай Хил хамгаалах байгууллагын алба хаагчдын тулгамдаж буй гол асуудлуудын нэг яахын аргагүй сургалт буюу мэдлэг боловсролтой хүний нөөцийн асуудал юм.

Орчин үеийн их дээд сургууль нь эрдэм шинжилгээ сургалтын ажил эрхлэхийн зэрэгцээ үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад анхаардаг болсон байна энэ хандлага нь зах зээлээ мэдэрсэн эрэлт хэрэгцээнд нийцсэн сургалт эрдэм шинжилгээ судалгаа үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулахад анхаардаг болсон байна.

Монгол улсын хилийн цэргийн шинэчлэгдэж буй энэ үед чадварлаг байнгын бүрэлдэхүүн түүний дотор ахлагчийн албан хаагчдын хэрэгцээ ихсэх хандлагатай байна. Нөгөө талаар өнөөгийн ахлагчийн талаарх хууль эрх зүйн баримт бичиг шинэчлэгдэж цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоо, ахлагчийн алба хаах журам

мэргэжлийн боловсролын тухай хууль сургалтын байгууллагад зайлшгүй анхаарах шаардлагатай болж байна. Ахлагчийн сургалтыг эдгээр шаталсан тогтолцооны дагуу чанартай сургалт явуулсанаар ахлагч нарын мэдлэг боловсролын түвшин мэргэжлийн чадварт чанарын ахиц гарч хил хамгаалах байгууллагын байнгын бүрэлдэхүүний дунд тодорхой байр суурь эзэлж тэдний амжиргааны түвшин сайжрах хандлагатай юм.

1.Өнөөгийн эдийн засгийн хямралын энэ үед төсвийг хэмнэх бодлого барьж байгаа хэдий ч ахлагчийг сургаж бэлтгэх тогтолцоог цогцоор нь боловсронгуй болгох шинээр мөрдөгдөж буй дүрэм, журам, тушаал, заавартай нийцүүлж дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт ойртуулан сургалтыг зохион байгуулахад ахлагчийн сургалтын бүтэц зохион байгуулалт ажиллагсадын албан тушаалын ангилал тэдний авч буй цалин хангамжийг нэмэгдүүлснээр тэдний үүрэг хариуцлагаа ухамсарлах чадварын нэмэгдүүлэх чиглэсэн арга хэмжээнүүдийн авч хэрэгжүүлэх шаардлагатай юм.

2.Мөн Хилчин ахлагч нарыг бэлтгэх шаталсан сургалтын тогтолцоо нь тухайн мэргэжилтний цэргийн хэргийн мэдлэг чадварын түвшинг үргэлж өсгөж байхаас гадна нийгэмд зөвшөөрөгдсөн боловсролын зэргийг хангахуйц байх нь чухал.

3.Хилийн цэрэгт ахлагч бэлтгэх сургалтуудыг тогтолцооны дагуу чанартай, үр дүнтэй зохион байгууахад сургалтын түвшин бүрд тохирсон гарын авлага боловсруулан гаргах хэрэгтэй. Үүний тулд гарын авлага боловсруулах ажлын хэсгийг ДХИС-ийн сургалтын алба, ХЗДХЯ, ХХБ-ын холбогдох хэлтэсүүдтэй хамтран зохион байгуулж томилох шаардлагатай гэж үзэж байна.

Өнөөгийн цэргийн сургалтад нийгмийн хэрэгцээ шаардлагыг баримталбал мэргэжлийн чадвартай, мэргэшсэн байх, боловсролын философийн чиг хандлагыг баримталбал бие бялдарын боловсролоор дамжуулан хүнийг бүх талаар хөгжүлэх шаардлага тулгамдаж байна.

Мэргэжлийн ахлагч бэлтгэх үйл ажиллагааны үндэс нь цэргийн мэргэжлийн сургалт юм.

Батлан хамгаалахын их сургууль нь мэргэжлийн ахлагч нараа дараах байдлаар сонгон шалгаруулж авдаг

Үүнд:

Мэргэжлийнн ахлагч бэлтгэхэд сонгон шалгаруулах шалгуур

-Тухайн хүний бодгалийн шинж чанар, авъяас чадварыг тодорхойлох

-Түүний үндсэн дээр тухайн сургалтын ачаалал даах чадварыг шалгаж тухайн мэргэжлийн цэрэгт тэнцэх эсэхийг тодорхойлох зорилгтой байна. Энэ шалгуур нь дотроо

-Антропометрийн буюу бие бялдарын болон насны

-Оюуны чадавхын буюу сэтгэл зүйн

-Суурь боловсролын

- Мэргэжлийн гэх мэт төрөл хэлбэртэй тэр бүхэнд тохирсон нормативтай байна

Санал:

Судалгааны ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хилчин ахлагч нарыг сургалтад хэрэглэгдэх ном гарын авлага гаргах.
2. Гадаад орнуудын ахлагч бэлтгэх сургалтын давуу талуудыг олж илрүүлэн улмаар уг сургалтад ашиглах
3. Ахлагч нарын давтан сургалтыг жил бүр ДХИС-д зохион байгуулах
4. ҮБХИС-ийн адил хилчин ахлагч бэлтгэх дамжаанд хөдөө орон нутгаас жил бүр элсэлт авч ахлагчийн сул орон тоог нөхөх
5. Хилчин ахлагч нарын дунд шилдэг ахлагч тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулах
6. Албан тушаалын тэргүүн болон сургагч ахлагч нарын цолыг олгож тэдний идэвх санаачилгыг дээшлүүлэх зэрэг саналтай байна.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын, хилийн отряд, хилийн салбарууд нь газар орон дээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах үүрэг хүлээдэг билээ. Тэгвэл Бид улсын хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэд техник, технологийг ашиглаж байгаа хэдий ч бүрэн шилжээгүй билээ. Тухайн хилчин нь хэдий ажил хийж байгаа ч бас тэдний ар гэрийнхний нийгмийн асуудал, цалин хөлсийг ч нэмэгдүүлэх шаардлагатай юм.

Хүн бүр үндсэн хууль болон хөдөлмөрийн тухай хуульд заасан албан үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлэн, эрүүл саруул орчинд ажиллуулах нөхцөл байдлаар хангах нь байгууллагын үүрэг юм иймд байгууллага энэхүү хуулийр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэ алба хаагчдын мэдлэг боловсролд анхаарч сурч боловсрох боломж бололцоогоор хангах явдал юм.

Цэргийн тусгай мэргэжилтэн бэлтгэх сургалтын байгууллага нь ахлагчийг сургаж бэлтгэх тогтолцоог цогцоор нь боловсронгуй болгох, шинээр мөрдөгдөж буй дүрэм журам, тушаал заавартай нийцүүлж дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишигт ойртуулах, Хилийн цэргийн цаашдын чиг хандлагад нийцүүлэн ахлагч нарыг бэлтгэх шаардлагатай байна.

Хэдийгээр ахлагчийг сургаж бэлтгэх сургалтын тогтолцооны эрх зүйн орчин бүрдсэн боловч сургалтыг явуулах танхим бүрдүүлэх орчин үеийн шаардлагын түвшинд сургалтын үйл ажиллагаа явуулах цэргийн мэргэжлийн боловсон хүчний чадавхи, нөөцүүдийг бий болгох асуудалд илүү анхаарах хэрэгтэй болоод байна. Цэргийн мэргэжилтэн бэлтгэх сургалтын өнөөгийн тулгамдаж буй асуудлыг онолын хэмжээнд судлан зөвхөн сургалтын байгууллага дотооддоо сургалтыг боловсронгуй болгох арга замуудыг боловсруулах биш харин шат шатандаа хэрэгжүүлэх боломжийг гаргаж ирэх нь чухал юм.

Эцэст нь дүгнэж хэлхэд манай улсын Хил хамгаалах байгууллагын мэргэжлийн чиг хандлага өөрчлөгдөхийн зэрэгцээ үүнийг дагаад ахлагч бэлтгэх сургалтын чанар арга барил мөн адил өөрчлөгдөх ёстой иймд батллан хамгаалах их сургуулийн ахлагчийн сургууль болон адил төстэй үйл ажиллагаа явуулдаг сургуулиудтай санал хүсэлт арга туршлагаа солилцох нь зүйтэй гэж үзэж байна.

Ашигласан материал

1. Цэргийн сургалт 2008 он
2. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого УБ 2002 он
3. Офицерын сургалт-бэлтгэл 2018 он

ХИЛЧДИЙН АЛБАНЫ АЧААЛАЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙН ҮНДЭС

Ц.Билгүүн
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант,
ахлах дэслэгч

Товч агуулга: Хилчдийн албаны ачаалалыг тодорхойлох арга зүйн үндэсийг тусгав.

Түлхүүр үг: Хилчин, ажил, ажлын ачаалал, нөлөөлөх хүчин зүйл, эрүүл мэнд

Оршил

Аливаа байгууллагын удирдлагын хөгжил дэвшлийн үндсэн хүчин зүйл нь “Хүмүүн капитал” болох хүн байдаг билээ. Учир нь хүн байгалийн бүтээгдэхүүн бөгөөд цаг хугацааны явцад хөгжиж байдаг онцгой чадвартай.

Тэгвэл байгууллагын хөгжлийн гол тулгуур болсон ажилтандаа чиглэсэн оновчтой, үр дүнтэй менежмэнтийг хэрэгжүүлсэнээр тухайн байгууллагын хөгжлийн хурд тодорхойлогддог. Хүн бүр өөр өөр орчин нөхцөлд төрж өсч, аз жаргалтай, сайн сайхан амьдрах нэг л хүсэлд хөтлөгдөн өөр өөрийн боломжийг ашиглан ажиллаж амьдардаг жамтай. Хүмүүс боловсрол, мэдлэг, чадвараасаа хамаарч удирдах болон гүйцэтгэх албан тушаалд ажилладаг бөгөөд хаана эрүүл аюулгүй ажиллах, амьдрах таатай орчин нөхцөл бүрдсэн байна тэнд хүмүүс тэмүүлж байдаг. Монгол улсын хилийн тухай хуульд “Улсын хил хамгаалах байгууллага” гэж Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулах, удирдах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, түүний харьяа хилийн цэргийн анги, салбарыг;[126] “хилчин” гэж хилийн цэрэгт алба хааж байгаа цэргийн жинхэнэ алба хаагчийг;[127] гэж тодорхойлсон байдаг билээ.Тэгвэл өөрийн сонгосон мэргэжлээ дагаж, орчин үеийн хөгжил дэвшил, төв суурин газраас алслагдан, эх орондоо өргөсөн тангарагтаа үнэнчээр зүтгэж, улсын хилийн торгон шугаман дээр Монгол Улсын хилийн халдашгүй

[126] Монгол Улсын хилийн тухай хууль Уб.,2016.3.1.11 дахь заалт.
[127] Монгол Улсын хилийн тухай хууль Уб.,2016. 3.1.18 дахь заалт

дархан байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлж, ажил, амьдралаа залгуулж байгаа гавьяатай хүмүүс бол хилчид юм.

Нийгэм хурдацтай хөгжиж байгаа хэдий ч Монгол Улсын хүн амын ихэнх хувь нийслэл Улаанбаатар хотод төвлөрч, аймаг, сумын төв гэсэн дарааллаар тархан суурьшиж үүнийг даган хөгжил дэвшил төв суурин газар илүү болж, хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх бодлого, хөрөнгө оруулалт хийгддэггүйгээс хөгжлөөс хоцорч байна.

Эдгээр хөгжил дэвшлээс алслагдсан, зэлүүд, хязгаар нутаг дэвсгэрт хилчид л ажиллаж, амьдарч улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах үүргээ нэр төртэй биелүүлж байна. Өнөөгийн нийгэмд хүн бүр амьдрах газар, хөдөлмөрлөх ажлын байраа өөрөө сонгох эрхтэй бөгөөд хүн бүр л орчин үеийн техник технологи хөгжсөн, амьдрах таатай орчин, амар хялбар ажил хийхийг хүсч түүнийгээ эрэлхийлдэг. Тэгвэл улсын хил хамгаалалтыг газар орон дээр зохион байгуулах үүрэг хүлээдэг хилийн салбарууд нь бүсийн онцлог, цагийн байдлаас шалтгаалан тэдний өдөр тутмын хийгдэж буй ажил, гүйцэтгэх үүрэг албаны ачаалал харилцан адилгүй байна. Цагийн байдал өрнөлттэй хилийн цэргийн салбар, харуулын бүрэлдэхүүн нь өдөр бүр хилийн манаанд үүрэг гүйцэтгэхээс гадна зарим тохиолдолд салбарын албан тушаалтангууд дутуу томилогдоогүйгээс болж зарим албан хаагч түүнийг орлон гүйцэтгэж илүү цагаар ажиллаж байгаа нь боловсон хүчний хангалт дутмаг байгаа өнөө цаг үед хилчдийн албаны ачааллыг багасгасан техник технологийн дэвшлийг улсын хил хамгаалалтад ашиглах, нэвтрүүлэх зайлшгүй шаардлагатай юм. Улсын хилд үүрэг гүйцэтгэж байгаа хилчид нь жилийн дөрвөн улиралд цаг агаар, цаг харгалзахгүй ажиллаж амьдарч байдаг нь хил хамгаалах албаны бас нэг онцлог юм. Мөн хилийн цэргийн салбарын офицеруудад хөтлөгдөх баримт бичиг, анги, байгууллагаас шалгалт их байгаа нь албаны ачаалалыг маш их нэмэгдүүлдэг. Сүүлийн жилүүдэд улсын хилд үүрэг гүйцэтгэх офицер, ахлагчийн тоо улам цөөрч байгаад дүгнэлт хийх, хилчдийн албаны ачаалал их байгаа талаар хилчин бүр ярьдаг ч энэ талаар тодорхой судалгаа хийж, бодитой арга хэмжээ авах шаардлага тулгарч байна.

Хүн бүр үндсэн хууль болон хөдөлмөрийн тухай хуульд заасан албан үүргээ гүйцэтгэх нөхцөл бололцоо, эрүүл саруул орчинд ажлын цагийн ачааллыг тэнцүүлэн ажиллаж, амьдрах ёстой. Хилийн

цэргийн алба нь төрийн тусгай чиг үүрэг бүхий онцгой алба бөгөөд хуулиар зарим эрх нь хязгаарлагддаг хэдий ч тайван цагт улсын хилд үүрэг гүйцэтгэх алба хаагчийн албаны ачаалал, ажлын байрны орчин нь хэвийн хэмжээнд байх ёстой билээ.Гэтэл өнөөгийн байдлаар хилчдийн албаны ачаалал хуульд заасан хугацаанаас илүү, ажиллаж, амьдрах орчин алс хязгаар нутагт байгаа зэрэг өвөрмөц онцлог байгаа нь энэхүү сэдвийг судлах үндэслэл болж байна.

Нэг. Алба, албаны ачааллын тухай ойлголт

“Алба” 1. Улсын хил хамгаалах зорилтыг амжилттай биелүүлэх зорилгоор бүх шатны дарга /захирагч/, штабуудаас явуулж буй иж бүрэн арга хэмжээ.

2.Цэргийн дүрмийн дагуу зохион байгуулагддаг хилийн анги, салбаруудын өдөр тутмын үйл ажиллагаа.

3.Хил хамгаалах байгууллага, ангийн орон тооны зарим нэгж[128]

Албан хаагч: Цалин авдаг, биеийн хүчний хөдөлмөрийн бус, оюуны хөдөлмөр эрхэлдэг ажилтан

Албан тушаалтан: Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг, нийтийн эрх зүйн хүрээнд захирамжлах, зохион байгуулах бүрэн эрхийг бие даан хэрэгжүүлдэг төрийн жинхэнэ алба хаагч[129]

“Ажил” гэсэн нэр томьёоны тайлбарыг авч үзвэл Монгол хэлний их тайлбар тольд “Ямар нэг юмыг бүтээн бий болгох, бэлтгэх боловсруулах биеийн болон оюуны үйл ажиллагааг хэлнэ”.[130]

Ажил гэдэг нь хүн өөрийн хэрэглээндээ зориулан цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэг юмыг бүтээн бий болгох, бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа, хийж гүйцэтгэх зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл гэж ойлгож болно.

“Хилийн алба” Монгол Улсын хэмжээнд улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах, хилийн талаар байгуулсан олон улсын гэрээг хэрэгжүүлэх, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгслийг

---

[128] Хилийн нэр томьёоны тайлбар толь.,Уб. 2010

[130] www.mongoltoli.mn

шалган нэвтрүүлэх үүрэг бүхий алба билээ.

“Албаны ачаалал” гэдэг нь хийх ажлын хэмжээ өөрөөр хэлбэл ажлын шаардлага болон ажлын орчин нөхцөлөөс шалтгаалан бий болж, хүний бие организм, мэдрэл оюунд ямар нэг байдлаар өөрчлөлт оруулж, нөлөө үзүүлж байдаг зүйл гэж болохоор байна. Ачаалалд хүмүүс харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж, түүний дарамтыг янз бүрээр мэдэрч байдаг учраас хувь хүмүүст ачааллын үзүүлэх нөлөөг баттай тогтоох боломжгүй.

Монгол Улсын Үндэсний статискийн хорооны Статистикийн нэр томьёоны тайлбар тольд “Тухайн хүн, эдийн засгийн нэгжийн хооронд тодорхой эсхүл цаашид сунгагдах хугацаагаар цалин, хөлстэй /эсхүл холимог орлого/ ажил гүйцэтгэхийн тулд байгуулсан гэрээ /ил эсхүл далд/”[131]-г хэлнэ.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Үндэсний тооцооны системийн хүрээнд эдийн засгийн үйл ажиллагааг тодорхойлсноор “Цалин хөлс, ашиг олох зорилгоор болон өөрсдийн хэрэглээндээ зориулан эрхэлж буй үйл ажиллагааг хэлдэг”.[132]

“**Байнгын ажлын байр”** гэж ажил олгогчийн заасан ажлын байранд, тогтоосон горимын дагуу түүнээс олгосон хөдөлмөрийн багаж хэрэгслээр, ажил олгогч, эсхүл түүний төлөөлөгчийн удирдлагын дор баталсан норм, үнэлгээ, сүлжээгээр цалин хөлс авч, ажлын өдөр, ээлжийн давтамжтайгаар гүйцэтгэх ажил, үүргийг хэлнэ[133] гэж заасан байдаг. Нийгмийн хамгаалал хөдөлмөрийн яамны сайдын 2010 оны 16 дугаар тушаалаар баталсан Үндэсний ажил мэргэжлийн ангилал тодорхойлолтод Статистик нэгж болох ажлын нэг байр буюу нэг хүний хийж гүйцэтгэх зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл. Нэгж буюу нэг хүн гэдэгт ажил олгогч, ажилтан, хувираа хөдөлмөр эрхлэгч аль аль нь орох бөгөөд ажил /ажлын байр/ гэдэгт албан тушаалыг хамруулан ойлгоно.[134]

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын философич Бэртрандт Рассэлл “ажил” гэдэг дараах хоёр агуулгаар

---

[131] Үндэсний статистикийн Хороо “Статистикийн нэр томьёоны Англи-Монгол тайлбар толь” Уб.,2008

[132] Хөдөлмөрийн яам “Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт” Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын гарын авлага. Уб., 2005

[133] Хөдөлмөрийн тухай хуулийн I бүлгийн 3.1.15 дахь заалт.,

[134] Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны нэр томьёоны тайлбар толь. Уб., 2014.

тодорхойлсон.Үүнд:

- Газар хөрсөн дээр юм уу, түүнтэй ойрхон оршиж, бусад материтай холбоотой ямар нэг материйн байр байдлыг хувирган өөрчлөхөд чиглэсэн ажил.

- Хүмүүст бусад материтай холбоотой ямар нэг материйн байр байдлыг хэрхэн хувирган өөрчлөхийг хэлж зааварлах ажил. Энэ боло ажил, хөдөлмөрийн бас нэг утга болох /оюуны/ ажил юм.[135]

СудлаачН.Содномдорж “Үйлдвэрлэл үйлчилгээний зорилгыг биелүүлэхэд чиглүүлэн зарцуулж байгаа хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг хөдөлмөр” гэнэ[136] гэж тайлбарласан байна.

Эдгээр толь бичиг, олон улсын болон төрийн байгууллага, судлаачдын тодорхойлолтуудаас дүгнэн үзэхэд “ажил” гэдэг нь хүн өөрийн хэрэглээндээ зориулан цалин хөлс ,орлого олох зорилгоор ямар нэг юмыг бүтээн бий болгох, бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа, хийж гүйцэтгэх зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын нэгдэл юм.

“Ажлын ачаалал” нэр гэдэг томьёоны тайлбарыг авч үзвэл Монгол хэлний их тайлбар тольд “Ачаалал” гэдэг нь зохих хүч чадлын хэм хэмжээнд тохирох ажил үүрэг, хувь, “Ажлын ачаалал” гэдэг нь хийх ажлын хэмжээ, “Ачаалал ихдэх” гэдэг нь хийвэл зохих ажил оногдсон хэм хэмжээнээсээ хэтрэх”

Монгол Улсын стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоолоор “мэдрэл сэтгэхүйн ачаалал, бие хүний ачаалал”-ын талаар тодорхойлж түүнийг хэмжих стандарт, тооцоолох арга аргачлалыг заажээ. Үүнд:

Мэдрэл сэтгэхүйн ачаалал

Мэдээллийг хүлээн авч боловсруулах уураг тархины ба сэтгэхүйн эрхтний үйл ажиллагаа давамгайлсан ажил.

Биеийн хүчний ажлын ачаалал

Бие мах бодийн тулгуур хөдөлгөөний эрхтний үйл ажиллагаа давамгайлж, нэгж хугацаанд их хэмжээний энерги, хүч зарцуулах биеийн хүчний хөдөлмөр /ажил/ MNS 5106: 2001/, /MNS 5107:

---

[135] Russell,B “Lob Des Mubiggangs” London., 1935

[136] Н.Содномдорж “Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг” Уб., 2000

2001/[137]

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид ХБНГУ)-ын Стандарчилал, хэмжил зүйн хүрээлэнгээс гаргасан ажлын зохион байгуулалтыг сайжруулахад тавих нийтлэг шаардлагад “Ажлын ачаалал” гэж хүний биеийн ба сэтгэл зүйн байдалд ажлын байранд тавигдах шаардлагууд болон ажиллах орчин нөхцөлийн үзүүлж байгаа нөлөөллийн цогцыг хэлнэ” гэж тодорхойлжээ. /DIN EN ISO 6385.2004/[138]

Ачаалал гэж ХБНГУ-ын судлаач В.Лаурих “Биеийн хүчний болон оюуны ажил, хөдөлмөр эрхлэх үйл явц нь хүний бие организмд ямар нэгэн үр нөлөө үзүүлж байдаг бөгөөд энэхүү үр нөлөө үзүүлж байгаа хүчин зүйлийн хэмжээг ачаалал гэнэ[139] гэж тодорхойлсон.

ХБНГУ-ын судлаач Р.Бийдинг, Л.Дюринг нар “ажлын ачаалал” гэдэг нь ажлыг гүйцэтгэхэд бие организм, мэдрэл, оюун санаанд тусдаг нөлөө бөгөөд ажилтан ажлыг ажил хэрэгчээр, зорилго чиглэлтэй гүйцэтгэхийн тулд энэхүү нөлөөг тэсвэрлэх хэрэгтэй болно гэж үзсэн.[140]

ХБНГУ-ын Статистикийн ерөнхий газрын ажлын ачаалал ангиллын хүрээнд цаг хугацааны дарамт буюу илүү цагаар ажиллах ажлын цаг урт байх зэргийн оюуны болон нийгмийн ачаалал гэж үздэг байна.

Монгол Улсад ажилтан цаг хугацаанаас шалтгаалсан ажлын ачаалал үүсгэхгүй байхаар Хөдөлмөрийн тухай хуулиар зохицуулсан байдаг. Тус хуулийн долдугаар зүйлд ажилтны ердийн ажлын өдрийн үргэлжлэл 8 цаг хүртэл, долоо хоногийн ажлын цагийг 40 хүртэл цаг[141] байхаар хуульчилсан байна. Харин ажил олгогчийн санаачилгаар ажилтны хуулиар тогтоосон ажиллах цагийг хэтрүүлэн

---

[137] Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоол “Бие хүчний болон мэдрэл сэтгэхүйн ажлын ачааллын стандарт”

[138] REFA Verband ful Arbeitsstudie und Betriebsorganissation e.V.,2002

[139] http://www.ergonassist.de/belbean-gefahrdung/Belastung.pdf Laurin, W.Belastung-Beanspruchung-Konzept.2015., Retrieved from

[140] Oesterreich,R Das Belastung-BeanspruchungKonzept-Im vergleich mit arbeitspsychologischen Konzepten8 Institut fur angewandte informatik technische universitat Berlin..,2012.

[141] Төрийн албаны тухай хууль.Төрийн мэдээлэл №25. 1999

ажиллуулсан бол тус хуулийн 74-р зүйлд заасны дагуу илүү цагаар ажиллуулсан гэж үздэг. Иймд энэхүү ойлголт эрх зүйн зохицуулалт, үндэс үндэслэн ажил олгогч албан хаагчийн хуулиар тогтоосон ажиллах цагаас илүү ажиллуулах нь ажлын ачааллын нэг хэлбэр гэж үзэн ажлын ачааллын үзэл баримтлалын хүрээг тодорхойлсон байна.

Ажлын ачаалалд нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн талаар судлаач Ж.Жанчив, Герман Улсын Эдийн засаг, нийгмийн шинжлэх ухааны институт болон Робэрт Кох институтийн судалгаануудад дараах хүчин зүйлс тодорхойлсныг тодруулж хүчин зүйлийн сонголт хийхэд суурь болголоо. Үүнд:

- Ажлын нягтрал буюу хэт их ажил төлөвлөх
- Төлөвлөх боломжгүй ажлын цаг
- Мэдээлэл солилцоо муу
- Хийх ажил ойлгомжгүй, тодорхойгүй
- Цаг хугацаа болон ажлын зүтгэлийн дарамт
- Удирдлагын ойлголт, хандлага муу
- Төлөвлөөгүй ажлууд
- Ажлын гүйцэтгэл
- Ажлын байранд өсөн дэвжих боломж тааруу
- Ажлын байрны найдваргүй байдал
- Ажлын тааламжгүй уур амьсгал
- Хүнд зүйл өргөх, зөөх
- Бөхийж, тонгойж, гүйцэтгэх гэх мэт тааламжгүй байрлалаар ажиллах
- Халуун, хүйтэн, чийгтэй гэх мэт орчин нөхцөлд ажиллах
- Урт ажлын цаг
- Ажлын газар хэтэрхий хол байх
- Нэгэн хэвийн ажил
- Хэтэрхий хатуу чанга ажлын дүрэм журам
- Мэргэжлийн хэт өндөр шаардлага зэргүүдийг дурдсан байна.

Дээрхээс дүгнэхэд “ажил” гэдэг нь хүний өөрийн хэрэглээндээ зориулан цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн юмыг бүтээн бий болгох, бэлтгэх, боловсруулах үйл ажиллагаа хийж гүйцэтгэх зорилт, даалгавар, үүрэг хариуцлагын нэгдмэл юм байна.

Ажлын ачаалал гэдэг нь хийх ажлын хэмжээ юм. Өөрөөр хэлбэл ажлын шаардлага, ажлын орчин, нөхцөлөөс шалтгаалан бие болж хүний организм, мэдрэл, оюунд ямар нэгэн байдлаар өөрчлөлт оруулж, нөлөө үзүүлж байдаг зүйл гэж үзэж болохоор байна.

Ачаалалд хүмүүс харилцан адилгүй хариу үйлдэл үзүүлж, түүний дарамтыг янз бүрээр мэдэрч байдаг учраас хувь хүмүүст ачааллын үзүүлэх нөлөөг баттай тогтоох боломжгүй. Харин ажлын байран дахь ачаалал нь ажлын байрны зохион байгуулалт, ажлын орчин нөхцөл эсвэл ажилтай холбоотой нийгмийн харилцаа холбоотойгоор ажлын байр болгонд харилцан адилгүй хэмжээгээр бий болдог гэж дүгнэж байна.

Хоёр.Хилчдийн энерги зарцуулалт, албаны ачааллын тухай харьцуулсан судалгаа

Энэ нь бодисын үндсэн солилцоо, “хоолны өвөрмөц үйлчлэл”, хөдөлмөр гэсэн үндсэн гурван бүрэлдэхүүнтэй. Эдгээрийг нийтэд нь **энерги зарцуулалт**[142] гэж нэрлэдэг.

Манай хилчид хоногийн 24 цагийн турш сэтгэл зүй, орчны харилцан адилгүй нөхцөлд байгаль цаг уурын ямар ч бэрхшээл сорилтыг үл харгалзан явган эсвэл төрөл бүрийн унаа (машин, мотоцикль, цасны чарга, завь, морь, тэмээ) хэрэглэж Монгол Улсын дархан хилийг амгалан тайван байлгах албан үүргээ гүйцэтгэдэг.

Хилийн манаа нь тухайн цагийн байдалд агшин зуурт дүгнэлт хийж, шийдвэр гаргадаг онцлогтой байдаг. Хилчдийн эх орныхоо өмнө хүлээсэн эрхэм үүргээ нэр төртэй, амжилттай биелүүлэхэд нь чухлаар нөлөөлөх хүчин зүйлсийн нэг нь тэдний эрхэлж буй алба, нас хүйс, бие махбодын онцлогт нь тохирсон зайлшгүй шаардагдах энергийн хэмжээг байнга нөхөн сэргээж байх явдал юм.

Хилчдийн ачааллын төвшинг дараах арга хэрэглэж тогтооно.Үүнд:

Нэгдүгээрт, бүх төрлийнн хөдөлмөр хийхэд зарцуулсан хугацааг цаг минутийн нарийвчлалтай хэмжинэ: Хоёрдугаарт, тухайн хөдөлмөрт зарцуулсан энерги үнэлгээг[143] (*Аливаа хөдөлмөр хийхэд тодорхой энерги зарцуулалт шаардагдана. Энергийн тэр хэмжээг хугацаагаар илэрхийлэхийг энерги үнэлгээ гэнэ. Жишээ нь цамц индүүдэхэд нэг минутад 5.97 кдж, цонх цэвэрлэхэд 12.36 кдж” энерги тус тус зардаг. Энэ бол тэдгээр ажлын энерги үнэлгээ юм),* Гуравдугаарт нийт өдөр шөнийн туршид зарцуулсан энергийн үнэлгээг хооронд нь нэмж гаргана. Ингээд **хөдөлмөрийн ачааллын коэффициентийг** тооцож гаргана.

---

[142] Монгол Улсын хилчдийн энерги зарцуулалт. Уб 2003

[143] Монгол Улсын хилчдийн энерги зарцуулалт., Уб. 2003

Хөдөлмөрийн ачааллын коэффициент нь тухайн ажлыг гүйцэтгэхэд зарцуулсан нэг минутад ноогдох энерги үнэлгээг нэг минутад ноогдох бодисын үндсэн солилцооны энерги үнэлгээнд хуваж гаргана.

Эндээс хөдөлмөрийн ачааллын төвшинг хоногийн 2 цагт тухайн хүнд шаардагдах бодисын үндсэн солилцоонд хуваж гаргана.

Хөдөлмөрийн ачааллын коэффициент 1.0-2.5 бол хөнгөн, 2.6-3.9 бол дунд, 4 ба түүнээс дээш бол хүнд хөдөлмөр эрхэлдэгт тооцогдоно.

Ажил хийж байгаад засварласан бол хөдөлмөрийн ачааллын бүх төрөлд хөдөлмөрийн ачааллын коэффициент эрэгтэй хүнд 1.54, эмэгтэй хүнд 1.68 гэж тооцно. Ажлын дундуур завсарласан хугацаа нийт ажилд зарцуулсан хугацааны 75% бол хөнгөн, 25% бол дунд, 40% бол хүнд хөдөлмөр эрхэлсэн гэж үздэг (James and Schofield,1990). Хөдөлмөрийн ачааллын төвшинг нэгж хугацаан дахь зүрхний лугшилтын тоо 90-ээс доош бол хөнгөн, 91-100 бол дунд зэрэг, 100-120 бол хүнд, 120 дээш бол маш хүнд ачаалалтай ажил гэж үзнэ.[144]

Хилчдийн хөдөлмөрийн төрлийг дараах аргаар тогтоосон. Судалгаа хийсэн хоногуудад хилчдийн амралтын нэг, ажлын 2 хоногт хийж гүйцэтгэсэн бүх хөдөлмөрийг минут-минутын нарийвчлалтайгаар өөрсдөөр нь тэмдэглүүлсэн мэдээлэл ашиглан хилчдийн хөдөлмөрийг дотор нь хөнгөн, дунд зэрэг, хүнд хөдөлмөр гэж үндсэн гурван төрөлд хуваж үзсэн.

Ийм гурван төрөлд ангилагдсан хөдөлмөрийн төрлөөс жишээ болгон Хүснэгт №6-д үзүүлэв.

Хилчдийн үндсэн 3 төрлийн хөдөлмөр хоногийн 24 цагт яаж хуваарилагдаж байгааг тогтоох зорилгоор хөдөлмөрийн ачааллын төвшинг таван- суваг бүхий Mini-Logger Series 2000 (Mini-Mitter CO., Sun River, OR) амбулаторын жижиг мониторинг багаж ашиглан хэмжсэн[145].

Хүснэгт №6

Хилчдийн гүйцэтгэж байгаа хөдөлмөрийн төрөл

Хөнгөн	Дунд зэрэг	Хүнд

[145] Монгол Улсын хилчдийн энерги зарцуулалт.,Уб 2003

Суугаа үйлдлүүд (ТВ үзэх, ном сонин унших г.м)	5-6 км/цагийн хурдтай тэгш газарт алхах	15-25 орчим кг ачаатай 5-6 км/цагийн хурдтай хурдан алхах
Гутал тосолж цэвэрлэх, зэвсэг арчиж цэвэрлэх	5-6 км/цагийн хурдтай өгсүүр газар алхах	Тэгш газ км/цаг орчим хурдтай гүйх,
3-4 км/цагийн хурдтай тэгш газар алхах үйлдлүүд	Захирагч, захирагдагчийн ёслох үйлдлүүд отряд, застав нэгдэх үйл ажиллагаа	5.5 км/цагийн хурдтай маршаар гүйх, “буундаа”, “гал” командаар ажиллах
Шал шүүрдэж цэвэрлэх	Буудлагын дасгал сургууль хийх	Цэргийн жагсаалын бүх төрлийн бэлтгэл сургууль
Хувцас угаах, индүүдэх	5 км/цагийн хурдтай маршаар алхах	Биеийн тамирын бүх төрлийн дасгал сургууль хийх
Усанд орох	20-30 кг ачаатай алхах	Бүрэн зэвсэг хэрэгсэлтэй маршаар явах
Хувцсаа өмсөх, тайлах, унтахаар орондоо орох, орноос босох	Шөнийн хилийн цагийн манаа, сэргийлэх манаа, цагийн манаа, харуул, заставын жижүүр үүрэг гүйцэтгэх	Хилийн эрлийн үед үүрэг гүйцэтгэх бүх үйл ажиллагаа
Нэмэлт ачаагүй, уулын уруу болон тэгш газраар алхах	5-6 км/цагийн хурдтай 20 орчим кг ачаатай алхах үйлдлүүд	Уул өөд өгсөж явах
4-5 км/цагийн хурдтай, тэгш гадаргаар 20 орчим кг ачаатай алхах	Гар худгаас ус авахаар явах, ус хутгаж саванд хийх, буцаж устай авчрах	20 орчим кг ачаатай, 7-8 км цагийн хурдтай явах

Ийм замаар өвлийн улиралд нийт 35458 минут (591 цаг буюу 25 өдөр), зуны улиралд 26609 минутын (443 цаг буюу 18 өдөр) зүрхний лугшилтын давтамжийн мэдээлэл цугларсан болно.

Хилчдийн албаны ачаалалд нөлөөлж буй хүчин зүйлс:

- Хүн хүч дутмаг
- Дэд бүтэц хөгжөөгүй
- Урт ажлын цаг
- Ажлын зүтгэлийн дарамт
- Мэргэжлийн хэт өндөр шаардлага
- Ажлын гүйцэтгэл зэрэг зүйлүүд маш их нөлөөлж байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт “Цалин хөлс” нь үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал урамшууллаас бүрдэнэ” гэж 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэгт “Ажилтанд үндсэн цалин дээр нь ажлын үр дүнгээр нэмэгдэл хөлс олгож болно” гэж, 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт “Шөнийн цагаар

ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол түүнд олгох нэмэгдүүлсэн цалин хөлсийг хамтын ба хөдөлмөрийн гэрээгээр зохицуулна”[146] гэж, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3 дахь хэсэгт “тусгай албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цол, зэрэг дэвийн, докторын, мэргэшлийн зэргийн нэмэгдлээс бүрдэнэ” гэж тус тус заасан байдаг.

Орчин үед хил хамгаалах алба нь уламжлалт хил хамгаалалтаас илүү техник, технологийн дэвшлийг нэвтрүүлсэн хүн хүчний ачааллыг багасгасан инженерийн төхөөрөмжийг хил хамгаалалтад ашиглах шаардлага урган гарч ирж байгаа юм. Хилчдийн алба, үйл ажиллагаанд нөлөөлж буй хүчин зүйлсээс харвал хүн хүч дутмаг, хэт их бичиг баримт, албаны шалгалт зэрэг их байгаа нь одоо үед залуучууд гарч байгаа бас нэг шалтгаан нөхцөл болж байна. Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны 90 хувь нь улсын хилд буюу хилийн зурвас, бүсэд явагддаг бөгөөд хилийн заставын бие бүрэлдэхүүн нь алба хаах хугацаандаа хилийн зурваст, ажиллаж амьдардаг.

Хилчид нь 25 жил цэргийн алба хааж цэргийн тэтгэвэр тогтоолгодог. Ингэхдээ хилийн харуул, хилийн застав, хилийн отряд, хил хамгаалах ерөнхий газар гэсэн нэгж, салбар, анги, байгууллагад шатлан дэвших зарчмаар алба хаадаг. Харин хилийн харуулын дарга нь энэ хугацааг бүгдийг нь хилийн харуул, застав дээр үүрэг гүйцэтгэдэг онцлогтой.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад эрэгтэй хүний дундаж наслалт 55 байгаа бөгөөд харуулын дарга нь өөрийн амьдралын 25 жилийг улсын хилийн халдашгүй дархан байдлыг хамгаалахад зориулан улсын хил дээр ажиллаж, амьдарч байна. Энэ нь түүний амьдралын 45.4 хувийг эзэлж байна.

Мөн хилийн заставт үүрэг гүйцэтгэж буй хилчид хилийн заставт хилийн манаа, заставын жижүүр, заставын цагийн манаа зэрэгт үүрэг гүйцэтгэж нойргүй хонох нь ч бий.

Тэгвэл нэг хоногийн нойр дутуу байснаар хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлөхийг авч үзье.

---

[146] Хөдөлмөрийн тухай хууль. Төрийн мэдээлэл.№25.1999

СЭМҮТ-ийн их эмч Ж.Гантулгаас тодруулахад: Тэрбээр “Нойр нь хүний амьдралын хамгийн чухал хэрэгцээ. Эрүүл сэтгэл зүйтэй амьдаръя гэвэл өдөрт 6-8 цаг сайтар унтаж амарч байх нь зүйтэй. Нойрыг ялан дийлэх гэж хичээх хэрэггүй. Үр дүнтэй ажиллаж суралцья, сэтгэл хангалуун амьдаръя гэвэл сайн унтаж амарч, тархи толгойгоо амраах нь чухал.

Сүүлд гаргасан судалгаанаас харахад нойр дутуу явсан хүн **тэнэгрэл буюу альцгеймер** өвчинд өртөх эрсдэл өндөр байна. Өөрөөр хэлбэл, нойргүй хоносон хүнийг сайн унтаж амардаг хүнтэй харьцуулахад альцгеймерийн өвчинд өртөх эрсдэл 2-3 дахин илүү байна. Унтаагүй хоносон шөнө болгон, нойр дутуу явсан хором бүрд бидний мэдрэлийн эсүүд хэзээ ч дахин сэргэхгүйгээр устаж байдаг гэжээ. Иймд хоногийн турш жижүүр, харуул хамгаалалт, хилийн цагийн манаанд үүрэг гүйцэтгэж байгаа хилчид минь мэдрэлийн маш олон эд эсээ гэмтээн,устгаж, эрүүл мэндээрээ хохирон үүрэг гүйцэтгэж байгаад дүгнэлт хийх цаг аль хэдийн болжээ.

Дүгнэлт

Хил хамгаалах байгууллагын хилийн салбарууд нь газар орон дээр улсын хил хамгаалалтыг зохион байгуулах үүрэг хүлээдэг билээ. Тэгвэл бүсийн онцлог, цагийн байдлаас шалтгаалан тэдний өдөр тутмын хийгдэж буй ажил, гүйцэтгэх үүрэг албаны ачаалал харилцан адилгүй байна. Бид улсын хил хамгаалалтад орчин үеийн дэвшилтэд техник, технологийг ашиглаж байгаа хэдий ч бүрэн шилжээгүй билээ. Сүүлийн жилүүдэд боловсон хүчин, хүн хүчний хангалт багасаж байгаа нь үлдэн үүрэг гүйцэтгэж байгаа хилчдийн ажлын ачаалал маш их нэмэгдэж байна. Үүнтэй холбогдуулан залуу боловсон хүчин албанаас бэрхшээх, ажлаасаа гарах, өндөр цалинтай өөр байгууллага руу шилжин ажиллаж байгаа нь хил хамгаалах боловсон хүчний дутагдалд оруулах нэг гол хүчин зүйл болж байна гэж дүгнэж байна.

Санал:

Судалгааны ажлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна.

1. Хилийн заставт үүрэг гүйцэтгэж байгаа хилчидэд жил бүр эмнэлгийн нэгдсэн үзлэг эрт илрүүлэгт заавал хамруулдаг байх.
2. Хилчдийн албаны ачааллыг багасгасан техник хэрэгслийг хил

хамгаалалтад түлхүү ашиглах
3. Хилийн заставт албан тушаалтнуудын сул орон тоог шуурхай нөхөх
4. Хил хамгаалах байгууллагын хэмжээнд амралт ачааллыг хянадаг нэгдсэн программтай болох

Ашигласан материал

1. Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлийн 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 87 дугаар тогтоол “Бие хүчний болон мэдрэл сэтгэхүйн ажлын ачааллын стандарт”
2. Үндэсний статистикийн Хороо “Статистикийн нэр томьёоны Англи-Монгол тайлбар толь” УБ.,2008
3. Хөдөлмөрийн яам “Хөдөлмөрийн зах зээлийн үндсэн үзүүлэлт” Хөдөлмөрийн салбарын ажилтнуудын гарын авлага. УБ., 2005
4. Russell,B “Lob Des Mubiggangs” London., 1935
5. Н.Содномдорж “Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг” УБ., 2000
6. Oesterreich,R Das Belastung-BeanspruchungKonzept-Im vergleich mit arbeitspsychologischen Konzepten8 Institut fur angewandte informatik technische universitat Berlin..,2012.
7. Монгол Улсын хилийн тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль. Төрийн мэдээлэл.№25.1999
9. www.mongoltoli.mn
10. Н.Содномдорж “Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг” Уб., 2000

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГАД ҮЙЛДЭГДЭЖ БУЙ ГЭМТ ХЭРЭГ, СЭТГЭЛ ЗҮЙН УЧИР ШАЛТГААН

Ц.Анхбаяр
Хилийн албаны сургуулийн
Хил судлалын магистрант, ахмад

Түлхүүр үг: Хил хамгаалах байгууллагад алба хааж буй цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн дасан зохицох байдал, гэрээт болон хугацаат цэргийн албан хаагчдын сэтгэл зүйн байдал:

Товч агуулга: Орчин цагийн хил хамгаалах байгууллагад алба хааж буй цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн хандлага албан тушаалтны мэдлэг, ур чадвар чухлаар тавигдаж байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд хил хамгаалах байгууллагын хил хамгаалалтын алба хаагчдын сэтгэл санаа тогтворгүй байдлаас гэмт хэрэгт холбогдох, сахилгын зөрчил гаргах зэрэг сөрөг зүйлс гарч байгаатай холбоотойгоор тэдний сэтгэл зүйг тогтвортой байлгах арга замыг судлах шаардлага гарч байна. Мөн улсын гүйцэтгэх үүргийн онцлог, албаны ачаалал, алба хаагчдын бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг хангах, албаны үйл ажиллагааг тасралтгүй, тогтвортой, найдвартай явуулахын тулд алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлийг шинжлэх ухааны үндэслэлтэй уялдуулан хангах явдалыг дээшлүүлэх, гэмт хэрэг, сахилга хариуцлага гарахаас урьдчилан сэргийлэх зайлшгүй шаардлагатай байна.

Нэг: Удиртгал хэсэг: Хилийн цэргийн хэмжээнд хилчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын хилийн тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль, “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, “Сахилга хариуцлагыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Цэргийн нийтлэг дүрмүүд, ХХЕГ-ын даргын 2016 оны А/30, 2019 оны А/14, 2021 оны А/21, 22, 23, 24 дүгээр тушаалуудыг үндсэн удирдлага болгон дараах арга хэмжээг зохион байгуулж байна. Хилийн цэргийн хэмжээнд 2011-2021 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар: Хилийн анги, тусгай салбаруудад гэмт хэрэг, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн хангалтын ажлыг эрчимжүүлэх зорилгоор 2012 онд “Хилийн цэргийн хэмжээнд явуулах социологийн судалгааны арга, аргачлал”, 2013 онд “Хилийн цэргийн хэмжээнд

социологийн судалгаа явуулах аргачлал”, 2015 онд “Хилчдээс авах социологийн судалгааны түгээмэл асуулт, сорил, сонжоо, асуулгын эмхтгэл”, ХЦАХ-дын дунд зохион байгуулах “Ухуулга, хүмүүжлийн ярианы сэдэв” эмхтгэл, “Шинэ дайчдын сургалтын төвд зохион байгуулах СМССА-ын зөвлөмж, аргачлал”, 2016 онд “Сэтгэл зүйн бэлтгэлийн гарын авлага”, 2018 онд “Сэтгэл зүйн гарын авлага”, “ХЦАХ-дын дасан зохицол, айдас, түгшүүрийн зэргийг тодорхойлох аргачлал”, “Хилийн манааны сэтгэл зүйн тохироог бүрдүүлэх аргачлал”, 2021 онд “Хугацаат цэргийн алба хаагчдад сэтгэл зүйн хангалт зохион байгуулах аргачлал”, “Бие бүрэлдэхүүнд танин мэдэхүй-эрх зүйн сургалт явуулах аргачлал”- ыг тус тус боловсруулж, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

Хоёр: Хилийн цэргийн алба хаагчдын гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлж буй хүчин зүйл.

Хүчин зүйл (factor) нь ямар нэгэн үзэгдэл, үйл явцын учир шалтгаан, хөдөлгөгч хүч, нөхцөл байдал мөн. Социологийн шинжлэх ухааны плюрализмын нэг илрэл болсон “Хүчин зүйлийн онол” нь нийгмийн түүхэн хөгжлийг нийгэм, соёл, эдийн засаг, оюун санаа, газарзүй болон үндэстний онцлог зэрэг адил ач холбогдол бүхий янз бүрийн хүчин зүйлүүдийн харилцан үйлчлэлийн үр дүн мөн гэж үздэг.

Хилийн цэрэг нь хилийн алба хаагч гэмт хэрэг үйлдэхээс, гэмт хэрэгт хохирохоос урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохиож ирсэн байна. Хилийн цэргийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажиллагааг хэрэгжүүлж буй нэгжийн бүтэц, зохион байгуулалт[147]

Хил хамгаалах ерөнхий газарт ёс зүйн зөвлөл, хилийн ангид ёс зүйн салбар зөвлөл байх бөгөөд тэдгээр нь Төрийн албаны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, Хилийн цэргийн алба хаагчдын ёс зүйн дүрэм, Монгол Улсын цэргийн нийтлэг дүрэм, ёс зүйтэй холбогдуулан гарсан эрх зүйн баримт бичгүүд, энэ журмыг удирдлага болгон ажилладаг байна.

Хилийн цэргийн хэмжээнд хилчдийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг Монгол Улсын Хилийн тухай, Цэргийн албаны тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Төрийн албаны тухай, Төрийн болон албаны нууцын тухай хууль, “Сахилга хариуцлага, дэг журмыг

чангатгах тухай” Монгол Улсын засгийн газрын 01 дүгээр албан даалгавар, “Сахилга хариуцлагыг чангатгах тухай" 258 дугаар тогтоол, Цэргийн нийтлэг дүрмүүд, ХХЕГ-ын даргын 2016 оны А/30, 2019 оны А/14, 2021 оны А/21, 22, 23, 24 дүгээр тушаалуудыг үндсэн удирдлага болгон дараах арга хэмжээг зохион байгуулж байна.

Хилийн цэргийн алба хаагчдын ёс зүйн дүрмийг 2011, 2016, 2019 онуудад холбогдох хууль, дүрэм, тушаалын өөрчлөлтөд нийцүүлэн шинэчлэн боловсруулж, “Ёс зүйн зөвлөл”, салбар зөвлөлийн үйл ажиллагааг хилчдийн ёс зүйг төлөвшүүлэх, болзошгүй гэмт хэрэг, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чиглүүлэн ажиллаж байна.

Хилийн анги, тусгай салбарууд орон нутгийн хууль, хяналтын байгууллага, хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газартай хамтран алба хаагчдад хууль, эрх зүйн боловсрол олгох, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хөгжлийг дэмжих, сэтгэл зүйн боловсрол олгох чиглэлээр хамтран ажиллаж, улирал тутам сургалт, сурталчилгааны арга хэмжээг зохион байгуулж байна.

Ёс зүйн салбар зөвлөлүүдээс хүний эрхийг хамгаалах, иргэдийг соён гэгээрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, хувь хүмүүстэй хамтарч бие бүрэлдэхүүний ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах талаарх сургалтыг жил бүр зохион байгуулсан.

Хилийн цэргийн алба хаагчдын ёс зүйн дүрэм, гэмт хэрэг, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай холбогдох эрх зүйн актуудаар гарын авлага боловсруулж, аудио хэлбэрт буулган хилийн анги, тусгай салбарын бие бүрэлдэхүүнд хүргэсэн.

Хилийн цэргийн хэмжээнд ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг тандах судалгааг ёс зүйн зөвлөлөөс жил бүр, салбар зөвлөлөөс хагас жил тутам авч, үр дүнг тооцсон.

Хилийн анги, тусгай салбаруудад “Цэргийн сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг улирал бүр зохион байгуулж, алба хаагчдын сахилга, хариуцлагын байдалд дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, уриалга, зөвлөмж гарган ажилласан.

Бие бүрэлдэхүүнээс сахилга ёс зүйн зөрчилд холбогдож болзошгүй алба хаагчдын судалгааг жил бүр гаргаж, тэдэнтэй ганцаарчилсан уулзалт хийх, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх,

удирдлагын бодлого шийдвэр, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актуудаар сургалт, сурталчилгаа явуулах зэрэг арга хэмжээнүүдийг сар бүр зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллаж байна.

Гурав: Хилийн цэргийн алба хаагчдтай зохион байгуулсан сэтгэл зүйн ажлын чиглэлээр:

Бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг мэргэжлийн түвшинд үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор хилийн 15 ангид сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээний өрөөг байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулсан байна.

Хилийн цэргээс бие бүрэлдэхүүний нийгмийн болон албанд тулгамдаж буй асуудлыг тодорхойлох, албаны үйл ажиллагаанд гарч буй ололт, дутагдлыг илрүүлэх, санал хүсэлтийг сонсох зорилгоор хагас жилд нэг удаа, хилийн анги, тусгай салбарт улирал бүр, хилийн салбарт сар бүр социологийн судалгаа авч, судалгааны мөрөөр төрөл бүрийн арга хэмжээг авч хэрэгжүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан.

Цэргийн албанд татагдан ирсэн иргэдийг судлах “Сэтгэл зүйн баг” ажиллуулж, судалгааны үр дүнг тухай бүр нь удирдлагад танилцуулан, болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй зохион байгуулсан байна.

“Илтгэгч, сэтгэл зүйч” нарын орон тооны бус бүлгийг 2015 оноос байгуулж, улирал бүр хилийн салбар, харуул, малын суурьт үүрэг гүйцэтгүүлэн хууль, тогтоомж, удирдлагын тушаал, шийдвэрийг сурталчлах, алба хаагчидтай бүлгийн ганцаарчилсан уулзалт зохион байгуулж, сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх ажлуудыг зохион байгуулан Хилийн цэргийн хэмжээнд 2021 оны байдлаар илтгэгч, сэтгэл зүйчдийн 29 бүлэгт, 544 алба хаагч томилогдон ажилласан.

Бие бүрэлдэхүүний сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ёс зүйг төлөвшүүлэх ажлын хүрээнд 2017 онд “Сахилга бат аюулгүй ажиллагаа", 2020 онд “Гэмт хэрэг, зөрчилгүй хамт олон” аянуудыг 3-6 сарын хугацаатай зохион байгуулж, сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх сургалт, сурталчилгааны цогц арга хэмжээг үр дүнтэйгээр хэрэгжүүлсэн.

Хилийн цэргийн 2021 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтийг хангах зорилгоор “Стрессгүй ажлын байр” аяныг 2021 оны 02 дугаар

сарын 01-ний өдрөөс эхлэн 2 үе шаттайгаар зохион байгуулан ажиллаж байна.

Хилийн анги, тусгай салбарын бие бүрэлдэхүүний сэтгэл зүйн хэв шинж, зан төрхийн өөрчлөлтийг тодорхойлох, алба хаах хугацааны уулзалт, ярилцлагын тэмдэглэл бүхий сэтгэл зүйн картыг хүн нэг бүрт нээж, алба үйл ажиллагаанд удирдлага болгон ажиллаж байна.

Хилийн цэрэгт ажилд орох хүсэлт гаргасан иргэдийн сэтгэл зүйг судлах, дүгнэлт хийх зорилгоор бие хүний болон хувь хүний зан араншинг тодорхойлох проектив арга, Льюшер, MBTI, MMPI, Зан төлөвийн акцентуаци гэсэн 5 төрлөөр сэтгэл зүйн сорил судалгаа авч, сонгон шалгаруулах комисст санал дүгнэлтийг хүргэж ажилласан.

Санал

1.4. Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.3 хэсэгт: Хилийн цэрэгт хугацаат цэргийн алба хаах иргэнд тавигдах шаардлагыг нэмж оруулах, Үүнд:“...ял шийтгэл эдлэж байгаагүй, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодисын хамааралгүй иргэнийг хилийн цэрэгт алба хаалгана” гэсэн нэмэлт өөрчлөлт хийх;

1.5. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 5 дахь заалтад: “Хилийн цэргийн албан хаагчийн (хилийн бүс, зурваст) үйлдсэн гэмт хэрэгт Хилийн цэргийн хэрэг бүртгэх алба мөрдөн шалгах ажиллагаа явуулна” гэсэн нэмэлт оруулах;

1.6. Монгол Улсын Хилийн тухай хууль 2016 онд батлагдан, 2017 оноос хэрэгжих эхэлсэн бөгөөд Хил хамгаалалтын дүрмийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дээрх хуульд нийцүүлэх шаардлагатай байна.

Дүгнэлт

Хилийн цэргийн алба хаагчдаас үйлдсэн гэмт хэрэг, түүний шалтгаан, нөхцөл, хүчин зүйлийг тодорхойлох зорилгоор явуулсан судалгааны ажлын үр дүнд үндэслэн дараах дүгнэлтэд хүрэв. Үүнд:

Энэ нь хилийн цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн түвшин Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа ижил төсөөтэй салбарынхаас доогуур байна.

2. Сүүлийн 10 жилийн хугацаанд хилийн цэргийн нийт 290 алба хаагч гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд болон бусад

байдлаар хохирсон бөгөөд тэдгээрийн 62 буюу 21.4% нь бусдын бие махбодид гэмтэл учруулах, 57 буюу 19.7% нь бусдын эд хөрөнгө хулгайлах, 28 буюу 9.7%-ийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн хохирогч болжээ. Энэ нь, гол төлөв, ажил үүрэгтээ хайнга хандах, бие биетэйгээ дүрмийн бусаар харилцах зэргээс үүдэлтэй байна.

3. 2010-2021 онд үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн 51.7% нь тал хээрийн болон уулын бүсэд үйлдсэн нь хилийн цэргийн албан хаагч гэмт хэрэг, зөрчил үйлдэхэд газар орон, цаг агаарын эрс тэс нөхцөл, алслагдсан байдал, ахуйн орчин зэрэг нь тодорхой хэмжээгээр нөлөөлөх хүчин зүйл болжээ.

4. Нийт гэмт хэрэг, зөрчилд холбогдогсдын 25.9%-ийг офицер, 35.9%-ийг ахлагч, 29.4%-ийг хугацаат цэргийн алба хаагч, 7.9%-ийг гэрээт цэргийн алба хаагч, мөн харилцааны зөрчлийн 27.1%-ийг офицер, 34.5%-ийг ахлагч, 33.6%-ийг хугацаат цэргийн алба хаагч, 3.7%-ийг гэрээт цэргийн алба хаагч байгаа нь офицер, ахлагч, хугацаат цэргийн алба хаагчдын эзлэх хувийн жин өндөр, харин гэрээт цэргийн алба хаагчдын эзлэх хувийн жин бага байгааг харуулж байна.

5. Архидан согтуурах зөрчлийн 29%-ийг офицер, 51%-ийг ахлагч, 12%-ийг гэрээт цэргийн алба хаагч, 5%-ийг хугацаат цэргийн алба хаагч үйлдсэн байгаа нь офицер, ахлагчийн эзлэх хувийн жин өндөр байгааг харуулж байна.

6. Хилийн цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийг шүүхээр шийдвэрлэсэн байдлаас үзэхэд, 42 хэрэгт 42 алба хаагч ял шийтгүүлж, 26 алба хаагч хохирчээ. Ял шийтгүүлсэн алба хаагчдын 16.6% нь өмнө ял эдэлж байсан нь хилийн цэргийн алба хаагч болон хугацаат цэргийн албанд татагдаж ирсэн иргэдийн дунд ял шийтгүүлсэн хүмүүс байсныг харуулж байна.

7. Судалгааны ажлын хүрээнд хилийн цэргийн хойд болон өмнөд хилд байрлаж буй 3 хилийн анги, 8 хилийн салбар, 3 хилийн харуул, 1 малын суурийн нийт 220 хугацаат цэргийн алба хаагч, 91 офицер, 53 гэрээт цэргийн алба хаагч, ахлагч нараас анкетын аргаар социологийн судалгаа авахад, хугацаат цэргийн алба хаагчдын 86% нь 19-21 насны хүмүүс байсан бөгөөд тэдгээрийн 57% нь сэтгэл санааны хямралтай, 22% нь хэт их ачаалалтай, 4% нь дүрмийн бус харилцаанд өртөж байсан, 5.5% нь дүрмийн бус харилцаанаас болж

үзэн ядах, өс санах сэдэл үүсдэг гэж хариулсан байна. Үүнээс үзэхэд, хилчдийн дунд албаны хэт их ачаалал, дүрмийн бус харилцаа нь сэтгэл санааны хямрал, тогтворгүй байдал үүсэхэд нөлөөлжээ.

8. Хилийн цэргийн офицер, ахлагч нараас авсан судалгаанаас үзэхэд, цэргийн албанд татагдан ирж буй залуус суурь хүмүүжлийн доголдолтой, боловсрол бага, бие бялдрын болон сэтгэл зүйн бэлтгэлгүй, гаж зуршилтай (хар тамхи, тоглоомын болон дэлгэцийн донтой) гэж хариулсан бол, хугацаат цэргийн алба хаагчид нь албаны ачаалал их, аж ахуйн ажил их хийлгэдэг, ахлагч нарын боловсрол бага, дүрмийн бусаар харилцдаг гэж хариулжээ. Энэ нь хугацаат цэргийн алба хаагчдын боловсрол нимгэн, суурь хүмүүжил тааруу байгааг харуулж байна.

9. Хил дээр алба хааж буй хугацаат цэргийн алба хаагчид сэтгэл санааны хямралд орон шантарч, улмаар цэргийн албанаас оргох, гэмт хэрэг үйлдэх санаа, сэдэл төрдөг талаараа дурьдсан нь тэдний орчиндоо дасан зохицох чадваргүйтэй холбоотой байна.

10. Хугацаат цэргийн албанд татагдан ирсэн хүмүүсийн зарим нь гэмт хэрэг үйлдэн шалгагдаж байсны улмаас болон эрүүл мэндийн хувьд тэнцэхгүй иргэдийг хилийн ангиас буцаадаг нь цэргийн албанд татагдагсан иргэдийн бүртгэл, судалгаа хангалтгүйг харуулж байна. Түүнчлэн, сэтгэцэд нөлөөт болон мансууруулах бодис хэрэглэдэг, гаж зуршилтай, бүтэн өнчин зэрэг хугацаат цэргийн алба хаагчдыг хилийн ангийн төвд алба хаалган, хараа хяналтдаа байлгадгаас хилийн застав, харуулд үүрэг гүйцэтгэх хүн хүчний хомсдол үүсгэж, алба хаагчдын ачааллыг нэмэгдүүлж байна.

11. Ковид-19 цар тахалтай холбоотойгоор 2020 оны 2 дугаар ээлж, 2021 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлага явагдаагүйгээс ажлын ачаалал нэмэгдсэн байна.

12. Судалгаанд хамрагдсан ахлагч, гэрээт цэргийн алба хаагчдын 45% нь 19-23 насныхан, тэдгээрийн 22% нь хүн хүчний дутагдалтай байдлаас болж 10-аас дээш хоногоор хилийн харуул, манаанд үүрэг гүйцэтгэдэг, 50% нь хилийн застав, харуул дээр үүрэг гүйцэтгэхэд сэтгэл санаа нь байнга хямардаг, 17% нь стресс бухимдлын түвшин өндөр байдаг гэжээ.

Энэ нь анхан шатны нэгж дээр үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагч удаан хугацаанд нийгмийн харилцаанаас тусгаарлагдан, сэтгэл зүйн тогтворгүй байдалд ордог болохыг харуулж байна.

13. Хилийн цэргийн алба хаагчдын үйлдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийн талаар хамгийн их хандалттай 50 сайтад гарсан 20 нийтлэл, 15 сурвалжлага, 50 мэдээ, 15 ярилцлага, эдгээр мэдээлэлтэй холбоотой 500 орчим хандалт, сэтгэгдлийн хүрээнд контент анализ хийж үзэхэд, иргэдийн нэг хэсэг нь цэргийн албанд татагдан явж буй залуус боловсрол нимгэн, бие бялдарын хөгжил сул, тэсвэр тэвчээргүй, хүний үг даадаггүй гэсэн бол, нөгөө хэсэг нь эх орноо хамгаалахаар очсон хүмүүс бие эрхтэн, амь насаараа хохирдог, дарга нарын харьцаа муутай, цэргүүдээ дэглэдэг учраас үр хүүхдээ цэрэгт явуулахгүй гэсэн харилцан адилгүй байр суурийг илэрхийлсэн байгаа нь хилийн цэргийн талаар олон нийтийн зөв ойлголт хангалтгүй гэж үзэхээр байна.

14. Хилийн цэргийн алба хаагчдаас гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлөх шалтгаан, нөхцлийг бий болгож буй хүчин зүйлсийг судлан үзэхэд, нийгэм-эдийн засгийн, хүн ам зүйн, боловсрол-хүмүүжлийн, нийгэм-сэтгэц зүйн, соёлын зэрэг объектив хүчин зүйл, хувь хүнээс шалтгаалсан гаж зуршил, хүмүүжлийн доголдол, буруу зан үйл, боловсролын хоцрогдол зэрэг субъектив хүчин зүйлс нөлөөлжээ.

Харуулын болон заставын цэргийн албаны зохион байгуулалт хангалтгүй, албаны хяналт сул, сургалт хүмүүжлийн ажлын доголдол, албаны эрсдлийн үнэлгээ хийдэггүй, дүрмийн бус харилцааг таслан зогсооход хангалттай анхаардаггүй зэрэг нь гэмт хэрэг үйлдэх дотоод хүчин зүйлс болж байна.

Ашигласан материал

Хууль тогтоомж, бодлогын баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. 2001 он
3. Монгол Улсын Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2017 он
4. Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль. 2017 он
5. Монгол Улсын Хилийн тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2016 он
6. Монгол Улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /шинэчилсэн найруулга/. 2019 он

Ном, сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний бүтээл

1. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол (ялын тухай сургаал). II боть. УБ., 2014 он
2. Хилийн цэрэгт үйлдэгдэж байгаа онц хүнд гэмт хэргийн шалтгаан, нөхцөл сэдэвт криминологи судалгааны тайлан. Хууль зүйн үндэсний хүрээлэн. УБ., 2010 он
3. Ж.Өвгөнбүргэд, Б.Эрдэнэбат, Б.Даяадан-Эрмэд. Цэргийн албанд үйлдэж болзошгүй гэмт хэрэг. гарын авлага. УБ., 2019 он
4. Б.Энхболд, С.Гантулга. Эрүүгийн эрх зүйн тусгай анги. Сурах бичиг. УБ., 2020 он

Цахим эх сурвалж

1. Хил хамгаалах ерөнхий газар. www.bpo.gov.mn
2. ХЗДХЯ. www.mojha.gov.mn
3. Дотоод хэргийн их сургууль. www.uia.gov.mn
4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем.

БИОМЕТРИЙН ОНЦЛОГ, ХЭРЭГЛЭЭ, БООМТЫН НЭВТРҮҮЛЭХ ЧАДВАРТ НӨЛӨӨЛӨХ НЬ

Б.Мөнгөнбагана
Хилийн албаны сургуулийн Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа

Хураангуй:

Дэлхий дахинд аюулгүй байдлыг хангахад биометрийг өргөнөөр ашиглаж байна. Хамгийн гол давуу тал нь аюулгүй байдал, түргэн шуурхай, найдвартай ажиллагаа, тав тухтай, эдийн засгийн хэмнэлт байдаг. Үүнтэй уялдан дэлхийн улс орнууд хилийн шалгалтад зорчигч болон паспортын ижижлсүүлэлт хийхэд биометрийг ашиглан туршилт явуулж, үйл ажиллагаандаа үе шаттайгаар нэвтрүүлсээр байна.

Түлхүүр үг:

Аюулгүй байдал, биометр, биометрийн төрөл, биометрийн систем, биометрийн паспорт, ижилсүүлэлт

ОРШИЛ

Дэлхий дахинд компьютерийн технологийн хөгжил нь объект болон төхөөрөмжид нэвтрэх, санхүүгийн гүйлгээг баталгаажуулах, нисэх буудлын аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэгтнийг эрэн сурвалжлах зэрэг олон чиглэлийн үйл ажиллагаанд биометрийг өргөнөөр ашиглах боломжийг олгож байна[148].

Биометрийн системийн хамгийн гол давуу тал нь аюулгүй байдал, түргэн шуурхай, найдвартай ажиллагаа, тав тухтай, эдийн засгийн хэмнэлт байдаг[149].

ҮНДСЭН ХЭСЭГ

Биометрийн системийн үндэс болсон хүний бие, түүний аль нэг хэсгийг хэмжих санааг анх францын криминалист Альфонс Бертильон /1853-1914/ боловсруулсан. Тэрээр 1879 онд гэмт хэрэгтний биеийн өндөр, толгойн хэмжээ, гар, гарын хуруу, хөлийн тавхайн урт, ам зураг, нүүрний зураг, содон шинж тэмдгийг агуулсан “Антропометр” нэртэй ижилсүүлэлтийг системийг санаачилсан.

---

[148] https://vc.ru/future/32006-hronologiya-kak-razvivalas-biometriya

[149] https://gazintech.ru/aspk_sapsan.php Автоматизированная система паспортного контроля «Сапсан»

Харин түүнээс 10 жилийн дараа буюу 1889 онд англий судлаач Френсис Гальтон биометр (biometry) гэсэн ойлголтыг анх гаргаснаас хойш өнөөг хүртэл бие даасан шинжлэх ухаан болж тодорхой арга, технологиор баяжин ашиглагдаж байна[150].

Биометрийн ижилсүүлэлтийг мэдлэгийн /нууц код, нууц асуултын хариулт/, шинж чанарын /хурууны хээ, гарын үсэг, дуу хоолойны өнгө/, эзэмшилтийн /карт, гар утас/ гэсэн үндсэн 3 төрлийн хүчин зүйлд тулгуурлан хийдэг.

Биометрийг улс орны аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг сахиулах, иргэний бүртгэлийн санг бүрдүүлэхэд түлхүү ашиглаж байсан ба Apple компани 2013 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр хурууны хээ уншигч Touch ID суурилуулсан iPhone 5s гар утсыг олон нийтэд танилцуулж худалдаанд гаргаснаар энгийн хэрэглээнд өргөнөөр нэвтрүүлсэн. Үүнээс хойш 2017 оны байдлаар биометрийн хамгаалалттай 1,5 тэрбум ширхэг гар утас худалдаалагдсан нь энгийн хэрэглээ буюу хувийн аюулгүй байдлыг хангах чиглэлд түлхүү ашиглагдах үндэс болсон.

Дэлхий дахинд биометрийн төхөөрөмжийн хэрэглээг үндсэн салбараар нь 2010-2021 оны байдлаар гаргаж график-1-ээр дэлгэрэнгүй харуулав.

График-1. Биометрийн хэрэглээ



Эх сурвалж: SecurityRussia.com

[150] Биометрия от «А» до «Я» полное руководство биометрической идентификации и аутентификации

Биометрийн систем нь ажиллах зарчмаасаа хамааран хүнийн биеийн онцлог шинж, хөдөлгөөнийн хүчинд суурилсан гэсэн үндсэн 2 төрөлд хуваагддаг.

1. Физиологийн онцлогт суурилсан биометрийн төрөл:
   - Хурууны хээ
   - Нүдний солонгон бүрхүүл
   - Нүдний торлог
   - Венийн зураг
   - Царай
   - Гарын геометр
   - ДНХ
   - Хөдөлгөөний хүчинд суурилсан биометрийн төрөл:
   - Бичгийн хэлбэр, гарын үсгийн онцлог
   - Зүрхний хэмнэл
   - Дуу, хоолойны өнгө
   - Дохио зангаа
   - Компьютерийн гар дээр ажиллах хурд болон онцлог
   - Алхалт

Хүний биометрийн зарим шинжийг өөрт нь мэдэгдэлгүйгээр нууцаар цуглуулан хадгалж мэдээллийн сан үүсгэх боломжтой боловч гарын венийн зураг, нүдний торлогийн мэдээллийн санг нууцаар бүрдүүлэх боломжгүй.

Дээр дурьдсан биометрийн эдгээр олон төрлүүд нь өөр өөрийн онцлог шинжтэй бөгөөд ямар зорилгоор хэрхэн ашиглах нь хэрэглэгчийн сонголтоос хамаарна.

Биометрийн ижилсүүлэлтийн явцад гарах алдаа нь биометрийн шинжээс бус харин түүнийг тооцоолон ижилсүүлж буй төхөөрөмжөөс хамааралтай байдаг.

Физиологийн онцлогт суурилсан биометрийн ижилсүүлэлтийн аргаас хамаарч системд алдаа гарах хувийг хүснэгт-1[151]-ээр дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-1. Ижилсүүлэлтэд алдаа гарах хувь

№	Биометрийн ижилсүүлэлтийн арга	Алдаа гарах магадлал /хувь/	
		Мэдээллийн санд бүртгэгдээгүй	Мэдээллийн санд бүртгэлтэй

[151] Биометрия от «А» до «Я» полное руководство биометрической идентификации и аутентификации

		этгээдийг хуурамчаар таних	этгээдийг танихаас татгалзах
1	Хурууны хээ	0,001%	0,6%
2	2D царайг таних	0,1%	2,5%
3	3D царайг таних	0,0005%	0,1%
4	Нүдний солонгон бүрхүүл	0,00001%	0,016%
5	Нүдний торлог	0,0001%	0,4%
6	Венийн зураг	0,0008%	0,01%

Эх сурвалж: SecurityRussia.com

Хөдөлгөөний хүчинд суурилсан биометрийн суурилсан биометрийн ижилсүүлэлтийн аргаас хамаарч системд алдаа гарах боломжийг хүснэгт-2[152]-ээр дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-2. Ижилсүүлэлтэд алдаа гарах боломж

№	Биометрийн ижилсүүлэлтийн арга	Алдаа гарах боломж
1	3D хурууны хээ уншигч	Боломжгүй
2	Хурууны хээний мультиспектраль уншигч	Боломжгүй
3	Хурууны хээ уншигч дуран	Боломжтой
4	Нүдний солонгон бүрхүүл	Боломжтой
5	2D царай таних	Боломжтой
6	3D царай таних	Боломжтой
7	Венийн зураг	Боломжгүй
8	Нүдний торлог	Боломжгүй

Эх сурвалж: SecurityRussia.com

Дэлхий дахинд аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжиж байгаатай холбоотойгоор улс орнууд зорчигчдод түргэн шуурхай үйлчлэх, аюулгүй байдлыг хангах зорилгоор биометрийн технологийг хилийн шалган нэвтрүүлэх боомт болон олон улсын нисэх буудлуудад өргөнөөр нэвтрүүлж байна. зорчигчид шалган нэвтрүүлэх албаны ажилтнуудын тусламжгүйгээр бие даан зорчигчийн болон хил нэвтрэх эрхийн баримт бичгийн шалгалтаар нэвтрэх боломж олгодог биометрийн системийг нэвтрүүлэх үндсэн нөхцөл болсон[153].

Улс орнууд хилийн биометрийн шалгалтад ашиглах зорилгоор эзэмшигчийн зураг, нэр, төрсөн он сар өдөр, паспортын дугаар, паспортыг олгосон болон хүчинтэй хугацаа, хэрэглэгчийн талаарх

[152] Биометрия от «А» до «Я» полное руководство биометрической идентификации и аутентификации

[153] https://gazintech.ru

бусад мэдээллийг агуулсан бичил чиптэй цахим паспортыг ашиглаж байна. Биометрийн паспортыг ашиглах санааг АНУ-д анх гаргасан бөгөөд 2001 оны 09 дүгээр сарын 11-ний өдөр болсон террорист халдлага нь биометрийн паспортыг ашиглах үйл явцыг эрчимжүүлснээр 2002 онд дэлхийн 188 орны төлөөлөгч нар Шинэорлеаны хэлэлцээрт гарын үсэг зурж биометрийг паспортын болон визийн ижилсүүлэлтийн үндсэн технологи болохыг хүлээн зөвшөөрсөн.

Биометрийн паспортыг Пакистан 2004 онд, ОХУ, Туркменистан 2008 онд, Узбекистан, Казахстан 2009 онд, Молдав 2011 онд, Беларусь 2012 онд, Израйль 2013 онд, Монгол 2016, Беларусь 2020 онд тус тус нэвтрүүлсэн. 2020 оны байдлаар дэлхийд 1,2 тэрбум ширхэг цахим паспорт ашиглагдаж байна[154].

Царайгаар таних биометрийн системийг 2018 онд АНУ-ын 14 олон улсын нисэх буудалд болон АНУ, Мексикийн хилийн автозамын боомтод, БНХАУ-ын Шанхайн олон улсын нисэх буудалд, 2020 онд БНХАУ-ын Бээжингийн, 2021 онд ОХУ-ын Домодедово, Шереметьево олон улсын нисэх буудлуудад албан ёсоор нэвтрүүлэн ашиглаж байна.

Олон улсын нисэх буудал, хилийн боомтуудад нэвтрүүлж байгаа царайгаар таних биометрийн төхөөрөмжийн ажиллагааны зарчмыг дэлгэрүүлэн авч үзвэл орчин үеийн бүх төхөөрөмжүүд нь нүүр таних аргаараа хоорондоо харилцан адилгүй боловч ажиллагааны зарчим нь ерөнхийдөө адил төстэй байдаг.

Биометрийн хүний царайгаар таних төхөөрөмжийн ажиллагааны зарчим нь дараах 4 үндсэн алхамаас бүрдэнэ. Үүнд:

1. Царайг илрүүлэх

Ухаалаг камер ганцаараа болон олны дунд байгаа хүний царайг олж илрүүлнэ. Хүн камер руу эгч харсан тохиолдолд илрүүлэх чадвар өндөр байдаг. Орчин үеийн төхөөрөмжүүд хүнийг камер руу тодорхой өнцгөөр эгц хараагүй байх үед илрүүлэх чадвартай болсон.

2. Хүний царайнд шинжилгээ хийх

[154] Юрий Минаев, Василий Мамаев, “Итоги и перспективы развития биометрических технологий” 01/02/21

Хүний царайны зургийг үүсгэж түүнд шинжилгээ хийнэ. Нүүр таних зориулалттай ихэнх төхөөрөмжүүд эзлэхүүн ихтэй 3D зураг ашиглахаас илүүтэйгээр 2D зураг үүсгэж мэдээллийн санд байгаа зургуудтай ижилсүүлэлт хийж давхцалыг шалгадаг.

Хүний царай бүр 80 цэгийг дайран зурагдсан өнцгөөр хэмжигддэг. Харин программ хангамж нь өнцгийн цэгүүдэд шинжилгээ хийдэг.

3. Зургийг өгөгдөхүүн болгож хувиргах

Царайнд хийсэн шинжилгээг математикийн томьёо болгон хувиргана. Хүний царай тоон код болон хувирна. Хүн бүрийн царай хүний хурууны хээ шиг дахин давтагдашгүй бүтэцтэй байдаг.

4. Давхцалыг олж илрүүлэх

Царайны кодоор мэдээллийн санд ижилсүүлэлт хийгдэж давхцалыг илрүүлнэ.

АНУ-ын Холбооны мөрдөх товчоо нь 21 орны 641 сая орчим зургийн мэдээллийг агуулсан санд нэвтрэх эрхтэй. Өөр нэг жишээ нь “Facebook”[155]-д хэн нэгний нэрээр тэмдэглэгдсэн зураг бүр мэдээллийн санд нь хадгалагдаж байдаг.

Царайгаар таних биометрийн технологийн сул тал нь гэрэлтүүлэг муутай орчинд, ухаалаг камер руу нүүр хандсан өнцгөөс хамаарч ижилсүүлэх чадвар нь буурдаг. Мөн түүнчлэн африк гаралтай өнгөт арьстай хүмүүсийг ижилсүүлэхэд системийн алдаа ихээр гарах тохиолдол байдаг.

“Шереметьево” олон улсын нисэх буудал нь ОХУ-д хамгийн анх “Единая биометрическая система” нэртэй төрийн мэдээллийн системийг ашиглан улсын хилээр нэвтрэх зорчигчдын ижилсүүлэлтийг гүйцэтгэж эхэлсэн.

---

[155] **Facebook** (компанийн бичдэг хэлбэр: *facebook*, урьдны нэр: *thefacebook*) нь дэлхийн хамгийн том нийгмийн сүлжээ бөгөөд Meta компани (Facebook Inc. 2021.10.28 хүртэл) хөтлөн явуулдаг байна. Facebooks (*англ.* үгчлэн орчуулбал: «нүүр ном», утгачилбал: «дурсамжийн дэвтэр») гэх нэр нь америкийн зарим коллежийн оюутнууд дунд тараадаг элдэв дүрстэй дурсамжийн дэвтрээс гаралтай юм.

Facebook нь хувь хүмүүс өөрийгөө олон нийтэд танилцуулах, санал сэтгэгдлээ хуваалцах эсвэл албан байгууллагууд бизнесээ танилцуулах сурталчилах, мөн түүнчлэн тодорхой сонирхлын бүлгүүд хувийн болоод хамтын сонирхолоо бусадтайгаа хуваалцах, хэлэлцэхэд ашигладаг.

Биометрийн системээр ОХУ-ын 18 нас хүрсэн, ОХУ-ын иргэний 75 болон түүнээс дээш серийн, биометрийн тэмдэглэгээтэй паспорттой иргэд үйлчлүүлэх боломжтой.

Шереметьево нисэх буудлын С терминалд “Сапсан” паспортын шалгалтын автомат системийг 2 жилийн хугацаанд туршилтын журмаар ашигласны дараа албан ёсоор 20 /орох, гарах чиглэлд тус бүр 10/ модулийг шалган нэвтрүүлэх албанд ашиглаж байна[156]. Зорчигч уг системийн паспортын шалгалтаар ороход 30 секундын хугацааг зарцуулдаг.

“Сапсан”[157] паспортын шалгалтын автомат систем нь оросын программ хангамжид суурилсан өндөр технологийн программ-аппаратын иж бүрдэл бөгөөд ОХУ-ын хилээр нэвтэрч байгаа зорчигчдын паспортын шалгалтыг бүрэн автоматаар гүйцэтгэж, паспортод хадгалагдсан биометрийн мэдээллийг эзэмшигчийн биометр өгөгдөхүүнтэй ижилсүүлэх зориулалттай.

“Сапсан”[158] паспортын шалгалтын автомат систем

- Зорчигчийг улсын хилээр нэвтрүүлэх тухай шийдвэрийг автоматаар гаргах;
- Шалгалтаар орох зорчигчийн хийх үйлдлийн дарааллыг маш ойлгомжтой харуулах интерфейстэй;
- Гадаад паспортын өгөгдлийг уншиж, хүчин төгөлдөр эсэхийг шалгана;
- Зорчигчийн нислэгийн талоныг паспортын шалгалтад оруулах шалгуурын дагуу уншуулна;
- Зорчигчийг микрочип, хурууны хээ, цээж зураг зэрэг олон шалгуурын дагуу автоматаар ижилсүүлнэ;
- Зорчигчийн царай, хурууны хээ зэрэг обьектын хуурмаглалыг илрүүлнэ;
- 2 ба түүнээс дээш этгээд нэгэн зэрэг хууль бусаар улсын хилээр нэвтрэх оролдлогоос урьдчилан сэргийлж, баримтжуулах боломжтой

Давуу тал нь:

---

[156] ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны захирлын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн №2/ДСП тушаал

[157] https://sapsan.gazintech.ru/

[158] https://sapsan.gazintech.ru/

- Зорчигчид дэлхийн шилдэг стандартад нийцсэн өндөр түвшний чанартай үйлчилгээ үзүүлнэ;
- Нэвтрүүлэх чадварыг паспортын шалгалтын шугамын 1 метр тутамд 3.3-аас багагүй дахин нэмэгдүүлнэ;
- Шалган нэвтрүүлэх боомтын нэвтрүүлэх чадварыг 6 дахин нэмэгдүүлнэ;
- Төхөөрөмж нь өөрчлөх боломжтой бүтэцтэй тул ямар ч талбайд зайг зөв ашиглан байрлуулах боломжтой;
- ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны шаардлагад нийцэж бүтээгдсэн;

“Сапсан” паспортын шалгалтын автомат системийн зорчигчдыг нэвтрүүлэх боломжийг дэлхийн хамгийн их багтаамжтай агаарын хөлгийн зорчигчдын тоонд харьцуулж судалсныг хүснэгт-3-аар дэлгэрэнгүй харуулав.

Хүснэгт-3. Сапсан төхөөрөмжийн нэвтрүүлэх чадамжийн судалгаа

№	Онгоцны төрөл	Ашигладаг компани	Багтаамж	Шереметьево нисэх буудлын С терминалаар зорчигчдыг шалган нэвтрүүлэх хурд 20 зорчигч/минут
1	Airbus A380-800	Qantas Emirates British Airlines	700 зорчигч	35 минут
2	Boeing 747-8	Cathay Pacific Cargo Korean Air Cargolux	605 зорчигч	30,25 минут
3	Boeing 747-400	Air China Korean Air United Airlines	660 зорчигч	33 минут
4	Boeing 777-300	Emirates Air France United Airlines	550 зорчигч	27,5 минут
5	Airbus A340-600	Lufthansa Iberia Mahan Air	475 зорчигч	23,75 минут

Эх сурвалж: Судалгааны явцад боловсруулсан материал

“Сапсан” паспортын шалгалтын автомат системийг нэвтрүүлэх чадвар нь хүчин чадлаас шалтгаалан шалган нэвтрүүлэх албанд ашиглаж байгаа модулийн тооноос шууд хамааралтай байгаа нь судалгаанаас харагдаж байна. Нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэхийн тулд модулийн тоог нэмэх шаардлагатай.

ДҮГНЭЛТ:

Дэлхийн улс орнууд биометрийн технологийг судлан хөгжүүлж, улсын аюулгүй байдлыг хангах, шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд үе шаттайгаар нэвтрүүлж тодорхой туршлагыг хуримтлуулсан. Биометрийн хэрэглээг стандартаар зохицуулж, эрх зүйн үндсийг бий болгох, хамтран ажиллах чиглэлээр тодорхой ажлууд хийгдэж байна.

Биометр нь шинжлэх ухаанд суурилсан, тодорхой үр ашигтай, олон салбарт хүлээн зөвшөөрөгдөж ашиглагдаж байгаа нь олон жилийн судалгаагаар харагдаж байгаа ба цаашид хэрэглээ нь улсын аюулгүй байдал, тэр дундаа шалган нэвтрүүлэх албаны үйл ажиллагаанд өргөнөөр төлөвтэй байна.

Биометрийн технологи нь хилийн боомтын нэвтрүүлэх чадварт нөлөөлж байгаа нь олон улсын туршлагаас харагдаж байна.

САНАЛ:

1. Биометрийн технологийг шалган нэвтрүүлэх албанд ашиглаж буй гадаад орнуудын туршлагыг нарийн судлах;
2. Биометрийн төрөл болон түүний онцлог, ажиллагааны зарчим, үр дүнд судалгаа хийж, хилийн боомтуудын төрөл, зэрэглэл, онцлогт тохирсон биометрийн технологийн үе шаттайгаар хилийн боомтуудад нэврүүлэх;

Ашигласан материал:

1. ОХУ-ын Холбооны аюулгүй байдлын албаны захирлын 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн №2/ДСП тушаал
2. Юрий Минаев, Василий Мамаев, “Итоги и перспективы развития биометрических технологий” 01/02/21
3. Автоматизированная система паспортного контроля «Сапсан»
4. Биометрия от «А» до «Я» полное руководство биометрической идентификации и аутентификации
5. https://sapsan.gazintech.ru/
6. https://vc.ru/future/32006-hronologiya-kak-razvivalas-biometriya
7. https://gazintech.ru/aspk_sapsan.php

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

Х.Баясгалан
Хилийн албаны сургуулийн
Хилийн бооМтын аюулгүй байдал,
шалган нэвтрүүлэх албаны
тэнхимийн эрхлэгч, хурандаа

***Түлхүүр үг**: Улсын хил, хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх алба, гэмт хэрэг, аюулгүй байдал, террорист, биометр өгөдөл*

Хураангуй: Хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хилийн аюулгүй байдлыг хангах хүрээнд улсын хилээр нэвтрэх зорчигчийг хүний биеийн давхцахгүй биометр өгөгдөлөөр бүртгэх үйл ажиллааны онол, практикийн асуудлыг дэвшүүлж, хэрэгжүүлэх талаар.

Нэгдсэн үндэстний байгууллагаас хэрэгжүүлж байгаа террорист этгээдийн хөдөлгөөнд хяналт тавих “Go travel” хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулж, зорчигчийн урьдчилсан мэдээллийг авч эрсдлийг үнэлэх, тооцоолох замаар, хил дамнасан гэмт хэрэг, террорист, олон улсад эрэн сурвалжлагдаж байгаа этгээдийн хөдөлгөөнд хяналт тавих, илрүүлэх, хил хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг сайжруулах зэрэг асуудлыг тусгасан.

ОРШИЛ

Олон улсын болон бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл байдал хурдтайгаар хувьсан өөрчлөгдөж, терроризмын аюул, үндэстэн, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг өргөжин тэлэхийн хэрээр зэвсэгт мөргөлдөөн, улс төр, эдийн засгийн хямрал, байгалийн гамшиг болон өлсгөлөн, ядуурлаас үүдсэн дүрвэгсдийн урсгал жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа үед олон улсын хамтын нийгэмлэг, улс орнуудын хувьд аюулгүй байдлын асуудал анхаарал татсан асуудал болж байна.

Хил дамнасан зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд өөрийн гишүүд болон зэвсэг, сум галт хэрэгсэл, хар тамхи мансууруулах бодис зэргийг улс орнуудын хилээр хууль бусаар нэвтрүүлэх ажиллагаа нарийсах тусам тэдэнтэй тэмцэх, үндэсний болон хилийн аюулгүй байдлаа хангах асуудал нь улс орнуудын хувьд хүнд сорилт болдог.

Дэлхийн ихэнх улс орнууд болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх үүднээс улсын хил нэвтэрч байгаа хүмүүсийн бүртгэл, хяналт, шалгалтад онцгой анхаарч, орчин үеийн дэвшилтэт технологийг өргөнөөр ашиглаж байгаа бөгөөд хүний биеийн давхцахгүй өгөгдөл буюу биометр мэдээлэлд суурилсан таних технологийг нэвтрүүлээд байна. Тухайлбал манай хөрш ОХУ, БНХАУ уг технологийг хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд 2017 оноос ашиглаж эхэлсэн.

Өнөөгийн байдлаар 114 орон бүх төрлийн паспортаа электрон /эзэмшигчийн биометр мэдээллийг агуулсан чиптэй/ болгосон бөгөөд 2023 он гэхэд бүх нисэх буудлын 70 хувь нь биометр мэдээлэлд суурилсан таних технологийг нэвтрүүлэхээр төлөвлөж байна. Монгол Улс дипломат, албан паспортаа цахим болгосон, үндэсний энгийн гадаад паспортыг цахим болгохоор төлөвлөж байна.

Монгол Улсын Их хурлаас 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль”-ийг баталж, 2021 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр болсон бөгөөд хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д “Гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед Монгол Улсын хилийн тухай хуулийн 17.6-д заасны дагуу хил хамгаалах байгууллага нь биеийн давхцахгүй өгөгдлийг авч, улсын хилээр нэвтэрсэн зорчигчийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэнэ” гэж заасан бөгөөд хуулийн хэрэгжилтийг хангах зайлшгүй шаардлага үүссэн.

Иймд хүний биеийн давхцахгүй биометр өгөгдлөөр бүртгэх ажиллагааг хэрэгжүүлж, улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн шинэчлэлийг хийж эхэлсэн бөгөөд хилийн аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг улам боловсронгуй болгохоор ажиллаж байна.

Энэ ажлын хүрээнд НҮБ-аас хэрэгжүүлж байгаа террорист этгээдийн хөдөлгөөнд хяналт тавих “Go travel” хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулж, улсын хил нэвтрэх зорчигчийн урьдчилсан мэдээллийг авч эрсдлийг үнэлэх, тооцоолох замаар террорист, гэмт этгээдийг илрүүлж аюулгүй байдлаа хангах нь чухал юм.

ШАЛГАН НЭВТРҮҮЛЭХ АЛБАНД ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИ НЭВТРҮҮЛЭХ

“Зорчигчийг хүний биеийн дахин давхцахгүй биометр өгөдлөөр бүртгэх ажиллагааны тухай”

Биометр гэдэг нь хүний физиологи, биологийн давтагдашгүй өгөгдлийн хэмжилтийг илэрхийлэх ухагдахуун бөгөөд уламжлалт аргууд болох текст суурьтай, мэдлэг суурьтай баталгаажуулалттай харьцуулахад тухайн хүний онцлогт суурилдаг тул илүү найдвартай гэж судлаачид үздэг байна.

Ялангуяа тооцооллын хурд үсрэнгүй нэмэгдсэн өнөө үед техникийн шийдэлтэй хосолсон энэхүү аргачлал нь хүнийг таних, баталгаажуулалт хийхэд хамгийн найдвартай, аюулгүй технологи болж хөгжсөн ба манай улсын хувьд хилийн аюулгүй байдлыг хангахад хүний биометр өгөгдлийг ашиглах талаар ямар нэгэн судалгаа урьд нь хийгдэж байгаагүй.

Биометр суурьтай аргачлал нь тухайн хүний хими, биологи, физиологи болон зан байдал, үйл хөдлөлийн зэрэг шинж чанарууд дээр үндэслэн хийгдэх боломжтой ба хүний аль шинж чанаруудыг сонгох нь тухайн үеийн хэрэгцээ, шаардлагад тулгуурлана.

Биометр өгөгдөл нь дараах үндсэн 4 шинж чанарыг агуулдаг. *Universality*: бүх хүнд байх ёстой; *Distinctiveness*: аливаа хоёр хүний хувьд ижилхэн байх ёсгүй; *Permanence*: цаг хугацаанаас үл хамаарсан буюу хувьсан өөрчлөгддөггүй байх; *Collectability*: хэмжиж, цуглуулах боломжтой байх.

Дээрх шаардлагыг хангасан биометрийн систем нь үндсэн 2 горимд ажилладаг. Эхний горим нь баталгаажуулалт (verification) буюу *“нэгийг харьцах нэг”* харьцуулалт хийх ба энэ тохиолдолд тухайн этгээдийг өөртэй нь харьцуулж, мөн эсэхийг нь тодорхойлдог. Хоёр дахь горим нь танилт (identification) буюу *“нэгийг харьцах олон”* харьцуулалт хийж ажилладаг.

Туршилтын программ хангамжийн үйл ажиллагаа

Туршилтын программ хангамж нь шалганы үйл ажиллагаа автоматаар ажиллах байдлаар буюу шалгагчгүйгээр ажиллах байдлаар зохиогдсон. Зорчигч нь дэлгэцэд программаас өгөх зааврын дагуу үйлдлүүдийг тодорхой дарааллаар хийн бүртгэлийн үйл ажиллагааг өөрөө явуулна.

Паспортын уншигч төхөөрөмжид паспортыг уншуулахад тухайн паспортын мэдээллээр иргэний мэдээллийг УБЕГ-ын иргэний мэдээлэл болон мэдээллийн санд авагдсан бусад шалгагдах шаардлагатай мэдээллээс автоматаар шалгалт хийгдэнэ. Үүний дараа камерын дүрснээс тухайн зорчигчийн нүүр царайг мэдээллийн санд авагдсан болон УБЕГ-ын иргэний зурган мэдээлэлтэй нүүр царайг харьцуулан тулгаж, төсөөтэй байдлыг хувьчлан харуулна.



Зорчигчийн нүүр царай тохирсон байдал. Бүртгэл цааш үргэлжилнэ



Зорчигчийн нүүр царай тохирохгүй байгаа байдал. 50 удаагийн давталтаар царай тохирохгүй бол бүртгэл цааш үргэлжлэхгүй анхны горимд шилжинэ.

Туршилтын программ хангамж болон мэдээллийн санд хоригтой иргэдийг дагалдах текст мэдээлэлгүйгээр /Регистрийн дугаар, овог, нэр гэх текст мэдээлэл/ зөвхөн зурган мэдээллээр илрүүлэн таних боломжтойгоор хийж өгсөн ба хэрэв зорчигчийн зураг хоригтой иргэдийн зурган мэдээллийн санд орсон бол программ цааш нэвтрүүлэхгүй байдлаар дараах зааврыг зорчигчид харуулна.



Нүүр царайны тулгалт амжилттай хийгдсэн тохиолдолд хурууны хээний бүртгэл / тулгалт хийгдэх ба дэлгэцэд дараах зааврыг харуулна.

Программд анх удаа бүртгэгдэж буй зорчигч бол тухайн зорчигчийн 10 хурууны хээг бүртгэж авна



Мэдээллийн санд өмнө бүртгэгдсэн зорчигч бол аль нэг хуруугаа төхөөрөмжид уншуулан өөрийгөө баталгаажуулна

ТЕРРОРИСТ ЭТГЭЭДИЙН ХӨДӨЛГӨӨНД ХЯНАЛТ ТАВИХ ХӨТӨЛБӨРИЙГ МОНГОЛ УЛСАД НУТАГШУУЛЖ, ХИЛИЙН ХЯНАЛТЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ХАРИЛЦАН АЖИЛЛАГААГ САЙЖРУУЛАХ

Олон улсын хэмжээнд үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болох хилийн аюулгүй байдлыг хангах асуудал 1990-ээд оны эхэн үеэс илүү чухлаар тавигдаж, хилийн менежмент, ухаалаг хил, цахим хил гэх мэт ойлголтууд бий болсон бөгөөд аюулгүй байдлын хувьд эрсдэл, эрсдэлийг тодорхойлох, урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарах болсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн 4 дүгээр зүйлд “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна[159]” гэж;

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын 1.1.2-т “Монгол Улсын нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй байдал болон бүрэн бүтэн байдал нь Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд багтана[160]”, 3.1-д “Хил хязгаарын халдашгүй дархан байдал нь Монгол Улсын оршин тогтнохуйн аюулгүй байдлын үндэс болно”, 3.1.2.4-т “Хилийн хамгаалалт, хяналт шалгалтын үйл ажиллагаанд мэдээллийн нэгдмэл, шуурхай байдлыг баталгаатай хангах зохион байгуулалт, техник, технологийн шинэчлэлийг хэрэгжүүлнэ” гэж;

-Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 8.3.-д *“Монгол Улсын Засгийн газар нь үндэсний аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.”;*

-Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хуулийн 6.1.4-т *“терроризм үл нутагших, террорист этгээд нэвтрэхгүй, орогнохгүй байх орчин нөхцөлийг бүрдүүлэх[161].”,* 6.1.9-т “зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах”;

Иргэний агаарын тээврийн тухай хуулийн

---

[159] Монгол улсын үндсэн хууль. 1992 он.

[160] Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он.

[161] Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль. 2019 он.

-Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийн 8.2.10-т “Олон улсын нислэг үйлдэх агаарын тээвэрлэгчээс зорчигчийн мэдээллийг урьдчилан авах.”, 25.1.10-т “энэ хуулийн 8.2.10-т заасан зорчигчийн мэдээллийг урьдчилан авах, харилцан мэдээлэл солилцох, түүний аюулгүй байдлыг хангах журам батлах.”;

-НҮБ-ын “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр” хэрэгжүүлэх Монгол Улсын Засгийн газар, НҮБ-ын Терроризмтой тэмцэх албатай 2021 оны 10 дугаар сарын 7-ны өдөр байгуулсан харилцан ойлголцлын санамж бичиг;

-Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 261 дугаар тогтоол;

-Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.3.1-д *“...хил хамгаалах албаны үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглана.”,* 4.3.9-д *“Гадаадын иргэн, харьяалалгүй хүний бүртгэл, мэдээлэл, хяналтын тогтолцоог боловсронгуй болгоно*[162]*.”;* гэж заасан нь дээр дурдсан бодлогын баримт бичгүүдийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлж, Монгол Улсад “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх хууль эрх зүйн үндэс болж байна.

Хил хамгаалах байгууллага нь улс орны хэмжээнд улсын хилийн хамгаалалтыг зохион байгуулж, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг шалган нэвтрүүлэх, хилийн боомтын аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэлийг хөтөлж, нэгдсэн сан бүрдүүлдэг.

Шалган нэвтрүүлэх албанд ашиглаж байгаа “Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем”-ийг БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага /КОІСА/-ын төслийн хүрээнд тус улсын “SysOne” компани байгуулсан ба системийн дотоод бүтэц, зохион байгуулалтын баримт бичиг, эх код, технологийн нууцлал “SysOne” компанид хадгалагддаг, системийг шинэчлэн сайжруулах, аюулгүй байдал, хэвийн ажиллагааг нь хангах үйл ажиллагаа гадаадын

[162] Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2020 он.

компаниас хамааралтай байгааг Тагнуулын ерөнхий газрын мэдээллийн аюулгүй байдлын газраас Хил хамгаалах ерөнхий газарт 2018 оны 12 дугаар сарын 13-наас 21-ний өдрүүдэд дээрх системд хийсэн мэдээллийн аюулгүй байдлын түвшин тогтоох эрсдэлийг үнэлэх шалгалтаар “Өндөр түвшний эрсдэлтэй” гэж дүгнэсэн байна.

“Улсын хилээр нэвтэрсэн зорчигч, тээврийн хэрэгслийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан”-д Интерполоор болон олон улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа алан хядах байгууллагын гишүүд 17400, хуулийн байгууллагуудаас улсын хил нэвтрэх эрхийг хязгаарласан 2800 гаруй иргэдийн мэдээллийг системд бүртгэсэн байдаг.

Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон олон улсын хэмжээнд эрэн сурвалжлагдаж байгаа этгээд өөрийн мэдээллийг өөрчлөн мөн бусдын мэдээллийг ашиглан өөрийн зургаар баримт бичиг гаргуулан улсын хил нэвтрэх тохиолдолд одоогийн ашиглагдаж байгаа систем нь илрүүлэх боломжгүй байдаг.

Дээрх аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилгоор ихэнх улс орнууд улсын хилээр нэвтрэх зорчигчийн бүртгэл, хяналт, шалгалтад онцгойлон анхаарч, шинэлэг мэдээлэлд суурилсан технологийг нэвтрүүлээд байна.

НҮБ-ын “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”, зорчигчийн урьдчилсан мэдээллийн шинэлэг технологийг зорчигчийн тухай урьдчилсан мэдээлэл (API), зорчигчийн нэрсийн бүртгэл (PNR)-ийн “goTravel” системийг ашиглах замаар террорист этгээдүүд болон онц хүнд гэмт хэрэгтнүүдийг илрүүлэх, террорист этгээдүүд, гэмт хэрэгтнүүдийн тухай олон улсын мэдээллийн санг олон улсын хуваарьт нислэгээр зорчиж байгаа гадаад, дотоод зорчигчдын дэлгэрэнгүй мэдээллийг хилийн хяналтын байгууллагууд урьдчилан авч, эрсдэлийн хяналт, шинжилгээ хийх, шуурхай шийдвэр гаргах, шаардлагатай арга хэмжээг урьдчилан зохион байгуулах боломжийг бүрдүүлэх зорилготой.

Мөн хилийн хяналт шалгалтыг сайжруулах, хялбаршуулахаас гадна эрчимтэй нэмэгдэж байгаа хар тамхи, мансууруулах бодисын худалдаа, хүний наймаа, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон терроризмын гэмт хэрэгтэй тэмцэх Монгол Улсын аюулгүй

байдлын чадавхыг бэхжүүлэх өндөр ач холбогдолтой. Тус хөтөлбөрийг агаарын бусад боомтод нэмэлт хөрөнгө оруулалтгүйгээр ашиглаж болох ба цаашид төмөр зам, авто замын боомтуудад нэвтрүүлэх боломжтой.

Энэхүү хөтөлбөр нь зорчигч тасалбар худалдан авсан, эсхүл нислэгийн бүртгэл хийлгэсэн даруйд тухайн зорчигчийн мэдээллийг төрийн мэдээллийн сангууд болон интерполоор эрэн сурвалжилж буй этгээдийн жагсаалт, нисэж болохгүй анхаарах зорчигчдын жагсаалт (Watch List), хар жагсаалт (Black List) визийн болон аяллын баримт бичгийн мэдээллийн сантай тулгаж эрсдэлийн дүн шинжилгээ хийснээр үр дүнг төрийн болон хилийн хяналтын байгууллагуудад 1-3 секундийн дотор илгээснээр шуурхай шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх юм.

Уг хөтөлбөрийг Нидерланд улсын засгийн газар анх боловсруулж 2018 оны 9 дүгээр сарын 26-нд системийн өмчлөх эрхийг НҮБ-д шилжүүлсэн. НҮБ тус хөтөлбөрийг боловсронгуй болгон “goTravel” нэртэй мэдээлэл цуглуулах дүн шинжилгээ хийх, хадгалах, солилцох боломжтой болгон боловсруулсан.

Аливаа улс зорчигчийн хөдөлгөөнийг хянах үндэсний программ хангамж бүхий тогтолцоог бий болгоход 25-30 орчим сая ам.доллар зарцуулдаг гэсэн олон улсын байгууллагын судалгаа байдаг. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нийт төсөвт өртөг нь 12-15 сая ам.доллар бөгөөд НҮБ-ын зүгээс өөрийн гишүүн орнуудын хандиваас бүрдүүлж хөгжиж байгаа болон эрсдэлийн зэрэг өндөртэй орнуудад буцалтгүй тусламж хэлбэрээр нутагшуулж байна.

Монгол Улсад энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 261 дугаартай тогтоол, ҮАБЗ- ийн н-52/36 зөвлөмж болон НҮБ-ын гишүүн улсын хувьд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 2178 (2001), 2396 (2017), 2482 (2019) дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ач холбогдолтой юм. Тус хөтөлбөрийг НҮБ-ын Терроризмтой тэмцэх хорооны гүйцэтгэх алба (UNCTED), Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC), Терроризмтой тэмцэх алба (UNOCT), Мэдээлэл, харилцаа холбооны технологийн алба (OICT), Олон улсын иргэний

нисэхийн байгууллага (ICAO), Олон улсын агаарын тээвэрлэгчдийн холбоо (IATA), Дэлхийн гаалийн байгууллага (WCO), Интерполын үндэсний товчоо (INTERPOL) зэрэг олон улсын байгууллагууд өөрийн гишүүн орнууд хэрэгжүүлэхийг зөвлөдөг бөгөөд цаашид НҮБ-ын гишүүн орнууд тус хөтөлбөрт бүрэн хамрагдах хандлагатай байна.

НҮБ, олон улсын байгууллагын мэргэжилтэн, шинжээчид 2020 оны 04 дүгээр сарын 19-23-ны өдрүүдэд 15 мэргэжилтэн, шинжээчдийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчин, үйл ажиллагааны бэлэн байдал, агаарын тээврийн салбарын болон техникийн урьдчилсан үнэлгээг зохион байгуулж холбогдох зөвлөмж, замын зураглалыг манай улсад өгсөн.

Түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн “Террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх талаар авах хэмжээний тухай 261 дугаар тогтоол баталж, уг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч байгууллагаар Хил хамгаалах ерөнхий газрыг тогтоож, хөтөлбөрийн үндэсний зохицуулагчийн чиг үүргийг Терроризмтой Тэмцэх Зөвлөлийн ажлын албанд хариуцуулсан.

Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол Улсад Терроризмтой тэмцэх зөвлөлийн даргын 2021 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн тушаалаар “НҮБ-ын террорист этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавих хөтөлбөр”-ийг нэвтрүүлж, нутагшуулах чиг үүрэг бүхий хууль, эрх зүй, үйл ажиллагааны, агаарын тээврийн, техникийн дэд ажлын хэсгүүдийг байгуулан бүрэлдэхүүнийг томилон ажиллуулж байна.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн 2022 онд Зорчигчийн Мэдээллийн Төвийг байгуулахаар холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Хөтөлбөр хэрэгжснээр ТЕГ, ЦЕГ, ГЕГ, ГИХГ, МБ зэрэг байгууллагуудын төлөөлөл уг төвд ажиллаж чиг үүргийн хүрээнд зорчигчийн урьдчилсан мэдээлэлд дүн шинжилгээ хийн хамтран ажиллах нөхцөл бүрдэнэ.

ДҮГНЭЛТ:

Дэлхийн хамгийн сийрэг хүн амын суурьшилтай, харьцангуй том газар нутагтай, далайд гарцгүй манай орны хувьд улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах асуудал нь үндэсний аюулгүй

байдлын үндэс юм. Иймд хилийн аюулгүй байдалд нөлөөлөх гадаад, дотоод хүчин зүйлсийг оновчтой тодорхойлох, бодлого боловсруулах, түүний эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийх замаар хилийн шалган нэвтрүүлэх албанд хүнийг биометрийн өгөгдлөөр таних, баталгаажуулах дэвшилтэд технологид суурилсан туршилтын ажлыг Хил хамгаалах ерөнхий газар болон “Чингис хаан” олон улсын агаарын замын боомтод амжилттай зохион байгуулж, хилийн боомтуудад хэрэгжүүлсэн нь олон улсын стандартад нийцсэн бөгөөд боомт газраар улсын хил зөрчих гэмт хэргийг таслан зогсооход чухал урьдач нөхцөл болох ач холбогдолтой.

Үүний зэрэгцээ Нэгдсэн үндэстний байгууллагаас террорист этгээдийн хөдөлгөөнд хяналт тавих “Go travel” хөтөлбөрийг Монгол Улсад нутагшуулж хэрэгжүүлсэнээр, зорчигчийн урьдчилсан мэдээллийг авч эрсдлийг үнэлэх, тооцоолох, хил дамнасан гэмт хэрэг, террорист, олон улсад эрэн сурвалжилагдаж байгаа этгээдийн хөдөлгөөнд хяналт тавих, тэдгээрийг илрүүлэх, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хилийн хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагаа сайжирах тул дээрх хөтөлбөрийг үе шаттайгаар нэвтрүүлэх нь зүйтэй гэж дүгнэж байна.

САНАЛ:

Монгол Улсын хилээр зорчигчийг хүний биеийн давхцахгүй биометр өгөгдлөөр шалган нэвтрүүлэх ажиллагааг олон улсын жишигт хүргэх, хилийн аюулгүй байдлыг хангах, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх хилийн хяналтын болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг боловсронгуй болгох хүрээнд дараах саналуудыг дэвшүүлж байна.

1. Монгол Улсын хилийн боомтуудад гадаадын иргэдээс гадна монгол иргэдийг шаардлагатай тохиолдолд хүний биеийн давхцахгүй өгөгдлөөр шалгах эрх зүйн орчинг бүрдүүлэх,
2. НҮБ-ын терроризмтэй тэмцэх албатай хамтран хэрэгжүүлэх “Go travel” хөтөлбөрийг 2023 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлж, зорчигчийн мэдээллийн төвийг байгуулахад шаардлагатай орон байр, орон тоо, төсвийн асуудлыг яаралтай шийдвэрлүүлэх,
3. “Go travel” хөтөлбөрийн мэдээллийн санг хилийн хяналтын болон хууль сахиулах байгууллагын мэдээллийн нэгдсэн

сангийн шаардлагатай хэсгийг холбох замаар гэмт этгээдүүдийн хөдөлгөөнд хяналт тавьж, гэмт хэргийг илрүүлэх ажиллагааг сайжруулах зэрэг болно.

Ашигласан материал:

1. Монгол улсын үндсэн хууль. 1992 он.
2. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он.
3. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх хууль. 2019 он.
4. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр. 2020 он.
5. Kwak, Keun-Chang, and Witold Pedrycz. "Face recognition using a fuzzy fisherface classifier." *Pattern recognition* 38.10 (2005): 1717-1732
6. Kim, Kwang In, Keechul Jung, and Hang Joon Kim. "Face recognition using kernel principal component analysis." *IEEE signal processing letters* 9.2 (2002): 40-42.
7. A. K. Jain, A. Ross, S. Prabhakar, "An Introduction to Biometric Recognition", IEEE Trans. on Circuits and Systems for Video Technology, Vol. 14, No. 1, pp 4-19, January 2004
8. Flom, Leonard, and Aran Safir. "Iris recognition system." U.S. Patent No. 4,641,349. 3 Feb. 1987.
9. Ma, Lia, Yunhong Wang, and Tieniu Tan. "Iris recognition based on multichannel Gabor filtering." *Proc. Fifth Asian Conf. Computer Vision*. Vol. 1. 2002.

БҮСЧИЛСЭН ХИЛ ХАМГААЛАЛТЫН ОНЦЛОГ

Ч.Чулуунхүү
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн
дэд профессор, дэд хурандаа

Товч агуулга: Бүсчилсэн хил хамгаалалтын эрх зүйн зохицуулалт, бүсчилсэн хил хамгаалалтад шилжих үндэслэл, түүний онцлог

Түлхүүр үг: Бүсчилсэн хил хамгаалалт

Оршил

Монгол Улс нь Төв азийн нутаг дэвсгэрт 1 сая 565 мян км^2 газар нутгийг эзэмшин суурьшсан, 3 сая 400 мянга гаруй хүн амтай, 8252.6 км хил хязгаартай, газар нутаг, хил хязгаарын байдлаараа дэлхийн эхний хорин улсын тоонд багтдаг, эх газрын эрс тэс уур амьсгал, экологийн эмзэг орчин бүхий уул, тал хээр, говь цөл хосолсон эргэх дөрвөн цагийн улиралтай, ард түмний өвөрмөц зан заншил бүхий нүүдлийн соёл ахуйтай ардчилал, зах зээлийн харилцаа хөгжиж буй тусгаар тогтносон Бүгд найрамдах улс билээ. Манай улстай зах нийлэн хиллэдэг ОХУ, БНХАУ улсууд нь цэрэг-улс төр, нийгэм, эдийн засаг, хөгжлийнхөө байр сууриараа дэлхийд тэргүүлэгч улс гүрнүүдийн тоонд зүй ёсоор тооцогддог.

Монгол Улсын физик газар зүйн онцлогийг үндэслэн улсын хил хамгаалалтыг говь цөлийн, тал хээрийн, ой тайгын, уулын бүсийн гэж ангилсан байна.

Үндсэн хэсэг

Бүс нутаг ба улсын хил

Бүс нутаг дахь таагүй нөхцөл байдал нь тухайн бүс нутаг дахь улс орнуудын аюулгүй байдал, түүний дотор улсын хил, хилийн орон зайд улс үндэстний аюулгүй байдалд нөлөөлөх тодорхой сөрөг хүчин зүйлүүдийг /нөхцөлийг/ бий болгодог.

Улсын хилийн бүс, хилийн бүс нутаг нь хил хамгаалах байгууллага, түүний анги, салбаруудын алба-байлдааны ажиллагаа явуулж байгаа үндсэн нутаг дэвсгэр бөгөөд энэ нутаг дэвсгэр нь хөгжлөөрөө, байгаль цаг агаарын байдлаараа, хилийн цагийн байдлын өрнөлтөөрөө харилцан адилгүй орон зайд оршдог байна.

Дэлхийн улсуудын авч үзэж байгаагаар дурьдсан нөхцөл байдлууд нь тухайн улсын аюулгүй байдалд нөлөөлөх, зайлшгүй анхаарвал зохих дараах сөрөг хүчин зүйлүүдийг бий болгодог гэж үздэг байна. Үүнд:

-Хөрш улсуудын тусгай албадын явуулж буй тагнуул-сөрөг ажиллагаа, үл үзэгдэж хил нэвтэрч буй урсгал;

-Тухайн улсын өөрийн геополитикийн ашиг сонирхлын хүрээнээс гаргах зорилгоор бусад бүлэг улсуудын зүгээс тодорхой бүс нутагт өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлэх хүчин чармайлт тавьж буй байдал болон найрсаг дотно харилцагч улсуудтай явуулах хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлөх оролдлого;

-Хил залгаа улсуудын үндсэрхэг үзэлтэй байгууллагууд өөрийн төс засгаас тухайн улсад алдагдсан болон маргаантай газар нутгаа эргүүлэн авах элдэв шаардлага, шахалт үзүүлэх;

-Хилийн шугамын явалт өөрчлөгдсөнөөс үүдэлтэй нутаг дэвсгэрийн харьяаллын талаарх санал зөрөлдөөнийг хурцатгах

-Хил орчмын нутаг дэвсгэр дэх нийгэм, улс төр, эдийн засгийн нөхцөл байдлын хүндрэл;

Олон улсын гэмт хэргийн бүлэглэлд хууль бусаар дүрвэгсдийг тухайн оронд оруулах, гуравдагч улсад гаргах болон түүхий эд, үнэт зүйлс, материалын нөөц, зэвсэг галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар хил нэвтрүүлэх оролдлого;

-Хил залгаа улстай хилийн шугам тодорхой тогтоогдоогүй байдал, цэрэг улс төрийн цагийн байдлын хурцадмал, хил орчим дах хууль бус бүлэглэлийн үйл ажиллагаа, улс орны дотоод зөрчлийг зохицуулах үйл явцын хүндрэлтэй холбоотойгоор хилийн зарим хэсгийн цагийн байдал тогтворгүйжих;

-Хил хамгаалах байгууллага, хилчдийн эсрэг тухайлбал, улсын хилийн шалган нэвтрүүлэх боомт газруудад гэмт хэрэгтэн, алан хядагчдын зүгээс явуулж буй хууль бус үйл ажиллагаа идэвхжих;

-Мэдээллийн сөргөлдөөний идэвхжил, улс үндэстэн дамнасан гэмт хэргийн бүлэглэлүүд төр засгийн эрх мэдлийг бууруулах, хил орчмын оршин суугч, цэргийн албан хаагчид тэдний гэр бүлийн эсрэг хууль бус үйлдэл хийхэд турхирах, заналхийлэх замаар сэтгэл зүйн мэдээллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулах;

-Улс орны дотоод дах цэрэг-улс төр, бизнес болон бусад ашиг сонирхлын зөрчлийн улмаас улсын хил хамгаалах байгууллагын зохион байгуулалтад сөргөөр нөлөөлөх, хүчийг сулруулахад хүргэх зэрэг болно.

1. **Бүсчилсэн хил хамгаалалт, хэрэгцээ шаардлага**

Хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулах ажиллагааны эх сурвалж нь хилийн асуудлаарх хууль тогтоомж, дүрэм, удирдамж, тушаалууд байх боловч тухайн хариуцсан хэсэг бүс нутаг дээрх эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэхдээ хилийн цагийн байдлын өрнөлтийг судлан, үнэлэлт дүгнэлт хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээгээр тодорхойлдог[163].

Одоогоор мөрдөгдөж буй дүрэмд хилийн цагийн байдлыг эсрэг талын нөхцөл байдал, өөрийн хүч хэрэгсэл, орон нутгийн нөхцөл байдал, байгаль цаг агаарын байдлуудыг үндэслэн үнэлж байгаа бөгөөд эдгээр үзүүлэлтүүдээс авч үзвэл Монгол Улсын бүс нутгуудын хилийн цагийн байдлын өрнөлт нь өөр хоорондоо харилцан адилгүй зарим талаар эрс тэс өөр нөхцөл байдалд үйл ажиллагаа явагдаж байгаа нь харагдана.

Жишээ нь: Монгол Улсын хойд чиглэл буюу ой тайгын хэсэгт ихэвчлэн хулгайн ан хийх, загас барих, хурдан удмын адуу хил давуулан оруулж ирэх зөрчил нийтлэг гардаг бол уулын хэсэгт мал хил давуулан хулгайлах, хориотой болон хязгаарласан эд зүйлсийг хил залгаа улсын иргэдтэй үгсэн хуйвалдах замаар худалдаж, хууль бус ашиг хонжоо хайх, тал хээрийн хэсэгт загас барих, ан хийх, богино зайн хилийн зөрчил гаргах зөрчлүүд давамгайлах, говь цөлийн чиглэлээр хилийн боомт орчмоор хууль бусаар бараа, эд зүйлс хил давуулах гэх мэтийн зөрчлүүд ихэвчлэн гарч байна.

Хилийн цагийн байдлын өрнөлтийг харгалзсан хил хамгаалалтын арга, тактик, хүч хэрэгслийн оновчтой хаваарилалгүйгээр нэг хэв загварын арга тактик, хүч хэрэгслээр хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулах явдал үргэлжилж байгааг өөрчлөн дээрх нөхцөл байдалд нийцсэн бүс нутгийн онцлогт тохирсон хилийн албаны үйл ажиллагааны шинэ хэлбэрт шилжих шаардлага гарч байсан.

Сүүлийн жилүүдэд:

---

[163] Бүс нутаг-Хил хамгаалалтын үзэл баримтлал. УБ 2012он. 18х

-Хилийн зөрчил улам зохион байгуулалттай хэлбэрт шилжиж байгаа;

-Хилийн зөрчигчид өндөр хурд, хүчин чадал бүхий техник хэрэгсэл хэрэглэх болсон;

-Хар тамхи, хүний наймаа, мансууруулах бодисын наймаа хүрээгээ тэлж, улам бүр өргөжсөн, түүний дотор Монгол Улс энэ төрлийн бүтээгдэхүүнийг хүлээн авагч, тээвэрлэгч, дамжуулагч, хэрэглэгч орон болж байгаа;

-Үйлдвэрлэл-үйлчилгээ, уул уурхай, бусад аж ахуй эрхлэх ажиллагаа хилийн бүс нутгийг бүхэлдээ хамрах болсон;

-Улсын хил нэвтрэх ажиллагаа олон цэгээр /Хилийн боомт, гарц/ байнгын тасралтгүй хэлбэрт шилжиж байгаа;

-Хилийн зөрчлөөс үүдэлтэй хууль бус үйлдлийн улмаас гарч буй сөрөг үр дагаварын тархах хүрээ өргөжиж байгаа;

-Хилийн бүс нутагт хууль бусаар оршин суух, аж үйлдвэрлэл эрхлэх явдал газар авч, эдгээрт оролцох гадаад иргэдийн тоо өдрөөс өдөрт нэмэгдэх хандлагатай болсон;

-Хилийн бүс нутагт байнга оршин суугчдын хэрэгцээ өсөхийн хэрээр үйлдвэрлэлийн үр ашиг, нөөцийн хомсдол бий болж, улмаар хил орчмын нутаг дэвгэрээс дайжих явдал газар авч байгаа;

-Аж ахуйн зорилгоор хил зөрчих явдал хилийн бүс, зурваст амьдрагчдаар үл хязгаарлагдаж, хилийн боомтоор хил нэвтрэн хууль бусаар эд зүйлс, мал амьтан хил давуулах;

Хилийн бүс нутагт уул уурхай, ашигт малтмал ашиглах явц хурдацтай хөгжиж, энэ чиглэлээрх хайгуул, олборолт үйлдэврлэл нэмэгдэж хилийн аюулгүй байдлыг хангах орон зайн хүрэлцээгүй байдлыг бий болгож байгаа зэрэг нь хилийн бүс нутгийг тодорхой болгох, хилийн аюулгүй байдлыг хангах далайцтай бодлогын арга хэмжээ авахыг шаардаж байна.

2. Бүсчилсэн хил хамгаалалтад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчин

Дэлхий улс гүрнүүд хилийн аюулгүй байдлыг хангах асуудлыг бүс нутгийн хэмжээнд авч үздэг бөгөөд энэ ч утгаараа хилийн тойрог, бүс нутгийн удирдах газар, хуурай газар, далай тэнгисийн эргийн командлал зэргийг байгуулж, тухайн бүс нутгийн хилийн аюулгүй байдлал, хил хамгаалалтын бүхий л асуудлыг хуулиараа дээрх

нэгжүүдэд хариуцуулан бие даасан оперативын удирдлага, нэгдлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг.

Монгол Улсын хувьд газар нутаг өргөн уудам боловч хүн ам цөөн, хөгжил хоцрогдмол байгаа нь хилийн албыг бүс нутгийн хэмжээнд авч үзэхэд учир дутагдалтай хэдий ч одоо үйлчилж буй зарим хууль тогтоомж, эрх зүйн актын хүрээнд, ялангуяа Загийн Газрын мөрийн хөтөлбөрт “Бүсчилсэн хил хамгаалалтап шилжинэ” гэж заасан нь хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтыг бүсчилсэн хэлбэрт шилжүүлэх эрх зүйн үндсэн нөхцөл болж байна.

Нөгөө талаар мөрдөгдөж буй хууль тогтоомжоор заагдсан заалтууд, хуулийн орчин, хилийн цагийн байдлын өрнөлтүүд нь бүс нутаг, бүсчлэлийг тухайлан авч үзэх нөцөлийг хангаж байна.

Бүс нутаг, бүсчлэл, “Бүсчилсэн хил хамгаалалт”-ын асуудлууд:

1. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
2. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого;
3. Монгол УЛсын Засгийн газрйн 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүсчилсэн хил хамгаалалт”-ын талаар тусгагдсан зүйл заалт;
4. Хууль Зүй дотоод хэргийн Сайдын баталсан “Дархан хил” хөтөлбөр;
5. Монгол Улсын Их ХУрлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд тусгагдаж бүсчилсэн хил хамгаалалтад шилжих эрх зүйн үндсэн баримт бичгүүд болж байна.

Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Хил хамгаалах бодлого”-ын 4.3.2-д “Улсын хилийн бүсчилсэн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлнэ” гэж тусгагдсаны дагуу үе шаттайгаар бүрэн шилжихээр төлөвлөж, бүс нутгийн газар орон, байгаль цаг уур, хилийн цагийн байдал, алба хаах нөхцөл зэргээс хамаарч цалин хөлс, хоол хүнс, хувцас зэргийн бүх төрлийн хангалтуудыг харилцан ялгавартайгаар тогтооно гэжээ.

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол улсын засгийн газраас 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүсчилсэн хамгаалалт”-ын талаар тусгагдсан зүйл заалт, Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдаар батлагдсан “Дархан хил

хөтөлбөр”, Монгол Улсын Их хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг эрх зүйн баримт бичигт дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлогод:

- Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн. / I зүйлийн 1/
- Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана. / I зүйлийн 7/
- Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдоно. / I зүйлийн 8/
- Улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх. /II зүйлийн 1.11/
- Эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцөлийг хангасан хилийн боомтуудыг ажиллуулах. /II зүйлийн 10/
- Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах. /III зүйлийн 1/
- Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих. / II зүйлийн 7/

Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

- Монгол Улсын хил хамгаалалтад орчин үеийн техник технологи нэвтрүүлж, хил дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр хууль хяналтын байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулан, хил хамгаалалтын нэгдсэн тогтолцоог баталгаажуулах. /IY зүйлийн 3.1/

- Улсын хилийн бүсчилсэн /уулын, ой тайгын, говь цөлийн, тал хээрийн хэсгийн/ хамгаалалтын тогтолцоог бүрдүүлнэ. / IY зүйлийн 3.2/

Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдаар батлагдсан "Дархан хил хөтөлбөр"-т:

- Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалалтын нягтрал чадавхийг нэмэгдүүлэх, хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх, мэргэжлийн хилчдийг бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох, тэдний нийгмийн хамгааллыг сайжруулахад чиглэнэ. / I зүйл/

Монгол улсын хилийн тухай хуульд:

- Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, Монгол Улсын хилийн хууль тогтоомж, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн зурвас, боомт, бүс, хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, зорчигч, тээврийн хэрэгслийг **шалган нэвтрүүлэх, цэргийн, инженер-техникийн, мэдээлэл технологийн, тагнуулын, хилийн төлөөлөгчийн** арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсын хил хамгаалалт гэнэ./31-р зүйлийн 2/

- Хилийн цэргийн анги, салбарын тоо, байршил, зэрэглэлийг хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллаж, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн анги, салбартай харьцангуй ижил хэмжээнд байх зарчим баримтлан Засгийн газар тогтооно. /34-р зүйлийн 3/

- Монгол Улсын хилээр галт зэвсэг, мансууруулах бодисын хууль бус наймаа, хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, хүн малын гоц халдварт өвчин тархах, олон улсын террорист байгууллагын төлөөний этгээд улсын хил нэвтрэхээс урьдчилан сэргийлэхэд Хил хамгаалах албаны гүйцэтгэх үүрэг улам өсөн нэмэгдэж, хил хамгаалах арга, ажиллагааны агуулга, хэлбэрийг эрс шинэчлэхийг шаардах болсон.

- Үйлдвэрлэл, үйлчилгээ томоохон хот суурин газрууд болон төмөр замын дагуух бүс нутгуудад хүн ам хэт төвлөрсөн нь

ажилгүйдэл, ядуурал ихсэхэд нөлөөлж хүн амын шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйдэх хандлага өссөн.

- Хил зөрчигчдийн үйл ажиллагаа нь зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, орчин үеийн өндөр хүчин чадлын автомашин, холбоо дохиоллын хэрэгсэл ашиглан цаг хугацааг товчлох болсон бөгөөд улсын хилийг өөрсдийн гэмт үйлдлээ хэрэгжүүлэх объектоо болгосон.
- Хил орчмын нутаг дэвсгэрт улс орны болон бүс нутгийн хөгжилд чухал үүрэг роль бүхий уул уурхай, ашигт малтмалын орд газруудын хайгуул, олборлолт нэмэгдэж, цаашид өргөжих, тэдгээрийг дагасан олон төрөл үйлчилгээ, хууль бус аргаар алт олборлогчдын эгнээ жилээс жилд тэлэн өргөжиж байна.
- Байгаль экологийн өөрчлөлт, элсний нүүдэл, цөлжилт, гол горхи, нуур ширгэж үгүй болох процесс тасралтгүй явагдаж, хил хамгаалалтыг зохион байгуулан явуулахад хүндрэл, бэрхшээлт байдлууд бий болсон зэрэг нь улсын хил хамгаалалтын зохион байгуулалт, хангалт үйлчилгээ, хил хамгаалах байгууллагын байгуулалтад ялгавартай хандах үндсэн нөхцөлүүд болж байна.

Бүсчилсэн хил хамгаалалт */Хилийн тухай хуулийн 33 дугаар зүйл/*

Хилийн нөхцөл байдал, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт гэнэ. /33-р зүйлийн 1/

Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан хилчний хилийн нэмэгдэл, цалин, хангамж, материал хэрэгслийн хангалтын норм, хэмжээг Засгийн газар тогтооно. /33-р зүйлийн 2/

Бүсчилсэн хил хамгаалалтыг зохион байгуулах, түүний арга хэлбэр, хангалт үйлчилгээтэй холбоотой журам, зааврыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална. /33-р зүйлийн 3/

Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах бүсүүдийн онцлогийг авч үзвэл:

Говь цөлийн бүс: Далайн түвшингээс дээш 1150-1220 метр өндөрт өргөгдсөн Монгол Алтайн нурууны салбар уулсуудын өмнөт хэсэг Шаргын, Хөхөлзөхийн, Борзонгийн, Галбын говиуд, Говийн их, бага дархан газрын А.Б бүсүүд, элсэн цөлүүд бүхий Говь-Алтай аймгийн Бугат, Эрдэнэ, Алтай, Баянхонгор аймгийн Баян-Өндөр,

Шинэжинст, Өмнөговь аймгийн Гурвантэс, Ноён, Хүрмэн, Номгон, Баян-Овоо, Ханбогд, Дорноговь аймгийн Хатанбулаг, Хөвсгөл Улаанбадрах, Замын-Үүд, Эрдэнэ, Өргөн зэрэг 17 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурвас, хилийн 6 орчим отряд, 30 гаруй застав, 70 гаруй харуулын хариуцсан 2011.7 км хэсэг буюу улсын хилийн 26.0 хувь хамрагдана.

Байгаль цаг уурын онцлог: Сул шороон хөрстэй, тэгш тал, дов толгод жалга сайр ихтэй, зарим хэсэгтээ элсэн манхан болон цэрдэн хөрстэй, булаг шандуудын ихэнх нь ширгэсэн, ургамлын гарц тачир, малын бэлчээр хомс, сүүлийн жилүүдэд цөлжилт эрчимтэй явагдаж байна.

Зуны улиралд 35-45 хэм хүртэл халж, өвөлдөө 35 хэм хүртэл хүйтэрдэг жилд дунджаар 70-80 мм хур тунадас унадаг, хаврын улиралд элсэн болон шороон шуурга шуурдаг.

Дэд бүтцийн хувьд: Хилийн отрядууд нь төв суурин газраас алслагдсан, цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хилийн отрядоос застав хооронд дунджаар 60-400 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад ихтэй.

Бүсийн хэсэгт байгаа хилийн отряд, застав, харуулууд нь 81 булаг шанд, худгаас ундны усаа хэрэглэж байна. Үүний 60.4 хувь нь ундны усны эрүүл ахуйн шаардлага хангахгүй, хилийн застав, харуулуудын 40.2 хувь нь 5-68 км газраас ундны усаа зөөвөрлөдөг.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл:

Эерэг тал нь:

- Цэргийн хяналт явуулах, улсын хил хамгаалалтыг суурин болон хөдөлгөөнт харуулаар хамгаалах боломжтой;
- Орон нутгийн оршин суугчид нь хил орчмын нутаг дэвсгэрт тогтоосон дэглэм журмыг хүндэтгэн сахидаг.

Сөрөг тал нь:

- Төв суурин газраас алслагдсан, дэд бүтэц хөгжөөгүй;
- Дулааны улиралд зэрэглээ үүсэж хяналт явуулах боломж багасдаг;
- Орон нутгийн Засаг захиргааны нэгжүүд улсын хилээс алслагдсан, цөлжилт ихээр явагдаж, нүүдлийн мал аж ахуй эрхлэх боломжгүйгээс хил орчмын нутаг эзэнгүйдэж хүн амын суурьшил сийрэгжсэн;

- Хил хамгаалалтад ердийн хөсөг ашиглах боломж хязгаарлагдсан;
- Ундны усны эх булаг хатуулаг ихтэй, дулааны улиралд мах махан бүтээгдэхүүний хангалт зохион байгуулахад хүндрэлтэй;
- Удаан хугацаагаар шороон шуурга шуурч, ган зуд болох тохиолдол элбэг.

Тал хээрийн бүс: Далайн түвшингээс дээш 550-1200 метр өндөрт өргөгдсөн Дорнод Монголын тал нутаг, Халх, Нөмрөгийн дархан цаазат газрын А бүсүүд, тусгай хэрэгцээний газрууд бүхий Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Наран, Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Халх гол, Матад, Баянтүмэн, Чойбалсан, Чулуунхороот, Дашбалбар, Баяндун, Баян-Уул зэрэг 2 аймгийн 13 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурвас, хилийн 6 орчим отряд, 40 гаруй застав, 80 гаруй харуулын хариуцсан 1857.3 км хэсэг буюу улсын хилийн 22.5 хувь хамрагдана.

Байгаль цаг уурын онцлог нь: Тэгш тал, элсэн манхан, уул, толгод, гуу жалга, гол, горхи, нуур, намаг, хусан ойтой, үржил шим сайтай хөрстэй, ургамлын гарц малын бэлчээр сайн боловч сүүлийн жилүүдэд Сүхбаатар аймгийн өмнөд хилийн хэсгээр цөлжилт эрчимтэй явагдаж байна.

Зуны улиралд 30-35 хэм хүртэл халж, өвөлдөө 25-30 хэм хүртэл хүйтэрдэг жилд дунджаар 100-150 мм хур тунадас унадаг, хаврын улиралд шороон шуурга шуурдаг.

Дэд бүтцийн хувьд: Хилийн отрядууд нь төв суурин газарт байрладаг, хилийн заставууд цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хилийн отрядоос застав хооронд дунджаар 25-300 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад багатай.

Хилийн бүс зурваст оршин суугчид, ажил үйлдвэр эрхлэгчдийн нягтрал нэмэгдэх хандлагатай.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл:

Эерэг тал нь:

- Нэг цэгээс хяналт явуулах, хүч хэрэгслийн шилжилт хөдөлгөөн үйлдэх боломж өндөр;
- Улсын хил хамгаалалтыг суурин болон хөдөлгөөнт харуулаар хамгаалах боломжтой;

- Инженерийн байгууламжийг хил хамгаалалтад ашиглах боломж ихтэй;
- Хил хамгаалалтад агт уналга, тээврийн хэрэгсэл ашиглах боломжтой;
- Мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариалан хөгжүүлэхэд тохиромжтой.

Сөрөг тал нь:

- Өнгөлөн далдлалтыг зохион байгуулах боломж харьцангуй муу;
- Цасан болон шороон шуургатай үед цэргийн хяналт хийх боломж хязгаарлагдмал;
- Байгалийн онц аюултай үзэгдлүүд, хээрийн түймэр их гардаг.

Ой тайгын бүс: Далайн түвшингээс дээш 1200-3150 метр өндөрт өргөгдсөн, Их Саян, Хангай, Хэнтийн нурууны салбар уулсууд бүхий Завхан аймгийн Тэс, Баянтэс, Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул, Баянзүрх, Улаан-Уул, Цагааннуур, Эрдэнэбулган, Цагаан-Үүр, Ханх, Ренчинлхүмбэ, Булган аймгийн Сэлэнгэ, Тэшиг, Сэлэнгэ аймгийн Түшиг, Сүхбаатар, Алтанбулаг, Хүдэр, Ерөө, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр, Дадал, Дорнод аймгийн Баян-Уул, Баяндун, Дашбалбар зэрэг 6 аймгийн 23 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурвас, хилийн 6 орчим отряд, 30 гаруй застав, 60 гаруй харуулын хариуцсан 2276.2 км хэсэг буюу улсын хилийн 27.5 хувь хамрагдана.

Байгаль цаг уурын онцлог: Битүү ой тайга, хөвч өндөр уул, сарьдгууд үргэлжлэн тогтсон, уул нурууд, гүн хавцал ангал, эгц хадан хясаа, туулахад хүндрэлтэй даваа, уулын түргэн урсгалт голууд, 50-60 хувь нь намгархаг хөрстэй.

Байгалийн баялаг ихтэй, ургамлын гарц, малын бэлчээр сайн. Газрын гадаргын 2.0 орчим хувийг усны эх булгууд эзэлдэг. Зуны улиралд 15-30 хэм хүртэл халж, өвөлдөө 30-40 хэм хүртэл хүйтэрдэг жилд дунджаар 300-400 мм хур тунадас унадаг.

Дэд бүтцийн хувьд: Хилийн отрядууд нь төв суурин газар байрласан, зам харилцаа дунд зэрэг, цахилгаан эрчим хүчинд хилийн заставууд холбогдоогүй, хилийн отрядоос застав хооронд дунджаар 35-260 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад ихтэй.

Хүн амын суурьшил сайн, орон нутгийн Засаг захиргаа хил хамгаалах нэгжүүддээ ойрхон.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл:

Эерэг тал нь:

- Өнгөлөн далдлалтын боломж өндөр;
- Улсын хил хамгаалалтад агт уналга, тээврийн хэрэгсэл хэрэглэх боломжтой;
- Мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариалан хөгжүүлэхэд тохиромжтой;
- Байгалийн өгөөж ашиглах боломжтой.

Сөрөг тал нь:

- Нэг цэгээс хяналтад хамрагдах хэсэг бага;
- Хилийн манаа овор ихтэй хэрэгсэл авч явахад хүндрэлтэй;
- Цаг агаар газар орны онцлогоос хамаарч үзэгдэх орчин хязгаарлагдмал нөхцөл үүсэх магадлал их;
- Хилийн манаа улсын хил зөрчсөн этгээдүүдийн отолтод өртөх;
- Хилийн манаа төөрөх, зүг чигээ алдах;
- Хилийн зөрчил гарсан үед эрэл, операц явуулах, цэргийн албан хаагчдыг шилжүүлэн байрлуулахад хүндрэлтэй;
- Холбоо харилцан ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй;
- Байгалийн бартаа саад, далдлалт их;
- Хилчид зэрлэг араатан амьтан, хортон шавьжид өртөх магадлал өндөр;
- Хур тунадас их унадгаас даваа гүвээ, голын гармууд хаагддаг.

Уулын бүс: Далайн түвшингээс дээш 1500-4000 метр өндөрт өргөгдсөн өргөн уудам, уулархаг нутагтай, уул толгод, хад асга ихтэй, эх газрын эрс тэс уур амьсгалтай. Тус бүс нутагт Баян-Өлгий аймгийн Ногооннуур, Цэнгэл, Улаанхус, Сагсай, Алтай, Дэлүүн, Булган, Увс аймгийн Бөхмөрөн, Сагил, Давст, Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Ховд аймгийн Булган, Үенч, Алтай, Говь-Алтай аймгийн Тонхил, Бугат, Алтай, зэрэг 4 аймгийн 19 сумын нутаг дэвсгэр дэх хилийн бүс зурвас, хилийн 5 орчим отряд, 30 гаруй

застав, 90 гаруй харуулын хариуцсан 1985.5 км хэсэг буюу улсын хилийн 24.0 хувь хамрагдана.

Байгаль цаг уурын онцлог: Мөнх цаст сарьдгууд, түргэн урсгалт уулын голууд, үргэлжлэн тогтсон уул нурууд, эгц хадан хясаа, туулахад хүндрэлтэй зам харгуйтай.

Нутгийн ихэнх хэсгээр ялзмаг хөрстэй, уулын хэсэгтээ цэвдэгтэй, Уулын тагаар өвөлдөө 40 хэм хүртэл хүйтэрч, зундаа 40 хэм хүртэл халдаг. Хур тунадас жилдээ 250-350 мм орчим унадаг. Жилийн дөрвөн улиралд халуун, хүйтэн нь тогтвортой биш байнга өөрчлөгддөг.

Дэд бүтцийн хувьд: Хилийн отрядууд нь төв суурин газар байрласан, цахилгаан эрчим хүчинд хилийн заставууд холбогдоогүй, хилийн отрядоос застав хүртэл дунджаар 35-250 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад ихтэй.

Хүн амын суурьшил сийрэг, сүүлийн жилүүдэд төв суурин газар луу шилжих хөдөлгөөн ихсэж байгаа.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл:

Эерэг тал нь:

- Хил зөрчигчид нь улсын хил зөрчихдөө уулын ам, хөндий, даваг ашигладаг тул хилийн зөрчил гарч болзошгүй чиглэлийг тогтооход дөхөмтэй;
- Өнгөлөн далдлалтын боломж өндөр;
- Улсын хил хамгаалалтад агт уналга хэрэглэх боломжтой;
- Мал аж ахуй, туслах аж ахуй эрхлэх, байгалийн баялаг ашиглахад тохиромжтой.

Сөрөг тал нь:

- Нэг цэгээс хяналтад хамрагдах хэсэг бага;
- Хилийн манаа овор ихтэй хэрэгсэл авч явахад хүндрэлтэй;
- Газар орны бартаа нугачаа, далдлалт их;
- Цаг агаар газар орны онцлогоос хамаарч үзэгдэх орчин хязгаарлагдмал;
- Хилийн манаа улсын хил зөрчсөн этгээдүүдийн отолтод өртөх магадлалтай;
- Хилийн зөрчил гарсан үед эрэл, операц явуулах, хүч хэрэгслийн шилжилт хөдөлгөөн үйлдэхэд бэрхшээлтэй;
- Холбоо харилцан ажиллагааг зохион байгуулахад хүндрэлтэй;

- Хил хамгаалалтад тээврийн хэрэгсэл ашиглах боломж хязгаарлагдмал, авто машин тогтоосон нормоос 2 дахин илүү шатах тослох материал зарцуулдаг;

- Цаг агаарын огцом өөрчлөлтөд хилийн манаа төөрөх, осгох, цасны нуранги, аянга цахилгаанд өртөх магадлал өндөр;

- Яаралтай эмнэлгийн тусламж бүх төрлийн хангалт үйлчилгээ авахад хүндрэлтэй зэрэг сөрөг талуудулсын хил хамгаалалтад сөргөөр нөлөөлдөг.

Дүгнэлт

Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол улсын засгийн газраас 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүсчилсэн хамгаалалт”-ын талаар тусгагдсан зүйл заалт, Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдаар батлагдсан “Дархан хил хөтөлбөр”, Монгол Улсын Их хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бүсчилсэн хил хамгаалалтын төсөл, дэд төслүүд хэрэгжиж, хил хамгаалалтад эерэгээр нөлөөлж, тодорхой хэмжээгээр үр дүнгээ өгч, ахиц дэвшил гарч байна.

Ашигласан материал

1. Монгол Улсын Төрөөс Хилийн талаар баримтлах бодлого 2002 он
2. Монгол Улсын Хилийн тухай хууль 2016 он
3. Монгол улсын засгийн газраас 2008-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөр 2009 он “Бүсчилсэн хамгаалалт”-ын талаар 2 зүйл.
4. Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдаар батлагдсан “Дархан хил хөтөлбөр”
5. Монгол Улсын Их хурлын 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал 2001 он
6. Бүсчилэн хил хамгаалалтын төсөл 2009 он
7. Усан хил хамгаалалтын дэд төсөл 2009 он
8. Говь цөлийн бүсийн дэд төсөл 2009 он
9. Тал хээрийн бүсийн дэд төсөл 2009 он
10. Уулын бүсийн дэд төсөл 2009 он
11. Ой тайгын бүсийн дэд төсөл 2009 он

ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛИЙН СОНСОНГЧДЫН СУРАЛЦАХУЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛ, ТЭДНИЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗАРИМ АРГА ЗАМ

Д.Энхтайван
Хилийн албаны сургуулийн
Хилийн албаны тэнхимийн ахлах багш,
хошууч

Удиртгал: Дэлхийн нийтийн боловсролын чиг хандлага нь нийгмийн хурдацтай хөгжил, мэдээлэл технологийн зуунд дасан зохицож амьдрах, хөгжих, улмаар амьдралын чанараа сайжруулах хандлага, арга барилтай иргэн төлөвшүүлэхэд анхаарч байна. Сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжлийн асуудал дэлхий нийтийн тулгамдсан асуудал болсон бөгөөд ялангуяа эдийн засаг, нийгэм, соёлын зэрэг бүхий л салбарын даяаршил улам бүр эрчимжиж байгаа энэ зууны хувьд хэрхэн хамтаар хөгжих, даяаршил болон дангааршил, нийтлэгжих болон ондооших харилцан эсрэг хандлагыг хүлээн зөвшөөрөх, зэрэгцэн орших боломжийг тодорхойлох шинэ зууны иргэдийг бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт болоод байна.

Орчин үед өөртөө итгэлтэй, хувийн зохион байгуулалт сайтай /менежмент/, бусдыг манлайлж нийгмийн олон талт харилцаанд зохицон өөрийн байр суурийг эзлэх, хамт олны хөгжилд өөрийн хувь нэмрийг оруулах чадвартай иргэн амжилттай сурч, ажиллаж, амьдрах боломжтойг өнөөгийн нийгмийн амьдрал харуулж байна. тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд “Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий монгол хүнийг хөгжүүлэх” зорилго дэвшүүлсэн байдаг бол хүний хөгжлийн үзүүлэлтийг тооцох үндсэн гурван хэмжигдэхүүний нэг нь эрдэм мэдлэг эзэмшсэн байдал буюу боловсролын түвшин байдаг.

Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “Сургуулийг хүн хөгжлийн төв болгоно. Сургууль хүүхдэд мэдлэг, боловсрол, чадвар олгодог төдийгүй эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, хүмүүжил, төлөвшилтэй, амьдрах ухаантай, эх оронч, үндэсний бахархалтай хүн болоход нь тусалдаг болно”, “... дээд боловсролд хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын

бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ", "Бүх шатны боловсрол, сургалтын байгууллагад нийгэм, сэтгэл зүй, дэд бүтцийн эрүүл, аюулгүй, ээлтэй орчин, нийгмийн үйлчилгээг бий болгоно" зэрэг боловсролын салбарт хүний хөгжлийг дэмжих асуудлуудыг тусгасан байна[164].

Иймд сонсогч, суралцагсдыг мэргэжилд чиглүүлэхээс гадна мэдлэг мэдээллээ ашигладаг, хөрвөх чадвартай, чөлөөтэй сэтгэж, үзэл бодлоо хуваалцах, бие даасан хариуцлагатай иргэн байхад чиглэсэн сургалтын хандлага руу хөтлөх шаардлагатай бөгөөд бусад их дээд сургуулиудтай харилцан уялдаа холбоотой ажиллаж оюутан залуусын танин мэдхүйн орчин хүрээг тэлэх бүтээлч Түүнчлэн Дотоод хэргийн их сургуулийн Хөгжлийн стратеги хөтөлбөр /2016-2025/-г Хууль зүйн сайдын 2016 оны А/119 тушаалаар баталж, энэ хөтөлбөрөөр Их сургуулийн алсын харааг "Хууль сахиулах салбарын шинжлэх ухаан, боловсролын хөгжилд тэргүүлэх байр суурьтай, олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулагч мэдлэг оюуны төв байна" гэж тодорхойлж, "Хүний эрх, шударга ёс, хуулийг дээдлэх хандлагыг суралцагч бүрт төлөвшүүлж, хууль сахиулах салбарын дэвшилд бодитой хувь нэмэр оруулах бүтээлч сэтгэлгээтэй, мэргэжлийн өндөр ёс зүй, чадвартай мэргэжилтэн бэлтгэнэ"[2] гэж эрхэм зорилгоо тодорхойлсон, мөн их сургуулийн Хил Хамгаалах Ерөнхий газартай 2018 оны байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд "... Хилийн албаны сургуулийн сургалтын үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэх, эрдэм шинжилгээ, судалгааны үр нөлөөг дээшлүүлж, улсын хил хамгаалалтад чиглүүлэх, багш алба хаагчдын мэргэжлийн мэдлэг, ур чадварыг сайжруулах" зэрэг Хилийн албаны сургуулийн сонсогчдын бие даан суралцах хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндэслэлийг тодорхойлж өгсөн байдаг.

Хөтөлбөр хэрэгжүүлэх хэрэгцээ, шаардлага.

/баримт нотолгоонд суурилсан байдал/

---

[164] "Боловсролын инновацийн асуудал" сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2016 он

[2] "Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам ОУЭШХ-ын эмхэтгэл, УБ. 2018. 134 дэхь тал"

Өнөөгийн нийгэмд чадварлаг боловсон хүчин бэлтгэхэд сонсогчдыг зөв төлөвшүүлэн хөгжүүлэх, танхимийн болон танхимийн бус цаг ашиглалтыг тодорхойлох, нөгөө талаар сургууль, багш, эцэг эхийн хараа хяналт, хамтын ажиллагааг сайжруулах суралцагсдын сурах идэвхи хандлага, ёс зүй дээр бүхий л хүрээнд хамтын хүчээр анхаарч ажиллах.

Уг хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр их сургуулийн захиргаа болон бүрэлдэхүүн сургууль, багш, сонсогчдын зүгээс юуны өмнө ямар үйл ажиллагаанд анхаарч, хэрхэн яаж хамтран ажиллах, цаашид аль хүрээнд ямар асуудлыг дэвшүүлж, шийдвэрлэх шаардлагатай байгааг тодруулан, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган ажиллах юм.

2021-2022 онд авсан Хилийн сургуулийн төгсөгчид судалгааны үр дүнгээс харахад:

1. Нэгдсэн давтлагын цаг гаргаж өгөх, захиргааны болон аж ахуйн ажил их хийлгэж байгаагаас хичээл тасалдах, даалгавар хийх орчин, нөхцөл бүрдүүлэхгүй байна.
2. Ном, гарын авлага хүрэлцэхгүй байгаа тул ХХЕГ-тай хамтарч гаргах шаардлагатай
3. Хичээлийн хөтөлбөр дээр цэргийн мэргэжлийн хичээлийн цаг, сэдвийг бага тавьдаг тул нэмэгдүүлэх шаардлагатай.
4. Хүнтэй харьцах хичээл ордоггүй, тийм боломж олгодогүй гэж 80 хувь нь үзсэн байна
5. Суралцагч нар сургууль дээр өөрийгөө хөгжүүлэх боломж маш хангалтгүй, юу хийлгэх гэж байгаа нь тодорхойгүй жагсаадаг, давтлагын цаг гаргадаггүй гэж 70 хувь нь үзсэн бол үлдсэн 30 хувь нь боломжтой гэж дүгнэсэн байна.
6. Давтлага, бие даалтын цаг гаргаж өгсөнөөр багаар ажиллах боломж бүрдэнэ гэж 73 хувь үзсэн байна.
7. Албан хэрэг хөтлөлтын хичээлийг амьдралд ойртуулж, хилийн застав, харуул, отрядын албан тушаалтны хэмжээнд тушаал төлөвлөх, төлөвлөгөө боловсруулах, илтгэл рапорт бичих гээд наад захын мэдлэг, дадлагыг олгох хэрэгтэй байна. Төгсөгчид энэ тал дээр маш муу мэдлэг, дадлагатай төгсөж байна.
8. Бага дарга нарыг сарын хугацаатай удирдуулаад сольж байхгүй бол 4 жил жагсаалд зогсчихоод төгсөөд жагсаалын өмнө гарахаараа хөл нь чичирээд, гар нь салганаад, дуу нь гарч өгөхгүй

хоосон ханиалгаад байдаг тул хүнийг захирах, командлах ур чадварыг дээшлүүлэх шаардлагатай.

9. Их сургуулийн хэмжээнд сонсогчдын бие даалтын цагийг албан ёсоор гаргаж, хэвшүүлж мөрдөх нь зүйтэй. Үдээс хойш ямар ч шалтгаан тайлбаргүйгээр жагсаж, цагийг дэмий өнгөрөөдөг. Ялангуяа нууцын хичээлийг номын санд сууж хийх шаардлага гардаг ч тийм бололцоо олгодоггүй. Сонсогчдыг захиргааны болон аж ахуйн ажлаар их дарж хичээлээс их хөндийрүүлж байна. Тэгээд ч дараа нь хичээл нөхөх асуудал, цаг гаргадаггүй гэж хариулсан байна.

Сонсогч, төгсөгчдөөс авсан дээрх судалгаанаас түүвэрлэн үзэхэд цогц чадамжийг хөгжүүлэх шаардлагатай бөгөөд бие даан хөгжихөд саад болж буй хүчин зүйлүүдийг судалж, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замыг эрэлхийлэх зайлшгүй шаардлага бий болж буй юм.

Эдгээр болон бусад хүчин зүйлүүдээс шалтгаалж сонсогчдын сурах идэвхи хандлага жил бүр муудаж, танхимийн болон танхимийн бус сургалтын цаг ашиглалт муу, үр ашиггүй өнгөрөөх, идэвхгүй, бэлэнчлэх сэтгэлгээтэй болох нөхцөл бүрдэж буй учраас Хилийн албаны сургуулийн сонсогчдын бие даан хөгжих хөгжлийн хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх албаны болон нийгмийн шаардлага байна гэж үзсэн.

Түүнчлэн суралцагчдыг нийгэмд тустай, хүмүүнлэгийн олон талт үйл ажиллагааг зохион байгуулах, түүгээр дамжуулан суралцагчдад хүмүүнлэг, энэрэнгүй, эх оронч үзлийг бий болгох, нийгмийн гишүүний хувьд аливаа сөрөг үзэгдэлд хариу нөлөөлөх мэдрэмжтэй, идэвхитэй байр суурьтай байх хандлага төлөвшүүлэх чиглэлээр ажлууд зохион байгуулагдаж байгаа боловч суралцагчдын тэгш оролцоог шаарддаггүй, тохиолдлын шинжтэй, нэгдсэн зохион байгуулалт, нэгдмэл зорилгод чиглээгүй сул талтай байна.

Хөтөлбөрийн зорилго, хүрэх үр дүн. Суралцагчдад цэргийн алба, бие бялдар, сэтгэл зүйн бүрэн төлөвшил олгох, мэдлэг, ур чадвараа тасралтгүй дээшлүүлэх, өөрчлөлтийг даган хувьсах, нийгэм, ажлын байрны сөрөг нөлөөллийг бууруулах, бүтээлч, асуудал шийдвэрлэх, амьдралын хэв маягийг зөв сонгох чадвар эзэмшүүлэх замаар төрийн тусгай албанд тогтвортой ажиллахад шаардагдах хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэгдэнэ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүрэх үр дүн

/шийдэл боловсруулсан байдал/

1.Хувь хүний ур чадвар, дадал, төлөвшил

-Шинийг эрэлхийлэх, асуудал шийдвэрлэх чадвар. /асуудлыг тодорхойлж, шинэ санаа гаргах, зураглах, боломжит хувилбарыг сонгож, илэрхийлэн харуулах/;

-Шинжлэн судлах, шийдэл гаргах /таамаглал дэвшүүлэн, харьцуулсан судалгаа, анализ хийж, загварчилж,баримт бичиг боловсруулах/;

-Системтэйгээр төлөвлөх / хоорондоо хамааралтай зүйлсийг бүхлээр нь олж харах, харилцан хамаарлыг нь ойлгож, ач холбогдлоор нь ангилан, чухал санаан дээр төвлөрч, харилцан хамаарлыг нь шалгах, харьцуулан сонгох/;

-Хувь хүний ур чадвар ба дадал /шинийг санаачлах эрмэлзэлтэй, уламжлалыг дээдлэн, уян хатан бүтээлч сэтгэлгээтэй байх, хувь хүний мэдлэг, ур чадвар, төлөвшлийг үнэлж, ухамсарладаг, бие даан суралцах ба цагийн болон нөөцийн менежментийг хэрэгжүүлдэг байх/.

2. Хүмүүстэй харилцах ур чадвар: /багаар ажиллах чадвар ба харилцаа/

-Багаар ажиллах /Баг бүрдүүлэх, багийг удирдах, хамтран ажиллах, манлайлах ур чадвартай байх/;

-Харилцааны чадвар /харилцааны стратеги, бүтцийг ойлгодог, бичгийн, электрон, мултимедиа, график дүрслэлээр болон яриа, бичгээр тайлагнах, хүнтэй харилцах үндсэн ур чадвартай байх/.

3. Бие бялдрын хөгжил, гардан тулааны бэлтгэлжилт

Бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийг хүч, тэсвэр, хурд, уян хатан, авхаалж самбаа гэсэн 5 чанараар хичээлийн жил бүр сонсогчдын хүрсэн түвшинг тогтоож, сонсогчдын бие бялдрын хөгжлийн хүрвэл зохих түвшинг чанар тус бүрээр тогтоож, 2 жил тутамд шинэчлэх.

4. Цэргийн албаны мэдлэг, ур чадвар

-Цэргийн алба хаагчийн эрх, үүрэг, хариуцлага

-Цэргийн алба хаагчийн хоорондын харилцаа

-Жагсаал түүнийг удирдах

-Цэргийн алба хаагчид хүртээх сайшаал, түүнийг хэрэглэх журам

-Цэргийн алба хаагчид оногдуулах шийтгэл, түүнийг хэрэглэх журам

-Рот, баталион захирагч, салааны захирагч, түүний орлогчийн эрх, үүргийг судалж мэдсэн байх;

-Захирагдагч нарын нэр төр, эрхийг хамгаалах, тэдэнтэй дүрмээр тогтоосон хүнлэг, энэрэнгүй, нөхөрсөг харьцах, удирдах;

-Бие бүрэлдэхүүний өмнө дүрмийн дагуу биеэ зөв авч явах

-Цэргийн дүрэмт хувцас өмсөх дүрмийн дагуу хувцас хэрэглэлийг зүүж хэрэглэх. Бүрэлдэхүүнд хувцасны үзлэг хийх

5. Сэтгэл зүйн бэлтгэл

Нэгдүгээр дамжааны суралцагчид:

-Алба, үйл ажиллагааны чиглэлээр суралцагч өөрийн мэдээлэл, мэдлэгийг олж авах,

-Багш, албан хаагчид, захирагч, бага дарга нарын үйл ажиллагаа, эрх мэдлийн хүрээний талаар тодорхой мэдэгдэхүүнтэй болж, хэрхэн харилцах сэтгэл зүйн бэлтгэлтэй болох

-Сургалт, хичээлийн чиглэлээр мэдээлэл, мэдлэгийг хүлээж авч, түүнд хэрхэн суралцах тухай арга барилыг олж эзэмших,

-Өөрийн сэтгэл зүйн онцлогийг танин мэдэх сэтгэц оношилгоонд хамрагдаж, сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээнд хамрагдах,

-Алба үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах сэтгэл зүйн бэлтгэлийг эзэмших.

- *Хоёрдугаар дамжааны суралцагчид:*

-Суралцагч өөрийгөө хөгжүүлэх чиглэлээр идэвхи санаачлага гаргаж, идэвхитэй хөгжүүлэх;

-Сургуулийн ерөнхий дэг, харилцааны соёл, нийтлэг хэмжигдэхүүнийг хэлбэрэлтгүй мөрдөх хэвшлийг өөртөө суулгасан байх,

-Багш, албан хаагчид, захирагч, бага дарга, суралцагсадтай харилцах тогтсон харилцааны соёлыг баримталж хэвшсэн байх,

-Хамт олныхоо сэтгэл зүйн онцлогийг танин мэдэж, тэдэнтэй харилцах өөрийн гэсэн арга зүйтэй болох,

-Албаны үүрэг гүйцэтгэх сэтгэл зүйн бэлтгэлтэй болох,

- *Гуравдугаар дамжааны суралцагчид:*

-Эзэмших мэргэжлийн үйл ажиллагааны талаар мэдлэгтэй болж, түүнийг хэрхэн гүйцэтгэх тухай сэтгэл зүйн бэлтгэлтэй байх,

-Албаны онцгой нөхцөл байдлын үед ажиллах арга тактик боловсруулах мэдлэгийг эзэмших, ажиллах сэтгэл зүйн бэлтгэлтэй байх,

-Албаны үйл ажиллагаанд хэрэглэгдэх зайлшгүй зүйлсийн мэдлэгтэй байх, түүнийг хэрэглэх чадварыг эзэмших,

-Албанд хөтлөгдөх бичиг баримтыг хөтлөх чадвартай болох, түүнийг явуулж хэвшсэн байх,

-Ажлын орчин нөхцөлд дасан зохицох суурийг тавьсан байх, ажиллах сэтгэл зүйн бэлтгэлээ нэмэгдүүлэх,

-Ажлын байрны стресс, бухимдлын нөхцөл байдалд хэрхэн өөртөө сэтгэл зүйн анхан шатны тусламж үзүүлэх чиглэлээр мэдлэгтэй болсон байх.

6. Нийгмийн оролцоо, хувь хүний авьяас, сонирхлын хөгжил

Суралцагчид суралцах хугацаандаа:

-Хувь хүний хөгжлийг дэмжих клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдсан байх;

-Мэргэжлийн чиглэлийн клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд тогтмол хамрагдсан байх;

-Амьдралын хэв маягаа өргөн хүрээтэй тодорхойлж, идэвхитэй, сэтгэл хангалуун амьдрах хэвшилтэй болсон байх;

-Нийгмийн төрөл бүрийн үйл ажиллагаа, хүмүүнлэгийн үйл ажиллагаанд сайн дурааараа оролцож хэвшсэн байх;

№	Хөгжүүлэх сургалтын чиглэл	Сургалтын агуулгад эзлэх хувь /100 хувиас/	Бие даан судлах хэлбэр, өдөр
1	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх ур чадварыг /илтгэх, мэтгэлцэх чадвар/ хөгжүүлэх	15	Клуб, дугуйланд хамрагдах /14 хоногт 1 удаа-Пүрэв гаригт/
2	Цэргийн албаны мэдлэг, ур чадвар, дадлыг хөгжүүлэх	20	Цэргийн дүрэм, ур чадварын мэдлэг олгох бие даалтын өдөр

			/7 хоног бүрийн Баасан гаригт/
3	Бие бялдар, өөрийгөө болон бусдыг хамгаалах гардан тулааны чадварыг хөгжүүлэх	20	Клуб, дугуйланд хамрагдах /14 хоногт 1 удаа-Пүрэв гаригт/
4	Гадаад хэлний хэрэглээний чадварыг хөгжүүлэх	15	Клуб, дугуйланд хамрагдах, бие даан судлах
5	Сэтгэл зүйн бэлтгэлээ хангах чадварыг хөгжүүлэх	10	Танхимийн болон бие даалтын сургалтын үеэр хавсран хөгжүүлэх
6	Хувь хүний авьяас, сонирхлын хөгжүүлэх	10	Клуб, дугуйланд хамрагдах /14 хоногт 1 удаа-Пүрэв гаригт/
7	Нийгэмд идэвхитэй байр суурьтай байх, багаар ажиллах, харилцааны соёл, сайн дурын хүмүүнлэгийн үйл ажиллагааны оролцоог дэмжих	10	Хувь хүний ур чадвар, дадал төлөвшил хөгжүүлэх бие даалтын өдөр /ЭЗНУС-иас /7 хоног бүрийн Мягмар гаригт/

Дээрх цогц чадамжийг бие даан хөгжүүлэх шаардлагыг харгалзан, их сургуулийн нэгдсэн график төлөвлөгөө болон хилийн албаны сургуулийн сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан авч үзэж, дээрх бие даан хөгжих чиглэлүүдийн заримыг нь хураангуйлан хамтатгаж, нэмэлтээр зайлшгүй чадвар суулгах шаардлагатай мэргэжлийн болон ерөнхий суурь хичээлүүдийн даалгавар, бие даалтуудыг хуваарьтайгаар хийлгэх зорилгоор ажлын 5 хоногийн 4 өдөрт зохион байгуулахаар дараах хуваарийг төслөөр боловсруулсан. Үүнд:

Сонсогчдын бие даан суралцах, хөгжүүлэх хуваарь /төсөл/

№	Өдөр	Бие даан суралцах үйл ажиллагааны чиглэл	Хариуцах эзэн	хэлбэр
1	Даваа	Мэргэжлийн мэдлэг, ур чадвар олгох бие даалт	Мэргэжлийн тэнхимийн эрхлэгч нар	Бие даалт
2	Мягмар	Хувь хүний ур чадвар, дадал төлөвшил олгох бие даалт	Ерөнхий суурь тэнхимийн эрхлэгч нар	Бие даалт
3	Лхагва	Сонсогчийн гадуур судалгааны цаг	Дамжааны захирагч нар	Гадуур
4	Пүрэв /тэгш, сондгой/	Клуб, дугуйланд хамрагдах болон эрдэм шинжилгээ судалгааны ажил	Клуб, дугуйлангийн удирдагчид	Клуб, дугуйлан
5	Баасан	Цэргийн дүрэм, ур чадварын мэдлэг олгох	Дамжааны захирагч багш нар	Бие даалт

Дүгнэлт:

Сайн дурын үйл ажиллагаанд хувь хүн эсхүл баг, хамт олноороо ашгийн төлөө бус, хүмүүнлэгийн үйл ажиллагааг

санаачлах, улмаар оролцох Их сургуулийн бүх шатны боловсролын зэрэг олгох сургалтанд хамрагдаж буй суралцагчид нь хичээлийн жилд 1-ээс доошгүй удаа хүмүүнлэгийн үйл ажиллагаанд заавал оролцож.

Клуб, дугуйланд суралцагчдын нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалах, суралцаж буй мэргэжлийн чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалт явуулах, сонирхлын бүлгээрээ нэгдэх, сурах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх арга зүйг эзэмших, нийгэмд бие хүн болон төлөвших, хамт олонч уур амьсгалыг бий болгоход чиглэгдсэн нэгдлийг ойлгон суралцах хугацаандаа багагүй цагийг клуб, дугуйлангийн үйл ажиллагаанд хамрагдахад зарцуулах. Сургалтын төлөвлөгөөний дагуу явагдах бүх хэлбэрийн хичээлийг явуулах боломжийг бүрэн хангасан техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлага хангасан кабинет, лаборатори, танхимтай байхаас гадна тэдний дунд чөлөөт цаг, соёл олон нийтийн үйл ажиллагаа явуулах, баг бүлгээр ажиллах зориулалттай анги, танхим, ариун цэврийн өрөө, сургуулийн орчинд амрах, түр саатах тохижуулсан орон зайтай байх.

Ашигласан материал:

1. “Боловсролын инновацийн асуудал” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлын эмхтгэл. УБ., 2016 он

2. Ууганбилиг А., Хилийн отрядын тусгай томилгоот бүлгийн бэлтгэлжилтйг сайжруулах зарим асуудал /магистрын ажил/ УБ., 2008 он

3. Хилээр овоглосон сургууль. УБ., 2009 он

4. Цэргийн сэтгэл зүйн хангалтын онолын үндэс Мөнхсаруул Т., УБ., 2013

5. Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам ОУЭШХ-ын эмхэтгэл., УБ. 2018. 134 дэх тал

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ТОГТОЛЦООГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ШААРДЛАГА, ҮНДЭСЛЭЛ

О.Гантулга
Хилийн боомтын аюулгүй байдал, шалган нэвтрүүлэх албаны тэнхимийн ахлах багш, хил судлалын ухааны докторант, хошууч

Товч агуулга: Орчин цагийн ойлголтоор улсын хил хамгаалалтын тогтолцоо гэдгийг шууд утгаар нь улсын хил, хязгаар нутагт үндэсний аюулгүй байдлыг хангах гэж ойлгох шаардлагатай бөгөөд энэ нь тогтолцоо байна уу, үгүй юу эсвэл яаж бүрдүүлэх вэ гэдгийг шинжлэх ухааны үндэстэй, онол арга зүйн дагуу дэлхийн нийтлэг жишиг, өөрийн орны өвөрмөц онцлогийн дагуу судалж, боловсруулан, хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үнэн хэрэгтээ, энэ тогтолцоог байна гэж үзвэл зөвхөн Хилийн цэрэг юм. Иймд уг асуудлыг өнөөгийн түвшинд зөв шийдэх үүднээс энэхүү сэдвийг судлан дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Улсын аюулгүй байдлын талаар эрдэм шинжилгээ судалгааны ажил хязгаарлагдмал хүрээнд бүрэн бус хэмжээнд хийгдэж байна. Гэвч улс орны хэмжээнд хийгээд улсын хилийн орон зайд аюулгүй байдлын удирдлага ямар байх талаар хийгдсэн бодитой судалгааны ажил цөөнгүй байна. Улсын хилийн аюулгүй байдлын тухай ойлголтыг тодруулах, түүний удирдлагын тогтолцоо, хэв шинжийг тодорхойлж амьдралд хэрэгжүүлэх зорилгоор уг сэдвийг судлах хэрэгтэй байна.

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлууд төр захиргааны маш олон байгууллагуудыг хамрах бөгөөд түүний төлөө хүлээх хариуцлагыг тооцох, ялангуяа хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдсэн, эс бүрдсэн эсэх талаар тодорхой болгох зайлшгүй шаардлагатайг гэрчилж байна гэж үзэж болно.

Түлхүүр үгс: Улсын хил, хилийн аюулгүй байдал, Хил хамгаалах байгууллага,

Үндсэн хэсэг:

Аюулгүй байдлын тухай ойлголт нь олон чухал шинж чанарыг агуулж байдаг. Тэр дундаа тухайн орны өөрийнх нь хөгжилтэй аюулгүй байдлын асуудал шууд холбоотой. Хөгжилгүй орны аюулгүй

байдал нь баталгаатай биш, харин улс орон хөгжилтэй бол аюулгүй байдал нь баталгаатай гэж ойлгож болох юм.

Урьд нь аюулгүй байдлаа хамгаалах асуудлыг том, хүчирхэг армитай буюу цөмийн зэвсэгтэй байх зэргээр төсөөлж ойлгож байсан төсөөлөл өнөөдөр нэгэнт хуучирч, аюулгүй байдлаа хамгаалах асуудал шинэ утга агуулгаар тодорхойлогдох болов.

Иймээс манай орны хувьд үндэсний аюулгүй байдлаа хэрхэн томъёолж, түүнийгээ хамгаалах тогтолцоог яаж бүрдүүлж, удирдахаас улсын язгуур эрх ашиг, сонирхлын баталгаа хангагдах болно. Үүнтэй шууд уялдаатайгаар улсын аюулгүй байдал, түүнийг хангах асуудлыг тэргүүн ээлжинд шийдвэрлэх явдал нь улсын аюулгүй байдал нэн түрүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрээс алдагдаж эхлэх магадлал хамгийн өндөр байдагт оршино.

Өнөөдөр улсын хилийн аюулгүй байдлын удирдлага төрийн ба төрийн бус олон байгууллагад цацагдсанаас тодорхойгүй байна. Миний төсөөлж буй таамаглалаар бол улсын үндэсний аюулгүй байдлын удирдлагыг нэг байгууллагад төвлөрүүлсэн тохиолдолд улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, хамгаалах асуудал тодорхой, цэгцтэй, үр дүнтэй болно гэж үзэж байна. Учир нь энэ асуудлыг төвлөрүүлэн хариуцсан байгууллага нь төрийн ба төрийн бус бүх байгууллага иргэдээс аюулгүй байдлын талаар хүлээсэн үүргийн нь биелэлтийг хянах, тодорхой үүргээр хангах, макро түвшинд авч хэрэгжүүлэх арга хэмжээг цогц иж бүрэн байдлаар тодорхойлох асуудал нэг мөр болно.

Эдийн засаг, улс төр болон соёлынхоо бие даасан байдлыг хангах талаар түүхэн эрхээ хэрэгжүүлж, батлахдаа, Монгол улс (Хүннү, Сянби, Нирун-Жужан, Их Монгол Улс, Монголын их гүрэн, Юань, Богд хаант Монгол улс, БНМАУ, Монгол улс) өрийн бодлогынхоо ерөнхий чиглэлд хил хязгаар нутагтаа засаг төрөө хамгаалах бүрэн тодорхой арга хэмжээнүүдийг байнга шийдвэрлэж ирсэн билээ. Энэ нь мэдээжийн хэрэг хэдий ч улс гүрний үүсэл нь дэлхийн геополитикийн зураг дээр өөрийнхөө тусгаарлыг бий болгож, улсын хил буюу түүний элементүүд нь энэ улсын үүсэн бий болохыг шаардах чадвартай эдийн засаг, нийгмийн сонирхолын болон соёл, хэл ярианы үндэс гарлын төрлийн нийтлэг байдпаас нийгэм улс төрийн нөлөөллийн хүрээний анхны үзэгдэхүйц хязгаар болдог.

Энэ агуулгын хувьд, тус улс нь дүрмээс гажууд оршоогүй юм. Түүний үүсэл нь улсын эдийн засгийн үндсийн хүрээний хязгаарын аюулгүй байдал, худалдаа, арилжааны гол замууд, болзошгүй довтолгооноос хүн амыг хамгаалахад хийгээд хилийн бүс дэх цагийн байдалд хянапт тавьж хангахыг бодитойгоор шаарддаг. Эрт дээр үеэс Монгол улсын хил хязгаарт анхны хилийн застав бий болсон байна. Эртний судлалын малтлага, он дараалсан бичгийн эх сурвалжууд нь заставын байгуулал, мэдээллийн системийн бүрдүүлэлт, хил хязгаарын ардыг шилж сонгож байсан байдал, хил орчмын тагнуул хийгээд бусад үйл явуулгыг багтаасан олон салаа, гүйцэт бодсон, хүчтэй, иж бүрэн арга хэмжээнүүдийг гэрчилж байна. Ингэж бидний элэнц хуланцууд Монгол улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсийг хил дээр буй болгожээ.

Хөгжлийн урт хугацааны болон олон удаагийн өөрчлөн байгуулалтын үр дүнд түүхэн байдлаар XXI зууны эхэн гэхэд манай улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцооны засаг төрийн байгууллын цөм нь улсын хязгаарыг хамгаалах алба боллоо. Мөн чанартаа өнөөдөр энэ нь улсын хил дээр түүний эрх ашгийн олон зууны туршлагын үр дүн, улс хоорондын харилцааны хөгжлийн болон сүүлийн жилүүдийн нийгмийн амьдралын үйл явдлын бодит, зүй тогтолтой үр дүнг хууль ёсоор баталгаажуулж байна. [165]

Өнөөдөр Монгол Улсын үндэсний аюулгүй байдал гэдгийг **"**Монгол улсад тусгаар тогтнолын болон төрийн цорын ганц эх булаг болсон түүний олон[166] үндэстэн, ястан ард түмний аюулгүй байдал" *гэж* ойлгоно.

Жинхэнэ төрийн бодлогын эх бичигт улсын эрх ашгийг гадаад, дотоод улс төр, эдийн засаг, цэрэг, мэдээлэл, хил, экологийн болон улсын бусад амьдралын идэвхтэй үйл ажиллагааны хүрээнд хамгийн өргөн агуулгаар найдвартай хамгаалах тухай өгүүлсэн байна. Нийгмийн амьдралын бүх хүрээний олон салангид заагийг цомтгон, жинхэнэ хилийн бүс дэх улсын эрх ашиг нь хилийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон чиглэлд чухалчлагдаж байна.

Хилийн аюулгүй байдлын түвшин нь хилийн хүрээн дэх болзошгүй болон бодит гадаад, дотоодын аюул заналын бүх

---

[165] "Монгол улсын хилийн үүсэл, хөгжил" номны 23-р тал, доктор (РЬ) Б.Цэдэн-Иш, 2003 он

"Пограничная безопасность России , статъяа, 2004 г. Лп1ете1/

спектрээс улсын хилийн болон Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр, хувь хүн, нийгэм, улсын амин чухал эрх ашгийн хамгаалагдсан байдал юм. Энэ нь хилийн орон зайд хилийн аюулгүй байдал болон цагийн байдалтай нягт уялдаатай улсын тогтвортой байдлын чухал, маш тодорхой үзүүлэлт юм. Өөрийнхөө мөн чанараараа, хилийн аюулгүй байдлыг хангах гэдэг нь үндэсний эрх ашиг дээр үндэслэгдсэн төрийн хилийн бодлогын гол, нэгтгэсэн илэрхийлэл юм.

Монгол улсын хилийн аюулгүй байдлын өнөөдрийн түвшинг шинжлэн судлахдаа, XX зууны эцэст манай оронд хийгээд дэлхий дахинаа цэрэг-улс төрийн болон нийгэм-эдийн засгийн чухал өөрчлөлт гарсанг бодолцох хэрэгтэй. Эдгээр өөрчлөлтүүд нь Монгол улсын үндэсний аюулгүй байдалд бодитой нөлөө үзүүлсэн бөгөөд түүнийг хангахад хийгээд тэр тусмаа хилийн хүрээнд зарчмын шинэ аргуудыг боловсруулж хэрэгжүүлэхийг шаардсан юм.

Бидний мэдэж байгаагаар, улсын эрх ашгийн хилийн хүрээ нь бусад бүх зүйлээс гадна, магадгүй, юуны өмнө, бусад олон хүрээнүүдээс өөрийнхөө онцгой чухал байр сууриар ялгардаг. Товчоор хэлэхэд, хилийн хүрээ нь аливаа улсын гадаад, дотоод хоёр том улс төр - нийгмийн амьдралын мужийн уулзварт оршдог.

Тодорхой үе шатанд, гаригийн түвшинд аливаа улсын хөгжил нь дотоодын өөрчлөлт, гадаад нөхцөл, үйлчлэлийн диалектик үр дүнг гэрчлэх “хилийн" шинж чанарыг агуулдаг. Яригдаж буй хоёр муж (гадаад, дотоод) бүрд хуримтлагдсан нөхцөл байдлын тогтвортой байдал нь хугацаа, шинж чанараараа аливаа улсын хилийн аюулгүй байдлын хангалттай тогтвортой нэгдмэл, заримдаа "ердийн" аюул заналыг урьдчилан тодорхойлдог. Тэр тусмаа, өнөөдөр Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдалд учирч болох аюул занал болон улс, нийгэм, хувь хүний идэвхтэй амьдралын чухал хүрээний нэг болох хилийн хүрээнд хэрэгжүүлэх үндсэн зорилго үүргийг тохиолдлоор тусгайлан тодорхойлоогүй юм. Учир нь зөвхөн хэдхэн жилийн өмнө оршиж байсан аюул заналаас өнөөдөр оршиж буй Монгол улсын хилийн аюулгүй байдлын аюул заналын ялгаа нь тус оронд огцом өсөж байгаа дотоодын нийгэм - эдийн засгийн болон улс төрийн тогтворгүй байдалд учирч байгаад оршино.

Олон улсын цэрэг улс төрийн болон хилийн цагийн байдлын

өөрчлөлт, хэтийн төлөвөөс дүгнэвэл улсын хил дээр үүсэж болзошгүй алан хядах ажиллагаа, түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх явдлыг онолын хувьд боловсруулах, хилийн алба, хил хамгаалалтанд туршин хэрэгжүүлэх, улс орны хил хязгаарыг нэвтэрч болзошгүй нөхцөлд хариу арга хэмжээг тухай бүрд нь авахад бэлэн байх нь алсыг харсан алхам болох буй заа.

Улсын хил, хилийн бүс зурваст үүсэх алан хядах ажиллагаа нь:

1. Тухайн хэсэг, чиглэл, хязгаар нутагт тогтвортой байдлыг бий болгох
2. Хил даван орж хил орчмын нутаг дэвсгэрт зэвсэггүй ба зэвсэгтэйгээр дээрэм тонуул хийх, иргэдийн эд хөрөнгө, малыг хулгайлах, халуун хүйтэн зэвсэг хэрэглэн алах зэргээр иргэдэд айдас, түгшүүр төрүүлэх
3. Дотоодын хулгайч нартай хамтран иргэдийн өмч хөрөнгө , амь зуулга босон малыг хуйвалдан хулгайлснаар амьдралын доройтол , ядууралд хүргэх, хил орчимд нутаглах, амьдрах бололцоогүй болгож, улмаар хязгаар нутгийг эзэнгүйдүүлэх, засаг төр, хууль хяналтын байгууллагад итгэх итгэлийг алдагдуулахад хүргэж байна.

Монгол улсын хил хамгаалалтын дүрэмд хорлон сүйтгэх тагнуулын бүлэг, зэвсэглэсэн өдөөн хатгалга, зэвсэггүй бөөн иргэд улсын хилийг нэвтрэх үед тэмцэх, асуудлыг тусгасан байдаг бөгөөд энэ нэр томъёолол нь өөр болохоос биш алан хядах ажиллагаатай л тэмцэх асуудлыг тусгасан гэж ойлгож болно. Гэвч мэдээж зарчмын ялгаа бий.

Манайд аллага хядлагын бүлэг, байгууллага байхгүй боловч эрүүгийн нөхцөл байдал хүнд, тэр тусмаа ноцтой хүнд гэмт хэргийн эзлэх хувь өндөр нарийн аргаар бодож төлөвлөсөн, зэвсэглэсэн, харгис хэрцгий шинжийг агуулах болсон бөгөөд хил дээр, хил орчимд гарч буй хилийн зөрчилтэй холбоотой хэргүүд ч эдгээр шинжийг агуулах болсон төдийгүй терроризмыг нөхцөлдүүлэгч хүчин зүйлүүд болох хар тамхины болон сум галт хэрэгслийн наймаа, газар нутгийн маргаан, хууль бус цагаачлал, дүрвэгсэд, хүний арилжаа, хил орчмын ард иргэдийн амьдралын доройтол зэрэг нь улсын хилтэй

салшгүй холбогдож улсын хилээр, шалган [167]нэвтрүүлэх боомтоор, боомт бус газраар гээд л зайлшгүй улсын хил давуулан оруулах, хил давуулан гаргах, хилээр дамжуулах гэх мэтээр улсын хилийн асуудалтай нягт холбогдож байгаа юм.

Терроризмын эсрэг "Монголын холбоо”-ны тэргүүн Ч.Баатар 2002 онд тавьсан илтгэлдээ "2002 оны эхний 6 сарын байдлаар өмнөд хөршөөс 300 гаруй иргэн хуурамч паспорт ашиглан манай улсын урд, хойд хилийг төвөггүй давж ОХУ-ын хил болоод тусгай албадуудад шалгагдаж илсэрсэн байна. Үүнээс үзэхэд хил хамгаалалт, шалгалт ямар байгаа, чухам хэд нь урдаас орж ирээд хойшоо гаралгүй хууль бусаар манайд орогнож байгааг хэн ч тогтоож чадаагүй болов уу? Мөн манайд гадаадын харьяат 100 гаруй мусульман шашинтан амьдардаг" тухай дурджээ.

Улсын хилийн гадаад, дотоод цагийн байдлуудын дүгнэлт хийхэд эрүүгийн зорилготой аллага манайд гарахгүй гэх баталгаагүй бөгөөд олон улсын террорист байгууллага, гэмт бүлгүүд манай хилээр орж, манай нутгаар дайрч өнгөрөх, байрших, хөрөнгө орлого, санхүүгийн эх үүсвэр болсон хар тамхи, мансууруулах бодис, сум галт хэрэгсэл болон бусад хориотой барааг улсын хилээр дамжин өнгөрүүлэх, үлдээн борлуулах, гадаад улсын ЭСЯ, түүний ажилтнуудын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй юм.

Алан хядах ажиллагааг алан хядах бүлэглэл улс орны дотроос болон хилийн цаанаас үйлддэг. Алан хядах бүлгийн удирдагчид гол төлөв 40-45 настай, гишүүд нь 20-25 настай хүмүүс голлож, эмэгтэйчүүд бүрэлдэхүүний нь 40-45 хувийг, эхнэргүй эрчүүд 70 хувийг тус тус эзэлдэг байна. Бүлэг нь 2-85 хүний бүрэлдэхүүнтэй, даруухан байдлаар амьдардаг бөгөөд ихэнх нь эрүүгийн гэмт хэрэгтнүүд байдаг онцлогтой.

Хил орчмын нутаг дэвсгэрт аллага хядлагын аюул нь олон улсын алан хядах төрөл бүрийн байгууллага, зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүдээс гарч болох юм.

Хилийн аюулгүй байдлын аюул заналын төсөөтэй жижиг бүлгийг ашигтай газар байршуулах нь зөвхөн иж бүрэн хийгдэж болохыг түүхэн туршлага харуулж байна. Хилийн аюулгүй байдлын зарим гадаад, ялангуяа дотоодын аюул заналын гүнзгийрэлт нь

“Улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох арга зам” сэдэвт ЭШБХ-ын илтгэл, 2002 он

бодитойгоор хилийн аюулгүй байдлыг хангах системийн өөрийн нь дотоод ноцтой хямралд хүргэж болно. Энэ дотоод системийн хямрал нь хэсэгчилсэн байдлаар хилийн аюулгүй байдлын аюул заналын өсөлтийн динамикаас хилийн аюулгүй байдлыг хангах системийн хөгжлийн хоцрогдолд илэрч байгаа нь өөрөө нэмэлт аюул занал болж байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн байгууллагын харъяалал:

Улсын хилийн зөрчил өсөн нэмэгдэж, улсын хил дээр хулгай дээрэм ихсэж, машины болон спиртийн наймаа, хээл хахууль газар авч, удаа дараа буун дуу гарч, хүний амь нас хохирч, хязгаар нутаг эзгүйрч хилчид алба амьдралын баталгаагүй болж байгаа зэргээр улсын хилийн аюулгүй байдалд урьд өмнө дурдагдаж байгаагүй аюул заналууд хурцаар илэрч, өсөн нэмэгдэж байгаа өнөө үед түүнийг хангах үндсэн үүрэг бүхий хилийн цэрэг хамаг байдлаа алдаж, хаа нэгэн байгууллагын хавсарга болж ирсэн түүхэн байдал хэвээр хадгалагдаж байгаатай шууд холбоотой юм. Хилийн цэргийн үүсэл хөгжил, үүх түүхээс өгүүлэхгүйгээр дахин байгуулагдсанаасаа хойш өөдлөн дээшилж, бас уруудан доошлоход нь нөлөөлсөн зарим хүчин зүйлүүдийн талаар авч үзье.

Тухайн үед нам, засгийн алдаатай бодлогын уршгаар хилийн цэргээ татан буулгачхаад байж байтал өмнөд хилийн цагийн байдал хурцдаж эзэнгүй орхисон хил хязгаар нутгаа алдахад хүрмэгц хязгаарын цэргээ дахин байгуулсан.

1967 онд Хязгаарын цэрэг дахин байгуулагдахдаа Нийгмийн Аюулаас Хамгаалах Яамны бүтэц бүрэлдэхүүнд оруулж, Хязгаарын ба Дотоодын Цэргийн Хэрэг Эрхлэх Газар, дараа нь Хилийн ба Дотоодын Цэргийг Удирдах Ерөнхий Газар болон өргөжиж улсын хилийн хамгаалалтыг удирдан зохион байгуулж байсан. Нэгэнт л энэ яамны салшгүй бүрэлдэхүүн хэсэг байсан болохоор тус яамны сайдад захирагдаж, хил хамгаалалтыг удирддаг газрын дарга нь орлогч сайдын эрхтэй, яамнаасаа чиглэл авч, тухайн үеийн нам төрийн дээд байгууллагад хандахад хүрвэл өнөөх яамандаа илтгэж, зөвшөөрөл хүсэж, дамжуулж харьцдаг тогтолцоонд орж удирдлагын шуурхай байдал алдагдаж байлаа.

Бие дааж асуудлыг шийдэх эрхгүй учир Хилийн цэргийн удирдлага отрядоороо явахдаа хүртэл сайддаа илтгэж байж

зөвшөөрөл авч, хилийн цэрэг, хилчдийн алба, амьдралтай холбоотой томоохон асуудлыг шийдэх болоход мөнөөх яамны сайд, коллегид санал оруулж, тэдгээрийн сэтгэлд нийцвэл зөвшөөрүүлж, эс нийцвээс зөнд нь орхидог.

"Монгол Улсын төрөөс Засгийн Газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн өөрчлөлт шинэчлэлийн талаар баримтлах бодлогын тухай" баримт бичгийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор баталж мөрдүүлсэн. Энэ баримт бичигт зааснаар чиглэлийн яамыг бодлого төлөвлөлтийн байгууллага байхаар бүтцийг нь өөрчлөх болж 1996 онд 40 дүгээр тогтоол гаргаж ХЦУГ-ыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн Газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах Засгийн газрын тохируулагч агентлаг болгосон. Энэ тогтолцоог Хилийн цэрэг БХЯ-ны харьяалалд биш зөвхөн энэ чиглэлийн асуудал эрхэлсэн сайдын эрхлэх ажлын хүрээнд л түүнтэй харьцаж асуудлаа шийдвэрлэсэн.

Гэтэл БХЯ Зэвсэгт хүчнээ өөрчлөн цомхон, чадварлаг мэргэжлийн хандлагатай болгох төрийн бодлогын удирдлага зохицуулалтыг алдагдуулж, Хилийн цэргийг харъяалалдаа оруулж нэгжүүддээ уусган нэптэх замаар үгүй хийхийг оролдож, төрийн захиргааны удирдлагыг Хилийн цэргийн мэргэжлийн удирдлагатай хутгаж, хилийн отряд, ангиудындотоод ажилд хутгалдан оролцож мэргэжлийн удирдлагын чиг үүргийг орлон гүйцэтгэхийг оролдож эхлэв.

Ийм зохисгүй ажиллагаанаас болоод Хилийн цэрэгт боловсон хүчний бодлого алдагдаж, бодлого сонголтоор төрийн хөрөнгөөр сургаж бэлтгэгдсэн мэдлэг, дадлага, чадвартай, албаны өндөр чадавхитай эрдэмтэн, мэргэжилтэн, генерал, офицерууд тэтгэвэрт гарах нэрийдлээр чаддаг, мэддэг албанаас нь холдуулан зайлуулж, улсын хил хамгаалалтын чухал хэрэгсэл болох нисэх эскадриль, дуу бүжгийн чуулга, “Эх орны манаа" сонин, эмнэлэг, музей зэргийг Хилийн цэргээс салган авч нэгтгэсэн бөгөөд боловсон хүчнээ шилж сонгох, хуваарилах, цэргийн цол олгох, төсвөө зарцуулах эрхийг нь хязгаарлаж бас заримыг нь өөрсдийн эрх мэдэлд төвлөрүүлөв. Эрх мэдлийн ийм төвлөрөл БХЯ- ны аппаратад зөвхөн боловсон хүчний бодлого санхүүгийн хүрээнд төдийгүй түүний бусад салбарууд ч хийгдсэнийг гэрчлэх нэг жишээ бол Хилийн цэрэгийн дээд сургуулийг Хилийн цэргийн мэдпээс гаргаж БХИС-ийн харъяалалд оруулж,

түүний сургалт соёл хүмүүжлийн тэнхимийг татан буулгасан явдал юм. Монгол улсын үндэсний аюулгүй байдлын хамгийн эмзэг асуудал болох улсын хил, Хилийн цэргийг ийм маягаар бусниулах эрхийг нэг хэсэг хугацаанд БХЯ эдлэв.

Монгол Улс шинэ Үндсэн хуулиндаа “Монгол улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хилийн халдашгүй дархан байдал”, “Улсын хил хамгаалалт нь Үндэсний Аюулгүй байдлын салшгүй хэсэг мөн" гэж хуульчлан баталгаажуулсан билээ. Мөн Монгол улсын хилийн хамгаалалт хил хяналтын албыг хариуцах төрийн захиргааны байгууллага нь Хилийн цэрэг болохыг Хилийн тухай хуулиар баталгаажуулсан юм.

Дараагийн арга хэмжээ нь Засгийн газар 2000 оны 1 дүгээр сард “Төсвийн захиран зарцуулах эрхийн тухай " зургадугаар тогтоол гаргаж, энэ тогтоолоор Зэвсэгт хүчин Хилийн цэрэгт Улсын Их Хурлаар баталж өгсөн урсгал төсвийг төвлөрүүлэн захирагчаар Зэвсэгт хүчний Ерөнхий Штаб, Хилийн Цэргийг Удирдах Газар байсныг өөрчилж төвлөрүүлэн захирах эрхийг БХЯ-нд олгосон явдал юм.

Ингэснээр Зэвсэгт Хүчин, Хилийн Цэргийн нэгтгэл ангиудыг БХЯ-аас шууд санхүүжүүлэн тайлан тэнцэл гаргадаг журамд шилжиж байгаа нь хэрэг дээ УИХ-ын 1996 оны 40 дүгээр тогтоолоор Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа тохируулагч агентлаг Хилийн Цэргийг Удирдах Газрыг БХЯ-ны хэрэгжүүлэгч агентлаг болгон хувиргав. МАХН Улсын Их Хурлын 2000 оны сонгуульд оролцсон мөрийн хөтөлбөртөө “Хилийн цэргийн харьцангуй бие даасан байдпыг хангана..." тунхагласны гавъяагаар хилчдийн дэмжлэгтэйгээр МАХН-ын 40 гаруй гишүүд Улсын Их Хуралд суудал авсан юм. Энэ заалтаа хэрэгжүүлэхийн тулд Хилийн цэргийг батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнээс, Хилийн цэргийн дээд сургуулийг БХИС-аас гаргаж, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд оруулсан нь сайшаалтай хэдий ч нэг сайд, яамнаас нөгөө сайд, яамны мэдэлд шилшүүлсэн нь чанарын онц ялгаа байхгүй байна.

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үндсэн үүрэгтэй Хилийн цэргийн харъяалал ийнхүү өөрчлөгдөж ирсэн нь нэг талаас улс төрийн тогтворгүй байдалтай, нөгөө талаас энэ асуудлыг

шинжлэх ухаан, онолын хэмжээнд судлаагүйтэй холбоотой юм.

“Хил" гэдэг ойлголт нь "улс" гэдэг шиг тийм өргөн утгыг агуулахгүй. Гагцхүү тэрээр нийгмийн философи, нийгэм судлал, улс төр судлал зэрэг шинжлэх ухааны олон салбаруудын ухагдахуунуудад багтдаг бөгөөд өөрөөр хэлбэл нийгэм-улс төрийн үзэгдэл болж байдаг байна. Ийнхүү "улсын хил" гэдэг нэр томъёо/ойлголт/ нь улс гэсэн нийгэм, улс төрийн нарийн тогтоцын зааг хязгаарыг илэрхийлж байна.

"Улсын нутаг дэвсгэрийн зааг хязгаарыг тодорхойлсон шугам" гэсэн хилийн тухай тодорхойлолт нь түүний гол шинж чанарыг илэрхийлж буй болохоос түүний бүх шинжийг илтгэн харуулсан төгөлдөр ойлголт болж чадахгүй. Улсын хил нь тухайн улсын нутаг дэвсгэрийн заагийг тэмдэглэх төдийгүй харилцан хамааралтай, харилцан үйлчлэлцэх нийгэм улс төрийн тогтолцоо бүхий хоёр улсын нутаг дэвсгэрийг зааглан тогтоосон шугам юм.

Улсын хил нь нийгэм, улс төрийн үзэгдэл мөнийн хувьд тухайн улс орны түүх, дипломат улс төрийн бодлоготой салшгүй холбоотой урт удаан хугацааны түүхтэй байдаг. Хүний нийгэм, улс гэсэн нийгэм - улс төрийн тогтолцоогүй, түүнчлэн улсын хил гэдэг ойлголт ч байхгүй байсан үе бий. Хүмүүсийн анхны хэлбэр болсон хүй нэгдлийн омог отгийн үед оршин амьдарч байсан нутаг газраа зааглаж байсангүй. Тэд оршиж амьдрах нөхцөл бүрдсэн газар орон дээр л байрлаж байсан.

Хожмоо улсын хил нь улс гэдгийн салшгүй шинж тэмдэг болсон юм. Ямар ч улс орон, бүр хүчирхэг улс газар нутаг зааг хязгааргүй байсангүй. Улсын хилийн асуудал тухайн улсын засаг захиргааны хамгийн өндөр түвшинд шийдвэрлэгдэж хэлэлцээр гэрээний харилцааг үүсгэн хөгжүүлэх болж улс төрийн шинж чанарыг агуулах болов. Аливаа нэгэн улсын хилийн шугамыг хүч хэрэглэж, эсвэл дипломат болон бусад аргаар өөрчилсөн тохиолдолд нутаг дэвсгэрийнхээ хэсгийг алдсан улс орон түүнийгээ эргүүлж авахын тулд янз бүрийн аргыг хэрэглэх шаардлагатай болдог.

Улсын хил, түүнийг хамгаалах тухай асуудал хэзээ ямагт засаг захиргааны анхаарлын төвд оршиж байлаа. Энэ асуудлыг харгалзан Монгол улсын төр засаг хил залгаа улсуудтайгаа улс төрийн харилцаа тогтоож, улсын хил хязгаарын хамгаалалтыг зохион байгуулсан юм. Энэ зорилгын үүднээс улсын хилийг сахин

хамгаалдаг цэрэгтэй болж, тэдгээрийг хилийнхээ дагуу байрлуулж, инженер техникийн хэрэгслээр хилээ төхөөрөмжилж, хилийн харуул, хамгаалалтыг зохион байгуулж, холбоо дохионы хэрэгсэлтэй болсон юм.

Төгсгөл хэсэг:

Улсын хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог цогц байдлаар хөгжүүлэх нь:

Монгол улсын үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлууд төр захиргааны маш олон байгууллагуудын дунд цацагдсан, түүний төлөө хүлээх хариуцлагыг тооцох , ялангуяа хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо бүрдсэн, эс бүрдсэн эсэх талаар тодорхой дурьдагдсан нь хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох зайлшгүй шаардлагатайг гэрчилж байна гэж үзэж болно.

Орчин цагийн ойлголтоор улсын хил хамгаалалтын тогтолцоо гэдгийг шууд утгаар нь улсын хил, хязгаар нутагт үндэсний аюулгүй байдпыг хангах гэж ойлгох шаардлагатай бөгөөд энэ тогтолцоо байна уу, үгүй юу эсвэл яаж бүрдүүлэх вэ гэдгийг шинжлэх ухааны үндэстэй, онол арга зүйн дагуу дэлхийн нийтлэг жишиг, өөрийн орны өвөрмөц онцлогийн дагуу судалж, боловсруулан, хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Үнэн хэрэгтээ, энэ тогтолцоог байна гэж үзвэл өнөөдөр энэ нь зөвхөн Хилийн цэрэг юм. Иймд уг асуудлыг өнөөгийн түвшинд зөв шийдэх үүднээс дараах хувилбар саналыг дэвшүүлж байна.

Хилийн аюулгүй байдлын асуудлыг шийдвэрлэх арга зам. Дээр тоочсон хийгээд шинээр үүсэх аюул заналын тохирох бүх масштабт улсын хилийн аюулгүй байдлын хангах тогтолцооны асуудал нь манай улсын хилийн аюулгүй байдпын хамгийн амин чухал асуудал мөн. Хилийн аюулгүй байдлын бүх иж бүрэн аюул заналын саармагжуулалт гэдэг нь улсын амьдрал үйл ажиллагааны гадаад бодлого, эдийн засаг, эрх зүй, нийгмийн болон бусад харилцан шүтэлцээт бүх хүрээ дэх байдлыг хэвийн болгох зайлшгүй шаардлагыг хөндөж буй олон чиглэлт үйл явц юм.

Энд хилийн аюулгүй байдлын үндсэн асуудлыг шийдвэрлэх нь хамгийн багаар үйл ажиллагааны гурван үндсэн векторыг санал болгож болох юм.

-Хилийн хүрээнд улс хоорондын харилцааны системийг

тогтворжуулах болон бэхжүүлэх /улсын хилийн аюулгүй байдалд нөлөөлөх, хүрч болмоор гадаад хүчин зүйлийг өөрчлөхөд анхаарна гэсэн үг/

-Улсын хөгжлийн эрх ашгийн эдийн засгийн аспөктийн хилийн хүрээн дэх урьтач тооцоо (улсын хилийн аюулгүй байдлыг тодорхойлж буй хөтлөгч дотоод хүчин зүйлд анхаарна гэсэн үг)

-Улсын хилийн аюулгүй байдлыг хангах системийг өөрийг нь сайжруулах, хөгжүүлэх (дотоод системийн хямрал үүсэх боломжийг зайлуулахын тулд)

-Мэдээллийн шинэ технологийг ашиглан хил дээр болон хилийн орон зай дахь цагийн байдлын мониторингийг сайжруулах, чухал мэдээллийг цуглуулах, нэгтгэн дүгнэх, системчлэх, задлан шинжлэх ба түүнээс үүдэн гарах хавсрага болон онолын чанартай чухал зааварчлагыг шуурхай боловсруулах ажлыг идэвхжүүлэх.

-Хилийн аюулгүй байдлыг хамтарч хангаж ажиллахад онцгой анхаарахдаа сонирхож буй талуудын улс хоорондын хүчин чармайлтыг нэгтгэх үндсэн дээр хөрш зэргэлдээх орнуудын гадаад хил дээр хамтын аюулгүй байдлын системийг бүрдүүлэхэд оролцох;

-Хилийн орон зай дахь асуудлыг шийдвэрлэхэд ази-номхон далайн бүс нутгийн эдийн засгийн бүлэглэлийн оролцогч-орнуудтай хилийн хамтын ажиллагааг хөгжүүлэх; сонирхогч талуудын хилийн аюулгүй байдлыг хангахаар тохиролцсон үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн хамтын ажиллагааг хөгжүүлэх.

-Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах системд тодорхой үүрэгтэй бусад яам, байгууллага, албадуудтай хамтарч ажиллахад хил хамгаалах байгууллагын зохицуулах үйл ажиллагааны механизмыг сайжруулах.

-Хилийн аюулгүй байдлыг хангах системийн бүх элементийн үйл ажиллагааг алдаа магадгүй санхүү, ар тал, материал-техникээр дэмжих;

-Хилийн албаны офицер, цэрэг, ажилтнуудын мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд боловсон хүчнийг шилж сонгох, байршуулах, офицерын бүрэлдэхүүний орон сууц, ахуйн асуудал, нийгмийн хамгаалал, шаардлагатай нөхцөлийг бий болгохтой холбогдолтой асуудлуудыг чанартай шийдвэрлэх үндсэн дээр офицерын бүрэлдэхүүнийг хадгалах, алба-байлдааны үйл ажиллагааны боловсон хүчнийг хангах.

-Улсын амьдрал үйл ажиллагааны хилийн хүрээний үүрэг, ач холбогдол болон үндэсний аюулгүй байдлыг хангах системийн институтуудын цөм болох хилийн албаны ажиллагааны улс төр, эдийн засаг, эрхийн хамгаалапт, нийгэм-соёлын ач холбогдолд хилийн аюулгүй байдлын асуудлууд хурцдаж байгаа талаарх нийгмийн мэдээллийн хангалтын системийг сайжруулах; хил орчмын орон нутгийн хүн ам болох залуучууд, өсвөр үеийнхэн, хүүхдийн боловсролын, нийгмийн, биеийн тамирын байгууллага, клубуудтай сайн дурын ардын дугуйлан, тэр тусмаа хилчин-эх орон ч болон бусад хэлбэрээр ажиллах.

Монгол улсын хилийн аюулгүй байдлыг хангах системийг сайжруулах талаарх бүх ажлын үндсэн дээр байгаа эрх зүйн хэм хэмжээний үйл ажиллагаа зайлшгүй шаардлагатайг орхигдуулж үл болно.

Дүгнэлт:

Аюулгүй байдал гэж аливаа улс орон хийгээд түүний төрийн тэргүүн энгийн иргэд бусдын хор хөнөөлөөс ангид биеэ даасан байхыг хэлнэ. Улс аюулгүй байдал нь ерөнхийдөө байгаль, төр, хүний аюулгүй байдлаас бүрдэнэ.

Хил хамгаалах байгууллага бараг бие даан улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний аюулгүй байдлыг хангах удирдлагыг хэрэгжүүлж байгаа нь төдийлөн үр дүнтэй цогц арга хэмжээ болж чадахгүй байна.

Хил хамгаалалтыг өөрийн нь шинэ чанарт хүргэх замаар Монгол улсын хилийн аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэх, хил хамгаалалтыг үе шаттайгаар шинэ нөхцөл байдал, үүрэгт хамгийн дээд зэргээр дассан зохицсон төрийн тусгай мэргэжлийн цэргийн байгууллага болгох;

Хилийн цэрэг хил хамгаалах байгууллагуудын цаашдын өөрчлөн байгуулалтын үр дүн нь өөрт байгаа хүч хэрэгслээ үр дүнтэй, оновчтой ашиглах явдал болно.

Ашигласан материал:

1. Монгол Улсын Хилийн тухай хууль. УБ., 2017.

2. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002.

3. Монгол улсын хил хамгаалалтын дүрэм I Хилийн застав. УБ.,

2007.

4. Монгол улсын терроризмтой тэмцэх тухай хууль. 2004.04.23.

5. Дорлигжав.Д. Монгол улсын хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. УБ., 2015.

6. Багабанди.Н. Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого.

7. Арвай.Ш. Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого

8. Монгол хэлний их тайлбар толь. УБ., 2016.

9. Арвай.Ш. БНМАУ-ын Хятадтай хил нийлсэн хэсгийн хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь. УБ.,

10.Бат-Эрдэнэ.Б.Төрөөс улсын хил, түүний хамгаалалтын талаар баримталсан бодлогыг судалсан нь

11. Наранжамц.Н. Тал хээрийн нөхцөлд хилийн Операц зохион байгуулах нь

12. Жавхланцогт.В. Улсын хилээр дүрвэгсэд нэвтрэх үеийн хилийн отрядын ажиллагааг боловсронгуй болгох нь

13. Ганболд.Ц. Хилийн харилцааны зарим асуудал. УБ., 2007.

УЛСЫН ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХАД ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ, НӨЛӨӨЛӨЛ, ОРОЛЦОО

Ч.Отгонсүрэн
Хилийн албаны сургуулийн цэргийн хэргийн тэнхимийн ахлах багш, хууль зүйн ухааны докторант, дэд хурандаа

Товч агуулга: Аливаа улс орны эцсийн зорилго нь оршин тогтнох явдал бөгөөд үндсэн арга зам нь “хөгжил” юм. Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн. Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална гэсэн нь хил орчмын нутгийн хөгжлийг түргэтгэх үндсэн тулгуур юм. Улсын хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй бүрэн бүтэн байдлыг хангах чухал нөхцлийн нэг нь хөгжлийг хангах “эдийн засгийн чадавхи”, түүний өсөлт байх ёстой.

Түлхүүр үг: Аюулгүй байдал, хил орчмын нутгийн засаг захиргаа, хилийн аймаг, сумдуудын хөгжил

Дэлхийн даяарчлал, олон улсын харилцаа, улс төр, эдийн засгийн нөхцөл байдал, терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийлэл нь тусгаар тогтносон бүрэн эрхт улс орнуудын язгуур ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж, «аюулгүй байдал» хэмээх ухагдахууныг өргөн цар хүрээтэйгээр судлахыг шаардаж байна.

“Аюулгүй байдал" гэдэг ерөнхий ойлголтыг янз бүрээр тайлбарлаж болно. Энэ ойлголт тодорхой тохиолдолд субъектын аюулгүй байдлын өвөрмөц онцлогийг илэрхийлэхийн зэрэгцээ, олон салбарт хэрэглэж болох нийтлэг утга агуулагдаж байдаг. Аюулгүй байдлын талаарх энэхүү ойлголтыг В.Далийн тайлбар тольд: "аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх" гэсэн бол, Я.Цэвэлийн тайлбар тольд: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй” гэж тайлбарласан байдаг.

Бодит амьдрал дээр янз бүрийн аюулууд урд нь байсан, одоо ч байгаа, цаашид байсаар байх нь тодорхой юм. Ийм учраас аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар гэж тодорхойлсон байна. “Аюулгүй байдал гэдэг нь бүхэлдээ хэн ч, юунаас ч айж түгшихгүй байх тийм нөхцөл мөн” гэдэг И.Зоненфельсийн тодорхойлолт олон улсын судлаачдын анхаарлыг ихээхэн татдаг бөгөөд энэ нь нийгмийн гишүүн бүр хэнээс ч, юунаас ч айж түгшихгүй амар тайван байвал тухайн нийгэм бүхэлдээ амар тайван байх боломж бүрдэнэ гэж үзсэн.

Аюулгүй байдал хэмээх ойлголтыг «цэргийн хүчин чадал»-тай холбож ойлгохоос илүүтэйгээр «эдийн засгийн чадавхитай» холбож тайлбарлах болсон байна. Үндэсний аюулгүй байдал, тэр дотроо хилийн аюулгүй байдлын асуудлыг эдийн засгийн хөшүүрэг, агууламжгүйгээр тайлбарлах, шийдвэрлэх боломжгүй юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь улс төр, дипломат, цэрэг, инженер-техник, зэвсэглэлийн төдийгүй, эрх зүй, эдийн засаг, соёл иргэншил, экологи, хүмүүнлэгийн зэрэг олон талт үйл ажиллагаагаар нөхцөлддөг, харилцан шүтэлцээтэй цогц шинжтэй ойлголт юм. Аливаа улс орны эцсийн зорилго нь оршин тогтнох явдал бөгөөд үндсэн арга зам нь “хөгжил” юм.

Улсын хил хязгаар, нутаг дэвсгэрийн халдашгүй бүрэн бүтэн байдлыг хангах чухал нөхцлийн нэг нь хөгжлийг хангах “эдийн засгийн чадавхи”, түүний өсөлт байх ёстой. Цэргийн шинжлэх ухаанд “улсын хилийг эдийн засгийн аргаар хамгаалах”, “хилийн эдийн засаг” гэх ухагдахуун, нэр томъёо, ойлголт зайлшгүй шаардлагатай. Түүнчлэн эдийн засгийн асуудлыг чухалчлан авч үзэхгүйгээр хилийн аюулгүй байдлыг хангах тухай ярих боломжгүй юм.

Хилийн аюулгүй байдал нь улсын хил хамгаалалтын хүч хэрэгсэл, цэргийн хангалт, санхүү ар талын хангалт үйлчилгээ төдийгээр хязгаарлагдахгүй, харьцангуй өргөн хүрээтэй ойлголт мөн бөгөөд улсын хил, хилийн орон зай, бүс нутаг, улс орны эдийн засгийн масштабаар төсөөлөгдөх харилцан шүтэлцээтэй бүтцийн олон элемент, шатлал бүхий тогтолцоо юм. “Хил орчмын нутаг дэвсгэр” гэдэгт хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэр хамаарахыг хуульчилсан байдаг. Энэ орон зайд манай улсын 14 аймгийн 67 сумын нутаг дэвсгэр багтаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэхдээ үндэсний нэгдмэл ашиг сонирхлыг дээдэлж, Монгол Улсын бүрэн эрхт байдал, хил хязгаар, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг бататгах зарчмыг үндэс болгоно”, Монгол Улсын хилийн тухай хуульд “Хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах улс төр, эрх зүй, дипломат, эдийн засаг, байгаль орчин, тагнуул, улсын хил хамгаалалтын цогц үйл ажиллагаагаар хангагдана” гэж заасан. Иймд хил орчмын энэхүү бүслүүр нутаг дэвсгэрийг «хилийн аюулгүй байдлыг хангах идэвхтэй бүс» гэж үзэн аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, тогтолцоо, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналтын горимыг тодорхойлох нь зүйтэй юм.

Өнөөдөр эзэнгүй шахам байгаа энэхүү орон зайд эдийн засгийг эрчимтэйгээр хөгжүүлж, хүн амын шилжилтийг чиглүүлснээр Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын холбогдох заалтууд хэрэгжиж, хил орчмын нутагт үндэсний язгуур ашиг сонирхол хангагдах гадаад, дотоод таатай нөхцөл бүрэлдэх юм.

Төрт ёсны түүхэн уламжлалт өвөг дээдсүүдийн маань үлдээсэн гайхамшиг бол манай улсын өргөн уудам газар нутаг, соёл иргэншил, монгол хүний ертөнцийг үзэх үзэл юм. Түүхээс үзэхэд эдийн засаг, нийгмийнхээ хөгжлийг төвд нь биш, улсын хил хязгаар нутагтаа төвлөрүүлж ирсэн юм билээ. Гэтэл өнөөгийн байдлаар манай улсын хил орчмын нутгийг хөгжүүлэх үйл явц төрийн нэгдсэн бодлогод зангилагдаж системчлэгдээгүй байдал энэ бүст хүн ам аж төрж, сэтгэл амар, тайван аж төрөх нөхцөл нийгэм, эдийн засгийн хувьд бүрдээгүй гэж үзэж болох юм.

Хил орчмын бүс нутгийн физик газар зүйн болон бусад цаг уурын нөхцөлд зохилдсон дэд бүтэц тавьж, өрхийн болоод жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, төрөөс эдийн засгийн эргэлтийг идэвхижүүлэх бодлогыг хэрэгжүүлснээр оршин сууж буй ард түмний амьдрал сайжирч, хилийн орон зай дахь хүн амын суурьшил нэмэгдэх нөхцөл бүрдэх юм.

Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “Эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй,

амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн". "Эдийн засгийн олон тулгуурт, оновчтой бүтцийг бий болгох, хөрөнгө оруулалтын тэнцвэртэй бодлого явуулах, санхүүгийн салбарын аюулгүй байдлыг баталгаажуулах, эрчим хүч, эрдэс баялгийн болон гадаад худалдаа, интеграцийн асуудлаар оновчтой бодлого баримтална" гэсэн нь хил орчмын нутгийн хөгжлийн түүчээг түргэтгэх үндсэн тулгуур юм.

Иймд хил орчмын нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжил нь үндэсний аюулгүй байдлын цогц асуудлуудтай шууд холбогдох бөгөөд Монгол Улсын хилийн аюулгүй байдал хангагдах нөхцлийг бүрдүүлэгч гэсэн байр суурийг баримталж байна. Хил орчмын нутгийг өөрийн нөхөн сэргээгдэх болон үл сэргээгдэх нөөц баялаг, газар зүйн бодлогодоо түшиглэн дэд бүтэц байгуулж, түүн дээр суурилсан үйлдвэрлэл, аж ахуйг хөгжүүлж, эдийн засгийн хувьд харьцангуй бие даасан байдлаар хөгжүүлэх шаардлагатай байна. Ийнхүү хил орчмын нутаг хөгжих хэрээр улс орон хөгждөг нийтлэг жишиг, зүй тогтол байдаг. Иймд хил орчмын нутаг нь хилийн аюулгүй байдлыг хангах нийгэм, эдийн засаг, үндэстэн угсаатан, соёл иргэншлийн зохицлыг тэнцвэртэй хөгжүүлэх шаардлагатай байна.

Хилийн аюулгүй байдлыг хангах тулгуур бүсэд дэд бүтэц /авто зам, төмөр зам, агаарын зам, эрчим хүч, харилцаа холбоо, мэдээлэл, холбооны сүлжээ, аялал, жуулчлал/, өрхийн болон жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлэх үйл явцыг төрөөс дэмжиж, үндэстэн угсаатан, соёл иргэншлийн тэнцвэртэй байдлыг хангахад төрийн бодлого төлөвлөлт, үйл ажиллага, хяналтын горимыг хангасан тогтолцоотой байх явдал чухал байна. Энэ нь хилийн аюулгүй байдлыг хангах чухал нөхцөл болох юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал бодлогын баримт бичигт зааснаар Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох зорилго, зорилтыг хангаж хэрэгжүүлэх хүрээнд хяналт тавих тогтолцоо нь хил орчмын нутагт хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог бий болгох үндсэн нөхцөл болох юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг

хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудыг хуульчилж, 7.2-д - Төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагууд өөрсдийн бүрэн эрхийн хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцож, хамтран ажиллах үүрэгтэй" гэж заасан байна. Иймд хил орчмын нутагт хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь сумдын өөрөө удирдах байгууллага, Засаг дарга, засаг даргын тамгын газар, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын салбар нэгж, албан тушаалтнуудаас бүрдэж, хилийн аюулгүй байдлыг хангах зорилтыг холбогдох хэм хэмжээнд нийцүүлэн хэрэгжүүлэх үүрэгтэй байх ёстой болно.

Хэдий ийм боловч хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо, үйл ажиллагаа хилийн тухай хууль, иргэдийг хил хамгаалалтад оролцуулах тухай журмын хүрээнд хэрэгжиж байгаа нь улсын хил орчмын нутгийн аюулгүй байдлыг хангахад учир дутагдалтай байгааг илтгэж байна. Үүний томоохон жишээ бол Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого бүхэл бүтэн 15 жилийн тэртээ батлагдаж хүчин төгөлдөр болсон хэдий ч хилийн аюулгүй байдлыг хангахад бодит байдлаар системчлэгдэж, хэрэгжээгүй гэж үзэхэд хүргэж байна.

Энэ нь хил орчмын нутгийн хүн амын суурьшил сийрэгжсэн, үндэстэн угсаатан соёл иргэншлийн тэнцвэрт байдал алдагдсан хэвээр байгаа, нийгмийн халамж хүртээмж, татварын талаар баримтлах хөнгөлөлт байхгүй байгаа, эдийн засгийн хөгжлийн бие даасан байдал царцанги байгаа зэргээр илэрхийлэгдэж байна. Нөгөөтэйгүүр Монгол Улсын аюулгүй байдлын гадаад орчны хүчин зүйлээс гадна дотоод орчинд:

-Хүн амын шилжилт хөдөлгөөн хөдөөнөөс хот руу чиглэж хотын хүн ам жилд дунджаар 30-40 мянгаар нэмэгдэж, нийт хүн амын 60 орчим хувь нь нийслэл Улаанбаатар хотод буюу нийт газар нутгийн 0,03 хувьд төвлөрсөн;

-Хүрээлэн буй байгаль орчны аюулгүй байдал алдагдаж, гамшгийн аюул нэмэгдсэн;

-Ядуурал, ажлын байрны хомсдол өсөж, хөдөө орон нутагт малчид, ажиллах хүчний тоо буурсан;

-Улсын эдийн засагт оруулах гадаадын хөрөнгө оруулалт зогсонги байдалд орсон;

-Улсын эдийн засгийн чадамж суларсан, гадаад болон дотоод өрийн хэмжээ нэмэгдсэн;

Дүгнэлт:

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын нэгийн 9-д “Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна” гэж заасан боловч, хэрэгжилтийг хангах субъект нь улсын хил хамгаалалт хариуцсан Засгийн газрын гишүүн байна гэж хуульчлагдсан. Энэ нь төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо хангагдаагүй байгаагаар илэрхийлэгдэж байна. Иймд төрөөс хилийн талаар баримтлах бодлогод “хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал”-ыг хангах асуудал нь улсын хил хамгаалалттай холбоотойгоор хэрэгжсэн. Энэ нь хил орчмын нутагт аюулгүй байдлыг хангах цогц асуудлыг хөндөхөд учир дутагдалтай болсон байна үзэж болохоор байна.

Хил орчмын нутаг дэвсгэрт хүн ам оршин суух таатай нөхцөл хангагдаагүй, эдийн засгийн эргэлт хангалтгүй байгаа нь хязгаар нутаг эзгүйдэх, түүх, соёл иргэншил оршин тогтнох нөхцөл алдагдахад хүргэжээ.

Хилийн аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход анхаарах: Үүнд:

1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлынг үзэл баримтлалын 3.1.2.5 дахь заалт, Төрөөс хилийн талаар баримтлах бодлогын 2 дугаар бүлгийн 1.2 дахь заалтуудыг үндэслэн Засгийн газар /Монгол Улсын Ерөнхий сайд/ болон хилийн аймаг, сумын өөрөө удирдах байгууллагын дэргэд Хил орчмын бүс нутгийн эдийн засгийг хөгжүүлэх /хилийн аюулгүй байдлыг хангах/орон тооны зөвлөлийг байгуулж, улс орны аюулгүй байдал, бүтээн байгуулалт, аялал жуулчлалтай холбоотой хөрөнгө оруулалтыг хил орчмын эдийн засгийн хөгжлийг хангахад чиглүүлэх;

2.Хилийн тухай хуульд заасны дагуу улсын хилийн аюулгүй байдлыг хангахад төрийн болон орон нутгийн захиргааны байгууллага, улсын хил хамгаалалтанд туслах хүчний гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх;

3.Хил хязгаар нутагт оршин сууж аж төрж буй иргэдийг татварын болон эрүүл мэнд, нийгмийн халамж үйлчилгээгээр хөнгөвчлөх, бүс нутгийн хилийн урамшуулалтай болгох зэргээр эрх зүйн зохицуулалтаар дэмжих;

4.Аюулгүй байдлын чиглэлээр эрдэмтэн, судлаачдын зүгээс Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд тулгуурлан хил орчмын нутгийн нийгэм эдийн засгийн хөгжлийг сэргээж эрчимжүүлэх, үндэстэн угсаатны соёл иргэншлийн тэнцвэрт байдлыг хадгалахад чиглэсэн судалгаа, шинжилгээний ажлыг холбогдох салбар судалгааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, хязгаар нутгийн хөгжлийн төлөө бодит хувь нэмрээ оруулахад анхаарах;

Иймд хил орчмын энэхүү хилийн нутаг дэвсгэрийг «хилийн аюулгүй байдлыг орон зай» гэж үзэн аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, тогтолцоо, төлөвлөлт, үйл ажиллагаа, хяналтын горимыг тодорхойлох нь зүйтэй юм.

Ашигласан материал

1. “Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам” Олон улсын хурлын эмхэтгэл 2018 он
2. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992.
3. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль эрх зүйн актуудын эмхэтгэл, УБ, 2007 он
4. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010.
5. Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. УБ., 2002.
6. Монгол Улсын Хилийн тухай хууль, Төрийн мэдээлэл, УБ., 2017, №06
7. Монгол-Оросын улсын хилийн дэглэмийн тухай Монгол Улс, Оросын холбооны улс хоорондын улс хоорондын гэрээ, УБ., 2007.
8. Ч.Улаанхүү “Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал” УБ 2014 он

УСАН ХИЛИЙН ШУГАМЫН ИНЖЕНЕРЧЛЭЛ ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛД НӨЛӨӨЛӨХ НЬ

/Хилийн цэргийн..... дүгээр ангийн жишээ нь дээр /

Л.Лхагвасүрэн
Хилийн албаны сургуулийн ар тал,
эдийн засгийн тэнхимийн дэд профессор,
Хил судлал, Боловсрол судлалын
магистр, хошууч

Хураангуй

Уур амьсгалын өөрчлөлт сүүлийн хэдэн арван жилийн турш хөгжлийг сааруулж, эрсдэлийг нэмэгдүүлэх хүчин зүйл болоод байна. Гэсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлтийн талаар дэлхийн хэмжээнд явагдсан хэлэлцүүлгүүд өнөөг хүртэл хилийн аюулгүй байдалд төдийлөн ач холбогдол өгөхгүй байсаар ирсэн нь судлаач миний уг сэдвийг судлах шалтгаан боллоо. Судалгаанаас авч үзэхэд сүүлийн жилүүдэд хил дагуух зарим гол мөрний өөрчлөлт нь Монгол Улсын нутаг дэвсгэр, хилийн шугамын явалтыг өөрчилж болзошгүй аюулд хүрсэн нь Үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөөлөх мөн болзошгүй эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар товч өгүүлэх болно.

Түлхүүр үг: Хил, ус, эрози

Удиртгал

Далай тэнгис гол, нуур нь өөртөө ургамал, амьтан биологийн, ашигт малтмал эрдэс баялаг, эрчим хүчний хязгааргүй нөөцийг агуулах бөгөөд усан тээвэр, холбооны чухал сүлжээг эзэлж, цэрэг дайны асар их сонирхлыг дагуулдаг. Газрын баялгийн нөөцийн хомстлыг далай тэнгист оршиж буй ихээхэн нөөц нэмэгдүүлэх бөгөөд хэн далай, тэнгисийг эзэмшинэ тэр улс гүрэн одоо ирээдүйд оршин тогтнохын хурц тэмцэлд татагдан орж байна. Монгол оронд 67000 км урттай 3811 гол горхи, 500 шоо метр эзлэхүүнтэй 3500 гаруй нуур, 7000 орчим булаг шанд, 540 шоо метр талбай бүхий 190 гаруй мөсөн гол 250 гаруй рашаан байдаг бөгөөд газрын доор усны 139 орд газар бий энэ тоо гол, нуураар баян мэт уншигдаж байгаа ч хэдхэн голоос бусад нь гадагшаа урсгалтай буюу хөрш зэргэлдээ

улс, орнуудын ус, Голд цутгадаг өөрөөр хэлбэл, ”Хүний” гол, нуур гэсэн үг. Харин үүний цаана гадагш урсгалгүй буюу бидний эх оронч” хэмээн нэрийддэг цөөхөн гол бий гэвч эдгээр эх оронч Голд хүн, мал хийгээд техникийн хор хөнөөл хүрч, урсац нь багассаар байгаа билээ.

Монгол Улсын усан хил нь үндсэндээ нуур, гол, горхиор дайран өнгөрөх бөгөөд өөр өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Иймээс усан хил хамгаалалтын өнөөгийн байдал түүнийг цаашид боловсронгуй болгох арга замыг судлах нь хил судлалын шинжлэх ухааны тулгамдаж буй нэг асуудал болж байна.

Судалгааны ажлын арга зүй

Баримт материал судлах, ажиглалт, харьцуулалтын аргуудыг ашигласан.

Судалгааны үр дүн

Монгол орны усны нөөцийн 80% нь гадаргын ус, 20% нь газрын доорх ус бөгөөд гадаргын усны нийт хэрэглээний 0.4% -ийг хүн амын унд ахуйн хэрэглээнд, 99.6% -ийг үйлдвэр үйлчилгээнд ашигладаг бол газар доорх усны 0.8% -ийг хүн амын унд ахуйн хэрэглээнд, 99,4%-ийг үйлдвэр үйлчилгээний хэрэглээнд хэрэглэдэг байна[4]. Монгол орны нийт ус ашиглалтыг, салбарын хамт харуулбал:

Манай Улсын 8852,6 км хилийн 901,058 км хэсэг буюу 10,9 хувийг усан хил эзлэх бөгөөд үүнээс ОХУ-тай 680 км, БНХАУ-тай 221,058км хэсгээр тус тус зах нийлэн хиллэж усан хилийн **96,6 хувийг голоор хил** болгосон хэсэг эзэлнэ. Судалгаанаас үзэхэд Монгол Улсын хилийн 1632,4 км хэсэг буюу 20,5 хувь нь тал хээрийн бүсэд улсын хил хамгаалалтыг хариуцан хамгаалдаг хилийн 32, 24, 27, 20,57, 17 дугаар отрядуудын хариуцсан хэсэгт хамаарах бөгөөд тус хилийн отрядуудын хариуцсан хэсгийн 90 хувь нь усан хил байна.

Тухайлбал Хилийн 20, 24, 32 дугаар отрядуудын хариуцсан хэсгийн хилийн шугамын дагуу Халх гол, Хэрлэн, Улз, Нөмрөг, дэгээ, Азарга, Бичигт, Чоно зэрэг томоохон голууд оршдог байна.

Монгол Улсын Хилийн тухай хуульд зааснаар Улсын хилийг тогтоохдоо дараах зарчмыг баримталдаг байна.

- Хуурай газарт тодорхой тэмдэгт, тогтвортой юмсыг хооронднь холбосон шулуун шугамаар, эсхүл уул нурууны усны хагалбараар;

- Гол, мөрөн, горхинд үндсэн урсгалын дундуур, нууранд нуурын эрэгт тулж ирсэн улсын хилийн шугамын хоёр үзүүрийг холбосон шулуун шугамаар;
- Улсын хил дамнасан байгууламжид улсын хилийн шугам өнгөрч байгаагаар гэж тусгасан байна.

Судалгааны хэсэгт “Гол, мөрөн, горхинд үндсэн урсгалын дундуур, нууранд нуурын эрэгт тулж ирсэн улсын хилийн шугамын хоёр үзүүрийг холбосон шулуун шугамаар”[168] хил тогтооно гэсэн үндсэн хэсгийг судлах бөгөөд Хил Хамгаалах Ерөнхий газрын даргын “Усан хил хамгаалалтыг зохион байгуулах” тухай зааварт тусгаснаар **Хилийн ус**- Улсын хилийн шугам дайран өнгөрч буй гол, нуур, горхи, цутгалан, түүний салаа болон бусад усан санг, **Эргийн хэсэг-** Хилийн усны эргийн дагуух газар орон тус тус хэлдэг байна.

Усан хилийн хамгаалалтыг зохион байгуулж байгаа хилийн отрядын албан тушаалтан хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хил хамгаалалтын дүрэм бусад эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ дараах үүргийг хүлээнэ “**Хариуцсан хэсгийн гол, нуурын усыг дайран өнгөрч буй хилийн шугамын явалт, газар орны онцлогийг мэддэг байх**”[169] гэсэн ойлголтуудтай учир судлаач миний бие голын голдирог гэж юу болох талаар тэр нь хэрхэн улс орны аюулгүй байдалд нөлөөлж болохуйц талаар судаллаа.

Урсгал усны үйл ажиллагаа: Гадаргын хэлбэр дүрсийг өөрчлөгч томоохон хүчний нэг бол урсгал усны үйл ажиллагаа юм. Борооны усны газарт шингэж амжаагүй үлдсэн хэсэг нь газрын гадаргын жижиг ховил сувгийг даган урсаж байхдаа ямагт булингартай байдгийг хүн бүр харсан байх. Тэгэхдээ чухам яагаад булингартай байна вэ гэж бодож байсан уу? Тэрхүү борооны ус нь замдаа тохиолдох тоосорхог, шаварлаг зүйлийг урсган авч явах ба түүгээр ч үл барам урсаж байгаа ховил сувгийнхаа ёроолыг ухаж гүнзгийрүүлсээр байдаг юм.

Эрози: Урсгал усны эвдэх үйл ажиллагааг хэлнэ.

Эрозийн процесс нь:

---

[168] *Хилийн тухай хууль нэгдүгээр бүлэг 8 дугаар зүйл*
[169] *Усан хил хамгаалалтын заавар 2 дах хэсэг 2,2,1*

- Гүний
- Хажуугийн
- Ухрах гэсэн гурван төрөл чиглэлээр явагдана.

Ус ямар нэг ховилоор урсахдаа ямагт ховилын ёроолыг ухаж, идэж өөрийн голдирлыг үүсгэдэг. Үүнийг гүний **эрози** гэнэ. Гадаргын налуу, урсаж буй усны хэмжээ их байх тусам гүний эрози хүчтэй явагддаг. Гүний эрози ихэнхдээ голын эх орчмоор давамгайлан явагддаг. Гүний эрозийн үр дүнд голын дэнж үүснэ. Урсгалын замд боржин, хүрмэн чулуу, гантиг гэх мэт хатуулаг ихтэй чулуулаг тохиолдож гүний эрози эрч хоцорч эхлэхэд голдирлын дунд хэсэгт хэдэн арван см-ээс хэдэн арван метрийн өндөртэй эгц мөргөцөг бүхий тавцан үүсэж түүн дээгүүр давж урсах голын ус байгалийн гайхамшигтай үзэгдэл болох хүрхрээг үүсгэнэ. Уулархаг нутаг эсвэл их хатуулагтай чулуулгийн дундуур урсаж байдаг голуудын гүний эрозийн үр дүнд каньон гэж нэрлэгдэх эгц хана бүхий гүн хавцлууд үүссэн байдаг. Чулуутын хавцал үүний жишээ юм.



Голын урсгалын дунд хэсэг, адаг орчим голдирлын налуу аажмаар бага болж ирэхэд голын ус хэдийгээр ихсэх боловч урсгалын хурд багасдаг учир гүний эрози бараг зогсож ёроолын идэгдэлт зогсож, усаар зөөгдөж яваа хэмхдэс материалууд тунаж эхлэх ба энэ үед голын ус эргээ өмнөхөөсөө арай илүүтэйгээр нурааж элэгдүүлж эхэлдэг юм. Ийнхүү голын ус эргээ идэж нураах процессыг **хажуугийн эрози** гэнэ.

Хажуугийн эрозийн үр дүнд **голын голдирол тахирлаж** тахирласан хэсгүүдийн эргээ элэгдүүлж нураасаар **меандр** гэх дүрсийг бий болгоно. Тал нутгийн урсгал дөлгөөнтэй голуудад тахирлалт буюу меандрлалт их байна. Тахирлалт ихэссээр зарим нэг меандр голдирлоосоо тасарч салах ба гол үерлэх үед голдирлтой холбогдож ус татрах үед дахин тасарч байвал түүнийг хар усан тохой гэж нэрлэдэг байна



Гол мөрөн нь:

- Идэж элэгдүүлэх
- Зөөн тээвэрлэх
- Хуримтлуулах гэсэн үйл ажиллагааг явуулдаг байна

Судалгааны энэ хэсэгт Хилийн цэргийн ..... дүгээр ангийн .... дүгээр салбарынн хариуцсан хэсгийг судалгаанд ашиглав. Тус заставын хариуцсан хэсгээр хиллэх усан хилийн уртыг харьцуулж үзэхэд доорх байдлаар гарч байна.

Хилийн цэргийн анги	Застав	Багана	Зай		Тэмдэгт босгосон газар	
.....	..... хилийн застав /Онон/	.....	Ёлт /Елатуй/ голын голдрилын дундуур явна. [761 хуртэл 1343.5м/	1	Ёлт Ела туй/ голын хоёр тальж эрэг дээр босгосон	Ёлт/ Елатуй/ голоор нийт 3 усны тэмдэг
		.....	Ёлт /Елатуй/ голын голдрилын дундуур явна. /762 хуртэл 1279.4/	1	Ёлт Ела туй/ голын хоёр тальж эрэг дээр босгосон	
		.....	Ёлт /Елатуй/ голын голдрилын дундуур явна. 763 яртэл 212.7	1	Ёлт Ела туй/ голын хоёр тальж эрэг дээр босгосон	
		.....	Хаслаг /Кошэлик/ голын голдрилын дундуур явна. 772 хуртэл 1506.4 м, 774 хүртэл 2722.6	1	Хаслаг Кошэлик/ голын хоёр талын эрэг дээр босгосон	Хаслаг /Кошэлик/ голоор нийт 5 усны тэмдэг
		.....	Хаслаг /кошэлик/ голын голдрилын дундуур явна. 775 хуртэл 1931.8м	1	Хаслаг Кошэлик/ голын хоёр талын эрэг дээр босгосон	
		.....	Хаслаг /Кошэлик/ голын голдрилын	1	Хаслаг Кошэлик/ голын хоёр	

			дундуур явна. 776 хүтэл 2627.1		талын эрэг дээр босгосон	
		.....	Хасглаг / Кошэлик/ голын голдрилын дундуур явна. / 777 хуртэл 1447.6	1	Хаслаг Кошэлик/ голын хоёр талын эрэг дээр босгосон	
		.....	Хаслаг / Кошэлик/ голын голдрилын дундуур явна. /778 хуртэл 2765.8 м/	1	Хаслаг Кошэлик/ голын хоёр талын эрэг дээр босгосон	
		Бүгд -**15,836,9** км				

Тус салбарын хариуцсан хэсгийн гол мөрний хил дагуух хэсгийн өөрийн талын бетон нь хавтангаар эргийг бэхэлж өгвөл эргийн нуралтаас хамгаалах, голын голдирог өөрчлөхгүй байх зэрэг олон давуу талуудтай байгаа юм. Хэрэв голын голдирог Монгол Улсын нутаг дэвсгэрийн талруу түрж орж ирвэл Монгол Улсын газар нутгийн хэмжээ өөрчлөгдөж хумигдах магадлалтай юм. Энэ нь “Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”[170] гэсэн үндсэн хуулийн заалтад сөргөөр нөлөөлж улмаар Улс орны оршин тогтнох аюулгүй байдлын асуудал тулгамдаж байгаа юм. Жижиг мэт зүйл боловч нэг хэсэг газар 1 метрээр наашлхад л улс орны бүрэн бүтэн байдал алдагдахад хүрнэ

Дээрх шинжилгээнээс үүдээд хил дагуух гол мөрний Монгол Улсын нутаг дэвсгэр талын эргийг дараах байдлаар хамгаалах боломжтой юм. Үүнд

- Эргийн хэсгийг тусгай зориулалтын төхөөрөмжөөр төхөөрөмжлөх
- Хууль эрх зүйн актад өөрчлөлт оруулах

[170] Монгол Улсын үндсэн хууль нэгдүгээр бүлэг дөрөвдүгээр зүйл 4.1

- Техникээр шийдэх
- Бүтээц байгуулах зэрэг саналуудаас хамгийн оновчтой буюу дэлхий нийтээр ашиглаж байгаа ганц арга нь эргийн хэсгийг тусгай зориулалтын бүтээцээр төхөөрөмжлөх юм. Энэ нь голын эрозыг өөрчлөхгүй хамгаалах юм эроз өөрчлөгдөхгүй бол Монгол Улсын хилийн шугамын өөрчлөгдөхгүй байх боломжтой юм. Судлаачид бид дараах байдлаар гол, мөрний эрэг дагуу 25 км газрыг бүтээц байгуулах тооцоог боловсруулав. Үүнд

Хээтэй хавтан

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	хээтэй хавтан /1*1.5/	ш	50,000	180,000	9,000,000,000
2	тээвэрлэлт	350 км	73	871,500	63,619,500
3	ачилт буулгалт /кран/	өдөр	60	400,000	24,000,000
4	хоол /20*60/	хүн өдөр	1,200	7,500	9,000,000
5	хүн тээвэрлэх машин /FAW CA 1092 E2/	50 км	73	27,900	2,036,700
6	Экскаватор	өдөр	60	350,000	21,000,000
Нийт дүн			**51466**	**1,836,900**	**9,119,656,200**

бетон хавтан

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	байгалын чулуу	ш	50,000	-	-
2	тээвэрлэлт	350 км	73	871,500	63,619,500
3	ачилт буулгалт /кран/	өдөр	60	400,000	24,000,000
4	хоол /20*60/	хүн өдөр	1,200	7,500	9,000,000
5	хүн тээвэрлэх машин /FAW CA 1092 E2/	50 км	73	27,900	2,036,700
6	Экскаватор	өдөр	60	350,000	21,000,000
Нийт дүн			**51466**	**1,656,900**	**119,656,200**

Байгалийн чулуу

д/д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
1	бетон хавтан /1*1.5/	ш	50,000	67,500	3,375,000,000
2	тээвэрлэлт	350 км	73	871,500	63,619,500
3	ачилт буулгалт /кран/	өдөр	60	400,000	24,000,000
4	хоол /20*60/	хүн өдөр	1,200	7,500	9,000,000
5	хүн тээвэрлэх машин /FAW CA 1092 E2/	50 км	73	27,900	2,036,700
6	Экскаватор	өдөр	60	350,000	21,000,000
Нийт дүн			**51466**	**1,724,400**	**3,494,656,200**

25 км газар дахь эргийн хамгаалалт босгох харьцуулалт

Судалгаанаас харахад хамгийн бага дүнтэй нь байгалын чулуугаар бүтцээц байгуулахад эдийн засгийн болон байгал орчинд ээлтэй байхаар харагдаж байгаа юм. Гол мөрний эрозыг хамгаалснаар Улс орны оршин тогтнох аюулгүй байдал хангагдана гэж үзэж байна. Эцэст нь “Монгол Улсын хил халдашгүй дархан байг”

Дүгнэлт

Судлаач эрдэмтдийн судалгаанаас харахад усан хил хамгаалалтын инженерчлэлийн талаар сүүлийн жилүүдэд маш ахиц дэвшилттэйгээр судалж байгаа ч судлаач миний судалгааны ажилд дараах дүгнэлтэд хүрч байна.

Гол мөрний эргийн инженерчлэлийн асуудал одоог хүртэл судлагдаагүй ч усан хил хамгаалалтын талаар түлхүү судалсан нь судалгааны явцад ажиглагдаж байна.

Цаашид гол мөрний эрэг голдирлын асуудлаар дэвшилттэйгээр судлах түүнд чиглэсэн төрийн бодлого эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэх

Өөрсдийн нөөц бололцоогоор эргийн хамгаалалтыг хийж гол мөрний голдирлыг өөрчлөхгүй байхад онцгой анхаарах зэрэг асуудлуудыг дэвшүүлэн тавьж байна

Ашигласан материал:

1. Наранцэцэг.Г., 2020 он. Гол мөрөн ай сав, УБ хот
2. Чойбаатар.Д., 2017 он. Усан хил хамгаалалт, УБ хот
3. Хадхүү.Ё., 2016 он. Гол мөрөн нуурын хамгаалалт, УБ хот
4. Монгол Улсын Үндсэн хууль
5. Аюулгүй байдлын тухай хууль

6. Хилийн тухай хууль
7. Хил хамгаалах байгууллагын усан хил хамгаалалтын заавар. УБ 2018
8. https://www.sciencedirect.com/science/article/pii/S0925857420303281
9. https://www.cambridge.org/core/books/abs/river
10. mechanics/riverbank
11. protection/44637305ACF057411E5B8CBF6B533471

ХИЛ ОРЧМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРИМ АРГА ЗАМ

Мягмарын Баярсайхан ДХИС-ийн Ахисан түвшний боловсролын сургуулийн магистр, докторын хөтөлбөрийн менежер, доктор, дэд хурандаа

Хураангуй агуулга:

Улс орны нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг хангах, тусгаар тогтнолыг бэхжүүлэн, улсын хил, хилийн орон зайд цагийн байдлыг тогтвортой байлгах, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт хамгаалах таатай нөхцөлийг хангах, учирч болзошгүй аюул, заналыг арилгах, үүссэн аюул заналаас хамгаалах тогтолцоо бүрдүүлэх нь хилийн аюулгүй байдлын үндсэн зорилго юм.

Түлхүүр үгс:

Үндэсний аюулгүй байдал, Хилийн аюулгүй байдал, Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, Хил хамгаалалт.

I.ОРШИЛ

Хүн төрөлхтний хөгжлийн явцад улс үндэстнүүдийн амьдрах орчин, орон зай болсон газар нутаг, түүний хил заагийг хэрхэн оновчтой бат бэх, тодорхой тогтоосон зэргээс түүний аюулгүй байдлыг хангах хэрэгцээ шаардлага нэмэгдэж ирсэн бөгөөд улмаар улсын хил хязгаар нь халдашгүй дархан, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал нь тухайн улсын оршин тогтнохуйг тодорхойлогч тулгуур ойлголт болж ирсэн байна.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь Монгол Улсын хилийн 8252,6 км хэсгийн халдашгүй дархан байдал болон “Монгол Улсын хилийн тухай хууль”-ийн 3 дугаар зүйлийн 1.14 дэх хэсэгт “...хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг...” хамруулан тодорхойлсны дагуу 69 сумын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны нэгдэл байх өвөрмөц онцлогтой юм.

Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр дэх хүн амын нягтрал бага, нийгэм, эдийн засгын хөгжил сул байгаа нь Монгол Улсын

үндэсний аюулгүй байдал болон улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах ажиллагаанд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлсийг бий болгож байгаа бөгөөд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг "...байгууллага, иргэний үйл ажиллагааг уялдуулан зохицуулах..."[171]-д чиглэгдсэн ажиллагааг бүрдүүлэхэд тулгамдсан асуудал болж байна.

Энэхүү илтгэлдээ Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааг хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжил, ард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоо, харилцан хамаарал, хилийн орон зайд үндэсний язгуур эрх ашгийг хангах зорилттой уялдуулан зохион байгуулах, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хүн амын амьдрах орчин, нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, хөгжлийн өнөөгийн байдал Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, хилийн аюулгүй байдалд хэрхэн нөлөөлж байгаа талаар судалж, хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх замаар хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах зарим арга замыг тодорхойлохыг зорьсон юм.

II. ҮНДСЭН ХЭСЭГ

Нэг: Аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт

Дэлхий дахинд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаа явуулах онцгой эрх бүхий субъект нь тусгаар тогтносон улс байдаг. Тусгаар тогтнож, бие даасан улс нь олон улсын эрх зүйн харилцааны гол оролцогч, анхдагч субъект[172] бөгөөд тусгаар тогтносон улс олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн дараах 4 шинжийг зайлшгүй хангаж байх шаардлагыг уламжлал болгон мөрдөж ирсэн байна. Үүнд:

- өөрийн нутаг дэвсгэртэй байх;
- бүрэн эрхт байдлыг хадгалсан байх;
- улс төрийн засаглалтай байх;
- харьяат иргэдтэй байх тус тус болно.

---

[171] Арвай, Ш. Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх асуудал. //ЭШХ-ын материал.-Уб., 2018. 22 дахь тал.

[172] Вестфалийн гэрээ.1648.

Тусгаар тогтносон улсын дээрх шинжийг хангаж, олон улсад тэр дундаа хил залгаа улсуудаар хүлээн зөвшөөрөгдсөн байх нь гол шинж бөгөөд аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны үндэс болдог байна.

Аюулгүй байдал гэдэг ерөнхий ойлголтыг "...олон талт, олон хүчин зүйл, шинжлэх ухааны олон салбараас хамааралтай байдгаас үүдэн аюулгүй байдлын тухай шинжлэх ухааныг "Аюул судлал"[173] гэж нэгдсэн ойлголтод хүрсэн боловч аюулгүй байдал гэх тодорхойлолтыг гадаад, дотоодын эрдэмтэн судлаачид өөр өөрийн салбар, судлагдахууны талаас нь янз бүрээр тайлбарлаж, дараах байдлаар тодорхойлж ирсэн. Үүнд:

1. "аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй"[174];
2. "айдсаас ангид орших нь аюулгүй байдлын жинхэнэ шинж чанар мөн"[175];
3. "аюулгүй байдал гэдэг нь гадна, дотнын аюул, заналаас хувь хүн, нийгэм, төр улсын амин чухал эрх ашиг хамгаалагдсан байдлын илэрхийлэл"[176];
4. "аюулгүй байдал нь"...төр, нийгэм, бие хүний (иргэний) ...түүхэн тодорхой нөхцөлд гадаад дотоодын бодит болон болзошгүй аюулаас үндэсний язгуур ашиг сонирхол найдвартай хамгаалагдсан байдал"[177];

5."аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх" ;

6."хөгжилд тулгуурлан өөрийгөө хамгаалах боломж бүрдүүлэгч нийгмийн тэр тогтолцоо аюулгүй юм" ;

7."тухайн улсад улс төрийн, эдийн засгийн ба нийгэмшлийг тогтвортой байдлыг тогтоон хангах, хуулиудыг чанд сахин биелүүлэх ба эрх зүйн дэг журмыг хангуулах, олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх үндэс болсон улс төр, эдийн засгийн, нийгэмшлийн, цэргийн, экологийн, мэдээллийн ба бусад шинжтэй дотоод ба гадаад

---

[173] Улаанхүү, Ч. Аюулгүй байдлын үндэс. -Уб., 2016. 18 дахь тал.
[174] Цэвэл, Я. Монгол хэлний товч тайлбар толь. -Уб., 1966. 60 дахь тал.
[175] Төртогтох, Г. Улсын хилийн аюулгүй байдал. -Уб., 2004. 3дахь тал.
[176] Улаанхүү, Ч. Аюулгүй байдлын үндэс. -Уб., 2016. 36 дахь тал.
[177] Бор, Ж. Дамдиндорж, Б нар. Монголын аюулгүй байдал. -Уб., 2016. 80 дахь тал.

шинж чанартай аюул заналхийллээс бие хүн, нийгэм ба төрийн амин чухал ашиг сонирхол хамгаалагдсан байдал” ;

8.“аюулгүй байдал гэдэг нь аюулаас хамгаалагдсан, аюул заналхийлээгүй байх нөхцөлийг хэлнэ” ;

9.“аюулгүй байдал гэдэг нь бүхэлдээ хэн ч, юунаас ч айж түгшихгүй байх тийм нөхцөл мөн”;

10.“... энэ нь нийгмийн гишүүн бүр хэнээс ч, юунаас ч айж түгшихгүй амар тайван байвал тухайн нийгэм бүхэлдээ амар тайван байх боломж бүрдэнэ гэж тэрбээр үзэж байснаас үүдэлтэй юм...” гэх зэрэг байдлаар тус тус тодорхойлсон байна.

Эдгээр тодорхойлолтууд нь тодорхой аюулд өртөхгүй байх **“...нөхцөл байдал...”** бүрэлдэн тогтож, бий болгосон орчныг заасан агуулгатай байна. Гэтэл зарим судлаачдын дэвшүүлсэн аюулгүй байдлын тодорхойлолтод аюулын эсрэг сөрөн зогсох үйл ажиллагааны **“...чадвар, чадавх...”**-ыг гол болгосон агуулгатай байгаа нь дараах байдлаар тодорхой харагдаж байна. Үүнд:

1. “... аюулгүй байдлын өнөөгийн агуулгыг "аюулаас бодитойгоор хамгаалагдсан байдал, түүнийг найдвартай сөрөн зогсох чадвар”[178];
2. “аюулгүй байдал нь аюулын судалгаанд үндэслэж, аюулд тохирсон шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдал”[179];
3. "аюулгүй байдал-аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх";
4. “аюулгүй байдал-дэлхийн нийгэмлэг, улс, нийгэм, хүний амьдралын оршин тогтнох үндсэн чухал язгуур эрх ашиг сонирхол гаднын болон дотоодын аюул заналаас найдвартай хамгаалагдсан байдал;
5. “аюулгүй байдал-амар тайван, бат бэх, итгэлтэй байх нөхцөл байдал, аюул болон эрсдэлээс чөлөөтэй байх”;
6. “аюулгүй байдал-хамгаалагдсан байдал”;

---

[178] Бельков, О.А.Поньятино-категориальный аппарат концепции национальной безопасности.1994.№3.С.91.

[179] Buzan, B. “Change and Insecurity” reconsidered. Contemporary Security Policy. ISSN 1352-3260.

7. “...аюулгүй байдлыг объектив болон субъектив утгаар нь тайлбарласан байна. Объектив утгаараа аюулгүй байдал гэдэг нь аюулгүй байх үнэт зүйлс, субъектив утгаараа аюул учрахад айдасгүй байх...”[180] тус тус болно.

Дээрх тодорхойлолтуудаар илэрхийлэгдэж байгаа агуулгаар нь авч үзвэл “Аюулгүй байдал” гэх ухагдахуун нь тодорхой аюулыг үүсгэхгүй байх **“нөхцөл байдал”**-д суурилан улмаар тодорхой аюул заналын эсрэг сөрөн зогсох үйл ажиллагааны **“чадвар, чадавх”**-ийг бий болгох нийлмэл шинж чанартай ойлголт юм гэж судлаачийн зүгээс үзэж байна.

Хоёр. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал:

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь бүхэлдээ хилийн аюулгүй байдал гэсэн ухагдахуунд хамаарч, Үндэсний аюулгүй байдлын хүрээнд багтаж байдаг зүй тогтолтой цогц ойлголт юм.

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (цаашид ҮАБҮБ гэх), батлан хамгаалах бодлого, нийгэм, эдийн засгийн чадавх, хүн ам зүйн бүтэц, олон улсын болон бүс нутгийн улс орнуудын хамтын нийгэмлэгүүдийн хүрээн дэх байр суурь, аюулгүй байдлаа хангах бодлоготой уялдсан онцлог бүхий үйл явц юм.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр нь дэлхийн ямар ч улсын оршин тогтнохуйг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор ирсэн иржээ. Хүн төрөлхтний түүхэн хөгжлөөс харвал газар нутаг, түүний хил хязгаарын асуудал нь аливаа үндэстэн, ястан, овог аймгуудын оршин тогтнохуйд гол байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд улс үндэстнүүдийн нэгдэн нийлэх, задран бутрах, бусдын эзэмшилд орох зэрэг нь гол төлөв газар нутгаас үүдэлтэй байжээ.

Аливаа улсын хил нь нийгэм улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын

[180] Arnold Wolfers. “National Security” as an Ambiguous Symbol. Political Science Quartely 67(4):481-502.

болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой..."[181] байна.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр нь дэлхийн ямар ч улсын оршин тогтнохуйг тодорхойлогч гол хүчин зүйл болсоор ирсэн иржээ. Хүн төрөлхтний түүхэн хөгжлөөс харвал газар нутаг, түүний хил хязгаарын асуудал нь аливаа үндэстэн, ястан, овог аймгуудын оршин тогтнохуйд гол байр суурь эзэлсээр ирсэн бөгөөд улс үндэстнүүдийн нэгдэн нийлэх, задран бутрах, бусдын эзэмшилд орох зэрэг нь гол төлөв газар нутгаас үүдэлтэй байжээ.

Аливаа улсын хил нь нийгэм улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой..."[182] байна.

2010 онд батлагдсан Монгол Улсын ҮАБҮБ-ын "Үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг, хангах арга зам" гуравдугаар бүлэгт оршин тогтнохын аюулгүй байдлын үндэс нь "Монгол Улсын тусгаар тогтнол бүрэн эрхт байдал, хил хязгаарын халдашгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал юм " гэжээ. Эдгээрийг доктор (Sc.D), профессор Ш.Арвай өөрийн бүтээлдээ хилийн аюулгүй байдал гэж авч үзэн дараах байдлаар томьёолсон байна. Үүнд:

- Хилийн аюул гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт төр, нийгэм, хувь хүнд биеийн хүч болон материалын ямар нэгэн хэлбэрээр хохирол учруулах гэсэн оролдлогын илэрхийлэл[183];
- Хилийн аюул нь нэгэнт тогтоон тэмдэглэсэн хилийг хууль эрхийн бус болгох мөн тогтоогдсон хилийн дэглэмийг зөрчих хоёр хэлбэрээр илэрнэ гэсэн байна.

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн тухай ойлголт нь орон зайн хувьд хил нь хил орчмын нутаг дэвсгэрийн эхлэл цэг, харин хил орчмын нутаг дэвсгэрийн төгсгөл нь улсын хилээр

---

[181] Дашдаваа, Д. Хилийн аюулгүй байдлын зарим асуудал. -Уб., 2014. 5 дахь тал
[182] Дашдаваа, Д. Хилийн аюулгүй байдлын зарим асуудал. -Уб., 2014. 5 дахь тал
[183]Арвай, Ш. Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам. -Уб., 2013. 22 дахь тал.

тодорхойлогдож байна. Тиймээс хил нь анхдагч бөгөөд, хил нь хил орчмын нутаг дэвсгэрийн, хил орчмын нутаг дэвсгэр нь хилийн оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлэгч байна.

Хилийн аюулгүй байдал, төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орон зайд хангах замаар үндэсний хийгээд, улс хоорондын аюулгүй байдлыг хангах тогтвортой урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагаа юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаа нь нэгдүгээрт Монгол Улсын Засгийн Газраас явуулж байгаа олон улсын хэмжээний улс төр, дипломат гадаад харилцааны ажиллагаа, хоёрдугаарт тайван цагт Монгол Улсын болон олон улсын гэрээ хэлэлцээрийг хэрэгжүүлэх, хилийн бүс зурваст хууль сахиулах ажиллагаа, гуравдугаарт Монгол Улсын хилийн орон зайд бий болж болзошгүй цагийн байдлын өрнөлтийн ямар нөхцөлд шилжин ажиллах бэлэн байдлыг ханган явуулж буй Хилийн алба-байлдааны ажиллагаа, дөрөвдүгээрт Монгол Улсын Батлан хамгаалах нэгдсэн тогтолцооны бүрэлдэхүүнд цэргийн ажиллагаа байна.

Хилийн халдашгүй дархан байдал нь олон улсын гэрээ эрх зүйгээр зохицуулагддаг бол хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь тухайн улсын дотоод хууль эрх зүйгээр зохицуулагддаг, харилцан нарийн уялдаатай системүүд юм. Хилийн халдашгүй дархан байдал нь хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд, мөн хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь хилийн халдашгүй дархан байдалдаа шууд харилцан нөлөөлдөг байна.

Монголд анх төрт ёс бий болсон цаг үеэс эхлэн улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг төрийн бодлогоор хангаж ирсэн арвин баялаг туршлагатай ард түмэн юм.

Гурав. Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал:

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаанд Хилийн цэргийн 6 тусгай ангийн 109 офицер хамрагдсан бөгөөд “Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн нийгмийн харилцааг зохицуулж буй эрх зүйн үйл ажиллагааны өнөөгийн байдлыг хангалттай гэж үзвэл та ямар

үнэлгээ өгөх вэ” гэсэн асуултад нийт оролцогчдын 22 нь буюу 20,1 хувь сайн, 36 нь буюу 33,2 хувь нь муу, 51 нь буюу 46,7 хувь нь дундаж төвшинд үнэлсэн нь сайжруулалт шаардлагатайг илэрхийлсэн гэж үзэхэд хүргэж байна.

Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй 685 орчим хуулиас улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг шууд зохицуулсан хэм хэмжээ бүхий 66 хууль нь 0,9 хувийг, шууд бус зохицуулалттай 36 хууль 0,5 хувийг буюу нийт 106 хууль байгаа нь 14,8 хувийг тус тус эзэлж байна.



Зураг 1. ХАБ-ыг хангах эрх зүйн ажиллагааны өнөөгийн байдалд өгсөн үнэлгээ[184]

Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хууль тогтоомжийн хэрэглээг тодорхойлох зорилгоор явуулсан социологийн судалгааг Хил хамгаалах байгууллагад ажиллаж буй нийт 607 алба хаагчийн хүрээнд явуулсан.

Төгссөн сургууль	ХХБ-д ажилласан байдал	Насны байдал

[184] Судалгааны ажлын хүрээнд авсан санал асуулга.

Хилийн сургууль	Энгийн мэргэжлээр	5 хүртэл жил	6-10 жил	11-15 жил	16-20 жил	25 хүртэл	25-30 хүртэл	31-45 хүртэл	46-аас дээш
64,2 %	35,8 %	22,3 %	35,8 %	23,8 %	14,9 %	0,08 %	31,8 %	56,7 %	0,02 %

Албан тушаалын хувьд						
Алба, тасгийн дарга	Алба, тасгийн офицер, мэргэжилтэн	Шалгагч	Шуурхай жижүүр	Хилийн заставын дарга	Салбарын дарга	Харуулын дарга
%	28,3 %	34,3 %	0,05 %	0,10 %	0,02 %	0,07 %

Хүснэгт 1. Судалгаанд хамрагдагсдын мэдээлэл.

Дээрх үзүүлэлтээс судалгаанд оролцсон алба хаагчдын дийлэнх хувь нь бакалаврын төвшинд мэргэжлийн чиглэлийн сургуулийг төгсөж, хил хамгаалах албаны мэргэжил эзэмшсэн, ажил албаны туршлагатай, албан тушаалын хувьд гүйцэтгэх түвшний алба хаагчид байгаа нь судалгааны үр дүн, үнэлэмжийг бодитой үзэхэд хүргэж байна. Судалгаагаар алба хаагчдад дараах 7 чиглэл улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны эрх зүйн зохицуулалтын мэдлэг чадвар хэрэгцээтэй байгаа нь харагдаж байна. Үүнд:

1. олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилт;
2. хилийн дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
3. хил орчмын дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт;

4. хилийн боомтод сахих журмыг хэрэгжүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
5. хил дамнасан гэмт хэргийг илрүүлэх таслан зогсоох ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
6. хилийн зөрчилд хойшлуулшгүй ажиллагаа явуулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
7. хилийн боомтод гарсан зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт тус тус болно.

Дээрх судалгаанаас Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байгаа үндэсний эрх зүйн зохицуулалтын чиглэлийг дараах байдлаар бүлэглэн авч үзэх боломжтой юм. Үүнд:

- хилийн дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
- хил орчмын дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт;
- хилийн боомтод сахих журам, түүний эрх зүйн зохицуулалт;
- гэмт хэрэг, зөрчилд хойшлуулшгүй ажиллагаа явуулах болон шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт тус тус болно.

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад алба хаагчдын ажил, албанд хэрэгцээтэй байгаа эрх зүйн эх сурвалжуудыг нийгмийн харилцаанд үйлчлэх шинжээр нь авч үзвэл “Хил орчмын дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт”, “Хилийн боомтод сахих журам, түүний эрх зүйн зохицуулалт”, “Гэмт хэрэг, зөрчилд хойшлуулшгүй ажиллагаа явуулах болон шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт”-ууд нь олон хууль тогтоомжуудын хүрээнд зохицуулагдаж байгаа хамарсан нийтлэг нийгмийн харилцаа болж байна. Харин “Хилийн дэглэм сахиулах ажиллагааны эрх зүйн зохицуулалт” нь Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал, хилийн халдашгүй дархан байдлыг хангах тусгай харилцааг зохицуулсан шинжтэй, Улсын хил хамгаалалтын эрх зүйн зарчмын суурь хэм хэмжээг агуулсан онцлогтой тул тусгайлан авч үзэх шаардлагатай.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болох хилийн аюулгүй байдал нь улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдал бөгөөд хилийн аюулгүй байдлыг улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн төрийн эрх бүхий байгууллагуудаас нэгдмэл бодлого, харилцан уялдаатай явуулах цогц дараах үйл ажиллагаагаар хангагдахаар тодорхойлсон. Үүнд:

1. улс төрийн үйл ажиллагаа;
2. эрх зүйн зохицуулалтын үйл ажиллагаа;
3. дипломат гадаад харилцаа;
4. эдийн засгийн тогтолцоо;
5. байгаль орчин, түүнийг хамгаалах үйл ажиллагаа;
6. тагнуулын үйл ажиллагаа;
7. улсын хил хамгаалалтын үйл ажиллагаа тус тус болно.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, тэдгээрийг уялдуулан зохицуулах, төрөөс хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Монгол Улсын Засгийн газар хариуцахаар хуульчилсан байна.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах орон зайг тодорхойлсон нэг чухал хэсэг бол хил орчмын нутаг дэвсгэр бөгөөд Монгол Улсын Хилийн тухай хуулийн 3.1.14 дэх хэсэгт “...хил орчмын нутаг дэвсгэр гэж хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрийг...” хэлнэ хэмээн тодорхойлсон. Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр нь 536,8 мянган км^2 газар нутгийг эзэлсэн өргөн уудам орон зай боловч хүн амын нягтрал харьцангуй бага 261,778 хүн амьдарч байгаа нь нэг км^2 газарт дунджаар 0,48 хүн оногдож байна.

Зураг 2. Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн хэмжээ

Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэр гэх ойлголтод нийт аймгийн 14 нь буюу 66,6 хувь, сумдын 20 гаруй хувь буюу 69 сумдын нутаг дэвсгэр орж байна.

Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах суурь хүчин зүйл болсон хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны бүрэлдэхүүн юм.

Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагаанд хил орчмын нутаг дэвсгэрийн ард иргэдийн сийрэгшилд хамгийн сөрөг нөлөөтэй гэж үзэх үндэслэлтэй бөгөөд энэ нь эдийн засгийн газар зүйн салбарын эрдэмтэн Л.Шаетцел, Н.Д.Кондратьев нарын дэвшүүлсэн бүс нутгийн бүсчилсэн хөгжлийн онолын “... төв рүү тэмүүлэх ...” зарчимд үндэслэгдэж байна. Энэхүү зарчмын дагуу хил орчмын нутаг дэвсгэрийг үүсгэх зохион байгуулалтын үндэс нь “...эдийн засгийн объектууд, хүн ам, нутаг дэвсгэрийн нөөц баялаг, тэдгээрийн хоорондох орон зайн уялдаа холбоо, харилцан хамаарлыг харгалзан тодорхойлох үйл явц...”[185] гэж үзсэн байна.

Манай улсын хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн түвшин эдийн засаг, газар зүйн ямар нэг уялдаа холбоо байхгүй, харилцан хамаарал бүхий нийлмэл хэв шинж байхгүй нь эрсдэлтэй гэж үзэхэд хүргэж байна. Энэ нь дээрх эрдэмтдийн дэвшүүлсэн “... төв рүү тэмүүлэх ...” онолын сөрөг хүчин зүйлийг бий болох зүй тогтлын

[185] Базаргүр Д. Монгол Улсын нийгэм, эдийн засгийг тэнхлэгээр хөгжүүлэх үзэл баримтлал. Уб., 2000.

дагуу Монгол Улсын хүн амын төвлөрөл нийслэл хот болон төвийн бүсийн хотуудад ихсэж, хязгаар нутаг эзгүйрэх хандлагатай болоход хүргэж байгаагаас харагдаж байна.

Монгол Улс нь хоёр мянга хоёр зуун хорь гаруй жилийн төрт ёсны түүхэн уламжлалаар хил хязгаар нутагт олон зуун жилийн турш ард иргэдээ, аравт зуут мянгат, түмтээр нь байрлуулан хил хязгаарын аюулгүй байдлыг хангаж, нутаг дэвсгэрийнхээ гүний болон төв хэсгийг нандигнан хадгалж ирсэн түүхтэй[186]. Гэтэл өнөөгийн Монгол Улсад хүн амын тал шахам хувь нь нийслэлдээ амьдарч хамгийн нандин байдлаар хамгаалагдах ёстой хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйдэж үндэсний аюулгүй байдалд ноцтой аюул учруулж болзошгүй орон зайг үүсгэж байна. Энэ нь Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилж үзэхэд нийт хүн амын 45.9 хувь нь нийслэл Улаанбаатар хотод, 18.7 хувь нь Хангайн бүсэд, 15.8 хувь нь Төвийн бүсэд, 12.6 хувь нь баруун бүсэд, 7.0 хувь нь зүүн бүсэд оршин сууж байгаа бол хилийн сумуудад 324’193 хүн буюу Монгол Улсын хүн ам (3,296,866)[187]-ын 9,8 хувь нь амьдарч байгаагаас харагдаж байна.



Зураг 3. Монгол Улсын хүн амын суурьшлыг бүсээр ангилсан судалгаа[188]

[186] Арвай, Ш. Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам.-Уб.,2013. 18 дахь тал.
[187] Үндэсний статистикийн хорооны тайлан, Уб., 2020. 132 дахь тал.
[188] Статистикийн мэдээллийн нэгдсэн сан (файлын сан) судалгаа.-Уб., 2020..

Дэлхий дахинаа хотжих хөдөлгөөн нэмэгдэж буй боловч ихэнх улсуудын нийслэлд хүн амынх нь 10 орчим хувь нь нийслэл хотдоо амьдарч, хил хязгаар болон дундын орон зайд үлдсэн иргэд нь амьдарч байгаатай харьцуулбал манай улсын хүн амын төвлөрөл дэлхий дахины жишгээс урвуу хамааралтай байгаа юм.

Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд нөлөөлөх хүчин зүйлсийг системтэйгээр судлан шинжилж, учирч болох аюул тулгамдсан асуудлыг тогтоож, холбогдох арга хэмжээг стратеги бүс нутаг оператив-тактикийн цар хэмжээнд хэрэгжүүлэх шаардлага гарч байна.

Бүс нутагт дайны аюул ерөнхийдөө холдож, зэвсэгт халдлага, түрэмгийлэл гарсан тохиолдолд НҮБ-ын аюулгүйн зөвлөлийн эрх хэмжээнд асуудлыг энхийн ба бусад аргаар шийдвэрлэдэг болсон орчин үед газар нутаг ихтэй, хүн ам цөөнтэй манай улсын хувьд нэн тэргүүнд улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт ҮАБ-ыг хангах гадаад, дотоод таатай орчин нөхцөл бүрдсэн байх стратегийн зорилтыг тэргүүлэх түвшинд тавьж, хөгжүүлэх шаардлагатай байгааг[189] зарим судлаачид дэвшүүлсэн байдаг. Тиймээс нийгэм, эдийн засгийн хөгжил урагшлах тусам хил орчмын нутаг дэвсгэрийг хөгжүүлэх ач холбогдол өсөн нэмэгдэж, хөрш улсуудын хил заагийн эдийн засгийн хамаарлыг цогц байдлаар авч үзэх шаардлага тавигдаж байна.

Монгол Улсын хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдалд шууд чиглэсэн аюул занал байхгүй ч шууд бус, дам байдлаар нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл ихэссэн, зайлшгүй тусгайлсан арга хэмжээ авах шаардлагатай болсон гэж үзэж байна.

III. ДҮГНЭЛТ.САНАЛ

Монгол Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааны өнөөгийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хүрээнд хийсэн судалгааны ажлын үр дүнд дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Монгол Улсын хилийн аюулгүй байдал нь улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн

[189] Арвай, Ш .Улсын хил, хязгаарын аюулгүй байдал, тулгамдсан асуудлууд шийдвэрлэх арга зам.-Уб.,2013. 13 дахь тал.

аюулгүй байдал гэсэн нийлмэл ойлголт бөгөөд улсын хилийн халдашгүй дархан байдлыг “Агаарын хил”, “Газрын гадаргын хил”, “Газрын хэвлийн хил”, “Усан хил” гэсэн дөрвөн хэсэгт авч үзэх нь оновчтой байна;

2. Хилийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг зохицуулж буй хэм хэмжээ, хуулиудын уялдаа холбоо, давхардал, шийдлийг судлан тогтоож, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох судалгааг эрх зүйн хэм хэмжээний шаталсан тогтолцоонд тулгуурлан нэгдүгээрт “Хилийн аюулгүй байдлыг хангах олон улсын эрх зүйн зохицуулалт”, хоёрдугаарт “Хилийн аюулгүй байдлыг хангах үндэсний эрх зүйн зохицуулалт” гэсэн хоёр чиглэлд авч үзэх;
3. Монгол Улсын ҮАБ-ыг хангах талаар УИХ-аас батлан гаргасан эрх зүйн эх сурвалжууд болох “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”, “Батлан хамгаалах бодлогын үндэс” зэрэг голлох баримт бичгүүдэд Монгол Улсын Хилийн аюулгүй байдлын талаарх бодлого, үзэл баримтлал нь Монгол Улсын ҮХ-ийн заалтаар тунхагласан хэм хэмжээний хүрээнд бүрэн тодорхойлсон гэж үзэх үндэслэлтэй байна;
4. “Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын агуулгыг өргөжүүлж Нийтлэг үндэслэл”, “Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын зорилго, зорилт, зарчим”, “Хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоо”, “Хилийн аюулгүй байдлын бодлогын хэрэгжилтийг хангах үйл ажиллагааны чиглэл”, “Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны хөгжлийн чиглэл”, “Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт”, “Хилийн аюулгүй байдлыг хангах бодлогын хяналт-шинжилгээ, үнэлгээ” гэсэн дэд бүлэгтэй байхаар шинэчлэх шаардлагатай байна;
5. Монгол Улсын Эрүүгийн хуульд дээр дурдагдсан “Хилийн ус”-ыг аж ахуйн зориулалтаар ашиглах, бохирдуулахаас сэргийлэн хориглож, хариуцлага тооцохоор заасан тодорхой заалт үгүй байна. Хэдийгээр Монгол Улсын Эрүүгийн хуульд “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг” гэсэн 24 дүгээр бүлгийн 24.1 дүгээр зүйл байгаа боловч уг гэмт хэргийн бүрэлдэхүүний шинж нь Монгол Улсын УХД-ийн гэрээгээр

тодорхойлогдсон хилийн ус ашиглах, хамгаалахтай холбоотой харилцааг зөрчсөн тохиолдлыг хамруулах зүйлчлэх боломжгүй байна;

6. Монгол Улсын “Амьтны тухай хууль”-д улсын хил орчмын нутаг дэвсгэрт хамаарах тусгайлсан зохицуулалт хэдийгээр үгүй ч ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад чиглэл нийтлэг хэм хэмжээг заасан нь байна. Гэвч улсын хил даван нүүдэллэх ан амьтдын талаарх зохицуулалт тус хуулинд нэмэлтээр бие даасан бүлэг заалт хэлбэрээр оруулах шаардлагатай байна;
7. Монгол Улсын “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 2 дугаар бүлгийн **“**Ашигт малтмал эрэх, хайх, ашиглах үйл ажиллагааг хязгаарлах, хориглох тусгай хэрэгцээний газар” гэсэн 14 дүгээр зүйлд улсын хилийн зурваст ашигт малтмалын үйл ажиллагаа хориглох заалт оруулах нь зүйтэй байна;
8. Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт мал аж ахуй эрхлэх харилцааг тусгайлан зохицуулсан үндэсний хууль, тогтоомж үгүй бөгөөд Зөрчлийн тухай болон Эрүүгийн хууль тогтоомжид тусгайлсан зохицуулалт нэмэлт, өөрчлөлтийн хэлбэрээр оруулах шаардлагатай байна;
9. Хилийн аюулгүй байдлыг хангах олон улсын эрх зүйн зохицуулалтын гол хэм хэмжээг агуулсан Монгол Улсын хилийн дэглэмийн гэрээний заалтыг хэрэгжүүлэх талаар манай улсын үндэсний хууль тогтоомжоор бүхэлд нь баталгаажсан эрх зүйн зохицуулалтын орчин бүрдсэн гэж үзэх боломжтой хэдий ч боловсронгуй болгох хэрэгцээ, шаардлага бий болсон байна.
10. Дэлхий дахинаа хотжих хөдөлгөөн нэмэгдэж буй боловч ихэнх улсуудын нийслэлд хүн амынх нь 10 орчим хувь нь нийслэл хотдоо амьдарч, хил хязгаар болон дундын орон зайд үлдсэн иргэд нь амьдарч байгаатай харьцуулбал манай улсын өнөөгийн хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжил, хүн амын төвлөрөл дэлхий дахины жишгээс урвуу хамааралтай байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж.

1. Монгол Улсын хууль. Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл. №1. 1992.
2. Монгол Улсын хууль. Үндэсний аюулгүй байдлын тухай. Уб., 2001.
3. Монгол Улсын хууль. Хилийн тухай. Уб., 2016.
4. Монгол Улсын хууль. Зөрчлийн тухай. Төрийн мэдээлэл. №24. Уб., 2017.
5. Монгол Улсын хууль. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай.Уб., 2020.

Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол.

6. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. №48. Уб., 2010.
7. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал. №48. Уб., 2011.
8. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Төрөөс хилийн талаар баримтлах бодлого. №20. Уб., 2002.

Ном бүтээл.

9. Арвай Ш. Аюулгүй байдлыг чандлан хангаваас бидний эх орон мөнх оршино. Уб., 2020.
10. Арвай Ш. Монгол Улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог. Уб., 2015.
11. Бор Ж., Чулуунбат В. Үндэсний аюулгүй байдлын онолын үндэс. Уб., 2012.
12. Бор Ж., Баатар Д. Монголын аюулгүй байдал. Уб.,2016.
13. Дашдаваа Д., Ганболд Ц., Муратхан А., Хилийн аюулгүй байдал.Уб., 2021.
14. Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль эрх зүйн актуудын эмхэтгэл. Уб., 2007.
15. Монгол Улсын хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд холбогдох эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. Уб., 2019.

16. Монгол, Хятадын хилийн дэглэмийн тухай Монгол Улсын засгийн газар, БНХАУ-ын засгийн газар хоорондын гэрээ. Уб., 2011.
17. Мягмар Д. Аюулгүй байдлын судалгааны зарим асуудал. Уб., 2014.
18. Улаанхүү Ч. Аюулгүй байдлын онол, арга зүйн асуудал. Уб., 2014.
19. Энхбаяр Ж. Аюулгүй байдлын олон талт асуудал. Уб., 2007.
20. Эрдэнэчимэг Б. Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлого. Уб., 2016
21. Япон улсын Үндэсний батлан хамгаалахын академийн аюулгүй байдал судлалын тэнхим. Аюулгүй байдлын тулгуур асуудлууд. Уб., 2016.

Нэг сэдэвт бүтээл.

22. Арвай Ш. БНМАУ-ын Хятадтай хил нийлсэн хэсгийн хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь. Шинжлэх ухааны докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2002.
23. Амгалан Ц. Монгол Улсын өмнөд хил орчмын нутаг дэвсгэрийн нийгэм-эдийн засгийн газарзүйн зарим асуудал. Газарзүйн ухааны докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2019.
24. Дашдаваа Д. Улсын хилийн аюулгүй байдал, түүнийг хангах зарим арга зам. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2010.
25. Гансүх Ц. Улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын тулгамдсан зарим асуудал, шийдвэрлэх арга зам. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон диссертаци. Уб., 2018.
26. Одбаяр Ц. Хилийн аюулгүй байдлыг хангахад тусгай томилгоот салбарын гүйцэтгэх үүргийн судалгаа. Цэргийн ухааны докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2013.
27. Энх-Амгалан Д. Уламжлалт бус аюул, түүний нийгэмд үзүүлэх нөлөөллийг бууруулах арга зам. Аюулгүй байдлын докторын зэрэг горилсон диссертац. Уб., 2017.

ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН СУРГАЛТ ХӨГЖИЛ

Д.Гэрэлтуяа
Хилийн цэргийн 0257 дугаар ангийн Сэтгэл зүйн бэлтгэлийн албаны социологи, дүн шинжилгээний ахлах офицер, ахмад

Товч агуулга:

Төрийн тусгай байгууллагын удирдах ажилтнуудын чадавхаас байгууллагын дотоод зохион байгуулалт, уялдаа холбоо, ажлын бүтээмж, гүйцэтгэлийн түвшин ихээхэн хамаардаг. Чадварлаг, ухаалаг удирдлагууд байгууллагыг төдийгүй өөрийн хариуцсан алба хаагчдын ур чадвар, хандлагыг өсгөдөг. Бэлтгэгдэж, бэлэн болсон удирдах ажилтнууд өөрийн залгамж халааг бэлтгэх арга барилд суралцаж, байгууллагууд өөрсдийн залуу манлайлагчдыг бодлогоор төрүүлж, бэлтгэж эхлээд байна.

Менежментийн түвшинд ажиллаж байгаа удирдлагуудад хүнийг удирдах мэдлэг, туршлагад нь шинэ сорилтууд тулгарч, менежментийн үйл ажиллагаа, өөрийгөө удирдах ур чадваруудтай тулгардаг. Орчин үед хувь хүнийг хөгжүүлсэн сургалтын чиг хандлага илүү ихээр илрэх болсон.

Мөн хүний эрх, эрх чөлөө, хүний эрхийн мэдрэмжтэй байхыг шаардсан энэ цаг үед удирдах ажилтнуудад “**гүйцэтгэх алба**”-ны зүгээс биш чадварлаг чиглүүлэгч байх шаардлага ихээр тавигдах болсон.

Иймд төрийн тусгай байгууллага, түүний дотор Хил хамгаалах байгууллагын хувьд хилийн цэргийн тусгай анги, салбарын удирдах ажилтнуудыг чадавхжуулах сургалт хөгжлийн хөтөлбөрийг орчин үеийн чиг хандлагатай уялдуулан боловсруулж гаргах зайлшгүй шаардлагатай байна.

Түлхүүр үг:
Сургалт хөгжил, удирдах ажилтны сургалт, хөгжлийн хөтөлбөр

АГУУЛГА

Удиртгал

1.Удирдах ажилтны ажлын арга барилын орчин үеийн чиг хандлага;

2.Удирдах ажилтны сургалтын хөтөлбөр боловсруулахад анхаарах асуудлууд;

3.Жишиг сургалтын хөтөлбөрийн загвар.

ОРШИЛ

Байгууллагын удирдах ажилтнуудын чадавхаас байгууллагын дотоод зохион байгуулалт, уялдаа холбоо, ажлын бүтээл, гүйцэтгэлийн түвшин ихээхэн хамаардаг. Чадварлаг, ухаалаг удирдлагууд байгууллагыг төдийгүй өөрийн хариуцсан алба хаагчдын ур чадвар, хандлагыг өсгөдөг байна.

Парэтогийн зарчим[190] ёсоор ашгийн 80 хувийг авч ирдэг, 20 хувийг буюу үйл явцыг голчлон зохион байгуулдаг тэдгээр удирдлагуудыг хайхад асар их зардал гаргаж байна. Учир нь тэдний нөлөө байгууллагад тогтвортой өсөлтийг бий болгодог.

Бэлтгэгдэж, бэлэн болсон удирдах ажилтнууд өөрийн залгамж халааг бэлтгэх арга барилд суралцаж, байгууллагууд өөрсдийн залуу манлайлагчдыг бодлогоор төрүүлж, бэлтгэж эхлээд байна[191].

Менежментийн түвшинд ажиллаж байгаа удирдлагуудад хүнийг удирдах мэдлэг туршлагад нь шинэ сорилтууд тулгарч, менежментийн үйл ажиллагаа, өөрийгөө удирдах ур чадваруудтай тулгарч байна.

НЭГ. УДИРДАХ АЖИЛТНЫ АЖЛЫН АРГА БАРИЛЫН ОРЧИН ҮЕИЙН ЧИГ ХАНДЛАГА

1. Хувь хүний хөгжил: (Эхлээд алба хаагчдыг алба хаагч гэж харахаасаа өмнө хувь хүн шүү гэдэг өнцгөөс нь харж хөгжүүлбэл оновчтой. Хувийн зохион байгуулалт, дадал зуршил, амьдралын хэв

[190] https://mn.wikipedia.org/wiki.

[191] http://www.hrconsulting.mn

маяг г.м. Монгол хүний нэг онцлог нь хүн шиг хандвал хүн шиг л хандана гэсэн дотоод бодол байдаг);

2. Мэргэжлийн ур чадвар: (Мэргэжлийн ажлаа хийж гүйцэтгэхэд дутагдаад байгаа ур чадварууд);

3. Багаар хамтран ажиллах ур чадвар: (Бусадтайгаа уялдаж, ойлголцож ажиллах чадварын түвшин) гэсэн ерөнхий 3 чиглэлийг бодолцож төлөвлөнө.

Сургалт хөгжлийн хөтөлбөрт:

1. Лекц, сургалт;
2. Алба хаагч, хамт олны уулзалт;
3. Өглөөний уулзалт буюу ажлын цагаас өмнө цуглаж мэдлэг, мэдээллээ солилцох, сонирхолтой хүн урьж яриа хийх;
4. Алба хаагчдын клуб буюу мэдлэг туршлагаа солилцдог өдөрлөг. Дотоод хөгжлийн клубын системийг бий болгосноор анги хамт олон туршлагаа тогтмол хуваалцан нэгнээсээ суралцаж тогтмол хөгжих тогтолцоо бүрдэнэ;
5. Гэр бүлийн өдөрлөг буюу нийт хамт олныг гэр бүлтэй нь урьж нээлттэй өдөрлөг зохион байгуулах. Гэр бүлд нь хил хамгаалах байгууллага, албаны үйл ажиллагааны онцлогийг мэдүүлэх зорилготой;
6. Үнэт зүйлийн өдөр буюу төрийн тусгай албаны үнэт зүйл, зорилго зорилт, алдаа онооны тухай нийтээр ярилцдаг өдөр;
7. Чин сэтгэлийн зурвас буюу нэг өдөр байгууллагаар шууданч ажиллуулж нэгэндээ зориулсан зурвас, захидлуудыг зөөж үйлчилнэ. Гомдож, туньсан сэтгэлийг тайлж уур амьсгалд эергээр нөлөөлдөг;
8. Мэдээллийн цаг буюу байгууллагын алба хаагчдад хамгийн их хэрэгтэй байгаа сэдвээр мэдээлэл хийлгэж болдог. Жишээ нь: Сэтгэл зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сонирхол, хобби, байрны зээл, даатгал, хэрхэн турах вэ г.м.
9. Урлаг спортын арга хэмжээ, тэмцээн уралдаан;
10. Хамт олноороо үзвэр үйлчилгээнд хамрагдах;
11. Ажлын чиг үүргээ нэг өдөр солилцож хийж, нэгнийхээ ажлын байрны онцлогийг мэдэж авах;

12. Алба, тасгууд хоорондоо өрсөлдөх уралдаан, тэмцээн гэсэн хэлбэрүүдээс оруулах боломжтой.

Зорилго, хэрэгцээ шаардлагаа тодорхойлох.

Хөтөлбөрийн зорилго нь Хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн анги хамт олны мэдлэг, ур чадварын нөөцийг илрүүлж ашиглах, шавхагдашгүй баялаг болох хүний бүтээлч сэтгэлгээ, туршлагыг хөгжүүлэхэд, баялаг бүтээхэд оролцуулахад чиглэдэг. Мөн алба хаагчдын сул талыг багасгах, давуу талыг дэмжиж илүү хөгжүүлэхэд чиглэж болно.

Сургалтын хэрэгцээ шаардлагыг гүйцэтгэлийн үнэлгээнээсээ тодорхойлж гаргаж ирнэ. Гүйцэтгэлийн үнэлгээнээс ур дүн муутай ажиллаж байгаа алба хаагчдын **муу ажиллаад байгаа шалтгааныг** тодорхойлно. Мэргэжлийн ур чадвар уу, эсвэл хувийн харилцаа, хандлагаас болов уу, эсвэл удирдлагын ур чадвар, баг хамт олны үл ойлголцол, хийх ажлын тодорхой биш байдлаас болов уу гэх мэтээр тодорхойлно. Тодорхойлсны дагуу төлөвлөлт гаргана.

1. Дотоод сургалт.

1.1.Төрийн тусгай байгууллагын зорилго, үзэл санаа, үнэт зүйл

1.2.Дэг, журам, заавар

- Дэг: Ажлын дэс дараалал;
- Журам: Болох, болохгүйн хил заагийг заасан;
- Заавар: Ажил хийх арга зүй, үйл явцын заавар;
- Эрхийг заана;
- Үүргийг заана.

2. Мэргэжлийн ур чадвар сайжруулах.

3. Хувь хүний хөгжил.

4. Байгууллагын соёлын үйл ажиллагаа гэх мэтээр төлөвлөнө.

Сургалтын хэрэгцээ шаардлагыг:

Алба хаагчдын санал асуулгаар тодорхойлж огт болдоггүй. Хэрвээ санал асуулгаар асуувал "Англи хэл сурах, Илтгэх урлаг" гэх мэт ямар ч уялдаа холбоогүй мөрөөдлийн жагсаалт болдог тул, ингэж тодорхойлохоос татгалз.

Нөөцөө тодорхойлох:

Сургалтын дотоод нөөц буюу байгууллагын алба хаагчид ямар сэдвээр ямар хугацаанд лекц сургалт орох чадвартайг тодорхойлох хэрэгтэй. “Жор үзсэн ламаас зовлон үзсэн чавганц дээр” гэдэг шиг ажлынхаа тухай **А-Я** хүртэл мэддэг алба хаагч бол хамгийн сайн сургагч болж чаддаг. Хамгийн үр дүнтэй сайн сургагчид бол дотоод сургагчид (тухайн анги салбарын алба хаагч) байдаг. Тиймээс өөрсдийн дотоод сургагчдыг бодлогоор дэмжиж, чанартай сайн сургалт, зөвлөгөө зохион байгуулах ажиллагааг системтэй нь холбож өгөх нь зөв. Дотоод сургалт нь мэргэжлийн бус, туршлагаа солилцох хэлбэрээр эхэлдэг боловч яваандаа илүү чанаржин сайжирч хэлбэржин мэргэжлийн сургалттай өрсөлдөхүйц болж хөгждөг.

Сургалтын байгууллагууд болон сургагч нарыг судлах:

Хилийн цэргийн анги, тусгай салбарын зорилгыг хангахад хэрэгтэй гэж үзсэн сургалтын байгууллагууд болон сургагч багш нарын жагсаалтыг гаргаж, тухайн байгууллагууд руу хандаж сургалтын дэлгэрэнгүй мэдээлэл болон сургалтын арга барил зэрэг мэдээллийг урьдчилан хүлээн авч тэдгээрийн салбартаа мэргэшсэн байдал, туршлага, сургалтын хэлбэр, арга зүй, технологи зэргийг судалж үзнэ. Мөн өөрсдөд тулгамдаж буй асуудлаа сургагч багш нартаа хэлж, гарах гарцыг нь тогтмол ярилцаж байх хэрэгтэй.

Хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх:

Хөтөлбөр нь амжилттай хэрэгжихийн тулд алба хаагчдын өдөр тутмын ажил, үүргийн хуваарьтай нягт уялдсан, ажлаа хийхэд нь төвөг учрахааргүй, энгийн шийдсэн байх ёстой. Сургалт хөгжлийн хөтөлбөр явагдаад байна гэж илт мэдэгдэхгүйгээр урсах мэт, өдөр тутмын үйл ажиллагаатай уялдаад урсах мэт хийж чадсан хөтөлбөр хамгийн сайн болсон гэсэн үг. Байгууллагын соёлтой нягт уялдсан хөтөлбөр л цааш амьдарч чаддаг. Хэт албадлагын шинжтэй болгоод алба хаагчдын дургүйцлийг хүргэвэл хөтөлбөр амжилтгүй болно. Тиймээс анхнаас нь хөтөлбөрийнхөө ач холбогдлыг алба хаагчдадаа сайн ойлгуулж хандлагыг нь бий болгох хэрэгтэй.

Сургалтын хэлбэр, аргачлалууд

Агуулгын хувьд:

1. Хувь хүний хөгжилд чиглэсэн;
2. Мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургалт гэсэн 2 чиглэл гаргаж болно.

Сургалтын орчны хувьд:

- Ажлын байрны сургалт (ажлын байран дээр богино хугацааны);
- Танхимын сургалт (сургалтын зориулалтын танхимд);
- Заалны сургалт (Спорт заал ашиглан, хөдөлгөөнт тэмцээнд суурилсан сургалт);
- Хээрийн сургалт (Хөдөө, байгалийн сайханд, гадаа талбайг ашиглан өрсөлдөөнт тоглоом, цэргийн хэргийн мэдлэг, тактикийн уралдаан тэмцээн хийх замаар баг хамт олны уур амьсгалыг зангиддаг сургалт)

Сургалтын аргууд: Лекц, семинараас гадна **<u>оролцоонд тулгуурласан</u>** аргачлалууд түлхүү хөгжиж байна. Жишээ нь: тоглоомын, дүрд тоглох, багийн ажиллагааны даалгавар биелүүлэх, кейс ажиллах гэх мэт. Сургалтын идэвхтэй олон талт аргачлалуудыг ашигласнаар хөтөлбөр сонирхолтой, үр дүнтэй болдог.

Сургалтын хэлбэр: Биечилсэн сургалтаас гадна доорх хэлбэрүүдийг ашиглавал илүү баялаг хүртээмжтэй болно. Алба хаагчдын мэдлэг хүлээн авах онцлогт тохирсон олон талт сургалтын хэлбэрүүд байвал маш сайн.

1. Аудио: Удирдлагуудын лекц яриа болон чадварлаг туршлагатай мэргэжилтнүүдийн хэлсэн үг зэргийг хураагуураар бичиж аудио архив бүрдүүлэх. Уг бичлэгүүдийг зохистой дараалалд оруулж заавал сонсох хичээлүүд болгон бэлтгэх боломжтой.

2. Видео: Онцгой, чухал ач холбогдолтой, дахин давтагдашгүй лекцүүдийг видео болгож архивлах. Мөн техник технологийн ашиглалтын зааврууд ыг видео хичээл болгож бэлтгэх. Видео хичээлүүдийг цуврал болгож шинэ алба хаагчийн заавал үзэх хичээлийн жагсаалт гаргаж үзүүлэх.

3. Цахим сургалт: Академик мэдлэг дээшлүүлэх, судалгааны чиглэлийн сургалтуудыг цахимаар зохион байгуулах боломжтой.

Хөтөлбөрийг үргэлж шинэчлэх:

Хөтөлбөрийн явцыг тогтмол дүгнэж сайжруулж байх хэрэгтэй. Тулгарч байгаа асуудал болон ажиглалт, судалгаанд үндэслэн эрэлттэй байгаа сургалтын сэдвийг тодорхойлж хөтөлбөрт нэмэлтээр оруулж байх нь зөв юм. Сургалтын агуулга, хэлбэр, сургагч багш нарын чадварыг тогтмол үнэлж, сул талуудыг нь илрүүлж байх хэрэгтэй. Хөтөлбөрийн **сургалт -> судалгаа -> үр дүнг дүгнэх -> дахин төлөвлөх** гэх мэтээр хөтөлбөрийг тогтмол сайжруулах тогтолцоогоо бүрдүүлэх хэрэгтэй.

ХОЁР. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНЫ СУРГАЛТ, ХӨГЖЛИЙГ САЙЖРУУЛАХ ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГА

Сургалтын болон хөгжлийн хөтөлбөрт зөв зохистой хөрөнгө оруулалт хийх нь энэ цаг үед маш чухал асуудал билээ. Үүний тулд сургалт хөгжлийн хөтөлбөр амжилттай хэрэгжүүлэхэд дараах 7 асуудлуудыг шийдэх шаардлагатай болоод байна. Үүнд:

1. Гүйцэтгэлийн албан тушаалтныг дэмжих:

Шат шатны удирдах албан тушаалтан нар үүрэг хариуцлагадаа дарагдсан байгаа ба тэд өөрсдийгөө арайхийн сургаж байна. Харин энэ үед бид анги салбарын удирдах ажилтны ажил хэргийг гүйцэтгэх менежерүүдийг (алба, тасгийн дарга нар) сургаж, дэмжих хэрэгтэй. **“Мерит” буюу шатлан дэвшүүлэх зарчмаар ажиллах.**

2. Сургалт, хөгжлийн богино хугацааны хэрэгцээг авч үзэх:Өмнө нь сургалтыг “Та энэ жилд юуг сурах нь чухал байсан” бол “одоо та 1 сарын дотор ямар ур чадвар, мэдлэгийг олж авсан бэ” гэдэг нь чухал болоод байна. Энэ нь тогтмол бөгөөд хурдацтай суралцах шаардлагатай гэдгийг харуулж байгаа юм. Үүнээс харахад анги салбарын хувьд **сургалт хөгжлийг урт удаан хугацаанд тасралтгүй байдлаар, богино хугацааны нэгээс нөгөө үйл ажиллагаанд шилжих байдлаар** зохион байгуулах хэрэгтэй байна. Фармерс даатгалын (Farmers Insurance) сургалт хариуцсан захирал Аннет Томпсон: (Annette Thompson) “Бид мэдээллийн хэт их ачааллаас зугтах нь амин чухал бөгөөд цаашид зөв мэдээллийг

шуурхай түргэн хүргэхэд илүү анхаарах ёстой”[192] гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Хилийн цэргийн анги, тусгай салбарын хувьд хилийн цагийн байдал үүссэн үед мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд анхаарах шаардлагатай гэж ойлгож болох юм .

3. Ажилтандаа карьерын хөгжлийг зааж сургах:

Бүх сургалтын хөтөлбөр нь нэг хэвийн загвартай бол хэрэгждэггүй. Хувь хүн өөрөө сургалтын ирээдүйн хандлагыг хянаж байх ёстой. Анги салбарын удирдах албан тушаалтнууд болон алба хаагчдын чадварын өсөлт хөгжил анги салбарын өөрийнх нь ялалт, амжилт, шинэчлэлт хийх ур чадварыг нэмэгдүүлэхэд чухал нөлөө үзүүлэх зүйл юм.

Натиксис Глобал Ассет Менежментийн (Natixis Global Asser Management) дэд ерөнхийлөгч Дон Жонс (Don Jones) уг асуудлыг дүгнэж: “Байгууллагад үр ашигтай зардал байгууллагыг нэгэн зэрэг үр ашгийг хангаж байхын тулд хувь хүн бүрд зориулсан шийдэл байх хэрэгтэй”[193] гэсэн байдаг. Энэ нь ч мөн Хил хамгаалах байгууллагын хувьд зөвхөн анги салбарын удирдах бүрэлдэхүүн бус алба хаагчдаа ур чадваржуулах, итгэл үнэмшлийг нэмэгдүүлэх, эв нэгдлийг хангахад баримтлах нэг зарчим байж болох юм.

4. Суралцах арга барилыг уян хатан байлгах:

Хилийг цэргийн анги, тусгай салбарын удирдах бүрэлдэхүүн, алба хаагчдад илүү их сургалт хөгжлийн үйл ажиллагаа хэрэгтэй гэхэд тэд энэ их ажлын ачаалал, хувийн амьдралын хажуугаар “Хэзээ, яаж цаг гаргах вэ?” гэж асуудаг. Тэгвэл анги салбарын хувьд уг асуудлыг шийдвэрлэхийн тулд залуу алба хаагчдыг суралцах боломжийг илүү хүртээмжтэй болгох шийдлийг нэвтрүүлэх, сургалт нь зөвхөн академик шинж чанартай бус хувь хүний хөгжлийг дэмжих зорилготой байх нь илүү ур дүнтэй байх болно.

5. Виртуал баг хамт олонд сургалтын үйл ажиллагааг илүү хүртээмжтэй хүргэх:

Хилийн цэргийн анги, тусгай салбарын өдөр тутмын цагийн хуваарьт үйл ажиллагаа, зохиогдох арга хэмжээний давтамжаас хамаарч алба хаагчдыг виртуал хамт олон гэж ойлгож болно. Энэ

[192] https://yorknewstimes.com

[193] “Сургалт хөгжлийг сайжруулах 7 арга зам” “MLC TRAINING” mlctraining.mn/b/2335

тохиолдолд тэднийг илүү бодитойгоор, бүтээлч байдлаар сургах шаардлагатай байна.

6. Удирдлагадаа итгэх итгэлийг бий болгох:

Аль ч анги салбарын алба хаагчид удирдлагаасаа шударга, нээлттэй, ил тод, чадварлаг, мэдрэмжтэй байдлыг шаарддаг. Ийм учраас удирдах түвшний алба хаагчдийг маш богино хугацаанд, өндөр үр дүнтэй сургалтын бодлогоор хангах ёстой.

7. Сургалтын хэв маяг, арга барилуудыг тохируулах:

Сургалт, хөгжлийн хөтөлбөрт шинээр гарч ирж буй чиг хандлагыг тодорхой болгож, хэв маяг арга барил нь орчин үеийн чиг хандлагатай, техник технологи ашигласан, хөгжилтэй, итгэл найдвар бий болгосон байдлаар зохион байгуулагдаж байж алба хаагчийн оролцоо, бүтээмжийг нэмэгдүүлэх, үр дүнг удирдах илүү зорилтот шийдлүүдийг бий болгоно.

Эдгээрээс гадна Curriculum буюу сургалтын хөтөлбөр гэдэг нь тодорхой түвшний сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалтын зорилго, зорилт, үр дүн, хөтөлбөрийн агуулга, сурах, сургах арга зүй, үнэлгээний арга зүй, орчин, хэрэглэгдэхүүн, тэдгээрийн хоорондын нарийн уялдаа холбоог тодорхойлсон нэгдмэл баримт бичиг юм.

Сургалтын хөтөлбөр нь дараах шинж чанарыг хангасан байна:

- Сургалтын үр дүнгийн болон хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангасан байна;
- Онол практикийг хослуулсан байна;
- Сургалтад хамрагдагчдын албан тушаалын болон хувь хүний чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байна;
- Сургалтын арга зүй, үр дүн, сургалтын үнэлгээний хэлбэрүүдийг бүрэн багтаасан байна;
- Хөтөлбөрт хамрагдагсдын санал зөвлөмжийг тусган байнга сайжруулдаг байна;
- Сургалт бүрийн хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байна.

Мөн орчин үед сургалтын хөтөлбөрт нийлмэл гэсэн нэр томьёог ашиглаж байгаа бөгөөд энэ нь “Сургалтад хамрагсдад хувь хүний, хувь хүн хоорондын харилцааны болон бүтээгдэхүүн, систем,

үйл ажиллагаа бий болгох ур чадвар олгоход чиглэсэн харилцан уялдаатай хичээлүүдийг агуулсан сургалтын хөтөлбөр”-ийг нийлмэл сургалтын хөтөлбөр[194] гэж нэрлэж байна.

Нийлмэл сургалтын хөтөлбөрийн онцлог шинж нь:

1. Сургалтын үр дүнгийн жагсаалтад хувь хүний, хувь хүн хоорондын харилцааны болон бүтээгдэхүүн, үйл ажиллагаа, систем бий болгох ур чадварыг заавал багтаасан байна;

2. Тухайн хөтөлбөрт байгаа сургалт бүрийн үр дүнд мэдлэгээс гадна ур чадвар, хандлага олгох үр дүнг заавал тусгасан байна;

3. Сургалтын хөтөлбөрийн үнэлгээ болон тасралтгүй сайжруулалтыг хийх төлөвлөгөөг сургалтын хөтөлбөрийн баримт бичигт заавал багтааж хэрэгжүүлдэг байна.

ГУРАВ. ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН УДИРДАХ АЖИЛТНУУДАД ЗОРИУЛСАН СУРГАЛТЫН ЖИШИГ ХӨТӨЛБӨР

Сургалтын хөтөлбөрийн ерөнхий танилцуулга

Хил хамгаалах байгууллага, хилийн цэргийн анги, тусгай салбарын удирдах ажилтнуудын чадавхаас анги, салбарын дотоод зохион байгуулалт, уялдаа холбоо, ажлын бүтээл, гүйцэтгэлийн түвшин, эв нэгдэл, зохион байгуулалт ихээхэн хамаардаг. Чадварлаг, ухаалаг удирдлагууд тухайн анги салбар төдийгүй ангийн алба хаагчдын ур чадвар, хандлагыг өсгөдөг.

[194] LAW ENFORCEMEN сэтгүүл 25/3 тал

Паретогийн зарчим ёсоор ашгийн 80%-г авч ирдэг 20% буюу үйл явцыг голчлон зохион байгуулдаг тэдгээр удирдлагуудын тогтвортой нөлөө анги, салбаруудад тогтвортой өсөлт (ажлын бүтээмж, дотоод эв нэгдэл) - ийг бий болгодог. Бэлтгэгдэж, бэлэн болсон удирдах ажилтнууд өөрсдийн залуу манлайлагчдыг бодлогоор төрүүлж, бэлтгэх чадвар суусан байна. Менежментийн түвшинд ажиллаж байгаа удирдлагуудад хүнийг удирдах мэдлэг туршлагад нь шинэ сорилтууд тулгарч, менежментийн үйл ажиллагаа, өөрийгөө удирдах ур чадваруудтай тулгардаг. Энэ бүхэнд зөвлөмж болгох анги салбарын удирдах албан тушаалтнуудад зориулан боловсруулсан хөтөлбөрийг танилцуулж байна.

Сургалтын зохион байгуулалт:

Сургалтууд дараах хэлбэрээр зохион байгуулагдаж болно.

1. Танхимын (Тодорхой зааланд сууж хамрагдах оролцоонд тулгуурласан сургалтын хувьд суралцагчдын дээд тооны хязгаар 25 байна);
2. Онлайн (Цахим программыг ашиглан зохион байгуулна);
3. Хосолсон (Цахим болон танхимын хэлбэрийг хослуулан ашиглах);
4. Вакумжсан.

Сургалтын хөтөлбөрийн модуль:

“Удирдах ажилтнуудад зориулсан сургалтын хөтөлбөр” нь дараах үндсэн модультай байна.

1. Менежментийн суурьтай сургалтын модуль;
2. Сэтгэл зүйн суурьтай сургалтын модуль;
3. Ерөнхий ур чадварыг дээшлүүлэх сургалтын модуль.

Сургалтын цаг: Сэдэв болон хөтөлбөрөөс хамаарна.

Сургалтын бүтэц

№	Сэдвийн хүрээний онолын эзлэх хувь	Сэдвийн хүрээний суралцагчдын оролцооны эзлэх хувь
1	**50%** (тухайн сэдвийн хүрээнд онолын гарч ирсэн шинэ ойлголтууд)	**50%** (багийн ажиллагаа, кейс, бүлгээр даалгавар гүйцэтгэх, дүрд тоглох гэм мэт)
2	**80%** (тухайн сэдвийн хүрээнд онолын гарч ирсэн шинэ ойлголтууд)	**20%** (багийн ажиллагаа, кейс, бүлгээр даалгавар гүйцэтгэх, дүрд тоглох гэм мэт)
3	**20%** (тухайн сэдвийн хүрээнд онолын гарч ирсэн шинэ ойлголтууд)	**80%** (багийн ажиллагаа, кейс, бүлгээр даалгавар гүйцэтгэх, дүрд тоглох гэм мэт)

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

1. Barnett, R. & Coates, K. (2005) A Schema. In Engaging the curriculum in Higher Education (p. 67-69). Berkshire: SRHE & Open University Press.

2. Biggs J. (2003) Teaching for Quality Learning at University. 2nd ed. Buckingham: The Society for Research into Higher Education & Open University Press; pp. 34–55.

3. Gardner, L. (2000) Faculty Development in Higher Education. National Academy for Academic Leadership.

4. Jacobs, H. editor, (2004). Getting Results with Curriculum Mapping. Alexandria, VA: ASCD

5. Joyce, B., Weil, M., Calhoun, E. : Models of teaching, 6th edition, Allyn & Bacon, 2000

6. Kuh, G.D. (2008) High-Impact Educational Practices: What They Are, Who Has Access to Them, and Why They Matter Association of American Colleges and Universities 32

7. Lattuca, L.R. (2006) Curricula in International Perspective. In J.J.F Forest & P.G. Altbach (Eds., International Handbook of Higher Education, part one: Global Themes and Contemporary Challenges (pp. 39-64). The Netherlands: Klumer/Springer.

8. Lattuca, L.R. & Stark, J.S. (2009) Shaping the College Curriculum: Academic Plans in Context. San Francisco: Wily & Sons.

9. Porter, A.C. (2005) Curriculum assessment. In J. L. Green, G. Camilli, & P. B. Elmore (Eds.), Complementary methods for research in

education (3rd edition). Washington, DC: American Educational Research Association.

10. Wolf, P. (2007) A model for facilitating Curriculum Development in Higher Education: A Faculty Driven, Data-Informed and Educational developer-Supported Approach, in Directions for Teaching and Learning pp. 15-20.

11. Various websites were also consulted on Curriculum Development, Design and Evaluation in all regions of the globe

12. LAW ENFORCEMEN сэтгүүл

Цахим эх сурвалж:

1. mn.wikipedia.org/wiki
2. www.hrconsulting.mn
3. yorknewstimes.com
4. mlctraining.mn